

# Үнэт Цаасны Танилцуулга

Үнэт Цаас Гаргагч:

ХАСБАНК

Андеррайтер:

RHINOS Investment

ULZII & Co CAPITAL

Хуулийн Зөвлөх:

BATBAYAR AND PARTNERS LLP

Хөндлөнгийн Аудитор:

EY Building a better working world

Хөндлөнгийн Үнэлгээчин:

BDO

СЗХ 2023 оны 05 сарын 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

# ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД

Монгол Улсын хууль тогтоомж, холбогдох журмын дагуу ХасБанк ХХК (цаашид "**Банк**" эсвэл "**Үнэт цаас гаргагч**" гэх) нь нийт **52,700,000** ширхэг, нэгж хувьцаа нь **677** төгрөгийн үнэ бүхий энгийн хувьцааг нийтэд анх удаа санал болгож байна. Нийтэд анх удаа хувьцааг санал болгож байгаатай холбогдуулан энэхүү Үнэт цаасны танилцуулгыг (цаашид **"Танилцуулга"** гэх) Компанийн тухай хууль, Үнэт цаасны тухай хууль, Банкны тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хороо (цаашид "**СЗХ**" гэх), Монголбанк (цаашид "**Монголбанк**" гэх), Монголын Хөрөнгийн Бирж ТӨХК (цаашид "**МХБ**" гэх)-ийн дүрэм, журмын дагуу боловсруулсан болно.

**"ҮНЭТ ЦААСЫГ МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ БҮРТГЭСЭН НЬ УГ ҮНЭТ ЦААСНЫ ЭРСДЭЛИЙН ТАЛААР АЛИВАА БАТАЛГАА ГАРГААГҮЙ БОЛОХЫГ АНХААРАХ НЬ ЗҮЙТЭЙ. ЭНЭХҮҮ ҮНЭТ ЦААСЫГ ХУДАЛДАН АВАХ ЗАМААР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХИЙХ НЬ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧ ТАНЫ ХУВЬД ЯМАГТ ЭРСДЭЛТЭЙ ҮЙЛДЭЛ БАЙДГИЙГ ОНЦГОЙЛОН АНХААРЧ, ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА, ҮНЭТ ЦААС ГАРГАХ АЖИЛЛАГААГ САЙТАР АНХААРАН СУДАЛСНЫ ҮНДСЭН ДЭЭР ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ШИЙДВЭРЭЭ ГАРГАХЫГ ЗӨВЛӨЖ БАЙНА."**

Хөрөнгө оруулагч та шаардлагатай тохиолдолд хөрөнгө оруулалтын мэргэжлийн байгууллагаас зөвлөгөө авсны үндсэн дээр шийдвэрээ гаргахыг зөвлөж байна. Мөн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахаас өмнө энэхүү Танилцуулгын 9 дүгээр бүлэгт агуулагдсан "Эрсдэлийн Хүчин Зүйлс"-ийн талаар анхааралтай уншихыг зөвлөж байна.

Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан одоо болон ирээдүйн цаг хугацаанд хамаарах аливаа мэдээ, мэдээлэл, төсөөлөл, тооцооллыг Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нь холбогдох эх сурвалжаас цуглуулсан мэдээлэл, өнгөрсөн үеийн гүйцэтгэл, өнөөгийн бодит нөхцөл байдал, итгэл үнэмшил дээр тулгуурлан бэлтгэсэн бөгөөд ямар нэг мэдээллийг санаатайгаар орхигдуулаагүй, гуйвуулаагүй болно. Танилцуулгад агуулагдаж буй өнгөрсөн үеийн гүйцэтгэл нь ирээдүйн гүйцэтгэлийн баталгаа биш бөгөөд Андеррайтер болон Үнэт цаас гаргагч нь ирээдүйн төсөөллийн биелэлтэд баталгаа гаргахгүйг анхаарна уу. Үнэт цаас гаргагчийн ирээдүйн санхүүгийн төсөөлөл нь макро эдийн засаг, улс төрийн тогтвортой байдал, зах зээл, хууль эрх зүйн орчин болон олон улсын нөхцөл байдал хэрхэн өөрчлөгдөх зэргээс ихээхэн хамааралтай болно.

Райнос Инвестмент ҮЦК ХХК нь үндсэн андеррайтераар ("Андеррайтер"), Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК туслах андеррайтераар ("Туслах Андеррайтер"), Батбаяр энд Партнерс ХХН нь хууль зүйн зөвлөгөө үзүүлэгчээр , БДО Аудит ХХК нь бие даасан бизнесийн үнэлгээчнээр, хамтдаа ("IPO Зөвлөхүүд"), мөн Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК хараат бус аудитораар ("E&Y" "Хараат бус аудитор") тус тус ажилласан болно.

| | |
|---|---|
| *Үнэт цаас гаргагч*<br>**ХасБанк ХХК** | *Үндсэн андеррайтер*<br>**Райнос Инвестмент ҮЦК ХХК** |
| *Туслах андеррайтер*<br>**Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК** | *Хөндлөнгийн бизнесийн үнэлгээчин*<br>**БДО Аудит ХХК** |
| *Хөндлөнгийн аудитор*<br>**Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК** | *Хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч*<br>**Өмгөөллийн "Батбаяр энд Партнерс" ХХН** |

ХАСБАНК 4937 2578697

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

# АНДЕРРАЙТЕРИЙН МЭДЭГДЭЛ

СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам”, МХБ-ийн “Үнэт цаасны бүртгэлийн журам” болон бусад холбогдох хууль тогтоомжийн хүрээнд Үнэт цаасыг нийтэд анх удаа санал болгож бүртгүүлэх, хөрөнгө оруулагчдад танилцуулахтай холбоотой бүхий л баримт бичгийг үнэн зөвөөр бүрдүүлсэн, СЗХ болон МХБ-д хүргүүлж буй танилцуулга нь адил, аливаа зөрүүтэй мэдээлэл тусгагдаагүй болно. Мөн энэхүү Үнэт цаасны танилцуулга болон түүнд хавсаргасан баримт материалыг үнэн зөвөөр холбогдох хууль тогтоомжийн дагуу бүрэн гүйцэд бүрдүүлсэн бөгөөд тэдгээртэй зөрчилдсөн эсхүл хуурамчаар бүрдүүлсэн ямарваа баримт бичиг байхгүй гэдгийг илэрхийлж энэхүү хариуцлагын мэдэгдлийг гарган баталгаажуулж байна.

Үндсэн андеррайтерийг төлөөлж:

Н.ЦЭВЭГМИД

Дэд Захирал

Райнос Инвестмент ҮЦК ХХК

Туслах андеррайтерийг төлөөлж:

Б.ӨЛЗИЙБАЯР

Гүйцэтгэх Захирал

Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК

СЗХ
он 2023 .05. 12 сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

# ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ

Хүснэгт 1: Үнэт цаасны хураангуй мэдээлэл

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | ХасБанк ХХК |
| Бүртгэл | Монголын Хөрөнгийн Бирж |
| Самбар/Ангилал | I ангилал |
| Гаргасан хувьцааны тоо ширхэг | 1,000,000,000 ширхэг |
| Нэрлэсэн үнэ | 100 төгрөг |
| Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг | 52,700,000 ширхэг |
| Нэмж гаргах хувь | 5.0062% |
| ▪ Стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилах хэмжээ | 70% буюу 36,890,000 ширхэг хувьцааг энэхүү Танилцуулгын 6.5-д заасны дагуу хуваарилах |
| ▪ Олон нийтэд хуваарилах хэмжээ | 30% буюу 15,810,000 ширхэг хувьцааг энэхүү Танилцуулгын 6.5-д заасны дагуу хуваарилах |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нийтэд санал болгох үнэ | 677 төгрөг |
| Нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо ширхэг | 1,052,700,000 ширхэг хувьцаа |
| Нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ | 35,677,900,000 төгрөг |
| Арилжааны арга хэлбэр | Тогтоосон үнийн арга |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт | Үйл ажиллагаагаа өргөжүүлж, зээлийн болон санхүүгийн түрээсийн багцын өсөлтийг хангах |
| Андеррайтерууд | Райнос Инвестмент ҮЦК ХХК (Үндсэн)<br>Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК (Туслах) |

ХАСБАНК
2578697

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

# АГУУЛГА

ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН АНХААРАЛД ........ 2
АНДЕРРАЙТЕРИЙН МЭДЭГДЭЛ ........ 3
ҮНЭТ ЦААСНЫ ХУРААНГУЙ МЭДЭЭЛЭЛ ........ 4
АГУУЛГА ........ 5
ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ ........ 8
ЗУРГИЙН ЖАГСААЛТ ........ 9
ГРАФИКИЙН ЖАГСААЛТ ........ 9
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ ........ 10
Нэг. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ ........ 13
1.1 ХасБанкны товч түүх ........ 13
1.2 Алсын хараа, Эрхэм зорилго ........ 16
1.3 Үнэт цаас гаргагчийн хууль ёсны бүртгэл, хаяг ........ 16
1.4 ХасБанкны хувьцаа эзэмшигчийн бүтэц ........ 17
1.5 Байгууллагын бүтэц ........ 18
1.6 Төлөөлөн Удирдах Зөвлөл ........ 19
1.7 Гүйцэтгэх Удирдлага ........ 24
1.8 Хүний нөөцийн удирдлага ........ 27
1.9 Компанийн засаглал ........ 28
1.9.1 Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн үйл ажиллагаа ........ 28
1.9.1.1 ТУЗ-ийн хурал ........ 29
1.9.1.2 ТУЗ-ийн үнэлгээ, гишүүдийн сургалт ........ 29
1.9.1.3 ТУЗ-ийн хороод ........ 29
1.9.2 Дотоод аудит ........ 31
1.9.3 Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх хороодын үйл ажиллагаа ........ 31
1.9.4 Компанийн засаглалын кодекс ........ 32
1.9.5 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого ........ 32
1.9.6 Зээлийн удирдлагын хороо ба зээл батлах эрх ........ 33
1.9.7 Зах зээлийн эрсдэлийн удирдлага ........ 34
1.9.7.1 Хүүгийн эрсдэлийн удирдлага ........ 34
1.9.7.2 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага ........ 34
1.9.7.3 Гадаад валютын ханшийн эрсдэл ........ 34
1.9.8 Банкны ил тод байдал ........ 35
1.10 Үл хөдлөх хөрөнгө ба үндсэн хөрөнгө ........ 35
1.11 Их хэмжээний болон холбоотой талтай хийсэн гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл ........ 36
1.11.1 Их хэмжээний хэлцэл ........ 36
1.11.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл ........ 36
1.11.3 Холбоотой талуудын тодруулга ........ 37
1.11.4 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны мэдээлэл ........ 38
1.11.5 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний гэрээ, хэлцэл ........ 39
1.12 Бусад гэрээ ........ 40
1.13 Эх үүсвэр олгогч санхүүгийн түнш байгууллагууд ........ 40
1.14 Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл ........ 42
1.15 Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) үйл ажиллагаа ........ 42
1.15.1 Нийгмийн хариуцлага ........ 42
1.15.2 Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа ........ 45
1.15.3 Уур Амьсгалын Ногоон Сантай хамтарсан Ногоон Санхүүжилт ........ 47
Хоёр. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ ........ 48
2.1 Макро эдийн засгийн үзүүлэлтүүд ........ 48
2.1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ) ........ 48
2.1.2 Гадаад худалдааны тэнцэл ........ 48
2.1.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш ........ 49
2.1.4 Инфляц ........ 50

ХАСБАНК
4937 2578697

СЗХ
он 2023 сар 05. өдөр 12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

2.1.5 Ажилгүйдэл ........ 50
2.2 Эдийн засгийн хэтийн төлөв ........ 51
2.3 Мөнгөний бодлого ........ 52
2.4 Монгол Улсын зээлжих зэрэглэл ........ 53
2.5 Санхүүгийн сектор ........ 54
2.5.1 Санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагууд ........ 55
2.5.2 Банкны систем ........ 56
2.5.3 Банкны системийн реформ ........ 58
Гурав. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, БИЗНЕС, СТРАТЕГИ ........ 60
3.1 Банкны бизнес зохион байгуулалт, бүтээгдэхүүн, үйлчилгээ ........ 60
3.1.1 Иргэдийн банк ........ 60
3.1.1.1 Хэрэглээний зээл ........ 60
3.1.1.2 Хадгаламж барьцаалсан зээл ........ 61
3.1.1.3 Бизнесийн зээл ........ 61
3.1.1.4 Орон сууцны зээл ........ 61
3.1.1.5 Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны зээл ........ 61
3.1.1.6 Харилцах данс ........ 62
3.1.1.7 Хадгаламжийн данс ........ 62
3.1.1.8 “Ирээдүйн Саятан” урт хугацаат хуримтлалын данс ........ 62
3.1.1.9 Карт ........ 62
3.1.2 Байгууллагын банк ........ 63
3.1.2.1 Эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн зээл ........ 63
3.1.2.2 Худалдааны санхүүжилт ........ 63
3.1.2.3 “Оюу Толгой” авлагын санхүүжилт ........ 64
3.1.2.4 Хамтын санхүүжилт ........ 64
3.1.2.5 Банкны баталгаа ........ 64
3.1.2.6 Байгууллагын харилцах данс ........ 65
3.1.2.7 Байгууллагын хадгаламжийн данс ........ 65
3.1.3 Санхүүгийн түрээс (ХасЛизинг™) ........ 65
3.1.3.1 Хүнд даацын техник, хэрэгсэл ........ 65
3.1.3.2 Суудлын автомашин ........ 66
3.1.3.3 Тоног төхөөрөмж ........ 66
3.1.3.4 Нийтийн болон амины орон сууц ........ 66
3.1.4 Гадаад төлбөр тооцоо ........ 66
3.1.5 Бизнесийг дэмжигч нэгжүүд ........ 67
3.2 Өрсөлдөөний орчин, стратеги ........ 68
3.2.1 Өрсөлдөөний орчин ба зах зээлд эзлэх хувь ........ 68
3.2.2 Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь болон бүтээгдэхүүн, үйлчилгээний харьцуулалт ........ 70
3.2.3 Үнэт цаас гаргагчийн зээл ба санхүүгийн түрээсийн багцын удирдлага ........ 71
3.2.4 Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн удирдлага ........ 74
3.2.5 Үнэт цаас гаргагчийн цахим банкны бизнес ........ 75
3.2.6 Дунд болон урт хугацааны бизнесийн бодлого ........ 75
3.2.7 Үнэт цаас гаргагчийн бизнес, эрсдэлийн удирдлагын бодлого ........ 76
3.2.8 Үнэт цаас гаргагчийн стратеги, зорилт (хураангуй) ........ 78
Дөрөв. БАНКНЫ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ ........ 80
4.1 СТОУС-ын дагуух санхүүгийн мэдээллүүд ........ 80
4.2 Удирдлагын зорилгоор (СТОУС-ын бус) бэлтгэсэн санхүүгийн мэдээллүүд ........ 81
4.2.1 Санхүүгийн гол үзүүлэлтүүд ........ 81
4.2.2 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт ........ 82
4.2.3 Санхүүгийн үзүүлэлтүүд (өмнөх 5 жилийн) ........ 83
4.3 Санхүүгийн төсөөлөл ........ 86
Тав. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ ........ 91
5.1 Үнэлгээний аргачлалууд ........ 91
Зургаа. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ ........ 94
6.1 Үнэт цаас гаргах тухай ........ 94

ХАСБАНК
2578697

СЗХ
он 2023 сар 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

6.2 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл ....95
6.3 Хувьцааг олон нийтэд санал болгох төлөвлөгөө ....95
6.4 Анхдагч зах зээлийн арилжааны арга ....96
6.5 Хуваарилалт ....97
6.6 Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр ....98
6.7 Үнэт цаасны нийлүүлэлт ....99
6.8 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт ....99
6.9 Үнэт цаасанд хамаарах эрх, үүрэг ....100
6.9.1 Хувьцаа эзэмшигчийн эрх ....100
6.9.2 Хувьцаа эзэмшигчийн үүрэг ....100
6.9.3 Нэмж хувьцаа гаргах ....100
6.9.4 Хувьцаа шилжүүлэхэд тавих хязгаарлалт ....101
6.9.5 Тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх ....101
6.9.6 Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг бууруулах ....101
6.9.7 Хувьцааг эргүүлэн худалдаж авах ....101
6.9.8 Хувьцааны хэлбэр, бүртгэл ....101
6.9.9 Гадаад дахь хувьцаа эзэмшигчидтэй холбоотой биржийн хяналт болон бусад заалтууд 102
6.9.10 Ногдол ашгийн хуваарилалт ....102
6.9.11 Ногдол ашгийн хязгаарлалт ....102
6.10 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн үүрэг ....102
6.11 Хувьцаа эзэмшигчдийн хурал, саналын эрх ....102
6.12 Монголбанкны оролцоо ....103
6.13 Банкыг татан буулгах ....103
6.14 Үнэ тогтворжуулах хөтөлбөр ....103
6.15 Андеррайтерийн худалдан авах Үнэт цаас ....104
6.16 Санал болгож буй хувьцаатай холбоотой татвар, хураамж ....104
6.17 Маргаан шийдвэрлэх ....104
Долоо. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ ....105
7.1 Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах үндэслэл ....105
7.2 Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах төлөвлөгөө ....107
Найм. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН ....109
8.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж ....109
8.2 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулагч байгууллагууд ....109
8.2.1 Монголбанкнаас баталсан журмууд ....109
8.2.2 Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос баталсан журмууд ....110
8.2.3 Банкны салбарын шинэчлэлийн хүрээнд Банкны тухай хуульд орсон шинэлэг зохицуулалт ....110
Есөн. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС ....112
9.1 Макро эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдлын эрсдэл ....112
9.2 Зээлийн болон төвлөрлийн эрсдэл ....115
9.3 Бизнесийн эрсдэл ....116
9.4 Хөрвөх чадварын эрсдэл ....119
9.5 Зах зээлийн эрсдэл ....121
9.6 Үйл ажиллагааны эрсдэл ....121
9.7 Нэр хүндийн эрсдэл ....131
9.8 Хууль эрх зүй, хянан нийцүүлэлтийн эрсдэл ....131
9.9 Үнэт цаас гаргагчийн хувь эзэмшигчдийн бүтэц, нээлттэй хувьцаат компани болох, хувьцаа санал болгохтой холбоотой эрсдэлүүд ....140
Арав. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН МЭДЭЭЛЭЛ ....145
10.1 Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй этгээдүүдийн ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдэгдэл ....145
10.2 Үндсэн андеррайтер ....145
10.2.1 Компанийн танилцуулга ....145
10.3 Туслах андеррайтер ....146
10.3.1 Компанийн танилцуулга ....146

ХАСБАНК
ХН4937 2578697

СЭХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

10.3.2 Андеррайтерын гэрээний тухай ....... 147
10.4 Хуулийн Фирм ....... 147
10.4.1 Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний тухай ....... 148
10.5 Хөндлөнгийн үнэлгээний байгууллага ....... 149
10.5.1 Компанийн танилцуулга ....... 149
10.5.2 Бизнесийн үнэлгээний гэрээний тухай ....... 149
10.6 Хөндлөнгийн Аудитор ....... 150
10.6.1 Компанийн танилцуулга ....... 150
10.6.2 Аудитын гэрээний тухай ....... 150

**ХАВСРАЛТУУД:**

ХАВСРАЛТ 1: Аудитлагдсан санхүүгийн тайлан 2022 он
ХАВСРАЛТ 2: Ногдол ашгийн бодлого
ХАВСРАЛТ 3: Хувьцаат компанийн (банкны) дүрмийн төсөл
ХАВСРАЛТ 4: Андеррайтерийн дүгнэлт болон тусгай зөвшөөрлийн хуулбар
ХАВСРАЛТ 5: Үнэлгээний компанийн дүгнэлт болон тусгай зөвшөөрлийн хуулбар
ХАВСРАЛТ 6: Хуулийн фирмийн дүгнэлт болон тусгай зөвшөөрлийн хуулбар
ХАВСРАЛТ 7: Хувьцаа гаргах тухай ТУЗ-ийн хурлын тогтоол
ХАВСРАЛТ 8: Хувьцаа гаргах тухай Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын тогтоол
ХАВСРАЛТ 9: Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн хуулбар

# ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт 1: Үнэт цаасны хураангуй мэдээлэл ....... 4
Хүснэгт 2: Үнэт цаас гаргагчийн хууль ёсны бүртгэл, хаяг ....... 16
Хүснэгт 3: ТСН-ийн Хувьцаа эзэмшигчдийн жагсаалт ....... 17
Хүснэгт 4: ТСН ХХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид ....... 18
Хүснэгт 5: Хүний нөөцийн бүтэц ....... 27
Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө ....... 35
Хүснэгт 7: Холбоотой талд олгосон зээл ....... 38
Хүснэгт 8: Холбоотой талаас авсан харилцах, хадгаламж ....... 38
Хүснэгт 9: Холбоотой талаас авсан урт хугацаат санхүүжилт ....... 38
Хүснэгт 10: Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан ....... 38
Хүснэгт 11: Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав буюу түүнээс дээш хэмжээний хэлцлүүд ....... 39
Хүснэгт 12: Эх үүсвэр олгогч байгууллагууд ....... 40
Хүснэгт 13: Зээлжих зэрэглэл - Moody's Investor Service ....... 42
Хүснэгт 14: Зээлжих зэрэглэл - Fitch Ratings ....... 42
Хүснэгт 15: Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа ....... 43
Хүснэгт 16: Тогтвортой Хөгжлийн Зорилтын хүрээнд хийгдэж буй ажлууд ....... 45
Хүснэгт 17: Санхүүгийн секторын идэвхитэй оролцогчид ....... 55
Хүснэгт 18: Хэрэглээний зээлийн нөхцөл ....... 60
Хүснэгт 19: Хадгаламж барьцаалсан зээлийн нөхцөл ....... 61
Хүснэгт 20: Бизнесийн зээлийн нөхцөл ....... 61
Хүснэгт 21: Орон сууцны зээлийн нөхцөл ....... 61
Хүснэгт 22: АОС-ны ногоон зээлийн нөхцөл ....... 62
Хүснэгт 23: Санхүүгийн түрээсийн нөхцөл - хүнд даацын техник ....... 66
Хүснэгт 24: Санхүүгийн түрээсийн нөхцөл - суудлын автомашин ....... 66
Хүснэгт 25: Санхүүгийн түрээсийн нөхцөл - тоног төхөөрөмж ....... 66
Хүснэгт 26: Санхүүгийн түрээсийн нөхцөл - нийтийн болон АОС ....... 66
Хүснэгт 27: Корреспондент банкууд ....... 67
Хүснэгт 28: Системд нөлөө бүхий банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн харьцуулалт ....... 69
Хүснэгт 29: Зах зээлд эзлэх хувь ....... 70

ХАСБАНК
УБН 117 2578697

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Хүснэгт 30: Системийн банкуудын зарим бүтээгдэхүүнүүдийн харьцуулалт ........ 70
Хүснэгт 31: Үнэт цаас гаргагчийн зохистой харьцаа үзүүлэлтийн биелэлт ........ 77
Хүснэгт 32: Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлан ........ 80
Хүснэгт 33: Санхүүгийн байдлын хураангуй тайлан ........ 80
Хүснэгт 34: Санхүүгийн гол хэмжүүрүүд ........ 81
Хүснэгт 35: МБ-с тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд ........ 82
Хүснэгт 36: Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа үзүүлэлтүүд ........ 83
Хүснэгт 37: Орлогын тайлангийн төсөөлөл ........ 88
Хүснэгт 38: Санхүүгийн төсөөллийн харьцаа үзүүлэлтүүд ........ 89
Хүснэгт 39: Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл ........ 89
Хүснэгт 40: Үнэт цаасны мэдээлэл ........ 94
Хүснэгт 41: IPO хийхийн өмнөх болон дараах хувьцаа эзэмшлийн бүтэц ........ 95
Хүснэгт 42: Стратегийн хөрөнгө оруулагчид тавих шалгуур, нөхцөл ........ 97
Хүснэгт 43: Олон нийтэд санал болгох хувьцааны хуваарилалтын матриц ........ 98
Хүснэгт 44: Нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт ........ 100
Хүснэгт 45: Үнэ тогтворжуулах хөтөлбөр ерөнхий нөхцөл ........ 103
Хүснэгт 46: ТСН-ийн хураангуй тайлан тэнцэл ........ 106
Хүснэгт 47: Үнэт цаас гаргарчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц ........ 108
Хүснэгт 48: Үндсэн андеррайтерийн мэдээлэл ........ 145
Хүснэгт 49: Туслах андеррайтерийн мэдээлэл ........ 146
Хүснэгт 50: Хуулийн фирмийн мэдээлэл ........ 148
Хүснэгт 51: Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын мэдээлэл ........ 149
Хүснэгт 52: Хөндлөнгийн аудиторын мэдээлэл ........ 150

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

Зураг 1: Түүхэн замнал ........ 13
Зураг 2: Онцлох үйл явдлууд ........ 14
Зураг 3: Хэтийн зорилт, Эрхэм зорилго, Үнэт зүйлс ........ 16
Зураг 4: Байгууллагын бүтэц ........ 19
Зураг 5: Эрсдэлийн удирдлагын тогтолцоо ........ 33
Зураг 6: Банкны системд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудын харьцуулалт 69
Зураг 7: Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын бүтэц ........ 76
Зураг 8: Үнэт цаас гаргагчийн стратегийн зорилт ........ 79

## ГРАФИКИЙН ЖАГСААЛТ

График 1: Дотоодын Нийт Бүтээгдэхүүн ........ 48
График 2: Экспорт, Импортын бүтэц ........ 48
График 3: Юан болон Ам.долларын төгрөгтэй харьцах ханш ........ 49
График 4: Инфляц ........ 50
График 5: Ажилгүйдлийн түвшин, оролцооны түвшин ........ 51
График 6: Эдийн засгийн бодит өсөлтийн таамаглал ........ 52
График 7: Мөнгөний гол үзүүлэлтүүд ........ 53
График 8: Монгол Улсын зээлжих зэрэглэл ........ 54
График 9: Банкны системийн зээлийн өрийн үлдэгдэл, түүний өсөлт ........ 56
График 10: Банкны системийн чанаргүй зээл, нийт зээлд эзлэх хувь ........ 57
График 11: Банкны системийн харилцах, хадгаламжийн үлдэгдэл, түүний өсөлт ........ 57
График 12: Иргэдийн зээлийн багц, чанаргүй зээлийн хэмжээ, бүтээгдэхүүний бүтэц ........ 72
График 13: Байгууллагын зээлийн хэмжээ, чанаргүй зээл, бүтээгдэхүүний бүтэц ........ 72
График 14: Санхүүгийн түрээсийн хэмжээ, чанаргүй түрээс, бүтээгдэхүүний бүтэц ........ 73
График 15: Үнэт Цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтэц ........ 74
График 16: Үнэт цаас гаргагчийн цахим банкны тоон үзүүлэлтүүд ........ 75

ХАСБАНК
УХН4937 2578697

СЗХ
он сар өдөр
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

График 17: Өмнөх хугацааны ашигт ажиллагааны үзүүлэлт ........ 83
График 18: Цэвэр хүүгийн маржин болон актив, пассивын дундаж хүү ........ 84
График 19: Хүүгийн бус орлого ........ 84
График 20: Зээл ба санхүүгийн түрээсийн багц, түүний чанар ........ 85
График 21: Нийт актив, ӨБҮХХ, ӨБҮХХ-н эрсдэлийн сан ........ 85
График 22: Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт ........ 86
График 23:Бизнесийн үнэлгээний хураангуй ........ 93

# ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

| | |
|---|---|
| AQR | Активын Чанарын Үнэлгээ (Asset Quality Review) |
| aROA | Дундаж активын өгөөж (average Return on Assets) |
| ASX | Австралийн хөрөнгийн бирж (Australian Stock Exchange) |
| ATM | Бэлэн Мөнгөний Машин (Automated Teller Machine) |
| BIO | Бельгийн Хаант Улсын Хөгжийн Сан (Belgian Investment Company for Developing Countries) |
| BoC | Bank of China |
| CDM | Бэлэн Мөнгөний Машин (Cash Deposit Machine) |
| DWM | Хөгжиж буй Дэлхийн Зах Зээл (Developing World Market) |
| ESG | Байгаль орчин, нийгэм, засаглалын үйл ажиллагаа (Environmental, Social, and Governance) |
| FATCA | АНУ-ын Гадаад дахь дансдын хөрөнгийг татварт хамруулах тухай хууль (The Foreign Account Tax Compliance Act) |
| FFI | Гадаадын санхүүгийн байгууллага (Foreign Finance Institution) |
| Finnfund | Финляндын Аж Үйлдвэрийн Хамтын Ажиллагааны Сан |
| GABV | Үнэ Цэнт Банкны Үйлчилгээ Үзүүлэх Дэлхийн Эвсэл (Global Alliance for Banking on Values) |
| HKEX | Хонг Конгийн хөрөнгийн бирж (Hong Kong Exchanges) |
| IBEC | Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банк (IBEC) |
| ICBC | Industrial and Commerce Bank of China |
| IGA | АНУ-ын улс хоорондын гэрээ (Intergovernmental Agreement) |
| IPO | Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа (Initial Public Offering) |
| IRS | АНУ-ын дотоод орлогын алба (Internal Revenue Service) |
| ISO | Олон Улсын Стандартчлалын Байгууллага (International Organization for Standardization) |
| IT | Мэдээллийн Технологи (Information Technology) |
| LCR | Хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (Liquidity Coverage Ratio) |
| LSE | Лондонгийн хөрөнгийн бирж (London Stock Exchange) |
| MBA | Бизнесийн Удирдлагын Магистрын зэрэг (Master of Business Administration) |
| MFS | Монголиа Финаншл Сервиз (Mongolia Financial Services) |
| MUFG | Mitsubishi UFG |
| NBC | Канадын Үндэсний Банк (National Bank of Canada) |
| NSFR | Цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (Net Stable Funding Ratio) |
| NYSE | Нью Йоркийн хөрөнгийн бирж (New York Stock Exchange) |
| OFAC | Сангийн яамны гадаадын хөрөнгийн хяналтын газар (Office of Foreign Assets Control) |
| OFID | ОПЕК-ийн Олон Улсын Хөгжлийн Сан (OFID) |
| OPEC | Нефть Экспортлогч Улсуудын Байгууллага (Organization for the Petroleum Exporting Countries) |
| ORIX | Орикс Корпораци (ORIX) |

ХАС
УХН4937 2576697

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| PCI DSS | Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын стандарт (Payment Card Industry Data Security Standard) |
| Proparco | Францын Хөгжлийн Агентлаг |
| ROE | Өөрийн хөрөнгийн өгөөж (Return of Equity) |
| Ronoc | Ронок Партнерс (Ronoc) |
| RTGS | Банксүлжээ (Real-Time Gross Settlement) |
| SAP | Хялбаршуулсан батлах үйл явц (Simplified Approval Process) |
| SMBG | Sumitomo Mitsui Banking Group |
| SWIFT | Дэлхий нийтийн банк хоорондын санхүүгийн харилцаа холбооны нийгэмлэг (Society for Worldwide Interbank Financial Telecommunications) |
| Triodos | Триодос Файр Шэйр Фонд (Triodos) |
| ААН | Аж ахуйн нэгж |
| Актив | Хөрөнгө |
| АНУ | Америкийн Нэгдсэн Улс |
| АХБ | Азийн Хөгжлийн Банк (Asian Development Bank) |
| ББСБ | Банк Бус Санхүүгийн Байгууллага |
| БЖДҮ | Бичил, жижиг, дунд, үйлдвэрлэл |
| БНСУ | Бүгд Найрамдах Солонгос Улс |
| БНУУ | Бүгд Найрамдах Унгар Улс |
| БНХАУ | Бүгд Найрамдах Хятад Ард Улс |
| БҮС | Банкны Үндсэн Систем |
| БҮЦАА | Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн ашиг, алдагдал |
| БҮЦБДО | Бодит үнэ цэнийн өөрчлөлтийн бусад дэлгэрэнгүй орлого |
| ГВАН | Гадаад валютын албан нөөц |
| ГШХО | Гадаадын шууд хөрөнгө оруулалт |
| ДНБ | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн |
| ЕБС | Ерөнхий боловсролын сургууль |
| ЕОДА | Европ Ойрх Дорнод Африк |
| ЕСБХБ (EBRD) | Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (European Bank for Reconstruction and Development) |
| ЕХ | Европын Холбоо |
| ЖДҮ | Жижиг дунд үйлдвэрлэл |
| ЗГҮЦ | Засгийн газрын үнэт цаас |
| ЗХУ | Зөвлөлт Холбоот Улс |
| ИЗБҮЦ | Ипотекийн зээл барьцаалсан үнэт цаас |
| КтХ | Компанийн тухай Хууль |
| МАК | Монголын Алт (МАК) ХХК |
| МБ | Монголбанк |
| мВт | милливатт |
| МВт | мегаватт |
| МИАТ | Монголын Иргэний Агаарын Тээвэр |
| МУ | Монгол Улс |
| МУИС | Монгол Улсын Их Сургууль |
| МХБ | Монголын Хөрөнгийн Бирж |
| НҮБ | Нэгдсэн Үндэсний Байгууллага |
| ОУВС | Олон Улсын Валютын Сан |
| ОУСК (IFC) | Олон Улсын Санхүүгийн Корпораци (International Finance Corporation) |
| ОХУ | Оросын Холбооны Улс |

ХАСБАНК
УХН4937 2578697

СЗХ
он сар өдөр
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| ӨБҮХХ | Өмчлөх бус үл хөдлөх хөрөнгө |
| Пассив | Өр төлбөр |
| ПОС (POS) | ПОС терминал (Point of Sale) |
| СЗХ | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| СТБЗ | Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөл |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт |
| СЯ | Сангийн Яам |
| ТББ | Төрийн Бус Байгууллага |
| ТБҮЦ | Төв банкны Үнэт Цаас |
| ТӨХК | Төрийн Өмчит Хувьцаат Компани |
| ТСН | ТэнГэр Санхүүгийн Нэгдэл |
| ТУЗ | Төлөөлөн Удирдах Зөвлөл |
| ТХЗ | Тогтвортой Хөгжлийн Зорилтууд |
| УАНС (GCF) | Уур амьсгалын Ногоон Сан (Green Climate Fund) |
| УИХ | Улсын Их Хурал |
| ҮОУС | Үнэлгээний Олон Улсын Стандарт |
| ҮЦК | Үнэт Цаасны Компани |
| ҮЦТХТ | Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв |
| ФАТФ (FATF) | Санхүүгийн хориг арга хэмжээ авах байгууллага (The Financial Action Task Force) |
| ФМО (FMO) | Нидерландын Хөгжлийн Агентлаг (Nederlandse Financierings-Maatschappij voor Ontwikkelingslanden N.V.) |
| ХДК | Хадгаламжийн Даатгалын Корпораци |
| ХХК | Хязгаарлагдмал Хариуцлагатай Компани |
| ЭБХ | Эко Банкны Хэлтэс |
| ЭХХ | Эрчим хүчний хэмнэлттэй |

ХАСБАНК
УХН 1937 2578697

# Нэг. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## 1.1 ХасБанкны товч түүх

ХасБанк нь 2001 онд Монгол улсын хоёр томоохон банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болох “Говийн Эхлэл” ХХК болон “Х.А.С” ХХК-иуд нэгдэн, мөн оны 12 сарын 27-ны өдөр Монголбанкнаас арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар “Зөв Банк, ХасБанк” уриан дор иргэдэд бичил зээл олгох, санхүүгийн үйлчилгээг бүх нийтэд хүртээмжтэй хүргэх зорилготойгоор банкны үйл ажиллагаагаа эхлүүлсэн. Анх 17 ажилтан, 1 сая ам.долларын гарааны хөрөнгөтэй бизнесээ эхлүүлж байсан бол өдгөө ХасБанкны үйл ажиллагаа өргөжин тэлж 3.9 их наяд төгрөгийн активтай, 1,323 ажилтантай Монгол Улсын системийн нөлөө бүхий банкуудын нэг болсон байна.

Зураг 1: Түүхэн замнал




Компанийн засаглал, нийгмийн хариуцлагын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээрээ салбартаа жишиг тогтоож буй ХасБанк нь Эх дэлхий, Эрдэнэт хүмүүн, Эрүүл ашгийг эрхэмлэсэн, санхүүгийн зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ тэргүүлэгч банк байх эрхэм зорилгыг өмнөө тавин Монгол орон даяар 71 салбар тооцооны төв, 6,700 гаруй мерчант сүлжээ, 360 гаруй АТМ-аар дамжуулан үйл ажиллагаа явуулж, 1 сая харилцагчдадаа банкны үйлчилгээг хүргэж байна.

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Зураг 2: Онцлох үйл явдлууд

## Онцлох үйл явдлууд

**2001**

2001.12.27-нд ХасБанк арилжааны банкны зөвшөөрлөө авав.



**2002**

МУ-д анх удаа хүүхдэд зориулсан Ирээдүйн саятан хадгаламжийг нэвтрүүллээ.

**2003**

400 гаруй ажилтандаа хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр, тэтгэврийн нэрийн дансны үйлчилгээг нэвтрүүллээ.

**2004**

ХҮЛЭГҮҮД

Хасын хүлэгүүд сагсан бөмбөгийн багийг байгуулж, тасралтгүй 19 жил дэмжиж байна. Тус баг нийт 7 удаа дээд лигийн аварга болсон.

**2006**

Монголд анх удаа бүрэн интерактив ажиллагаатай 1888 дуудлагын төвийг байгуулав.

Заалны хөлбөмбөгийн "Дуулиан-2020" тэмцээнийг санаачлан зохион байгуулж эхэллээ.

**2009**



Хүүхэд залууст санхүүгийн боловсрол олгох тэмүүлэл, Афлатон хөтөлбөрүүдийг хэрэгжүүлж эхэлсэн нь өдгөө ЕБС-ийн хичээлд ороод байна.

АМАР Мобайл банкны үйлчилгээг зах зээлд нэвтрүүлж, гар утсаараа банкны үйлчилгээ авах боломжтой боллоо.

**2010**

Эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нийлүүлж, агаарын бохирдлыг бууруулах зорилгоор эко зээл олгож эхэллээ.



**2011**

Микро Энержи кредит байгууллагаас хүлэмжийн хий бууруулсны нөхөн төлбөр авсан анхны банк боллоо.

microenergy credits

**2012**

1 сая ам.долларын хөрөнгөтэй эхэлсэн төсөл 1 тэрбум ам.долларын активтай системийн 4 дэх том банк боллоо.




**2013**

Хүлэмжийн хийг бууруулах бизнесийн зээлийн хөтөлбөрийг эхлүүлэв. Энэ хугацаанд 2.1 сая тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулаа.

Мэдээллийн аюулгүй байдлын олон улсын ISO 27001 стандартыг Банкны салбартаа анх удаа нэвтрүүллээ.

**2014**

АХБ-аас 30 сая ам.доллар, OPEC-ийн Олон Улсын Хөгжлийн Сангаас 20 сая ам.долларын санхүүжилт амжилттай татав.

Банкны үндсэн системээ амжилттай шинэчилж, Flexcube системийг шилжлээ.

ХАСБАНК
УХН4937 2578697

СЗХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

**2015**

Брэндийн шинэчлэлт хийж, харилцагч төвтэй үйлчилгээг үзүүлэн, насан туршийн банк байх зорилгыг тодорхойлов.



Төлбөрийн картын системээ бүрэн шинэчилж, Картын процессингийн төвийг байгууллаа.

Харилцагчийг хамгаалах зарчмуудыг хангасан МУ-ын анхны банк хэмээн үнэлэгдэж, батламж авлаа.

**2016**

ОУ-ын стандартын Tier 2 шаардлагыг хангасан дата төвийг байгууллаа.

НҮБ-ын Уур амьсгалын ногоон сангаас магадлан итгэмжлэгдсэн Үндэсний Хэрэгжүүлэгч Байгууллага боллоо.




IFC, FMO зэрэг 8 байгууллагаас 108.5 сая ам.долларын санхүүжилт татсан нь тухайн үедээ арилжааны нэг банканд олгогдсон хамгийн том синдикат санхүүжилт болж байв.

**2017**

Төлбөрийн картын мэдээллийн аюулгүй байдлын PCI DSS стандартын шаардлагыг бүрэн хангалаа.



АТМ-ийн бүх үйлчилгээ болон интернэт банкаар ХасБанкны данс хооронд хийх гүйлгээний шимтгэлүүдийг тэглэлээ.




Уур амьсгалын ногоон сангаас 20 сая ам.долларын эх үүсвэр татаж сэргээгдэх эрчим хүчний төслүүдийг санхүүжүүлэв.

**2018**

Арилжааны банкнуудад хийгдсэн Активын чанарын үнэлгээнд ХасБанк хамгийн сайн гүйцэтгэл үзүүллээ.

EBRD-аас 40 сая ам.доллар, GCF-ээс 17.6 сая ам.долларын санхүүжилт авлаа.

Технологид суурилсан санхүүгийн үйлчилгээ үзүүлэх бизнесүүдийг дэмжин, нээлттэйгээр хамтран ажиллаж эхэллээ.




**2019**

ХасБанк, УАНС-ийн эх үүсвэрээр санхүүжүүлсэн 10 мегаваттын Нарны цахилгаан станц Говьсүмбэр аймагт ашиглалтад орлоо.



IFC-аас 65 сая ам.доллар, ADB-аас 30 сая ам.долларын санхүүжилт татлаа.

**2020**

Ковид 19-ийн улмаас зээлийн эргэн төлөлтөд нь хүндрэл учирсан харилцагчдынхаа зээлийн гэрээний нөхцөлд өөрчлөлт оруулла.

Нидерландын Хөгжлийн Агентлагаас 100 сая ам.долларын хамтын санхүүжилт авлаа.

FMO
Entrepreneurial Development Bank

**2021**

ХасЛизинг компани ХасБанктай нэгдлээ.

ХасБанк шинэчлэгдлээ. Дижитал банкаа улам сайжруулан, шинэлэг үйлчилгээ, шинэ өнгө төрхтэйгээр танилцууллаа.



"Бизнесийг дэмжих саруул"-г зарлан орон даяар хэрэгжүүлснээс гадна ажлын байрыг дэмжих 3%-ийн хүүтэй зээлийн хөтөлбөрт нэгдэж бичил, жижиг дунд бизнес эрхлэгчдийг дэмжлээ.



**2022**



НҮБ-ын Уур Амьсгалын Ногоон Сангийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэгдлээ.



МУ-д анх удаа хүүхдэд зориулан гаргасан Ирээдүйн саятан хадгаламж 20 нас хүрлээ.

Цахим шилжилтийн хүрээнд үндсэн системээ шинэчлэн сайжруулж, дэлхийн мэдээллийн технологийн салбарт тэргүүлэгч Инфосис компанийн Финакл системийг амжилттай нэвтрүүллээ.

ХАСБАНК
2578697

СЗХ 2023 .05. 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

## 1.2 Алсын хараа, Эрхэм зорилго

ХасБанк нь иргэд, аж ахуйн нэгжүүдэд санхүүгийн хүртээмжтэй үйлчилгээг түргэн шуурхай үзүүлж, Монгол Улсынхаа нийгэм, эдийн засагт хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Ингэхдээ бид бүтээмжтэй, тогтвортой өсөлт бүхий санхүүгийн байгууллагыг бий болгож харилцагч, ажиллагчид, түншүүд болон хувьцаа эзэмшигчдийн үнэ цэнийг ямагт өсгөх зорилготой ажиллаж байна.

*Зураг 3: Хэтийн зорилт, Эрхэм зорилго, Үнэт зүйлс*

| Хэтийн Зорилт | Эрхэм Зорилго | Бидний Үнэт Зүйлс |
|---|---|---|
| Бид Монголдоо дэлхийн түвшний санхүүгийн үйлчилгээтэй байгууллага болно. | Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашгийг эрхэмлэн харилцагчиддаа үнэ цэнтэй санхүүгийн үйлчилгээг хүргэж, насан туршийн түнш нь байх болно. | Хүртээмжтэй, Санаачилгатай, Нийгмийн хариуцлагатай, Харилцагч төвтэй, Эрч хүчтэй, Мэргэжлийн. |

## 1.3 Үнэт цаас гаргагчийн хууль ёсны бүртгэл, хаяг

Хүснэгт 2: Үнэт цаас гаргагчийн хууль ёсны бүртгэл, хаяг

| | |
|---|---|
| **Компанийн гэрчилгээ гарсан огноо:** | 2001 оны 12-р сарын 28 |
| **Регистрийн дугаар:** | 2578697 |
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 9016001007 |
| **Бүртгэлтэй хаяг:** | Монгол Улс, Улаанбаатар хот 14200, Ерөнхий сайд Амарын гудамж, ХасБанкны байр, Шуудангийн салбар 46, Шуудангийн хайрцаг 721, |
| **Монголбанкнаас олгогдсон тусгай зөвшөөрлүүд:** | 1) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 610 тоот тушаалаар “Мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл”, “Гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах зөвшөөрөл, Үнэт зүйл хадгалах зөвшөөрөл, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх”;<br>2) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2002 оны 512 тоот тушаалаар “Гадаад төлбөр тооцоо эрхлэх энгийн зөвшөөрөл”;<br>3) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 424 тоот тушаалаар “Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагааг эрхлэх нэмэлт зөвшөөрөл,” “Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах зөвшөөрөл”;<br>4) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 354 тоот тушаалаар “Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл”<br>5) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-258 тоот тушаалаар “Үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах” зөвшөөрөл;<br>6) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-107 тоот тушаалаар “Зээл болон санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах нэмэлт зөвшөөрөл”;<br>7) Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-334 тоот тушаалаар “Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл”, нийт 11 төрлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан. |

ХАСБАНК
УЧН 2578697

СЗХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| СЗХ-ноос олгогдсон тусгай зөвшөөрлүүд: | 8) Санхүүгийн Зохицуулах Хорооны 2012 оны 386 тоот тушаалаар “Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл”. |

## 1.4 ХасБанкны хувьцаа эзэмшигчийн бүтэц

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (цаашид “ТСН” гэх, регистрийн дугаар 2595788) нь Үнэт цаас гаргагчийн нийт энгийн хувьцааг 100% эзэмшдэг хөрөнгө оруулалтын толгой компани юм. ТСН нь 2022 оны 11 дүгээр сарыг хүртэл Банк, Даатгал болон Үнэт цаас, брокерын компаниудын хувьцааг 100% эзэмшиж байсан бөгөөд Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн хүрээнд хэрэгжүүлж буй компанийн бүтцийн өөрчлөлтийн төлөвлөгөөний дагуу Даатгал болон Үнэт цаас, брокерын компаниудаа гуравдагч этгээдэд бүрэн шилжүүлснээр энэхүү Танилцуулгыг боловсруулах үеийн байдлаар ТСН зөвхөн ХасБанкны 1,000,000,000 ширхэг хувьцааг (100%) эзэмшиж байна.

ТСН нь Монгол Улсын хуульд заасан энгийн хувьцаа эзэмшихтэй холбоотой эрх үүргийг өөрийн хувьцаа эзэмшигчдийн өмнөөс хэрэгжүүлдэг. ТСН нь олон улсын санхүүгийн байгууллагууд, олон улсын болон дотоодын компаниуд, хөрөнгө оруулалтын сангууд, хувь хүмүүсээс бүрдсэн нийт 12 хувьцаа эзэмшигчидтэй болно. Үнэт цаас гаргагчийн дүрмийн дагуу эцсийн хувьцаа эзэмшигчид болох ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нь ХасБанкны Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд шууд төлөөлөлтэй байдаг. ТСН-ийн хувьцаа эзэмшигчид нь энэхүү үнэт цаасны танилцуулга бэлдэх үеийн байдлаар дараах байдалтай байна.

Хүснэгт 3: ТСН-ийн Хувьцаа эзэмшигчдийн жагсаалт

| ТСН ХХК-ийн хувьцаа эзэмшигчид | Улс | Хөрөнгө оруулсан он | Хувьцааны эзэмшлийн хувь |
|---|---|---|---|
| Монголын Алт (МАК) ХХК | Монгол* | 2013 | 20.00% |
| Олон Улсын Санхүүгийн Корпорац (IFC) | Олон Улс | 2007 | 17.17% |
| ОРИКС Корпораци (ORIX) | Япон | 2013 | 16.81% |
| Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD) | Олон Улс | 2007 | 12.91% |
| Канадын Үндэсний Банк (NBC) | Канад | 2015 | 10.52% |
| Ронок Партнерз (Ronoc) | Унгар** | 2008 | 10.15% |
| Монголия Файненшл Сервизис (MFS) | Сингапур | 2013 | 6.63% |
| Триодос Фэйр Шэйр Фанд (Triodos) | Голланд | 2004 | 3.73% |
| Нээлттэй Нийгэм Хүрээлэн ТББ*** | Монгол | 2001 | 1.59% |
| Улаанбаатар Ротари Клуб ТББ*** | Монгол | 2001 | 0.30% |
| Магваны Болдоо | Монгол | 2010 | 0.10% |
| Чулууны Ганболд | Монгол | 2011 | 0.09% |
| **НИЙТ** | | | **100.00%** |

* Монголын Алт (МАК) ХХК-ийн өөрчлөн байгуулалт дууссаны дараа тус хувьцаа эзэмшигч нь ТСН ХХК-ийн хувьцааг Унгар Улс дахь өөрийн 100% эзэмшлийн охин компаниар дамжуулан үргэлжлүүлэн эзэмших болно. Энэхүү өөрчлөн байгуулалттай холбоотой зөвшөөрөл Монголбанкнаас хүлээгдэж байгаа болно.
**Тус хувьцаа эзэмшигчийн харьяалал Унгар Улс руу шилжиж байгаа бөгөөд Танилцуулга бэлдэх үеийн байдлаар Монголбанкнаас зөвшөөрөл хүлээгдэж байгаа болно.
***Компаний тухайн хуулийн 20-р зүйлийн дагуу ХасБанк болон ТСН-ийг нэгтгэх төлөвлөгөөний хүрээнд тус хоёр ТББ нь ТСН-ийн хувьцаа эзэмшлээс гарахаар төлөвлөж/ажиллаж байгаа болно.

Монгол Улсын Их Хурал 2021 оны 1 дүгээр сарын 28-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан бөгөөд тус хууль нь 2021 оны 2 дугаар сарын 25-ны өдрөөс хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь арилжааны банкны өмчлөлийн төвлөрлийг сааруулах замаар өмчлөгч болон удирдлагын хувьд хяналтын тэнцвэрт байдлыг хангах боломжтой болно гэж хууль тогтоогчдоос үзэж байгаа болно. ХасБанк нь Банкны тухай хуулийн дагуу хувьцааны эзэмшлийн дээд хязгаар 20% байх шаардлагыг шууд хувьцаа эзэмшлийн хувьд хангахгүй байгаа хэдий ч эцсийн өмчлөгч буюу ТСН-ийн хувьцаа эзэмшлийн хувьд хангаж байгаа Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа цорын ганц Банк юм.

ХАСБАНК
2578697

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-05-05
БҮРТГЭВ-02

Компанийн тухай хуульд заасанаар гаргасан хувьцааны 5% (хувь) ба түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч нь нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид тооцогддог бөгөөд ТСН нь ХасБанкны хувьцааг дангаар 100% эзэмшиж байгаа тул нөлөө бүхий хувьцаа эзэмшигч юм. Мөн ТСН-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 4: ТСН ХХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид

| | |
|---|---|
| MAK | Монголын Алт (МАК) ХХК нь ТСН-ийн 20.00% (хувь)-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд үндэсний хөрөнгө оруулалттай, геологи, уул уурхай, барилгын материал, үл хөдлөх хөрөнгө, зочид буудал, агаарын тээвэр, хөдөө аж ахуй, хөрөнгө оруулалтын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын тэргүүлэгч компаниудын нэг юм. МАК нь нүүрсний экспортоор эхний 2-т ордог ба Монгол улсын 3 дахь том зэсийн ордыг хөгжүүлж байна. Мөн түүнчлэн МАК нь Монгол Улсын хамгийн том цементийн үйлдвэрийг ажиллуулдаг ба дотоодын хөрөнгө оруулалттай компани юм. |
| IFC | Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) нь ТСН-ийн 17.17% (хувь)-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд 1956 онд Бретон Вуудзийн гэрээгээр байгуулагдсан 185 улс орны гишүүнчлэлтэй (Монгол Улс 1991 оны 2 дугаар сард гишүүнээр элссэн), Дэлхийн Банкны Группийн гишүүн, хувийн хэвшлийг дэмжих зорилгоор үйл ажиллагаа явуулдаг олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. |
| ORIX | ORIX Корпорац нь ТСН-ийн 16.81% (хувь)-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд Япон улсад төвтэй банк, санхүү, лизинг, даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, 1964 онд байгуулагдсан, 36 мянга гаруй ажилтантай, дэлхийн 37 оронд салбартай, Нью-Йорк, Токиогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани юм. |
| EBRD | Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD) нь ТСН-ийн 12.91% (хувь)-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд хувийн хэвшил, бизнес эрхлэгчдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий дэлхийн гурван тив, 40 гаруй оронд үйл ажиллагаа явуулж буй олон талт банк юм. EBRD нь 71 улс, Европын Холбоо, Европын Хөрөнгө Оруулалтын Банкны эзэмшилд байдаг. |
| NATIONAL BANK OF CANADA | Канадын Үндэсний Банк (NBC) нь ТСН-ийн 10.52% (хувь)-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд анх 1859 онд үүсгэн байгуулагдаж, 1979 оноос Канадын Үндэсний Банк нэртэйгээр арилжааны банкны үйл ажиллагаа явуулж буй Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Канадын Квебек мужийн Монреаль хотод төвтэй банк юм. |
| RONOC | Ронок Партнерз нь ТСН-ийн 10.15% (хувь)-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд 2007 онд Майкл Маддены үүсгэн байгуулсан, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, БНУУ-д төвтэй хөрөнгө оруулалтын сан юм. |
| MONGOLIA OPPORTUNITIES PARTNERS | Монголия Файненшл Сервисиз (MFS) ТСН-ийн 6.63% (хувь)-ийн хувьцаа эзэмшигч бөгөөд Монголиа Опортунитиз Фанд ХХК-ийн Сингапур улсад үүсгэн байгуулсан тусгай зориулалттай компани юм. |

## 1.5 Байгууллагын бүтэц

Үнэт цаас гаргагч нь компанийн сайн засаглалаар тэргүүлэгч байгууллагын хувьд олон улсын жишигт нийцсэн бүтэц зохион байгуулалттайгаар үйл ажиллагаагаа удирдан зохион байгуулж байна.

ХАСБАНК
УХН 1937 2578697

Зураг 4: Байгууллагын бүтэц




## 1.6 Төлөөлөн Удирдах Зөвлөл

ХасБанкны Төлөөлөн Удирдах Зөвлөл (цаашид “ТУЗ” гэх) нь нийт 12 гишүүнтэй байхаар зохион байгуулагдсан бөгөөд аль нэг хувьцаа эзэмшигчтэй харилцан хамааралгүй ТУЗ-ийн даргаас гадна хараат бус дөрвөн ТУЗ-ийн гишүүний орон тоотой. ТУЗ-ийн гишүүнийг хувьцаа эзэмшигчдийн хурлаас 2 жилийн хугацаатай сонгодог бөгөөд улиран сонгогдох боломжтой байдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааг Банкны дүрэм болон ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмаар зохицуулж байна. Үнэт цаасны танилцуулга бэлдэх өдрийн байдлаар үнэт цаас гаргагчийн ТУЗ-д дараах гишүүд ажиллаж байна.



**Санжай Гупта**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга**

Санжай Гупта нь 2017 оны 3 дугаар сараас ХасБанкны Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн гишүүнээр, 2019 оны 3 дугаар сараас ТУЗ-ийн даргаар томилогдон ажиллаж байна. Тэрээр Дели дэх Сэинт Стивинг коллежийг Физикийн шинжлэх ухааны бакалавр, Дели Их Сургуулийн Менежментийн факультетыг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 1981 оноос 2001 оны хооронд БНЭУ, Англи болон ХонгКонг дахь Банк оф Америка банкинд хэдэн хэдэн чухал албан тушаал хашиж байсныг дурдвал, Байгууллагын банк хариуцсан захирал, Энэтхэг дэх Файнэншл Институшнс Групп хариуцсан захирал, Европ, Ойрх Дорнод, Африкийн (ЕОДА) Эрсдэлийн удирдлага хариуцсан захирал, ЕОДА-ийн Стракчард Кредит Группийн гүйцэтгэх захирал, Ази дахь Инвестмент Банкинг Группийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байжээ. 2001 оноос 2005 оны хооронд тэрээр Кредит Лионассд Ази, Номхон далайн бүсийн Байгууллагын Зээл хариуцсан захирлаар ажиллаж байсан. Мөн тэрээр 2006 оноос 2015 оны хооронд Кредит Агриколь Группэд Ази дахь зээлийн дахин санхүүжилт хариуцсан захирал Глобал Энержи Группийн Ази хариуцсан захирал зэрэг албан тушаал хашиж байсан арвин туршлагатай Банкир юм.

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02



**Гүмэнжавын Цэвэгжав**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Гүмэнжавын Цэвэгжав нь 2019 оны 5 дугаар сараас ХасБанк болон Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Гүйцэтгэх захирал болон ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр 2011 оноос өнөөг хүртэлх хугацаанд ХасБанкинд Ерөнхий захирал, Иргэдийн банк хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, ХасЛизинг ХХК-д Гүйцэтгэх захирал, Тэнгэр Даатгал ХХК-д ТУЗ-ийн дарга, Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д Санхүү хариуцсан захирал зэрэг албан тушаалуудад тус тус ажиллаж байсан. Г.Цэвэгжав нь АНУ дахь томоохон компаниудад ажиллаж байсан туршлагатай. Тэрээр АНУ-ын "Колорадогийн Их Сургууль"-г Бакалавр, "Рэжис Их Сургууль"-г Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн.



**Нямтайширын Цэлмүүн**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Нямтайширын Цэлмүүн нь 2012 оноос Монголын Алт (МАК) Корпорациас нэр дэвшиж ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр МАК корпорацын Ерөнхийлөгч/Гүйцэтгэх захирлын албан тушаал хашдаг бөгөөд олборлох үйлдвэрлэл, барилгын материал боловсруулах болон агаарын тээврийн салбарт хөрөнгө оруулалт, бизнесийн өргөн мэдлэг, туршлагатай. Н.Цэлмүүн нь АНУ-ын Индиана мужийн Валпараисо Их Сургуулийг Бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн бөгөөд санхүүгийн инженерингийн чиглэлээр Стэнфордын Их Сургуулийн Хонгконг гэрчилгээт сургалт, Харвардын Бизнесийн сургуулийн хөтөлбөрүүдэд тус тус суралцсан.



**Майкл Мадден**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Майкл Мадден нь 2009 оноос Ронок Партнерзаас нэр дэвшиж ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүү, олон улсын төлбөр тооцооны салбарт нийт 30 гаруй жил ажилласан туршлагатай. Түүний амжилт түүний бүтээлч сэтгэлгээ, манлайлал, олон улсын түншүүдтэй харилцах болон зөвшилцөлд хүрэх чадварт нь тулгуурлан бий болжээ. Тэрээр иргэдийн банк, картын болон дижитал төлбөр тооцооны өргөн мэдлэгтэй, хөгжиж буй эдийн засаг бүхий улс орнуудад хэрэгжүүлсэн хөрөнгийн оруулалтын туршлагатай. Мөн тэрээр АНУ-д санхүүгийн зөвлөгөө үзүүлэгч "Тенео" компанид Санхүүгийн зөвлөх, ТУЗ-ийн даргын албан тушаалыг 2011 оноос хойш хашиж байна. Тэрээр 2008 онд хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа явуулдаг Ronoc компанийг үүсгэн байгуулсан ба тус компанийн гүйцэтгэх партнерийн үүрэг гүйцэтгэдэг. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох Ронок Партнерзаас нэр дэвшин ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр хамгийн урт хугацаанд ажиллаж буй болно. Мөн тэрээр цахим төлбөр тооцооны чиглэлээр зах зээлдээ тэргүүлж буй ОнГөү компанийг Мянмар Улсад үүсгэн байгуулсан ба тус компанийн ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.

ХАСБАНК

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

2003 онд Ренайссанс Капитал группийг үүсгэн байгуулахад гар бие оролцож Ренайссанс Кредитийг үүсгэн байгуулагч, гүйцэтгэх захирлаар ажилласан бөгөөд тус компанийг ОХУ-ын хамгийн том хэрэглээний санхүүжилтийн компани болгон өргөжүүлж чаджээ. Өмнө нь тэрээр Американ Экпресс санхүүгийн байгууллагын Ирланд дахь салбарт хэд хэдэн албан тушаал хашиж, ОХУ-д карт нутагшуулах ажлыг гардан гүйцэтгэж, хамгийн сүүлдИх Британид дэд ерөнхийлөгч, Европ, Ойрх Дорнод, Африкийн франчайз хариуцсан захирлын албан тушаал хашиж байсан.



**Ив Жако**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Ив Жако нь 2016 онд Нэйшнл Банк оф Канада (Канадын үндэсний банк)-аас нэр дэвшиж түүнээс хойш ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр Франц улсын И Эс Эс И Си их сургуулийн дипломтой бөгөөд АНУ-ын Вартон сургуульд санхүүгийн чиглэлээр докторын ухааны зэрэг хамгаалахаар тэтгэлэгт хамрагдсан. Тэрээр банкны салбарт тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд Эй Экс Эй Групп болон Бред Банк Групп зэрэг томоохон банк санхүүгийн байгууллагуудад ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал, дэд захирлын албан тушаалд ажиллаж байсан. Тэрээр иргэдийн банк, хөрөнгийн зах зээл, хөрөнгө зохицуулалт, байгууллагын банк, хөрөнгийн удирдлага зэрэг чиглэлээр ажиллаж байсан туршлагатай. Өдгөө тэрээр Канадын үндэсний банкны тэргүүн дэд ерөнхийлөгч, Эй Би Эй Банк , Эй Ти Эй Ай Ти, Наткан Интенейшнл зэрэг байгууллагуудын ТУЗ-ийн даргаар ажиллаж байна.



**Анджей Витак**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Анджей Витак нь 2019 оноос Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)-с нэр дэвшиж, ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүүгийн салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай нэгэн бөгөөд Украин, Узбекистан зэрэг улс дахь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-ийн суурин төлөөлөгч, орлогчоор ажиллаж байсан. Мөн тэрээр ОХУ, Польш, Монгол, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд болон зүүн Европын улс орнууд дахь байгууллагуудад ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан. Одоогоор чанаргүй актив, эрсдэлтэй зээлийн удирдлагын чиглэлээр хэрэгжүүлж буй ЕСБХБ-ны төслүүдэд бие даасан зөвлөхөөр ажиллаж байна. Анджей Витак нь Польш улсын Силезиа их сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

ХАСБАНК



**Албертус Браггинк**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Албертус Браггинк нь 2020 онд Орикс Корпорациас нэр дэвшин ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Албертус Браггинк нь Нидерландын хамгийн том санхүүгийн байгууллага болох Рабобанкинд 30 гаруй жил ажилласан туршлагатай мэргэшсэн банкир юм. Тэрээр 2004-2016 оны хооронд тус банкинд гүйцэтгэх удирдлагын төвшинд санхүү болон эрсдэлийн удирдлага чиглэлээр ажиллаж байсан. Одоо тэрээр Орикс Корпорацийн ТУЗ-ийн зөвлөхөөр ажиллахаас гадна Нидерландын болон бусад улс орны томоохон байгууллага, компаниуд ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. Албертус Браггинк нь Нидерландын Твенте их сургуулийн Бизнесийн удирдлагын магистр болон докторын зэрэгтэй.



**Сюзана Херринг Карр**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**

Сюзана Херринг Карр нь 2022 онд ОУСК-с нэр дэвшиж ХасБанкны ТУЗ-д томилогдон ажиллаж байна. Тэрээр хөгжиж буй санхүүгийн зах зээлд 30 гаруй жил ажилласан туршлагатай юм. Тэрээр хөрөнгө оруулалтын бүтэц, багцын удирдлага, зээлийн бодлого, хөгжлийн нөлөөлөл хэмжилт, компанийн засаглал зэрэг өргөн хүрээний асуудлаар арвин туршлагатай. Тэрээр өмнө нь Бүгд Найрамдах Серби улсад төвтэй ПроКредит Банк болон Люксембургт төвтэй Бичил Санхүүжилтийг Сайжруулах Хөтөлбөр зэрэг байгууллагуудад ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан. Мөн 1996-2016 оны хооронд ОУСК-д удирдах албан тушаалуудад ажиллаж байсан. Тэрээр Дьюкийн их сургуулийг Эдийн засгийн чиглэлээр бакалаврын зэрэгтэй төгссөн.



**Баянсаны Уламбаяр**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

Баянсаны Уламбаяр нь 2015 оноос эхлэн ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр ажиллаж байна. Тэрээр өмнө нь Токио хотод Лиман Бродерс болон Номура Секьюритис зэрэг хөрөнгө оруулалтын банкуудад ажиллаж байсан ба Монголд эргэн ирээд Дрэйпер Капитал болон Композит Капитал зэрэг хөрөнгө оруулалтын сангуудад зөвлөх болон Монголын талыг хариуцсан захирлаар ажиллаж байсан. Мөн богино хугацаанд Алтай Холдинг группийн гүйцэтгэх захирлаар ажилласан. Б.Уламбаяр нь хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр ажиллахаас өмнө Японы Сони корпорацид судалгаа хөгжүүлэлтийн инженерээр ажиллаж байсан туршлагатай. Б.Уламбаяр нь Токиогийн Технологийн Их Сургуулийг электроникийн инженерингийн бакалавр, магистрын зэрэгтэй төгссөн. Мөн АНУ-ын Чикагогийн Их Сургуулийн Бизнесийн сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж, магистрын зэрэг хамгаалсан.

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02



**Нираж Вэдва**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

Нираж Вэдва нь 2018 оноос эхлэн ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр 36 жилийн турш банкны салбарт мэдээллийн технологийн чиглэлээр удирдлагын түвшинд ажилласан туршлагатай. Нираж Вэдва нь Тек Махиндра (Энэтхэг Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй бөгөөд технологийн чиглэлээр дэлхийн Топ 20-д багтдаг компани), Швейцар Улсын Темонос (банкны программ хангамж чиглэлээр дэлхийд тэргүүлэгч) болон Нуклеус Софтвэр (зээлийн программ хангамж чиглэлээр тэргүүлэгч улс дамнасан компани) зэрэг компаниудад ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2019 оны 6 дугаар сард мэдээлэл технологийн зөвлөх үйлчилгээний чиглэл бүхий Акселерик ЭфЗикомпанийг Арабын Нэгдсэн Эмират улсад байгуулсан бөгөөд тус компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Мөн тэрээр технологийн компаниудад зөвлөх албан тушаал хашдаг байна. Нираж Вэдва нь “Дели их сургууль”-ийн бакалавр зэрэгтэй, “Индира Гандигийн нэрэмжит их сургууль”-ийг магистрын зэрэгтэй төгссөн.



**Эрик Версавел**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

Эрик Версавел нь 2022 оноос эхлэн ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр 40 гаруй жил Брюссель ламберт банк болон ING Банкинд ажилласан бөгөөд үүний 30 гаруй жилд удирдах албан тушаал хашиж байжээ. 1998 оноос ING банкны Индонез дахь PT Индонез ING Банкинд захирлаар ажиллаж байсан бол 2000 оноос хойш ING Банкны Хятад, Солонгос, Украйн зэрэг улсыг хариуцсан захирлаар, мөн Монгол Дахь ING-ийн суурин төлөөлөгчөөр тус тус ажиллаж байв. Эрик Версавел нь ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр сонгогдох хүртлээ Тэнгэр Даатгал ХХК-ийн хараат бус гишүүнээр 2019-2022 оны хооронд ажиллаж байсан. Тэрээр Бельги улсын Антверпенийн их сургуулийг Хууль зүйн ухааны Магистрын зэрэгтэй төгссөн. Мөн тэрээр Сингапурын удирдлагын их сургуулийн Сингапурын ТУЗ-ийн гишүүдийн институтийн дипломтой бөгөөд компанийн засаглал, зээлийн бүтцийн өөрчлөлт, уналттай зах зээл чиглэлээр мэргэшсэн банкир юм.



**Ами Чой**

**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**

Ами Чой нь 2023 оноос эхлэн ХасБанкны ТУЗ-ийн хараат бус гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр 1994 оноос банк, санхүүгийн салбарт буюу ХонгКонг дахь “Ситибанк”-нд системийн хөгжүүлэлтийн менежерээр ажлын гараагаа эхлүүлсэн бөгөөд тус банкны иргэдийн банк, цахим банкны асуудал хариуцсан дэд захирал хүртэл дэвшин нийт 26 жил ажиллажээ. Түүнчлэн, “Гуанжу дахь Хятадын Гуангфа банк”, “Шинжен дэх Пинг Ан Банк”, “Шанхай дахь Зүүн ази (Хятад)-ийн банк”2-нд тус тус иргэдийн банк, цахим банкны асуудал хариуцсан дэд захирал зэрэг удирдах албан тушаалтнаар ажилласан туршлагатай.

ХАСБАНК
УХН 1937 2578697

Банкны салбарт ажиллаж эхлэхээс өмнө тэрээр 16 жил IT салбарт буюу “АйБиЭм”-д банк даатгалын салбарын системийн автоматжуулалт чиглэлээр ажилласан туршлагатай. Тэрээр “Хонк Конгийн Политехникийн их сургууль” болон “Лондонгийн Сити их сургууль”-г мэдээллийн системийн шинжилгээ, дизайны чиглэлээр магистрын зэрэгтэй төгссөн байна.

## 1.7 Гүйцэтгэх Удирдлага

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагыг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Банкны дүрмийн дагуу ТУЗ-аас томилсон Гүйцэтгэх Захирал хэрэгжүүлдэг. Мөн Банкны өдөр тутмын үйл ажиллагааг үр ашигтай, өндөр хяналттай зохион байгуулах зорилгоор Гүйцэтгэх Захирал нь өөрийн удирдлага доор гүйцэтгэх удирдлагын багийг томилон ажиллуулж байна. Банкны удирдлага нь өөрийн ажил үүргээ гүйцэтгэхдээ харилцагчид, хадгаламж эзэмшигчид, ажиллагчид, хувьцаа эзэмшигчид болон хамтран ажилладаг байгууллагуудын эрх ашгийг нэн тэргүүнд тавин ажилладаг.

Гүйцэтгэх уридлагын багт:



**Гүмэнжавын Цэвэгжав**

**Гүйцэтгэх захирал**

Г.Цэвэгжав нь 2019 оноос эхлэн ХасБанкны Гүйцэтгэх захирал, ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байна. Тэрээр 2011 оноос өнөөг хүртэлх хугацаанд ХасБанкинд Ерөнхий захирал, Иргэдийн банк хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, ХасЛизинг ХХК-д Гүйцэтгэх захирал, Тэнгэр Даатгал ХХК-д ТУЗ-ийн дарга, Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-д Санхүү хариуцсан захирал зэрэг албан тушаалуудад тус тус ажиллаж байсан. Г.Цэвэгжав нь АНУ дахь томоохон компаниудад ажиллаж байсан туршлагатай. Тэрээр АНУ-ын “Колорадогийн их сургууль”-г Бакалавр, “Режисийн их сургууль”-г Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн.



**Ганзоригийн Эрдэнэбаяр**
**Санхүү хариуцсан захирал**

Г.Эрдэнэбаяр нь 2013 оноос эхлэн ХасБанкны Санхүү хариуцсан захирлаар ажиллаж байна. Тэрээр анх 2005 онд ХасБанкнаас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд хасаг цагийн туслах ажилтан, эрсдэлийн менежер, Эрсдэлийн нэгдсэн удирдлагын газрын захирал, Санхүүгийн удирдлагын газрын захирал зэрэг албан тушаалд тасралтгүй ажиллаж байгаад тус албан тушаалд томилогдсон ХасБанкны ууган ажилтан юм. Г.Эрдэнэбаяр нь 2006 онд Санхүү Эдийн Засгийн Дээд Сургуулийг бизнесийн удирдлагын бакалавр, 2012 онд Японы Олон Улсын Их Сургуулийг Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн.



**Бавааны Еркин**

**Байгууллагын банк хариуцсан захирал**

Б.Еркин нь 2020 оноос эхлэн ХасБанкны Байгууллагын банк хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрээр ХасБанканд 2002 онд орсон бөгөөд ХасБанкны төв салбарын жижиг дунд бизнесийн зээлийн мэргэжилтнээр ажлын гараагаа эхлэн, Бизнес төвийн захирал, Байгууллагын банкны захирал зэрэг албан тушаалд тасралтгүй ажиллаж байгаа ХасБанкны ууган ажилтан юм. Б.Еркин нь 2001 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн Сургуулийг нягтлан бодогч, эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.



**Энэбишийн Уламбаяр**

**Иргэдийн банк хариуцсан захирал**

Э.Уламбаяр нь 2020 оноос ХасБанкны Иргэдийн банк хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрээр ХасБанканд 2013 оноос хойш ажиллаж байгаа бөгөөд Ерөнхий аудитор, Үйл ажиллагаа хариуцсан захирлаар тус тус ажиллаж байсан. Мөн 2013 оноос өмнө Оюу Толгой ХХК, Монгол Улсын Хөгжлийн Банк, Монголбанк зэрэг байгууллагуудад мэргэжилтнээс эхлэн удирдах албан тушаал хашиж байсан туршлагатай. Э.Уламбаяр нь МУИС-ийн Эдийн засгийн сургуулийг Банкны эдийн засагч мэргэжлээр бакалавр, Австрали улсын “Victoria University”-г Бизнесийн удирдлагын магистр зэрэгтэй төгссөн байна.



**Серыкжаны Дауренбек**

**Лизинг хариуцсан захирал**

С.Дауренбек нь 2013 оноос эхлэн Хаслизинг (2021 оны 11 дүгээр сар хүртэл Хаслизинг нь тусдаа ААН байсан)-ийн Лизинг Хариуцсан захирлаар ажиллаж байгаа. Тэрээр анх 2000 онд ХасБанкны үүсгэн байгуулагч “Хөгжлийн Алтан Сан”-д салбарын захирал, улмаар ХасБанк байгуулагдсанаар Бүсийн захирал, Зээлийн Эрсдэлийн Удирдлагын хэлтсийн захирал, Дотоод Аудитын газрын захирал зэрэг албан тушаалд ажиллаж байсан ХасБанкны ууган ажилтан юм. С.Дауренбек нь 1998 онд Монгол Улсын Их Сургуулийн Эдийн Засгийн сургуулийг Банк санхүүгийн эдийн засагч мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгссөн.

СЗХ 2023 оны 05 сарын 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02



**Илия Аврамов**

**Эрсдэл хариуцсан захирал**

Илия Аврамов нь 2019 оноос эхлэн ХасБанкны Эрсдэл хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрээр Төв болон Зүүн Европын орнууд, Зүүн Өмнөд Ази, АНУ-ын банкнуудад 23 жил ажилласан арвин туршлагатай бөгөөд Рафейзн Банк Сингапур-т Ерөнхий захирлын орлогч бөгөөд Эрсдэл хариуцсан захирлаар ажиллаж байсан. Илия Аврамов нь олон улсын мэргэшсэн нягтлан бодогч цолтой бөгөөд Төв Европын Их сургууль болон Нью-Йоркийн Их сургуулийг эдийн засгийн магистр зэрэгтэй төгссөн.



**Ганзоригийн Зул**

**Үйл ажиллагаа хариуцсан захирал**

Г.Зул нь 2020 оноос ХасБанкны Үйл ажиллагаа хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрээр анх 1999 онд ХасБанкны үүсгэн байгуулагч "Хөгжлийн Алтан Сан"-гаас ажлын гараагаа эхэлсэн бөгөөд улмаар ХасБанк байгуулагдаж Захиргаа, үйл ажиллагааны хэлтсийн захирал, Хүний нөөцийн газрын захирал, Хүний нөөц хариуцсан захирал зэрэг албан тушаалд тасралтгүй ажиллаж байгаа ХасБанкны ууган ажилтан юм. Г.Зул нь Бүгд Найрамдах Болгар улсын Софи хотын Их Сургуулийг төгссөн.



**Хүрэлбаатарын Өнөрбат**

**Мэдээллийн технологи хариуцсан захирал**

Х.Өнөрбат нь 2022 оноос ХасБанкны Мэдээллийн технологи хариуцсан захирлаар томилогдон ажиллаж байна. Тэрээр ХасБанканд 2012 оноос эхлэн Программ хангамжийн хэлтэс, газрын захирлаар тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд мэдээллийн технологийн салбарт нийт 21 жил ажилласан туршлагатай юм. Х.Өнөрбат нь МУИС-ийн Математик компьютерын сургуульд Мэдээллийн технологийн мэргэжлээр бакалавр болон магистрын зэрэг хамгаалсан.



**Нямсүрэнгийн Мөнхцэлмэг**

**Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга**

Нямсүрэнгийн Мөнхцэлмэг нь 2022 оноос ХасБанкны Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн даргаар томилогдон ажиллаж байна. Тэрээр төр болон хувийн хэвшилд тасралтгүй 15 гаруй жил ажилласан мэргэшсэн хуульч юм. Мөнхцэлмэг нь 2006 онд МУИС-ийн Хууль зүйн сургуулийг бакалавр, 2012 онд Япон улсын Кюшигийн Их Сургуулийн Хуулийн сургуулийг Олон улсын бизнесийн эрх зүйн магистр, 2019 онд Австралийн

ХАСБАНК
УБ 4937 2578697

Мельбүрнийн Их Сургуулийн Хуулийн сургуулийг Олон улсын нийтийн эрх зүйн чиглэлээр магистрын зэрэгтэй тус тус төгссөн.

## 1.8 Хүний нөөцийн удирдлага

ХасБанкны хүний нөөцийн бодлого нь мэргэжлийн, ёс зүйтэй, өндөр ур чадвар бүхий ажилтнуудаас бүрдэх ажил хэрэгч соёлыг дэмжих, гүйцэтгэлээс хамаарсан өрсөлдөхүйц цалин урамшууллын системийг бүрдүүлэх, ажилтнууд үзэл бодлоо нээлттэй, чөлөөтэй илэрхийлэх ажлын орчинтой байх, шударгаар үнэлүүлэх, сурч хөгжих боломжоор хангах, эрүүл, аюулгүй, тав тухтай ажиллах орчныг бүрдүүлэхэд чиглэдэг.

Банк нь 21 жилийн түүхэн хөгжлийн явцад бий болгосон байгууллагын өвөрмөц соёл, үлгэр жишээ сайн засаглалыг хөгжүүлж, цаашид энэхүү байгууллагын соёлоо улам бүр сайжруулан бэхжүүлэхийн тулд бүх талын оролцоог хангасан, шударга тогтвортой хөдөлмөрийн харилцааг хэрэгжүүлэхийн зэрэгцээ бүтээмжтэй, өндөр гүйцэтгэлтэй чадварлаг ажилтнуудаас бүрдсэн цомхон багаар бизнес төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээр ажиллаж байна.

2022 оны эцсийн байдлаар нийт идэвхтэй ажилтны тоо 1,143 байгаа ба ажилтнуудын дундаж нас 34.1, ажилласан дундаж хугацаа 7.6 жил байна. Үүнээс гадна 180 ажилтан урт хугацааны амралттай байна.

Хүснэгт 5: Хүний нөөцийн бүтэц

| Идэвхтэй ажилтан: | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|
| Салбар, тооцооны төв | 798 | 769 | 758 | 722 |
| Төв алба | 424 | 389 | 425 | 421 |
| **Нийт** | **1,222** | **1,158** | **1,183** | **1,143** |
| Улаанбаатар | 836 | 801 | 822 | 787 |
| Орон нутаг | 386 | 357 | 361 | 356 |
| **Нийт** | **1,222** | **1,158** | **1,183** | **1,143** |

Банк нь ажилтнуудаа сонгон шалгаруулахдаа Монгол Улсын Үндсэн Хуульд заасны дагуу нас хүйс, үндэс угсаа, нийгмийн гарал үүсэл, шашин шүтлэг, улс төрийн үзэл зэргийг үл харгалзан шударгаар, нээлттэйгээр сонгон шалгаруулан авдаг. 2022 онд 280 ажилтныг сонгон шалгаруулж авсан бол 92 ажилтан өөр албан тушаалд дэвшин ажиллаж байна.

Нийт ажилтнуудын 62 хувь нь эмэгтэй, 38 хувь нь эрэгтэй ажилтнуудаас бүрдэж байгаа бол менежер болон удирдах албан тушаалд эмэгтэйчүүд талаас илүү хувийг эзэлж байна.

Банк нь олон улсын стандарт, практикийн дагуу ажлын байрны үнэлгээг хийж албан тушаалын зэрэглэлийг тогтоодог. Албан тушаалын зэрэглэлд харгалзах цалин, урамшууллын систем нь тогтвортой, өндөр гүйцэтгэлийг дэмжихэд чиглэсэн байдаг.

Цалин хөлсийг шат дараатайгаар салбарын дундаж болон инфляцаас хамааруулан нэмэгдүүлэхээс гадна Банкны гүйцэтгэлд суурилсан хувьсах цалингийн системийг хэрэгжүүлж байна. Мөн богино болон урт хугацааны урамшууллын хөтөлбөрүүдийг хэрэгжүүлдэг. Үүнээс гадна ажилтнууддаа чиглэсэн төрөл бүрийн арга хэмжээг зохион байгуулж, ажилтнуудын ажил-амьдралын тэнцвэрт байдлыг хангахад ихээхэн чармайлт гаргадаг. Тухайлбал ажлын уян хатан цаг, ажиллах таатай орчин, хувийн эрүүл мэндийн даатгалд хамруулах зэрэг үүнд багтана. Үүнээс гадна ажилтнуудаа сурч, хөгжих боломжийг бүрдүүлэх, дотоод болон гадаад олон төрлийн сургалтад хамруулдаг. 2022 онд давхардсан тоогоор 2,700 орчим ажилтан өссөн дүнгээр 224,800 хүн/цагийн сургалт, хөгжлийн хөтөлбөрт хамрагдсан байна.

СЗХ
2023 05. 12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

Сайн сайхан оршихуй хөтөлбөрийн хүрээнд ажилтнууд гэр бүл болон нийгмийн өмнө хүлээсэн үүргээ хариуцлагатайгаар биелүүлж байна. Тухайлбал ХасCup спортын арга хэмжээ, явган аялал, ажилтнуудын өөрсдийн санаачилгаар байгуулсан сонирхлын клубуудын үйл ажиллагаагаар дамжуулан ажилтнуудын чөлөөт цагийг үр бүтээлтэй өнгөрүүлэх, нөхөрсөг бие биенээ гэсэн хамт олны соёлыг бэхжүүлэн ажиллаж байна.

## 1.9 Компанийн засаглал

Үнэт цаас гаргагчийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал бөгөөд Банкны засаглалын дотоод журмын дагуу толгой компани ТСН ХХК-ийн хувьцаа эзэмшигчид Банкны хувьцаа эзэмшигчийг төлөөлдөг. Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт хувьцаа эзэмшигчдээс сонгогдсон ТУЗ нь хувьцаа эзэмшигчдийн мэдэлд хамрагдахаар тусгайлан заасан асуудлуудаас бусад бүх асуудлаар шийдвэр гаргадаг. ТУЗ нь Үнэт цаас гаргагчийн стратеги, бодлогыг тодорхойлж, эдгээр зорилгод хүрэхэд шаардлагатай санхүүгийн болон хүний нөөцийг бүрдүүлэх төлөвлөгөөг батлах зэргээр Үнэт цаас гаргагчийг стратегийн удирдлагаар хангадаг. ТУЗ нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа хууль тогтоомж, дотоод журам, батлагдсан төлөвлөгөө, төсвийн хүрээнд Үнэт цаас гаргагчтай нэгдмэл сонирхолтой бүх талуудын эрх ашгийн төлөө явагдаж буй эсэхэд хяналт тавьж, эрсдэлийг илрүүлж, үнэлж, удирдахын тулд дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж ажилладаг. ТУЗ нь эрх үүргээ хэрэгжүүлж, үйл ажиллагаагаа үр дүнтэй явуулах үүднээс байнгын хороодыг байгуулж, хороод нь ТУЗ-өөс өгсөн тодорхой чиг үүргийн дагуу ТУЗ-ийн хэлэлцэх асуудлуудаар зөвлөмж дүгнэлт гаргаж ТУЗ-д танилцуулах, мөн ТУЗ-өөс өгсөн эрх мэдлийн хүрээнд тодорхой асуудлаар шийдвэр гаргадаг. Яаралтай эсвэл онцгой асуудлуудыг шийдвэрлэх зорилгоор бусад түр хороог байгуулж ажиллуулдаг. Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал удирдаж явуулдаг. Гүйцэтгэх захирал нь Үнэт цаас гаргагчийг төлөөлөн ажиллаж, хувьцаа эзэмшигчид болон ТУЗ-д тогтмол тайлагнах үүрэгтэй.

### 1.9.1 Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн үйл ажиллагаа

**ТУЗ-ийн дарга**

Үнэт цаас гаргагчийн Гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн даргын албан тушаалыг давхар эрхэлдэггүй, иймхүү эрхлэхийг компанийн дүрмээр хориглодог. ТУЗ-ийн дарга болон Гүйцэтгэх захирал нь эрх мэдлийн тэнцвэр бүхий харилцаатай ажиллаж, шийдвэр гаргалтад бие даасан боловч хоорондоо уялдаа холбоотой оролцдог.

**ТУЗ-ийн гишүүний үүрэг**

ТУЗ-ийн гишүүн нь гүйцэтгэх удирдлагыг стратегийн удирдлагаар хангах, үйл ажиллагаанд нь хяналт тавих үндсэн чиг үүрэгтэй. ТУЗ-ийн гишүүн зөвхөн өөрийн нэр дэвшүүлсэн төдийгүй нийт хувьцаа эзэмшигчид, үнэт цаас гаргагчийн ашиг сонирхлын үүднээс ажиллах үүрэгтэй.

**ТУЗ-ийн хараат бус гишүүний үүрэг**

ТУЗ-ийн хараат бус гишүүн Үнэт цаас гаргагчийн удирдлагын үйл ажиллагааг хараат бусаар хянах, Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд оролцож, ТУЗ-ийн шийдвэрийн талаар зөрүүтэй байр суурьтай байсан бол энэ тухайгаа мэдээлж, хувьцаа эзэмшигчдийн асуултад хариулах, тодруулга хийх үүрэг гүйцэтгэдэг.

ХАСБАНК
УХН 1027 2578697

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

#### 1.9.1.1 ТУЗ-ийн хурал

ТУЗ нь Үнэт цаас гаргагчийн дүрэм, ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмын дагуу үйл ажиллагаагаа явуулдаг. ТУЗ-ийн үйл ажиллагааны гол хэлбэр нь ТУЗ-ийн хурал бөгөөд хурлын шийдвэрийг тогтоолоор баталгаажуулж гаргадаг. ТУЗ-ийн ээлжит хурлын чөлөөт цагт ТУЗ-ийн үйл ажиллагааг онлайн болон холбооны бусад хэрэгслээр дамжуулан явуулж эчнээ санал хураалтаар шийдвэр гаргадаг.

Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн бүх ээлжит хурал, ТУЗ-ийн хороодын болон бусад хуралд оролцож Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүү нягтлан бодох бүртгэл, хянан нийцүүлэлт, засаглал болон үйл ажиллагааны бусад асуудлуудаар шаардлагатай мэдээлэл, тайлбар гаргаж өгдөг.

#### 1.9.1.2 ТУЗ-ийн үнэлгээ, гишүүдийн сургалт

Зохистой засаглалын зарчмын дагуу ТУЗ нь засаглал, үйл ажиллагаагаа сайжруулан ажиллах зорилгоор хамтын гүйцэтгэлийг үнэлэх, дутагдлыг илрүүлэх, үйл ажиллагааг сайжруулах тодорхой арга хэмжээ авахын тулд жил бүр ТУЗ-ийн үйл ажиллагааны үнэлгээ явуулдаг. Үүнээс гадна тодорхой шалгуурыг үндэслэн ТУЗ-ийн гишүүд өөр хоорондын үнэлгээг тус бүр хийдэг. ТУЗ-ийн үйл ажиллагааны болон гишүүдийн үнэлгээ нь компанийн засаглалын сайн туршлагад тооцогддог бөгөөд ТУЗ-ийг бэхжүүлэх, сул талыг олж илрүүлэх, чадамжийг дээшлүүлэх, үр дүнг нэмэгдүүлэх, бүтцийн талаар гишүүдийн дунд санал солилцох боломжийг олгож байдаг.

Мөн түүнчлэн, ТУЗ-ийн шинээр сонгогдсон гишүүдийг Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, байгууллагын соёлтой танилцуулж, ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлагын талаар мэдээлэл өгөх зорилгоор ТУЗ-ийн гишүүдийг сургалт танилцуулгын дараах хөтөлбөрт хамруулдаг.

- ТУЗ-ийн шинэ гишүүдэд Үнэт цаас гаргагчийн стратеги, бизнес төлөвлөгөө, дотоод засаглалын баримт бичиг, санхүүгийн тайлан, үйл ажиллагааны болон дотоод хяналтын бодлого, ТУЗ болон түүний хороодын хурлын тэмдэглэл, тогтоол, болон ТУЗ-ийн гишүүдэд шаардлагатай бусад баримт бичиг, холбогдох хууль тогтоомж зэрэг багц баримт бичгүүдийг хүргүүлдэг.
- ТУЗ-ийн шинэ гишүүдийг Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүдтэй танилцуулах, Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, тулгарч буй хүндрэлүүдийн талаар газар дээр танилцуулж хэлэлцэх зорилгоор уулзалтуудыг зохион байгуулдаг.
- Шаардлагатай тохиолдолд чухал харилцагч, нэгдмэл сонирхолтой талуудтай уулзалт зохион байгуулдаг.

Шинэ гишүүд Үнэт цаас гаргагчийн Ёс зүйн хэм, хэмжээ ба Сонирхлын зөрчлийн журам, ТУЗ-ийн гишүүдийн үүрэг хариуцлагын заалтуудтай танилцаж, хүлээн зөвшөөрч буйгаа гарын үсэг зурж мэдэгдэх үүрэгтэй байдаг.

#### 1.9.1.3 ТУЗ-ийн хороод

Үнэт цаас гаргагчийн ТУЗ нь тодорхой чиг үүрэг бүхий 3 байнгын хороотой ба эдгээр хороод нь тодорхой асуудлуудаар мэргэжлийн зөвлөмж гаргаж, ТУЗ-ийн үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд туслах зорилготой. Хороодын үйл ажиллагаатай холбоотой ерөнхий заалтууд нь ТУЗ-ийн үйл ажиллагааны дотоод журмаар

зохицуулагддаг ба тухайн хороонд хамаарах асуудал нь холбогдох хорооны дүрмээр зохицуулагдана. ТУЗ нь дараах байнгын хороодтой.

- Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо;
- Эрсдэлийн удирдлагын хороо;
- Аудитын хороо.

ТУЗ-ийн хороод нь 5 буюу түүнээс дээш гишүүнтэй байх бөгөөд тэдгээр нь ТУЗ-ийн гишүүн байна. ТУЗ-ийн гишүүн нь нэгээс дээш хороонд ажиллаж болох бөгөөд Монгол Улсын Банкны тухай хуульд заасны дагуу ТУЗ-ийн хараат бус гишүүн нь Эрсдэлийн удирдлагын болон аудитын хороодод заавал ажиллах үүрэгтэй. Олон улсын зохистой засаглалын зарчим, Монголбанкнаас гаргасан журмын дагуу ТУЗ-ийн Аудитын хороог хараат бус гишүүн даргалдаг, ТУЗ-ийн гишүүн гүйцэтгэх захирал нь ТУЗ-ийн Аудит, Эрсдэлийн удирдлага, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороодын гишүүнээр ажилладаггүй. Хороодын үйл ажиллагааны гол хэлбэр нь хорооны хурал бөгөөд хорооны шийдвэрийг ТУЗ-д танилцуулах зөвлөмж хэлбэрээр гаргадаг. Хороодын ээлжит хурлууд нь ТУЗ-ийн хурлын өмнөх өдөр товлогддог.

- **Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо** нь зохистой засаглалын зарчим, бодлого зэрэг компанийн зохистой засаглалын асуудлыг хариуцаж, нэгдмэл сонирхолтой бүх талын эрх ашигт нийцсэн банкны ил тод, тогтвортой үйл ажиллагаа явуулахад чиглэл өгч, мөн хяналт тавихад шаардагдах бүтэц, процесс бүхий зохистой засаглалын тогтолцоог бүрдүүлж ажиллах үүрэгтэй. Уг хороо нь дараах үндсэн үүрэг хариуцлагатай. Үүнд: 1) ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдох нэр дэвшигчдийг сонгон шалгаруулах, үнэлэх, ТУЗ-д санал болгох; 2) Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн үнэлгээ хийж, цалин урамшууллыг тогтоох, хувьцаанд суурилсан урамшууллын хөтөлбөрт хяналт тавих, ТУЗ-ийн цалин урамшууллын талаар ТУЗ-д санал оруулах; 3) ажилчдын зээлийн нөхцөлийг хянах.

  Гишүүд: Майкл Мадден (дарга), Анджей Витак, Санжай Гупта, Нямтайширын Цэлмүүн, Албертус Браггинк тус тус ажиллаж байна.

- **Эрсдэлийн удирдлагын хороо** нь эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай.

  Гишүүд: Ив Жако (дарга), Нямтайширын Цэлмүүн, Албертус Браггинк, Баянсаны Уламбаяр (хараат бус), Нираж Вэдва (хараат бус), Сюзанна Херринг Карр, Эрик Версавел (хараат бус) тус тус ажиллаж байна.

- **Аудитын хороо** нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, их хэмжээний болон сонирхлын зөрчил бүхий хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх

СЭХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг.

Гишүүд: Баянсаны Уламбаяр (дарга, хараат бус), Ив Жако, Анджей Витак, Албертус Браггинк, Нираж Вэдва (хараат бус), Сюзанна Херринг Карр, Эрик Версавел (хараат бус) тус тус ажиллаж байна.

### 1.9.2 Дотоод аудит



Дотоод аудитын газар нь ТУЗ-ийн дэргэдэх аудитын хороонд шууд тайлагнадаг бөгөөд Ерөнхий Аудитор Э.Ундармаа оролцуулан нийт 18 хүний бүрэлдэхүүнтэй ажиллаж байна.

Дотоод аудитын үйл ажиллагааны үндсэн зорилго нь Банкны засаглал, эрсдэлийн удирдлага, дотоод хяналтын тогтолцоог хараат бусаар үнэлэх, Банкны үйл ажиллагааг сайжруулах, үнэ цэн нэмэхэд оршиж байна. Энэхүү зорилгын хүрээнд дотоод аудитын газар нь Дотоод Аудитын Олон улсын Институтээс гаргасан Дотоод Аудиторуудын Олон Улсын мэргэжлийн практикийн стандарт болон Ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

Дотоод аудитын нэгж нь 2014 оноос хойш процессын аудитын аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн бөгөөд Банкны процесс бүрийг тодорхойлж, процессын эрсдэлийн үнэлгээний дагуу эрсдэлд суурилсан аудитыг хийж, Банкны эрсдэл, хяналтын тогтолцооны дотоод мэдээллийн бааз суурийг бий болгон ажиллаж байна. Процессын аудит нь Банкны үйл ажиллагааны зураглалыг дэлгэрэнгүй боловсруулж, тухайн процесс дахь эрсдэлүүд болон хяналтуудыг тодорхойлох замаар түлхүүр хяналтын хэрэгжилт, үр ашигт байдлыг шалгадаг аргачлал юм. Түүнчлэн 2019 оноос эхлэн үргэлжилсэн аудитын аргачлалыг үйл ажиллагаандаа нэвтрүүлж эхэлсэн нь аудитын үйл ажиллагааны үр ашгийг болон банкны дотоод хяналтын орчинг сайжруулахад хувь нэмэр оруулж байгаа юм. Баталсан бодлого, дүрэм болон аудиторуудын гарын авлагын хэрэгжилт, нийцтэй байдалд анхаарч, шинэчлэх, хөгжүүлэх шаардлага байгаа эсэхэд дүгнэлт өгч ажиллаж байна.

### 1.9.3 Гүйцэтгэх удирдлагын дэргэдэх хороодын үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагааг үр дүнтэй, өндөр хяналтын дор удирдан зохион байгуулах үүднээс гүйцэтгэх удирдлагын дэргэдэх тодорхой чиглэл бүхий хороодуудыг ажиллуулж байна. Үүнд:

- **Гүйцэтгэх удирдлагын хороо** нь Үнэт цаас гаргагчийн стратегийн ач холбогдол бүхий асуудлуудыг хэлэлцэж шийдвэр гаргах, үйл ажиллагааны болон санхүүгийн гүйцэтгэлд хяналт тавих, бусад хороодын үйл ажиллагааг хянах, төсөв зарцуулахтай холбоотой шийдвэр гаргах болон бусад бодлогын чухал асуудлуудыг хэлэлцдэг.
- **Эрсдэлийн удирдлагын хороо** нь ТУЗ-өөр батлагдсан эрсдэлийн хязгаар үзүүлэлтийн биелэлтэд хяналт тавих, Үнэт цаас гаргагчийн эрсдэл даах чадварыг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж хэрэгжүүлэх, дотоод хяналтын тогтолцооны найдвартай, тасралтгүй байдалд хяналт тавьдаг. Мөн үйл ажиллагааны эрсдэлийн асуудлыг тусгайлан авч хэлэлцэх чиг үүрэг бүхий дэд хороод (Үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын хороо, Зээлийн хороо зэрэг) холбогдох эрсдэлийн талаар тусгайлан хяналт хэрэгжүүлдэг.

ХАСБАНК 2071937 2578697

- **Актив пассивын удирдлагын хороо** нь Үнэт цаас гаргагчийн актив-пассивын бүтэц, хөрвөх чадварын байдал, мөнгөн урсгал, хүүгийн бодлого, хүү болон валютын позицтой холбоотой асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргадаг.
- **Бусад дэд хороодод** мэдээлэл технологийн хороо, бизнес хөгжлийн хороо, хүний нөөцийн хороо, тендерийн хороо багтах бөгөөд тухайн үйл ажиллагааны чиглэлүүдийн хүрээнд холбогдох асуудлыг хэлэлцэж, шийдвэр гаргадаг.

### 1.9.4 Компанийн засаглалын кодекс

СЗХ-ны 2022 оны 3 дугаар сарын 23-ны өдрийн 145 дугаартай “Компанийн засаглалын кодекс”-ийг шинэчлэн батлах тухай тогтоолоор батлагдсан Компанийн засаглалын кодекс ("Кодекс")-ийг Монгол Улсын үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад үнэт цаас гаргагч, даатгагч, итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхэлдэг бүх компаниуд дагаж мөрдөхөөр заасан. Энэхүү Кодексоор Компанийн засаглалын 9 зарчим тогтоож шинээр мөрдүүлж эхэлсэн.

Үнэт цаас гаргагч нь Кодексийн зохицуулалтад нийцэж, тогтоосон шаардлагыг хангаж байгаа эсэхэд хөндлөнгийн хуулийн фирм хууль зүйн дүгнэлт гаргасан бөгөөд Үнэт цаасны танилцуулгад хавсаргасан болно. Хуулийн дүгнэлтэд мөн хувьцаат компанийн дүрмийн төсөл болон банкны дотоод дүрэм, журам нь хувьцааг нийтэд санал болгосны дараа Кодексийн шаардлагад нийцэх эсэх талаар дурдсан болно.

### 1.9.5 Эрсдэлийн удирдлагын тогтолцоо, бодлого

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын засаглал нь дараах зүйлсээс бүрдэнэ. Үүнд:

- Хяналтын тогтолцоог бэхжүүлэх Хамгаалалтын гурван бүс;
- Хамгаалалтын гурван бүсийг хэрэгжүүлэх бодлого, журам, заавар бүхий эрсдэлийн засаглалын нэгдсэн бичиг баримтууд;
- Хүлээн зөвшөөрөх эрсдэл, эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилт, хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий засаглалын хороод;
- Хамгаалалтын гурван бүсийн зарчимд суурилсан эрсдэлийн удирдлага, хяналтын тогтолцоог сайжруулах чиг үүргийг тодорхойлсон Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлогын бичиг баримт;
- Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн баталсан Хянан нийцүүлэлтийн тогтолцоо.

**Хамгаалалтын 3 бүсийн зарчим** нь Банкны дотоод хяналтын тогтолцоог хамгаалалтын 3 бүсийн зохион байгуулалтаар ажиллуулах нь банкны газар, нэгжүүдийн үүрэг, хариуцлагуудыг зааглаж, аливаа эрсдэлийг илрүүлэх, удирдахад илүү системтэй ажиллах боломжоог олгодог.

СЗХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Зураг 5: Эрсдэлийн удирдлагын тогтолцоо




Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн засаглалыг дараах хороодууд хэрэгжүүлдэг. Үүнд:

- ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо: ТУЗ-ийн гишүүдийг төлөөлж эрсдэлийн асуудлууд дээр хяналт тавьж ажилладаг. Мөн эрсдэлийн хүлээн зөвшөөрөх хязгаар, хэмжээг баталдаг.
- Эрсдэлийн удирдлагын Хороо: эрсдэлийн удирдлагын бодлого, журамд тодорхойлсон эрсдэлийн төрлүүдээр алдагдал, хохирлын түвшинг хянах, Үнэт цаас гаргагчийн эрсдэл даах чадварыг үнэлэх, эрсдэлээс урьдчилан сэргийлэх, түүнийг бууруулах, хяналтын тогтолцооны найдвартай байдалд хяналт тавьдаг.
- Үйл ажиллагааны Эрсдэлийн Хороо: үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон үйл ажиллагааны эрсдэлийн зөвшөөрөх хэмжээнд хяналт тавьж ажилладаг.
- Зээлийн удирдлагын Хороо: зээлийн эрсдэлийн удирдлагын бодлого болон ТУЗ-с тогтоосон эрх хэмжээний хүрээнд зээл батлах эрхтэй бөгөөд зээлийн алдагдлыг боломжит хамгийн бага түвшинд удирдан ажиллах үндсэн чиг үүрэгтэй.

### 1.9.6 Зээлийн удирдлагын хороо ба зээл батлах эрх

Банкны зээлийн санал шийдвэрлэх дээд эрх мэдэл бүхий этгээд нь ТУЗ бөгөөд ТУЗ-ийн Эрсдэлийн удирдлагын хороо нь Банкны Зээлийн удирдлагын хороонд тодорхой эрх шилжүүлэн ажилладаг. Мөн Банкны Зээлийн удирдлагын хороо нь тодорхой зээл шийдвэрлэх эрхийг бизнес нэгжүүд болон салбаруудад олгодог.

Зээлийн санал шийдвэрлэхэд эрх бүхий этгээдүүдийн 100 хувийн саналаар зээлийн саналыг батлах бөгөөд нэгдсэн саналд хүрээгүй тохиолдолд зээлийн саналыг дараагийн шатны эрх бүхий хороонд уламжилна. Зээлийн санал шийдвэрлэх эрх бүхий этгээд нь өөрийн болон өөрийн хамаарал бүхий этгээдийн зээлийн санал шийдвэрлэх процесст оролцдоггүй.

ХАСБАНК

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

### 1.9.7 Зах зээлийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн эрсдэл гэдэгт санхүүгийн зах зээл дээрх сөрөг өөрчлөлт болон зах зээл дээрх хүү, валютын ханш, хөрөнгийн үнэ, түүхий эдийн үнийн хэлбэлзэл зэрэг зах зээлийн нөхцөл байдлын өөрчлөлтөөс шалтгаалж Банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээ, ашигт ажиллагаа, баланст үүсэж болзошгүй сөрөг үр дагаврууд хамаарна.

Банк нь өөрийн эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд жил бүр ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооноос тогтоосон эрсдэлийн зөвшөөрөх төвшнүүдийг Банкны бизнес төлөвлөгөө, стратегитай уялдуулан шинэчлэн баталж, үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажилладаг. Түүнчлэн эрсдэлийн удирдлагын нэгжийн зүгээс хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд эрсдэлийг удирдахаас гадна зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны үзүүлэлтүүдийг хангаж ажиллахад хяналт тавьдаг. Хүлээгдэж буй эрсдэлийг тодорхойлох, зах зээл дээр бий болж болзошгүй шокуудын нөлөөг хэмжих зорилгоор хувилбарт шинжилгээ, цочролын сорил (стресс тест) –ийг тогтмол хийж гүйцэтгэдэг.

#### 1.9.7.1 Хүүгийн эрсдэлийн удирдлага

Зах зээлийн хүүгийн өөрчлөлтөөс шалтгаалан Банкны санхүүгийн байдалд сөрөг нөлөөлөл гарахыг хүүгийн эрсдэл гэж тодорхойлдог. Банк нь хүүгийн эрсдэлийн үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарын хүрээнд удирдаж ажилладаг.

Түүнчлэн хүүгийн эрсдэлийн удирдлагын хүрээнд хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий нийт актив, пассивын зөрүү, хүүгийн өөрчлөлтөд мэдрэмтгий байдлын шинжилгээ (PV01) болон хувилбарт шинжилгээг тогтмол гүйцэтгэн, холбогдох хороогоор хэлэлцэж, хүүгийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн бизнесийн шийдвэрүүдийг гаргадаг.

#### 1.9.7.2 Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлага

Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагад Банкны төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг хангахад зорьдог бөгөөд богино хугацааны төлбөрийн чадварын эрсдэлийг бууруулах болон актив, пассивын урсгалын хугацааны зөрүүг тэнцвэржүүлэхэд чиглэдэг.

Банк нь батлагдсан Эрсдэлийн удирдлагын тогтолцооны хүрээнд хөрвөх чадварын эрсдэлийн үзүүлэлтүүдийг зохицуулагч байгууллагын шаардлага болон хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд тогтмол хангаж ажилладаг. Эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг Монголбанкнаас тавьдаг зохистой харьцааны доод шаардлагын хүрээнд хангаж ажиллахаас гадна хөрвөх чадварын нөөц (liquidity buffer), богино хугацаат хөрвөх чадварын үзүүлэлт (short-term liquidity ratio), хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (LCR), цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR) зэрэг үзүүлэлтүүдийг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хүрээнд тооцон, актив пассивын бүтцийг тус хязгааруудын хүрээнд оновчтой байршуулдаг. Мөн зах зээл болон банкны салбарт үүсэж болзошгүй гэнэтийн шоктой үед Банкинд үүсэх нөлөөллийг тооцох үүднээс цочролын сорил, хувилбарт шинжилгээг хийж гүйцэтгэн шийдвэр гаргалтдаа ашигладаг.

#### 1.9.7.3 Гадаад валютын ханшийн эрсдэл

Банк нь гадаад валютын ханшийн огцом хэлбэлзлээс баланст үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах зорилгоор тухайн гадаад валютуудад нээлттэй позицийн лимитийг тогтоон, хянаж ажилладаг. Үүний хүрээнд олон улсад өргөн ашигладаг хамгийн их

ХАСБАНК
2578697

СЗХ
он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

эрсдэлийн арга (Value-At-Risk)-ыг үйл ажиллагаандаа ашиглаж байна. Мөн гадаад валютын шууд бус эрсдэл болох валютын зээлийн эрсдэлийг бууруулах, харилцагчийг ирээдүйн валютын ханшийн хэлбэлзлээс хамгаалах зорилгоор 2014 оноос эхлэн валютын зээл олголтыг бууруулж, 2022 оны эцсийн байдлаар нийт зээлийн багцад эзлэх гадаад валютын зээлийн үлдэгдлийг 2%-с доош түвшинд удирдан ажиллаж байна.

### 1.9.8 Банкны ил тод байдал

Банк нь ил тод байдлын зарчмын хүрээнд холбогдох хууль тогтоомж, Монголбанкны журмыг хэрэгжүүлж ажиллаж байна. Тухайлбал:

- Хувьцаа эзэмшигчдийн бүтэц, нөлөө бүхий хувьцаа эзэмшигчдийн талаарх мэдээллийг Банкны жилийн тайланд оруулж Банкны цахим хуудсанд жил бүр мэдээлдэг.
- ТУЗ-ийн дарга, гишүүд, хараат бус гишүүд, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, мөн эрх бүхий албан тушаалтнуудын талаар олон нийтэд мэдээлдэг. Мөн Банкны үйл ажиллагааны бүтэц зохион байгуулалт, санхүү бүртгэлийн тогтолцоо, дотоод хяналтын тогтолцоо хэрхэн ажилладаг талаар олон нийтэд мэдээлсэн байдаг.
- Банкны жил, улирлын санхүүгийн тайлан, аудитаар баталгаажсан тайлан, банкны ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирлаар баталгаажуулсан жилийн ажлын тайланг тогтоосон хугацаанд Монголбанкинд хүргүүлж, сонин хэвлэл, өөрийн вэб хуудсаар дамжуулан олон нийтэд тайлагнадаг.
- Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, гаргасан аккредитив, бусад үүрэг, ажил, үйлчилгээний талаар цахим хуудсанд тогтмол мэдээлдэг.
- Банкны цахим хуудсанд банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий нөхцөл, хүү, шимтгэл, хураамжийг үнэн зөв, бүрэн бүтэн тусгадаг.
- Банкны жилийн тайланд нийгмийн хариуцлагын талаар жил бүр мэдээлж, жилийн тайланг Банкны цахим хуудсанд байршуулдаг.

## 1.10 Үл хөдлөх хөрөнгө ба үндсэн хөрөнгө

Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгийг дараах байдлаар бүртгэсэн нь Эд Хөрөнгийн Эрхийн Улсын Ерөнхий Бүртгэл, Автотээврийн Үндэсний Төв байгууллагын улсын бүртгэлийн гэрчилгээгээр баталгаажсан болно. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй аливаа эд хөрөнгийг бусдад барьцаалаагүй болно.

Хүснэгт 6: Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй хөдлөх болон үл хөдлөх хөрөнгө

| | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|
| **Үл хөдлөх хөрөнгө (нийт)** | 207 |
| Банкны эзэмшлийн үл хөдлөх хөрөнгө | 58 |
| Өмчлөх бус үл хөдлөх хөрөнгө | 149 |
| | |
| **Газар эзэмших эрх** | 24 |
| Банкны эзэмшлийн газар | 24 |
| | |
| **Банкны эзэмшлийн тээврийн хэрэгслүүд** | 4,210 |
| Эзэмшиж, ашиглаж буй тээврийн хэрэгслүүд | 67 |

ХАСБАНК
УХН4937 2578697

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| Фидуцийн гэрээ болон лизингээр эзэмшиж буй хөрөнгө | 4,143 |

| | |
|---|---|
| **Бусад хөрөнгө** | 52 |
| Зохиогчийн эрхийн гэрчилгээ | 34 |
| Барааны тэмдэг | 18 |

Дээр дурдсан хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг хуулийн дүгнэлтээс (хавсралт 6) үзнэ үү.

## 1.11 Их хэмжээний болон холбоотой талтай хийсэн гэрээ, хэлцлийн талаарх мэдээлэл

### 1.11.1 Их хэмжээний хэлцэл

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1-д "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл /компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй/", 87.1.2-т "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт" байвал эдгээр нь их хэмжээний хэлцэлд хамаардаг.

Хуулийн фирмийн дүгнэснээр Үнэт цаас гаргагч нь 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн хооронд их хэмжээний хэлцэл хийгээгүй байна.

### 1.11.2 Сонирхлын зөрчилтэй хэлцэл

Сонирхлын зөрчлийн хэлцлийг Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт "сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-ийн гишүүдийн олонхийн саналаар гаргана." гэж заасан бол 92 дугаар зүйлийн 92.2 дахь хэсэгт "Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно" гэж заасан байдаг.

Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэгт "Банкнаас холбогдох этгээдтэй хийх хэлцэл нь банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй байж болохгүй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд холбогдох хуульд заасан шаардлага, журмыг баримтална." гэж заасан байдаг.

Үнэт цаас гаргагчийн сонирхлын зөрчилтэй этгээдтэй байгуулах гэрээг ердийн үйл ажиллагааны дагуу бусад талтай байгуулах гэрээнээс хөнгөлөлттэй нөхцөлөөр байгуулахгүй байх, мөн сонирхлын зөрчилтэй хэлцлийн үнийн дүнг ТУЗ-р тогтоох ба зөвшөөрлийг ТУЗ-ийн хараат бус гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэхийг хуулиар зохицуулсан байдаг.

Хуулийн фирмийн тодорхойлсноор Банкны 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс 2023 оны 1 дүгээр сарын 01-ний өдрийн хооронд байгуулсан гэрээнүүдээс 2022 оны жилийн эцсийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй нийт 15 сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгаа бол 2020 оны 1 дүгээр сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хүчин төгөлдөр байгаа 7 сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байна. Эдгээр 22 сонирхлын зөрчил бүхий

ХАСБАНК
УХН4937 2578697

гэрээ хэлцэл нь ТУЗ-ийн зөвшөөрлийн дагуу батлагдсан бөгөөд хууль тогтоомжид нийцсэн гэж Хуулийн фирм дүгнэсэн болно.

### 1.11.3 Холбоотой талуудын тодруулга

Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.2 дахь заалтад зааснаар Банкны холбогдох этгээдэд (i) банкны нэгдлийн оролцогч, (ii) банк, банкны нэгдлийн оролцогчийн хувьцааны тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувь хүн, хуулийн этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд, (iii) хувьцааных нь тав болон түүнээс дээш хувийг банк эзэмшдэг хуулийн этгээд, (iv) хувьцааных тав болон түүнээс дээш хувийг банкны эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд эзэмшдэг хуулийн этгээд (v) банк, банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд, (vi) банкны эрхлэх үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг банктай нэгдмэл сонирхолтой этгээд, (vii эрх бүхий албан тушаалтных нь чиг үүргийг банкны эрх бүхий албан тушаалтан давхар гүйцэтгэдэг хуулийн этгээд (viii) банкны саналын эрхтэй хувьцааны арав болон түүнээс дээш хувийг эрх бүхий албан тушаалтан нь эзэмшдэг хуулийн этгээд, (ix) энэ заалтад заасан этгээдтэй нэгдмэл сонирхолтой бусад хувь хүн, хуулийн этгээд (x) Монголбанкнаас холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд тус тус хамаарахаар тодорхойлсон байдаг.

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30 дахь заалтад зааснаар Холбогдох этгээдийн мөн тодорхойлдог ба (i) а.хувь хүний тухайд тухайн хүний эхнэр, нөхөр, хүү, охин, өргөмөл хүү, өргөмөл охин буюу дагавар хүү, дагавар охин, хүргэн, бэр, ач, зээ, өөрийн болон түүний эхнэр /нөхөр/-ийн эцэг, эх, хойд эцэг, хойд эх, ах, эгч, дүү, эцэг нэгтэй буюу эх нэгтэй ах, эгч, дүү, (ii) тухайн хүн эрх бүхий албан тушаалтнаар нь ажилладаг хуулийн этгээд, (iii) энэ хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.30 дахь заалтад заасан этгээд дангаар, эсхүл хамтдаа эзэмших саналын эрх бүхий хувьцааны 10 буюу түүнээс дээш хувийг эзэмшдэг компани болон хуулийн этгээд, (iv) тухайн этгээд ажил олгогч бол түүний ажилтан, (v) компани бол түүний толгой, хараат, охин, зэргэлдээ компани (vi) Санхүүгийн Зохицуулах Хорооноос "холбогдох этгээд" гэж тодорхойлсон бусад этгээд тус тус хамаарахаар хуульчилсан болно.

Банк нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-36 дугаар тушаалын 3 дугаар зүйлд заасны дагуу банктай холбоотой хязгаарлалтыг тооцох, баталгаажуулах, тайлагнах, хянан шалгах журамд заасны дагуу холбогдох этгээдийн мэдээллийн санг бүрдүүлж, тайлант хугацаанд хүргүүлэн ажилладаг.

Үнэт цаас гаргагч нь холбогдох этгээдийн мэдээллийг дээр дурдсан журмын дагуу мэдээлэх үүрэгтэй бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар нийт 248 иргэн, хуулийн этгээд холбоотой талыг бүртгүүлсэн байна. Үүнээс 89 нь хуулийн этгээд, 159 нь иргэн байгааг дараах байдлаар бүлэглэж болно:

- Үнэт цаас гаргагчийн шууд болон шуд бус хувьцаа эзэмшигч хуулийн этгээд – 8;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүнтэй холбоотой хуулийн этгээд – 53;
- Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, түүнтэй холбоотой иргэн – 52;
- Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан – 19 (Үнэт цаасны танилцуулга бэлдэх үеийн байдлаар эрх бүхий албан тушаалтан 1-р нэмэгдэж 20 болсон);
- Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтантай холбоотой хуулийн этгээд – 28;
- Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтантай холбоотой иргэн – 88.

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн холбоотой талтай хийсэн хэлцлийн үлдэгдэл дараах байдалтай байна.

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Хүснэгт 7: Холбоотой талд олгосон зээл

| Холбоотой талд олгосон зээл: | Үлдэгдэл (тэрбум төгрөгөөр) |
|---|---|
| Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд | 0.0 |
| ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх удирдлагын гишүүд | 1.4 |
| Бусад холбоотой этгээд | 0.1 |
| **Нийт үлдэгдэл** | **1.5** |

Хүснэгт 8: Холбоотой талаас авсан харилцах, хадгаламж

| Холбоотой талаас авсан харилцах, хадгаламж: | Үлдэгдэл (тэрбум төгрөгөөр) |
|---|---|
| Толгой компани | 22.5 |
| Толгой компанийн хувьцаа эзэмшигчдэд | 0.2 |
| ТУЗ-ийн гишүүд болон Гүйцэтгэх Удирдлагын гишүүд | 8.8 |
| Бусад холбоотой этгээд | 47.6 |
| **Нийт үлдэгдэл** | **79.1** |

Хүснэгт 9: Холбоотой талаас авсан урт хугацаат санхүүжилт

| Холбоотой талаас авсан урт хугацаатай санхүүжилт: | Үлдэгдэл (тэрбум төгрөгөөр) |
|---|---|
| Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD) | 89.0 |
| Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) | 17.2 |
| **Нийт үлдэгдэл** | **106.2** |

Дээр дурдсан гэрээ хэлцэл болон түүний үлдэгдэл нь бизнесийн ердийн үйл ажиллагааны явцад үүссэн бөгөөд холбоотой талуудад ногдуулсан болон холбоотой талуудаас ногдуулсан хүү, шимтгэлийн нөхцөл нь ердийн нөхцөлтэй байна. Холбоотой этгээдэд авлага, өглөгийн ямар нэг баталгаа гаргасан болон хүлээн авсан зүйл байхгүй болно.

### 1.11.4 Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны мэдээлэл

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 8.32 дахь заалтад тодорхойлсны дагуу тус Танилцуулга бэлдэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтны мэдээллийг дараах байдлаар харуулав.

Хүснэгт 10: Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтан

| № | Овог, Нэр | Албан тушаал | Тухайн албан тушаалд томилогдсон огноо |
|---|---|---|---|
| 1 | Санжэй Гупта | ТУЗ-ийн Дарга | 2019.03 |
| 2 | Ив Жако | ТУЗ-ийн гишүүн | 2016.03 |
| 3 | Г.Цэвэгжав | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх захирал | 2019.05 |
| 4 | Майкл Мадден | ТУЗ-ийн гишүүн | 2009.05 |
| 5 | Н.Цэлмүүн | ТУЗ-ийн гишүүн | 2012.08 |
| 6 | Анджей Витак | ТУЗ-ийн гишүүн | 2019.02 |
| 7 | Албертус Браггинк | ТУЗ-ийн гишүүн | 2020.06 |
| 8 | Сюзана Херринг Карр | ТУЗ-ийн гишүүн | 2022.04 |
| 9 | Б.Уламбаяр | ТУЗ-ийн гишүүн | 2015.07 |
| 10 | Нираж Вэдва | ТУЗ-ийн гишүүн | 2018.06 |
| 11 | Эрик Версавел | ТУЗ-ийн гишүүн | 2022.10 |
| 12 | Ами Чой | ТУЗ-ийн гишүүн | 2023.04 |
| 13 | Г.Эрдэнэбаяр | Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал | 2013.01 |
| 14 | Э.Уламбаяр | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал | 2020.01 |
| 15 | Б.Еркин | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал | 2020.01 |

ХАСБАНК
2578697

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| 16 | С.Дауренбек | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Лизинг хариуцсан захирал | 2021.11 |
| 17 | Илия Аврамов | Эрсдэл хариуцсан захирал | 2019.10 |
| 18 | Г.Зул | Үйл ажиллагаа хариуцсан захирал | 2020.01 |
| 19 | Х.Өнөрбат | Мэдээллийн технологи хариуцсан захирал | 2021.03 |
| 20 | Н.Мөнхцэлмэг | Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга | 2022.06 |

### 1.11.5 Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний гэрээ, хэлцэл

Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав буюу түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний нийт 65 гэрээ байгуулагдсан ба бүгд гадаадын банк, хөрөнгө оруулалтын сан, санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татахтай холбоотой байгуулагдсан гэрээ байна. Эдгээр гэрээнээс 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй нийт 28 гэрээг Хуулийн фирм хянан баталгаажуулсан болно.

Хүснэгт 11: Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав буюу түүнээс дээш хэмжээний хэлцлүүд

| № | Гэрээний нөгөө тал | Огноо | Гэрээний төрөл |
|---|---|---|---|
| 1 | Green climate fund | 2017 | Зээлийн гэрээ |
| 2 | Зээлийн батлан даалтын сан | 2017 | Хадгаламжийн гэрээ |
| 3 | European Bank for Reconstruction and Development | 2018 | Зээлийн гэрээ |
| 4 | European Bank for Reconstruction and Development | 2019 | Зээлийн гэрээ |
| 5 | DEG-Deutsche Investitions-Und Entwickicklungsgesellschaft BMH, Finnish Fund for Industrial Cooperation Ltd, SIFEM AG, International Finance Corporation, Societe de promotion et de participation pour la cooperation economique | 2019 | Зээлийн гэрээ |
| 6 | Green climate fund | 2019 | Зээлийн гэрээ |
| 7 | International Investment Bank | 2019 | Зээлийн гэрээ |
| 8 | INFOFIN CVSO | 2019 | Зээлийн гэрээ |
| 9 | Raisin Bank AG | 2019 | Зээлийн гэрээ |
| 10 | Asian development bank | 2019 | Зээлийн гэрээ |
| 11 | Nederlandse financiaring-maatschappij voor ontiwikkelingslanden N.V, International bank for economic co-operation, The OPEC fund for international development | 2019 | Зээлийн гэрээ |
| 12 | European Bank for Reconstruction and Development | 2020 | Зээлийн гэрээ |
| 13 | Baobab Secutities Limited | 2020 | Зээлийн гэрээ |
| 14 | Incofin CVSO CVBA-SO | 2021 | Зээлийн гэрээ |
| 15 | ResponsAbility Global Micro and SME Finance Fund | 2021 | Зээлийн гэрээ |
| 16 | Global Climate Partnership Fund S.A | 2021 | Зээлийн гэрээ |
| 17 | European Bank for Reconstruction and Development | 2021 | Зээлийн гэрээ |
| 18 | DWM Income Funds S.C.A – SICAV SIF | 2022 | Зээлийн гэрээ |
| 19 | European Bank for Reconstruction and Development | 2022 | Зээлийн гэрээ |
| 20 | DWM Income Funds S.C.A – SICAV SIF | 2022 | Зээлийн гэрээ |
| 21 | ACTIAM Financial Inclusion Fund & DWM Asset Management LLC | 2022 | Зээлийн гэрээ |
| 22 | Microfinance Initiative for Asia (MIFA) Debt Fund SA, SICAV SIF | 2022 | Зээлийн гэрээ |
| 23 | Nederlandse Financierings-Maatshhappij voor Ontwikkelingslanden N.V | 2022 | Зээлийн гэрээ |
| 24 | Blueorchard Invest S.a.r.l | 2022 | Зээлийн гэрээ |
| 25 | Blueorchard Invest S.a.r.l | 2022 | Зээлийн гэрээ |
| 26 | INCOFIN CVSO, IIV Mikrofinanzfonds | 2022 | Зээлийн гэрээ |
| 27 | Micro, Small and Medium Enterprises Bonds S.A, | 2022 | Зээлийн гэрээ |
| 28 | International Finance Corporation | 2022 | Зээлийн гэрээ |

Эдгээр гэрээнд гарын үсэг зурсан албан тушаалтны эрх мэдэл болон гэрээний хүчин төгөлдөр байдлын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хуулийн фирмийн гаргасан хуулийн дүгнэлтээс (хавсралт 6) үзнэ үү.

ХАСБАНК

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

## 1.12 Бусад гэрээ

Үнэт цаас гаргагчийн сүүлийн 3 жилийн хугацаанд байгуулсан бөгөөд 2022 оны эцсийн байдлаар хүчин төгөлдөр 1,085,974 гэрээ байгаа болно. Эдгээр хүчин төгөлдөр гэрээг (i) бизнесийн ердийн үйл ажиллагаатай холбоотой хийгдсэн гэрээ, хэлцэл (ii) хөдөлмөрийн харилцаатай холбоотой гэрээ (iii) үндсэн үйл ажиллагаатай холбоотой бусад гэрээ гэж ангилж болно.

Үнэт цаас гаргагчийн байгуулсан зээлийн болон бусад баталгааны гэрээ, хадгаламжийн гэрээ, харилцах дансны гэрээ, аккредитив, батлан даалтын гэрээ нь холбогдох хууль тогтоомж, Үнэт цаас гаргагчийн дотоод дүрэм, журамд нийцэж байгааг Хуулийн фирм өөрийн дүгнэлтэд тусгасан болно (хавсралт 6).

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаатай холбоотой бусад гэрээний хувьд сүүлийн 3 жилд хийгдсэн гэрээнээс 692 гэрээ хүчин төгөлдөр байна. Эдгээр хүчин төгөлдөр гэрээг (i) Худалдах, худалдан авах гэрээ (ii) Үл хөдлөх хөрөнгө түрээслэх гэрээ (iii) Ажил, үйлчилгээ үзүүлэх гэрээ, (iv) Даатгалын гэрээ (v) Бусад гэрээ гэж ангилна. Эдгээр гэрээ нь холбогдох хууль тогтоомж, Банкны дотоод дүрэм, журамд нийцсэн байгааг Хуулийн фирм өөрийн дүгнэлтэд тусгасан байна (хавсралт 6).

## 1.13 Эх үүсвэр олгогч санхүүгийн түнш байгууллагууд

Хүснэгт 12: Эх үүсвэр олгогч байгууллагууд

| | |
|---|---|
| FMO | FMO-г Голландын засгийн газрын үүсгэн байгуулсан бөгөөд AAA зэрэглэлтэй Хөгжлийн Санхүүгийн байгууллага юм. Тус байгууллага нь хөгжиж буй орны бизнесийн төсөл хөтөлбөрүүдээр дамжуулан хувийн хэвшлийн тогтвортой хөгжлийг дэмждэг бөгөөд хувийн хэвшлийг дэмжих нь тухайн орны иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулахад чухал ач холбогдолтой гэж үздэг. FMO нь нийгэм, эдийн засагт урт хугацаандаа эерэг нөлөө бүхий аливаа төсөл хөтөлбөрүүдэд хөрөнгө оруулахыг чухалчилдаг. |
| KFW DEG | 1962 онд үүсгэн байгуулагдсан DEG нь 2001 оноос KfW группийн охин компани болсон бөгөөд хөгжиж буй зах зээлд зээл болон хөрөнгө оруулалт хэлбэрээр урт хугацааны эх үүсвэрийг олгодог. Мөн гарааны бизнес эрхлэх санаачилгыг дэмжиж, санхүүжүүлэн ажилладаг. DEG нь өөрийн хөрөнгө оруулалтын тухайн улсын эдийн засгийн хөгжилд үзүүлэх нөлөөлөлд ихээхэн ач холбогдол өгдөг ба урт хугацааны хамтын ажиллагааны хүрээнд ХасБанкаар дамжуулан Монгол улсын жижиг дунд бизнесийг санхүүжүүлэхэд хамтран ажиллаж байна. |
| ADB ASIAN DEVELOPMENT BANK | Азийн Хөгжлийн Банк (ADB) нь 1966 онд байгуулагдсан бөгөөд 1991 онд Монгол улс гишүүнээр элссэн. Өдгөө 68 гишүүн улс бүхий бүс нутгийн хөгжлийн банк юм. АХБ нь боловсрол, хүрээлэн буй орчин, дэд бүтэц, бүс нутгийн хамтын ажиллагаа, санхүүгийн салбарыг дэмжих үндсэн чиглэлээр ажиллаж байна. |
| IFC International Finance Corporation | Дэлхийн Банкны Группийн гишүүн болох Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) нь хөгжиж буй эдийн засаг дэх хувийн хэвшлийг дэмжихэд чиглэсэн хамгийн том олон улсын хөгжлийн байгууллага юм. IFC-ийн үндсэн зорилго нь хувийн хэвшилд зориулсан санхүүгийн эх үүсвэрийг олгох, шинээр ажлын байр бий болгох бизнесийг дэмжих замаар иргэдийн амьжиргааны түвшнийг дээшлүүлэх юм. |
| EBRD | Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD) нь хувийн хэвшил, бизнес эрхлэгчдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий дэлхийн гурван тив, 40 гаруй оронд үйл ажиллагаа явуулж буй олон талт банк юм. EBRD нь 71 улс, Европын Холбоо, Европын Хөрөнгө Оруулалтын Банкны эзэмшилд байдаг. |

СЗХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| GREEN CLIMATE FUND | Уур Амьсгалын Ногоон Сан (GCF) нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн конвенцын хүрээнд 2010 онд байгуулагдсан сан юм. GCF нь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулж, цаг уурын өөрчлөлтөд дасан зохицох, ирээдүйд уур амьсгалын өөрчлөлтөд тэсвэртэй хөгжлийн замыг бий болгох талаар улс орнуудыг дэмжин ажилладаг. Ногоон санхүүжилтийг магадлан итгэмжлэгдсэн байгууллагаар дамжуулан олгодог бөгөөд ХасБанк нь GCF-ийн Монгол улс дахь үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар хоёр дахь удаагаа магадлан итгэмжлэгдсэн юм. |
| IBEC International Bank for Economic Co-operation | Олон Улсын Эдийн Засгийн Хамтын Ажиллагааны Банк (IBEC) нь 1963 онд байгуулагдсан олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. IBEC-ийн үндсэн зорилго нь өөрийн гишүүн найман орны эдийн засгийн хөгжил, гадаад худалдааны харилцааг дэмжихэд чиглэдэг бөгөөд Монгол Улс нь гишүүн орнуудын нэг нь юм. IBEC нь ХасБанктай хамтран экспорт, импортын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг аж ахуй нэгжийг санхүүжүүлэх зорилгоор хамтран ажиллаж байна. |
| PROPARCO Groupe Agence Française de Développement | PROPARCO нь хувийн хэвшилд чиглэсэн эдийн засаг, нийгэм, байгаль орчны тогтвортой хөгжлийг дэмжих зорилго бүхий Францын Хөгжлийн Агентлагийн үүсгэн байгуулсан санхүүгийн байгууллага юм.<br>PROPARCO нь дэлхийн 80 оронд үйл ажиллагаагаа явуулдаг бөгөөд 500 гаруй жижиг дунд бизнес эрхлэгчид, бичил санхүүгийн байгууллагууд, бүс нутгийн банкнуудтай хамран ажилладаг. |
| OPEC FUND | OFID нь 1976 онд байгуулагдсан бөгөөд дэлхий даяар нийгэм, эдийн засгийн тогтвортой хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилгоор төр, хувийн болон худалдааны салбарт санхүүжилт олгодог хөрөнгө оруулалтын сан юм. |
| finnfund | FinnFund нь Финландын төрийн болон хөрөнгийн зах зээлийн санхүүжилттэй хөгжлийн санхүүгийн байгууллага юм. Finnfund нь хөрөнгө оруулалт, урт хугацаат зээл, хөгжиж буй орнуудын хэрэгжүүлж буй төслүүдэд хөрөнгө оруулалт хийдэг ба олсон ашгаа дахин хөрөнгө оруулах замаар тогтвортой хөгжлийг дэмжин ажилладаг. |
| incofin Investment Management | Incofin нь хөгжиж буй орнуудын бичил санхүүгийн байгууллагуудад хөрөнгө оруулалт хийдэг санхүүгийн байгууллага юм. Тус байгууллага нь банк санхүүгийн үйлчилгээг авах боломжгүй хүн амд зээл, хадгаламж, даатгал зэрэг санхүүгийн үйлчилгээг хүргэхийг зорьдог. Мөн хөдөө аж ахуйн салбарт идэвхтэй ажилладаг, алслагдмал бүст үйл ажиллагаа явуулж буй бизнес эрхлэгчдэд санхүүжилт олгоход дэмжлэг үзүүлдэг. |
| Developing World Markets | АНУ-д төвтэй хөрөнгө оруулалтын удирдлагын DWM байгууллага нь хөгжиж буй эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих зорилготой бөгөөд зөвхөн хөгжиж буй зах зээлд хөрөнгө оруулалт хийдэг байгууллага юм. 1994 онд хувийн хөрөнгө оруулалттайгаар үүсгэн байгуулагдсан тус байгууллага нь Голланд, Герман, Япон зэрэг олон улсын зах зээлээс өдгөө 2 тэрбум гаруй ам.долларын санхүүжилтийг босгосон бөгөөд тэдгээрийн хөрөнгө оруулалтыг удирдан үйл ажиллагаа явуулдаг. |
| symbiotics | Symbiotics нь хөгжиж буй орнуудын бичил, жижиг, дунд үйлдвэрлэл болон бага-дунд орлоготой өрхийг дэмжих, санхүүжүүлэх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг тэргүүлэгч хөрөнгө оруулалтын компани юм. Тус компани нь хөрөнгө оруулалтын багцын удирдлага, санхүүгийн зөвлөгөө өгөх чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг бөгөөд нийт 25 гаруй санг удирдаж байна. |
| BIO Investing in a Sustainable Future | BIO нь хөгжиж буй орнуудын хувийн хэвшлийг дэмжин, тогтвортой хөгжлийн зорилтуудад хүрэх боломжийг олгох зорилго бүхий Бельгийн санхүүгийн байгууллага юм. BIO нь санхүүгийн салбар, томоохон аж ахуйн нэгжүүд, дэд бүтцийн төслүүдэд түлхүү хөрөнгө оруулалт хийдэг. |

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| FRONTERA CAPITAL | Frontera Capital нь хөгжиж буй зах зээлд голчлон хөрөнгө оруулалт хийдэг хөрөнгө оруулалтын компани юм. Санхүүгийн зах зээлийн өргөн туршлагатай тус байгууллага нь дэлхийн 125 гаруй улсын мөнгөний зах, валют арилжаа, засгийн газрын үнэт цаасны арилжаа зэрэгт идэвхтэй оролцдог. |
| BlueOrchard Impact Investment Managers | BlueOrchard нь 20 гаруй жилийн туршлагатай, хөрөнгө оруулалтын сан бөгөөд дэлхий даяар 260 сая гаруй хүнд үйлчилж буй томоохон бичил санхүүг дэмжигч байгууллага юм. BlueOrchard нь тус санд хөрөнгө оруулалт хийсэн мэргэжлийн хөрөнгө оруулагчдын хамтаар орлогын тэгш бус байдал болон уур амьсгалын өөрчлөлтийг бууруулахад чиглэсэн үйл ажиллагааг дэмждэг. |
| SIFEM SWISS INVESTMENT FUND FOR EMERGING MARKETS | SIFEM нь Швейцар улсын Хөгжлийн санхүүжилтийн байгууллага юм. Тус байгууллага эдийн засгийн тогтвортой хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулах зорилгын хүрээнд жижиг дунд бизнес эрхлэгчдэд хөрөнгө оруулах, санхүүжилт олгох чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. |

## 1.14 Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл

Үнэт цаас гаргагч нь дэлхийн хамгийн нэр хүндтэй үнэлгээний агентлагууд болох Moody's Investors Service болон Fitch Ratings байгууллагуудаар өөрийн зээлжих зэрэглэлийн үнэлгээг 2008 оноос хойш тасралтгүй хийлгүүлж байна. 2022 оны байдлаар тус агентлагуудаас гаргасан үнэлгээний тайланд Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэлийг дараах байдлаар үнэлсэн болно. Үүнд:

Хүснэгт 13: Зээлжих зэрэглэл - Moody's Investor Service

| Moody's Investor Service-ийн үнэлгээ: | ХасБанк | Монгол Улс |
|---|---|---|
| Зээлжих зэрэглэл - Гадаад валют | B3/NP | B3/NP |
| Зээлжих зэрэглэл- Төгрөг | B2/NP | B2/NP |
| Банкны хадгаламж | B3/NP | B3/NP |
| Суурь зээлжих зэрэглэл | B3 | B3 |
| Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл | B3 | B3 |
| Хэтийн төлөв | Stable | Stable |

Хүснэгт 14: Зээлжих зэрэглэл - Fitch Ratings

| Fitch Ratings-ийн үнэлгээ: | ХасБанк | Монгол Улс |
|---|---|---|
| Урт хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл | B/тогтвортой | B/тогтвортой |
| Богино хугацааны гадаад валютын зээлжих зэрэглэл | B | B |
| Урт хугацааны төгрөгийн зээлжих зэрэглэл | B/тогтвортой | B/тогтвортой |

## 1.15 Байгаль орчин, нийгэм, засаглалын (ESG) үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь Эрдэнэт хүмүүн, Эх дэлхий, Эрүүл ашиг гэсэн гурван тулгуурт зарчмыг мөрдлөг болгон ажилладаг бөгөөд өөрийн бизнесийн үйл ажиллагаагаар дамжуулан нийгэм болоод байгаль орчинд эерэг үйл ажиллагаа явуулахыг хичээдэг. Мөн аливаа хууль бус, ёс зүйгүй, байгаль орчинд хор нөлөөтэй бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээс эрс татгалзаж, ESG-ийн зарчмуудыг үйл ажиллагаандаа мөрдөн ажилладаг.

### 1.15.1 Нийгмийн хариуцлага

Үнэт цаас гаргагч нь нийгмийн хариуцлагаа өндөрт ухамсарлаж Монгол Улсын соёлын өвийг дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудын эрдэм мэдлэгийг дээшлүүлэх, байгаль орчныг

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

хамгаалах, урлаг спортыг хөгжүүлэх чиглэлээр дараах үйл ажиллагааг жил бүр зохион байгуулж, хамтран ажилладаг. Үүнд:

Хүснэгт 15: Нийгэмд чиглэсэн үйл ажиллагаа

| | |
|---|---|
| **Мод тарих ХасТөгөл аян** | 2008 оноос эхлэн "ХасТөгөл" мод тарих аяныг жил бүр зохион байгуулж, 21 аймаг, Улаанбаатар хотод 30 ногоон төгөл байгуулсан. 2022 онд "ТЭРБУМ МОД" үндэсний хөдөлгөөний Баруун салаа, Үндэсний цэцэрлэгт хүрээлэн, Зайсангийн аманд мод тарьсан. Мөн ТЭРБУМ МОД санд өөрийн үйл ажиллагааны орлогоос санхүүжилт олгон ажиллаж байна. |
| **"Органик Монгол" хөтөлбөр** | "Органик Монгол" хөтөлбөрийн хүрээнд хүнсний ногоо тарих чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг харилцагчдадаа хөнгөлөлттэй нөхцөлөөр зээлд хамрагдах боломжийг олгож байна. |
| **"Афлатон" санхүүгийн боловсролын хөтөлбөр** | 8-13 насны хүүхдүүдэд нийгэм, санхүүгийн боловсрол олгох хөтөлбөр бөгөөд дэлхийн 100 гаруй оронд хэрэгжиж байна. Хөтөлбөрт хот, хөдөөгийн 17 сургуулийн 2500 сурагч хамрагдсан. |
| **"Тэмүүлэл" санхүүгийн боловсролын хөтөлбөр** | 2009 оноос эхлэн Дэлхийн Эмэгтэйчүүдийн Банктай (WWB) хамтран 14-18 насны сурагч хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох зорилгоор нийт 13 модультай "Тэмүүлэл" хөтөлбөрийг хэрэгжүүлж эхэлсэн нь 2017 оноос ЕБС-ийн хичээлийн хөтөлбөр албан ёсоор орсон. |
| **"Boom 2020" хүүхдийн хөл бөмбөгийн тэмцээн** | 2006 оноос хойш "Boom-2020" хөл бөмбөгийн тэмцээнийг санаачлан ивээн тэтгэж ирсэн бөгөөд "Boom-2020" хөл бөмбөгийн тэмцээнд оролцсон хүүхдүүдэд санхүүгийн боловсрол олгох сургалтыг зохион байгуулан ажиллаж байсан. |
| **Хасын Хүлэгүүд сагсан бөмбөгийн баг** | Монгол Улсад багийн спортыг хөгжүүлэх, сурталчлан таниулах ажилд идэвхтэй ажиллаж ирсэн бөгөөд 2004 онд Хасын хүлгүүд сагсан бөмбөгийн багийг үүсгэн байгуулж, өдгөө 19 дэх жилдээ тасралтгүй дэмжин ажиллаж байна. |
| **Спортын хамтын ажиллагаа** | - ХасБанк дугуйн клуб /2016-2019/ албан ёсны спонсор.<br>- Хасын хүлэгүүд хоккейн баг /2015-2016/ албан ёсны спонсор.<br>- Хасын хүлэгүүд хөл бөмбөгийн баг /2006-2012/ албан ёсны спонсор.<br>- Монголын е-спортын хөгжилд хувь нэмрээ оруулж байна.<br>- Бээжин 2022 өвлийн олимпын наадамд оролцож буй тамирчдаа дэмжиж, Монголын Үндэсний Олимпын Хорооны албан ёсны түншээр хамтран ажиллалаа.<br>- "Мэргэн академи" хүүхдийн хоккейн клубтэй хамтран ажиллаж, хоккейн спортоор хичээллэгч хүүхэд багачуудыг дэмжиж байна. |
| **ТАСАМ** | Тэнгэрлиг өвөг дээдсийнхээ мөрөөр замнаж, тэдний үлдээсэн үнэлж баршгүй өв соёлыг сурвалжлан, хойч үе төдийгүй дэлхий нийтэд сурталчлан таниулах эрхэм үйлсэд Тархан суурьшсан Монголчууд буюу ТАСАМ ТББ-ыг дэмжин, баримтат кино, ном, гэрэл зургийн үзэсгэлэн зэрэг олон төсөлд хамтран ажилласан. |
| **Харилцагчийг хамгаалах ухаалаг хөдөлгөөн** | ХасБанк Харилцагчийг хамгаалах ухаалаг хөдөлгөөнд нэгдэж, тус хөдөлгөөний 7 зарчим 99 шалгуур үзүүлэлтийг бүрэн хангасан хэмээн батламжлагдсан арилжааны банк бөгөөд энэ хүрээнд Ил тод, нээлттэй байх, Харилцагчийг өрийн дарамтаас хамгаалах, Харилцагчийн мэдээллийн нууцлал, аюулгүй байдлыг хангах, Харилцагчийн гомдлыг хүлээн авч, шийдвэрлэх зэрэг зарчмуудыг мөрддөг. |
| **Тосонхулстай** | "The Nature Conservancy" байгууллагатай 2013 оноос хамтран ажиллаж, Дорнод, Хэнтийн тал хээрийн бүсийг хамгаалахад хувь нэмрээ оруулж байна. Энэхүү ажлын хүрээнд тус бүс нутгийн нуур, булгийн ус, бэлчээрийн даац, ан амьтан, биологийн төрөл зүйлийн судалгаа хийх, байгаль хамгаалагч ажиллуулах, нутгийн ард иргэдэд |

СЭЗХ 2023.05.12 БҮРТГЭВ №01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| | сургалт хийх, хууль бус алт олборлогч, хулгайн анчидтай тэмцэх, булаг, шанд хамгаалж, хашаа хайс барих зэрэг ажлуудад хамтран ажиллаж байна. |
| **ХАС Холбоо ТББ** | ХасБанкны ажилтнуудын санаачилгаар нийгэм байгаль орчинд хувь нэмэр оруулах, хүүхэд багачуудын сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулах зорилготой Хөгжлийн Алтан Сан Холбоо ТББ-ыг 2003 онд байгуулсан бөгөөд тус ТББ-аар дамжуулан хүүхэд залуусын санхүүгийн боловсрол олгох чиглэлээр олон үйл ажиллагаа явуулсан. |
| **Ном, бичиг соёл түгээх** | Тархан суурьшсан монголчууд ТББ-тай хамтран Перс, Англи хэлнээ Их Монгол Улсын 810, Монголын Ил Хант Улсын 760 жилийн ойд зориулан гаргасан “Ил хаадын Урлаг, соёлын бүтээлүүд”, “Эзэнт гүрний соёрхолт өв: Уран барилгууд” номыг эрхлэн гаргасан.<br><br>Зураач Р.Батцэнгэлтэй хамтран “Монголын Нууц Товчоо” түгээмэл эх.<br><br>Нэрт эрдэмтэн Бямбын Ринчений бүтээлүүдийн эмхэтгэл 4 боть.<br><br>Богино өгүүллэгийн нэрт мастер Жагдалын Лхагвын “Толгодын цаана ингэ буйлна” шилмэл өгүүллэгийн түүврийг ивээн тэтгэж хэвлүүллээ.<br><br>Болор судар хэвлэлийн газраас эмхтгэн гаргасан Төрийн шагналт зохиолууд 3 боть. |
| **Өв соёл түгээх** | Соёлын олон төрлийг хөгжүүлэх, техник технологийн дэвшилд тулгуурласан дэлхийн шилдэг бүтээлийг Монголын үзэгчдэд хүргэх, дүрслэх урлагийн салбарын олон улсын хамтын ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор Монголын Урлагийн Зөвлөлөөс “Ул мөр” сэдвийн дор зохион байгуулсан “Улаанбаатар” ОУ-ын медиа урлагийн наадмыг 2 жил ивээн тэтгэж хамтран ажилласан.<br><br>Бүгд Найрамдах Франц Улсад зохион байгуулагдсан Монгол соёлын өдрүүд болон Монгол Улс ЮНЕСКО-д элссэний 60 жилийн ойд зориулж ЮНЕСКО-ийн төв байранд зохион байгуулагдсан МОНГОЛЫН САЙХАН ОРОН дижитал фото үзэсгэлэн дэмжиж хамтран ажилласан. |
| **Оюутны тэтгэлэгт хөтөлбөр** | ХасБанкны ТУЗ-ийн гишүүн асан Питер Морроугийн нэрэмжит оюутны тэтгэлэгт хөтөлбөрийг 7 дахь жилдээ амжилттай зохион байгуулж, Банк, санхүү, эдийн засаг, бизнесийн удирдлага, дата аналист, мэдээллийн технологийн чиглэлээр амжилттай суралцаж буй оюутнуудын сургалтын төлбөрт дэмжлэг үзүүлж байна.<br><br>Мэдээллийн технологийн чиглэлээр суралцаж буй оюутан залууст банкнаас ажлын гараагаа эхлүүлэх боломжийг олгох зорилготой “Цалинтай оюутан” хөтөлбөрийг 3 дахь жилдээ зохион байгуулж, шалгарсан оюутнууд цалинтай дадлага хийж байна.<br><br>Шударга Ёсыг Бадраах сантай хамтран оюутны тэтгэлэгт хөтөлбөртэй 11 дэх жилдээ хамтран ажиллаж байна. |
| **Эрүүл мэнд** | Гэмтэл согог судлалын үндэсний төвийн Ясны үений гэмтлийн I тасаг болон Нэгдсэн мэс заслын тасгуудыг бүрэн засах төсөлд хамтран ажилласан.<br><br>ЭХЭМҮТөвд хүүхдийн нарийн мэргэжлийн эмчээр мэргэшин бэлтгэгдэж буй резидент эмч нарын сурах, ажиллах орчныг сайжруулах төсөлд хамтран ажилласан.<br><br>“Зүрх мартахгүй” төсөлтэй хамтран ажилласан.<br><br>Ковид-19 цар тахлын халдвараас урьдчилан сэргийлэх, эмч, эмнэлгийн байгууллагын ажилтнууд болон онцгой байдлын албан |

СЗХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

хаагчдад шаардлагатай хувцас, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж зэрэг бусад зүйлсийг авахад хамтран ажилласан.

### 1.15.2 Байгаль орчинд ээлтэй үйл ажиллагаа

Үнэт цаас гаргагч нь 2001 онд үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш бичил, жижиг дунд бизнесийг санхүүжүүлэн ирсэн бөгөөд тогтвортой байдлыг чухалчлан үзэж, нийгэм, байгаль орчны асуудалд онцгой анхаарч ирсэн.

Үнэт цаас гаргагч нь Тогтвортой Санхүүгийн зарчмууд, Монгол Улсын ногоон таксономид нийцүүлэн үйл ажиллагаагаа явуулж, 2019, 2020, 2021 онуудад Монголын Тогтвортой Санхүүгийн Холбооноос өндөр үнэлгээнүүдийг авч байсан. Мөн Тогтвортой Санхүүгийн Зарчмын дор нэгдсэн олон улсын банк, санхүүгийн байгууллагуудын үүсгэн байгуулсан GABV (https://www.gabv.org/) холбооны үүсгэн байгуулагч гишүүдийн нэг юм.

GABV-ийн хамтын зорилго нь банкуудын үйл ажиллагааг илүү ил тод болгож, эдийн засаг, нийгэм, байгаль орчны эерэг өөрчлөлтийг дэмжих явдал юм.

Тус эвслийн гишүүн банкууд нь Тогтвортой Санхүүжилтийн Зарчмуудад нийцүүлэн үйл ажиллагаа явуулдаг бөгөөд олон улсад тулгараад буй бэрхшээлүүдэд шийдэл олж өнөөгийн санхүүгийн тогтолцоог орлох шинэ, эерэг, тогтвортой хувилбарыг төлөвшүүлэхэд зорьж байна. Эдийн засгийн хувьд харилцан хамааралтай, өнөөгийн болон хойч үеийн өмнө хариуцлага хүлээх болно гэдгийг ухамсарлан эдгээр компани, байгууллагууд нь эх дэлхий дахь хүн бүхний амьдралын чанарыг сайжруулах шаардлагатай гэдэгт итгэл үнэмшилтэй байдаг.

Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь 2007 оноос хойш НҮБ-ын Тогтвортой Хөгжлийн Зорилтуудыг дэмжин, түүний арван зорилтуудыг өөрийн компанийн бодлого, бизнесийн үйл ажиллагаанд тусган ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь НҮБ-ийн Даян Дэлхийн Гэрээнд дэмжлэг үзүүлэх замаар хүний эрх, хөдөлмөрийн эрх, байгаль орчныг дээдэлж, хээл хахууль болон авлигатай тэмцэн тогтвортой хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд өөрийн хувь нэмрийг оруулан ажилладаг.

2022 оны байдлаар Тогтвортой Хөгжлийн Зорилтуудын хүрээнд гаргасан ажлаас дурдвал:

Хүснэгт 16: Тогтвортой Хөгжлийн Зорилтын хүрээнд хийгдэж буй ажлууд

| Зорилт | Хийгдэж буй ажил | Зорилт | Хийгдэж буй ажил |
|---|---|---|---|
| 1 | **Ядуурлыг бууруулах:** ХасБанкны төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд хэрэгжүүлж буй хөнгөлөлттэй эко зээл, хүүгийн татаастай эрчим хүчний хэмнэлттэй бүтээгдэхүүн нь эцсийн хэрэглэгчдэд боломж болон хүртээмжийг нэмэгдүүлдэг. | 9 | **Инноваци болон дэд бүтцийг нэмэгдүүлэх:** ХасБанк нь том хэмжээний нарны цахилгаан станцыг бүрэн санхүүжүүлсэн Монголын анхны арилжааны банк болсон. |
| 3 | **Эрүүл мэндийг дэмжих:** Эрчим хүчний хэмнэлттэй (ЭХХ) бүтээгдэхүүн борлуулах хөтөлбөрийн хүрээнд 173,852 ЭХХ-тэй бүтээгдэхүүнийг 150,489 өрхөд борлуулж нүүрсхүчлийн хий болон агаарын бохирдлыг бодитоор бууруулсан. | 10 | **Тэгш бус байдлыг бууруулах:** Мерси Кор Олон Улсын байгууллагатай хамтран туршилтын журмаар хэрэгжүүлсэн Ногоон бэлчээрийн төсөл нь Монголын бэлчээрийн доройтолтой газар нутгийн малчдад уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг бууруулах зорилготой юм. |
| 5 | **Хүйсийн эрх, тэгш байдлыг хангах:** Уур Амьсгалын Ногоон Сантай хамтран хэрэгжүүлж буй Хүлэмжийн хийг бууруулах бизнес зээлийн хөтөлбөрийн 50-иас доошгүй хувь нь эмэгтэй бизнес | 11 | **Ээлтэй хот, иргэдийн оролцоог дэмжих:** ХасБанкны Эко автомашины зээлийн хөтөлбөр нь утаа бага ялгаруулдаг 1,067 тээврийн хэрэгслийн худалдан авалтын санхүүжилтийг олгосон бол бизнесийн |

ХАСБАНК
УХН 4937 2578697

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

эрхлэгчдэд чиглэсэн байдаг. Тус тоо 2018 оны байдлаар 77.9% -д хүрсэн.



**Баталгаат ундны ус, ариун цэврийн байгууламжаар хангах:** ХасБанкны хамтран санхүүжүүлсэн 10 МВт-ын хүчин чадалтай Нарны цахилгаан станц нь 25 жилийн ашиглалтын хугацаанд ойролцоогоор 4.3 тэрбум литр усыг хэмнэнэ.



**Сэргээгдэх эрчим хүчийг нэвтрүүлэх:** ХасБанкны хамтран санхүүжүүлсэн 10 МВт-ын хүчин чадалтай нарны цахилгаан станц нь 15,395 мВт/жил бага нүүрстөрөгч бүхий эрчим хүчийг Төвийн Бүсийн Эрчим Хүчний Системд нийлүүлж байна.

зээл нь агаарын бохирдлыг бууруулсан байна.



**Хариуцлагатай хэрэглээг дэмжих:** Уур амьсгалын Ногоон сантай хамтран хэрэгжүүлж буй зээлийн хөтөлбөрүүд нь бизнес болон өрхийн байгаль орчинд нөлөөлөх нөлөөллийг эрчим хүчний хэмнэлттэй худалдан авалтаар бууруулах боломжийг олгож байна.



**Уур амьсгалын өөрчлөлтийн үр нөлөөг багасгах:** Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах Үндэсний хүлээсэн үүрэг болон Ногоон Хөгжлийн бодлогын хүрээнд хүлэмжийн хийг бууруулж байна.

Мөн Үнэт цаас гаргагч нь олон улсын нэр хүнд бүхий хөгжлийн санхүүгийн байгууллагуудын нэгэн адилаар хууль бус, ёс зүйгүй, байгаль орчинд сөрөг нөлөөтэй бизнесийн үйл ажиллагааг санхүүжүүлэхээс эрс татгалздаг. Санхүүжүүлэхээс татгалздаг үйл ажиллагааг дурдвал:

- Монгол улсын хууль, тогтоомж, олон улсын гэрээ конвенцээр зөвшөөрөгдөөгүй, хууль бус үйл ажиллагаа;
- Галт зэвсгийн үйлдвэрлэл, худалдаа;
- Архины төрлийн үйлдвэрлэл болон худалдаа (шар айраг, дарснаас бусад);
- Тамхины үйлдвэрлэл, худалдаа;
- Мөрийтэй тоглоом, казино болон түүнтэй ижил төрлийн үйл ажиллага;
- CITES-ээр зохицуулагдсан амьд байгаль эсвэл амьд байгалийн бүтээгдэхүүний худалдаа;
- Цацраг идэвхт материалын үйлдвэрлэл, худалдаа;
- Нийлмэл буюу шөрмөсөн чулуу (асбестос)-ны үйлдвэрлэл, худалдаа, хэрэглээ;
- Хяналтгүй, хориотой ойгоос бэлтгэсэн мод болон модон бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;
- PCB-ийн агууламж бүхий бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа;
- Халуун орны чийглэг ой эсвэл онгон зэрлэг ойгоос арилжааны зориулалтаар мод бэлтгэх үйл ажиллагаа болон эдгээр газраас мод бэлтгэх тоног төхөөрөмж худалдаа;
- Хүчээр хөдөлмөрлүүлэх, хүүхдэд хөнөөлтэй хөдөлмөрийн оролцоо бүхий үйлдвэрлэл, үйл ажиллагаа;
- Химийн хортой материалыг их хэмжээгээр үйлдвэрлэх, худалдах, хадгалах, тээвэрлэх, химийн хортой материалуудыг арилжааны цар хүрээгээр хэрэглэх;
- Олон улсын хэмжээнд хэрэглээнээс гарч байгаа, хориглосон эмийн бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаа.

### 1.15.3 Уур Амьсгалын Ногоон Сантай хамтарсан Ногоон Санхүүжилт

Үнэт цаас гаргагчийн Эко банкны нэгж нь бизнесийн үйл ажиллагааны төрөл тус бүрээр хүлэмжийн хийн ялгарлын суурь үзүүлэлтийг тогтоох, эрчим хүчний хэмнэлтийг хэмжих, тогтвортой санхүүгийн шийдлүүдийг санал болгох чиглэлээр мэргэшсэн бизнесийн нэгж юм. Тус нэгж нь 2009 онд анх байгуулагдсан бөгөөд эко төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх, нүүрстөрөгчийн санхүүжилт, тогтвортой эрчим хүчний санхүүжилт хийх гэсэн гурван үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг.

Үнэт цаас гаргагч нь НҮБ-ын Уур амьсгалын өөрчлөлтийн суурь конвенцын хүрээнд уур амьсгалын өөрчлөлтөд дасан зохицох, нөлөөллийг сааруулахад зориулж хөгжингүй орнуудаас хөгжиж буй орнуудад олгох санхүүжилтийн гол механизм болох Уур амьсгалын ногоон сан (УАНС)-гийн магадлан итгэмжлэгдсэн Монгол Улсын анхны арилжааны банк юм.




УАНС нь Үнэт цаас гаргагчийн хамтран ажилладаг тогтвортой санхүүжилтийн хамгийн том түнш байгууллага бөгөөд 2019 онд "Эрчим хүчний хэмнэлттэй хэрэглээний зээлийн хөтөлбөр"-ийг эхлүүлсэн нь тус сангийн Хялбаршуулсан батлах үйл явц (SAP) аргачлалаар батлагдсан анхны хувийн хэвшлийн санхүүжилтийн санал байсан юм. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн санхүүжилттэй Сүмбэрийн нарны цахилгаан станц нь 2019 оны 3 дугаар сард Монгол Улсын төвийн сүлжээнд эрчим хүч нийлүүлж эхэлсэн нь УАНС-ийн хамтарсан санхүүжилтээр Монголд хэрэгжүүлсэн төдийгүй тус сангийн хувьд бүрэн хэрэгжиж дууссан анхны томоохон төсөл болсон байна.

УАНС-ийн Удирдах зөвлөлийн 34 дэх удаагийн хурал 2022 оны 10 дугаар сарын 17-ны өдрөөс 20-ны өдрүүдэд БНСУ-ын Инчеон хотноо болж, уг хурлаар Үнэт цаас гаргагчийг УАНС-ийн Үндэсний хэрэгжүүлэгч байгууллагаар 2 дахь удаагаа магадлан итгэмжилсэн байна.

Үнэт цаас гаргагчийн өнгөрсөн хугацаанд олгосон ногоон санхүүжилтүүдийн үр дүнд нийт 2.1 сая тонн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулсан гэсэн тооцоо гарсан байна.

СЭХ
2023 05 12
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

# Хоёр. МАКРО ЭДИЙН ЗАСГИЙН БОЛОН ЗАХ ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ

## 2.1 Макро эдийн засгийн үзүүлэлтүүд

### 2.1.1 Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)

2022 онд ДНБ 52.9 их наяд төгрөгт хүрч нэрлэсэн үнээр өмнөх оноос 21.4%-р өссөн бол 2015 оны зэрэгцүүлсэн үнээр тооцсон бодит ДНБ 28.4 их наяд төгрөгт хүрч өмнөх оноос 4.8%-р өссөн байна. Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуй, бүтээгдэхүүний цэвэр татвар, үйлчилгээний салбарууд, бөөний болон жижиглэнгийн худалдаа, барилга, аж үйлдвэрийн салбарууд зэрэг нөлөө үзүүлсэн байна.

График 1: Дотоодын Нийт Бүтээгдэхүүн







Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

### 2.1.2 Гадаад худалдааны тэнцэл

Гадаад худалдааны нийт бараа эргэлтийн хэмжээ 2022 онд өмнөх оноос 32.1%-р (5.2 тэрбум ам.доллар) өсөж 21.2 тэрбум ам.долларт хүрчээ. Үүнд, экспорт 35.7%-р өсөж 12.5 тэрбум ам.доллар, импорт 27.2%-р өсөж 8.7 тэрбум ам.долларт тус тус хүрснээр гадаад худалдааны тэнцэл 3.8 тэрбум ам.долларын ашигтай гарсан байна.

График 2: Экспорт, Импортын бүтэц







Экспортыг гол түнш улсуудаар задалж харвал дийлэнх буюу 84.4%-ийг БНХАУ-руу, 8.2% -ийг Швейцар Улс руу экспортолсон бараа бүтээгдэхүүн бүрдүүлжээ. БНХАУ-руу гаргаж буй

ХАСБАНК
УХН:037 2578697

экспортын 56.8%-ийг нүүрс, 25.9%-ийг зэсийн баяжмал тус тус бүрдүүлж байгаа бол Швейцар Улс руу гаргаж буй экспортын 99.7%-ийг алтны экспорт бүрдүүлж байна. 2022 оны эхний улиралд БНХАУ-ын Ковид-19 цар тахлын эсрэг хэрэгжүүлсэн хатуу хязгаарлалттай холбоотойгоор хил дээрх нэвтрүүлэлт удааширч улмаар нүүрсний экспортын хэмжээ өмнөх оны мөн үеэс 63%-иар буураад байсан хэдий ч хил гаалийн асуудал аажмаар хэвийн болсноор экспорт хоёрдугаар улирлаас сэргэж 2022 оны эцэс гэхэд 31.8 сая тонн нүүрс экспортолсон нь өмнөх оноос 97%-иар өссөн үзүүлэлт юм.

Импортын хувьд 2022 онд мөн 27.2%-р өсөж 8.7 тэрбум ам.долларт хүрэхэд дизель түлш, автобензин, хүнс, суудлын автомашин, болон барилгын материал бусад тоног төхөөрөмжийн импорт өссөн нь нөлөөллөө. Нийт импортын 35.3%-ийг БНХАУ-аас, 30%-ийг ОХУ-аас импортолсон бараа бүтээгдэхүүн бүрдүүлсэн байна.

### 2.1.3 Төгрөгийн гадаад валюттай харьцах ханш

2020, 2021 онуудад харьцангуй тогтвортой байсан төгрөгийн албан ханш 2022 онд ам.долларын эсрэг 20.9%-р суларч, оны эцэст 3,445 төгрөгт хүрээд байна. Мөн гадаад худалдааны гол түнш болох БНХАУ-ийн Юаны эсрэг төгрөгийн ханш 10.8%-р суларсан байна.

График 3: Юан болон Ам.долларын төгрөгтэй харьцах ханш




Эх сурвалж: Монголбанк

2022 онд Монгол Улсын төлбөрийн тэнцлийн алдагдал 0.7 тэрбум ам.доллар, урсгал дансны алдагдал 2.6 тэрбум ам.долларт хүрсэн нь төгрөгийн ханш сулрах гол нөхцөл болов. Энэхүү төлбөрийн тэнцлийн алдагдал нь санхүүгийн болоод санхүүгийн бус олон хүчин зүйлээс хамааралтай байсанг энд дурдах нь зүйтэй. Улмаар 2021 оны эцэст 4.4 тэрбум ам.долларт хүрээд байсан гадаад валютын албан нөөц (ГВАН) 2022 оны эцэс гэхэд 22.1%-иар буурч 3.4 тэрбум ам.долларт хүрсэн байна.

СЭХ 2023.05.12 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

### 2.1.4 Инфляц

Цар тахлын нөхцөл байдлаас шалтгаалсан дэлхий даяар нийлүүлэлтийн сүлжээний тасалдал, эдийн засгаа сэргээх хөтөлбөрийн хүрээнд явуулсан мөнгөний тэлэх бодлого зэргээс шалтгаалан эрчим хүч, хүнс болон бусад бараа, бүтээгдэхүүний үнийн өсч, дэлхийн ихэнх улс орнуудад инфляц нэмэгдсэн. Монгол Улсын хувьд ч дээрх нөхцөл байдал бий болж, улмаар 2022 оны 12 дугаар сарын байдлаар инфляц 13.2%-д хүрч Монголбанкны зорилтот түвшнээс даруй 5.2 нэгж хувиар өндөр байна. Инфляцыг бүрэлдэхүүнээр задалж харвал хүнсний бараа, ундаа, ус, хувцас бөс бараа, орон сууц цахилгаан, хийн болон бусад түлш, эм тариа эмнэлгийн үйлчилгээний бүлгийн үнийн өсөлт инфляц өндөр гарахад голлон нөлөөлсөн байна. Хил гаалийн хязгаарлалт, худалдааны түнш орнуудын инфляц, төгрөгийн ханшийн сулрал зэрэг нөлөөгөөр импортын бүтээгдэхүүний үнэ өссөн нь инфляцын 40% орчмыг бүрдүүлж байна.

График 4: Инфляц




Эх сурвалж: Монголбанк

Түүнчлэн цар тахлын дараа уул уурхайн бус эдийн засгийн үйл ажиллагаа аажмаар сэргэж эрэлтийн шалтгаантай инфляц мөн нэмэгдэх хандлага ажиглагдаж байна. Монголбанк төгрөгийн өгөөжийг өсгөх, эрэлтийн гаралтай инфляйн шалтгаан, хүлээлтийг тогтворжуулах зорилгоор 2022 онд 5 удаагийн мөнгөний бодлогын хорооны шийдвэрээр бодлогын хүүг 6%-с 13%-д хүргэж, мөнгөний бодлогыг хатууруулж ажиллав. Төрөөс мөнгөний бодлогын талаар 2023 онд баримтлах үндсэн чиглэлд Монголбанк инфляцыг 2023 онд 1 оронтой тоонд барих, дунд хугацаанд 6% (+/-2%) байлгахаар зорьж байна.

### 2.1.5 Ажилгүйдэл

Цар тахлын нөхцөл байдлаас үүдэн гарсан удаа дараагийн хөл хорио, хязгаарлалтуудаас шалтгаалан 2020 онд хөдөлмөрийн захын идэвхжил суларч, ажилгүйдлийн түвшин нэмэгдэж эхэлсэн. Энэхүү нөхцөл байдал 2021 оны эхний улирал хүртэл үргэлжилсэн бөгөөд дээр дурдсан хязгаарлалтууд аажмаар суларч эхэлснээр ажилгүйдлийн түвшин 2022 оны 2 дугаар улирлаас эхлэн буурах хандлагатай болж байна. 2022 оны эцсийн байдлаар ажилгүйдлийн түвшин 5.3% буюу сүүлийн 5 жилийн хамгийн доод түвшинд хүрсэн бөгөөд энэ нь үйлдвэрлэл, үйлчилгээ, худалдааны салбаруудад цар тахлын дараах сэргэлт үргэлжилж улмаар хөдөлмөрийн зах зээлийн идэвхжил сэргэсэнтэй холбоотой.

График 5: Ажилгүйдлийн түвшин, оролцооны түвшин




Эх сурвалж: Үндэсний Статистикийн Хороо

## 2.2 Эдийн засгийн хэтийн төлөв

**Хөрөнгө оруулагчдын анхааралд: Энэхүү дэд бүлэгт орсон мэдээлэл, таамаглал нь үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн олон нийтэд нээлттэй мэдээлэл, тоо баримт дээр үндэслэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуурх буюу гадаад орчны олон хүчин зүйлээс хамааран үр дүн, таамаглал, төсөөлөл нь өөрчлөгдөж болохыг анхаарна уу. Гадаад орчны хүчин зүйлсэд тухайлбал макро эдийн засаг болон улс төрийн орчин, дэлхийн зах зээлийн нөхцөл байдал, инфляц, валютын ханш, КОВИД19 цар тахлын үргэлжилсэн болон дам нөлөө, хөрөнгийн зах зээл, банкны салбарын орчин ба түүний өөрчлөлт зэргийг онцлон дурдаж болно. Түүнчлэн энэхүү хэсэгт агуулагдаж буй түүхэн тоо баримтаас бусад мэдээлэл нь ирээдүйн нөхцөл байдлын талаарх Үнэт цаас гаргагчийн гаргаж буй таамаглал бөгөөд ирээдүйн талаарх таамаглал нь олон төрлийн эрсдэлүүд, тодорхойгүй байдал болон бусад хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай байдаг. Улмаар Үнэт цаас гаргагчийн ирээдүйн бодит гүйцэтгэл, санхүүгийн үр дүнд шууд нөлөө үзүүлж, таамаглал, бодит гүйцэтгэл хоёрын дунд материаллаг зөрүү үүсгэх боломжтой. Мөн Украин болон ОХУ-ын хооронд үүсээд буй цэрэг дайны нөхцөл байдал урт хугацаанд үргэлжлэх, хурцдах тохиолдолд дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлж, цаашлаад Монгол Улсын эдийн засаг, банкны салбарт шууд болон шууд бусаар хохирол учруулж болохыг анхаарна уу. Үнэт цаасны танилцуулгыг боловсруулахдаа дээр дурдсан тодорхойгүй байдал болон гадаад орчны эрс тэс нөхцөл байдлыг тооцоололд оруулаагүй тул хөрөнгө оруулагч та хөрөнгө оруулалтын шийдвэрээ өөрийн бие даасан дүн шинжилгээнд үндэслэн гаргахыг зөвлөж байна.**

2022 онд цар тахлын дараах эдийн засгийн сэргэлт үргэлжилснээр эдийн засгийн бодит өсөлт 4.8%-д хүрлээ. Оны 2 дугаар улирлаас хил гаалийн хязгаарлалт харьцангуй суларч, уул уурхайн бүтээгдэхүүний экспорт сэргэж эхэлсэн нь эдийн засгийн өсөлтийг голлон тэтгэлээ. Цар тахлын үеийн хязгаарлалтууд бүрэн цуцлагдсанаар өрхийн хэрэглээ нэмэгдэж эхэлсэн нь мөн эдийн засгийн өсөлтийг дэмжсэн байна.

Гэсэн хэдий ч 2022 онд БНХАУ-ын "Тэг КОВИД" бодлого, ОХУ болон Украин Улсын хооронд үүссэн цэрэг дайны хурцадмал нөхцөл байдал зэрэг гадаад орчны тодорхой бус байдалууд нь эдийн засагт томоохон сорилтыг дагуулж байв. Энэхүү тодорхой бус нөхцөл байдал одоо ч үргэлжилсэн хэвээр байгаа нь цаашид эдийн засгийн төлөвийг таамаглахад төвөгтэй болгож байна.

Монгол Улсын хувьд 2022 оны эхний улиралд үүсээд байсан БНХАУ-ын хил дээрх хязгаарлалт, гацалтаас үүдэлтэй экспортын тасалдал оны сүүлийн хагаст шийдэгдэж,

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

экспорт нэмэгдэж эхэлсэн нь ирэх онд ч уул уурхайн бүтээгдэхүүний тэр дундаа нүүрсний экспорт төлөвлөсөн хэмжээнд хүрч, улмаар эдийн засгийн өсөлтийг дэмжихээр хүлээгдэж байна. Түүнчлэн Оюу толгойн далд уурхайн үйлдвэрлэл 2023 оны эхний хагаст үйл ажиллагаагаа эхлүүлж, зэсийн баяжмалын олборлолт нэмэгдсэнээр эдийн засгийн өсөлтийг тэтгэх хүлээлттэй байна. Харин нөгөө талд гадаад орчны тодорхой бус байдлаас шалтгаалан гадаад эрэлт буурах, гадаад худалдааны нөхцөл муудах, мөнгөний хатуу бодлогын нөлөөгөөр санхүүжилтийн нөхцөл чангарч байгаа зэрэг нь хувийн секторын хөрөнгө оруулалтыг бууруулах, уул уурхайн бус салбарын өсөлтийг сааруулах эрсдэлийг бий болгож байна.

ОУВС 2023 оны Монгол улсын эдийн засгийн өсөлтийг 4.5%, Дэлхийн Банк 5.2%, АХБ 5.4% байхаар тус тус төсөөлж байгаа бол 2024 оны өсөлтийг ОУВС 5.5%, Дэлхийн банк 6.4%, АХБ 6.1% байхаар тус тус таамагласан байна.

График 6: Эдийн засгийн бодит өсөлтийн таамаглал




Эх сурвалж: Монголбанк, ОУВС

## 2.3 Мөнгөний бодлого

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу "Монголбанкны үндсэн зорилт нь үндэсний мөнгөн тэмдэгт - төгрөгийн тогтвортой байдлыг хангах" бөгөөд ингэхдээ а) Арилжааны банкуудын заавал байлгах нөөцийн хэмжээг тогтоох, б) Бодлогын хүүг тогтоох замаар мөнгөний бодлогыг хэрэгжүүлдэг.

Монголбанк нь нээлттэй зах зээлийн үйл ажиллагаагаар дамжуулан арилжааны банкуудтай 1-28 долоо хоногийн хугацаатай Төв банкны Үнэт Цаас (ТБҮЦ) арилжаалдаг. ТБҮЦ өгөөж нь Монголбанкны бодлогын хүүтэй уялдсан байхаас гадна мөнгөний захын суурь хүү болж байна. Мөн Төв банкны байнгын хэрэгслүүд болох овернайт хадгаламж болон репо санхүүжилт нь банкуудын богино хугацааны актив, пассивын удирдлагыг хэрэгжүүлэх, хөрвөх чадварыг хангах зорилгоор ашиглагддаг.

2020, 2021 онуудад Ковид-19 цар тахлын эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг сааруулах зорилгоор Монголбанк бодлогын хүүгээ нийт 4 удаа бууруулж 11%-иас 6%-д хүргэсэн бол 2022 онд цар тахлын улмаас үүссэн нийлүүлэлтийн тасалдал, төлбөрийн тэнцлийн алдагдал нэмэгдсэнээр гадаад валютын ханш чангарч эхэлсэн, гадаад суурь хүү хурдтай өссөн, зах зээл дээр инфляцын хүлээлт нэмэгдсэн зэрэг нь инфляц өсөх шалтгаан болж улмаар төгрөгийн харьцангуй өгөөжийг нэмэгдүүлэх, хүлээлтийг удирдах, эрэлтийн гаралтай инфляцаас сэргийлэх зорилгоор Монголбанк мөнгөний бодлогын төлөвийг чангаруулах шаардлага бий болсон. Иймд Монголбанк Мөнгөний Бодлогын Хорооны 2022 оны 1 дүгээр сарын ээлжит бус хурал, 3 дугаар сар, 6 дугаар сар, 9 дүгээр сар, 12 дугаар сарын ээлжит хурлуудаар эдийн засаг, банк, санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал гадаад, дотоод орчны төлөвийг хэлэлцэн бодлогын хүүг харгалзан 0.5, 2.5, 1.0, 2.0, 1.0 нэгж хувиар тус нэмэгдүүлж улмаар 13%-д хүргэж нэмэгдүүлсэн. Улмаар инфляц 2022 оны сүүлийн хагаст тогтворжих хандлагатай болж байна. Дунд хугацаанд инфляц аажмаар буурч Монголбанкны зорилтот түвшинд хүрэхээр хүлээгдэж байгаа хэдий ч гадаад орчноос шалтгаалсан тодорхой бус байдлууд нийлүүлэлтийн талд эрсдэл үүсгэж байгаа бол нөгөө талд төсвийн зардлын тэлэлт эрэлтийн шалтгаантай инфляцыг өдөөх эрсдэлтэй байна.

График 7: Мөнгөний гол үзүүлэлтүүд




Эх сурвалж: Монголбанк

## 2.4 Монгол Улсын зээлжих зэрэглэл

Олон улсын Fitch Ratings (Fitch) байгууллага 2019 оны 7 дугаар сард Монгол Улсын урт хугацааны үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэлийг “B- тогтвортой”-с “B тогтвортой” болгож төлөвийг дээшлүүлсэн. 2020, 2021, 2022 онуудад мөн тус зэрэглэлийг хэвээр үлдээж баталгаажуулсан байна. Мөн Moody’s Investor Service (Moody’s) олон улсын зэрэглэл тогтоогч агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг 2017 оны 12 дугаар сард “Caa1 тогтвортой"-с "B3 тогтвортой" болгож сайжруулсан. Харин 2020 оны 5 дугаар сард тогтвортой төлөвийг “сөрөг” болгож бууруулаад байсан бол 2021 оны 3 дугаар сарын үнэлгээний тайландаа төлөвийг “тогтвортой” болгож өөрчилсөн. Ийнхүү төлөвийг сайжруулахад 1.0 тэрбум долларын Чингис болон Гэрэгэ бондыг харьцангуй бага хүүгээр буюу жилийн 3.5% ба 4.5%-иар дахин санхүүжүүлсэн нь нөлөөлсөн талаар тайландаа тусгажээ. Сүүлийн байдлаар буюу 2023 оны 2 дугаар сард Moody’s агентлаг эдийн засгийн хүлээгдэж буй өсөлт, гадаад өрийн удирдлага сайжирч харьцангуй тогтвортой түвшинд хүрсэн зэрэг шалтгаанаар зээлжих зэрэглэл болон төлөвийг хэвээр үлдээж баталгаажуулсан. Fitch агентлагийн тайланд дурдсанаар Монгол Улсын зээлжих зэрэглэлийг бууруулж болзошгүй хүчин зүйлд а) Гадаад санхүүжилт татах нөөц боломж хязгаарлагдмал, гадаад валютын нөөц буурах, б) Төсвийн алдагдал болон засгийн газрын

өрийн ДНБ-д эзлэх хувийг бууруулж чадахгүй байх, в) Улс төрийн тодорхой бус байдлаас үүдэн ГШХО буурах зэрэг эрсдэлүүдийг нэрлэсэн байна.

График 8: Монгол Улсын зээлжих зэрэглэл




Эх сурвалж: Олон улсын зээлжих зэрэглэл тогтоогч Мүүдиз болон Фитч агентлаг.

## 2.5 Санхүүгийн сектор

Монгол Улсын санхүүгийн секторыг банкууд, ББСБ болон даатгалын компаниуд тулхүү бүрдүүлж байна. Тус салбарууд нь зах зээлийн хөгжилтэй зэрэгцэн зохих түвшинд хөгжиж төлөвшсөн байгаа бол сүүлийн жилүүдэд технологид суурилсан бизнес загвартай банк бус санхүүгийн байгууллагууд (финтек) идэвхтэй үйл ажиллагаа явуулан, зах зээлд тодорхой байр суурийг олоод байна. Зах зээл хөгжиж, өрсөлдөөн нэмэгдэхийн хэрээр бүтээгдэхүүн үйлчилгээний нөхцөл, чанар сайжирч, технологид суурилсан бүтээгдэхүүнүүд зах зээлд ихээр гарч байна.

Үүний зэрэгцээ сүүлийн жилүүдэд дотоодын хөрөнгийн зах зээл мэдэгдэхүйц идэвхжиж, үлэмж хэмжээгээр өсөөд байна. Хөрөнгийн зах зээлийн оролцогчид буюу үндсэн байгууллагуудад зүй ёсоор Монголын Хөрөнгийн Бирж, Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв, үнэт цаасны андеррайтэр болон брокерын компаниуд, кастодиан банкны үйлчилгээ үзүүлэгчид болон хөрөнгө оруулалтын сан зэргийг нэрлэж болохоор байна.

2022 оны эцсээр санхүүгийн салбарын нийт хөрөнгийн хэмжээ 57.1 их наяд төгрөгт хүрсэн нь өмнөх оны мөн үеэс 13.5%-иар өссөн үзүүлэлт бөгөөд тухайн жилийн нэрлэсэн дотоодын нийт бүтээгдэхүүний 108% орчимд байна.

Банкны системийн хувьд өнөөдрийн байдлаар 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулдаг бөгөөд эдгээрээс 5 банкыг Монголбанкны тодорхойлолтоор Банкны системд нөлөө бүхий банкнууд гэж авч үздэг бөгөөд нийт банкны салбарын хөрөнгийн 91.1%-ийг бүрдүүлж байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 4 дүгээр сарын 19-ний өдрийн А/105 тушаалын дагуу Банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтыг шинэчлэн баталсан ба үүнд ХасБанк багтсанаас гадна Монголын топ арилжааны банкнууд болох Хаан Банк, Худалдаа Хөгжлийн Банк, Голомт Банк болон Төрийн Банк нь жагсаалтад орсон байдаг. Системд нөлөө бүхий банкийг тодорхойлохдоо тухайн банкны актив хөрөнгийн хэмжээ, харилцагчийн тоо, нийт төлбөр тооцооны системд оролцож байгаа үүрэг зэрэг олон чухал хүчин зүйлийг харгалзан үздэг байна.

Арилжааны банкнуудаас гадна төрийн өмчит Монгол Улсын Хөгжлийн Банк үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд тус банк нь арилжааны банкуудтай хамтран болон дангаараа Монгол улсын хөгжилд ач холбогдолтой гэж үзсэн чухал төсөл, хөтөлбөрүүдийг

СЗХ 2023 оны 05 сарын 12 өдөр ҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

санхүүжүүлэх зорилготой байгууллага юм. Харин тус банк нь активын чанарын асуудалтай байгаагаас шалтгаалан зээл олголтын идэвхитэй үйл ажиллагаа явуулахгүй байна. Мөн одоогоор гадаадын банкны салбар байхгүй болно.

Хүснэгт 17: Санхүүгийн секторын идэвхитэй оролцогчид

| | Арилжааны Банк | ББСБ | ХЗХ | Даатгал | ҮЦК |
|---|---|---|---|---|---|
| Оролцогчид | 12 | 513 | 196 | 18 | 52 |
| Актив хөрөнгө (тэрбум төгрөг) | 45,952 | 3,527 | 268 | 475 | 189 |
| Салбар, нэгжийн тоо | 1,393 | 427 | 61 | 246 | 36 |
| Ажилчдын тоо | ~16,200 | ~4,550 | ~760 | ~1,400 | n/a |
| Харилцагчийн тоо (давхардсан) | 6.2 сая | 4.6 сая | 0.072 | ~1.3M | n/a |

Эх сурвалж: Монголын Банкны Холбоо, СЗХ, МХБ-ийн тайлангууд

### 2.5.1 Санхүүгийн салбарын зохицуулагч байгууллагууд

Санхүүгийн салбарын зохицуулалтын орчныг Монгол Улсын Санхүүгийн Тогтвортой Байдлын Зөвлөлөөр (СТБЗ) авч үзэж болно. Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2007 оны 5 дугаар сарын 9-ний өдрийн хамтарсан тушаалаар СТБЗ анх байгуулагдсан байдаг.

Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2 дахь хэсэгт зааснаар СТБЗ-ийн үндсэн чиг үүрэг нь Монгол Улсын санхүүгийн тогтолцооны тогтвортой байдлыг хангахтай холбоотойгоор тогтолцооны шинжтэй эрсдэлийг илрүүлэх, хянах, бууруулах талаар хэлэлцэж, гишүүдийн үйл ажиллагааг уялдуулах явдал юм. СТБЗ-ийн бүрэлдэхүүнд Монголбанкны Ерөнхийлөгч, Сангийн Сайд, Санхүүгийн Зохицуулах Хорооны Дарга, Хадгаламжийн Даатгалын Корпорацын Гүйцэтгэх Захирал багтдаг. СТБЗ-ийн үйл ажиллагааны үндсэн хэлбэр нь түүний ээлжит болон ээлжит бус хуралдаан бөгөөд ээлжит хуралдааныг улиралд нэгээс доошгүй удаа зохион байгуулж байна.

Санхүүгийн салбарын үндсэн зохицуулагч байгууллагуудад:

- **Монголбанк** нь банкны үйл ажиллагаанд хяналт тавих, мөнгөний бодлого тодорхойлох, хэрэгжүүлэх, мөнгөн тэмдэгт гаргах, удирдах, үндэсний төлбөрийн системд хяналт тавих, макро бодлогын зохистой хэрэгжилтэд хяналт тавих бүрэн эрхтэй бөгөөд хэрэгжүүлэгч байгууллага.
- **Санхүүгийн Зохицуулах Хороо** (СЗХ) нь банкнаас бусад санхүүгийн үйл ажиллагааг зохицуулах үндсэн чиг үүрэгтэй. СЗХ нь хувьцаат компани, банк бус санхүүгийн байгууллага, даатгалын компани болон зуучлах үйлчилгээний байгууллага, үнэт цаасны компани, хадгаламж зээлийн хоршоо, үл хөдлөх хөрөнгийн зууч, үнэт металл, чулууны дилер арилжаалагчдын үйл ажиллагаанд хяналт тавьдаг.
- **Хадгаламжийн Даатгалын Корпорац** (ХДК) нь хадгаламжийн даатгалын тухай хууль батлагдаж, хадгаламж эзэмшигчдийг хамгаалах механизм хуульчлагдсаны дагуу 2013 онд үүсгэн байгуулагдсан компани юм. Арилжааны банкууд нь бүх харилцах, хадгаламжийн дансны үлдэгдлийн 0.0625%-тай тэнцэх хураамжийг хуулийн дагуу улирал бүр ХДК-д төлж, даатгалын сан хөрөнгийг бүрдүүлж байна.
- **Сангийн Яам** нь санхүүгийн салбарт хууль тогтоомж хэрэгжүүлэх, төрийн бодлогыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий захиргааны гүйцэтгэх байгууллагуудын нэг бөгөөд Татварын Алба болон Гаалийн Ерөнхий Газар нь тус яамны харьяа байгууллага бөгөөд холбогдох чиг үүргийн хүрээнд санхүүгийн зах зээлд оролцогчдод хяналт шалгалтыг хэрэгжүүлдэг агентлагууд юм.

ХАСБАНК УХН 4937 2578697

СЗХ
он 2023 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

- **Монголын Хөрөнгийн Бирж** (МХБ) нь 1991 онд байгуулагдсан 66 хувь төрийн өмчит, өөрийгөө зохицуулагч байгууллага бөгөөд тус биржид бүртгэлтэй гишүүн компаниудын үнэт цаасны хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг зохицуулдаг.

### 2.5.2 Банкны систем

Банкны системд 2023 оны 1 дүгээр сарын байдлаар 12 арилжааны банк үйл ажиллагаа явуулж байна. Үүнээс төрийн өмчийн оролцоотой 1 банк, мөн зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа явуулахгүй байгаа 3 жижиг арилжааны банк багтаж байна. 2022 оны эцсийн байдлаар банкны системийн нийт хөрөнгө 45.9 их наяд төгрөг буюу энэ нь Монгол Улсын ДНБ-ийн 87%-д хүрсэн байна. Иргэд аж ахуй нэгжид олгосон зээлийн өрийн үлдэгдэл 22.0 их наяд төгрөгт хүрсэн бол иргэд аж ахуй нэгжээс татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжийн дүн 27.6 их наяд төгрөгт хүрсэн байна.

Дотоодын арилжааны банкуудаас гадна идэвхтэй үйл ажиллагаа явуулдаггүй хэдий ч өөрсдийн төлөөлөгчийн газраар дамжуулан судалгаа, шинжилгээ болон аливаа хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилготойгоор байгуулагдсан гадаадын 4 банкны (SMBC, MUFG, BoC, ICBC) төлөөлөгчийн газар ажиллаж байна.

Салбар дахь нийт зээлийн өрийн үлдэгдэл өнгөрсөн 5 жилд 8.5 их наяд төгрөгөөр өссөн байгаагаас зөвхөн сүүлийн 2 жилд 4.9 их наяд төгрөг буюу нийт өсөлтийн 60%-г бүрдүүлсэн байна. Энэхүү өсөлтөд цар тахлын үед ЗГ болон Монголбанкнаас хамтран хэрэгжүүлсэн эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа идэвхжүүлэхэд чиглэсэн 10 их наядын хөтөлбөр томоохон нөлөө үзүүлсэн. Салбарын зээлийн багцын жилийн дундаж өсөлт 5.2% (өмнөх 5 жилийн үзүүлэлтээр) байгаа ба дийлэнх хэсгийг төгрөгийн зээлийн өсөлт бүрдүүлж байна. Харин гадаад валютын зээлийн үлдэгдэл буурч нийт зээлийн багцад эзлэх хувь 4.2% (2017 онд 17.3% байсан) байгаа нь Монголбанкнаас хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийн нөлөө, тэр дундаа урт хугацаат своп хэлцлийн эерэг нөлөө гэж дүгнэж болохоор байна.

График 9: Банкны системийн зээлийн өрийн үлдэгдэл, түүний өсөлт




Эх сурвалж: Монголбанк

2018 оны эхнээс 2022 он хүртэл банкны системийн чанаргүй зээлийн үлдэгдэл 0.9 их наяд төгрөгөөр нэмэгдсэн нь жилд дунджаар 13.6% өссөн үзүүлэлт юм. Хэдий тийм ч 2022 онд банкны системийн чанаргүй зээл 2.6%-р буюу 54 тэрбум төгрөгөөр буурсан байна. Чанаргүй зээлд Монголбанкны “Активыг ангилах, активын эрсдэлийн сан байгуулж, зарцуулах” журмын дагуу “хэвийн бус”, “эргэлзээтэй” болон “муу” ангилалд бүртгэгдсэн зээлүүд багтдаг.

2017-2018 онд Олон Улсын Валютын Сангийн (ОУВС) хөтөлбөрийн хүрээнд Монголбанкнаас арилжааны банкнуудад хэрэгжүүлсэн Активын Чанарын Үнэлгээний дараагаар системийн чанаргүй зээлийн үлдэгдэл 630 тэрбум төгрөгөөр огцом нэмэгдэж чанаргүй зээлийн нийт зээлийн өрийн үлдэгдэлд эзлэх хувь 10.4%-д хүрч байв. 2022 оны 12 дугаар сарын байдлаар системийн чанаргүй зээлийн үлдэгдэл нийт зээлийн 9.2%-ийг эзэлж байна.

График 10: Банкны системийн чанаргүй зээл, нийт зээлд эзлэх хувь




Эх сурвалж: Монголбанк

Системийн чанаргүй зээлийг бүтцээр нь авч үзвэл иргэдэд олгосон зээл 501 тэрбум төгрөг (25%), аж ахуйн нэгж, хуулийн этгээд болон бусад санхүүгийн байгууллагад олгосон зээл 1,509 тэрбум төгрөг (75%) тус тус бүрдүүлж байна. Мөн 2022 онд системийн чанаргүй зээл буурахад ААН-д олгосон зээл 62 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлсөн бол иргэдийн чанаргүй зээлийн үлдэгдэл өмнөх оны эцсээс 6.9 тэрбум төгрөгөөр өссөн үзүүлэлттэй байна.

2018-2022 онуудад банкны салбарын нийт харилцах, хадгаламжийн үлдэгдэл жилд 9.5%-р өсөж, 27.6 их наяд төгрөгт хүрсэн байна.

График 11: Банкны системийн харилцах, хадгаламжийн үлдэгдэл, түүний өсөлт




Эх сурвалж: Монголбанк

2022 оны 12 дугаар сарын байдлаар арилжааны банкнуудын татан төвлөрүүлсэн эх үүсвэрийг бүтцийн хувьд авч үзвэл харилцах данс 39.6%, хугацаагүй хадгаламж 8.8%, харин хугацаатай хадгаламж 51.6%-ийг тус тус бүрдүүлж байна. 2020 онд татан төвлөрүүлсэн хөрөнгийн бүтэц дотор харилцах данснаас хугацаагүй хадгаламж руу

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

шилжих хөдөлгөөн ажиглагдаж байсан бол 2021, 2022 онуудад харилцах дансны өсөлт илүү байсан байна.

УИХ-ын 2020 оны 21 дүгээр тогтоолоор батлагдсан Зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо болон Засгийн Газар хамтран "Харилцах данс, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй, хүү, түүнтэй төстэй бусад төлбөр төлөхгүй байх агуулгаар холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах" арга хэмжээ авахаар заасан бөгөөд 2020 оны 4 дүгээр сарын 29-ний өдрөөс эхлэн Ковид-19 цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай хуулийн дагуу харилцах дансанд хүү тооцохгүй байхаар зохицуулсан. Тус зохицуулалтад 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр нэмэлт өөрчлөлт орж “хугацаагүй хадгаламжийн данс”-нд хүү тооцохгүй байхаар шийдвэрлэсэн. Ковидийн хууль нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр хүртэл үйлчлэн 2023 оны 01 дүгээр сарын 1-ний өдрөөс дуусгавар болсон болно.

Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэгт “харилцах дансны үлдэгдэлд тооцох хүүгийн хэмжээг эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо болон санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хамтран тогтооно” гэж заасны дагуу 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Сангийн яамны хамтарсан тушаалаар Харилцах дансны үлдэгдэлд төлөх хүүгийн хэмжээг жилийн 3%-с хэтрэхгүй байхаар тогтоосон.

Валютын бүтцээр нь авч үзвэл нийт харилцах, хадгаламжийн 65.6% буюу 18.1 их наяд төгрөг нь үндэсний мөнгөн тэмдэгт төгрөгөөр, 34.4% буюу 9.5 их наяд төгрөгтэй тэнцэх нь гадаад валют (ам.доллар болон юан дийлэнх) бүрдүүлж байна.

### 2.5.3 Банкны системийн реформ

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг 2021 оны 1 дүгээр сарын 28-ны өдрийн УИХ-ын намрын чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн баталсан. Банкны тухай хуульд оруулсан нэмэлт өөрчлөлтийн хэрэгжилтийг хангуулснаар банкны хувьцаа эзэмшлийн төвлөрөл буурч, өмчлөл, удирдлага-хяналтын тэнцвэртэй байдлыг бүрдүүлэх ач холбогдолтой. Түүнчлэн арилжааны банкуудад хувьцаа эзэмшил, удирдлагын төвлөрсөн байдлаас үүдэлтэй эрсдэл буурч, банкны хувьцааны эзэмшил, мэдээллийн хүртээмжээр дамжуулан олон нийтийн хяналт бий болох, зах зээлийн дохиолол бүрдэх, банкны хяналт шалгалтын бие даасан байдал нэмэгдэхээс гадна хөрөнгийн зах зээлийн хөгжилд эергээр нөлөөлөх олон давуу талыг бий болгоно.

Мөн Монголбанкны Ерөнхийлөгч болон Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын хамтарсан А-50/53 дугаар тушаалаар ажлын хэсэг байгуулагдаж, А-90/85 дугаар тушаалаар Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлж хувьцаат компани болох, А-262/262 дугаар тушаалаар хувь нийлүүлсэн хөрөнгөд өөрчлөлт оруулах тухай журмыг тус тус баталж шийдвэрлэсэн.

Хуульд заасны дагуу Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийг мөрдөж эхлэх хугацааг дараах байдлаар журамласан байна. Үүнд:

- Банкны системд нөлөө бүхий банкууд 2023 оны 6 дугаар сарын 30-ны дотор олон нийтэд хувьцаагаа санал болгох замаар компанийн хэлбэрээ өөрчилж, нээлттэй хувьцаат компани болох;
- Арилжааны банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасыг аливаа хувьцаа эзэмшигч этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт тухайн банкны нийт

ХАСБАНК
ҮХН4937 2578697

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

гаргасан хувьцааны 20%-с хэтрэхгүйгээр эзэмших шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангах;

- Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нийт гишүүдийн гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байх шаардлагыг 2022 оны 6 дугаар сарын 30-ны дотор хангах.

Дээрх хуулийн шаардлагын дагуу 2023 онд банкны системд нөлөө бүхий банкуудын (Төрийн Банкнаас бусад) хувьцаа эзэмшигчдийн бүтцэд томоохон өөрчлөлт гарахаар хүлээгдэж байгаа хэдий ч, 20%-ийн шаардлагыг хангаж чадах эсэх нь ихээхэн эргэлзээтэй байна.

ХАСБАНК
УХН4937 2578697

# Гурав. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА, БИЗНЕС, СТРАТЕГИ

## 3.1 Банкны бизнес зохион байгуулалт, бүтээгдэхүүн, үйлчилгээ

Үнэт цаас гаргагч нь Иргэдийн банк, Байгууллагын банк, Санхүүгийн түрээс гэсэн үндсэн гурван бизнесийн сегментэд хуваагддаг бөгөөд эдгээрийн бизнесийн үйл ажиллагааг тасралтгүй дэмжин ажиллах чиг үүрэг бүхий арын албаны нэгжүүдтэй (Бүртгэл, Санхүү, Төлбөр тооцоо, Эрсдэлийн удирдлага, Мэдээлэл технологи, Хүний нөөц, Хууль гэх мэт). Харилцагчдадаа хэрэгцээтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг нь түргэн шуурхай хүргэхийн тулд бизнес нэгжүүд нь ямагт технологийн дэвшлийг ашиглахыг зорьдог бөгөөд мөн Банкны арын албаны нэгжүүд нь бүхий л нөөц болон санхүүгийн эх үүсвэрээр хангаж ажилладаг.

### 3.1.1 Иргэдийн банк

Иргэдийн банк нь зах зээлд тогтсон байр суурьтай, өөрийн гэсэн онцлогтой бөгөөд харилцагчдадаа шаардлагатай санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг уламжлалт банкны салбар, тооцооны төвөөр дамжуулан үзүүлэхээс гадна технологийн дэвшлийг ашиглан цахим банкны үйлчилгээг түлхүү үзүүлэхэд анхаарч байна. Иргэдийн банканд данстай харилцагчид нь давхардсан тоогоор Монгол улсын нийт хүн амын 30% орчмыг эзэлж байна.

Технологийн дэвшилтийг ашиглах нь банкны бизнесийн нэн чухал шаардлага бөгөөд Үнэт цаас гаргагч нь 2016 оноос эхлэн үйлчилгээгээ цахимжуулахад анхаарч, шат дараатай томоохон хөрөнгө оруулалтуудыг хийж ирсэн. Үүнд: АТМ, карт уншигч төхөөрөмжийн дэд бүтэц, интернэт болон мобайл банкны аппликейшн, мөн банкны үндсэн системийг шинэчлэх болон дижитал банкны системийг шинэчлэх төслүүд 2019-2022 онуудад амжилттай хэрэгжиж, харилцагчдадаа үзүүлж буй үйлчилгээний дийлэнх хувь нь цахим сувгаар хийгдэж байна.

Үнэт цаас гаргагч нь Улаанбаатар хотод нийт 32, орон нутагт 39 салбар, нэгжээр дамжуулан банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэж байна. Цар тахлын сорилттой цаг үед Үнэт цаас гаргагч нь харилцагчдадаа банкны бүтээгдэхүүн үйлчилгээг тасралтгүй, хурдан шуурхай, найдвартай хүргэж ажилласан. Мөн банкны бүтээгдэхүүн үйлчилгээг зайнаас дижитал сувгаар дамжуулан хүргэх, харилцагчийн үйлчилгээний төвийн нөөцийг бэхжүүлэх, хүртээмжийг нэмэгдүүлэх чиглэлд тогтмол сайжруулалтууд хийгдэж байна.

Иргэдийн банк нь дараах үндсэн бүтээгдэхүүнүүдийг харилцагчдадаа уламжлалт салбар, тооцооны төвүүдээр болон цахим сувгаар дамжуулан хүргэж байна. Үүнд:

#### 3.1.1.1 Хэрэглээний зээл

Хэрэглээний зээл нь цалингийн зээл болон хэрэглээний худалдан авалтын зээл гэсэн үндсэн бүтээгдэхүүнтэй. Эдгээр зээлийн бүтээгдэхүүнийг харилцагч өөрийн санхүүгийн хэрэгцээнд тохирсон уян хатан нөхцөл, эргэн төлөлтийн хуваарьтайгаар авах боломжтой.

Хүснэгт 18: Хэрэглээний зээлийн нөхцөл

| Төрөл | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| Цалингийн зээл | Зээлжих чадвараар тодорхойлогдоно | 1.5% - 1.7% | 30 сар хүртэл |
| Хэрэглээний худалдан авалтын зээл | Зээлжих чадвараар тодорхойлогдоно | 2.0% | 30 сар хүртэл |

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

### 3.1.1.2 Хадгаламж барьцаалсан зээл

Хадгаламж барьцаалсан зээл нь харилцагчийн санхүүгийн гэнэтийн хэрэгцээг хуримтлалдаа нөлөөлөхгүйгээр шуурхай шийдвэрлэх боломжийг олгодог бүтээгдэхүүн юм. Уг бүтээгдэхүүнийг 2019 оноос цахим хэлбэрт шилжүүлсэн байна.

Хүснэгт 19: Хадгаламж барьцаалсан зээлийн нөхцөл

| Төрөл | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| Салбар | Барьцаалж буй хадгаламжийн 85% хүртэл | Хадгаламжийн хүү + (0.33%-с 0.60% хүртэл) | 24 сар хүртэл (хадгаламжийн гэрээний хугацаанд) |
| Цахим банк | 50 сая төгрөг хүртэл | | |

### 3.1.1.3 Бизнесийн зээл

Иргэдийн банк нь бичил болон жижиг дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгж, иргэдийн санхүүгийн хэрэгцээнд нийцсэн эргэлтийн хөрөнгийн болон хөрөнгө оруулалтын зориулалттай бизнесийн зээлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгодог. Бизнесийн зээл нь харилцагчийн санхүүгийн чадавхийг нэмэгдүүлэх, бизнесийн хэвийн үйл ажиллагааг тогтвортой хадгалах, техник, тоног төхөөрөмж худалдан авах болон бизнесийн цар хүрээгээ нэмэгдүүлэхэд зориулагдсан байдаг.

Мөн ногоон санхүүжилтийн хүрээнд тодорхой шалгуур хангасан аж ахуйн нэгж, бизнес эрхлэгч иргэдэд эрчим хүчний хэмнэлтийг урамшуулах зорилготой зээлийг санал болгож байна. Бизнесийн зээлийн бүтээгдэхүүн нь харилцагчийн бизнесийн онцлог, зээлийн зориулалт, санхүүгийн чадавхи зэргээс хамааран уян хатан нөхцөлтэй байдаг

Хүснэгт 20: Бизнесийн зээлийн нөхцөл

| Төрөл | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| Эргэлтийн хөрөнгийн зээл | Зээлжих чадвараар тодорхойлогдоно | 1.8% - 2.0% | 36 сар хүртэл |
| Хөрөнгө оруулалтын зээл | Зээлжих чадвараар тодорхойлогдоно | 1.8% - 2.0% | 60 сар хүртэл |
| Ногоон зээл | Зээлжих чадвараар тодорхойлогдоно | 1.25% | 60 сар хүртэл |

### 3.1.1.4 Орон сууцны зээл

Үнэт цаас гаргагч нь өөрийн эх үүсвэрийн болон хөтөлбөрийн (ЗГ-ийн 6%-ийн ипотек) орон сууцны зээлийг харилцагчдад санал болгодог.

Хүснэгт 21: Орон сууцны зээлийн нөхцөл

| Төрөл | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| Өөрийн эх үүсвэрийн орон сууцны зээл | 500 сая төгрөг хүртэл | 1.3%-1.5% | 240 сар хүртэл |
| Хөтөлбөрийн орон сууцны зээл | 200 сая төгрөг | 0.5% | 360 сар хүртэл |

### 3.1.1.5 Эрчим хүчний хэмнэлттэй орон сууцны зээл

Үнэт цаас гаргагч нь Уур амьсгалын ногоон сан (УАНС)-ийн санхүүжилттэйгээр Эрчим хүчний хэмнэлттэй амины орон сууцны зээлийг олгож байна. Энэхүү хөтөлбөр нь батлагдсан зураг төслийн дагуу амины орон сууц бариулахад санхүүжилт олгодог. Зээлээр санхүүжүүлэх амины орон сууцыг туршлагатай, шалгуур хангасан барилгын компаниудаар бариулах бөгөөд эрчим хүчний хэмнэлт

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

хамгийн багадаа 20% байх шаардлага тавьдаг бөгөөд хөндлөнгийн аудитор хэмжин баталгаажуулдаг.

Хүснэгт 22: АОС-ны ногоон зээлийн нөхцөл

| Төрөл | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| Амины орон сууц бариулах | 180 сая хүртэл | 1.0% | 240 сар хүртэл |
| Хотхоны орон сууц худалдан авах | 200 сая хүртэл | | |

### 3.1.1.6 Харилцах данс

Үнэт цаас гаргагч нь харилцагчдадаа бизнесийн болон хувийн дансаа шуурхай, найдвартай удирдахад нь зориулан харилцах дансны үйлчилгээг санал болгодог. Харилцах данс нь төгрөг, USD, EUR, RUB, JPY, CNY, AUD болон CAD валютаар байх боломжтой байдаг.

### 3.1.1.7 Хадгаламжийн данс

Үнэт цаас гаргагч нь энгийн, тодорхой нөхцөлтэй хадгаламжийн бүтээгдэхүүнийг иргэд болон бичил, жижиг, дунд бизнес эрхлэгч харилцагчдад санал болгодог бөгөөд энгийн хугацаагүй хадгаламжаас эхлээд хүүгээ сар бүр зарлагадах боломжтой хугацаатай хадгаламж хүртэл төрөл бүрийн хадгаламжийн бүтээгдэхүүнийг санал болгож байна. Хадгаламж нь гэрээний хугацаа болон валютын төрөл, хэмжээнээс хамааран харилцан адилгүй хүүтэй.

### 3.1.1.8 “Ирээдүйн Саятан” урт хугацаат хуримтлалын данс

Үнэт цаас гаргагч нь Монголын ирээдүйн эзэд болох хүүхэд багачуудад зориулан Ирээдүйн Саятан урт хугацаат хүүхдийн хадгаламжийн бүтээгдэхүүнийг Монголын банк санхүүгийн зах зээлд анхлан нэвтрүүлсэн бөгөөд 2022 онд энэхүү бүтээгдэхүүний 20 жилийн ойг тэмдэглэн өнгөрүүллээ.

Өнгөрсөн 20 жилийн хугацаанд Монголын 5 хүүхэд тутмын 1 нь Ирээдүйн Саятан хадгаламж эзэмшигч болж, олон нийтэд хамгийн сайн танигдсан бүтээгдэхүүн болсны зэрэгцээ Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн багцад голлох ач холбогдолтой бүтээгдэхүүн болж чаджээ. Ирээдүйн саятан хадгаламж нь харилцагч хүүхдийг 18 нас хүртэл хугацаатайгаар нээгддэг бөгөөд сар бүр хүүгээс хүү боддог өндөр өгөөжтэй бүтээгдэхүүн юм. Тус бүтээгдэхүүн нь өдгөө 200 гаруй мянган харилцагчтай болсон байна.

### 3.1.1.9 Карт

Үнэт цаас гаргагч нь дэлхийн хаана ч гадаад валютаар гүйлгээ хийх боломжтой, төлбөр тооцооны хамгийн өргөн сүлжээ бүхий Visa, UnionPay төлбөрийн картыг харилцагчдадаа санал болгодог. Платинум төлбөрийн картад нисэх онгоцны буудлын VIP танхимд нэвтрэх эрх бүхий Priority pass дагалддаг бол Monpay төлбөрийн картаар ХасБанкны ПОС терминалаар хийсэн худалдан авалтын гүйлгээний 1%-ийг дансандаа буцаан авах боломжтой. Мөн худалдан авалтын гүйлгээ бүрээсээ миль хуримтлуулж, хуримтлуулсан милээрээ МИАТ ТӨХК-аас бүтээгдэхүүн, үйлчилгээ, нислэгийн тийз авах боломжтой МИАТ кредит картыг харилцагчдадаа санал болгон ажиллаж байна.

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

### 3.1.2 Байгууллагын банк

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй дунд болон томоохон компаниудад хэрэгцээтэй санхүүжилтийг олгох, мөнгөн урсгалыг зөв оновчтой удирдахад нь туслах зорилгоор хамтран ажиллаж байна. Байгууллагын банкны үйлчилгээ уламжлалт санхүүгийн бүтээгдэхүүнүүд байхаас (зээл, хадгаламж, худалдааны санхүүжилт, валютын арилжаа болон гадаад төлбөр тооцоо) гадна Банк нь өөрийн хамтрагч санхүүгийн байгууллагуудтай хамтран харилцагчийнхаа шаардлагатай байгаа санхүүжилтийг илүү уян хатан нөхцөлтэй, хүү багатайгаар олгох боломжтой байдаг.

Банк нь харилцагчийн санхүүгийн хэрэгцээ, зорилго, бизнесийн онцлогийг ойлгож түүнд тохирсон шийдэл санал болгож ажиллахад байнга анхаардаг. Мөн харилцагч байгууллагуудынхаа удирдлага, ажилтнууд болон бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчид гээд тухайн бизнесийн бүхий л оролцогчдод нь санхүүгийн үйлчилгээ үзүүлэхийг зорьдог.

Байгууллагын банк нь олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран хөрөнгө оруулалтын зориулалтаар хүү багатай хамтарсан санхүүжилт хийдэг. Тус зээл нь дотоодын аж ахуйн нэгжүүд хөрөнгө оруулалт хийхэд туслахын зэрэгцээ Банкны өөрийн хөрөнгийн үр ашигтай хуваарилалтад эерэг нөлөө үзүүлдэг. Байгууллагын банк нь дараах үндсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдадаа санал болгож байна. Үүнд:

#### 3.1.2.1 Эргэлтийн хөрөнгө болон үндсэн хөрөнгийн зээл

Үнэт цаас гаргагч нь эргэлтийн хөрөнгийн зориулалттай зээл, зээлийн шугамыг 36 хүртэл сарын хугацаатайгаар, үндсэн хөрөнгийн зээлийг 60 хүртэл сарын хугацаатайгаар харилцагчдад олгож байна. Зээлийн хүү нь зах зээлийн нөхцөл байдал, харилцагч байгууллагын хамтын ажиллагааны түвшин зэргийг харгалзан харилцан тохиролцдог. Түүнчлэн зээлийн эргэн төлөлтийг харилцагчийн бизнесийн онцлог, борлуулалтын мөчлөг зэргийг харгалзан уян хатан тогтоодгоороо онцлогтой. Ингэснээр харилцагчид бизнесээ төлөвлөх, болзошгүй эрсдэлээс сэргийлэх бүрэн боломжтой.

Байгууллагын банк нь зээлийн бүтцийг оновчтой, бизнесийн онцлогт тохирсон байдлаар тодорхойлох нь эрсдэлийг үлэмж хэмжээгээр бууруулж, харилцагчийг хамгаалах чухал ач холбогдолтой гэж үздэг. Иймд харилцагчийг хамгаалах бодлогод харилцагчийн бизнесийн нууцыг хадгалах, харилцагчтай ямарваа нэг хэлбэрээр өрсөлдөхгүй байх, харилцагчийг хэт их өрийн дарамтад оруулах санхүүжилт олгохгүй байх, харилцагчид санхүүгийн зөвлөгөө өгөх зэргийг тусгаж, өдөр тутмын үйл ажиллагаанд мөрдөж ажилладаг.

Зээл хүсэгч байгууллагуудын хувьд банкны барьцаа хөрөнгийн шаардлага хамгийн их хүндрэл учруулдаг тухай олон янзын судалгаа, санал асуулгын үр дүн нийтлэгдсэн байдаг. Тэгвэл Үнэт цаас гаргагч нь зээлийн бодлогодоо зээлийн барьцаанд үл хөдлөх хөрөнгөөс гадна тоног төхөөрөмж, тээврийн хэрэгсэл, эргэлтийн хөрөнгө барьцаалахыг зөвшөөрдөг бөгөөд байнгын, найдвартай харилцагчдад гэрээний орлого, ирээдүйд бий болох төслийн орлого зэргийг барьцаалж шаардлагатай санхүүжилтийг шийдвэрлэдэг болно.

#### 3.1.2.2 Худалдааны санхүүжилт

Худалдааны санхүүжилтийн нь импортын болон экспортын аккредитив, төлбөрийн баталгаа гэсэн үндсэн бүтээгдэхүүнүүдийг харилцагчдад санал болгож байна. Тухайн бүтээгдэхүүнүүд нь худалдан авагч болон бэлтгэн нийлүүлэгчийн итгэлцлийг нэмэгдүүлж, төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлийг бууруулдгаараа онцлогтой. Аккредитив, баталгааны бүтээгдэхүүн нь жилийн 4-6% эрсдэлийн шимтгэлтэй,

ХАСБАНК

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

зээлийн хүүтэй харьцуулахад маш бага зардалтай, харилцагчдад ашигтай бүтээгдэхүүн юм.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид, бүтэц, ил тод байдал, бизнесийн ёс зүй зэрэг нь олон улсын байгууллагуудын итгэлийг нэмэгдүүлж, худалдааны санхүүжилтийн шугам нээх боломжийг олгодог. Ингэснээр Үнэт цаас гаргагч нь зах зээлд худалдааны санхүүжилтийн гол тоглогчдын нэг болж чадсан.

### 3.1.2.3 “Оюу Толгой” авлагын санхүүжилт

Энэхүү бүтээгдэхүүнийг 2016 онд арилжааны банкнуудаас анхдагч нь болж харилцагчдад үзүүлж эхэлсэн. Оюу толгой ХХК-ийн ханган нийлүүлэгч байгууллага авлагаа баталгаажуулсны үндсэн дээр 90% хүртэл хэмжээний богино хугацаатай санхүүжилтийг барьцаагүйгээр өдөрт нь авах боломж олгодог нь энэхүү бүтээгдэхүүний онцлог юм. Түүнчлэн санхүүжилтийн хүүг Монголбанкны бодлогын хүүтэй уяж өгснөөр харилцагчдад хямд хүүтэй санхүүжилт авах боломжийг бүрдүүлдэг болно.

### 3.1.2.4 Хамтын санхүүжилт

Европын Сэргээн Босголт, Хөгжлийн банк (EBRD)-тай хамтарсан “Эрсдэл хуваах хөтөлбөр”-ийг Байгууллагын банк нь 2014 оноос эхлэн хэрэгжүүлж байна. Өнгөрсөн хугацаанд нийт 55.0 сая АНУ-ын доллартой тэнцэх хэмжээний хамтын санхүүжилтийг харилцагчдад олгож, бизнесээ өргөжүүлэхэд дэмжлэг үзүүлсэн байна. Санхүүжилтийг хуваан гаргаж, тэр хэмжээгээрээ эрсдэлээ хариуцдаг энэхүү хөтөлбөр нь олон улсад түгээмэл хэрэглэгддэг санхүүгийн хэрэгсэл юм. Зээлийн судалгаа хийх, зээлийн шийдвэр гаргахад шаардлагатай бүхий л мэдээллийг цуглуулах, EBRD-ийн шаардлагад нийцсэн байдлаар мэдээллийг бэлтгэж хүргүүлэх ажлыг Банк хариуцаж хийдгээрээ энэхүү хөтөлбөр давуу талтай. Түүнчлэн зээлийн шийдвэр гарсны дараа зээл, барьцааны гэрээ байгуулах, зээлийн гэрээний хугацаанд хяналт тавих, шаардлагатай мэдээллээр EBRD-г хангах ажлыг Байгуулагын банк хариуцан гүйцэтгэдэг. Ингэснээр олон улсын байгууллагуудаас тавьдаг өндөр шаардлагыг харилцагч байгууллагууд харьцангүй хялбар, төвөг багатайгаар даван туулдаг нь хөтөлбөрийн онцлог юм. Хамтын санхүүжилтийн хөтөлбөрт хамрагдсан харилцагчдад дараах давуу талууд бий болдог.

- Харилцагч байгууллагууд олон улсын санхүүгийн байгууллагын зээлийн нөхцөл, шаардлагыг ойлгож мэдэх, үйл ажиллагаагаа уялдуулж, сайжруулах, цаашлаад ирээдүйд олон улсын санхүүгийн байгууллагад шууд хандаж санхүүжилт хүсэх туршлага хуримтлуулахаас гадна санхүүжилтийн түүх үүсэж, бизнесийн нэр хүнд өсдөг.
- Арилжааны банкны нэг зээлдэгчид олгох зээлийн хязгаараас илүү дүнгээр санхүүжилт авах боломж бүрддэг.
- Санхүүжилтэд олон улсын санхүүгийн байгууллага оролцсоноор санхүүжилтийн хугацаа урт, хүү бага, уян хатан нөхцөлтэй санхүүжилт авах боломж бүрддэг.

### 3.1.2.5 Банкны баталгаа

Үнэт цаас гаргагч нь харилцагч байгууллага, иргэний өмнөөс гуравдагч талд төрөл бүрийн баталгаа гаргах үйлчилгээг үзүүлж байна. Баталгаа гаргахдаа харилцагчаас байршуулсан эх үүсвэрт үндэслэхээс гадна эх үүсвэргүйгээр гаргах боломжтой. Энэ

СЭХ
2023 .05. 12-ны өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

тохиолдолд зээлтэй адилтган судалгаа хийж, гэрээ байгуулсны үндсэн дээр баталгаа гаргах боломжтой болдог.

Банкны баталгааны олон төрөл байдаг бөгөөд гол нь баталгаа гаргуулагч, баталгаа хүлээн авагч болон банк харилцан тохиролцож хийдэг гурван талт хэлцэл юм. Түгээмэл гаргадаг баталгааны төрлүүдийг жагсаавал:

- **Тендерийн баталгаа:** Төрийн байгууллага болон хувийн хэвшлээс зарласан аливаа тендерт оролцохдоо гаргадаг баталгааны төрөл.
- **Гүйцэтгэлийн баталгаа:** Гэрээний дагуу хүлээсэн үүргээ зохих ёсоор биелүүлэх баталгаа болгон гаргадаг баталгааны төрөл.
- **Урьдчилгаа төлбөрийн баталгаа:** Гэрээний дагуу ажил, үйлчилгээ үзүүлэхэд шаардагдах урьдчилгаа төлбөрийг гэрээний дагуу зарцуулж, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг баталж гаргадаг баталгааны төрөл.
- **Чанарын баталгаа:** Гэрээгээр гүйцэтгэсэн ажил, үйлчилгээний баталгаат хугацаанд ямарваа нэгэн чанарын доголдлыг гарахгүйг, гарсан тохиолдолд өөрийн хөрөнгөөр үнэ төлбөргүй засаж өгөхийг баталж гаргадаг баталгааны төрөл.
- **Төлбөрийн баталгаа:** Гэрээгээр хүлээсэн аливаа төлбөрийн үүргийг цаг хугацаандаа, бүрэн төлөхийг баталж гаргадаг баталгааны төрөл.

#### 3.1.2.6 Байгууллагын харилцах данс

Үнэт цаас гаргагч нь харилцагч компаниудад харилцах дансны үйлчилгээг хүргэж байна. Үнэт цаас гаргагчийн харилцах дансны үйлчилгээний нөхцөл нь уян хатан, зардал багатай байдаг. Банк дотроо харилцах данс хооронд хийгдсэн бүх төрлийн шилжүүлэг, төлбөр тооцоо “шимтгэлгүй” байдаг бөгөөд MNT, USD, EUR, JPY, CNY, CAD, AUD, RUB, KRW, GBP зэрэг 8 төрлийн валютаар данс нээх боломжтой.

#### 3.1.2.7 Байгууллагын хадгаламжийн данс

Үнэт цаас гаргагч нь харилцагч байгууллагуудад MNT, USD, CNY гэсэн 3 төрлийн валютаар байгууллагын хадгаламжийн үйлчилгээ үзүүлж байна. Хадгаламж нь гэрээний хугацаа болон валютын төрөл, хэмжээнээс хамааран харилцан адилгүй хүүтэй.

### 3.1.3 Санхүүгийн түрээс (ХасЛизинг™)

ХасЛизинг™ нь 2021 оны 11 дүгээр сарыг хүртэл ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн охин компани байсан бөгөөд группийн бүтцийн өөрчлөлтийн хүрээнд 2021 оны 11 дүгээр сараас эхлэн Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн дагуу ХасБанктай нэгдэн, ХасБанкны үндсэн бизнесүүдийн адил үйл ажиллагаагаа явуулж байна. ХасЛизинг™ нь 2007 оноос эхлэн иргэд болон компаниудад шинэ техник хэрэгсэл, автомашин болон тоног төхөөрөмжийг санхүүгийн түрээсээр ашиглах боломжийг олгож, олон улсын жишигт нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээгээр салбартаа тэргүүлэгч болон ажиллаж байна.

ХасЛизинг™ нь харилцагч нартаа дараах бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгож байна. Үүнд:

#### 3.1.3.1 Хүнд даацын техник, хэрэгсэл

Дэлхийд нэр хүнд бүхий брэндийн Монгол Улсад албан ёсоор борлуулах эрхтэй нийлүүлэгч байгууллагууд болох БарлоВорлд Монголиа ХХК (Caterpillar, SEM),

СЗХ
2023 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Трансвест Монголиа ХХК (Komatsu), Хера Экуйпмент ХХК (Hyundai, TONLY), АОДЭ ХХК (Sinotruk, XCMG), Монмач ХХК (Zoomlion), Юу Эл Экьюпмент ХХК (JCB) зэрэг албан ёсны борлуулагч байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.

Хүснэгт 23: Санхүүгийн түрээсийн нөхцөл - хүнд даацын техник

| Урьдчилгаа | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| 20% ба түүнээс дээш | Түрээсийн хөрөнгөөс хамаарна | 1.6%-1.9% | 60 сар хүртэл |

### 3.1.3.2 Суудлын автомашин

Зах зээлд нэр хүнд бүхий автомашины албан ёсны дистрибьютерүүд болох Таван Богд ХХК (Lexus, Toyota), Мөнххада ХХК (Lexus, Toyota), МСМ Групп ХХК ( Mercedes Benz, Jeep, Ford, Fuso, BYD), Старчейз Улаанбаатар ХХК (Land Rover, Porsche) Бавариа Моторс ХХК (BMW, Mazda), Моннис Моторс ХХК (Nissan, Renault) болон бусад албан ёсны борлуулагч байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.

Хүснэгт 24: Санхүүгийн түрээсийн нөхцөл - суудлын автомашин

| Урьдчилгаа | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| 10% ба түүнээс дээш | Түрээсийн хөрөнгөөс хамаарна | 1.5%-2.0% | 30-96 сар хүртэл |

### 3.1.3.3 Тоног төхөөрөмж

Эмчилгээ оношилгоо, үйлдвэрлэл үйлчилгээ, газар тариалан, хөдөө аж ахуйн салбарт ашиглагдах тоног төхөөрөмжийг Монгол Улсад албан ёсны борлуулах эрхтэй байгууллагууд болох Монос Групп, Медимпекс Интернэшнл ХХК, Шинжьюкү ХХК, Эй энд Эйч ХХК бүх төрлийн эмчилгээ, оношилгооны тоног төхөөрөмжийн албан ёсны борлуулагч байгууллагуудтай хамтарч ажиллаж байна.

Хүснэгт 25: Санхүүгийн түрээсийн нөхцөл - тоног төхөөрөмж

| Урьдчилгаа | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| 20% ба түүнээс дээш | Түрээсийн хөрөнгөөс хамаарна | 1.8%-1.9% | 36 сар хүртэл |

### 3.1.3.4 Нийтийн болон амины орон сууц

Улаанбаатар хотын сонгогдсон бүсэд 80м2-с дээш талбай бүхий нийтийн болон амины орон сууцны зээлийн шуурхай үйлчилгээ.

Хүснэгт 26: Санхүүгийн түрээсийн нөхцөл - нийтийн болон АОС

| Урьдчилгаа | Хэмжээ | Сарын хүү | Хугацаа |
|---|---|---|---|
| 25% ба түүнээс дээш | Худалдан авах хөрөнгийн үнэлгээнээс хамаарна | 1.4%-1.5% | 240 сар хүртэл |

## 3.1.4 Гадаад төлбөр тооцоо

Үнэт цаас гаргагч нь харилцагчдынхаа гадаад төлбөр тооцоо хийх, олон улсаас төлбөр хүлээн авах хэрэгцээг олон улсын жишиг шаардлагын дагуу СВИФТ сүлжээгээр дамжуулан цаг хугацаанд нь найдвартай гүйцэтгэж байна. Мөн худалдааны санхүүжилт буюу аккредитив, гадаад баталгааны төлбөр тооцоог гүйцэтгэдэг. Банк нь дараах олон улсын корреспондент банкуудтай хамтран ажиллаж байна. Үүнд:

СЭХ
2023.05.12
оны сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Хүснэгт 27: Корреспондент банкууд

| № | Банкны нэр | Гүйлгээ хийх боломжтой валют |
|---|---|---|
| 1 | NATIONAL BANK OF CANADA | USD, CAD |
| 2 | COMMERZ BANK | EUR, GBP |
| 3 | KOOKMIN BANK | USD |
| 4 | KOREA EXCHANGE BANK | USD, KRW |
| 5 | AUSTRALIA AND NEW ZEALAND BANKING | AUD |
| 6 | BANK OF CHINA (HONG KONG)LIMITED | CNY, HKD |
| 7 | AGRICULTURAL BANK OF CHINA | CNY |
| 8 | INDUSTRIAL AND COMMERCIAL BANK | USD, CNY |
| 9 | BANK OF CHINA | CNY |
| 10 | BANK OF INNER MONGOLIA | USD, CNY |
| 11 | SUMITOMO MITSUI BANK | JPY |
| 12 | BANK OF TOKYO-MITSUBISHI | JPY |
| 13 | OVERSEA CHINESE BANKING CORPORATION | USD, SGD |
| 14 | RAIFFEISEN BANK | RUB |

### 3.1.5 Бизнесийг дэмжигч нэгжүүд

**Санхүү удирдлага, Хөрөнгө зохицуулалт, Актив пассивын удирдлага** хариуцсан нэгжүүд нь Үнэт цаас гаргагчийн урт хугацааны стратеги, зорилтод хүрэхэд нь дэмжлэг үзүүлэн ажилладаг. Санхүү бүртгэл, удирдлагын нэгж нь байгууллагын санхүүгийн тайлан, мэдээг СТОУС болон Монголбанкны журам зааварт нийцүүлэн цаг хугацаанд нь тайлагнах, мөн санхүүгийн мэдээллийг удирдлага болон бусад дотоод, гадаад хэрэглэгчдэд цаг тухайд нь хүргэх, дүн шинжилгээ хийхэд нь дэмжлэг үзүүлэн ажилладаг. Мөн бизнес нэгжүүдийн гүйцэтгэлд хяналт тавих, тэдгээрийн шийдвэр гаргалтад шаардлагатай мэдээлэл бэлтгэж, дүн шинжилгээ хийдэг. Үнэт цаас гаргагчийн санхүүгийн дотоод хяналтын орчныг бүрдүүлэх, нягтлан бодох бүртгэлийн журам, стандарт болон зохицуулагч байгууллагаас тогтоосон дүрэм, журмыг биелүүлэх нь мөн үндсэн чиг үүрэг нь байдаг. Банк нь 2019 оноос эхлэн балансын оновчтой, үр ашигтай бүтцийг бий болгох стратегийг хэрэгжүүлж, үүний хүрээнд активын бүтцийг сайжруулах, эх үүсвэрийн зардлыг бууруулах чиглэлээр шат дараалсан ажлуудыг хийж, гүйцэтгэсэн. Харин Хөрөнгө зохицуулалт болон Актив пассивын удирдлагын чиг үүргийн хүрээнд Үнэт цаас гаргагчийн өдөр тутмын мөнгөн урсгалыг үр ашигтай удирдах, богино хугацаанд байршуулан орлого олох, валютын позицийг зохистой харьцааны хязгаарын хүрээнд удирдах, мөн өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон цэвэр хүүгийн зөрүү (маржин)-г тогтвортой төвшинд байлгахад чухал үүрэгтэй ажиллаж байна.

**Эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж** нь Үнэт цаас гаргагчийг аливаа эрсдэлээс урьдчилан сэргийлэх, өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай эсэхэд хяналт тавих, активын чанарыг хамгаалж ажиллахад чухал үүрэгтэй оролцдог. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бодлого, түүний засаглал нь ТУЗ болон Гүйцэтгэх Удирдлагын өндөр оролцоонд суурилдаг бөгөөд байгууллагын соёлд мөн нягт шингэсэн байдаг. Ингэснээрээ Үнэт цаас гаргагч нь бизнес, үйл ажиллагааны бүх түвшиндөө өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон хөрвөх чадварын зохистой харьцааг өндөрт хангаж, эрсдэл багатай балансын бүтцийг бий олгох, чанаргүй активыг бага төвшинд удирдахад чиглэн ажилладаг.

**Хянан нийцүүлэлт хариуцсан нэгж** нь байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг холбогдох хууль болон зохицуулагч байгууллагаас гаргасан журам, шаардлагад нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж, салбар тооцооны нэгж болон бизнес нэгжүүдийг зөвлөмжөөр хангах замаар дэмжин ажилладаг. Мөн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх

ХАСБАНК

СЭХ
он 2023 сар 05 . 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

эрсдэлийг үнэлэн, түүнээс урьдчилан сэргийлэх, тодорхойлогдсон эрсдэлийг бууруулах арга хэмжээ авахаас гадна харилцагчийг таньж мэдэх, банкны системээр дамжиж буй гүйлгээнд хяналт тавьж, сэжигтэй болон эрсдэлтэй гүйлгээг илрүүлэхэд өндөр анхаарал хандуулан ажилладаг.

**Хүний нөөцийн удирдлага хариуцсан нэгж** нь Үнэт цаас гаргагчийн стратегийг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, сургах, чухал албан тушаалтнуудыг орлон ажиллах төлөвлөгөөг боловсруулан, хэрэгжүүлж ажилладаг. Мөн удирдлагыг хүний нөөцтэй холбогдолтой мэдээлэл болон зөвлөмжөөр хангах, шаардлагатай хүний нөөцийг бүрдүүлэх, сургах, гүйцэтгэлийн удирдлагыг хэрэгжүүлэх, цалин урамшууллын бодлогыг боловсруулах, мөн байгууллагын соёлыг хадгалахад чиглэсэн дотоод арга хэмжээнүүдийг зохион байгуулах, ажиллагчдын хувь хүний хөгжлийг дэмжихэд чиглэсэн үйл ажиллагаануудыг хэрэгжүүлдэг.

**Мэдээлэл, технологи хариуцсан нэгж** нь программ хангамж, техник хэрэгсэл, системүүдийн өдөр тутмын хэвийн, аюулгүй, найдвартай үйл ажиллагааг ханган ажилладаг. Мөн харилцагчийн үйлчилгээг илүү түргэн шуурхай, хүндрэл багатайгаар үзүүлэхэд шаардлагатай технологийн шийдлүүдийг эрэлхийлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн ажиллаж байна. Үнэт цаас гаргагч нь 2022 оны байдлаар зохих хэмжээнд технологид суурилсан Банк болсон бөгөөд мэдээлэл технологийн хувьд төвлөрсөн дэд бүтцийг бий болгон ажиллаж байна.

**Хуулийн нэгж** нь бизнес нэгжүүдэд бие даасан хуулийн зөвлөгөө, дэмжлэг үзүүлдэг. Мөн банкны бизнес болон үйл ажиллагааны хүрээнд гарч болзошгүй хууль, эрх зүйн эрсдэлийг үнэлэх, бууруулахад чиглэн ажилладаг. Аливаа шинээр хийгдэх бизнес, хэлцлийн гэрээ, журам зааврыг боловсруулахад хуулийн нэгж чухал үүрэгтэйгээр оролцдог.

**Үйл ажиллагаа, арын албаны нэгжүүд** нь банкны өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай бараа, үйлчилгээний худалдан авалтыг ил тод, үр ашигтай зохион байгуулах, өмчийн харилцаа буюу хөрөнгийн удирдлага, засвар үйлчилгээг цаг тухайд нь гүйцэтгэх, бэлэн мөнгөний хадгалалт, тээвэрлэлт болон ATM-ын тасралтгүй хэвийн үйл ажиллагааг явуулах, ажилтан болон харилцагчийн аюулгүй байдлыг бүрдүүлж ажиллах үүрэгтэй. Мөн бичиг хэрэг, архив, харилцагчийн хэрэг бүртгэлийн үйл ажиллагааг хариуцаж ажилладаг.

## 3.2 Өрсөлдөөний орчин, стратеги

### 3.2.1 Өрсөлдөөний орчин ба зах зээлд эзлэх хувь

2017 оноос эхлэн гадаадын шууд хөрөнгө оруулалт эрс буурч, төсвийн алдагдал дотоодын нийт бүтээгдэхүүний 17%-д хүрсэн, мөн Хөгжлийн Банкны олон улсын зах зээлд гаргасан бондын төлбөрийг гүйцэтгэхэд хүндрэлтэй болж, улмаар банкны салбарын активын чанар муудах нөхцөл байдал үүссэн зэрэг нь Олон Улсын Валютын Сангийн Өргөтгөсөн Санхүүжилтийн Хөтөлбөрт орох гол шалтгаануудын нэг болсон юм. Тус хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудын активын чанарт анх удаа хөндлөнгийн мэргэжлийн үнэлгээ (AQR) хийлгэж, системийн өөрийн хөрөнгийн дутагдлыг 530 тэрбум төгрөг[1] буюу дотоодын нийт бүтээгдэхүүний 1.9%-тай тэнцүү байна гэсэн дүгнэлтийг өгсөн.

Тус хөтөлбөрийн хүрээнд арилжааны банкуудын хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 100 тэрбум төгрөгт хүргэх (2021 оноос мөрдөх), банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг нэмэгдүүлэх, түүний дотроо өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг шат дараатайгаар нэмэгдүүлэх арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлж эхэлсэн.

[1] Эх сурвалж: Монголбанкны 2018 оны 2 дугаар сарын 23-ны өдрийн мэдээллийн товхимол – "Активын чанарын үнэлгээний үр дүнгийн талаарх мэдээлэл"

Зураг 6: Банкны системд идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй арилжааны банкуудын харьцуулалт (2020-2022 дундаж үзүүлэлтээр тооцов)




Мөн “Банкны салбарын шинэтгэлийн хөтөлбөр”-ийн хүрээнд системд нөлөө бүхий банкуудыг олон нийтэд хувьцаагаа гарган компанийн хэлбэрээ өөрчлөхөөс өмнө Монголбанкны санаачилгаар Активын Чанарын хараат бус үнэлгээг “Pricewaterhouse Coopers Tax & Advisory LLP” компани 2022 оны 6 дугаар сараас 8 дугаар сарын хооронд хийж гүйцэтгэсэн. Тус үнэлгээний үр дүнд банкны системд нийт 22.2 тэрбум төгрөг буюу ДНБ-ний 0.05% тэнцэх хэмжээний нэмэлт өөрийн хөрөнгийг төвлөрүүлэх шаардлагатай болсон. Харин Үнэт цаас гаргагчийн хувьд тус хараат бус шалгалтаар өөрийн хөрөнгийн хүрэлцээ хангалттай гэсэн дүгнэлтийг авсан болно.

2022 оны байдлаар банкны системд нөлөөл бүхий арилжааны 5 банк нь нийт системийн 90% гаруйг бүрдүүлж байна.

Өнгөрсөн 4 жилийн энэхүү зохицуулалтын орчин, гадаад дотоод нөхцөл байдал, Ковид-19 цар тахал зэрэг нь банкны системд ихээхэн нөлөө үзүүлж, банкуудыг активаа илүү зөв удирдах, хувь нийлүүлсэн хөрөнгөө нэмэгдүүлэх, өөрийн хөрөнгөө зөв хуваарилах, үйл ажиллагаагаа илүү үр ашигтай болгохыг шаардаж байна.

Хүснэгт 28: Системд нөлөө бүхий банкуудын зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийн харьцуулалт

| 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаарх үзүүлэлт | Байвал зохих хэмжээ | ХасБанк | Хаан Банк | ХХБ | Голомт Банк | Төрийн Банк |
|---|---|---|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа | >9% | 20.1% | 16.7% | 17.2% | 17.7% | 24.4% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа | >12% | 20.1% | 16.7% | 17.2% | 17.7% | 24.4% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт | >25% | 41.1% | 46.0% | 43.4% | 36.3% | 42.2% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) | <±15% | 6.2% | 2.8% | -0.9% | 8.0% | 7.2% |

СЗХ 2023 оны 05 сарын 12 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт) | <±30% | 6.9% | 3.0% | 4.2% | 10.8% | 8.2% |

Эх сурвалж: Арилжааны банкуудын цахим хуудас

### 3.2.2 Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь болон бүтээгдэхүүн, үйлчилгээний харьцуулалт

2019 оноос эхлэн Монголбанкнаас арилжааны банкуудад тавих зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг чангаруулсантай холбоотойгоор Үнэт цаас гаргагч нь мөн үеэс стратегидаа өөрчлөлт оруулж, активын өсөлтөөс илүүтэйгээр балансын чанарт анхаарч, эрсдэлээ хянаж чадах хэмжээнд зээлийн багцыг өсгөх бодлого баримтлан ажиллаж эхэлсэн. Энэхүү бодлогын хүрээнд Үнэт цаас гаргагч нь томоохон дүнтэй бизнесийн зээлүүдэд тавих шалгууруудыг чангаруулж, зээлийн багцыг иргэдийн зээл болон бичил, жижиг-дунд бизнесийн зээлээр бүрдүүлэхэд түлхүү анхаарч ажилласан. Мөн активт гарч буй энэхүү өөрчлөлттэй уялдуулан эх үүсвэрийн бүтцэд томоохон өөрчлөлт оруулж, эх үүсвэрийн зардлыг бууруулах шат дараалсан арга хэмжээ авснаар 2020-2022 оны хооронд Үнэт цаас гаргагчийн балансын чанар болон ашигт ажиллагаа эрс сайжирсан болно.

Хүснэгт 29: Зах зээлд эзлэх хувь

| **Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувь** (сонгогдсон үзүүлэлтийн хувьд) | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| Нийт актив | 9.3% | 9.7% | 8.9% | 8.6% | 8.5% |
| Татварын дараах цэвэр ашиг | n/a* | 3.4% | 10.3% | 13.7% | 9.9% |
| Зээлийн багц | 11.0% | 10.0% | 7.7% | 8.8% | 9.5% |
| Харилцах болон хадгаламж | 8.5% | 8.8% | 8.3% | 8.3% | 7.9% |
| Гадаад, дотоод бусад эх үүсвэр | 30.6% | 32.5% | 29.4% | 19.4% | 12.5% |
| АТМ-ын тоо | 11.9% | 11.8% | 14.0% | 14.3% | 14.3% |
| POS-ын тоо | 11.3% | 8.6% | 8.0% | 8.0% | 8.1% |

Эх сурвалж: Монголбанкны тоон мэдээлэлд үндэслэн тооцов.

Хүснэгт 30: Системийн банкуудын зарим бүтээгдэхүүнүүдийн харьцуулалт

| | | | | | ТӨРИЙН БАНК |
|---|---|---|---|---|---|
| Зээлийн бүтээгдэхүүн<br>Зээлийн хэмжээ<br>Сарын хүү (2023 оны 2 дугаар сарын байдлаар) | | | | | |
| **Цалингийн зээл** | Хэрэглээнээсээ шалтгаална<br>1.50% - 1.70%<br><30 сар | 50 сая хүртэл<br>1.45% - 1.9%<br><30 сар | 50 сая хүртэл<br>1.5% - 1.7%<br><30 сар | 50 сая хүртэл<br>1.45% - 1.75%<br><30 сар | 50 сая хүртэл<br>1.50% - 1.70%<br><30 сар |
| **Ипотекийн зээл** | <500 сая<br>1.50%<br><240 сар | <1 тэрбум<br>1.35% - 1.60%<br><240 сар | <500 сая<br>1.60% - 1.80%<br><240 сар | Үл хөдлөх хөрөнгийн үнийн 80%<br>1.25% - 1.55%<br><240 сар | <1 тэрбум<br>1.50% - 1.80%<br><240 сар |
| **Жижиг бизнесийн зээл** | Хэрэглээнээсээ шалтгаална<br>1.80% - 2.00%<br><36 сар | Хэрэглээнээсээ шалтгаална<br>1.60% - 1.90%<br><36 сар | Хэрэглээнээсээ шалтгаална<br>1.60% - 1.90%<br><36 сар | Хэрэглээнээсээ шалтгаална<br>1.40% - 1.70%<br><36 сар | 500 сая төгрөг хүртэл<br>1.60% - 1.90%<br><40 сар |
| **Бизнесийн зээл** | Хэрэглээнээсээ шалтгаална<br>1.80% - 2.00%<br><60 сар | Хэрэглээнээсээ шалтгаална<br>1.60% - 1.90%<br><60 сар | Хэрэглээнээсээ шалтгаална -<br>1.80% - 1.95%<br><84 сар | Хэрэглээнээсээ шалтгаална<br>1.40% - 1.70%<br><60 сар | Хэрэглээнээсээ шалтгаална -<br>1.80% - 2.00%<br><96 сар |
| **Эрчим хүчний** | 200 сая хүртэл<br>1.0% | 1 тэрбум хүртэл<br>1.35% | 300 сая хүртэл<br>1.2% | 300 сая хүртэл | 100 сая хүртэл<br>1.00%-1.35% |

ХАСБАНК

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| **хэмнэлттэй амины орон сууц худалдан авах зээл** | 240 сар хүртэл | 240 сар хүртэл | 60 сар хүртэл | Бодлогын хүү +(2%-4%)* 240 сар хүртэл | 180 сар хүртэл |
| Хадгаламжийн бүтээгдэхүүн<br>Дансны доод үлдэгдэл<br>Сарын хүү (2023 оны 2 дугаар сарын байдлаар) | | | | | |
| **Харилцах данс** | -<br>Хүүгүй | -<br>0.25% | 1,000<br>Хүүгүй | 5,000<br>0.25% | 1,000<br>Хүүгүй |
| **Хугацаагүй хадгаламж** | 10,000<br>0.20% | 5,000<br>0.55% | 5,000<br>0.55% | 10,000<br>0.38%-0.55% | 5,000<br>0.40%-0.57% |
| **Хугацаатай хадгаламж** | 20,000<br>0.92% | 10,000<br>1.04% | 20,000<br>1.03% | 10,000<br>1.03% | 10,000<br>1.03% |
| **Хүүхдийн хадгаламж** | 20,000<br>0.92% | 10,000<br>1.06% | 20,000<br>1.06% | 20,000<br>1.09% | 10,000<br>1.08% |
| Карт | | | | | |
| **Дебит карт** | VISA, UPI | VISA, UPI | VISA, UPI | VISA, UPI, AMEX | VISA, UPI |
| **Зээлийн картын жилийн хүү** | 1.50%-2.8% | 2.00%-3.00% | 2.00%-2.50% | 2.00%-3.50% | 1.80%-2.40% |

*Жилийн хүү
Эх сурвалж: арилжааны банкуудын цахим хуудас

### 3.2.3 Үнэт цаас гаргагчийн зээл ба санхүүгийн түрээсийн багцын удирдлага

Зээлийн багц нь олон төрлийн зээлийн бүтээгдэхүүнээс бүрдэж байгаа бөгөөд Иргэдийн банкны зээлийн багц 68%, Байгууллагын банкны зээлийн багц 21%, санхүүгийн түрээсийн багц 11%-г тус тус бүрдүүлж байна. Үнэт цаас гаргагч нь салбартаа бичил болон жижиг зээлийн бүтээгдэхүүнийг борлуулах чадвар өндөртэй, мөн тус зээлийн багцын өгөөж харьцангуй өндөр байгааг харгалзан тус бүтээгдэхүүнийг түлхүү борлуулахаар зорьж байна. Мөн сүүлийн жилүүдэд хэрэгжүүлж байгаа гол төслүүдийн нэг болох хэрэглээний бүх төрлийн зээлийг хүний оролцоо багатайгаар буюу цахим сувгаар дамжуулан борлуулахад чиглэсэн төслүүдийг хэрэгжүүлж байна. Хэрэглээний зээлийн бүтээгдэхүүнд худалдан авалтын зээл, цалингийн зээл, орон сууцны зээл болон картын зээл хамаарна. Энэхүү бүтээгдэхүүний борлуулалт нь нь хүүгийн мэдрэмжтэйгээс гадна зээлийн процесс түргэн шуурхай, харилцагчид чирэгдэл багатай байхаас ихээхэн хамаардаг.

Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилүүдэд үйл ажиллагаагаа улам үр ашигтай болгож, байгууллагын томоохон харилцагчийн сегментэд ажиллах арга барил, олон улсын санхүүгийн байгууллагуудаас эх үүсвэр татах боломжтой зэрэг өрсөлдөөний давуу талаа ашиглан сайн харилцагчдадаа ямар ч нөхцөлд хэрэгцээтэй санхүүжилтийг нь тасалдуулахгүй олгох бодлого барин ажилладаг.

**Иргэдийн банкны зээл:** Үнэт цаас гаргагч нь 2019-2022 онд зээлийн багцын чанарыг сайжруулах, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зорилгоор эрсдэлтэй сегмент, харилцагчийг

График 12: Иргэдийн зээлийн багц, чанаргүй зээлийн хэмжээ, бүтээгдэхүүний бүтэц




илрүүлэх арга хэмжээ авч, түүний хүрээнд зээлийн багцын бүтцийг үе шаттайгаар өөрчилсөн. Үүний хүрээнд 2018-2020 онд иргэдийн зээлийн багц 25%-р буурсан бол 2021, 2022 онуудад Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээх арга хэмжээнүүдийн хүрээнд харилцагчдадаа бүх төрлийн зээлийн санхүүжилтийг олгож тус сегментийн багцыг 35% өсгөөд байна.

Банк нь бизнесийн орлоготой иргэн, аж ахуйн нэгжид үйл ажиллагааны чиглэл, бизнесийн онцлогт нь тохирсон эргэлтийн хөрөнгийн зээл, хөрөнгө оруулалтын зээлийг олгохоос гадна баталгаа, аккредитивын бүтээгдэхүүнийг санал болгон хамтран ажиллаж байна. Харин цалингийн орлоготой иргэдэд цалингийн зээл, хэрэглээний худалдан авалтын зээл, кредит карт зэрэг зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож байна.

Иргэдийн банк нь харилцагчид зориулж бүтээгдэхүүн, үйлчилгээ боловсруулахдаа бодит үнэ тогтоох зарчмыг баримтладаг. Харилцагчид олгох зээлийн хэмжээг зохицуулагч байгууллагаас баталсан журам, зааврын хүрээнд тогтоодог бөгөөд харилцагчийг өрийн дарамтад орохоос урьдчилан сэргийлж зөвлөмж, мэдээллээр тогтмол хангаж байна.

**Байгууллагын банкны зээл:** Зээлийн багцыг чанаржуулах, ашигтай багц бүрдүүлэхэд чиглэсэн стратегийг сүүлийн жилүүдэд хэрэгжүүлэн ажиллаж байна. Энэхүү стратегийн

График 13: Байгууллагын зээлийн хэмжээ, чанаргүй зээл, бүтээгдэхүүний бүтэц



СЭХ 2023 он 05 сар 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

хүрээнд анхаарал татсан, ирээдүйд эрсдэлд орж болзошгүй томоохон дүнтэй бизнесийн зээлүүдийн үлдэгдлийг бууруулах, чанаргүй зээлийг төлүүлэх, шинээр чанаргүй зээл гарахаас сэргийлэх арга хэмжээнүүдийг шат дараалан авч ажилласан. Үүний үр дүнд 2018-2020 онд зээлийн багц 45%-р, чанаргүй зээлийн багц 21%-р тус тус буурсан байна. Харин 2021 оноос эхлэн Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийг сэргээх арга хэмжээний хүрээнд байгууллагын зээлийн багцыг аажим нэмэгдүүлж байна.

**Санхүүгийн (ХасЛизинг™) түрээс:**

Дэлхийд нэр хүнд бүхий автомашин, техник тоног төхөөрөмжийг Монгол Улсад албан ёсоор борлуулдаг бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажиллаж иргэд, ААН байгууллагад санхүүгийн түрээсээр хурдан шуурхай, нэмэлт барьцаагүйгээр олгодог нь тус бүтээгдэхүүний онцлог билээ. Харилцагчдын хувьд дэвшилтэт технологи бүхий, орчин үеийн шинэ техник хэрэгсэл, автомашиныг санхүүгийн түрээсээр авч, ажлын бүтээмжээ дээшлүүлдэг.

Хэдийгээр 2022 онд тээвэр логистикийн хүндрэлийн улмаас санхүүгийн түрээсээр олгох шинэ автомашин, техникийн хангалт, хүрэлцээ дутмаг байсан ч бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудтай хамтран ажилласны үр дүнд 2022 оны эцсийн байдлаар санхүүгийн түрээсийн нийт багц 223 тэрбум төгрөгт хүрч өмнөх оноос 13.5%-иар өссөн үзүүлэлттэй байна. ХасЛизинг™-ийн бизнесийн онцлог нь чанаргүй санхүүгийн түрээсийг маш бага түвшинд буюу 1%-иас доогуур тогтвортой удирдан ажиллах арга барил болно.

График 14: Санхүүгийн түрээсийн хэмжээ, чанаргүй түрээс, бүтээгдэхүүний бүтэц




Цаашдаа бэлтгэн нийлүүлэгч байгууллагуудын тоог нэмэгдүүлэх, мөн зах зээлд шинэ бүтээгдэхүүнийг гаргахаар ажиллаж байна. Үүнд, хуучин автомашин болон хувийн хаус худалдан авахад зориулсан санхүүгийн бүтээгдэхүүнүүдийг туршин ажиллаж байна.

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

### 3.2.4 Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн удирдлага

Үнэт цаас гаргагч нь эх үүсвэрийн оновчтой бүтцийг бий болгох зорилгоор дотоод болон гадаад эх үүсвэрийг тогтвортой татан төвлөрүүлэн ажиллаж байна. Дотоод эх үүсвэрт иргэдийн харилцах, хадгаламж дийлэнх хувийг бүрдүүлдэг бол гадаад эх үүсвэр нь олон улсын санхүүгийн байгууллагуудаас авсан урт хугацаатай (3-5 жил хүртэл) ам.долларын эх үүсвэр байдаг. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд гадаад валютаар зээл олгохыг хязгаарладаг тул олон улсын санхүүгийн байгууллагаас татан төвлөрүүлсэн ам.долларын эх үүсвэрийг Монголбанктай своп хэлцэл хийх замаар төгрөгийн урт хугацаатай эх үүсвэрт хөрвүүлж байна. 2022 онд олон улсын 8 санхүүгийн байгууллагатай урт хугацаат санхүүжилт татах гэрээ хэлцэл хийж, үүнээс 83 сая ам.долларыг 2022 ондоо хүлээн авч, үлдсэн 130 сая ам.долларыг 2023 онд багтаан авахаар үүрэг хүлээсэн болно. Энэхүү шинэ эх үүсвэрүүд нь эрчим хүчний хэмнэлтийг бий болгох санхүүжилт болон эмэгтэй бизнес эрхлэгчдийг дэмжихэд түлхүү зарцуулагдана. Гадаад эх үүсвэрийн дэлгэрэнгүй мэдээллийг энэхүү Танилцуулгын хавсралт 1 (аудитлагдсан санхүүгийн тайланг)-с үзнэ үү.

График 15: Үнэт Цаас гаргагчийн эх үүсвэрийн бүтэц




Үнэт цаас гаргагч нь 2019-2020 онуудад тодорхой зорилготойгоор зээлийн багцыг бууруулах бодлого баримтлан ажилласан тул илүүдэл эх үүсвэрийн хэмжээг багасгах шаардлага үүссэн. Үүний хүрээнд гадаад эх үүсвэр болон дотоодоос татан төвлөрүүлсэн гадаад валютын хадгаламжийн үлдэгдлийг бууруулан ажилласан. Мөн зээлийн хүүг бууруулах стратегийн хүрээнд зах зээлд хамгийн бага хадгаламжийн хүүг санал болгох замаар эх үүсвэрийн өртгийг бууруулж чадсан байна.

Хадгаламжийн өсөлтийн үндсэн хүчин зүйл нь сайн засаглал, нэр хүнд, найдвартай байдал гэж дүгнэж болно. Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн үндсэн бүтээгдэхүүнүүдийн нэг болох Ирээдүйн Саятан хүүхдийн хадгаламжийн үлдэгдэл нь сүүлийн 5 жилд нэг дахин нэмэгдсэн нь Засгийн Газраас хэрэгжүүлж буй хүүхдийн мөнгөтэй холбоотой байхаас гадна иргэд урт хугацааны хуримтлалд ихээхэн анхаарч байгаагын нэг илэрэл гэж үзэж байна.

ХАСБАНК
ХН4937 2578697

СЗХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

### 3.2.5 Үнэт цаас гаргагчийн цахим банкны бизнес

Үнэт цаас гаргагч нь төлбөр тооцооны үйлчилгээндээ технологийн дэвшилтийг нэвтрүүлэн ажиллаж байна. Тухайлбал, картаа зайнаас удирдах, онлайн зээл авах зэрэг олон боломж бүхий шинэчилсэн дижитал банкны аппликейшнийг 2021 онд зах зээлд нэвтрүүлсэн бөгөөд үүний үр дүнд дижитал банкны идэвхтэй харилцагчийн тоо 26%-иар нэмэгдсэн байна.

График 16: Үнэт цаас гаргагчийн цахим банкны тоон үзүүлэлтүүд




### 3.2.6 Дунд болон урт хугацааны бизнесийн бодлого

**Хөрөнгө оруулагчдын анхааралд:** Энэхүү дэд бүлэгт орсон мэдээлэл, таамаглал нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн олон нийтэд нээлттэй мэдээлэл, тоо баримт дээр үндэслэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуурх буюу гадаад орчны олон хүчин зүйлээс хамааран үр дүн, таамаглал, төсөөлөл нь өөрчлөгдөж болохыг анхаарна уу. Гадаад орчны хүчин зүйлсэд тухайлбал макро эдийн засаг болон улс төрийн орчин, дэлхийн зах зээлийн нөхцөл байдал, инфляц, валютын ханш, Ковид-19 цар тахлын үргэлжилсэн болон дам нөлөө, хөрөнгийн зах зээл, банкны салбарын орчин ба түүний өөрчлөлт зэргийг онцлон дурдаж болно. Түүнчлэн энэхүү хэсэгт агуулагдаж буй түүхэн тоо баримтаас бусад мэдээлэл нь ирээдүйн нөхцөл байдлын талаарх Үнэт цаас гаргагчийн гаргаж буй таамаглал бөгөөд ирээдүйн талаарх таамаглал нь олон төрлийн эрсдэлүүд, тодорхойгүй байдал болон бусад хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай байдаг. Улмаар Үнэт цаас гаргагчийн ирээдүйн бодит гүйцэтгэл, санхүүгийн үр дүнд шууд нөлөө үзүүлж, таамаглал, бодит гүйцэтгэл хоёрын дунд материаллаг зөрүү үүсгэх боломжтой. Мөн Украин болон ОХУ-ын хооронд

ХАСБАНК
4937 2578697

СЗХ 2023.05.12 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

**үүсээд буй цэрэг дайны нөхцөл байдал урт хугацаанд үргэлжлэх, хурцдах тохиолдолд дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлж, цаашлаад Монгол Улсын эдийн засаг, банкны салбарт шууд болон шууд бусаар хохирол учруулж болохыг анхаарна уу. Үнэт цаасны танилцуулгыг боловсруулахдаа дээр дурдсан тодорхойгүй байдал болон гадаад орчны эрс тэс нөхцөл байдлыг тооцоололд оруулаагүй тул хөрөнгө оруулагч та хөрөнгө оруулалтын шийдвэрээ өөрийн бие даасан дүн шинжилгээнд үндэслэн гаргахыг зөвлөж байна.**

Нээлттэй хувьцаат компанийн хувьд зах зээлд эзлэх байр сууриа нэмэгдүүлэхээс гадна хувьцааны ханшийн тогтвортой өсөлтийг хангах нь ихээхэн сорилтуудын дагуулдаг. Үнэт цаас гаргагчийн хувьд зах зээлд нэгэнт бий болгосон онцлог, байр суурь, өнөөгийн санхүүгийн байдал нь цаашид (ирэх 5 жилд) бизнесийн цар хүрээгээ тэлэх ихээхэн боломжтойг харуулж байгаа. Мөн ирэх жилүүдэд эдийн засгийн бодит өсөлт жилд 4%-6%, банкны системийн өсөлт жилд 12-15% байхаар хүлээгдэж байгаа энэ үед Үнэт цаас гаргагч нь зах зээлд эзлэх байр сууриа (2022 оны байдлаар нийт активын зах зээлд эзлэх хувь 8.6% байна) нэмэгдүүлэх зорилго тавин ажиллана.

Зураг 7: Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын бүтэц




### 3.2.7 Үнэт цаас гаргагчийн бизнес, эрсдэлийн удирдлагын бодлого

Үнэт цаас гаргагч нь 2019 оноос эхлэн эрсдэлийг бууруулж, санхүүгийн байдал болоод ашигт ажиллагаагаа сайжруулах замаар ирээдүйн өсөлтийн суурийг тавих бодлогыг хэрэгжүүлж ирсэн. Энэхүү бодлогын үр дүнд Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгийн хүрэлцээг хувьцаа эзэмшигчдээс нэмж хөрөнгө таталтгүйгээр буюу дотоод нөөц

СЗХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

боломжоор нэмэгдүүлж, зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг давуулан биелүүлж, эрсдэл даах чадвараа улам бэхжүүлсэн байна.

Хүснэгт 31: Үнэт цаас гаргагчийн зохистой харьцаа үзүүлэлтийн биелэлт

| Шалгуур үзүүлэлтүүд | Байвал зохих хэмжээ | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|---|
| 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа | >9% | 16.9% | 17.4% | 20.1% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа | >12% | 17.4% | 17.4% | 20.1% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт | >25% | 54.9% | 44.3% | 41.1% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) | <±15% | -1.8% | -1.1% | 6.2% |
| Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт) | <±40% | -4.2% | -2.2% | 6.9% |

Үнэт цаас гаргагч нь цаашид энэхүү эрсдэлийн удирдлагын оновчтой бодлогоо үргэлжлүүлэн баримтлах, өндөр эрсдэл авахгүйгээр активаа өсгөхөөр төлөвлөж байна. Ингэхдээ:

I. **Өөрийн хөрөнгийн хүрэлцээг ханган ажиллах**

2019 онд Монголбанкны баталсан “Банкны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, хяналт тавих” журмын хүрээнд Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээ эрс сайжруулах шаардлага үүссэн. Тус өөрчлөлтийн хүрээнд нийт 18 сарын хугацаанд нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний нэмэлт шаардлага 3 удаа, эрсдэлээр жигнэсэн активын тооцоолол 4 удаа тус тус чангарах, мөн үүний зэрэгцээ Үнэт цаас гаргагчийн томоохон дүнтэй чанаргүй активуудад нэмж сан байгуулах шаардлагатай тулгарсан зэрэг нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт огцом муудах нөхцөл байдлыг үүсгэж байлаа. Харин тухайн нөхцөл байдлыг бодитоор дүгнэн - 1) эрсдэл өндөртэй эдийн засаг, бизнесийн сегментэд зээл олгохоос зайлсхийх, 2) алдагдал өндөртэй, ашиггүй зээлийн бүтээгдэхүүнийг бууруулах, 3) анхаарал хандуулах болон чанаргүй ангилалтай активыг төлүүлэх зэрэг цогц арга хэмжээнүүдийг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд Үнэт цаас гаргагч нь 2020-2022 онуудад өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтээ эрс сайжруулж, балансын бүтцээ чанаржуулж чадсан байна. Үнэт цаас гаргагч нь балансын (жишээ нь актив, пассивын өсөлт) өсөлтийг эдийн засгийн хувьд ашигтай байхаас гадна шаардлагатай үед эрсдэлийг бууруулж болохуйц тохиргоо хийх боломжтойгоор удирдах бодлого баримтлан ажилладаг.

II. **Эрсдэлийг оновчтой удирдах, активын эрсдэлийн санг хүрэлцээтэй төвшинд хадгалах**

Энэхүү зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Үнэт цаас гаргагч нь нэн тэргүүнд үйл ажиллагааны орлогоо нэмэгдүүлэх, нэмэгдэл орлогоос активын эрсдэлийн санг хангалттай байгуулах зарчмаар ажиллаж байна. Үйл ажиллагааны цэвэр орлогыг нэмэгдүүлэх нь дан ганц орлогын удирдлагын асуудал биш бөгөөд санхүүгийн болон үйл ажиллагааны зардлуудыг зөв голдиролд оруулах нь ашигт ажиллагаанд ихээхэн нөлөөлдөг. Үнэт цаас гаргагч нь 2022 оны эцсийн байдлаар Монголбанкны журмын дагуу активт байгуулсан эрсдэлийн сангуудыг чанаргүй активт (чанаргүй зээл болон ӨБҮХХ) сангуудыг хангалттай хэмжээнд ханган ажилласан бөгөөд тус үзүүлэлтийг цаашид тогтвортой байлгахаар зорьж байна.

ХАСБАНК
4937 2578697

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

### III. Хөрөнгө оруулагчийн үнэ цэнийг нэмэгдүүлэх

Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгийн өгөөжийг (татварын дараах цэвэр ашгийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа) тогтвортой байлгах (20% ба түүнээс дээш)-ын тулд дараах арга хэмжээг авч ажиллана. Үүнд: 1) активын өгөөж болон эх үүсвэрийн зардлыг оновчтой удирдах замаар цэвэр хүүгийн зөрүүг хадгалах, 2) санхүүгийн сахилга баттай байж зардлын үр ашгийг 50%-иас доош удирдах, 3) чанаргүй активыг тогтмол бага төвшинд удирдах арга хэмжээнүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлнэ.

### IV. Цахимжуулалт

Үнэт цаас гаргагч нь мэдээлэл технологийн дэд бүтцэд шат дараалсан хөрөнгө оруулалтуудыг хийж, бүтээгдэхүүн үйлчилгээгээ цахим болгох төслүүдийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Технологийн дэвшил нь Иргэдийн банкны бизнесийн суурь нь болдог гэдэг утгаараа Үнэт цаас гаргагч нь дунд болон урт хугацааны технологийн шийдлүүдийг эрэлхийлж, өөрийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхээр ажиллаж байна. Цахимжуулалт болон үйл ажиллагааны автоматжуулалт нь энэ зорилтын хүрээнд хийгдэж байгаа нэн тэргүүний ажлууд болно. 2022 онд цахим шилжилтийн ажлын хүрээнд Үнэт цаас гаргагч нь өөрийн Үндсэн Системээ шинэчилж (Financle), зээлийн үйл ажиллагааг автоматжуулах зэрэг томоохон төслүүдийг амжилттай хэрэгжүүлж, үйл ажиллагаандаа нэвтрүүлсэн байна.

### 3.2.8 Үнэт цаас гаргагчийн стратеги, зорилт (хураангуй)

Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилүүдэд шинэ технологид суурилсан арилжааны банкны дэд бүтцийг бий болгохоор ажиллаж байгаа бөгөөд харилцагчийн төлбөр тооцоо, гүйлгээний зардлыг хамгийн бага түвшинд тогтвортой байлгахаар зорин ажиллаж байна.

ХАСБАНК

СЗХ 2023 .05. 12
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

Зураг 8: Үнэт цаас гаргагчийн стратегийн зорилт




Үнэт цаас гаргагчийн активын чанар, балансын бүтэц, өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг эрс сайжруулсан. 2019-с 2022 он хүртэлх хугацаанд:

- Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 9%-с 20.1%-д хүргэсэн;
- Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцааг 29.5%-с 41.1%-д хүргэсэн;
- Чанаргүй зээл болон ӨБҮХХ-ийн үлдэгдлийг 189 тэрбум төгрөгөөс 134 тэрбум төгрөгт хүргэж, нийт эрсдэлийн сан болон чанаргүй активын харьцааг 100%-с дээш хангасан.

Банкны үндсэн болон дэд системүүдийг шинэчлэх ажил хийгдсэн. Үүнд Finacle БҮС болон iExceed дижитал банкны систем, зээлийн үйл ажиллагааг автоматжуулах LOS чухал үүрэг гүйцэтгэж байна.

Төлбөр тооцооны дэд бүтэц, сүлжээг өргөтгөж, 6700 орчим POS, 360 ATM/CDM төхөөрөмж, мөн хамтран ажиллагч байгууллагуудын сүлжээг 5,500 терминалаар нэмэгдүүлсэн.

- Хуримтлуулсан ашгийг нэмэгдүүлэх замаар өөрийн хөрөнгийн органик өсөлтийг бий болгох,
- Эрсдэлийг зөв удирдаж ашигт суурилсан аргаар зах зээлд эзлэх хувийг нэмэгдүүлэх,
- Банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг цахимжуулах замаар харилцагчийнхаа төлбөр тооцооны шууд болон шууд бус зардлыг бууруулах.

ХАСБАНК

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

# Дөрөв. БАНКНЫ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

## 4.1 СТОУС-ын дагуух санхүүгийн мэдээллүүд

Энэхүү бүлэгт агуулагдсан мэдээлэл нь ХасБанк болон түүний нэгж Хаслизинг (2021 оны 11 дүгээр сараас өмнө ТСН-ийн 100%-ийн охин компани байсан бөгөөд 2021 оны 11 дүгээр сард Үнэт цаас гаргагчийн шийдвэрээр компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлд заасны дагуу ХасБанканд нэгтгэсэн)-ийн санхүүгийн үзүүлэлтийг түүхэн хугацаанд нөхөж нэгтгэсэн байдлаар толилуулж байгаа болно.

Үнэт цаас гаргагчийн 2020 оны санхүүгийн тайланг Деллойт Онч Аудит ХХК, 2021 болон 2022 онуудын санхүүгийн тайланг Эрнст энд Янг Монголия Аудит ХХК аудиталсан бөгөөд тайланг тодруулгын хамт энэхүү Танилцуулгад хавсаргав (Хавсралт-1). СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн хураангуй орлого, үр дүнгийн тайлан болон санхүүгийн байдлын тайланг дараах байдлаар зэрэгцүүлж харуулав.

Хүснэгт 32: Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлан

| Сая төгрөгөөр | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 381,757 | 332,086 | 376,659 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (262,487) | (174,330) | (156,332) |
| **Хүүгийн цэвэр орлого** | **119,270** | **157,756** | **220,327** |
| Хураамж ба шимтгэлийн орлого | 23,289 | 26,944 | 30,702 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | (6,390) | (8,019) | (11,289) |
| **Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого** | **16,899** | **18,925** | **19,413** |
| Арилжааны цэвэр ашиг | 2,054 | 6,194 | 16,984 |
| БҮЦАА-д бүртгэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого | 3,255 | 3,602 | 3,350 |
| Үйл ажиллагааны бусад цэвэр орлого/(зардал) | (8,662) | (374) | 3,597 |
| **Үйл ажиллагааны нийт орлого** | **132,816** | **186,103** | **263,671** |
| Зээлийн алдагдлын цэвэр зардал | (19,925) | (4,571) | (9,153) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **112,891** | **181,532** | **254,518** |
| Үйл ажиллагааны зардал | (70,280) | (80,471) | (109,335) |
| Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга | 1,175 | 1,407 | 1,507 |
| **Татварын өмнөх ашиг** | **43,786** | **102,468** | **146,690** |
| Орлогын татварын зардал | (10,102) | (27,205) | (40,851) |
| **Тайлант жилийн ашиг** | **33,685** | **75,263** | **105,839** |
| Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах | 169 | 3,000 | 854 |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого** | **33,854** | **78,263** | **106,693** |

Хүснэгт 33: Санхүүгийн байдлын хураангуй тайлан

| сая төгрөгөөр | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 179,505 | 248,313 | 431,342 |
| Монголбанк дахь заавал байлгах нөөц | 186,373 | 214,231 | 255,683 |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | 75,684 | 49,223 | 107,799 |
| Санхүүгийн хэрэгслүүд | 42,356 | 76,289 | 83,897 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 62,983 | 90,001 | 102,765 |
| БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө | | | |
| Өмчийн хэрэгслүүд | 3,610 | 3,613 | 4,682 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө | | | |
| Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 82,528 | 42,487 | 282,232 |

| | | | |
|---|---|---|---|
| Өрийн хэрэгслүүд | 1,207,367 | 926,715 | 596,388 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,364,715 | 1,701,558 | 1,900,053 |
| Бусад хөрөнгө | 58,198 | 60,593 | 71,527 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | 3,034 | 134 | 2,063 |
| Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө | 63,559 | 67,214 | 68,221 |
| Биет бус хөрөнгө | 14,706 | 15,453 | 18,895 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 21,260 | - | - |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 3,535 | 4,135 | 5,233 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **3,369,413** | **3,499,959** | **3,930,780** |
| | | | |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | - | 371 | 1,640 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр | | | |
| Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж | 1,939 | 2,691 | 51,867 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 2,025,471 | 2,252,100 | 2,438,619 |
| Зээлээр авсан санхүүжилт | 937,586 | 768,776 | 857,363 |
| Өрийн Үнэт цаас | 10,619 | 8,404 | - |
| Хойшлогдсон нөхцөлт хандив | 10,319 | 9,243 | 7,971 |
| Түрээсийн өр төлбөр | 3,176 | 5,423 | 5,310 |
| Бусад өр төлбөр | 58,300 | 64,250 | 68,482 |
| Орлогын татварын өглөг | 8,771 | 4,706 | 23,840 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,056,181** | **3,115,964** | **3,455,092** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Энгийн хувьцаа | 58,626 | 100,000 | 100,000 |
| Нэмж төлсөн капитал | 1,818 | 1,818 | 1,818 |
| Нөөцүүд | 57,852 | 84,602 | 95,708 |
| Хуримтлагдсан ашиг | 194,936 | 197,575 | 278,162 |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | **313,232** | **383,995** | **475,688** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **3,369,413** | **3,499,959** | **3,930,780** |

## 4.2 Удирдлагын зорилгоор (СТОУС-ын бус) бэлтгэсэн санхүүгийн мэдээллүүд

Энэхүү Танилцуулга нь СТОУС-ын тодорхойлолт, ангилал болон томьёоллын дагуу бэлтгэсэн санхүүгийн мэдээллээс гадна удирдлагын мэдээллийн зорилгоор боловсруулсан санхүүгийн үзүүлэлтүүдийг агуулсан болно. Тухайлбал зохицуулагч байгууллагын холбогдох дүрэм, журмын дагуу тооцдог зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон Үнэт цаас гаргагчийн бизнесийн үр дүн, гүйцэтгэлийг хэмжихэд өргөн ашиглагддаг санхүүгийн мэдээллүүд үүнд багтдаг. Мөн энэхүү удирдлагын мэдээллийн зорилгоор ашигладаг санхүүгийн тоо, харьцаа үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, тодорхойлолт нь бусад арилжааны банкнууд болон санхүүгийн байгууллагуудын ашиглаж байгаа аргачлалаас өөр байхыг үгүйсгэхгүй бөгөөд банкуудын санхүүгийн үзүүлэлтүүдийн харьцуулалтыг шууд хийх нь зарим тохиолдолд тохиромжгүй байж болно. Удирдлагын мэдээллийн зорилгоор ашигладаг санхүүгийн үзүүлэлтүүд нь Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэлийг хэмжих болон шийдвэр гаргалтад чухал үүрэгтэй байдаг тул энэхүү Үнэт цаасны танилцуулгад зарим чухал санхүүгийн үзүүлэлтүүдийг сонгон авч толилуулав.

### 4.2.1 Санхүүгийн гол үзүүлэлтүүд

Үнэт цаас гаргагчийн санхүүгийн гол үзүүлэлтүүдийг дараах байдлаар хураангуйлан харьцуулав.

Хүснэгт 34: Санхүүгийн гол хэмжүүрүүд

| Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв | 2020 оны 12 дугаар сарын | 2021 оны 12 дугаар сарын | 2022 оны 12 дугаар сарын |
|---|---|---|---|

| | 31-ний байдлаар | 31-ний байдлаар | 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн өгөөж* (ROE) | 12.0% | 24.0% | 27.6% |
| Активын өгөөж (aROA) | 1.0% | 2.1% | 2.6% |
| Татварын дараах цэвэр ашиг (СТОУС-ын дагуу) | 33.7 | 75.3 | 105.8 |
| Татварын дараах цэвэр ашгийн жилийн өсөлт | +39.5% | +123.4% | +40.6% |
| Цэвэр хүүгийн маржин** (NIM) | 3.9% | 5.3% | 7.8% |
| Чанаргүй зээлийн хувь (NPL ratio) | 6.3% | 4.4% | 4.0% |
| МБ журам, шаардлагын дагуу байгуулсан ЗТУБАХСан болон чанаргүй зээлийн харьцаа*** | 102.7% | 118.6% | 130.3% |
| Үйл ажиллагааны зардал, орлогын харьцаа**** | 49.9% | 41.9% | 39.9% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 54.9% | 44.3% | 41.1% |

* Тухайн оны цэвэр ашгийг оны эхний өөрийн хөрөнгөд харьцуулан тооцсон.
** Тухайн оны цэвэр хүүгийн орлогыг тогтортой хүүгийн орлого олдог дундаж активт харьцуулан тооцсон.
*** Монголбанкны холбогдох журам, шаардлагын дагуу байгуулсан зээл төлөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан (ЗТУБАХС)-ийн нийт дүнг чанаргүй зээл-санхүүгийн түрээсийн үлдэгдэлтэй харьцуулан тооцсон.
**** Үйл ажиллагааны зардлыг (хуулийн дагуу Хадгаламжийн Даатгалын Корпорацид улирал бүр төлдөг хадгаламжийн даатгалын шимтгэлийг хассан) үйл ажиллагааны нийт орлогод (цэвэр хүүгийн орлого + хүүгийн бус цэвэр орлого) харьцуулан тооцсон.

### 4.2.2 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийн биелэлт

Үнэт цаас гаргагч нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хانган, хяналт тавин ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд буюу 2019-2022 онуудад авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үр ашигтай байдал болон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт эрс сайжирсан. Энэхүү Танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ Монголбанкны тогтоосон байвал зохих түвшнээс харьцангуй өндөр (1 дахин) түвшинд байгаа нь Үнэт цаас гаргагч цаашид өөрийн хөрөнгөөрөө активын өсөлтийг хангах бүрэн боломжтойг илтгэж байна.

Хүснэгт 35: МБ-с тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд

| Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа > 9%* | 16.9% | 17.4% | 20.1% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа > 12% | 17.4% | 17.4% | 20.1% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >25% | 54.9% | 44.3% | 41.1% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15% | -1.8% | -1.1% | 6.2% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-30% | -4.2% | -2.2% | 6.9% |
| Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа** <300% | 77.2% | 72.8% | 66.6% |
| Үндсэн хөрөнгө, хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө, борлуулах зориулалттай хөрөнгийн нийлбэр нийт хөрөнгийн харьцаа <8% | 2.5% | 1.7% | 1.7% |
| Том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын төвлөрлийн харьцаа <25% | 7.0% | 7.1% | 7.7% |

*2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ХасБанкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервалын шаардлага 3.5 нэгж хувь болсноор ХасБанкны Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа болон нөөц интервалын доод хэмжээ 12.5% байхаар тогтоосон болно. Монголбанкны журмын дагуу нөөц интервалын дээд хэмжээ нь 4 нэгж хувь хүртэл байх боломжтой байдаг.
**Өөрийн хөрөнгийн 5 хувиас дээш дүнтэй активын нийлбэрийг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа.

Мөн Банкны тухай хуульд заасны дагуу Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар хураангуйлан дараах хүснэгтээр харуулав.

СЭХ 2023.05.12 БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

Хүснэгт 36: Үнэт цаас гаргагчийн холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа үзүүлэлтүүд

| Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй): | | | |
| Банкны нийт хувьцаа эзэмшигчид | 0.0% | 0.0% | 0.0% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 0.2% | 0.1% | 0.1% |
| Банкны бусад холбогдох этгээд | 1.8% | 1.8% | 1.6% |
| Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй): | | | |
| Банкны нийт хувьцаа эзэмшигчид | 0.0% | 0.0% | 0.0% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 0.5% | 0.4% | 0.3% |
| Банкны бусад холбогдох этгээд | 3.6% | 4.5% | 3.8% |

### 4.2.3 Санхүүгийн үзүүлэлтүүд (өмнөх 5 жилийн)

Энэхүү бүлэгт агуулагдсан мэдээлэл нь ХасБанк болон түүний нэгж Хаслизинг (2021 оны 11 дүгээр сараас өмнө ТСН-ийн 100%-ийн охин компани байсан бөгөөд 2021 оны 11 дүгээр сард Үнэт цаас гаргагчийн шийдвэрээр Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн дагуу ХасБанканд нэгтгэсэн)-ийн санхүүгийн үзүүлэлтийг түүхэнд хугацаанд нөхөж нэгтгэсэн байдлаар толилуулж байгаа болно.

2021, 2022 онд нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бизнес, эдийн засагт олон төрлийн хүндрэлүүд үүсэж, иргэд болон ААН-үүдэд ихээхэн сорилтуудыг дагуулж байсан. Үнэт цаас гаргагч нь сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Банкны балансын бүтэц болон ашигт ажиллагааг сайжруулсан.

График 17: Өмнөх хугацааны ашигт ажиллагааны үзүүлэлт



2022 оны татварын дараах цэвэр ашиг 105.8 тэрбум төгрөгт хүрч, өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 27.6%-д хүрсэн нь түүхэн өндөр үзүүлэлт юм. Ийнхүү ашигт ажиллагаа сайжирсан нь актив пассивын оновчтой бүтцийг бий болгож, бизнесийн үр ашиг болон активын чанараа сайжруулсантай шууд холбоотой.

График 18: Цэвэр хүүгийн маржин болон актив, пассивын дундаж хүү




Цэвэр хүүгийн орлогоос гадна 2022 оны хувьд хүүгийн бус орлогын өсөлт ашигт ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлсэн. Үнэт цаас гаргагчийн хүүгийн бус орлогын дийлэнх хэсэг нь валют арилжааны орлого, картын төлбөр тооцоо, олон улсын төлбөр тооцоо, гадаад худалдааны төлбөр тооцоо болон баталгаа, батлан даалтын шимтгэл, хураамжийн орлогоос бүрддэг.

Валют арилжааны хувьд Үнэт цаас гаргагч нь аливаа спекуляци шинжтэй арилжаанд оролцдоггүй бөгөөд зөвхөн зохицуулагч байгууллагаас тогтоосон хязгаарын хүрээнд валютын позицоо үр дүнтэй, эрсдэл багатайгаар удирдах замаар орлогоо нэмэгдүүлж ажилладаг. 2022 оны тухайд дотоод, гадаад валютын зах ихээхэн хэлбэлзэлтэй, өндөр spread-тэй байсан нь тухайн онд ийнхүү валют арилжааны орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна.

График 19: Хүүгийн бус орлого




Мөн сүүлийн 5 жилд банкны картын төлбөр тооцооны дэд бүтцэд оруулсан хөрөнге оруулалт, ПОС терминалын өргөтгөл, АТМ-ийн тоо нэмэгдсэн зэргээс шалтгаалан картын цэвэр хураамж, шимтгэлийн дүн тогтвортой өсч байна.

СЗХ 2023.05.12 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь 2019-2021 онуудад эрсдэлийн удирдлагын бодлогын өөрчлөлтийн хүрээнд активын чанараа сайжруулан ажилласан нь 2021, 2022 онуудад зээлийн алдагдалтай холбоотой зардлыг (эрсдэлийн сангийн зардал болон бусад үнэт цэнийн бууралтын зардал) тогтвортой бага түвшинд удирдах нөхцөлийг бүрдүүллээ.

График 20: Зээл ба санхүүгийн түрээсийн багц, түүний чанар




*Эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцохдоо МБ-ны журам, шаардлагын дагуу байгуулсан ЗТУБАХСангийн дүнг чанаргүй зээл ба санхүүгийн түрээсийн үлдэгдэлд харьцуулж тооцсон.

Үнэт цаас гаргагчийн баримтлан ажиллаж буй зээлийн эрсдэлийн удирдлагын бодлогын хүрээнд зээлийн судалгааны стандарт, шаардлагыг өндөрт тавьж, аливаа эрсдэл өндөр эдийн засгийн салбар, сегментэд олгох зээлийн хэмжээнд тодорхой хязгаарлалтуудыг тогтоож (concentration and industry limit), чанаргүй зээлийг эрт илрүүлж, холбогдох эрсдэлийн санг хангалттай түвшинд (risk coverage) байгуулж ажилладаг.

График 21: Нийт актив, ӨБҮХХ, ӨБҮХХ-н эрсдэлийн сан




*ӨБҮХХ-д СТОУС-ийн дагуу дахин үнэлгээ хийдэг бөгөөд энэхүү графикт агуулсан мэдээлэл нь тус ӨБҮХХ-ийг тэнцэлд анх бүртгэсэн дүнгээр илэрхийлж харуулсан болно.
** Эрсдэлийн сангийн хүрэлцээний үзүүлэлтийг тооцохдоо МБ-ны журам, шаардлагын дагуу байгуулсан ӨБҮХХ-ийн эрсдэлийн сангийн дүнг ӨБҮХХ-ийн нийт үлдэгдэлд харьцуулж тооцсон.

Үнэт цаас гаргагч нь төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа тогтвортой өндөрт хангаж ажиллах зорилгоор хөрвөх чадвар өндөртэй активуудыг зохих түвшинд барин ажилладаг. 2017 оны 10-р сард дотоодын мөнгөний захын нэн чухал хэрэгсэл болох Засгийн Газрын Үнэт цаасны арилжаа согссон нь өдгөө арилжааны банкууд нь төгрөгийн илүүдэл эх үүсвэрийг зөвхөн Төвбанкны Үнэт цаас (ТБҮЦ)-т байршуулах нөхцөл байдлыг бий болгож байна. 2022 оны

эцсийн байдлаар Банкны эзэмшиж буй ТБҮЦ-ны хэмжээ 579.5 тэрбум төгрөг байгаа нь зах зээлд гаргасан нийт ТБҮЦ-ны 10% орчмыг эзэлж байна. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй ТБҮЦ-ны үлдэлдэл 2020 онд дундаж хэмжээнээс харьцангуй өндөр байсан нь тухайн онд зээлийн багцаа хумисан, мөн төгрөгийн хадгаламжийн эх үүсвэр нэмэгдсэнтэй холбоотой. Харин 2021 оны Ковид-19 цар тахлын дараах эдийн засгийн орчинд харилцагчиддаа шаардлагатай санхүүжилтийг олгож, зээлийн багцыг нэмэгдүүлсэнээр ТБҮЦ-ны хэмжээ буурсан болно. Өнөөгийн мөнгөний зах, банкны системийн нөхцөл байдалд ТБҮЦ нь арилжааны банкны хөрвөх чадварыг илтгэх нэн чухал үзүүлэлт гэдгийг энд дурдах нь зүйтэй.

График 22: Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт




## 4.3 Санхүүгийн төсөөлөл

**Хөрөнгө оруулагчдын анхааралд:** **Энэхүү дэд бүлэгт орсон мэдээлэл, таамаглал нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн олон нийтэд нээлттэй мэдээлэл, тоо баримт дээр үндэслэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуурх буюу гадаад орчны олон хүчин зүйлээс хамааран үр дүн, таамаглал, төсөөлөл нь өөрчлөгдөж болохыг анхаарна уу. Гадаад орчны хүчин зүйлсэд тухайлбал макро эдийн засаг болон улс төрийн орчин, дэлхийн зах зээлийн нөхцөл байдал, инфляц, валютын ханш, Ковид-19 цар тахлын үргэлжилсэн болон дам нөлөө, хөрөнгийн зах зээл, банкны салбарын орчин ба түүний өөрчлөлт зэргийг онцлон дурдаж болно. Түүнчлэн энэхүү хэсэгт агуулагдаж буй түүхэн тоо баримтаас бусад мэдээлэл нь ирээдүйн нөхцөл байдлын талаарх Үнэт цаас гаргагчийн гаргаж буй таамаглал бөгөөд ирээдүйн талаарх таамаглал нь олон төрлийн эрсдэлүүд, тодорхойгүй байдал болон бусад хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай байдаг. Улмаар Үнэт цаас гаргагчийн ирээдүйн бодит гүйцэтгэл, санхүүгийн үр дүнд шууд нөлөө үзүүлж, таамаглал, бодит гүйцэтгэл хоёрын дунд материаллаг зөрүү үүсгэх боломжтой. Мөн Украин болон ОХУ-ын хооронд үүсээд буй цэрэг дайны нөхцөл байдал урт хугацаанд үргэлжлэх, хурцдах тохиолдолд дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлж, цаашлаад Монгол Улсын эдийн засаг, банкны салбарт шууд болон шууд бусаар хохирол учруулж болохыг анхаарна уу. Үнэт цаасны танилцуулгыг боловсруулахдаа дээр дурдсан тодорхойгүй байдал болон гадаад орчны эрс тэс нөхцөл байдлыг тооцоололд оруулаагүй тул хөрөнгө оруулагч та хөрөнгө оруулалтын шийдвэрээ өөрийн бие даасан дүн шинжилгээнд үндэслэн гаргахыг зөвлөж байна.**

**Өнгөрсөн хугацааны санхүүгийн гүйцэтгэлийн тухайд:** Үнэт цаас гаргагчийн 2022 оны санхүүгийн үр дүн, ашигт ажиллагаа нь өмнөх 4 жилд хэрэгжүүлсэн стратеги, актив пассивын бүтцийг оновчтой, үр ашигтай болгоход чиглэсэн бодлогын арга хэмжээнүүдийн

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

үр дүн байсан болно. 2019 оноос Үнэт цаас гаргагч нь шинэ стратегийн дагуу дараах бодлогын өөрчлөлтүүдийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлсэн. Үүнд:

- Харилцагч болон сегментийн ашигт ажиллагааг эрсдэлд суурилсан өөрийн хөрөнгийн хүрэлцээний удирдлагатай уялдуулж, ашиг багатай, алдагдалтай балансын зүйл (актив, пассив аль аль нь)-ийг тодорхойлж, балансын оновчтой бүтцийг бий болгох шат дараалсан ажлуудыг хэрэгжүүлсэн. Үүний үр дүнд активын чанар сайжирч, зардал өндөртэй эх үүсвэрийн үлдэгдлийг бууруулсан.
- Зээлийн багцыг эрсдэл багатай сегмент, бүтээгдэхүүнд төвлөрүүлэх бодлого баримталсан. Ингэснээрээ зээлийн багцад эдийн засгийн мөчлөгөөс хамаарч чанаргүй зээл нэмэгдэх байдлыг сааруулж, зээлийн багцын төвлөрлийг улам саармагжуулсан.
- Мөн ирээдүйд эрсдэж болзошгүй томоохон дүнтэй зээлүүдийг урьдчилан илрүүлж, 2019-2021 онуудад тус зээлүүдийн үлдэгдлийг бууруулах, эрсдэлийн санг нэмэгдүүлэх бодлого баримтлан ажилласан.
- Актив пассивын удирдлагыг сайжруулах замаар гадаад валютын илүүдэл пассивыг бууруулсан. Олон улсын санхүүгийн байгууллагуудаас гадаад валютын эх үүсвэрийг зөвхөн Монголбанктай урт хугацаат своп хэлцэл хийх тохиолдолд татах, мөн өндөр хүүтэй гадаад эх үүсвэрүүдийг төлөх замаар пассивын бүтцийг сайжруулсан.
- Хадгаламж, зээлийн хүүг Банкны хөрвөх чадварын байдал, Монголбанкны бодлогын хүү болон эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан удирдсан.
- КОВИД-ын хуулийн дагуу харилцах, хугацаагүй хадгаламжид хүү төлөхгүй байх хуулийн зохицуулалт хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор 2021, 2022 онд эх үүсвэрийн зардал тодорхой хэмжээгээр хэмнэгдсэн бол нөгөө талдаа Засгийн Газраас хэрэгжүүлсэн “Эрүүл мэндээ хамгаалж, эдийн засгаа сэргээх” хөтөлбөр болон зохицуулагч байгууллагаас авч хэрэгжүүлсэн бусад арга хэмжээнүүдийн үр дүнд балансад хүүгүй болон бага хүүтэй актив, пассив (засгийн газраас олгох хүүгийн татаас орсон дүнгээр жилийн ~10%-ийн хүүтэй зээл болон ЗГ-ийн ипотекийн зээлийн хүүг царцаасан гэх мэт) үүссэн нь цэвэр дүнгээрээ ашигт ажиллагаанд материаллаг нөлөө үзүүлээгүй байна. Өөрөөр хэлбэл Ковид-19 цар тахлын үед Засгийн газар болон зохицуулагч байгууллагаас авч хэрэгжүүлсэн арга хэмжээнүүд Үнэт цаас гаргагчийн хүүгийн орлого, зардалд ойролцоо дүнгээр нөлөө үзүүлсэн.
- Зардлын үр ашгийг нэмэгдүүлж, үйл ажиллагааны зардлыг тогтмол зардал болон гүйцэтгэлд суурилсан хувьсах зардлын бүтэцтэй байхаар өөрчилсөн.
- Мөн мэдээлэл технологи, түүний дэд бүтцэд хөрөнгө оруулалтууд хийж, шинэ технологи нэвтрүүлэх замаар Банкны үйл ажиллагаа, үйлчилгээ, зээлийн процессыг хялбаршуулах ажлуудыг хэрэгжүүлж байна.

**Ирээдүйн санхүүгийн төсөөллийн тухайд:** Үнэт цаас гаргагч нь дээр дурдсан стратеги болон бодлогын арга хэмжээнүүдийг цаашид тууштай үргэлжлүүлэх төлөвлөгөөтэй байна. Харин Үнэт цаас гаргагчийн өөрийн хяналтаас гадуурх макро эдийн засгийн болон зах зээлийн орчинтой холбоотой дараах урьдач нөхцөлийг санхүүгийн төсөөлөлдөө ашигласан болно:

- ДНБ-ний жилийн бодит өсөлт 4%-6% хооронд байхаар төсөөлөв. Үүнд, Оюу Толгойн далд уурхайн олборлолт хийж эхлэх хугацааг 2023 онд байхаар тооцсон. Мөн манай орны улс төрийн тогтвортой байдал нь эдийн засгийн өсөлтөд ихээхэн нөлөө үзүүлдэг бөгөөд энэ талаар санхүүгийн төсөөлөлд тогтвортой байхаар тооцсон.

ХАСБАНК
УХН4937 2578697

- Банкны системийн зээлийн багц 2018-2022 онуудад 28%-иар өссөн байна. Үнэт цаас гаргагчийн тооцож байгаагаар ирэх 5 жилд эдийн засгийн өсөлт болоод инфляцын түвшнөөс хамаараад банкны системийн зээлийн багц жилд 12%-15% өсөх боломжтой гэж харж байна.
- Харин Үнэт цаас гаргагчийн хувьд зээлийн багцыг жилд 20%-25% өсгөхөөр санхүүгийн төлөвлөлд тусгасан. Энэхүү өсөлт нь Үнэт цаас гаргагчийн өмнөх хугацааны гүйцэтгэлд үндэслэсэн байхаас гадна энэхүү Танилцуулга бэлдэх үеийн байдлаар зээлийн багцын өсөлтийг хангахад шаардлагатай өөрийн хөрөнгийн хүрэлцээ (нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө 2022 оны эцсийн байдлаар 20.1%) болон шинээр татан төвлөрүүлэхээр тооцсон эх үүсвэрийн боломжид үндэслэн тооцсон болно. Мөн Үнэт цаас гаргагчийн зээлийн багц 2018 онд 39.3%, 2021 онд 26.2% тус тус өсч байсныг дурдах нь зүйтэй юм.
- Зээлийн багцын өсөлтийг хангахын тулд Үнэт цаас гаргагч нь харилцах, хадгаламжийн үлдэгдлийг жилд 13%-15% өсгөхөөр тооцсон. 2020, 2021 онуудад Монголбанкны бодлогын хүү буурсантай зэрэгцээд банкны системд хадгаламжийн хүү буурч, энэ нь хөрөнгийн зах идэвхжих шалтгаан болж, иргэдийн дунд хувьцааны хөрөнгө оруулалт хийх хандлага нэмэгдсэн. Харин 2022 оны хувьд бодлогын хүү 6%-с өсөж 13%-д хүрсэн нь банкны системд эх үүсвэрийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна. Цаашид эдийн засгийн тогтвортой өсөлт хангагдах нөхцөлд түүнийг дагаад иргэдийн хуримтлал өсөх боломжтой гэж тооцож байна.
- Үнэт цаас гаргагчийн хувьд нэг чухал давуу тал нь олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас урт хугацаатай эх үүсвэр татах боломжтой явдал юм. Тухайлбал 2022 онд 200 гаруй сая ам.долларын урт хугацаатай эх үүсвэр татах хэлцэл хийж, нийт гадаад эх үүсвэрийн боломжит хэмжээг 337 сая ам.долларт хүргээд байна. Мөн ирэх 5 жил нийт гадаад эх үүсвэрийн хэмжээг 660 сая ам.долларт хүргэхээр төлөвлөж байна. Ийнхүү гадаад эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх нь Банкны эх үүсвэрийн бүтцийг хүү, хугацаа болоод хэмжээний хувьд оновчтой удирдах нөхцөлийг бүрдүүлдэгээс гадна харилцагчдынхаа урт хугацаатай зээлийн санхүүжилтийн хэрэгцээг хангах боломжийг нэмэгдүүлдэг. Санхүүгийн төсөөлөлд олон улсын санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлэх ам.долларын урт хугацаатай бүх эх үүсвэрийг Монголбанкны холбогдох журмын дагуу своп хэлцэл хийж төгрөгт хөрвүүлэхээр тооцсон болно.

Дээр дурдсан урьдач нөхцөл, таамаглалд үндэслэн 2023-2027 онуудын орлого үр дүнгийн тайлангийн төсөөллийг дараах байдлаар харуулав (нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргасны дараа татан төвлөрүүлэх хөрөнгийг оруулахаас өмнөх үеийн байдлаар):

Хүснэгт 37: Орлогын тайлангийн төсөөлөл

| Сая төгрөгөөр | 2022 гүйцэтгэл | 2023 төсөөлөл | 2024 төсөөлөл | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2027 төсөөлөл |
|---|---|---|---|---|---|---|
| Хүү орлого | 373,350 | 498,167 | 566,613 | 657,658 | 780,507 | 920,317 |
| Хүү зардал | (155,015) | (267,133) | (299,807) | (354,592) | (422,180) | (510,450) |
| **Цэвэр хүүгийн орлого** | **218,335** | **231,034** | **266,806** | **303,065** | **358,327** | **409,867** |
| Шимтгэл, хураамжийн орлого | 30,201 | 39,480 | 46,392 | 53,294 | 61,148 | 69,676 |
| Шимтгэл, хураамжийн зардал | (11,289) | (12,791) | (14,555) | (16,583) | (18,916) | (21,599) |
| Валют арилжаа, ханшийн тэгшитгэлийн цэвэр орлого | 19,613 | 14,400 | 14,400 | 16,560 | 19,044 | 21,901 |
| Хандивын орлого | 1,507 | 1,800 | 1,200 | 1,200 | 1,200 | 1,200 |
| Бусад орлого | 2,782 | 1,440 | 1,440 | 1,440 | 1,440 | 1,440 |
| **Хүүгийн бус цэвэр орлого** | **42,813** | **44,329** | **48,877** | **55,911** | **63,916** | **72,617** |
| **Үйл ажиллагааны нийт орлого** | **261,148** | **275,364** | **315,684** | **358,976** | **422,243** | **482,484** |
| Эрсдэлийн сангийн зардал | (9,476) | (5,880) | (10,900) | (13,320) | (17,520) | (24,000) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **251,671** | **269,484** | **304,784** | **345,656** | **404,723** | **458,484** |
| **Үйл ажиллагааны зардал** | **(104,982)** | **(107,503)** | **(116,569)** | **(126,684)** | **(138,896)** | **(154,606)** |
| Хүний нөөцийн зардал | (66,267) | (65,034) | (70,003) | (75,610) | (81,844) | (90,824) |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Үйл ажиллагааны бусад зардал | (38,715) | (42,469) | (46,567) | (51,074) | (57,053) | (63,782) |
| **Татварын өмнөх ашиг** | **146,689** | **161,981** | **188,215** | **218,972** | **265,827** | **303,879** |
| Татварын зардал | (40,851) | (39,222) | (46,329) | (54,023) | (65,737) | (75,250) |
| **Татварын дараах цэвэр ашиг** | **105,839** | **122,759** | **141,886** | **164,949** | **200,090** | **228,629** |

## 2023-2027 оны санхүүгийн төсөөллийн харьцаа үзүүлэлтүүд (нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргасны дараа татан төвлөрүүлэх хөрөнгийг оруулахаас өмнөх үеийн байдлаар):

Хүснэгт 38: Санхүүгийн төсөөллийн харьцаа үзүүлэлтүүд

| % | 2022 гүйцэтгэл | 2023 төсөөлөл | 2024 төсөөлөл | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2027 төсөөлөл |
|---|---|---|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт | 20.1% | 19.4% | 20.8% | 20.8% | 21.0% | 20.9% |
| Нийт өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт | 20.1% | 19.4% | 20.8% | 20.8% | 21.0% | 20.9% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) | 27.6% | 25.8% | 25.0% | 24.5% | 25.1% | 24.2% |
| Активын өгөөж (ROA) | 2.6% | 3.1% | 3.1% | 3.0% | 3.0% | 2.8% |
| Цэвэр хүүний маржин | 7.8% | 7.0% | 6.9% | 6.5% | 6.3% | 6.0% |
| Үйл ажиллагааны зардал, орлогын харьцаа | 39.9% | 38.6% | 36.7% | 35.1% | 32.7% | 31.9% |
| Чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа | 4.0% | 3.5% | 3.3% | 3.2% | 3.1% | 3.1% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 41.1% | 32.7% | 34.9% | 32.9% | 33.0% | 32.2% |

## 2023-2027 оны санхүүгийн байдлын тайлангийн төсөөллийг дараах байдлаар (нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргасны дараа татан төвлөрүүлэх хөрөнгийг оруулахаас өмнөх үеийн байдлаар):

Хүснэгт 39: Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

| *Сая төгрөгөөр* | 2022 гүйцэтгэл | 2023 төсөөлөл | 2024 төсөөлөл | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2027 төсөөлөл |
|---|---|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (цэвэр)** | **676,222** | **414,479** | **637,838** | **723,578** | **834,538** | **943,736** |
| Бэлэн мөнгө | 100,775 | 40,000 | 40,000 | 40,000 | 40,000 | 40,000 |
| МБ-д байршуулсан бэлэн мөнгө | 481,591 | 283,352 | 501,072 | 580,826 | 685,430 | 787,879 |
| Гадаадын банканд байршуулсан бэлэн мөнгө | 85,192 | 91,426 | 97,065 | 103,052 | 109,408 | 116,156 |
| Дотоодын банканд байршуулсан бэлэн мөнгө | 9,069 | - | - | - | - | - |
| Үнэ цэнийн бууралт | (404) | (300) | (300) | (300) | (300) | (300) |
| **Хөрөнгө оруулалт, хадгаламж (цэвэр)** | **973,320** | **1,010,030** | **1,126,560** | **1,192,132** | **1,476,431** | **1,774,337** |
| МБ-д байршуулсан хөрөнгө | 242,784 | 146,282 | 155,305 | 164,883 | 175,053 | 185,850 |
| Бусад банканд байршуулсан хөрөнгө | 49,950 | 20,000 | - | - | - | - |
| ТБҮЦаас | 579,500 | 738,730 | 855,924 | 899,850 | 1,160,910 | 1,433,238 |
| ЗГҮЦаас | - | - | - | - | - | - |
| ИЗБҮЦаас | 73,418 | 82,729 | 93,221 | 105,043 | 118,366 | 133,377 |
| Бусад Үнэт цаас | 24,945 | 24,945 | 24,945 | 24,945 | 24,945 | 24,945 |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 9,291 | 3,430 | 3,545 | 3,900 | 4,299 | 4,750 |
| Үнэт цаасны хямдруулалт | (2,329) | (1,847) | (2,140) | (2,250) | (2,902) | (3,583) |
| Үнэ цэнийн бууралт | (4,240) | (4,240) | (4,240) | (4,240) | (4,240) | (4,240) |
| **Зээл ба урьдчилгаа (цэвэр)** | **2,002,758** | **2,510,483** | **3,026,503** | **3,644,938** | **4,392,779** | **5,301,127** |
| Нийт зээл ба санхүүгийн түрээс | 2,054,086 | 2,563,476 | 3,085,563 | 3,712,018 | 4,471,574 | 5,397,547 |
| Чанаргүй зээл ба санхүүгийн түрээс | 81,607 | 90,242 | 102,993 | 118,724 | 138,958 | 165,349 |
| СТОУС-р тооцсон үнэ цэнийн бууралт | (76,047) | (80,847) | (90,447) | (102,447) | (118,647) | (141,327) |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 31,512 | 35,508 | 40,011 | 45,086 | 50,804 | 57,247 |
| Хойшлогдсон зээлийн шимтгэл | (6,793) | (7,654) | (8,625) | (9,719) | (10,952) | (12,341) |
| **ӨБҮХХ (цэвэр)** | **35,217** | **13,104** | **3,120** | **2,760** | **2,400** | **2,040** |
| Бусад хөрөнгө оруулалт | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 |
| Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө (цэвэр) | 80,823 | 86,460 | 91,820 | 96,876 | 101,431 | 105,409 |
| Дериватив санхүүгийн хөрөнгө | 107,799 | 104,446 | 95,639 | 105,617 | 217,385 | 392,252 |
| Бусад | 49,959 | 38,432 | 41,350 | 45,179 | 50,193 | 56,747 |
| **НИЙТ АКТИВ** | **3,930,780** | **4,182,117** | **5,027,512** | **5,815,762** | **7,079,839** | **8,580,329** |

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

| Сая төгрөгөөр | 2022* гүйцэтгэл | 2023 төсөөлөл | 2024 төсөөлөл | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2027 төсөөлөл |
|---|---|---|---|---|---|---|
| **Харилцах, хадгаламж** | **2,425,855** | **2,444,295** | **2,760,627** | **3,150,669** | **3,615,573** | **4,080,478** |
| Харилцах | 638,708 | 520,000 | 608,000 | 696,000 | 820,000 | 944,000 |
| Хугацаагүй хадгаламж | 142,278 | 175,000 | 200,000 | 227,500 | 265,000 | 302,500 |
| Хугацаатай хадгаламж | 1,635,464 | 1,739,545 | 1,941,629 | 2,214,570 | 2,516,100 | 2,817,630 |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 9,406 | 9,751 | 10,998 | 12,598 | 14,473 | 16,348 |
| **Бусдаас авсан эх үүсвэр** | **907,593** | **1,069,760** | **1,481,018** | **1,741,069** | **2,388,251** | **3,232,546** |
| Төслийн эх үүсвэрүүд | 134,949 | 129,917 | 137,930 | 146,438 | 155,469 | 165,058 |
| Банк хоорондын эх үүсвэр | 51,857 | - | - | - | - | - |
| Репо | - | - | - | - | - | - |
| Гадаад эх үүсвэр | 720,257 | 939,245 | 1,342,414 | 1,593,873 | 2,231,927 | 3,066,524 |
| Хоёрдогч өглөг | - | - | - | - | - | - |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 7,430 | 8,373 | 9,434 | 10,631 | 11,979 | 13,498 |
| Хойшлогдсон эх үүсвэрийн шимтгэл | (6,900) | (7,775) | (8,761) | (9,872) | (11,124) | (12,535) |
| Бусад эх үүсвэр | 13,128 | 14,385 | 16,210 | 18,265 | 20,582 | 23,192 |
| Болзошгүй үүргийн эрсдэлийн сан | 221 | 249 | 280 | 316 | 356 | 401 |
| Дериватив санхүүгийн өр төлбөр | 1,640 | - | - | - | - | - |
| Бусад пассив | 106,656 | 84,980 | 95,872 | 109,554 | 108,583 | 128,616 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,455,093** | **3,613,670** | **4,354,007** | **5,019,874** | **6,133,346** | **7,465,233** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 |
| Эрсдэлийн сангийн нөөц | 62,820 | 53,129 | 19,021 | 21,328 | 19,018 | 11,197 |
| Нөөцийн сан | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 |
| Бусад | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 |
| Тухайн оны ашиг | 105,839 | 122,759 | 141,886 | 164,949 | 200,090 | 228,629 |
| Өмнөх онуудын хуримтлагдсан ашиг | 187,323 | 287,853 | 414,720 | 517,472 | 642,165 | 800,591 |
| Ногдол ашиг | (15,000) | (30,000) | (36,828) | (42,566) | (49,485) | (60,027) |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | **475,688** | **568,447** | **673,505** | **795,888** | **946,494** | **1,115,096** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **3,930,780** | **4,182,117** | **5,027,512** | **5,815,762** | **7,079,839** | **8,580,329** |

*2022 оны санхүүгийн гүйцэтгэл баганад толилуулсан мэдээлэл, санхүүгийн зүйлүүд нь удирдлагын мэдээлэл, тайлагналын зорилгоор толилуулсан бөгөөд зарим мэдээллийн хувьд аудитлагдсан санхүүгийн тайлангийн ангилал, зүйлээс зөрүүтэй болно.

Санхүүгийн төсөөллийн зорилгоор 2023-2027 онуудад тогтвортой ногдол ашиг хуваарилахаар тооцсон хэдий ч компанийн дүрэм, ногдол ашгийн бодлогын дагуу ногдол ашиг хуваарилах эсэх асуудал нь Хувьцаа Эзэмшигчдийн эрхлэх асуудал бөгөөд Монголбанкнаас холбогдох зөвшөөрөл авсны үндсэн дээр хэрэгжих боломжтой байдаг. Ногдол ашгийн бодлогыг Үнэт цаасны танилцуулгын Хавсралт 2-оос үзнэ үү.

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

# Тав. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮНЭЛГЭЭ

**Хөрөнгө оруулагчдын анхааралд: Энэхүү дэд бүлэгт орсон мэдээлэл, таамаглал нь Үнэт цаасны танилцуулга бэлтгэх үеийн олон нийтэд нээлттэй мэдээлэл, тоо баримт дээр үндэслэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуурх буюу гадаад орчны олон хүчин зүйлээс хамааран үр дүн, таамаглал, төсөөлөл нь өөрчлөгдөж болохыг анхаарна уу. Гадаад орчны хүчин зүйлсэд тухайлбал макро эдийн засаг болон улс төрийн орчин, дэлхийн зах зээлийн нөхцөл байдал, инфляц, валютын ханш, Ковид-19 цар тахлын үргэлжилсэн болон дам нөлөө, хөрөнгийн зах зээл, банкны салбарын орчин ба түүний өөрчлөлт зэргийг онцлон дурдаж болно. Түүнчлэн энэхүү хэсэгт агуулагдаж буй түүхэн тоо баримтаас бусад мэдээлэл нь ирээдүйн нөхцөл байдлын талаарх Үнэт цаас гаргагчийн гаргаж буй таамаглал бөгөөд ирээдүйн талаарх таамаглал нь олон төрлийн эрсдэлүүд, тодорхойгүй байдал болон бусад хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай байдаг. Улмаар Үнэт цаас гаргагчийн ирээдүйн бодит гүйцэтгэл, санхүүгийн үр дүнд шууд нөлөө үзүүлж, таамаглал, бодит гүйцэтгэл хоёрын дунд материаллаг зөрүү үүсгэх боломжтой. Мөн Украин болон ОХУ-ын хооронд үүсээд буй цэрэг дайны нөхцөл байдал урт хугацаанд үргэлжлэх, хурцдах тохиолдолд дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлж, цаашлаад Монгол Улсын эдийн засаг, банкны салбарт шууд болон шууд бусаар хохирол учруулж болохыг анхаарна уу. Үнэт цаасны танилцуулгыг боловсруулахдаа дээр дурдсан тодорхойгүй байдал болон гадаад орчны эрс тэс нөхцөл байдлыг тооцоололд оруулаагүй тул хөрөнгө оруулагч та хөрөнгө оруулалтын шийдвэрээ өөрийн бие даасан дүн шинжилгээнд үндэслэн гаргахыг зөвлөж байна.**

## 5.1 Үнэлгээний аргачлалууд

БДО Аудит ХХК нь СЗХ-ноос бизнесийн үнэлгээ хийх зөвшөөрөл авсан бие даасан үнэлгээний байгууллага юм.

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үнэлгээний дүгнэлт гаргахдаа орлогын хандлагын нэг арга болох "Үлдэгдэл Ашгийн" загварыг (Residual Income Model) ашигласан болно. Үнэлгээний компани нь ногдол ашгийг хорогдуулах загвар болон зах зээлийн харьцуулалтын аргыг ашиглан үнэлгээний үр дүнг давхар баталгаажуулсан байна.

- Үнэлгээний олон улсын стандартын (ҮОУС) 105 буюу Үнэлгээний хандлагууд ба аргуудын 40.2 эсхүл 40.3 дугаар догол мөрд заасан шалгуурыг хангасан тохиолдолд бизнесийн үнэлгээнд орлогын хандлагыг ихэвчлэн ашигладаг. Мөн Үнэт цаас гаргагч нь ойрын ирээдүйд (санхүүгийн төсөөллийн хүрээнд) бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй, хэвийн үргэлжлүүлнэ гэсэн урьдач нөхцөлд уг бизнесийн бий болгож чадах эдийн засгийн өгөөж буюу мөнгөн урсгалд үндэслэн бизнесийн үнэлгээнд Хорогдуулсан Мөнгөн Урсгал (Discounted Cashflow Model)-ын загварыг ашиглах боломжтой.
- ҮОУС 105 буюу Үнэлгээний хандлага ба аргуудын 20.2 эсвэл 20.3 дугаар догол мөрд заасан шалгуурыг хангасан тохиолдолд бизнесийн үнэлгээнд зах зээлийн хандлагын аргыг ашиглах нь тохиромжтой байдаг. Зах зээлийн арга нь ижил төстэй эсвэл харьцуулах боломжтой бизнес, хувьцааны зах зээлийн мэдээлэлд тулгуурладаг учир тухайн бизнесийн үнэлгээний талаар илүү бодит дүгнэлт гаргах боломжийг олгодог. БДО нь өөрсдийн дотоод мэдээллийн сан, Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй арилжааны банкнууд болон PitchBook Data, S&P Capital IQ зэрэг албан ёсны мэдээллийн эх сурвалжийг ашиглан энэхүү бизнесийн үнэлгээнд Зах зээлийн харьцуулалтын аргаар үнэлгээг давхар баталгаажуулсан болно.

СЗХ
2023 05. 12
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

Дараах ерөнхий болон тусгайлсан урьдач нөхцөл, төсөөлөлд үндэслэн Үнэт цаас гаргагчийн эздийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолсон болно. Дор дурдсан үнэлгээний урьдач нөхцөл, төсөөллүүд нь Үнэлгээний өдрийн байдлаарх бодит байдалтай нийцэж байна гэж үзсэн болно. Үүнд:

- Үнэт цаас гаргагч нь дунд хугацаанд өөрийн бизнесийг тасралтгүйгээр үргэлжлүүлнэ.
- Үнэт цаас гаргагчийн тасралтгүй ажиллагаа эсвэл бизнесийн үндсэн чиглэлд ирээдүйн урьдчилан харах боломжтой хугацаанд мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй.
- Үнэт цаас гаргагчаас тооцоолсон санхүүгийн төсөөлөл нь Үнэт цаас гаргагчийн болон арилжааны банкны салбарын түүхэн хандлагад суурилсан. Бизнес төлөвлөгөөнд багтсан мэдээллийн агуулга, тооцоолол нь үнэн зөв, бодитой байна гэж төсөөлсөн.
- Дунд хугацааны санхүүгийн төсөөлөл (2023-2027)-д багтсан аливаа тооцоолол нь Банкны бизнесийн нөөц, боломжийг хамгийн сайн ашиглана гэдэгт үндэслэсэн. Тус санхүүгийн төсөөлөлд байгууллагын нөөц ашиглалтыг боломжит хамгийн дээд түвшинд байхаар тооцсон бөгөөд эдгээр тооцоолол нь удирдлагын хамгийн сайн мэдлэг, туршлага дээр үндэслэн бэлтгэгдсэн гэж төсөөлсөн.
- Хөдөлмөрийн орц, ажиллах хүчний сургалт, ажил олгогчоос ажилтанд олгох зардалд огцом өөрчлөлт гарахгүй. Мөн түүнчлэн ажиллах хүчний мэргэжлийн ур чадварын дутагдал, мэргэжлийн ёс зүйн доголдлоос үүсэх аливаа зарга, маргаан үүсэхгүй.
- Засгийн газрын бодлого, зохицуулалтын гэнэтийн өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа болон үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд мэдэгдэхүйц сөргөөр нөлөөлөхгүй.
- Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа нь Монгол Улсын татварын хууль тогтоомжийн дагуу зохицуулалттай байна.
- Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулаагүй хөрөнгө, өр төлбөр эсвэл хэвийн бус үүрэг хариуцлага, үнэлгээний өдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй шүүхийн томоохон зарга маргаан зэрэг үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөөтэй аливаа болзошгүй зүйл байхгүй.
- Үнэт цаас гаргагчийн бизнесийн салбарт мэдэгдэхүйц нөлөөлөх байгалийн гамшиг, цаг уурын таагүй нөхцөл ирээдүйн урьдчилан харах боломжтой хугацааны туршид үүсэхгүй. Үнэлгээний өдрийн байдлаар Ковид-19 цар тахлыг цаашид БДО Монгол Үнэт цаас гаргагчийн удирдлагын багийн зүгээс таамаглаж байгаагаас өөр байдлаар үргэлжлэхгүй гэж үзэн дунд хугацааны санхүүгийн төсөөлөлд тусгасан болно.

Үнэлгээний урьдач нөхцөл, төсөөлөл гаргахад үнэлгээний өдрөөрх бодит байдлаас ялгаатай байх тохиолдолд үүнийг “тусгай төсөөлөл” гэж ҮОУС-ын 104 дүгээр зүйлийн 200.4 дэх хэсэгт заасан. БДО энэхүү үнэлгээний тайланд дараах тусгай таамаглалуудыг хүлээн зөвшөөрсөн болно. Үүнд:

- Инфляц өндөр байгаа өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан, үнэлгээний тооцоололд Үнэлгээний өдрийн байдлаарх түүхэн инфляцын түвшинг ашиглахын оронд ОУВС-аас гаргасан Монгол Улс болон АНУ-ын инфляцын 2027 оны эцсийн төсөөллийг ашигласан.
- Үнэт цаас гаргагчийн ирээдүйн ногдол ашгийг санхүүгийн төсөөлөлд байгаа хэмжээгээр тооцсон.

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Дээрх урьдач нөхцөлийн хүрээнд BDO-с 20.3%-ийн хорогдуулалтын хувийг ашиглан Үнэт цаас гаргагчийн 2023-2027 оны санхүүгийн төсөөлөлд үндэслэн IPO хийхээс өмнөх үеийн байдлаар Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон нийт эздийн өмчийн зах зээлийн суурь үнэ цэн нь 676,950 сая төгрөг буюу нэгж хувьцааны үнэлгээ нь 677 төгрөг гэж тооцоолсон.

Үнэлгээний байгууллага нь дэлхийн эдийн засгийн тодорхойгүй байдал, Ковид-19 цар тахлын үргэлжилсэн дам нөлөө, Монгол Улсын инфляц болон төлбөрийн тэнцлийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлийн тогтворгүй байдлыг харгалзан үнэлгээний дээд болон доод интервалыг мөн тооцсон. БДО-ийн дүгнэлтийг дараах байдлаар хураангуй харуулав. Үнэлгээний дэлгэрэнгүй тайланг энэхүү Үнэт цаасны танилцуулгын Хавсралт 5-с үзнэ үү.

График 23:Бизнесийн үнэлгээний хураангуй




Эх сурвалж: ХасБанкны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Өмчийн Үнэлгээний Тайлан, БДО Аудит ХХК

СЗХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭЭ-02

# Зургаа. ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

## 6.1 Үнэт цаас гаргах тухай

2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан "Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль" болон "Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль"-ийн дагуу ХасБанк нь 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор олон нийтэд нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэйгээр өөрчлөн зохион байгуулагдах шаардлагатай болсон.

Үнэт цаас гаргагч нь Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх тухай журмын 4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5, 61.1.7 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1, 62.1.2, 62.1.4 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 10 болон 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, Үнэт цаас гаргагчийн толгой компани болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, Үнэт цаас гаргагчийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1, 8.5.1 (ii), 8.5.1 (vi) болон 8.5.1 (viii) дахь заалт, Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн нийт хувьцааны 5.0062% (хувь) буюу 52,700,000 ширхэг хувьцааг нэмж гарган Монголын Хөрөнгийн Биржээр анх удаа нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн.

Хүснэгт 40: Үнэт цаасны мэдээлэл

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | ХасБанк ХХК |
| Бүртгэл | Монголын Хөрөнгийн Бирж |
| Самбар/Ангилал | I ангилал |
| Гаргасан хувьцааны тоо ширхэг | 1,000,000,000 ширхэг |
| Нэрлэсэн үнэ | 100 төгрөг |
| Нэмж гаргах хувьцааны тоо ширхэг | 52,700,000 ширхэг |
| Нэмж гаргах хувь | 5.0062% |
| ▪ Стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилах хэмжээ | 70% буюу 36,890,000 ширхэг хувьцааг энэхүү Танилцуулгын 6.5 дахь хэсэгт заасны дагуу хуваарилах |
| ▪ Олон нийтэд хуваарилах хэмжээ | 30% буюу 15,810,000 ширхэг хувьцааг энэхүү Танилцуулгын 6.5 дахь хэсэгт заасны дагуу хуваарилах |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Нийтэд санал болгох үнэ | 677 төгрөг |
| Нийтэд санал болгосны дараах хувьцааны тоо ширхэг | 1,052,700,000 ширхэг хувьцаа |
| Нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн хэмжээ | 35,677,900,000 төгрөг |
| Арилжааны арга хэлбэр | Тогтоосон үнийн арга |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт | Үйл ажиллагаагаа өргөжүүлж, зээлийн болон санхүүгийн түрээсийн багцын өсөлтийг хангах |
| Андеррайтерууд | Райнос Инвестмент ҮЦК ХХК (Үндсэн)<br>Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК (Туслах) |

СЗХ
2023 .05 . 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

Хувьцаа нэмж гаргасны дараа Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшлийн бүтэц дараах байдалтай болно.

Хүснэгт 41: IPO хийхийн өмнөх болон дараах хувьцаа эзэмшлийн бүтэц

| IPO-ийн өмнөх байдлаар | | | IPO-ийн дараах байдлаар | | |
|---|---|---|---|---|---|
| Банкны хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо ширхэг | % | Банкны хувьцаа эзэмшигчид | Хувьцааны тоо ширхэг | % |
| Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК | 1,000,000,000 | 100.00% | Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК | 1,000,000,000 | 94.99% |
| - | - | - | Олон нийт | 52,700,000 | 5.01% |
| **Нийт** | **1,000,000,000** | **100.00%** | **Нийт** | **1,052,700,000** | **100.00%** |

## 6.2 Нийтэд санал болгох үнэ тогтоосон үндэслэл

БДО Аудит ХХК нь үнэт цаасны зах зээлд оролцогч этгээдэд үйлчилгээ үзүүлэх эрх бүхий байгууллага бөгөөд Үнэт цаас гаргагчтай аливаа харилцан, хамааралгүй хуулийн этгээд болно. БДО Аудит ХХК нь Үнэт цаас гаргагчийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар тасалбар болгосон аудитлагдсан санхүүгийн үр дүн болон Үнэт цаас гаргагчаас бэлтгэсэн дунд хугацааны санхүүгийн төсөөлөлд үндэслэн бизнесийн үнэлгээг хийж гүйцэтгэсэн бөгөөд бизнесийн үнэлгээний тайланг энэхүү Танилцуулгад хавсаргасан болно.

Үнэлгээний байгууллага нь Үнэт цаас гаргагчийн хувьцааг нийтэд санал болгон анх удаа гаргах (IPO) үйл ажиллагаанд зориулж 100%-ийн бизнес өмчлөлийн зах зээлийн үнэлгээг ҮОУС болон Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжийн дагуу Орлогын хандлагыг сонгон авч үнэлсэн бөгөөд үнэлгээний үр дүнг баталгаажуулах зорилгоор ногдол ашиг хорогдуулах загвар болон зах зээлийн харьцуулалтын аргыг давхар ашигласан.

СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдрийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 9 дүгээр зүйлийн 9.1.1 дэх хэсэгт заасны дагуу “Үнэт цаас гаргагч нь андеррайтерийн хамтаар үнэлгээчнээс ирүүлсэн үнэлгээний үр дүнд үндэслэн анхдагч зах зээлд санал болгох үнийг тогтоох эрхтэй” байдаг.

Үнэт цаас гаргагч нь хувьцаагаа олон нийтэд санал болгох үнийг тогтоохдоо хөрөнгийн зах зээлийн багтаамж, түүний хөрвөх чадвар, Үнэт Цаас гаргагчийн ирээдүйн өсөлтийн төсөөлөл, түүнчлэн нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах ажиллагаанд олон нийт хэрхэн оролцох тандалт болон бусад хүчин зүйлсийг харгалзан үзсэн болно. Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн R-2023-20 тогтоол, Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн SR-2023-06 тогтоолын дагуу Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан олон нийтэд санал болгох Үнэт цаас гаргагчийн нэгж хувьцааны үнийг 677 төгрөг 00 мөнгө байхаар шийдвэрлэсэн болно.

## 6.3 Хувьцааг олон нийтэд санал болгох төлөвлөгөө

СЗХ-ны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр баталсан Үнэт цаасны бүртгэлийн журам (цаашид “СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журам” гэх)-ын 3 дугаар зүйлийн 3.3 дахь хэсэгт заасны дагуу СЗХ-ны шийдвэр гарсаны дараа Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь хамтран хувьцааг анхдагч зах зээлд санал болгох хугацааг (цаашид "Санал болгох хугацаа" гэх) тодорхойлж, энэ талаар мэдээллийг олон нийтэд нээлттэй хүргүүлнэ.

Нийтэд санал болгох хувьцааг анхдагч зах зээлд дараах хуваарийн дагуу байршуулна.

I. **Үнэт цаасыг бүртгүүлж, холбогдох зөвшөөрөл авах**

СЗХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгох Үнэт цаасыг бүртгэлд бүртгүүлэх хүсэлтийг СЗХ болон МХБ-д гаргах бөгөөд эдгээр эрх бүхий байгууллагуудаас Үнэт цаасыг бүртгэхийг зөвшөөрснөөр Үнэт цаасыг нийтэд санал болгон арилжаалах боломжтой болно.

**II. Нийтэд танилцуулах**

Үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгох, арилжаалах зөвшөөрөл гарсны дараа Үнэт цаасыг нийтэд санал болгон танилцуулах аяныг зохион байгуулна. Үүнд хөрөнгийн зах зээлийн мэргэжлийн оролцогч, олон нийт болон стратегийн хөрөнгө оруулагчдад зориулсан танилцуулга уулзалт болон олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр Үнэт цаасыг танилцуулах мэдээ мэдээлэл зэрэг нь багтана.

**III. Анхдагч зах зээлийн арилжааны захиалга хүлээн авах**

Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн нийтэд анх удаа санал болгож буй хувьцааг анхдагч зах зээлд байршуулахдаа СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.2-т “Андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн Хороонд бүртгэгдсэн Үнэт цаасны танилцуулгад заасан арга хэлбэрээр нийтэд санал болгон гаргах хувьцааг анхдагч зах зээлд байршуулж, худалдана” хэмээн заасны дагуу Монголын Хөрөнгийн Биржийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга бүртгэлийн платформыг ашиглан анхдагч зах зээлийн захиалгыг хүлээн авах бөгөөд, мөн тус журмын 7.12-т “...бусад Үнэт цаасны компанийн харилцагчдыг захиалга өгч, хувьцаа худалдан авах тэгш боломжоор хангасан байх...” гэж заасны дагуу бусад Үнэт цаасны компанийн оролцоог тэгш боломжоор хангаж ажиллана.

**IV. Анхдагч зах зээлийн арилжааны хуваарилалт хийх**

Андеррайтер нь энэхүү Танилцуулгын 6.5-д заасны дагуу хувьцаа захиалгад хуваарилалт хийнэ. Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргаж буй хувьцааг Андеррайтер нь хөрөнгө оруулагчдад худалдаж, санхүүжилтийг амжилттай татан төвлөрүүлсэн өдрөөс хойш ажлын 3 өдөрт багтаан уг ажиллагааны талаарх дэлгэрэнгүй тайланг арилжаа эрхлэх байгууллагын дүгнэлтийн хамт СЗХ-нд хүргүүлнэ. СЗХ нь уг тайланг хүлээн авч ажлын 3 өдөрт багтаан хянах зохицуулалттай бөгөөд нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаа амжилттай явагдсан гэж үзвэл Үнэт Цаасны Төвлөрсөн Хадгаламжийн Төв ХХК-д өмчлөх эрхийн бүртгэл хийх болон арилжаа эрхлэх байгууллагад Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох бичгээр хүргүүлнэ.

**V. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа**

Үнэт цаасыг анх удаа нийтэд санал болгох ажиллагаа амжилттай болсон тохиолдолд Арилжаа эрхлэх байгууллага нь Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллагын хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг хийсэн тухай мэдэгдлийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 2 хоногт багтаан тухайн Үнэт цаас гаргагчийн хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааг эхлүүлнэ. Үнэт цаасны хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээр хувьцааг анхдагч зах зээлээс худалдан авсан хувь хөрөнгө оруулагчид энэхүү Үнэт цаасны танилцуулгын хүснэгт 42-ын дагуу хувьцаагаа бусдад худалдаалах эрх нээлттэй болно.

## 6.4 Анхдагч зах зээлийн арилжааны арга

МХБ-ийн 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдөр баталсан Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам (цаашид “МХБ-ийн Анхдагч зах зээлийн арилжааны журам” гэх)-ын 3

ХАСБАНК
УХН4937 2578697

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК
INVESTMENT ҮЦК
УЛААНБААТАР ХОТ

СЗХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

дугаар зүйлийн 3.1.3 дахь заалтад заасны дагуу Үнэт цаас гаргагч нь олон нийтэд санал болгож буй бүх хувьцаag "**ТОГТООСОН ҮНИЙН АРГА**"-ыг ашиглан арилжаална.

Олон нийтэд санал болгосон үнийн дүнгээс давсан захиалга ирсэн тохиолдолд захиалгыг энэхүү Танилцуулгын 6.5-д заасны дагуу биелүүлнэ.

## 6.5 Хуваарилалт

МХБ-ийн Анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.3 дахь хэсэгт "Үнэт цаас гаргагч, андеррайтер нь Үнэт цаасны танилцуулгад арилжааны арга, стратегийн, мэргэжлийн болон жижиглэнгийн хөрөнгө оруулагчдад Үнэт цаас хуваарилах зарчим, хувь хэмжээ болон хязгаарлалтын нөхцөл байгаа тохиолдолд тус нөхцөлүүдийг тодорхой тусгасан байна" хэмээн заасны дагуу нийтэд санал болгож буй 52,700,000 ширхэг энгийн хувьцааны 70% буюу 36,890,000 ширхэг энгийн хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад хуваарилж, захиалгыг бүрэн биелүүлнэ.

Стратегийн хөрөнгө оруулагч гэдэгт МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 3.4 дэх хэсэгт тодорхойлсон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд давуу талыг бий болгох, Үнэт цаасыг 6 сараас доошгүй хугацаанд тусгаарлуулах үүрэгтэй хөрөнгө оруулагчийг ойлгох бөгөөд Үнэт цаас гаргагчийн тухайд уг шаардлагыг хангасан, Үнэт цаас худалдан авч, хөрөнгө оруулалтаа тогтвортой хадгалах, Үнэт цаас гаргагчийн ирээдүйн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзэлтэй хөрөнгө оруулагчийг сонгон авч стратегийн хөрөнгө оруулагчид тооцсон. Стратегийн хөрөнгө оруулагчдын нийт захиалга нь санал болгож буй хувьцааны тоо ширхгээс давсан тохиолдолд стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг цаг хугацааны дараалаар биелүүлж, хэтэрсэн захиалгыг олон нийтэд санал болгож буй хувьцаанаас хуваарилах зарчмаар биелүүлнэ.

Хүснэгт 42: Стратегийн хөрөнгө оруулагчид тавих шалгуур, нөхцөл

| Хөрөнгө оруулагч | ҮЦТХТ-д тусгаарлалт хийх хугацаа | Хуваарилах хувьцааны тоо ширхэг | Нэгж хувьцааны санал болгох үнэ /Төгрөг/ | Нэг хөрөнгө оруулагчид хуваарилах доод хэмжээ /Төгрөг/ | Нэг хөрөнгө оруулагчид хуваарилах дээд хэмжээ /Төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| Үнэ цэнтэй харилцагчид | 6 сар | 26,202,289 | 677.00 | 30,000,000 | 1,000,000,000 |
| Үнэт цаас гаргагчийн ажилтнууд | 12-24 сар | 10,540,000 | 677.00 | 1,000,000 | 200,000,000 |
| Үнэт цаас гаргагчийн Андеррайтер | 12 сар | 147,711 | 677.00 | - | - |
| **Нийт** | | **36,890,000** | | | |

Нийтэд санал болгож буй нийт хувьцааны 30% буюу 15,810,000 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгоно. Олон нийтэд санал болгох энгийн хувьцаанаас худалдан авах захиалгын дүн давсан тохиолдолд захиалга өгсөн хөрөнгө оруулагчдын захиалгыг хөрөнгө оруулагчдын тооноос хамаарч тодорхой тооны хувьцааны захиалгыг бүрэн биелүүлж, түүнээс давсан захиалгыг хувь тэнцүүлэх зарчмаар биелүүлнэ. Ингэхдээ МХБ-ийн Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журмын 3 дугаар зүйлийн 3.3 дахь заалтыг үндэслэн Үнэт цаас гаргагчаас дараах хязгаарлалтын нөхцөлийг тогтоосон. Үнэт цаасны танилцуулгын хүснэгт 43-аас үзнэ үү.

ХАСБАНК

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК
ХХК

Хүснэгт 43: Олон нийтэд санал болгох хувьцааны хуваарилалтын матриц

| Хөрөнгө оруулагчийн тоо | Захиалга бүрэн биелэх хувьцааны тоо ширхэг | Нэгж хувьцааны Үнэ /Төгрөг/ | Захиалга бүрэн биелэх дүн /Төгрөг/ |
|---|---|---|---|
| 1-5,000 | 3,160 | 677.00 | 2,139,320 |
| 5,001 - 10,000 | 1,580 | 677.00 | 1,069,660 |
| 10,001 - 15,000 | 1,050 | 677.00 | 710,850 |
| 15,001 - 20,000 | 790 | 677.00 | 534,830 |
| 20,001 - 30,000 | 520 | 677.00 | 352,040 |
| 30,001 - 40,000 | 390 | 677.00 | 264,030 |
| 40,001 - 50,000* | 310 | 677.00 | 209,870 |

* *50,001 ба түүнээс дээш тооны хөрөнгө оруулагчид худалдан авах захиалга ирүүлсэн тохиолдолд хувь тэнцүүлэн хуваарилах зарчмыг баримтална.

Нэгж хувьцааг хуваах боломжгүй учир хуваарилсан хувьцааны тоог хэрэв бутархай байвал 0.5-аас дээш бутархайг 1 бүхэл нэгжид, 0.5-с доош бутархайг 0 нэгжид шилжүүлэн тооцно. Бутархай оронг бүхэл тоонд шилжүүлсний дараа хуваарилалт хийгдсэн нийт хувьцааны тоо олон нийтэд санал болгож буй хувьцааны тооноос илүү гарсан тохиолдолд хамгийн олон ширхэг хувьцаа авах захиалга өгсөн харилцагчдын Үнэт цаасны тооноос тус бүр нэг ширхгийг хасах зарчмаар арилжихаар санал болгож буй тоотой тэнцүүлнэ.

Үнэт цаас гаргагч болон Андеррайтерууд нь санал болгож буй хувьцааг хэрхэн хуваарилах талаар холбогдох дүрэм, журмын хүрээнд шийдвэр гаргах эрхтэй. Хэрэв санал болгосон нийт хувьцаанаас давсан захиалга олон нийтээс ирүүлсэн тохиолдолд хөрөнгө оруулагчдын захиалгын дүнгээс цөөн хувьцаа хуваарилагдах бөгөөд Үнэт цаас гаргагч болон Андеррайтерууд нь хамтарсан шийдвэрээр, үндэслэл дурдахгүйгээр, тавигдсан шалгууруудын аль нэг эсвэл бүгд хангагдсан эсэхээс үл хамааран аливаа захиалгаас бүхэлд нь эсвэл хэсэгчлэн татгалзаж болно. Захиалга өгөхөөр шилжүүлсэн үнийн дүнгээс биелэгдээгүй үнийн дүнг хөрөнгө оруулагчдад буцаан олгох бөгөөд буцаан олгон мөнгөн хөрөнгөд Үнэт цаас гаргагч нь хүү төлөхгүй бөгөөд мөнгөн хөрөнгийн буцаахтай холбоотой банкны гүйлгээний шимтгэлийг хөрөнгө оруулагч хариуцна. Андеррайтерууд хөрөнгө оруулагчдад санал болгосон хувьцааны хуваарилалтын талаар холбогдох мэдээллийг хүргүүлэн ажиллана.

## 6.6 Ажилтнуудад хувьцаа эзэмшүүлэх хөтөлбөр

Үнэт цаас гаргагчаас ажилтнууд болон удирдлагад зориулсан хувьцаа эзэмшүүлэх тусгайлсан хөтөлбөр байхгүй бөгөөд харин Үнэт цаас гаргагчийн толгой компани буюу ТСН-ийн хувьцааны үнэд суурилсан урт хугацааны урамшууллын хөтөлбөр хэрэгжиж байна. Энэхүү хөтөлбөр нь ажилтнуудад болон удирдлагад хувьцаа эзэмшүүлэх үүрэггүй бөгөөд харин ТСН-ийн хувьцааны үнэ цэнтэй уялдсан мөнгөн урамшууллыг тодорхой шалгуурын дагуу сонгогдсон ажилтнууд болон удирдлагад олгох хөтөлбөр болно.

Үнэт цаас гаргагчийн урт хугацааны зорилтын биелэлт, ирээдүйн ашигт ажиллагаа болон зах зээлийн үнэлгээ нь ажилтнууд болон удирдлагын ажлын гүйцэтгэлээс шууд хамааралтай байдаг тул тэднийг тогтвортой, үр бүтээлтэй ажиллуулах зорилгоор стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгын хүрээнд холбогдох хууль тогтоомж, журмын дагуу Үнэт цаас гаргагчийн ажилтнууд болон удирдлагад хувьцааны хуваарилалт хийхээр шийдвэрлэсэн.

Үнэт цаас гаргагчийн ажилтнууд болон удирдлага нь стратегийн хөрөнгө оруулагчийн хувьд санал болгож буй хувьцаанаас гадна олон нийтэд санал болгож буй хувьцаанаас худалдах авах захиалга өгөх эрх нь бусад хөрөнгө оруулагчдын нэгэн адил нээлттэй болно.

## 6.7 Үнэт цаасны нийлүүлэлт

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон нэмж гаргаж буй хувьцааны бүртгэл болон нийлүүлэлтийг ҮЦТХТ нь СЗХ-ноос Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон хувьцаа гаргах ажиллагаа амжилттай явагдсан тухай албан бичгийг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор Үнэт цаас гаргагчийн хувьцааны өмчлөх эрхийн бүртгэлийг хийж гүйцэтгэнэ.

Хэрэв шинээр санал болгож буй хувьцааг нийлүүлэх боломжгүй болсон тохиолдолд тухайн хувьцааны хуваарилалтыг хүчингүйд тооцож захиалгын төлбөрийг аливаа хүү болон нөхөн төлбөргүйгээр хөрөнгө оруулагчдад буцаан олгоно. ҮЦТХТ-р дамжуулан хувьцааг нийлүүлэх, төлбөр тооцоо хийгдэхээс өмнө хөрөнгө оруулагчдын хооронд хийгдсэн хувьцааны хэлцэл нь зөвхөн холбогдох талуудын эрсдэлд тооцогдоно. Хуваарилалтыг хүчингүйд тооцож төлбөрийг буцаасантай холбоотой учирсан хохирлыг Үнэт цаас гаргагч, Үндсэн андеррайтер (Райнос Инвестмент ҮЦК ХХК), Туслах андеррайтер (Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК) болон Монголын Хөрөнгийн Бирж (МХБ) хариуцахгүй болохыг анхаарна уу.

## 6.8 Татан төвлөрүүлэх хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь олон нийтэд шинээр санал болгож буй 52,700,000 ширхэг энгийн хувьцааг амжилттай арилжаалан 35,667,900,000 төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлэхээр тооцож байна. Энэхүү санхүүжилтээс шинээр Үнэт цаас гаргахтай холбогдон гарах дараах шууд зардлуудыг холбогдох журам, СТОУС-ийн дагуу хасаж, үлдсэн хөрөнгийг нэн тэргүүнд Банкны бизнесийн үйл ажиллагаа, тэр дундаа зээлийн багцын дунд хугацааны өсөлтийг хангахад зарцуулахаар төлөвлөж байна. Үнэт цаас гаргахтай холбоотой шууд зардалд:

- Райнос Инвестмент ҮЦК ХХК болон Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-д төлөх андеррайтерын шимтгэл;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1-р заалтын дагуу БДО Аудит ХХК-р гүйцэтгүүлсэн бизнесийн үнэлгээний төлбөр;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1.4-р заалтын дагуу Эрнст энд Янг Монголия Аудит ХХК-р гүйцэтгүүлсэн аудиторын тодорхойлох захидал, дүгнэлтийн төлбөр;
- Үнэт цаасны бүртгэлийн журмын 2.1 заалтын дагуу Өмгөөллийн "Батбаяр энд Партнерс" ХХН-өөр гүйцэтгүүлсэн хуулийн дүгнэлтийн төлбөр;
- МХБ-ийн бүртгэлийн болон анхдагч зэх зээлийн хураамж;
- ҮЦТХТ-ийн бүртгэлийн болон анхдагч зах зээлийн хураамж;
- Бусад зохицуулагч байгууллагуудын шимтгэл, хураамж.

Үнэт цаас гаргахтай холбоотой дээр дурдсан шууд зардлуудыг хассаны дараах байдлаар нийтээс татан төвлөрүүлсэн цэвэр санхүүжилт нь 34,038,994,820 төгрөг болно.

Үнэт цаас гаргагч нь дунд хугацааны санхүүгийн төсөөлөлдөө зээл болон санхүүгийн түрээсийн багцыг жилийн 20%-25% өсгөхөөр тооцсон бөгөөд татан төвлөрүүлсэн цэвэр санхүүжилтийг дараах байдлаар активт хөрөнгөд байршуулж, зарцуулахаар төлөвлөж байна.

Хүснэгт 44: Нийтээс татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

| Зээлийн сегмент | Цэвэр санхүүжилтийг зарцуулах хувь | Цэвэр санхүүжилтийг зарцуулах мөнгөн дүн |
|---|---|---|
| Иргэдийн зээлийн багц | 66% | 22,465,736,581 |
| Байгууллагын зээлийн багц | 19% | 6,467,409,016 |
| Санхүүгийн түрээсийн багц | 15% | 5,105,849,223 |
| **Нийт** | **100%** | **34,038,994,820** |

## 6.9 Үнэт цаасанд хамаарах эрх, үүрэг

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь Компанийн тухай хууль, Компанийн дүрэм болон бусад хууль, тогтоомжид заасан эрх үүргийг эдлэх ба эдгээрээс тусгайлан дурдвал:

### 6.9.1 Хувьцаа эзэмшигчийн эрх

- Хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа асуудлаар эзэмшиж байгаа хувьцааны тоотой хувь тэнцүү санал өгөх;
- Эзэмшиж буй хувьцааны хувь хэмжээгээр ногдол ашиг авах;
- Компанийг татан буулгах үед Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх;
- Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйл бол Компанийн дүрэмд заасны дагуу Компаниас нэмж гаргах хувьцаа, түүнд хамаарах Үнэт цаасыг өөрийн эзэмшиж байгаа хувьцаанд хувь тэнцүүлэн тэргүүн ээлжид худалдах авах;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад эрх багтана.

### 6.9.2 Хувьцаа эзэмшигчийн үүрэг

- Өөрийн нэр, оршин суугаа газрын хаяг болон эзэмшиж байгаа Үнэт цаасны тоог Компанийн Үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх этгээдэд мэдээлэх, түүнчлэн эдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүрд нь мэдэгдэх;
- Нийт гаргасан хувьцааны гуравны нэг болон түүнээс дээш хувийг дангаараа эсхүл нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран худалдан авч эзэмшихийг хүссэн этгээд нь Компанийн тухай хууль болон Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд заасны дагуу энэ тухайгаа нийтэд мэдээлэх замаар худалдан авах санал гаргах;
- Нийт гаргасан хувьцааны тавааc дээш хувийг дангаараа болон өөрийн нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшсэн этгээд өмчлөх эрх үүссэнээс хойш ажлын 3 хоногийн дотор энэ тухай Компанид бичгээр мэдэгдэх;
- Компанийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5 дахь хэсэгт зааснаас бусад тохиолдолд өөрийн эзэмшлийн хувьцааныхаа хэмжээгээр хариуцлага хүлээх;
- Хууль тогтоомж болон Компанийн дүрмээр тогтоосон бусад үүрэг орно

### 6.9.3 Нэмж хувьцаа гаргах

Банк нь хувьцаа, түүнд хамаарах Үнэт цаас гаргах асуудлыг ТУЗ-өөр хэлэлцэж, Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар шийдвэрлэдэг. Үнэт цаас гаргагчийн 2023 оны 3 дугаар сарын 27-ны өдрийн Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит бус Хурлаар ТУЗ-ийн тогтоолыг үндэслэн энгийн хувьцаа нэмж гаргахаар шийдвэрлэсэн ба уг Үнэт цаастай холбоотой хуульд заасан тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг одоогийн хувьцаа эзэмшигч хэрэгжүүлэхгүй байх шийдвэрийг мөн гаргасан байна.

СЗХ
2023 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

#### 6.9.4 Хувьцаа шилжүүлэхэд тавих хязгаарлалт

Үнэт цаас гаргагчийн дүрэмд тусгайлсан хязгаарлалт байхгүй боловч Монголбанк, СЗХ-ны 2021 оны А-262/262 тоот тушаалаар батлагдсан Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн болон хувь нийлүүлэгчдийн бүтцэд зөвшөөрөл олгох журмын дагуу хувьцаа эзэмшигч нь хувьцаа гаргах, нэгтгэх, хуваах замаар бүтцийн өөрчлөлт хийх зэрэг үйл ажиллагааны үр дүнд нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох эсхүл нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн 1 хувь ба түүнээс дээш хувиар нэмэгдүүлэх үед Монголбанкнаас зөвшөөрөл авах шаардлагатай байдаг.

#### 6.9.5 Тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх

Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсгийн дагуу энгийн хувьцаа гаргах үед хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшилд буй хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжинд худалдан авах давуу эрх эдэлдэг. Энэхүү эрхийг Компанийн тухай хуульд заасны дагуу Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар хязгаарлаж болдог.

#### 6.9.6 Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг бууруулах

Холбогдох хууль тогтоомжийн дагуу Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийг бууруулах эсэх асуудлыг ТУЗ-өөр хэлэлцэж, Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар шийдвэрлэж болдог. Үүнд: (i) хувьцааг хүчингүй болгох, (ii) дүрэмд өөрчлөлт оруулах замаар хувьцааны нэрлэсэн үнийг бууруулах шийдвэр гаргаж болно.

#### 6.9.7 Хувьцааг эргүүлэн худалдаж авах

Үнэт цаас гаргагч нь Монгол Улсын хууль тогтоомж, дүрэм журмын дагуу, эрх бүхий байгууллагаас урьдчилан зөвшөөрөл авсны үндсэн дээр хувьцааг эргүүлэн худалдан авч болох бөгөөд дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд, (i) тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтрэхгүй байх, (ii) хувьцааг эргүүлэн худалдан авснаар тухайн үеийн балансад тусгагдсан нийт гаргасан хувьцааны нэрлэсэн үнийн дүн буюу хувь нийлүүлсэн хөрөнгөөс багасахгүй байх, (iii) энгийн хувьцааны таваас дээш хувийг худалдан авах тохиолдолд Компанийн тухай хуульд заасан нөхцөл журмын дагуу Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас хувьцааг эргүүлэн худалдаж авах зөвшөөрөл олгосон байх. ТУЗ нь хувьцааг эргүүлэн худалдан авах зөвшөөрөл олгохдоо худалдан авч болох хувьцааны тоо, эргүүлэн худалдаж авах арга зам, хувьцааг худалдан авах үнийн хязгаар зэргийг нарийвчлан зааж өгсөн байна.

Үнэт цаас гаргагч нь эргүүлэн худалдан авсан хувьцаанд санал өгөх, ногдол ашиг авах эрхгүй байх бөгөөд тус хувьцаа нь Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын ирцийн тоонд орохгүй.

#### 6.9.8 Хувьцааны хэлбэр, бүртгэл

Энгийн хувьцаанд хувьцааны гэрчилгээ олгохгүй буюу биет бус хэлбэртэй байна. Хувьцаа эзэмшигчдийн нэр, хаяг болон хууль, тогтоомжид заасан бусад мэдээлэл ҮЦТХТ-д цахим хэлбэрээр бүртгэгдэнэ.

Үнэт цаас гаргагч нь ҮЦТХТ-ийн туслалцаатайгаар энгийн хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг тухай бүр шинэчлэн хөтөлнө. Энгийн хувьцаа нь зохицуулагч байгууллагын (нөлөө бүхий хувьцаа эзэмшиж байгаа тохиолдолд) эсхүл хоёр талын харилцан тохиролцоонд үндэслэн түгжих нөхцөлтэй байж болох ба бусад тохиолдолд Монголын Хөрөнгийн Биржээр дамжуулан хувьцааны өмчлөлийг чөлөөтэй шилжүүлж буюу арилжаалж болно. Тухай бүрд хувьцааны өмчлөлийн бүртгэлийг ҮЦТХТ хийнэ.

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

### 6.9.9 Гадаад дахь хувьцаа эзэмшигчидтэй холбоотой биржийн хяналт болон бусад заалтууд

Монгол Улсын хуулийн дагуу энгийн хувьцаанд хөрөнгө оруулах, төлбөр тооцоог хийхэд валютын тусгайлсан хязгаарлалт байхгүй болно. Мөн иргэншлээс үл хамааран Монгол болон Гадаад улсын иргэд энгийн хувьцаа эзэмших, санал өгөх бүрэн эрхтэй ба хязгаарласан аливаа зүйл заалт хуульд болон Компанийн дүрэмд байхгүй болно.

### 6.9.10 Ногдол ашгийн хуваарилалт

Үнэт цаас гаргагчийн ногдол ашгийн бодлого нь Банкны стратегитэй нийцсэн байх бөгөөд Үнэт цаас гаргагч нь хувьцаа эзэмшигчдэд тогтвортой урт хугацааны үнэ цэнийг бий болгох, тогтвортой ногдол ашиг хуваарилахыг зорино.

Ногдол ашиг хуваарилах эсэх болон түүний хэмжээг Үнэт цаас гаргагчийн төлбөрийн чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, Зохицуулагч байгууллагын тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон Үнэт цаас гаргагчийн ирээдүйн өсөлтийн боломж зэргийг харгалзан үзэж ТУЗ хэлэлцэж, холбогдох хууль, журмын дагуу жил бүрийн Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар шийдвэрлүүлнэ. Ногдол ашгийн бодлогыг Үнэт цаасны танилцуулгын хавсралт 2-оос үзнэ үү.

### 6.9.11 Ногдол ашгийн хязгаарлалт

Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар шийдвэрлэсэн ногдол ашиг хуваарилах эсэх асуудлыг Монголбанк өөрийн бүрэн эрхийн хүрээнд хянаж, Үнэт цаас гаргагчийн зохистой харьцаа алдагдах эрсдэлтэй гэж үзвэл ногдол ашиг хуваарилах эсэх асуудалд хязгаарлалт тогтоож болдог.

## 6.10 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн үүрэг

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу арилжааны банкны гаргасан болон эргэлтэд байгаа хувьцааны 5% (хувь) ба түүнээс дээш хувийг шинээр эзэмшиж, нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох хөрөнгө оруулагч нь Монголбанканд бүртгүүлж зөвшөөрөл авдаг. Түүнчлэн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааг компанийн гаргасан хувьцааны 1% (хувь) ба түүнээс дээш хэмжээгээр нэмэгдүүлсэн тохиолдолд мөн Монголбанканд бүртгүүлж, зөвшөөрөл авах зохицуулалттай. Энэхүү журмыг хэрэгжүүлснээр Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтөд тусгагдсан арилжааны банкны хувь нийлүүлэгчдийн бүтцэд дангаараа буюу холбогдох этгээдийн хамтаар Банкны хувьцааны 20% (хувь)- с илүүгүй хувь эзэмшилтэй байх нөхцөлийг бүрдүүлдэг.

## 6.11 Хувьцаа эзэмшигчдийн хурал, саналын эрх

Компанийн тухай хуулийн дагуу жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдрийн дотор Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит Хурлыг зохион байгуулна. ТУЗ-өөс шаардлагатай гэж үзвэл Хувьцаа Эзэмшигчдийн ээлжит бус Хурлыг хуралдуулж болно. Түүнчлэн, хувь нийлүүлсэн хөрөнгийн аравны нэгээс дээш хувийг дангаараа буюу хамтран эзэмшиж буй Хувьцаа эзэмшигчид, эсхүл хоёр ба түүнээс дээш ТУЗ-ийн хараат бус гишүүд нь Хувьцаа Эзэмшигчдийн Хурлыг зарлан хуралдуулах хүсэлт гаргаж болно.

Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд энгийн хувьцаа тус бүр нэг саналын эрхтэй байна. Хувьцаат Компанийн (ХК Банкны) дүрмийн төслийг Үнэт цаасны танилцуулгын хавсралт 3-аас үзнэ үү.

## 6.12 Монголбанкны оролцоо

Үнэт цаас гаргагч нь Банкны тухай хууль тогтоомж, Монголбанкнаас тогтоосон дүрэм, журам, шийдвэрийг зөрчсөн, эсхүл зөрчиж болзошгүй нөхцөл байдал үүссэн, банкны тусгай зөвшөөрлийн шаардлага хангаагүй, эсхүл найдваргүй, хэвийн бус үйл ажиллагаа явуулсан бол Монголбанк Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг сайжруулах, найдвартай, тогтвортой удирдлагыг сэргээх зорилгоор урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна. Монголбанкнаас авсан урьдчилан сэргийлэх арга хэмжээ нь хангалтгүй гэж үзвэл нөхцөлт удирдлагыг хэрэгжүүлэхээр шийдвэрлэж, бүрэн эрхт төлөөлөгчийг томилж болно. Нөхцөлт удирдлагын үед Монголбанкнаас томилсон бүрэн эрхт төлөөлөгч нь Үнэт цаас гаргагчийн удирдлагын эрх, үүргийг түр шилжүүлэн авах, банкны үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үзүүлэлтийг хянаж баталгаажуулах болон шаардлагатай тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн саналын эрхийг түдгэлзүүлэх хүртэл арга хэмжээ авах эрхтэй байдаг.

## 6.13 Банкыг татан буулгах

Үнэт цаас гаргагчийг Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын шийдвэрээр татан буулгаж болно. Үнэт цаас гаргагчийн дүрэмд зааснаар татан буулгах асуудлыг Хувьцаа Эзэмшигчдийн Хуралд оролцож байгаа тухайн асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Компанийн дүрэмд заасан саналын хувь хэмжээгээр шийдвэрлэнэ. Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаар Үнэт цаас гаргагчийг татан буулгах шийдвэр гарснаас хойш 3 хоногийн дотор Монголбанкинд холбогдох баримт бичгийг хүргүүлж зөвшөөрөл авна. Монголбанкнаас зөвшөөрөл олгосон тохиолдолд татан буулгах тухай шийдвэрт заасны дагуу татан буулгах комисс, банкны бүртгэлд байгаа эд хөрөнгө, үнэт зүйлсийг нягтлан шалгах эрх бүхий хянан шалгах комисс болон сонгосон аудит нь Үнэт цаас гаргагчийг татан буулгах ажлыг хийж гүйцэтгэнэ. Үнэт цаас гаргагчийг бүх өр төлбөр, хоёрдогч өглөг зэргийг бүрэн барагдуулсны дараа үлдэх хөрөнгийг тухайн хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн эзэмшиж буй хувьцааны эрхийн дагуу хуваарилна.

## 6.14 Үнэ тогтворжуулах хөтөлбөр

СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 8 дугаар зүйл болон Үнэт цаас гаргагч болон Андеррайтеруудын хооронд 2023 оны 3 дугаар сарын 13-ны өдөр байгуулсан “Андеррайтерийн гэрээ”-ний 3.1.1 дэх заалтад заасны дагуу Андеррайтерууд нь Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааны үнийг тогтворжуулах, үнийн хэт өндөр савалгаанаас хамгаалах, хөрвөх чадварыг нэмэгдүүлэх, үнийн тогтвортой байдлыг хангах зорилгоор хувьцааны үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийн хураангуйг дараах хүснэгтэд харуулав. Үүнд:

Хүснэгт 45: Үнэ тогтворжуулах хөтөлбөр ерөнхий нөхцөл

| | |
|---|---|
| **Андеррайтеруудын үүрэг** | Хоёрдогч зах зээлийн арилжаа эхэлснээс хойш 1 сарын хугацаанд хувьцааны үнийн тогтвортой байдал, хөрвөх чадварыг хангах, хувьцааны үнэ олон нийтэд худалдах анхдагч үнээс буурах нөхцөл байдал үүссэн тохиолдолд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх эх үүсвэр нь олон нийтэд хувьцааг санал болгож татан төвлөрүүлсэн хөрөнгөөс ангид байна. |
| **Андеррайтеруудын хариуцлага** | Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэхдээ Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 80 дугаар зүйлд заасны дагуу зах зээлийг урвуулан ашиглахыг хориглоно. |
| **Хөтөлбөрийн хугацаа** | Үнэ тогтворжуулах хөтөлбөр нь хоёрдогч зах зээлийн арилжааны эхний өдрөөс эхлэн 1 сар (30 хоног) үргэлжилнэ. |

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

| | |
|---|---|
| **Үнэ тогтворжуулах нөхцөл** | Заасан хугацаанд хувьцааны ханш анхдагч зах зээлд санал болгосон үнээс 15% буурсан нөхцөлд, эсхүл 7 өдөр дараалан 15%-иар өссөн нөхцөлд. |
| **Үнэ тогтворжуулах хөтөлбөрийг хэрэгжүүлэх андеррайтерууд** | Үндсэн андеррайтер: Райнос Инвестмент ҮЦК ХХК<br>Туслах андеррайтер: Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК |

Андеррайтерууд нь холбогдох журмын дагуу үнэ тогтворжуулах хөтөлбөрийн эцсийн үр дүнг хөтөлбөр дууссанаас хойш ажлын 3 хоногийн дотор СЗХ, МХБ-д тайлагнаж, олон нийтэд мэдээлнэ.

## 6.15 Андеррайтерийн худалдан авах Үнэт цаас

СЗХ-ны Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.5.3 дахь хэсэг, 7 дугаар зүйлийн 7.6 дахь хэсэгт тус тус заасны дагуу Андеррайтерууд олон нийтэд анхдагч зах зээлд нийлүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлэх зорилгоор санал болгож буй хувьцаанаас нийт 100 сая төгрөгийн хувьцааг өөрийн нэрийн Үнэт цаасны дансаар дамжуулан худалдан авна (6.5-ын дагуу).

## 6.16 Санал болгож буй хувьцаатай холбоотой татвар, хураамж

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч нь Үнэт цаас худалдан авах болон худалдахтай холбоотой аливаа хураамж, шимтгэлийг бүрэн хариуцах бөгөөд Үнэт цаасны арилжаанаас олсон орлого, ашигт хамаарах татварыг хуульд заасан хувь хэмжээгээр өөрөө хариуцан төлөх үүрэгтэй. Мөн Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч Үнэт цаасанд хамааралтай ногдол ашгаас холбогдох хуулийн дагуу татвар төлөх үүрэгтэй.

## 6.17 Маргаан шийдвэрлэх

Энэхүү Танилцуулга болон олон нийтэд хувьцааг анх удаа санал болгох үйл ажиллагаа нь Монгол Улсын хуулиар зохицуулагдана. Энэхүү Танилцуулга болон Үнэт цаас санал болгохтой холбогдон үүсэж болзошгүй аливаа маргааныг Монгол Улсын хууль, тогтоомжийн дагуу шүүхээр шийдвэрлэгдэнэ.

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

2023-05-
БҮРТГЭВ-02

# Долоо. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙГ ӨӨРЧЛӨН БАЙГУУЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

## 7.1 Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах үндэслэл

2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Монгол Улсын Их Хурлаас Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулиар аливаа нэг этгээдийн дангаар болон холбогдох этгээдийн хамт банкинд эзэмших хувьцааны хэмжээнд банкны гаргасан нийт хувьцааны 20%-р дээд хязгаарыг тогтоосон бөгөөд уг хязгаарлалтын шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангасан байхаар хуульчилсан. Банкны тухай хуульд орсон өөр нэгэн томоохон өөрчлөлт нь **"банкны системд нөлөө бүхий банк"** гэж тодорхойлогдсон банкнууд нь 2023 оны 6 дугаар сарын 30-ний өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн зохион байгуулах шаардлага (хамтад нь "Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтүүд" гэх). Эдгээр өөрчлөлтүүд нь хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах замаар банкны ил тод, найдвартай, хариуцлагатай байдлыг сайжруулах зорилготой гэж хууль санаачлагчид үзсэн болно.

Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг дагаж мөрдөхийн тулд Үнэт цаас гаргагч нь нэг хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцаа эзэмшлийг 20%-с хэтрүүлэхгүй байх шаардлагыг биелүүлэх үүрэгтэй бөгөөд одоогийн байдлаар энэ шаардлагыг Үнэт цаас гаргагч нь шууд эзэмшлийн түвшинд хангаагүй байгаа болно. Иймд толгой болон охин компани гэсэн групп компанийн бүтцийг халах замаар Үнэт цаас гаргагч нь өөрийн Толгой компани (ТСН)-тэй нэгдэж өөрчлөн байгуулагдах шаардлагатай болох юм ("Банкийг өөрчлөн байгуулах"). Ингэснээр Толгой компанийн хувьцаа эзэмшигчид нь 2023 оны 12 дугаар сарын 31-ний дотор Үнэт цаас гаргагчийн хувьцааг шууд байдлаар эзэмших бөгөөд нэг хувьцаа эзэмшигчийн (холбогдох этгээдийн хамт) Үнэт цаас гаргагчийн хувьцааны шууд эзэмшил нь Үнэт цаас гаргагчийн гүйлгээнд гаргасан нийт хувьцааны 20%-с ихгүй болно.

Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасанаар арилжааны банкны эзэмших боломжтой Үнэт цаасны дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20%-с хэтэрч болохгүй, мөн нэг компанийн гаргасан хувьцааны 10%-с дээш хувь байж болохгүй гэсэн хязгаарлалттай байдаг. Өөрөөр хэлбэл ТСН-ийг компанийн тухайн хуулийн 20 дугаар зүйлийн дагуу ХасБанктай нэгтгэхэд ТСН-ийн бусад охин компаниуд нь ХасБанкны охин компани болох нөхцөл байдал үүссэн учир (банкны тухай хууль зөрчигдөх нөхцөл байдал) ТСН-ийн хөрөнгө оруулалт бүхий бусад охин компаниудыг ТСН-ээс гаргах шаардлага үүссэн болно. Энэхүү хуулийн шаардлага, нөхцөл байдалд үндэслэн ТСН нь Банкны тухай хуулийн 17 дугаар зүйл болон 36 дугаар зүйлд заасан шаардлагыг хангах зорилгоор компанийн нэгдлийг өөрчлөн байгуулах төлөвлөгөөг боловсруулж, 2022 оны 12 дугаар сарын 31-ий дотор ТСН-ийн бүтцийг дараах байдлаар өөрчилсөн. Үүнд:

- ХасЛизинг ХХК-ийг компанийн тухай хуулийн 20-р зүйлийн дагуу ХасБанкинд нэгтгэсэн;
- Глашир Ассет Тусгай Зориулалтын Компанийг хуулийн дагуу татан буулгасан;
- Блью Скай Фонд компанийг хуулийн дагуу татан буулгасан;
- Глашир Ассет ХХК-ийг Тэнгэр Капитал ҮЦК ХХК-д нэгтгэж, Тэнгэр Капитал ҮЦК ХХК-д эзэмшиж байсан бүх хувьцааг худалдсан;
- Тэнгэр Даатгал ХХК-д эзэмшиж байсан бүх хувьцааг худалдсан.

ТСН группийн хэмжээнд дээрх өөрчлөн байгуулалтыг хэрэгжүүлсний үр дүнд Үнэт цаасны танилцуулга бэлдэх үеийн байдлаар ТСН-ийн эзэмшилд зөвхөн ХасБанк ХХК-ийн нийт

СЗХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

гаргасан хувьцаа болох 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаа (100%-ийн хувь эзэмшил) үлдсэн бөгөөд бусад хуулийн этгээдэд хувь эзэмшил байхгүй болно.

ТСН-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх хураангуй санхүүгийн байдал:

Хүснэгт 46: ТСН-ийн хураангуй тайлан тэнцэл

| Сая төгрөгөөр | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх үлдэгдэл |
|---|---|
| **Хөрөнгө** | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 22,527.7 |
| Хөрөнгө оруулалт (ХасБанкны 1,000,000,000 ширхэг хувьцаа) | 101,817.8 |
| Бусад хөрөнгө | 3.2 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 5.1 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **124,353.8** |
| **Өр төлбөр** | |
| Бусад өглөг | 224.8 |
| Татварын өглөг | 553.6 |
| **Нийт өр төлбөр** | **778.4** |
| **Эздийн өмч** | |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 73,080.0 |
| Нөөцийн сан | 809.5 |
| Хуримтлагдсан ашиг | 49,685.9 |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | **123,575.4** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **124,353.8** |

Төлөвлөгөөнд (дор тодорхойлсон утгаар ойлгоно) тусгасны дагуу банкны хувьцааг анх удаа олон нийтэд санал болгож анхдагч зах зээлд амжилттай арилжаалсны дараа ХасБанкинд ТСН-ийг нэгтгэх замаар Банкийг өөрчлөн байгуулахаар төлөвлөөд байна. Улмаар нэгтгэх ажиллагааны үр дүнд ХасБанк нь ТСН-ийн эрх, үүрэг, хариуцлагыг шилжүүлэн авна. Ийнхүү ТСН-р дамжуулан шууд бусаар Банканд хувьцаа эзэмшдэг одоогийн бүх хувьцаа эзэмшигчид Банкны шууд хувьцаа эзэмшигчид болох юм.

Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах арга, хэлбэрийг эцэслэн тодорхойлох бүрэн эрхтэй этгээд нь Банкны Хувьцаа Эзэмшигчдийн Хурал бөгөөд уг хуралд анхдагч зах зээлийн арилжааны үеэр олон нийтэд анх удаа санал болгосон хувьцааг захиалан худалдаж авсан бүхий л шинэ хөрөнгө оруулагчдыг оролцуулан бүх хувьцаа эзэмшигчид оролцоно. Хувьцаа Эзэмшигчдийн Хурлаас гаргасан уг шийдвэр нь Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлийн үндсэн дээр хэрэгжих боломжтой болно. Ийнхүү өөрчлөн байгуулахад хууль тогтоомжийн болон бүртгэл хийлгэх, зөвшөөрөл авах зэрэг захиргааны үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж болох хүндрэл бэрхшээлүүд нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөв, санхүүгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж болзошгүйг энд тэмдэглэх нь зүйтэй.

Иймд Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг дагаж мөрдөх, Банкны өдөр тутмын үйл ажиллагааг аливаа саатал, тасалдалгүйгээр хэвийн үргэлжлүүлэх үүднээс Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах ажлыг тогтоосон хугацаанд хийж гүйцэтгэх зайлшгүй шаардлагатай болохыг хөрөнгө оруулах сонирхол бүхий боломжит бүхий л хөрөнгө оруулагч, хувьцаа эзэмшигчдийн зүгээс анхаарч үзэх нь зүйтэй юм. Аливаа нэг этгээдийн хувьцаа эзэмшлийн хэмжээнд тавигдаж буй хязгаарлалтыг мөрдөөгүйгээс үүсэж болох эрсдэлийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг “Эрсдэлийн хүчин зүйл 9.9.1” дэх хэсгээс харна уу.

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

## 7.2 Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах төлөвлөгөө

Үнэт цаас гаргагчийн хувьцааг анх удаа олон нийтэд амжилттай санал болгож, арилжаалсны дараа толгой компанийг үнэт цаас гаргагчид нэгтгэх замаар өөрчлөн байгуулах төлөвлөгөөг Үнэт цаас гаргагчийн дүрэм болон Компанийн тухай хуульд заасны дагуу Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хувьцаа Эзэмшигчдийн Хурал (үүнд Толгой компани болон Үнэт цаас гаргагчийн хувьцааг анх удаа нийтэд санал болгон арилжаалах үед Үнэт цаас гаргагчид хөрөнгө оруулалт хийсэн бусад хөрөнгө оруулагчид хамаарна)-ын шийдвэр болон холбогдох хуулийн болон татварын зөвлөхүүдээс өгсөн зөвлөмжид үндэслэн хэрэгжүүлж дуусгахаар төлөвлөж байна. Өөрчлөн байгуулах төлөвлөгөөг хэрэгжүүлэх нь нэг хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээдийн хамт эзэмших хувьцаа эзэмшлийг 20%-с хэтрүүлэхгүй байх зэрэг Банкны тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1 дэх хэсэг болон 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсгүүдэд заасан шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний дотор биелүүлэх арга зам болно.

2011 оны 10 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Компанийн тухай хууль нь компанийг өөрчлөн байгуулахтай холбоотой харилцааг зохицуулдаг. Ийнхүү тус хуулийн 20 дугаар зүйлийн дагуу нэгтгэх замаар Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах ажиллагааг авч хэрэгжүүлснээр ТСН буюу толгой компанийн одоогийн хувьцаа эзэмшигчид нь Үнэт цаас гаргагчийн шууд хувьцаа эзэмшигчид болно Үнэт цаас гаргагч нь хариуцлагатай, үнэт зүйл болон зорилгодоо үнэнч байгууллага болохын хувьд Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлтүүдийг бүрэн дагаж мөрдөх энэхүү үүрэг даалгаврыг үнэнчээр, эргэлзээгүйгээр биелүүлэх чин эрмэлзэлтэй хэвээр байна. Хуульд заасан эцсийн хугацааг цаашид сунгах эсэхийг үл харгалзан Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах ажиллагааг 2023 оны 12 дугаар сарын 31-ний дотор буюу одоогийн тогтоосон хугацаанд, холбогдох хууль, журмын дагуу гүйцэтгэж дуусгахаар зорьж байгаа болно. Аливаа хууль тогтоомж, дүрэм журмыг дагаж мөрдөх нь зах зээл дэх Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, найдвартай байдлыг хадгалахад нэн чухал болохыг үүгээр тэмдэглэж байна.

Үнэт цаас гаргагч болон түүний толгой компани ТСН-ийг нэгтгэх хэлцэл нь Компанийн тухайн хуулийн 89 дүгээр зүйлийн 89.3.4 дэх заалтад заасны дагуу сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй болохыг 2022 оны 3 дугаар сарын 22-ний өдөр Монголбанкнаас бидэнд мэдэгдсэн бөгөөд Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулахдаа Банкны тухай хуульд заасны дагуу тухайн үедээ Монголбанкнаас эцсийн байдлаар зөвшөөрөл авах шаардлагатай.

Иймд, Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтүүдийг бүрэн дагаж мөрдөх боломжийг Үнэт цаас гаргагчид олгох үүднээс шинээр хөрөнгө оруулж хувьцаа эзэмшигч болж буй бүхий л хөрөнгө оруулагч нарыг Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдийн хуралдаа зохих ёсоор оролцож, Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах асуудалд саналаа өгч зөвшөөрсөн шийдвэр гаргана (эргэлзээ төрүүлэхгүйн үүднээс тодруулахад гол хувьцаа эзэмшигч болох ТСН буюу толгой компани болон бусад хувьцаа эзэмшигч нар бүгд санал өгнө) гэсэн хүлээлттэй байгаа болно.

Мөн, Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулахад хууль тогтоомж, Үнэт цаас гаргагчийн дотоод журам болон Дүрмийн дагуу Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж, Татварын алба зэрэг холбогдох эрх бүхий байгууллагуудын зөвшөөрлийг авах шаардлагатай бөгөөд тийнхүү авсны үндсэн дээр өөрчлөн байгуулах ажиллагааг хэрэгжүүлж дуусах юм.

Хүснэгт 47-д үзүүлсний дагуу ТСН-ийн хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй хувьцааг зах зээлийн бодит үнэлгээгээр Үнэт цаас гаргагчийн хувьцаанд хөрвүүлэх бөгөөд Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулахаас өмнөх үеийн ТСН-ийн эзэмшиж байсан Үнэт цаас

СЭХ
2023 .06. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

гаргагчийн 1,000,000,000 ширхэг хувьцааг ТСН-ийн хувьцаа эзэмшигчдэд тэдгээрийн ТСН-д эзэмшиж буй хувь эзэмшил, үнэлгээнд хувь тэнцүүлэн эзэмшүүлнэ.

Хүснэгт 47: Үнэт цаас гаргарчийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц

| Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчид | Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулахаас өмнөх хувьцаа эзэмшил (хувиар) | Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулсны дараах хувьцаа эзэмшил (хувиар) |
|---|---|---|
| Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК | 94.99% | - |
| Анхдагч зах зээлийн арилжаагаар хувьцаа худалдан авсан хувьцаа эзэмшигчид | 5.01% | 5.01% |
| Монголын Алт (МАК) ХХК | - | 19.37% |
| Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) | - | 16.63% |
| ОРИКС Корпораци (ORIX) | - | 16.28% |
| Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (EBRD) | - | 12.50% |
| Канадын Үндэсний Банк (NBC) | - | 10.18% |
| Ронок Партнерс (Ronoc) | - | 9.83% |
| Монголиа Оппортунити Партнерс (MFS) | - | 6.42% |
| Триодос Файр Шэйр Фонд (Triodos) | - | 3.61% |
| Нээлттэй нийгэм форум | - | - |
| Улаанбаатар ротари клуб | - | - |
| Магван Болдоо | - | 0.10% |
| Чулуун Ганболд | - | 0.09% |
| Нийт | 100.00% | 100.00% |

# Найм. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ОРЧИН

Энэхүү бүлэгт Үнэт цаас гаргагчийн биенесийн үйл ажиллагааг зохицуулсан Монгол Улсын хууль тогтоомж, зохицуулагч байгууллагаас баталсан эрх зүйн актын талаарх ерөнхий мэдээллийг хураангуйлан иш татах байдлаар дурдаж оруулсан болно.

Хууль эрх зүйн орчны өөрчлөлтөд хэрхэн нийцэж ажилладаг талаар "Эрсдэлийн хүчин зүйл" хэсгээс танилцана уу.

## 8.1 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж

Үнэт цаас гаргагчийн үндсэн үйл ажиллагаа нь дараах хуулиар зохицуулагддаг болно. Үүнд:

- Иргэний хууль /2002 он/;
- Компанийн тухай хууль /2011 он/;
- Банкны тухай хууль /2010 он/;
- Зөвшөөрлийн тухай хууль /2022 он/;
- Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль /2021 он/;
- Санхүүгийн түрээс /Лизинг/ийн тухай хууль /2006 он/;
- Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль /2009 он/;
- Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль /2015 он/;
- Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль /2013 он/;
- Банкны салбарын тогтвортой байдлыг хангах тухай хууль /2018 он/;
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль /2013 он/;
- Валютын зохицуулалтын тухай хууль /1994 он/;
- Даатгалын мэргэжлийн оролцогчийн тухай хууль /2004 он/;
- Үнэт цаасны зах зээлийн тухай хууль /2013 он/;
- Татварын ерөнхий хууль /2019 он/;
- Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль /2019 он/;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль /2019 он/;
- Хөдөлмөрийн тухай хууль /2021 он/ зэрэг болно.

## 8.2 Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулагч байгууллагууд

Үнэт цаас гаргагч нь Монголбанк болон Санхүүгийн Зохицуулах Хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн хүрээнд үйл ажиллагаа эрхэлдэг тул эдгээр эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар, аргачлал зэрэг эрх зүйн хэм хэмжээ тогтоосон актыг өдөр тутмын үйл ажиллагаандаа дагаж мөрддөг болно.

### 8.2.1 Монголбанкнаас баталсан журмууд

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-82 дугаар тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журам";

- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны А-143 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт шалгалтын журам";
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-138 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журам";
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны А-82 дугаар тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан "Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам";
- Монголбанкны Ерөнхийлөгчийн 2012 оны А-99 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Банкны нэгжийн журам".
- Монголбанкны бусад журам, заавврыг холбоосоос үзэх. https://www.mongolbank.mn/mn/p/1480

### 8.2.2 Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)-ноос баталсан журмууд

- СЗХ-ны 2019 оны 4 дүгээр тогтоолоор баталсан "Үнэт цаасны зах зээлийн зохицуулалттай үйл ажиллагааны багц дүрэм"-ийн нэгдүгээр хавсралт "Үнэт цаасны зах зээлд зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн журам";
- СЗХ-ны 2019 оны 4 дүгээр тогтоолын дөрөвдүгээр хавсралт "Хөрөнгийн зах зээлийн зохицуулалттай этгээдээс мэдээлэл ирүүлэх, түүнд хяналт тавих журам";
- СЗХ-ны 2019 оны 4 дүгээр тогтоолын гуравдугаар хавсралт "Зохицуулалттай этгээдийн эрсдэлийн сангийн журам";
- СЗХ-ны 2022 оны 145 дугаар тогтоолын хавсралтаар баталсан "Компанийн засаглалын кодекс".
- СЗХ-ны бусад журам, заавврыг холбоосоос үзэх. http://www.frc.mn/frc/hynalt/d/pc/8871

### 8.2.3 Банкны салбарын шинэчлэлийн хүрээнд Банкны тухай хуульд орсон шинэлэг зохицуулалт

Монгол Улсын Их хурлаас 2021 оны 1 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулж арилжааны банкийг 2022 оны 6 дугаар сарын 30-ны өдөр /энэ хугацааг 2022 оны 6 дугаар сарын 03-ны өдрийн хуулиар 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр болгон хойшлуулсан/-ийн дотор банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани, бусад банкны хувьд хувьцаат компани хэлбэртэй болох хуулийн шаардлага тогтоож өгсөн.

Тус нэмэлт, өөрчлөлттэй холбоотойгоор Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуульд зааснаар банк нь хуульд заасан шаардлагыг хэрэгжүүлэх хугацаа, Үнэт цаасаа нийтэд нээлттэй санал болгох төлөвлөгөө, хувьцааны үнийн төсөөлөл, боломжит хөрөнгө оруулагчдын тандан судалгаа зэргийг тусгасан "Банкийг нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах төлөвлөгөө"-г батлан 2021 оны 7 дугаар сарын 01-ний өдрийн дотор Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороонд хүргүүлэх болон 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах үүрэг хүлээж байгаа болно.

Дээрх хууль тогтоомжийг хэрэгжүүлэх зорилгоор Монголбанкны Ерөнхийлөгч, Санхүүгийн Зохицуулах Хорооны даргын 2021 оны 3 дугаар сарын 26-ны өдрийн А-90/85 дугаартай хамтарсан тушаалаар "Банкийг хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах,

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, тайлагнах, хянах түр журам" болон 2021 оны 10 дугаар сарын 05-ны өдрийн А-262/262 дугаартай хамтарсан тушаалаар "Хувьцаат компани хэлбэртэй банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт оруулах зөвшөөрлийн журам"-ыг тус тус баталсан. Тус журмын дараах холбоосоос үзнэ үү: https://legalinfo.mn/mn/detail?lawId=16207160426231.

ХАСБАНК

СЭХ
2023 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

# Ес. ЭРСДЭЛИЙН ХҮЧИН ЗҮЙЛС

Ирээдүйн хөрөнгө оруулагчид хувьцаанд хөрөнгө оруулахаасаа өмнө дор дурдсан эрсдэл, тодорхой бус байдал болон энэхүү танилцуулгад тусгагдсан эсвэл иш татсан бусад мэдээлэлтэй анхааралтай танилцах шаардлагатай. Эрсдэлийн хүчин зүйлс хэсэгт тусгагдсан эрсдэл, тодорхойгүй байдал нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд учирч болзошгүй гэсэн таамаглалд суурилдаг. Үнэт цаас гаргагчид одоогийн байдлаар мэдэгдээгүй байгаа бусад эрсдэл, нөхцөл байдал, эсвэл Үнэт цаас гаргагчийн хувьд ач холбогдолгүй гэж үзэж байгаа эрсдэл нь ирээдүйд дангаараа эсвэл хамтдаа чухал ач холбогдол бүхий хүчин зүйлс болж болох бөгөөд Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдал болон хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм. Энэ үед буюу тухайн нөхцөл байдал үүсэх, эсхүл эдгээр эрсдэлийн хүчин зүйлсэд тодорхойлсон үйл явдал үүссэн тохиолдолд энгийн хувьцааны үнэ буурч, хөрөнгө оруулагчид хөрөнгө оруулалтаа хэсэгчлэн эсвэл бүхэлд нь алдаж болзошгүй.

Эдгээр эрсдэлийн хүчин зүйлс, үйл явдлууд нь тохиолдож болзошгүй гэнэтийн зүйлс юм. Үнэт цаас гаргагч нь дор дурдсан хэд хэдэн эрсдэлтэй нэгэн зэрэг тулгарч болох ба дор тайлбарласан нэг буюу хэд хэдэн эрсдэл нь хоорондоо харилцан хамааралтай байж болно. Энэхүү Үнэт цаасны танилцуулгад тусгасан эрсдэлийн хүчин зүйлсийн танилцуулсан дугаарлалт, дэс дараалал нь аливаа утга илэрхийлэхгүй буюу эрсдэл үүсэх магадлал, ач холбогдол, үйл ажиллагааны үр дүн, Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, хэтийн төлөв зэрэгт үзүүлэх нөлөөллийн хэм хэмжээтэй хамааралгүй болно. Үнэт цаас гаргагч нь нягтлан бодох бүртгэлийн холбогдох зарчмуудад үндэслэн зарим үйл явдал болон идэвхтэй явагдаж буй шүүхийн маргаанд эрсдэлийн сан байгуулах шаардлагатай эсэхийг тодорхойлдог. Үнэт цаасны танилцуулгад өөрөөр заагаагүй бол энэ хэсэгт дурдсан эрсдэлийн хүчин зүйлсэд тусгайлан эрсдэлийн сан байгуулаагүй болно.

Хөрөнгө оруулагчид нь үнэт цаасанд хөрөнгө оруулахын өмнө тухайн үнэт цаасны танилцуулгатай бүрэн танилцаж, бие даасан дүгнэлт гаргасан байхыг зөвлөж байна. Мөн аливаа хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахын өмнө өөрийн үнэт цаасны брокер, хуульч, аудитор болон бусад санхүү, хууль эрх зүй, татварын зөвлөхүүдтэй зөвлөлдөж, энгийн хувьцаанд хөрөнгө оруулахтай холбоотой эрсдэлийг сайтар нягталж, өөрийн нөхцөл байдлыг үнэлэн хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргах нь зүйтэй.

Дараах эрсдэлүүд нь Үнэт цаас гаргагч, түүний хувьцаа эзэмшигчдийн бүтэц, энгийн хувьцаа болон хувьцааг нийтэд санал болгох үйл ажиллагаатай холбоотой гол эрсдэлүүдийн түүвэр юм. Эрсдэлийг түүвэрлэн дурдахдаа Үнэт цаас гаргагч нь өнөөгийн нөхцөл байдалд үүсэж болзошгүй эрсдэл, эрсдэл үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хөрөнгө, болон хөрвөх чадварын болон өөрийн хөрөнгийн хэрэгцээ, боломжит ногдол ашгийн төлбөр, нэр хүнд, Үнэт цаас гаргагчийн удирдлагын хэрэгжүүлэх шаардлагатай үйл ажиллагааны цар хүрээ зэргийг харгалзан үзсэн болно. “Эрсдэлийн Хүчин Зүйлс” бүлэгтэй бүрэн танилцаж, хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахыг Хөрөнгө оруулагчдад зөвлөж байна.

## 9.1 Макро эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдлын эрсдэл

**9.1.1. Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал, дэлхийн эдийн засаг, бүс нутгийн эдийн засгийн хэтийн төлөв нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагчийн бизнес, гүйцэтгэлд Азийн болон дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, тухайн бүс нутгийн, ялангуяа Үнэт цаас гаргагчийн орлогыг голчлон бүрдүүлдэг

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Монгол Улсын ирээдүйн эдийн засгийн хэтийн төлөв нөлөөлдөг. Макро эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдал, хямрал, засгийн газрын дампуурал, төсвийн таналт, үнээс үүдэлтэй санхүүгийн зах зээлийн хямрал, тогтворгүй байдал зэрэг нь Үнэт цаас гаргагчийн бизнес, үйлчлүүлэгчдийн идэвх болон зан төлөв, түүнчлэн Үнэт цаас гаргагчийн санхүүгийн гүйцэтгэл, ашигт ажиллагаанд нөлөөлж болзошгүй юм. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд эдийн засгийн гадаад хүчин зүйлс буюу ажилгүйдлийн түвшин, хэрэглээний болон засгийн газрын зардлын түвшин, засгийн газрын төсөв мөнгөний бодлого, инфляцын түвшин, бондын өгөөжийн түвшин, валютын ханш, хөрөнгө эх үүсвэрийн олдоц ба өртөг, зах зээлийн индексүүд, хөрөнгө оруулагчдын санхүүгийн зах зээлд итгэх итгэл, хэрэглэгчдийн итгэл, санхүүгийн зах зээл дэх хөрвөх чадвар, түүхий эдийн үнэ ба хүүгийн түвшин, үл хөдлөх хөрөнгийн үнэ, үйлчлүүлэгчийн зан үйлийн өөрчлөлт зэрэг нь нөлөөлж болзошгүй. Эдгээр хүчин зүйлс Монгол Улсын эдийн засаг, санхүүгийн зах зээлд шууд нөлөө үзүүлж байдаг. Түүнчлэн БНХАУ-ын эдийн засгийн огцом удаашрал, цар тахалтай холбоотой эдийн засгийн сөрөг нөлөөлөл, дэлхийн хэмжээнд зээлийн хүүгийн гэнэтийн өсөлтөд зах зээлийн үзүүлэх сөрөг хариу үйлдэл, геополитикийн хурцадмал байдал, дайн, терроризм, байгалийн болон хүний үүсгэсэн гамшиг зэрэг Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуур үйл явдал, бусад хүчин зүйлс Монгол Улсын эдийн засгийн нөхцөл байдалд нөлөөлж болзошгүй.

Ковид-19 цар тахалтай холбоотой логистикийн хүндрэлүүд нь 2020 онд Монголын эдийн засаг 4.6%-р буурахад нөлөөлсөн ба энэ нь 1990-ээд оноос хойших хамгийн муу үзүүлэлт юм. 2021 онд хэсэгчилсэн сэргэлт эхэлсэн хэдий ч 2021 онд ердөө 1.6%, 2022 онд 4.8%-ийн өсөлттэй байна. Зах зээлийн уналт, Монголын эдийн засгийн байдал муудах нь Үнэт цаас гаргагчийн үйлчлүүлэгчид болон харилцагч талуудын санхүүгийн үүргээ биелүүлэх чадварыг бууруулснаар Үнэт цаас гаргагчийн активын чанарт муугаар нөлөөлж, Үнэт цаас гаргагчийн зээлийн эрсдэлийн сангийн зардлыг нэмэгдүүлэх, Үнэт цаас гаргагчийн шимтгэлийн орлогыг багасгах эсвэл Үнэт цаас гаргагчийн дахин үнэлгээний алдагдлыг нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөөллийг бий болгож болзошгүй. Эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлд үүсэж болзошгүй дээрх хүчин зүйлс нь Үнэт цаас гаргагчийн санхүүжилт, хөрөнгө босгох чадварт нөлөөлж, Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үр дүн, үйл ажиллагаа, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Валютын ханшийн өөрчлөлт, хүүгийн түвшин, өгөөжийн муруйн өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн бизнес, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй. Монголбанкны баримталж буй мөнгөний бодлого нь хүү болон өгөөжийн муруйг өсөх дарамтыг бий болгож, улмаар Үнэт цаас гаргагчийн хүүгийн маржинд нөлөөлж болзошгүй. Инфляцын түвшин өндөр хэвээр удаан үргэлжлэх нь үйлчлүүлэгчийн зан төлөвт сөргөөр нөлөөлж, хадгаламж гадагшлах урсгалыг бий болгох, долларжилтыг нэмэгдүүлэх, улмаар Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Мөн хүүгийн өсөлт, тухайлбал, АНУ дахь Холбооны нөөцийн сангийн хүү эсвэл Монголбанкны бодлогын хүү нэмэгдэх хүлээлт нь эдийн засгийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж, хүүгийн зардлыг нэмэгдүүлснээр Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх магадлалтай.

Иймд Монголын болон дэлхийн эдийн засагт үүсэж болзошгүй зарим нөхцөл байдал нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

**9.1.2. Санхүүгийн зах зээлд үүсэж болзошгүй саатал, зах зээл дээр үнэ тогтоох боломжгүй байдал, зах зээлийн тогтворгүй байдал нь Үнэт цаас гаргагчийн санхүүжилтийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

СЭХ
2023 -05. 12
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

Санхүүгийн зах зээлд урьдчилан таамаглах боломжгүй богино болон урт хугацааны хэдэлгээн, үнэ тогтоох боломжгүй нөхцөл байдал, хөрвөх чадварын хомсдол, эдийн засгийн цочрол үүсэх эрсдэл ямагт байдаг.

Зах зээлийн эдгээр нөхцөл байдал нь Үнэт цаас гаргагчийн зарим бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ болон эрэлтэд нөлөөлж Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа болон балансын бүтцэд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй. Ийм нөхцөл байдал нь Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдал, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Зах зээлийн эдгээр нөхцөл байдал нь Үнэт цаас гаргагчийн санхүүжилт, эх үүсвэрийг цаг тухайд нь хангалттай хэмжээгээр бүрдүүлэхэд саад учруулж болно. Энэ нь ердийн үетэй харьцуулахад өөр нөхцөлөөр хөрөнгө босгох, эсвэл нэмэлт зардал гаргахад хүргэж болзошгүй юм. Цаашилбал, дээрх орчинд Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагын стратеги буюу балансын удирдлага, үнийн бодлого зэрэг нь зах зээлийн хэвийн үетэй харьцуулахад үр дүн багатай байж болох бөгөөд энэ нь Үнэт цаас гаргагчийн ашиг орлого, санхүүгийн байдал болон хөрвөх чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Олон улс дахь засгийн газрын өрийн зах зээлийн доройтол, бусад эдийн засгийн цочрол нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдал, хэтийн төлөв, Үнэт цаас гаргагчийн санхүүжилт, санхүүгийн хэлцлүүд, хүүгийн удирдлагын стратегид материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Мөн геополитикийн хурцадмал байдал, дайн, терроризм, байгалийн болон хүний үүсгэсэн гамшиг, тахал болон бусад ижил төстэй үйл явдлууд нь санхүүгийн зах зээлд том хэмжээний хэлбэлзлийг үүсгэж болзошгүй. Зах зээлийн тогтворгүй байдал болон бусад шалтгаануудаас үүдэн зах зээлийн урт хугацааны уналт үүсэх магадлал ямагт байдаг. Түүхэн мэдээллээс харахад зах зээлийн томоохон үйл явдлууд нь урьдчилан таамаглахад хэцүү эсвэл боломжгүй байдаг бөгөөд эдгээр үйл явдал нь урт хугацаанд үргэлжилбэл Үнэт цаас гаргагч нь их хэмжээний алдагдал хүлээх эрсдэлтэй. Иймд зах зээлийн тогтворгүй байдал, хөрвөх чадварын дутагдал, зах зээл дээр үнэ тогтоох боломжгүй байдал зэрэг нь Үнэт цаас гаргагчийн хөрөнгө, санхүүжилтийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж, бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

**9.1.3. ОХУ, Украины хоорондын мөргөлдөөний улмаас үүсэж болох хурцадмал байдал нь Үнэт цаас гаргагчийн корреспондент банкуудтай хийх гүйлгээ, гадаад валютын төлбөр тооцоо, хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаанд саад учруулж, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдал, хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй.**

ОХУ нь Монгол Улсын экспорт, импортын гол түншүүдийн нэг юм. Монгол Улсын арилжааны банкууд ОХУ-ын томоохон банкуудтай бизнесийн харилцаатай бөгөөд тэдгээр банкуудаар дамжуулан гадаад валютын их хэмжээний төлбөр тооцоог гүйцэтгэдэг. Мөргөлдөөний үйл явцтай холбогдуулан барууны орнууд ОХУ-ын аж ахуйн нэгж, хувь хүмүүс, тэр дундаа Үнэт Цаас гаргагчийн бизнесийн харилцаа бүхий ОХУ-ын зарим корреспондент банкуудын эсрэг хориг арга хэмжээ авсан байна. Мөргөлдөөн хэрхэн үргэлжлэхээс хамаарч барууны орнууд нь хориг арга хэмжээг чангатгах, хамрах хүрээг өргөтгөх, улмаар Монгол Улсын арилжааны банкууд болон Үнэт цаас гаргагчийн харилцдаг ОХУ-ын бүх корреспондент банкуудыг хамруулж болзошгүй байна. Энэ тохиолдолд Монгол Улсын арилжааны банкууд болон Үнэт цаас гаргагчийн гадаад валютаар төлбөр тооцоо хийх боломж хязгаарлагдаж, улмаар Монгол Улсын макро эдийн засгийн орчин болон Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

ХАСБАНК

**9.1.4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь бусад санхүүгийн байгууллагуудын доголдол эсхүл олон нийтийн зүгээс доголдолтой хэмээн үзсэний улмаас материаллаг сөрөг нөлөөлөлд өртөх магадлалтай. Энэ тохиолдолд системийн хэмжээний хөрвөх чадварын асуудал үүсэх, бусад санхүүгийн байгууллага тэдгээртэй харилцагч талууд томоохон алдагдал хүлээх, төлбөрийн чадваргүй байдалд хүрч болзошгүй бөгөөд улмаар Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадвар, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдал, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.**

Санхүүгийн байгууллагууд зээл, худалдаа болон бусад бизнесийн харилцааны үр дүнд өөр хоорондоо нягт холбоо харилцаатай байдаг. Үүний үр дүнд нэг байгууллагын дампуурал, дампуурлын өндөр магадлал, эсвэл дампууралтай холбоотой мэдээлэл тарах зэрэг нь бусад байгууллагуудад нөлөөлж, системийн хэмжээнд хөрвөх чадварын томоохон асуудал, санхүүгийн алдагдалд хүргэж болзошгүй юм. Энэ нь бусад санхүүгийн байгууллагуудын дампууралд хүргэж болзошгүй бөгөөд үүнийг "системийн эрсдэл" гэж нэрлэдэг. Системийн эрсдэл нь Үнэт цаас гаргагч болон төлбөр тооцооны байгууллагууд буюу санхүүгийн зуучлалын үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Монгол Улсын санхүүгийн салбарын системийн эрсдэл өндөр түвшинд байсаар байна. Улсын өрийн хэмжээ их, зарим банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээ бага, системийн банкууд хоорондын харилцан холбоо өндөр гэх мэт байдал нь системийн эрсдэлд нөлөөлж буй чухал хүчин зүйлс юм. Санхүүгийн хямралын үед хөрвөх чадварын хангалтгүй байдал бий болох, банк хоорондын зээлийн хүүгийн түвшин огцом өсөх зэргээс үүдэн санхүүжилтийн зардал өсөх эрсдэлтэй байдаг ба Монгол Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй Үнэт цаас гаргагчийн хувьд системийн эрсдэлд орох магадлал ямагт байдаг.

Үнэт цаас гаргагч нь аливаа харилцагч санхүүгийн байгууллагын дампуурал, эсвэл төрийн өмчлөлд шилжих гэх мэт бүтцийн өөрчлөлтөөс үүссэн харилцагч талын эрсдэлд өртөж болзошгүй бөгөөд хэрэв тус санхүүгийн байгууллагуудын үйл ажиллагаанд доголдол үүссэн тохиолдолд эсвэл үүргээ биелүүлэх боломжгүй болсон үед алдагдал хүлээх эрсдэлтэй байдаг. Арилжааны банкуудын хөрөнгө зохицуулалтын үйл ажиллагаа тус эрсдэлд илүү өртөмхий байдаг. Харилцагч тал аливаа шалтгааны улмаас үүргээ биелүүлээгүйгээс үүдэн Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадвар, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдал, хэтийн төлөвт ноцтой сөрөг нөлөө үүсэж болзошгүй.

## 9.2 Зээлийн болон төвлөрлийн эрсдэл

**9.2.1 Зээлийн болон төвлөрлийн эрсдэл Үнэт цаас гаргагчийн бизнест ямагт тулгарч байдаг ба бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагчийн зээлийн багц нь нэгж харилцагчийн түвшинд, дэд салбарын түвшинд эсхүл нийт зээлийн багцын түвшинд зээлийн эрсдэлд орж болзошгүй. Түүхэн хугацаанд Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанар эдийн засгийн нөхцөл байдал болон бусад хүчин зүйлсийн улмаас нийт багцын хэмжээд болон дэд салбарын хэмжээнд муудаж байсан тохиолдол байдаг. Үүний нэг тод жишээ бол Ковид-19 цар тахлын эдийн засаг болон банк санхүүгийн салбар дахь багцын чанарт үзүүлсэн нөлөөлөл билээ. Эдийн засгийн нөхцөл байдлаас хамааран Үнэт цаас гарагчийн зарим харилцагчид төлбөрийн чадваргүй болох буюу Үнэт цаас гаргагчаас авсан зээлийг эргэн төлөх боломжгүй болж болзошгүй.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны орлого бүхэлдээ Монгол Улс дахь үйл ажиллагаанаас бүрддэг бөгөөд Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын ихэнх хувь нь Монгол Улсын аж ахуйн нэгж, иргэдэд олгосон зээл байдаг. Иймд Үнэт цаас гаргагч болон түүний үйл ажиллагаа нь Монгол Улсын эдийн засаг, улс төр, нийгмийн нөхцөл байдал,

СЗХ 2023 .05. 12 он сар өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

ажилгүйдлийн түвшин гэх мэт хүчин зүйлсээс ихээхэн хамааралтай байдаг. Иргэд, байгууллага болон жижиг дунд бизнес эрхлэгчдийн зээл нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн чухал хэсэг бөгөөд тус зээлүүдийн барьцаа хөрөнгө болох үл хөдлөх хөрөнгийн үнийн тогтворгүй байдал нь Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанар, үйл ажиллагаанд шууд нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Монгол Улсын эдийн засаг, зарим дэд салбар нь алт, зэс, коксжих нүүрс, төмрийн хүдэр зэрэг цөөн тооны экспортын бараа бүтээгдэхүүний үнээс шууд хамааралтай байдаг. 2018 оноос хойш эдгээр бараа бүтээгдэхүүний үнэ харьцангуй өндөр байгаа боловч нөхцөл байдал өөрчлөгдөж болзошгүй юм. Үнийн огцом уналт, тогтворгүй байдал нь уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулдаг аж ахуйн нэгжүүдэд сөргөөр нөлөөлж улмаар тус салбарт олгосон Үнэт цаас гарагчийн зээлийн багцын чанар муудах эрсдэлтэй байдаг. Уул уурхайн салбарын нөлөөлөл өндөр Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй Үнэт цаас гаргагчийн хувьд энэ эрсдэлийн нөлөөлөл өндөр байх магадлалтай.

Үнэт цаас гаргагчийн төвлөрлийн эрсдэлийг бууруулах зорилгоор зээлийн багцыг төрөлжүүлэх, хязгаар тогтоох зэрэг арга хэмжээ авдаг ба тус арга хэмжээ үр дүн багатай, амжилтгүй болж болзошгүй бөгөөд зээлийн төвлөрөл нэмэгдэхийн хэрээр их хэмжээний алдагдал учрах магадлал нэмэгдэж байдаг. Хэрэв дээр дурдсан эрсдэлүүд үүсэх тохиолдолд Үнэт цаас гаргагчийн бизнес, орлого, үйл ажиллагаа, санхүүгийн байдал, хэтийн төлөвт ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

## 9.3 Бизнесийн эрсдэл

**9.3.1. Үнэт цаас гаргагчийн стратегийн хэрэгжилт, стратеги хэрэгжилтийн үр дүн хүлээсэн хэмжээнд хүрэхгүй, өөр үр дүн авчрах тохиолдолд Үнэт цаас гаргагчийн бизнес, орлого, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдал, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагчийн стратегийн үндсэн зорилтуудад дижитал банканд хөрөнгө оруулах, харилцагчийн үйлчилгээг сайжруулах, эрсдэлд суурилсан эрүүл өсөлт хийх замаар ашигт ажиллагааг нэмэгдүүлэх зэрэг багтдаг. Тус стратегийн хүрээнд Үнэт цаас гаргагч нь дараах тоон үзүүлэлтийг зорин ажиллаж байна. Үүнд, ирэх жилүүдэд өөрийн хөрөнгийн өгөөжийг 20%-иас дээш, зардал орлогын харьцааг 40%-иас доош, 1 дүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг 12.5%-иас дээш, ногдол ашгийг жил бүр зохих түвшинд тараах зорилтыг тавин ажиллаж байна. Үнэт цаас гаргагчийн стратеги, зорилтууд өнөөдрийн байдлаар Үнэт цаас гаргагчид мэдэгдэж буй макро эдийн засгийн нөхцөл байдал, хүүгийн түвшин, орлого, зардал, эрсдэлийн түвшин зэрэг хүчин зүйлс, таамаглал, хүлээлтэд суурилсан болно. Эдгээр хүчин зүйлс, таамаглал, тооцоолол нь өөрчлөгдөх эсхүл Үнэт цаас гаргагчийн хүлээлтээс өөр байх магадлалтай. Мөн түүнчлэн удирдлагын анхаарал болгоомжгүй байдал, буруу шийдвэр, сонголт, үр ашиггүй байдал болон бусад шалтгааны улмаас Үнэт цаас гаргагч нь зорьсон зорилгодоо хүрч чадахгүй байх магадлалтай.

Үнэт цаас гаргагч нь өөрийн бизнесийг өргөжүүлэн тэлэх боломжуудыг тогтмол судалж, эрэлхийлэх бөгөөд энэ хүрээнд шинэ бүтээгдэхүүн гаргах эсвэл зах зээлд эзлэх байр суурийг нэмэгдүүлэх талаар тодорхой арга хэмжээг авч хэрэгжүүлэх болно. Үнэт цаас гарагчийн хувьд бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэн тэлэх явцад дараах эрсдэл үүсэж болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлэх, санал болгоход ихээхэн цаг хугацаа, хөрөнгө болон бусад нөөцийг зарцуулж болно. Хэрэв эдгээр бүтээгдэхүүн, үйлчилгээ эсвэл бүтээгдэхүүн, үйлчилгээгээ сайжруулах санал санаачилгууд нь амжилттай хэрэгжихгүй эсвэл төлөвлөсний дагуу шинэлэг байж чадахгүй тохиолдолд Үнэт цаас гарагч нь зах зээлийн боломжоо алдаж, холбогдох зардлыг нөхөж чадахгүй байж болох бөгөөд

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

энэ нь Үнэт цаас гарагчийн орлого, зарлагад ноцтой сөрөг нөлөө үзүүлж болно. Үнэт цаас гаргагч нь холбогдох дүрэм, журамд нийцээгүй шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг боловсруулах магадлал байдаг. Үүний үр дүнд Үнэт цаас гаргагч нь алдагдал хүлээх, торгууль төлөх, зохицуулагч байгууллагын сануулга авахаас гадна нэр хүндийн эрсдэлд орж болзошгүй. Үнэт цаас гаргагч нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох, эсвэл одоогийн санал болгож буй бүтээгдэхүүн, үйлчилгээг сайжруулах ажилд удирдлагын багийн цаг, хүч хөдөлмөрийг ихээр зарцуулж болзошгүй ба тус цаг хугацаа, хөдөлмөрийг бусад төсөл, санаачлагд ашиглах боломжийг алдаж болзошгүй. Зохицуулагч байгууллага нь Үнэт цаас гаргагчид шинэ эсхүл илүү хатуу шаардлагыг тавьж болзошгүй бөгөөд эдгээр зохицуулалтын шаардлагуудыг дагаж мөрдөхийн тулд үйл ажиллагааны болон удирдлагын зардлыг (удирдлагын оролцоо, зарцуулах цагийг оруулснаар) нэмэгдүүлэх магадлалтай. Мөн Үнэт цаас гаргагч нь бизнесийн шинэ боломжуудыг олж илрүүлэх боломжгүй байдалд хүрч болзошгүй.

Үнэт цаас гаргагчийн стратегийг амжилттай хэрэгжүүлэх эсвэл бизнесийн боломжуудыг эрэлхийлэх чадварт эдийн засаг, бизнесийн ерөнхий нөхцөл байдал зэрэг хүчин зүйлс нөлөөлнө. Эдгээрийн ихэнх нь Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуур байдаг бөгөөд Үнэт цаас гаргагчийг бизнесийн зорилгодоо хүрэхэд хүндрэл учруулж болзошгүй юм. Хэрэв Үнэт цаас гарагчийн стратеги амжилттай хэрэгжихгүй, эсвэл Үнэт цаас гарагчийн стратеги нь хүлээгдэж буй үр өгөөжөө өгөхгүй, эсвэл Үнэт цаас гарагч нь шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг амжилттай гаргах, сайжруулах, бизнесийн бусад боломжуудыг цаг тухайд нь эсвэл огт хэрэгжүүлэх боломжгүй бол энэ нь Үнэт цаас гарагчийн бизнес, орлого, үйл ажиллагааны үр дүн, санхүүгийн байдал, хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлж болно.

**9.3.2. Зээл, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаанд хамаарал бүхий хууль тогтоомжид өөрчлөлт орох нь Үнэт цаас гаргагчийн зээл, санхүүгийн түрээсийн бизнест сөргөөр нөлөөлөх буюу улмаар Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Монгол Улсын Банкны тухай хуулийн ("Банкны тухай хууль") шинэчилсэн найруулгад банкууд хувьцаагаа хөрөнгийн биржид гаргах замаар компанийн хэлбэрийг өөрчлөх, банкны аль нэг хувьцаа эзэмшигчийн эзэмшлийг 20%-иас хэтрүүлэхгүй байх шаардлагыг тавьсан. Одоогийн байдлаар Үнэт цаас гаргагч нь эцсийн өмчлөгчийн хувьд энэхүү хуульд заасан нэг хувьцаа эзэмшигчийн эзэмших дээд хязгаар болох 20%-ийн шаардлагыг биелүүлсэн байна. Үүнээс үл хамааран Үнэт цаас гаргагч нь нэмэлт хувьцаа гаргах, хөрөнгийн бирж дээр бүртгэл бүхий нээлттэй банк болох ажлыг хэрэгжүүлж байна. Нийтэд шинээр гаргах нэмэлт хувьцааг бүрэн арилжаалсан тохиолдолд Үнэт цаас гаргагчид илүүдэл өөрийн хөрөнгө бий болно. Тус хөрөнгийг Үнэт цаас гаргагчийн стратегийн дагуу эрсдэл, өгөөжийн зохих түвшинд зээл болон бусад бүтээгдэхүүн хэлбэрээр байршуулахад цаг хугацаа шаардагдах магадлалтай.

Зохицуулагч байгууллагаас авч хэрэгжүүлж буй хэрэглээний зээлийн хязгаарлалт болон холбогдох хууль дүрмийн өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн иргэдийн банкны бизнест буюу Үнэт цаас гаргагчийн хэрэглээний зээлийн багцын өсөлт, түүнээс олох хүүгийн орлого, тухайн зээлийн эргэн төлөлтийн чадвар зэрэгт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

**9.3.3. Үнэт цаас гаргагч нь өндөр өрсөлдөөн бүхий зах зээлд үйл ажиллагаа явуулдаг. Өрсөлдөөнөөс үүдэн Үнэт цаас гаргагчийн хүүгийн маржин, зах зээлд эзлэх хувьд дарамт үүсэж, улмаар Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.**

Үнэт цаас гаргагч нь иргэдийн болон байгууллагын банкны бүтээгдэхүүн, үйлчилгээний өрсөлдөөн ихтэй орчинд үйл ажиллагаа явуулдаг. Зах зээлийн гол өрсөлдөгчид нь томоохон системийн банкууд, бусад банкууд, банк бус санхүүгийн байгууллагууд, хамтын

СЭХ 2023 05 12 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

сангууд, жижиг тоглогчид, зээлийн бүтээгдэхүүн санал болгодог санхүүгийн бус компаниуд (автомашины түрээсийн компаниуд гэх мэт), технологийн компаниуд байдаг. Тухайлбал, санхүүгийн бус болон технологийн компаниуд хэрэглээний зээлийн зах зээлд идэвхтэй үйл ажиллагаа явуулж эхэлсэн. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд тавигддаг зохицуулагч байгууллагын шаардлага болон зохицуулалт нь бусад өрсөлдөгч байгууллагуудтай харьцуулахад харьцангуй өндөр байдаг. Иймд шинээр үүсэж буй технологийн компаниуд болон бусад шинэ оролцогчид нь төлбөрийн үйлчилгээ, мобайл төлбөрийн шинэ систем, цахим хэтэвч зэрэг үйлчилгээг түргэн шуурхай нэвтрүүлж Үнэт цаас гаргагчийн бизнестэй хүчтэй өрсөлдөж байна. Ялангуяа эдгээр байгууллагуудын төлбөрийн үйлчилгээний шийдлүүд нь Үнэт цаас гаргагчийн харилцагч татах чадварт сөргөөр нөлөөлж болзошгүй бөгөөд улмаар Үнэт цаас гаргагчийн бизнесийн цар хүрээнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Мөн блокчэйнд суурилсан шинэ технологиуд олон нийтийн сонирхлыг ихээр татаж байгаа нь уламжлалт санхүүгийн салбарт сөрөг нөлөө бүхий томоохон өөрчлөлтийг бий болгож болзошгүй юм.

Өрсөлдөөний хүч нь олон хүчин зүйлээс хамаардаг бөгөөд зарим хүчин зүйлс нь Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуур байдаг. Үүнд санхүүгийн зах зээлийн нөхцөл байдал, санхүүгийн хямралын дараах банкуудад итгэх итгэл, эдийн засаг, хэрэглэгчдийн эрэлт хэрэгцээ, нэр хүнд, бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэ, шинж чанар, түгээлтийн суваг, компаниудын нэгдлийн нөлөөлөл, технологийн өөрчлөлт, шинээр гарч ирж буй инновацилаг өрсөлдөгчид, зохицуулалтын арга хэмжээ, өрсөлдөгчдийн давуу тал болон бусад олон хүчин зүйлс багтдаг. Санхүүгийн бус эсвэл технологид суурилсан бусад өрсөлдөгчидтэй харьцуулахад арилжааны банкуудад зохицуулагч байгууллагын хяналт илүү тавигддаг бөгөөд энэ нь тэгш бус өрсөлдөөнийг бий болгодог. Банкуудын хувьд хяналт шалгалт, шаардлагатай холбоотой зардал өндөр гарах тохиолдол байдаг. Мөн зарим өрсөлдөгчид Үнэт цаас гаргагчтай харьцуулахад илүү их нөөц, санхүүгийн боломжтой байж болно. Нөөцийн давуу тал бүхий өрсөлдөгч банкуудаас ирэх өрсөлдөөн эдийн засаг сайжрахын хэрээр ширүүсч, Үнэт цаас гаргагчийн зах зээлд эзлэх хувийг бууруулж болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь үйлчлүүлэгчдийн тоог нэмэгдүүлэх, хадгалах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний хэмжээг нэмэгдүүлэх үүднээс бизнесийн харилцаа холбоог бэхжүүлэхийг ямагт хичээн ажилладаг. Хэрэв Үнэт цаас гаргагч нь үйлчлүүлэгчидтэй тогтоосон харилцааг хадгалж, бэхжүүлж чадахгүй байдал үүссэн тохиолдолд шинээр харилцагч татах, эсхүл харилцагчаа хадгалж үлдэх чадвар буурах ба улмаар зах зээлд эзлэх байр сууриа алдаж болзошгүй.

ОУВС-гийн хөтөлбөрийн хүрээнд банкны өөрийн хөрөнгийн доод хэмжээг нэмэгдүүлэх болон банкны хувьцаа эзэмшлийн хязгаарлалттай холбоотой зохицуулалтын өөрчлөлтүүдээс шалтгаалан зарим банкууд нэгдэх, нийлэх явдал ажиглагдаж байна. Хэрэв Монгол Улсын банкны салбарт системийн ач холбогдол бүхий банкууд нэгдэх тохиолдолд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй банкны салбарын өрсөлдөөний талбарт нөлөөлж болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь иргэдийн болон байгууллагын банкны харилцагчид, хөрөнгө оруулагчдаас хөрөнгө, эх үүсвэр татах үед ширүүн өрсөлдөөнтэй тулгарч байдаг. Тус өрсөлдөөн ширүүссэн тохиолдолд эх үүсвэрийн зардал нэмэгдэх ба энэ үед Үнэт цаас гаргагч нь зээлийн хүүгээ нэмэх боломжгүй байдал үүсвэл Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа, санхүүгийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Өрсөлдөөний дарамт нь Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээний үнэд дарамт учруулж, эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлэх эсвэл зах зээлд эзлэх хувийг алдахад хүргэж, бизнес, санхүүгийн байдал, ашигт ажиллагаанд материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

ХАСБАНК
INVESTMENT BANK LLC
УЛААНБААТАР ХОТ

**9.3.4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд улс төр, хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн болон бусад олон төрлийн эрсдэлүүд нөлөөлж байдаг.**

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нийгэм, улс төр, эдийн засгийн тогтворгүй байдлын эрсдэлүүд нөлөөлж байдаг. Жишээ нь валют арилжааны хязгаарлалт ба ханшийн хяналт, бусад хязгаарлалтын бодлого, арга хэмжээ, гадаадын хөрөнгө оруулалтын хуулийн өөрчлөлт, гэнэтийн татвар болон бусад төлбөр, улс төр, зохицуулалт, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, эдийн засгийн хориг арга хэмжээ, хөдөлмөрийн хуультай холбоотой өөрчлөлт зэрэг өргөн хүрээний хүчин зүйлс багтаж байдаг. Мөн Засгийн газар санхүүгийн үүргээ биелүүлэхгүй байх нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй байдаг.

Үнэт цаас гаргагч нь зохицуулагчдын зүгээс өөрийн хөрөнгийн болон хөрвөх чадварын шаардлага, дүрэмд оруулах өөрчлөлтийг тодорхой хэмжээнд таамаглаж чаддаг боловч зарим тохиолдолд тухайн өөрчлөлтөд таарах тохиргоог богино хугацаанд хийх боломжгүй байдал үүсдэг. Энэ үед Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үр ашиг буурж, зардал нэмэгдэж болзошгүй. Үнэт цаас гаргагч нь татварын болон хөдөлмөрийн зохицуулалтад гарсан өөрчлөлтүүдтэй өөрийн үйл ажиллагааг уялдуулан өөрчилж байгаагаас үл хамааран Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны үр ашигт байдал болон зардлын удирдлагад сөрөг нөлөө үүсэж болзошгүй.

Улс төр, нийгэм, эдийн засгийн тогтолцооны өөрчлөлт, хууль, эрх зүйн зохицуулалтад орох өөрчлөлт, дайн, үймээн самуун, зэвсэгт мөргөлдөөн зэрэг эрсдэлийн хүчин зүйлсийг урьдчилан таамаглах боломжгүй бөгөөд эдгээр хүчин зүйлс бий болсон тохиолдолд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, ашиг, нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

**9.3.5. Банкны уламжлалт бизнес загвар нь дунд болон урт хугацаанд хоцрогдох буюу бизнес загварт дорвитой өөрчлөлт оруулах шаардлага үүсэж болзошгүй.**

Олон төрлийн зохицуулалт, өөрийн хөрөнгийн өндөр шаардлага, том хэмжээний дэд бүтэц дээр суурилан явагддаг банкны уламжлалт бизнес загвар нь техникийн дэвшил, хууль дүрмийн өөрчлөлт, шинэ өрсөлдөөн зэргээс үүдэн хоцрогдох буюу зах зээлээс шахагдах нөхцөл байдал үүсэж болзошгүй. Энэ үед Үнэт цаас гаргагч нь өөрийн бизнес загварыг өөрчлөн шинэ бизнес чиглэлд төвлөрөх шаардлага үүсэх ба бизнесийн зарим үйл ажиллагааг зогсоож үйл ажиллагааны цар хүрээнд томоохон өөрчлөлт оруулж болзошгүй.

## 9.4 Хөрвөх чадварын эрсдэл

**9.4.1. Хөрвөх чадварын хомсдол нь Үнэт цаас гаргагчийн бизнест эрсдэл учруулах бөгөөд Үнэт цаас гаргагчийн эх үүсвэр, бизнес, санхүүгийн байдал, ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Хөрвөх чадварын эрсдэл нь банкны бизнесийн салшгүй нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагаас хамааран харилцан адилгүй байдаг. Жишээлбэл, санхүүжилтийн тодорхой эх үүсвэрээс хэт хамааралтай байх (богино хугацааны болон овернайт санхүүжилт гэх мэт), зээлжих зэрэглэлийн өөрчлөлт, эх үүсвэрийн нөөц зэргийг дурдаж болно. Хөрвөх чадварын асуудал олон нийтэд тарж, нийтийг хамарсан болгоомжлол зах зээлд бий болсон тохиолдолд харилцагч талууд Үнэт цаас гаргагчид эх үүсвэр олгохоос татгалзах эсвэл хадгаламж эзэмшигчид хадгаламжаа татах нөхцөл байдал үүсэж болзошгүй.

Хэрэв Үнэт цаас гаргагч нь хөрвөх чадвараа үр дүнтэй удирдаж чадахгүйгээс үүдэн Үнэт цаас гаргагч нь төлбөр тооцоо хоцроох, зохицуулагч байгууллагын шалгуур үзүүлэлтийг биелүүлэх боломжгүй болох ба улмаар Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, ашигт ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

**9.4.2. Үнэт цаас гаргагчийн эх үүсвэр нь харилцагчдын хадгаламж болон бусад санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэрээс бүрддэг. Харилцагчдаас хадгаламж татах, бусад санхүүгийн байгууллагаас эх үүсвэр авах боломжгүй болсон тохиолдолд Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадвар, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагчийн эх үүсвэрийн ихэнх хэсгийг иргэдийн болон бизнес банкны харилцагчдаас татсан харилцах, хадгаламж бүрдүүлж байдаг. Энэхүү харилцах, хадгаламжийн хэмжээ нь Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуур байдаг хэд хэдэн хүчин зүйлийн нөлөөгөөр хэлбэлзэх магадлалтай. Иргэд, бизнесийн байгууллагуудын банкны системд итгэх итгэл, өрсөлдөөн, гадагш чиглэсэн мөнгөн урсгал зэрэг нь богино хугацаанд банкны систем дахь харилцах хадгаламжийн хэмжээнд шууд нөлөөлдөг. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар харилцах хадгаламжийн нийт дүн 2,416 тэрбум төгрөг буюу Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 61.5%-тай тэнцэж байна. Үнэт цаас гаргагчийн хадгаламж татах чадвар дээр дурдсан хүчин зүйлсээс шалтгаалан муудсан тохиолдолд Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадвар болон эх үүсвэрийн хэрэгцээг хангах чадварт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Мөн Үнэт цаас гаргагч нь харилцах, хадгаламжаас гадна олон улсын санхүүгийн байгууллагуудаас татсан эх үүсвэрээр өөрийн үйл ажиллагааг санхүүжүүлдэг. Олон улсын зах зээл дээрх нөхцөл байдал, банкинд системд итгэх итгэл зэрэг Үнэт цаас гаргагчийн хяналтаас гадуур байдаг хүчин зүйлсээс шалтгаалан Үнэт Цаас гаргагчийн гадаад эх үүсвэр татар чадвар өөрчлөгдөж байдаг. 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар Үнэт Цаас гаргагчийн олон улсын санхүүгийн байгууллагаас татсан эх үүсвэр 720 тэрбум төгрөг буюу Үнэт цаас гаргагчийн нийт хөрөнгийн 18.3%-тай тэнцэж байна.

Зэх зээлд хөрвөх чадварын хомсдол удаан үргэлжилсэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь ердийн үетэй харьцуулахад өндөр өртгөөр эх үүсвэр татах, эх үүсвэрийн шинэ суваг хайх нөхцөл байдал үүсэж болзошгүй. Энэ нь Үнэт цаас гаргагчийн хөрвөх чадвар, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

**9.4.3. Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл буурах эсвэл буурах хүлээлт үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагчийн эх үүсвэр татах чадвар буурах, эх үүсвэрийн зардал өсөх эрсдэлтэй. Энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөв, санхүүгийн байдал, өрсөлдөх чадвар, нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.**

Үнэлгээний агентлагууд Үнэт цаас гаргагчийн эрсдэл даах чадвар болон үйл ажиллагааны орчныг үнэлж, зээлжих зэрэглэл тогтоодог. Үнэт цаас гаргагч нь дараах зээлжих зэрэглэлтэй байна. Moody's: B3 тогтвортой төлөвтэй (хамгийн сүүлд 2022 оны 7 дугаар сард шинэчлэгдсэн) болон Fitch Ratings Ltd: B тогтвортой төлөвтэй (хамгийн сүүлд 2022 оны 8 дугаар сард шинэчлэгдсэн).

Үнэлгээний агентлагийн үнэлгээ нь олон төрлийн хүчин зүйлс дээр суурилдаг. Зарим хүчин зүйлс нь Үнэт цаас гаргагч болон түүний гаргаж буй санхүүгийн хэрэгслүүдийн онцлог шинж чанартай холбоотой байдаг бол зарим нь эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал болон макро эдийн засгийн орчны өөрчлөлт, Монгол Улсын зээлжих зэрэглэл зэрэг Үнэт Цаас гаргагчийн хяналтаас гадуурх бусад хүчин зүйлстэй холбоотой байдаг. Бодит байдал дээр байгууллагын зээлжих зэрэглэл нь үйл ажиллагаа явуулж буй улсын зээлжих зэрэглэлээр хязгаарлагддаг тул Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл нь Монгол Улсын зээлжих зэрэглэлээс шууд хамаарч байдаг. Зээлжих зэрэглэл тогтоох агентлаг нь зээлжих зэрэглэлийг хэрхэн өөрчлөх талаар урьдчилан таамаглахад хүндрэлтэй байдаг. Түүнчлэн үнэлгээний агентлагууд үнэлгээний аргачлалаа тодорхой давтамжтайгаар өөрчилдөг бөгөөд энэ үед Үнэт цаас гаргагчийн зээлжих зэрэглэл буурч болзошгүй.

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Зээлжих зэрэглэл буурснаар Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн зах зээлд оролцох эрх хязгаарлагдах, боломжит хөрөнгө оруулагчид багасах, эх үүсвэрийн өртөг нэмэгдэх, эх үүсвэр татах боломж багасах, зарим бизнесийн үйл ажиллагаа зогсох зэрэг сөрөг нөлөө үүсэж болзошгүй. Энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөв, санхүүгийн байдал, өрсөлдөх чадвар, нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй.

## 9.5 Зах зээлийн эрсдэл

**9.5.1. Зээлийн хүү болон гадаад валютын ханшийн өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагчийн бизнес буюу банк санхүүгийн бизнест зах зээлийн эрсдэл ямагт нөлөөлж байдаг. Зах зээл дэх хүүгийн түвшний хөдөлгөөн болон валютын ханшийн тогтворгүй байдал нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд шууд нөлөөлж зарим тохиолдолд хүүгийн орлогыг бууруулах, зардлыг өсгөх, ирээдүйн мөнгөн урсгалд нөлөөлөх зэрэг сөрөг үр дагавартай байж болзошгүй.

Жишээлбэл, зах зээл дэх хүүгийн түвшин өсөж байгаа үед Үнэт цаас гаргагчийн орлого олдог актив буюу зээлийн багцын өгөөж эх үүсвэрийн зардлаас удаан өссөн тохиолдолд Үнэт цаас гаргагчийн хүүгийн зардал хүүгийн орлогоос хурдан өсөж, Үнэт цаас гаргагчийн цэвэр хүүгийн орлого буурах эрсдэлтэй. Энэ нь Үнэт цаас гаргагчийн ирээдүйн ашиг орлого, мөнгөн урсгалд сөргөөр нөлөөлж болзошгүй. Зах зээлийн хүүгийн түвшинг урьдчилан таамаглахад хэцүү байдаг тул Үнэт цаас гаргагч нь хүүгийн эрсдэлийг зөв удирдах шаардлагатай байдаг.

Мөн түүнчлэн, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь валютын ханшийн өөрчлөлт ихээхэн нөлөө үзүүлж байдаг. Жишээлбэл, гадаад валютаар авсан зээл, эх үүсвэрийг ханшийн өөрчлөлтөөс хамгаалах зорилгоор своп хэлцэл хийж болдог. Тухайн своп хэлцлийн хэмжээ нь авсан зээл буюу эх үүсвэрээс хэмжээ эсхүл хугацааны хувьд зөрүүтэй, эсвэл своп хэлцэл хийсэн эсрэг тал нь үүргээ биелүүлэх боломжгүй нөхцөл байдал үүссэн тохиолдолд Үнэт цаас гаргагч нь ханшийн эрсдэлд орох бөгөөд үйл ажиллагааны үр дүн, мөнгөн урсгал, ашигт сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын үйл ажиллагаандаа төрөл бүрийн гадаад валютаар арилжаа хийн үйлчлүүлэгчдийн хэрэгцээнд нийлүүлж байдаг ба тус арилжаанаас үүдэн гадаад валютын нээлттэй позиц үүсэж байдаг. Үнэт цаас гаргагчийн зүгээс энэхүү нээлттэй позицийг зөв зохистой удирдах үүднээс дотоод болон гадаад харьцаа үзүүлэлтийг даган мөрдөж эрсдэлийн хэмжээг удирддаг. Гадаад валютын позицийг зөв удирдаагүй үед ханшийн огцом хөдөлгөөн нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

Эдгээр эрсдэл нь Үнэт цаас гаргагчид шууд нөлөөлөхөөс гадна шууд бусаар буюу харилцагч, үйлчлүүлэгчээр дамжуулан нөлөөлж болдог. Жишээлбэл, ханшийн эрсдэлийг буруу удирдсан үйлчлүүлэгч нь алдагдал хүлээн, Үнэт цаас гаргагчаас авсан зээл болон гэрээний үүргээ биелүүлэх боломжгүй байдал үүсэж болзошгүй.

## 9.6 Үйл ажиллагааны эрсдэл

**9.6.1. Үнэт цаас гаргагчийн хөрөнгө босгох чадвар, нэр хүнд, санхүүгийн байдал, ашигт ажиллагаа, үйл ажиллагааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлж болохуйц үйл ажиллагааны эрсдэлийн төрлүүд байдаг.**

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд эдийн засаг, бизнесийн орчны тодорхойгүй нөхцөл байдлаас үүдэн үйл ажиллагааны эрсдэл бий болох ба үйл ажиллагааны эрсдэл нь

ХАСБАНК
УХ84937 257369

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

дотоодын процесс, хүний хүчин зүйлс, мэдээллийн технологийн аюулгүй байдал болон гадаад орчны нөлөөллийн улмаас бий болдог.

Үнэт цаас гаргагчийн хувьд бүтээгдэхүүн, үйлчилгээгээ харилцагчдад хүргэж, өдөр тутмын үйл ажиллагаагаа хэвийн явуулахад технологийн дэд бүтэц, эрсдэлийн удирдлага, хяналтын процесс зэрэг нь чухал үүрэг гүйцэтгэдэг. Эдгээр үйл ажиллагаанд ашиглаж буй техникийн шийдэл нь хангалтгүй тохиолдолд зөрчил, ашиглан зэрэг сөрөг үр дагавар үүсэж болзошгүй. Үүнээс үүдэн Үнэт цаас гаргагч нь алдагдал хүлээх, захиргааны арга хэмжээнд орох, улмаар нэр хүндийн эрсдэлд орж болзошгүй. Хэрэв технологийн шийдлийг зөв зохистой, үр дүнтэйгээр ашиглаж чадвал уг эрсдэлүүдийг бууруулах боломжтой байдаг.

Үйл ажиллагааны эрсдэлийн төрлүүд:

- **Хүний хүчин зүйлийн дотоод эрсдэл.** Үүнд Үнэт цаас гаргагчийн ажилтан Монгол Улсын холбогдох хууль тогтоомж болон Үнэт цаас гаргагчийн эрх зүйн баримт бичгийг зөрчсөн үйлдлийн улмаас нэр хүндийн болон эд хөрөнгийн хохирол учрахыг ойлгох ба Үнэт цаас гаргагчийн эд хөрөнгийг залилан мэхлэх, завшин үрэгдүүлэх, хууль тогтоомж зөрчих, эрх мэдлээ урвуулан болон хэтрүүлэн ашиглах зэргээр илэрнэ.
- **Хүний хүчин зүйлийн гадаад эрсдэл.** Үүнд Үнэт цаас гаргагчийн ажилтнаас бусад этгээдийн Монгол Улсын холбогдох хууль тогтоомж зөрчсөн үйлдлийн улмаас нэр хүндийн болон эд хөрөнгийн эрсдэл учрахыг ойлгоно.
- **Хянан нийцүүлэлтийн эрсдэл.** Үүнд Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авч буй болон нийлүүлж буй талын ажилтны холбогдох хууль, дүрэм журмыг зөрчсөн үйлдлийн улмаас учрах эрсдэлийг ойлгоно.
- **Хөдөлмөрийн харилцаанаас үүсэх эрсдэл.** Үүнд Үнэт цаас гаргагчийн ажилтан болон ажил горилогчийн холбогдох хууль, тогтоомж, эрх зүйн актад заасан эрхийг хязгаарласан үйлдэл, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн нөхцөл байдалтай холбоотой маргааны улмаас учрах эрсдэлийг ойлгоно.
- **Харилцагч, бүтээгдэхүүн үйлчилгээ болон бизнесийн харилцааны эрсдэл.** Үүнд бизнесийн зохисгүй эсхүл алдаатай үйл ажиллагаа, харилцагчийн мэдээллийн нууцлалтай холбогдох аливаа асуудал, бүтээгдэхүүн үйлчилгээг болон бусад үйл ажиллагаанд ашиглаж буй загвар, аргачлалын алдаа, дутагдалтай холбоотойгоор учрах эрсдэлийг ойлгоно.
- **Эд хөрөнгөд учрах эрсдэл.** Үүнд гэнэтийн осол эсхүл давагдашгүй хүчин зүйлийн улмаас Үнэт Цаас гаргагчийн эд хөрөнгөд хохирол учрах эрсдэлийг ойлгоно.
- **Системийн доголдолтой холбоотой эрсдэл.** Үүнд мэдээллийн технологийн систем, программ хангамж, тоног төхөөрөмжийн үйл ажиллагаа болон дэд бүтцэд үүссэн доголдол, саатал, тасалдлын улмаас үүсэх эрсдэлийг ойлгоно.
- **Бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх, тайлагнах болон хянах үйл ажиллагаанаас үүсэх эрсдэл.** Үүнд харилцагчийн мэдээлэл, дансны удирдлагатай холбогдох үйл ажиллагааны доголдол, бүтээгдэхүүн үйлчилгээ үзүүлэх болон гүйлгээ хийх үйл ажиллагаанд үүсэх аливаа доголдол, бусад харилцагч түншүүд болон бэлтгэн нийлүүлэгчдийн харилцаанаас үүсэх эрсдэлийг ойлгоно.
- **Хяналт шалгалттай холбоотой эрсдэл.** Үүнд холбогдох хууль тогтоомж, дүрэм журмын хэрэгжилт болон харилцагч, талуудын гэрээний үүргээ биелүүлж буй байдалд хэрэгжүүлж буй хяналтыг буруу, дутуу хийснээс бий болох эрсдэлийг ойлгоно.

ХАСБАНК

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

- **Нэр хүндийн эрсдэл.** Үүнд Үнэт цаас гаргагч, түүний бизнес болон харилцагчдын нэр хүндэд сөргөөр нөлөөлөх аливаа эрсдэлийг ойлгоно.

Үнэт цаас гаргагч нь эрсдэлийн удирдлага, эрсдэлийг бууруулах болон хяналтын үйл ажиллагааг хэрэгжүүлэх үйл ажиллагаандаа ихээхэн хэмжээний нөөц боломжийг зарцуулж байгаа болович эдгээр нь үйл ажиллагааны эрсдэлийг үр дүнтэйгээр удирдах баталгаа болохгүй юм. Аливаа үйл ажиллагааны эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд материаллаг хэмжээний сөрөг нөлөө үзүүлж болох ба хөрөнгө босгох чадвар, нэр хүнд, санхүүгийн байдал, ашигт ажиллагаа, үйл ажиллагааны үр дүнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

**9.6.2. Үнэт цаас гаргагч нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, хянах, шинэчлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг ба энэ үйл ажиллагааг эсхүл хяналтыг буруу хэрэгжүүлсний улмаас хянан нийцүүлэлтийн, торгууль, шийтгэлийн зэрэг эрх зүйн болон нэр хүндийн эрсдэлүүд бий болдог.**

Үнэт цаас гаргагч нь шинэ бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлэх, хянах, шинэчлэх үйл ажиллагааг тогтмол хэрэгжүүлдэг бөгөөд үүнд зээл, харилцах, хадгаламж, төлбөр тооцоо зэрэг бүх бүтээгдэхүүн, үйлчилгээг хамруулдаг. Бүтээгдэхүүн үйлчилгээ нэвтрүүлж, шинэчлэхэд холбогдох хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын аливаа шаардлагад нийцүүлэх бөгөөд дотоодын болон олон улсын стандарт, арга аргачлалыг нэвтрүүлэхийг зорьж ажилладаг. Мөн тухайн бүтээгдэхүүн үйлчилгээ нь зах зээлд эрэлт хэрэгцээтэй, үр ашигтай эсэхэд хяналт тавьж ажилладаг.

Бүтээгдэхүүн үйлчилгээтэй холбоотой гаргасан буруу шийдвэр, холбогдох хууль тогтоомж, дүрэм журмыг зөрчих, эсхүл хяналтын үйл ажиллагааг буруу хэрэгжүүлсний улмаас тухайн бүтээгдэхүүн үйлчилгээг зах зээлд амжилттай нэвтрүүлж чадахгүй байх, улмаар хянан нийцүүлэлтийн, торгууль, шийтгэлийн зэрэг эрх зүйн болон нэр хүндийн эрсдэлүүд бий болдог.

**9.6.3. Үнэт цаас гаргагч нь эрсдэлийг удирдах зорилгоор эрсдэлийн загваруудыг ашигладаг бөгөөд загварт ашиглагддаг таамаг, төсөөллүүд нь тухайн цаг үе, нөхцөл байдалтай нийцэхгүй болсны улмаас буруу үр дүн гарах, улмаар Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа болон санхүүгийн үзүүлэлтүүдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч нь үйл ажиллагаандаа ашигладаг эрсдэлийн загваруудын үр дүнд үндэслэн гаргасан шийдвэр нь буруу байх, эсхүл загварыг буруу хөгжүүлж, хэрэгжүүлсний улмаас алдагдалд орох эрсдэлтэй. Энэ эрсдэл нь загваруудад ашигласан тоон мэдээлэл алдаатай байх, чанар, дэвшүүлсэн таамаг төсөөллийн хэрэгжих магадлал бодитой бус байх, загварын ашиглалт болон дүгнэлт буруу, дутуу эсхүл техник технологийн сул байдал зэргээс шалтгаалан үүсдэг.

Үнэт цаас гаргагч нь төрөл бүрийн эрсдэлийн загвар, хүндрэлтэй нөхцөлийн төсөөлөл, мэдрэмтгий байдлын шинжилгээ болон бусад эрсдэлийн үнэлгээний аргачлалуудыг ашигладаг болович эдгээр аргачлалыг ашиглан бүх эрсдэлийг тодорхойлох, огт эрсдэлгүй болгох боломжгүй юм. Үнэт цаас гаргагчийн эрсдэлийг удирдах зарим хэрэгсэл, хэмжүүрүүд нь зах зээлийн түүхэн мэдээлэлд суурилдаг бөгөөд эрсдэлийн хэмжээг тооцохын тулд статистик аргачлал болон бусад хэрэгслийг ашигладаг. Эдгээр арга хэрэгсэл, хэмжүүрүүд нь ирээдүйд бий болж болзошгүй эрсдэлийг алдаатайгаар таамаглах магадлалтай тул Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа, санхүүгийн байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй.

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Үнэт цаас гаргагч нь эдийн засгийн нөхцөл байдал, хүлээгдэж буй эрсдэл зэрэгт хийсэн хөндлөнгийн болон дотоодын үнэлгээ, активын багцын төрөл, барьцааны хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулах боломж зэрэгт үндэслэн зохицуулагч байгууллагын холбогдох журам, зааврын дагуу зээлийн эрсдэлийн санг байгуулдаг. Хөндлөнгийн болон дотоодын үнэлгээний арга аргачлал нь зарим талаараа дутмаг, буруу байж болох бөгөөд энэ тохиолдолд зээлийн эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх эсхүл бууруулах шаардлага гарч болно. Зээлийн эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлэх, байгуулсан эрсдэлийн сангийн хэмжээнээс өндөр дүнгээр алдагдал хүлээх болон үнэ цэнийн бууралттай зээлийн багцын хэмжээ нэмэгдэх зэрэг тохиолдлуудад Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа болон санхүүгийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж болно.

Үнэт цаас гаргагч нь эсрдэлийн загваруудад дэвшүүлсэн таамаглал, төсөөллийг бодит нөхцөл байдал, хууль эрх зүй, зохицуулалтын өөрчлөлтүүдтэй уялдуулан шинэчилдэг бөгөөд загваруудад орсон эдгээр өөрчлөлтүүд нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, өөрийн хөрөнгийн хүрэлцээ зэрэг санхүүгийн үзүүлэлтүүдэд нөлөөлж, санхүүгийн алдагдалд хүргэж болзошгүй. Мөн Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн үйлчилгээний үнийн бодлогодоо өөрчлөлт оруулах шаардлагатай болдог. Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг тогтоодог аргачлал нь үнийг бодитой тогтооход дутагдалтай байж болох бөгөөд бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг буруу тогтоох эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа, ирээдүй хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болно.

Мөн тоон загварчлал бүхий загварууд нь бүх төрлийн эрсдэлийг харгалзахгүй эсхүл зарим тоон мэдээлэл байхгүй, хангалтгүй зэрэг шалтгааны улмаас мэргэжлийн ур чадвар, туршлагад суурилан эрсдэлийг үнэлж дүгнэдэг. Энэ нь тоон загварчлал бүхий загваруудтай харьцуулахад үнэн зөв байх магадлал бага тул урьдчилан тооцоолоогүй эсхүл буруу тооцоолсон эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болно.

Үнэт цаас гаргагчийн эрсдэлийн удирдлагад ашигладаг загваруудыг сайжруулж боловсронгуй болгосноор Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа болон санхүүгийн үзүүлэлтүүдэд үзүүлэх сөрөг үр дагаврыг бууруулж болно.

**9.6.4. Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэгч гуравдагч талуудаас шууд хамааралтай байдаг. Эдгээр гуравдагч талууд нь бүтээгдэхүүн үйлчилгээгээ цаг тухайд нь бүрэн гүйцэт нийлүүлэхгүй байх эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт болон хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болно.**

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа нь бүтээгдэхүүн үйлчилгээ нийлүүлэгч гуравдагч талуудаас шууд хамааралтай байдаг. Ач холбогдол бүхий үйлчилгээ үзүүлэгч гуравдагч талууд нь Монголбанкны RTGS, картын процессын систем, олон улсын төлбөр тооцооны SWIFT сүлжээ зэргийг нийлүүлэгч байгууллагууд байдаг бөгөөд тэдний үйл ажиллагаа, системд доголдол, тасалдал бий болоход Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа доголдож, бүтээгдэхүүн үйлчилгээг харилцагчдадаа цаг тухайд нь хүргэж чадахгүй байх эрсдэл бий болдог. Эдгээр эрсдэл учрах нь Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, бизнесийн үйл ажиллагаа, ашигт ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

**9.6.5. Үнэт цаас гаргагч нь санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцүүлэн гаргахын тулд ашигласан зарим таамаглал нь алдаатай байх тохиолдол нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт, өөрийн хөрөнгийн хүрэлцээ зэрэгт материаллаг хэмжээний нөлөө үзүүлж болзошгүй**

ХАСБАНК
УАН4937 2578697

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартад нийцсэн санхүүгийн тайлан бэлтгэхийн тулд зарим таамаглалыг дэвшүүлдэг бөгөөд эдгээр нь санхүүгийн тайлангийн нийт хөрөнгө, өр төлбөр, эзэмшигчийн өмч, орлого, зардлын хэмжээнд нөлөөлдөг. Таамаглал дэвшүүлэхэд тохиолддог тодорхой бус байдлын улмаас ирээдүйн тайлант үеийн бодит үр дүн нь таамаглалаас ялгаатай байж болно. Тухайлбал шүүхийн нэхэмжлэлтэй холбоотой асуудлыг таамаглах, хууль эрх зүйн зохицуулалтын шийдвэрийг оновчтой тусгахад хүндрэлтэй байдаг тул нэмэлт эрсдэлийн сан байгуулах шаардлага гарч болно.

Үнэлгээ, тооцоолол, таамаглал нь түүхэн хугацааны үйл явц болон бусад хүчин зүйлс, тухайлбал аливаа ирээдүйн үйл явдлыг үндэслэлтэй гэж үзсэн таамаглал зэрэгт тулгуурлан байнга өөрчлөгдөж байдаг. Нягтлан бодох бүртгэлийн таамаглалд өөрчлөлт орох тохиолдолд өөрчлөлт орох тайлант хугацаанд эсхүл ирээдүйн тайлант хугацаанд тэдгээр өөрчлөлтүүдийг хүлээн зөвшөөрдөг. Үнэт цаас гаргагчийн хувьд чухал ач холбогдолтой гэж үзсэн нягтлан бодох бүртгэлийн бодлого болон бүртгэлд санхүүгийн болон санхүүгийн бус хөрөнгийн үнэ цэнийн бууралтын бүртгэл, үл хөдлөх эд хөрөнгийн үнэлгээ, эрсдэлийн сан, орлогын албан татвар, хөрөнгө, өр төлбөр, болзошгүй өр төлбөр, нэгтгэл болон задаргаа зэрэг зүйлс багтдаг. Хэрэв Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн санхүүгийн тайланд буруу дүгнэлт, тооцоолол, таамаглал ашигласан нь тогтоогдвол энэ нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдэд материаллаг нөлөө үзүүлж болзошгүй.

**9.6.6. Үнэт цаас гаргагч нь мэдээ мэдээллийн бүртгэлийг үнэн зөв хийх, бичиг баримтын бүрдлийг хангах, архивлах шаардлагатай байдаг бөгөөд энэ үйл ажиллагаанд алдаа дутагдал гарах тохиолдолд хууль, дүрэм, журам зөрчих, шүүхийн байгууллагад нотлох баримт гаргаж өгөх, бүртгэл, гүйлгээ, төлбөр тооцоонд хяналт тавих чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүйд хүргэх эрсдэлтэй. Энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, нэр хүнд болон санхүүгийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлж болно.**

Үнэт цаас гаргагч нь мэдээ мэдээллийн бүртгэлийг үнэн зөв хийх, бичиг баримтын бүрдлийг хангах, архивлах шаардлагатай байдаг. Бичиг баримтын бүрдэл дутуу, хангалтгүй, мэдээ мэдээллийн бүртгэл муу, дутуу, архив үүсгээгүй, бичиг баримтын эх хувийг хадгалаагүй, бичиг баримт, мэдээ, мэдээллийг алдагдуулах зэрэг нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болно.

Харилцагчдад техник технологийн дэвшил, цахим сувгийг ашиглан бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэх нь энэ төрлийн эрсдэлийг нэмэгдүүлдэг. Жишээлбэл, харилцагч интернэт болон ухаалаг төхөөрөмжийг ашиглан бүтээгдэхүүн үйлчилгээг цахим сувгаар авсан тохиолдолд бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэгч Үнэт Цаас гаргагчийн хувьд харилцагчийн мэдээ мэдээллийг хадгалах, тоон гарын үсгийг ашиглан бичиг баримттай танилцсан байдлыг баталгаажуулах зэрэг нь илүү хүндрэлтэй болдог. 9.6.8 Үнэт цаас гаргагчийн мэдээллийн технологийн системийн тасалдал, доголдол нь дүрэм журам, гэрээний үүргээ зөрчихөд хүргэж, Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд, хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлж болно гэсэн хэсэгтэй танилцана уу.

Хэрэв эрх зүйн бичиг баримт болон төлбөр тооцоо, гүйлгээтэй холбоотой бичиг баримтуудыг зохих ёсны дагуу бүрдүүлж, хадгалаагүй, харилцагчийн тоон эсхүл бодит гарын үсгээр тухайн бичиг баримтыг баталгаажуулаагүйгээс холбогдох хууль, эрх зүй, дүрэм журмыг зөрчих, аливаа бизнесийн шийдвэр гаргалтад эсхүл хяналт шалгалтын байгууллагад шаардлагатай бичиг баримтыг цаг хугацаанд нь гаргаж өгч чадахгүй байх эрсдэл бий болдог.

Үнэт цаас гаргагч нь харилцагчийн эсхүл гүйлгээтэй холбоотой бичиг баримтыг дутуу бүрдүүлсэн тохиолдолд харилцагчаас гэрээний дагуу үүргээ биелүүлэхийг шаардаж

чадахгүй байх нөхцөлд хүргэдэг. Үнэт цаас гаргагч нь бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлж байх явцад харилцагч талаас авсан мэдээ мэдээлэл, бичиг баримтыг баталгаажуулж, эсхүл тэдгээрийн бүрдлийг бүрэн гүйцэт хангуулж чадаагүй тохиолдолд бичиг баримт, мэдээ мэдээллийг нотлох болон хяналтын чиг үүргээ хэрэгжүүлж чадахгүй болох бөгөөд энэ нь торгууль, шийтгэл төлөх зэрэг зохицуулалтын арга хэмжээнд орох эрсдэлийг бий болгодог. Үнэт цаас гаргагчийн бизнесийн онцлог, олон тооны ижил төстэй гэрээ, хэлцэл бэлтгэх зэргээс үүдэлтэй нэг жижиг алдаа нь томоохон эрсдэлийг дагуулж байдаг.

Тиймээс Үнэт цаас гаргагч нь бичиг баримтын бүрдэл, мэдээ мэдээллийн бүртгэлийн зохистой системийг бий болгох, харилцагч талуудаас тухай бүрт шаардлагатай мэдээ, мэдээллийг авах үйл ажиллагааг буруу, дутуу хэрэгжүүлэхэд торгууль, шийтгэл төлөх нөхцөл байдал бий болох ба энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, нэр хүнд, санхүүгийн үзүүлэлтүүдэд сөргөөр нөлөөлдөг.

**9.6.7. Үнэт цаас гаргагч болон түүний удирдлага нь Үнэт цаас гаргагчийн өөрийн, болон харилцагч талуудын талаарх мэдээллийн үнэн зөв, бүрэн бүтэн байдлыг хангаж ажилладаг. Хэрэв эдгээр мэдээллүүд байхгүй, бодитой бус, бүрэн бус, шинэчлэгдээгүй эсхүл буруу бол энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд, нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч нь харилцагчдын мэдээллийн баазыг бий болгох, тэдний төлбөр тооцоог гүйцэтгэхийн тулд Мөнгө угаах, терроризмтой тэмцэх үйл ажиллагааны шаардлагыг дагаж мөрдөх, эрсдэлд орохоос урьдчилан сэргийлэхийн тулд тодорхой мэдээллийг харилцагчдаас авдаг. Жишээлбэл, Үнэт цаас гаргагч нь харилцагчдад зээл олгох эсхүл ажил үйлчилгээ үзүүлэх эсэхийг шийдэхийн тулд тэдний өгсөн мэдээлэл, түүний дотор санхүүгийн тайлан болон бусад санхүүгийн мэдээлэлд тулгуурлан шинжилгээ хийдэг. Үнэт цаас гаргагч нь харилцагч болон бусад талуудын аудитын компаниар баталгаажсан санхүүгийн тайлан, төрийн байгууллагаас тэдний талаар өгсөн лавлагаа зэргийг шийдвэр гаргалтад ашигладаг.

Хэрэв Үнэт цаас гаргагч нь холбогдох мэдээллийг аваагүй, эсхүл хүлээн авсан, бүртгэсэн мэдээлэл нь хангалтгүй, үнэн зөв бус, шинэчлэгдээгүй, бүрэн бус байвал буруу шийдвэр гаргах, зээлийг хэтрүүлэн олгох зэрэг эрсдэл бий болдог. Энэ нь Үнэт цаас гаргагчийг хууль, дүрэм, журмыг зөрчих, харилцагч нь хориг арга хэмжээнд өртсөн байгааг илрүүлж чадахгүй байх эсхүл харилцагчид тохироогүй бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлэх зэргээр харилцагч болон гуравдагч этгээдийн өмнө хүлээсэн үүргээ зөрчихөд хүргэж болзошгүй юм. Мөн харилцагч эсхүл бусад талуудын мэдээлэл буруу эсвэл бүрэн бус байгаа нь Үнэт цаас гаргагч нь хяналт шалгалтын байгууллага, татварын албанд буруу эсвэл бүрэн бус мэдээлэл өгөх эсвэл мэдээллийг цаг тухайд нь өгч чадахгүй байх шалтгаан болдог.

Харилцагчид болон бусад талуудын талаарх мэдээлэл байхгүй, бодитой бус, хангалтгүй, шинэчлэгдээгүй эсхүл бүрэн бус байвал торгууль, шийтгэл төлөх ба энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд, нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж болно. Үнэт цаас гаргагч нь нэг харилцагч болон түүний харилцан хамаарал бүхий этгээдэд олгох зээлийн дээд хэмжээ эсхүл аль нэг эдийн засгийн салбарт олгох зээлийн хэмжээнд хязгаарлалтуудыг тогтоодог. Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын удирдлага хангалтгүй байвал энэ нь төвлөрлийн эрсдэл бий болох, холбогдох дүрэм, журмыг зөрчиж, эрсдэлд ороход хүргэж болзошгүй юм. Мөн Үнэт цаас гаргагчийн гаргаж буй стратегийн шийдвэрүүд нь анхны өгөгдлийн үнэн зөв байгаа эсэхээс ихээхэн хамаардаг. Жишээлбэл, санхүүгийн гүйцэтгэл, санхүүгийн үзүүлэлтүүдийн талаарх мэдээлэл эсхүл "эрсдэлээр жигнэсэн актив", "активын чанар" эсхүл өөрийн хөрөнгө болон хөрвөх чадварын хэмжээг тооцоолоход ашигласан мэдээлэл буруу байвал гаргасан стратегийн шийдвэрүүдэд сөрөг нөлөө учирч болзошгүй.

СЗХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

Цаашилбал зохих шийдвэр гаргахад шаардлагатай мэдээ, мэдээлэл бэлэн биш эсхүл системээс тайлан мэдээ татах боломжгүй болох зэрэг бэрхшээлүүд учирч болно. Энэ тохиолдолд Үнэт цаас гаргагч нь бусад системүүд болон өөрийн бизнесийн нэгжүүдээс өгөгдлийг гараар цуглуулж, тайлагналын шаардлагад нийцсэн маягтын дагуу тайлан мэдээг бэлтгэх шаардлагатай болдог. Үнэт цаас гаргагчийн удирдлагад шаардлагатай мэдээллийн чанар хангалтгүй, эсхүл бүрэн бус, шинэчлэгдээгүй, ашиглах боломжгүй болсноос, гарч болох алдааг зохих ёсоор үнэлээгүйгээс Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, нэр хүндэд сөрөг нөлөө учирч болзошгүй.

**9.6.8. Үнэт цаас гаргагчийн мэдээллийн технологийн системийн тасалдал, доголдол нь дүрэм журам, гэрээний үүргээ зөрчихөд хүргэж, Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд, хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлж болно.**

Үнэт цаас гаргагчийн технологийн дэд бүтэц нь бизнесийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн, үйлчилгээг харилцагчдад хүргэхэд чухал ач холбогдолтой байдаг. Нөөц системүүд болон болзошгүй нөхцөл байдлын төлөвлөгөөнүүд байдаг хэдий ч эдгээр нь процесс, системийн хүчин чадал, аюулгүй байдалд тасалдал, доголдол, зөрчлүүд гарахгүй, гарсан тохиолдолд асуудлыг түргэн шуурхай залруулах боломжтой эсэх талаар баталгаа болохгүй.

Харилцагч өөрийн дансны мэдээлэлд хандаж чадахгүй, гүйлгээ, төлбөр тооцоогоо гүйцэтгэж чадахгүй болох нь Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх ба улмаар тухайн асуудлыг засч залруулахад ихээхэн хэмжээний зардал гарч болзошгүй бөгөөд одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн зохицуулалтаар тухайн харилцагчдад нөхөн төлбөр төлөх зэрэг сөрөг үр дагаврыг бий болгодог.

Үнэт цаас гаргагчийн интернэт болон мобайл банкны үйл ажиллагаа богинохон хугацаанд тасалдахад л банкны үйлчилгээг тасралтгүйгээр хэрэгжүүлэх нь ямар ач холбогдолтой болохыг харуулдаг бөгөөд энэ болзошгүй эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж болно.

Мэдээллийн технологийн тасалдал, доголдол нь дараах нөхцөл байдал бий болоход хүргэж болно. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа болон харилцагчдад бүтээгдэхүүн үйлчилгээг цаг хугацаанд нь түргэн шуурхай хүргэхэд саад болох;
- Удирдлагын мэдээллийн системийн алдаа, доголдол үүсэх;
- Үнэт цаас гаргагч нь зохицуулагч байгууллагад шаардлагатай тайлан мэдээг цаг тухайд нь үнэн зөв гаргаж өгч чадахгүй болох, улмаар хууль, дүрэм журам зөрчих;
- Хүний хүчин зүйлсээс үүсэх дотоод болон гадаад эрсдэлийг удирдаж чадахгүй болох. Жишээлбэл, Үнэт цаас гаргагчийн ажилтан эсхүл гуравдагч этгээдийн хууль, дүрэм журам зөрчсөн үйлдэл, эс үйлдэл, санаатай болон санамсаргүй үйлдсэн эс үйлдлүүдийг цаг тухайд нь илрүүлж чадахгүй болох;
- Мэдээ, мэдээлэл алдах, улмаар хууль дүрэм зөрчих, нэр хүндийн эрсдэлд орох;
- Мэдээ, мэдээллийг гар аргаар цуглуулах, бэлтгэх, тэдгээрийг баталгаажуулах зэргээр их хэмжээний зардал гаргах.

Техник технологийг үр ашигтайгаар ашиглан автоматжуулалтыг хийх нь Үнэт цаас гаргагчийн хяналтын тогтолцоонд чухал үүрэг гүйцэтгэдэг. Хяналтын тогтолцоонд техник технологийг ашиглаагүйгээс аливаа зөрчил, эс үйлдэхүйг цаг тухайд нь илрүүлж, тайлагнаж чадахгүй байх улмаар эрсдэлийн тохиолдол, ашиглангийн шинж чанар бүхий үйлдлүүд бий болсноор санхүүгийн алдагдалд хүрэх, торгууль шийтгэл төлөх, нэр хүндийн эрсдэлд орох

ХАСБАНК

зэрэг эрсдэлүүд бий болдог. Тиймээс техник технологийн боломжуудыг ашиглан хяналтын үйл ажиллагааг автоматжуулах нь энэ төрлийн эрсдэлүүдээс сэргийлэх, бууруулах ач холбогдолтой.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, харилцаа холбоо, мэдээллийн системийн тасалдал, доголдлыг удирдаж чадаагүйгээс хууль, дүрэм журам зөрчих, нэр төрийн эрсдэлд орох, торгууль, шийтгэл төлөх зэргээр алдагдал хүлээж болдог бөгөөд эдгээр нь Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд, хэтийн төлөвт сөргөөр нөлөө үзүүлж болно.

**9.6.9. Үнэт цаас гаргагч нь өөрийн ажилтан болон гуравдагч этгээдийн буруутай үйл ажиллагаанаас үүдэлтэй хүний хүчин зүйлийн дотоод болон гадаад эрсдэл, цахим гэмт хэрэгт өртөж болох бөгөөд энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, нэр хүнд, санхүүгийн үзүүлэлт болон хэтийн төлөвт материаллаг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч нь залилан мэхлэлт, гэмт хэрэг, цахим гэмт хэрэг, мөнгө угаалт болон өөрийн ажилтан болон үйлчилгээ үзүүлэгч гуравдагч этгээдийн ажилтны ёс зүйгүй үйлдэл зэргээс үүдэлтэй эрсдэлд өртөж болно. Энэ төрлийн үйлдлүүдэд мэдээ мэдээлэл болон хэрэглэгчийн нэр, нууц үгийг хулгайлах, ramsomware, үйлчилгээ үзүүлэхээс татгалзах халдлага (DDOS, distributed denial of service), дэд бүтцэд нэвтрэх, ач холбогдол бүхий программ, системүүдийн талаарх мэдээлэл цуглуулах, систем, бүтээгдэхүүн, үйлчилгээг зөвшөөрөлгүй ашиглах, дотоод бодлого, журам зэргийг зөвшөөрөлгүй хуулбарлах, залилан хийх зэрэг үйлдлүүд хамаарна.

Үнэт цаас гаргагчийн ажилтнууд болон харилцагчид нь фишинг болон хортой програм зэрэг цахим гэмт хэргийн хохирогч болж болзошгүй. Фишинг халдлагын үед харилцагчид нь сошиал инженерчлэлээр дамжуулан нууц үгээ алдах тохиолдол гардаг бол хортой программчлалын халдлагаар харилцагчийн компьютерт вирус халдварлуулдаг. Цахим гэмт хэргийн хувьд залилангийн шинж чанартай гүйлгээг харилцагчийн өмнөөс гүйцэтгэх зэрэг үйлдлүүд хамаарна.

Хувь хүн болон зохион байгууллалттай гэмт бүлэглэлүүд цахим орчинд үйлдсэн гэмт үйлдлээс /Жишээ нь DDOS халдлага/ шалтгаалан Байгууллагын үйл ажиллагаа, мэдээллийн системд доголдол үүсэж улмаар харилцагчдад үзүүлэх үйлчилгээ тасалдаж болзошгүй байдаг. Мэдээллийн системийн доголдол нь дүрэм журам, (гэрээний) үүргийг зөрчихөд хүргэхээс гадна байгууллагын нэр хүнд, үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдал, хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлдэг. Хувь хүмүүс болон зохион байгуулалттай гэмт бүлэглэлүүд нь цахим сувгаар дамжуулан ашиглан, залилан үйлдэхээр завдах мөн байгууллагын мэдээллийн систем /Байгууллагын болон хэрэглэгчийн мэдээлэл болон гүйлгээний мэдээллүүд /-д халдахаар байнгын оролдлого хийж байгаа нь дэлхий даяар банкны салбарт өсөн нэмэгдэж буй аюул занал болоод байна.

Цахим аюулгүй байдал, мэдээллийн технологид учирч болзошгүй эрсдэл нь хурдацтай хувьсан өөрчлөгдөж байгаа ба байнгын анхаарал, хөрөнгө мөнгө шаардаж байна. Цахим орчинд үйлдэгдэх халдлагын цар хүрээ нэмэгдэж, аргачлал нарийсаж буй нь аюулгүй байдал, (хувь хүний) мэдээлэл алдагдах томоохон зөрчилд хүргэж болзошгүй байна. Үүнээс гадна энэ төрлийн халдлагын улмаас байгууллага нь өөрийн өгөгдөлд хандах, системийн үйл ажиллагаагаа удирдах боломжгүй болох эрсдэлтэй бөгөөд өгөгдлийн баазыг хамгаалахад их хэмжээний нөөц, хөрөнгө зарцуулж болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь цахим гэмт хэргийн үр дагавар, цар хүрээг тогтмол хянах ба эрсдэлийг бууруулахаар цахим аюулгүй байдлын хөтөлбөр болон бусад арга хэмжээг авч өсөн нэмэгдэж буй аюул занал байнгын анхаарлаа хандуулж ажилладаг хэдий ч цахим аюулгүй

байдлын эрсдэлийг хангалттай хэмжээнд удирдах боломжгүй байх эрсдэл ямагт байдаг. Эрсдэлийг зохих ёсоор удирдсан боловч цахим халдлагад өртөж улмаар дүрэм журам зөрчих, зохицуулагч байгууллагад шалгуулах, арга хэмжээ авхуулахаас гадна байгууллагын бизнес, нэр хүнд, үйл ажиллагаа, санхүүгийн нөхцөл байдал, төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй.

**9.6.10. Үнэт цаас гаргагч нь өөрийн, харилцагчдын, бизнесийн түншүүдийн, бэлтгэн нийлүүлэгчдийн болон бусад гуравдагч этгээдийн мэдээллийг санамсаргүйгээр олон нийтэд ил болгосноор нэр хүндийн эрсдэлд орох эрсдэлтэй бөгөөд энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж болно.**

Үнэт цаас гаргагч нь нууцын зэрэглэлтэй үнэ цэн бүхий мэдээ, мэдээллийг хадгалах, бусдад дамжуулахтай холбоотойгоор холбогдох хууль, тогтоомжийг мөрдөх, гэрээний эрх үүргээ биелүүлэх үүрэгтэй. Үнэт цаас гаргагчийн ажилтны эсхүл гэрээт болон харилцагч байгууллага, түүний ажилтны санаатай болон санамсаргүй үйлдлийн улмаас Үнэт цаас гаргагчийн болон түүний харилцагчдын мэдээ, мэдээллийг олон нийтэд ил болгох нь Үнэт цаас гаргагчид зөрчлийн хэрэг үүсэх, нууцын зэрэгтэй мэдээлэл алдах, гэрээ болон хууль тогтоомж зөрчих, итгэл алдах зэрэг эрсдэлийг бий болгодог. Түүнчлэн алдагдсан мэдээ мэдээллийг Үнэт цаас гаргагч, түүний харилцагчид болон ажилтнуудын эсрэг ашиглах тохиолдол гарч болно. Зөөврийн компьютер, диск, хэвлэмэл бичиг баримтыг гээсэн, хулгайд алдсан, мөн Үнэт цаас гаргагчийн болон түүний харилцагчдын мэдээллийг хувийн болон бусад зорилгоор хулгайлах, хэвлэл мэдээллийн хэрэгслээр цацах, хувийн цахим шуудан руу илгээх, цахим орчинд хадгалах зэрэг үйлдлээс үүдэлтэй мэдээлэл алдагдаж болно. Мэдээ, мэдээлэл алдагдсанаар Үнэт цаас гаргагч нь нэр хүндийн эрсдэлд орж, алдагдал хүлээж, улмаар түүний бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

**9.6.11. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, хамтран ажилладаг гуравдагч этгээд болон харилцагчид нь цар тахал, байгалийн гамшигт үзэгдэл, олон нийтийн аюулгүй байдалд саад учруулж болзошгүй үйл явдал, үймээн самуун, эмх замбараагүй байдал, алан хядах ажиллагаа, дайны болон дайсагнасан үйлдэл зэрэгт өртөж болно. Энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа нь цар тахал, байгалийн гамшигт үзэгдэл болон осол гэх мэт олон нийтийн аюулгүй байдалд саад учруулж болзошгүй үйл явдлуудад өртөж болзошгүй. Эдгээр үйл явдал нь Үнэт цаас гаргагчийн биет хөрөнгө, ажилтнуудад хохирол учруулж болзошгүй. Давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Үнэт цаас гаргагч нь өөрийн харилцагчид болон гуравдагч этгээдэд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу эсхүл албан шаардлагын дагуу хариуцах шаардлага гарч болно. Байгалийн гамшиг, түүнд үзүүлэх хариу арга хэмжээ нь эдийн засаг, улс төрийн тодорхойгүй нөхцөл байдлыг бий болгож, улмаар Монгол Улсын эсхүл дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлд сөргөөр нөлөөлж болзошгүй. Үнэт цаас гаргагчийн дата төвүүд үер, газар хөдлөлт зэрэг байгалийн гамшигт нэрвэгдсэн тохиолдолд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа нь хүний хүчин зүйлийн үүдэлтэй гал түймэр, террорист болон хорлон сүйтгэх ажиллагаа, үймээн самуун, ажил хаялт, дайны зэргээс үүдэн тасалдах магадлалтай байдаг. Эдгээр үйл явдлууд, түүнд үзүүлэх хариу арга хэмжээ нь эдийн засаг, улс төрийн тодорхой бус байдлыг бий болгож, улмаар Монгол Улсын эсхүл дэлхийн эдийн засгийн нөхцөл байдал, санхүүгийн зах зээлд, цаашлаад Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

СЗХ 2023 .05. 12 өдөр БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023 -05- 15 БҮРТГЭВ-02

**9.6.12. Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон ажилтнуудыг татах, тогтоон барих чадвар нь бизнесийн амжилтын чухал хэсэг бөгөөд эс бөгөөс Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, гүйцэтгэл, ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагчийн амжилтын үндэс нь мэдлэг, ур чадвар бүхий удирдлагын баг болон ажилтнуудтай шууд холбоотой. Гүйцэтгэх удирдлагын багийн гишүүд болон чухал мэдлэг, ур чадварыг эзэмшсэн түлхүүр ажилтнуудыг алдах нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд материаллаг хэмжээний сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Үнэт цаас гаргагчийн стратеги, бизнес төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд түлхүүр ажилтнуудын нөлөө их байдаг. Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн хувьд ажилтнууд нь түүний хамгийн чухал үнэт зүйлийн нэг бөгөөд ур чадвар бүхий ажилтны төлөөх өрсөлдөөн их байдаг. Үнэт цаас гаргагч нь ур чадвар бүхий түлхүүр ажилтныг татах, тогтоон барихын тулд тэдний цалин, хангамжийг хангалттай хэмжээнд тогтоохыг хичээдэг.

**9.6.13. Үнэт цаас гаргагч болон түүний харилцагчдын бизнесийн үйл ажиллагаа нь ган гачиг, үер ус, түймэр, дулаан орны шимэгч хорхой болон өвчний тархалт, биологийн төрөл зүйлийн бууралт зэрэг цаг уурын дулаарлын бодит нөлөөлөлд өртөх мадаглалтай. Энэ нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүү, үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.**

Цаг уурын дулаарлын нөлөөллөөр дэлхийн дундаж температур тогтмол өсөж байгаагаас шалтгаалан цаг уурын эрс тэс үзэгдэл буюу томоохон хэмжээний үер, гал түймэр, удаан үргэлжлэх ган, дулаан орны шимэгч болон өвчний тархалт ихсэх хандлагатай байгаа ба энэ нь Үнэт цаас гаргагч болон түүний харигч байгууллагуудад сөргөөр нөлөөлөх магадлалтай. Эдгээр үзэгдэлтэй холбоотой бизнесийн үйл ажиллагаа доголдох, төрөл бүрийн түүхий эд, нөөц хомсдох, аж ахуйн нэгжийн эд хөрөнгөд томоохон хэмжээний хохирол үүсэх зэрэг нь бизнес нэгжүүдэд сөргөөр нөлөөлж эдийн засаг, улс төрийн орчныг тогтворгүйжүүлэх эрсдэлтэй байдаг. Энэхүү эрсдэлээс урьдчилан сэргийлэх, зөв зохистой үнэлгээ өгч, тохирох арга хэмжээг авах шаардлагатай байдаг ба энэ нь зарим бизнесийн хувьд өртөг өндөр, хэрэгжүүлэхэд хүнд байх магадлалтай.

**9.6.14. Байгал орчин, нийгэм, засаглалын эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдал, гүйцэтгэлд сөргөөр нөлөөлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч болон түүний харилцагчдын үйл ажиллагаанд нь байгаль орчин, нийгэм, засаглалын төрөл бүрийн эрсдэл нөлөөлж байдаг. Байгал орчны чиглэлд зарим эрсдлийг дурдвал: цэвэр усны буруу ашиглалт, хог хаягдлын хариуцлагагүй удирдлага, биологийн төрөл зүйл болон ойн санд сөргөөр нөлөөлөх үйл явц гэх мэт зүйлс багтдаг. Нийгмийн чиглэлд цалингийн тэнцвэргүй байдал, ажиллах орчны аюулгүй байдал, ажлын байран дах эрх тэгш болон олон талт байдал зэрэг зүйлс алдагдсанаар эрсдэл үүсдэг бол засаглалын эрсдэлд ТУЗ-ийн бүтэц болон олон талт байдал, байгууллагын ёс зүйн хэм хэмжээ, авлигал, залилангаас сэргийлэх чадвар зэрэг нь шууд нөлөөтэй байдаг. Үнэт цаас гаргагчийн хувьд олон улсын хамтрагч байгууллага болон хувьцаа эзэмшигчдийн туслам, дэмжлэгээр байгаль орчин, нийгэм, засаглалын зөв зохистой тогтолцоог бүрдүүлж чадсан хэдий ч хурдацтай өөрчлөн хөгжиж буй олон улсын стандарт болон хууль зүйл шаардлага нь тодорхой хэмжээний эрсдэлийг ямагт учруулж байдаг. Үнэт цаас гаргагчийн байгаль орчин, нийгэм, засаглалын бодлого журам, стратеги нь дээр дурдсан аливаа эрсдэлээс сэргийлж чадаагүй тохиолдолд Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлж, тус эрсдэлд мэдрэг харилцагч болон боловсон хүчнийг алдах, хямд төсөр эх үүсвэр татах боломжгүй болох, зарим хууль журамд заасан торгууль алданги хүлээж болзошгүй.

ХАСБАНК

СЗХ 2023 05 12 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

## 9.7 Нэр хүндийн эрсдэл

**9.7.1. Үнэт цаас гаргагч нь түүний үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлт болон хэтийн төлөвт материаллаг хэмжээний сөрөг нөлөөл үзүүлэхүйц нэр хүндийн эрсдэлд өртөх магадлалтай.**

Үнэт цаас гаргагчийн зохисгүй үйл ажиллагаа нь Үнэт цаас гаргагчид өөрт, түүний ажилтнуудад, түүний харилцагчид болон бусад үйлчилгээ үзүүлэгч талуудад сөргөөр нөлөөлж болзошгүй. Мөн Үнэт цаас гаргагчийн ажилтан, харилцагчид эсхүл бусад талуудын хууль, дүрэм журам зөрчих, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, татвараас зугтах, зайлсхийх зэрэг зохисгүй үйлдлүүдийн улмаас нэр хүндийн эрсдэлд орж болзошгүй.

Сүүлийн жилүүдэд засгийн газар, улс төрийн намууд, хэвлэл мэдээллийн байгууллагууд болон олон нийтийн зүгээс банкуудын зээл, хадгаламжийн хүүгийн хувь хэмжээнд ихээхэн анхаарал хандуулах болсон. Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа нэмэгдсэнтэй холбоотой тэдний хараа хяналтууд улам нэмэгдэх магадлалтай байна. Банкуудын зээлийн үйл ажиллагааны талаарх засгийн газар болон олон нийтийн ойлголт бодит байдлаас зөрүүтэй байх магадлалтай ба энэ үед хэдий Үнэт цаас гаргагч нь зах зээлийн зарчмаар үнэ тогтоож байгаа боловч олон нийтийн зүгээс шүүмжлэлтэй хандан нэр төрд нь халдах үйлдэл үзүүлж болзошгүй. Эдгээр үйл явц нь Үнэт цаас гаргагчийн нэр хүндийг унагаж, эрсдэлд оруулж болзошгүй.

Дээр дурдсан эрсдэлийн төрлүүдээс гадна Үнэт цаас гаргагч болон түүний ажилтнууд, харилцагчид болон бусад гуравдагч талууд нь хууль, дүрэм журмын шаардлагыг биелүүлэхгүй, ёс зүйн хэм хэмжээг зөрчсөнөөс хамааран мөнгө угаалт, хээл хахууль, террорист үйл ажиллагааг санхүүжүүлэхээс сэргийлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлэх, татвар төлөхөөс зайлсхийх, бүтээгдэхүүн үйлчилгээний чанар, ил тод байдал зөрчигдөх, харилцагчид учирч болзошгүй эрсдэлээс сэргийлэх үйл ажиллагааг хангалтгүй хэрэгжүүлэх, хувийн мэдээ, мэдээллийг хадгалах хамгаалах дүрэм журмыг зөрчих, мэдээллийг алдах зэрэг үйлдлээс үүдэлтэй эрсдэл бий болж болно. Мөн харилцагчийн мэдээллийг харах эрхгүй ажилтан нь харилцагчийн дансны мэдээллийг задруулах, хулгайлах, бусдад дамжуулах зэрэг хориотой үйлдэл нь Үнэт цаас гаргагчийг нэр хүндийн эрсдэлд оруулж болзошгүй.

Нэр хүндийн эрсдэлийг зөв удирдаагүй тохиолдолд Үнэт цаас гаргагчийн харилцагч талуудын Үнэт цаас гаргагчтай бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх сонирхлыг бууруулж, улмаар Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагааг бууруулахаас гадна зохицуулагч байгууллагын хяналт, шалгалтыг нэмэгдүүлэх, ажиллах хүчний сэтгэл ханамжид сөргөөр нөлөөлөх улмаар ур чадвар бүхий ажилтныг ажилд авахад хүндрэл учирч болзошгүй. Олон нийтийн дундах мэдээлэл үнэн зөв эсэхээс үл хамааран, Үнэт цаас гаргагчийн нэр хүндтэй холбоотой эдгээр асуудлууд хөндөгдөх нь Үнэт цаас гаргагчийн бизнест сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

## 9.8 Хууль эрх зүй, хянан нийцүүлэлтийн эрсдэл

**9.8.1. Банк санхүүгийн салбарын эсхүл Үнэт цаас гаргагчийн өөрийн онцлогоос хамаарч Үнэт цаас гаргагчийн үнэ тогтоох бодлоготой холбоотой зарим үйл явц нь Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдэд сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай.**

Үнэт Цаас гаргагчийн ашигт ажиллагаа нь зээл, хадгаламжийн хүүгийн зөрүүнээс олж буй орлого дээр суурилдаг ба зээл гаргахтай холбоотой бусад зардлыг шимтгэл хэлбэрээр харилцагчдаас авдаг. Харилцагчид санхүүгийн байгууллагаас авсан зээл, байршуулсан хадгаламжид тооцогдох хүүгийн хувь хэмжээнд ихээхэн анхаарал хандуулах болсон ба хүүний хувь хэмжээ, зээл, хадгаламжийн хүүний зөрүү, бүтээгдэхүүн үйлчилгээний шимтгэл зэрэгтэй холбоотой шүүмж, санал гомдол нэмэгдэх хандлагтай байна. Эдгээр санал

ХАСБАНК

гомдол, шүүмжийн ач холбогдол, давтамж нь зохицуулагч байгууллага болон хэвлэл мэдээллийн хэрэгслийн анхаарал хандуулж буй байдлаас хамаарч нэмэгддэг бөгөөд үүнээс үүдэн Үнэт Цаас гаргагч нь харилцагчаа алдах эрсдэлийг бий болгож байна.

Дээр дурдсан нөхцөл байдал нийгэмд үүсэх нь Үнэт цаас гаргагчийн бүтээгдэхүүн үйлчилгээний үнийг зах зээлийн зарчмаар тогтооход бэрхшээл учруулж, удирдлага, хүний нөөцийн зардлыг нэмэгдүүлэх тул Үнэт цаас гаргагчийн ашигт ажиллагаа, санхүүгийн байдалд, хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

**9.8.2. Хянан нийцүүлэхтэй холбоотой эрх зүйн өөрчдөлтүүд нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч нь зохицуулалт их буюу хууль эрх зүй, засаглалтай холбоотой өндөр шаардлага бүхий орчинд үйл ажиллагаа явуулдаг. Зохицуулагч байгууллагын зүгээс өөрийн хөрөнгө, хөрвөх чадвар, компанийн засаглалтай холбоотой нэмэлт шалгуур тогтоож болох бөгөөд эдгээр шаардлага, шалгуур нь өөрчлөгдөн хувьсаж байдаг.

Үнэт цаас гаргагчид хууль эрх зүй, зохицуулалтын нэмэлт өөрчлөлтийн биелэлтийг хангахад хүндрэл учирч болзошгүй юм. Банкны үйл ажиллагаа нь Монгол Улсын хууль тогтоомжтой нийцтэй байхаас гадна олон улсын зарим нэг хууль дүрэмд нийцүүлэн үйл ажиллагаа явуулах шаардлага үүсдэг ба үүний нэг жишээ нь АНУ-ын Гадаад дахь дансны хөрөнгийг татварт хамруулах тухай хууль (FATCA) юм. (АНУ-ын Гадаад дахь дансны хөрөнгийг татварт хамруулах тухай хууль (FATCA)-ийн дэлгэрэнгүй тайлбартай [9.8.3] Хууль эрх зүй, зохицуулалтын өөрчлөлт нь Үнэт Цаас гаргагчийн бизнесийн загвар, үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй гэсэн хэсгээс танилцана уу).

Сүүлийн 10 жилийн хугацаанд санхүүгийн салбарт үүссэн томоохон дампуурал, бүтцийн өөрчлөлт оруулах зэрэг үйл явдлаас үүдэн санхүүгийн салбарын оролцогч байгууллагууд нь зохицуулагч байгууллагын хатуу хараа хяналт дор үйл ажиллагаа явуулж байна. Үүний нэг жишээ нь 2018 онд Олон улсын валютын сангийн Өргөтгөсөн санхүүжилтийн хөтөлбөрийн хүрээнд банкны секторт Активын чанарын үнэлгээг хийсэн үйл явдал юм.

Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль эрх зүйн зохицуулалтын биелэлтийг хангаж ажиллахын тулд нийт ажилтнуудын хууль эрх зүй, бодлого журмын мэдлэгийг нэмэгдүүлэх ажилд ихээхэн хүч хөдөлмөр, хөрөнгө мөнгө зарцуулах шаардлагатай болдог. Эрх зүйн зохицуулалтыг биелүүлж ажиллахтай холбоотой шаардлагатай арга хэмжээг авч ажиллахгүй тохиолдолд хянан нийцүүлэлтийн алдаа гарах, түүнийг засах, арилгах явцад хүн хүч, мөнгөн хөрөнгийн нэмэлт зардал гарах ба бүтээгдэхүүн хөгжүүлэлт, бизнесийн үйл ажиллагааг удаашруулах эрсдэлтэй. Тухайлбал ФАТФ-ын удирдамжийн дагуу Монгол Улс нь 2018-2020 онд санхүүгийн ил тод байдлын стратегийн дутагдалтай гэж дүгнэгдсэн тул Монгол Улсын Мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн нэмэлт өөрчлөлтийн дагуу банкууд нь Харилцагчаа таньж мэдэх бодлого, мөнгө угаалттай тэмцэх систем болон тайлагналыг чангатгах шаардлагатай болсон.

Үнэт цаас гаргагч нь хууль тогтоомжийг биелүүлэхгүй эсхүл биелэлтийг хойшлуулах нь их хэмжээний мөнгөн торгуульд унах, нэр хүндийн эрсдэлд орох, хяналт шалгалтын байгууллагын зүгээс үйл ажиллагааны зөвшөөрлийг түдгэлзүүлэх, үйл ажиллагааг зогсоох хүртэлх арга хэмжээ авахад хүргэдэг.

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин нь эрх зүйн болон санхүүгийн ихээхэн хэмжээний зардал мөнгө, хүн хүч зарцуулахыг шаарддаг тул Үнэт Цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүдэд материаллаг хэмжээний нөлөө үзүүлдэг.

**9.8.3. Хууль эрх зүй, зохицуулалтын өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн загвар, үйл ажиллагаа, санхүүгийн үзүүлэлтүүд болон хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй.**

2017 оноос хойш Монголын банкны секторын шинэчлэлийг хийж эхэлсэнтэй холбоотойгоор холбогдох хууль тогтоомжид нэмэлт өөрчлөлт орсоор байна. Зохицуулагч байгууллагууд болон хууль тогтоогчид нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, бизнес модель, орлого, зардал, санхүүгийн үзүүлэлт болон хэтийн төлөвт нөлөөлөх магадлал бүхий хуулийн өөрчлөлтийг санаачлан ажиллаж байна. Түүнчлэн хууль эрх зүйн актыг өөрөөр тайлбарлан хэрэгжүүлэх, эсхүл татварын алба болон бусад эрх бүхий байгууллагуудаас аливаа хууль, дүрэм журмыг хэрэгжүүлэхдээ баримталдаг бодлого, зарчмаа өөрчлөх зэрэг нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлж болзошгүй юм. Одоогийн байдлаар өргөн барьсан, олон нийтэд хэлэлцүүлж байгаа хууль тогтоомжийн өөрчлөлтүүд эсхүл ирээдүйд хүчин төгөлдөр болох бусад өөрчлөлтүүдийн Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд үзүүлэх нөлөө өндөр байх магадлалтай. Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, засаглал, зохистой байдалд нөлөөлөх хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа болон өөрчлөлт оруулахаар хэлэлцэгдэж буй хууль, дүрэм журмуудыг дор дурдав. Үүнд:

- **Банкны тухай хууль.** Улсын их хурал 2021 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд шинэчилсэн хуулиар нэг хувьцаа эзэмшигч банкны нийт хувьцааны хорин хувиас илүүгүй хувийг эзэмших бөгөөд энэхүү зохицуулалтыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөс мөрдөж эхэлнэ. Түүнчлэн банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтыг шинэчлэн баталсан бөгөөд системийн нөлөө бүхий банкуудыг олон нийтэд нээлттэй хувьцаат компани болох шаардлагыг тавьсан ба Үнэт цаас гаргагч нь банкны системд нөлөө бүхий банкуудын нэг юм. Эдгээр өөрчлөлтүүд нь хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах замаар банкны ил тод, найдвартай, хариуцлагатай байдлыг сайжруулах зорилго бүхий банкны шинэчлэлийн арга хэмжээнүүдийн нэг юм. Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгчдийн хувьд нэг хувьцаа эзэмшигчийн хувьцаа эзэмшлийг 20 хувиас ихгүй байх шаардлагыг хангаж байгаа ч Банкны тухай хуулийн нэмэлт өөрчлөлттэй холбоотой шаардлагыг биелүүлэхийн тулд Үнэт цаас гаргагчийн толгой компанийн бүтцийг өөрчлөх шаардлага үүсэж байна. Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болох шаардлагыг биелүүлэхийн тулд анх удаа олон нийтэд хувьцаагаа санал болгон анхдагч зах зээлд арилжааг амжилттай явуулах шаардлагатай болсон. Хэдийгээр Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болж, шинэ шаардлагуудыг биелүүлж байгаа ч, уг ажлыг төлөвлөх, холбогдох зөвшөөрлүүдийг авах, зохион байгуулах, төлөвлөсөн арга хэмжээг хэрэгжүүлэхийн тулд Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын зүгээс хийгдэх ажлуудыг оролцуулаад ихээхэн хөрөнгө мөнгө, зардал, нөөц шаардагдаж байна. Үүний нэгэн адил хувьцааг анх удаа олон нийтэд санал болгосноос хойш Үнэт цаас гаргагчийн хувьцаа биржээр чөлөөтэй арилжаалагдаж эхлэхтэй холбогдуулан Үнэт цаас гаргагчийн зүгээс их хэмжээний нөөц, хөрөнгө зарцуулах шаардлага үүсэж болзошгүй. Цаашид Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааг зохицуулсан зарим хуулиудад өөрчлөлт орохыг мөн үгүйсгэхгүй юм.

- **Өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой шаардлага.** Монголбанк нь Базелийн Хяналт шалгалтын хорооноос баталсан Базел II, III стандартыг хэрэгжүүлснээр Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварт нөлөө үзүүлж болзошгүй юм. Үүний хүрээнд банкуудыг гадны үнэлгээний агентуудын тогтоосон зээлжих зэрэглэлд үндэслэн эрсдэлээр жигнэсэн активын хэмжээг тодорхойлохыг шаардаж болно. Энэ зохицуулалтыг баталж, хэрэгжүүлэх хугацаа, агуулга, үр нөлөө нь тодорхойгүй

хэвээр байгаа ч ийнхүү эрсдэлээр жигнэсэн активын хэмжээг тодорхойлох нь томоохон дүнтэй зээл болон ипотекийн зээлд тооцсон эрсдэлийн жингийн хувь хэмжээнээс хамаарсан мэдэгдэхүйц зөрүү үүсэж, эрсдэлээр жигнэсэн активын хэмжээнд нөлөө үзүүлж болзошгүй.

- **Хадгаламжийн даатгалын тогтолцоо.** УИХ-аас 2013 оны 1 дүгээр сард "Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль"-ийг баталсан. Хуульд заасны дагуу Хадгаламжийн даатгалын корпорац нь даатгалын тохиолдол бий болсон бол банкны хадгаламжийн даатгалын сангийн санхүүжилтэд оруулсан хувь хэмжээтэй уялдуулан нэг хадгаламж эзэмшигчийн нийт 20 сая төгрөг хүртэлх хадгаламжийг нөхөн төлнө гэж зохицуулсан. Системийн хэмжээний дампуурлын тохиолдол бий болоход Хадгаламжийн даатгалын корпорацаас ихээхэн хэмжээний нөхөн төлбөр төлөх шаардлага бий болно. Энэ тохиолдолд илүү олон хадгаламж эзэмшигчдийн хадгаламжид даатгалын нөхөн төлбөрт олгох хэрэгцээ бий болсноор хадгаламжийн даатгалын санхүүжилтийн бүтцэд өөрчлөлт орж болзошгүй.
- **Хадгаламжийн хүүгийн татвар.** Улсын их хурлаас 2020 оны 01 дүгээр сарын 01-ний өдөр Татварын шинэчилсэн хуулийг баталж, хадгаламж, бонд болон бусад өрийн хэрэгслийн хүүгийн орлогод 10 хувийн орлогын албан татвар ногдуулдаг болсон. Монгол Улсад зээлийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий аж ахуйн нэгжийн орлогын албан татварын суурь нь бизнесийн ердийн үйл ажиллагааны хүрээнд хүүгийн орлогыг хүүгийн зардлаар нөхөхөөс бусад тохиолдолд хүүгийн орлогод татвар ногдуулдаг болсон. Үүний үр дүнд хадгаламжийн цэвэр өгөөж буурч, зарим олон нийтийн, төрийн өмчийн болон олон нийтэд бүртгэлтэй өрийн үнэт цаастай харьцуулахад банкны хадгаламжийн эрэлт буурсан.
- **FATCA.** 1986 оны АНУ-ын төрийн сангийн журмын нэмэлтийн дагуу, Дотоод орлогын хуулийн 1471 дүгээр зүйлээс 1474 дүгээр зүйлд үндэслэн АНУ-ын бус (гадаадын) санхүүгийн байгууллагуудад тус байгууллага нь АНУ-ын Дотоод орлогын албатай ("IRS") гэрээ байгуулсан, үүний дагуу тодорхой тайлан гаргах, үйлчлүүлэгчийн зохих шалгалт, суутгалын шаардлагыг ("FFI Гэрээ") дагаж мөрдөхийг зөвшөөрсөн эсвэл Орон нутгийн засаг захиргаа нь FATCA-ийн хэрэгжилтийг хөнгөвчлөх зорилгоор АНУ-тай засгийн газар хоорондын гэрээ байгуулсны үндсэн дээр IGA-ийн харьяалалд байдгаас бусад тохиолдолд АНУ-ын эх үүсвэрийн төлбөрөөс 30%-ийн суутган татвар ногдуулж болно. Банк нь FFI гэрээний шаардлагыг биелүүлэхийг зорьж ажилладаг. FATCA нь Банканд, ялангуяа үйлчлүүлэгчдийг шинээр татах, таньж мэдэх үйл явцад нөлөөлдөг.
- **Иргэний хууль, барьцаа хөрөнгийн хууль.** Үнэт цаас гаргагчийн үндсэн бизнесийн үйл ажиллагаатай холбоотой холбогдох хууль тогтоомжид гарсан өөрчлөлтүүд нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд материаллаг хэмжээний нөлөө үзүүлж болзошгүй. Тухайлбал Иргэний хууль, шүүхийн үйл ажиллагааг зохицуулдаг хууль тогтоомж, барьцааны хөрөнгийн тухай хуулиудын нэмэлт өөрчлөлтүүд нь Үнэт цаас гаргагчийн зээлдэгч, барьцаалуулагч нартай байгуулсан гэрээнүүдэд нөлөөлж болно. Ийм өөрчлөлт нь Банк болон харилцагч хоорондын байгуулсан гэрээний агуулга, хүчин төгөлдөр байдалд нөлөөлөөд зогсохгүй, Үнэт цаас гаргагчийг гэрээний нөхцөл, үйл ажиллагааны арга барилаа өөрчлөхөд хүргэж болзошгүй юм. Түүнчлэн зарим бүтээгдэхүүн, үйлчилгээг зогсооход хүргэхээс гадна гэрээний хүчин төгөлдөр байдал алдагдаж, барьцааны хөрөнгөөр үүргийн гүйцэтгэлийг хангуулж чадахгүй нөхцөл байдалд орохыг үгүйсгэхгүй бөгөөд үүнтэй холбоотой алдагдалд хүргэж болзошгүй юм.

Дээр дурдсан шинэ хууль тогтоомж, санаачилгуудыг хэрэгжүүлэх хугацаа, нөлөөллийг хараахан тодорхойлох боломжгүй юм. Гэвч эдгээр болон бусад шинэ дүрэм, журам, шаардлага, болон бодлогын өөрчлөлтүүд нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгө, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд материаллаг болон сөрөг нөлөөл үзүүлж, хөрөнгө босгох, ногдол ашгийн хэмжээг бууруулах, хуулийн этгээдийн бүтэц, хөрөнгө, санхүүжилтийн бүтцэд өөрчлөлт оруулах, зарим бизнесийн үйл ажиллагааг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн зогсоох шийдвэр гаргахад хүргэж болзошгүй.

Аливаа хууль тогтоомжийн санаачилгууд нь Үнэт цаас гаргагчийн гүйцэтгэх удирдлагын зүгээс үр дагаврыг тодорхойлох, дүн шинжилгээ хийхэд цаг хугацаа, нөөц зарцуулах шаардлагыг бий болгодог. Үнэт цаас гаргагч нь стратеги, үйл ажиллагаа, бодлого, журмаа эдгээрээс үүдэлтэй холбогдох шаардлагад нийцүүлэн өөрчлөх шаардлагатай болж магадгүй юм. Ялангуяа одоогийн хууль тогтоомжийн санаачилгын цар хүрээг харахад зарим шинэ шаардлагуудыг цаг тухайд нь хэрэгжүүлэхгүй эсхүл алдаатай хэрэгжүүлэх, улмаар дагаж мөрдөхгүй байх, үүнтэй холбоотой сөрөг үр дагавар гарахыг үгүйсгэхгүй. Түүнчлэн шинэ шаардлагын улмаас зарим харилцагчдадаа үйлчилгээ үзүүлэх боломжгүй болох эсхүл зарим өөр бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгохоос өөр аргагүйд хүрч болзошгүй. Эдгээр өөрчлөлтүүд нь Үнэт цаас гаргагчийн мэдээллийн технологийн систем, санхүү нөөцийн хэрэгцээнд ихээхэн дарамт үзүүлж, стратегийн зорилтуудыг хэрэгжүүлэхэд саад болж болзошгүй.

**9.8.4. Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвартай холбоотой зохицуулагч байгууллагын бодлого журмын өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадвараа үр дүнтэйгээр удирдах чадварт нөлөөлж, өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх эсхүл ногдол ашиг хуваарилахыг хязгаарлах шаардлагатай болж болзошгүй.**

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг үр дүнтэй удирдах нь Үнэт цаас гаргагчид стратегийн зорилтоо биелүүлж, тогтвортой өсөлт хийхэд дэмжлэг болдог. Үнэт цаас гаргагч нь зохицуулагч байгууллагаас шаарддаг өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлтийг хангаж ажиллах ёстой байдаг бөгөөд өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг үр дүнтэй, оновчтой удирдах нь эдийн засгийн тодорхойгүй нөхцөл байдлын үед аливаа гэнэтийн үйл явдлаас Үнэт цаас гаргагч болон түүний хөрөнгө оруулагчдыг хамгаалах ач холбогдолтой.

Монголбанк өөрийн хөрөнгийн хүрэлцээ болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлагад өөрийн хөрөнгийн хэмжээ, хүрэлцээ, эдийн засгийн хүндрэлийг даван туулахад шаардагдах нэмэлт буфер тогтоох болон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын тайлагналыг сайжруулах нэмэлт, өөрчлөлтийг оруулсан бөгөөд цаашид ч нэмэлт өөрчлөлт оруулж болох юм.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг дараах байдлаар тогтоосон. Үүнд:

- Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ 9%.
- Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн буфер буюу нөөц интервал нь суурь болон тусгай хэсгийн нийлбэрээс бүрдэнэ.
    - Суурь хэсэг нь бүх банкинд хамаарах бөгөөд 2 нэгж хувь байна.
    - Тусгай хэсэг нь системийн нөлөө бүхий банкинд хамаарах бөгөөд зах зээлд эзлэх хувиас хамааран 2 нэгж хувь хүртэл байна.
- Нийт өөрийн хөрөнгийн зохистой харьцааны доод хэмжээ 12% байна.

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

Монголбанкны одоогийн зохицуулалтын дагуу Үнэт цаас гаргагчийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хэмжээ [9% + нэмэлт шаардлага 3.5%], нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний доод хэмжээ 12.0% байгаа ч Монголбанк нь өөрийн хөрөнгийн нөөц интервалыг нэмэгдүүлэх, эсхүл мөчлөг сөрсөн интервалын хэмжээг шинээр тогтоох зэрэг өөрчлөлт оруулж болно.

Өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны шаардлагыг нэмэгдүүлэх тохиолдолд Үнэт цаас гаргагч нь нэмж хувьцаа гаргах байдлаар өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлсэн тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн бүтцэд өөрчлөлт орж болно. Мөн Үнэт цаас гаргагч нь нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зарим бүрэлдэхүүн хэсгийг нэмэгдүүлэх замаар нийт өөрийн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлэх тохиолдолд хуваарилах ногдол ашгийн хэмжээ багасах магадлалтай байдаг. Банкны тухай хуулийн дагуу зохицуулагч байгууллагын зүгээс Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзвэл ногдол ашиг хуваарилахыг хязгаарлах боломжтой. Түүнчлэн Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилах хэмжээний ашигтай ажиллаагүй эсхүл өөрийн хөрөнгийн хүрэлцээтэй холбоотой нөөц интервалын шаардлагыг биелүүлээгүй тохиолдолд ногдол ашиг тараахгүй байж болно. Эдгээр арга хэмжээнүүд нь санал болгож буй хувьцааны үр дүнд материаллаг хэмжээний сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгийн хэмжээгээ нэмэгдүүлж чадахгүй бол эрсдэлээр жигнэсэн активын хэмжээг бууруулах, зарим бүтээгдэхүүн үйлчилгээ, бизнесийн үйл ажиллагаагаа зогсоох эсхүл эрсдэл өндөртэй активыг бууруулах зэрэг арга хэмжээг авах шаардлага тулгарч болно. Үнэт цаас гаргагч нь өөрийн хөрөнгийн хүрэлцээний зохистой харьцааг хангаж чадахгүй бол Үнэт цаас гаргагчийн урт хугацаанд тогтвортой үйл ажиллагаагаа явуулж чадах эсэхэд итгэх харилцагчид, талуудын итгэл буурч, харилцах, хадгаламжийн эх үүсвэр гадагшлах, үйл ажиллагаагаа хэвийн үргэлжлүүлэхэд хүндрэл учирч болзошгүй.

Үнэт цаас гаргагч нь төлбөр түргэн гүйцэтгэх чадварын зохистой харьцааны доод хэмжээ, шаардлагыг нэмэгдүүлэхэд эх үүсвэрийнхээ бүтцийг өөрчлөх ба энэ нь эх үүсвэрийн зардлыг нэмэгдүүлж, орлого бага олдог, хөрвөх чадвар өндөр хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж, хөрвөх чадвар бага хөрөнгийг бууруулах шаардлагатай болно. Хэрэв хөрвөх чадварын эрсдэлийг үр дүнтэйгээр удирдаж чадахгүй тохиолдолд богино хугацаат өр төлбөрөө цаг хугацаанд нь төлж чадахгүй байх эрсдэлтэй.

Тиймээс Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн удирдлагатай холбоотой аливаа үйл ажиллагаа хязгаарлагдсан тохиолдолд түүний санхүүгийн үзүүлэлтүүд, зохистой харьцааны биелэлт, төлбөр түргэн гүйцэтгэх чадвар, түүнчлэн хувьцааны үнэ буурахад нөлөө үзүүлж болзошгүй.

**9.8.5. Үнэт цаас гаргагч нь бизнесийн үйл ажиллагааны хүрээнд өөрийн нэр хүнд, хэтийн төлөв, үйл ажиллагаа, санхүүд сөрөг нөлөө учруулж болзошгүй хууль эрх зүйн эрсдэлд өртөх магадлалтай байдаг. Аливаа төлбөр тооцоо болон шүүхийн маргааны үр дагавар нь тодорхой биш байдаг тул эрсдэлийн санг нарийн тодорхойлоход хүндрэлтэй байдаг. Тиймээс Үнэт цаас гаргагч нь өөрийн бизнес, санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагаа болон хэтийн төлөвт нөлөөлөхүйц хуулийн буюу шүүхийн маргаанд нэр холбогдох, торгууль төлөх, алдагдалд орох эрсдэлтэй байдаг.**

Үнэт цаас гаргагч нь өдөр тутмын бизнесийн үйл ажиллагааныхаа хүрээнд хэрэг маргаан шийдвэрлэх шүүхийн ажиллагаанд оролцдог. Үнэт цаас гаргагч нь өөрийн харилцагч, зээлдэгч, ажилтан, хувьцаа эзэмшигч болон бусад этгээдтэй холбоотой үүссэн хэрэг маргаан, шүүхийн болон захиргааны арга хэмжээнд өртөх эрсдэлтэй. Өнөөдөр болон ирээдүйд учирч болзошгүй хууль эрх зүйн арга хэмжээнээс урьдчилан сэргийлэх зардал өндөр байдаг. Түүнчлэн хэрэг маргаан нь үндэслэлтэй эсэх болон хууль шүүх торгуулийн

ХАСБАНК
2578637

арга хэмжээ авагдах эсэхээс үл хамааран уг ажиллагаа нь Үнэт цаас гаргагчийн олон нийт дэх нэр хүндэд сөргөөр нөлөөлж харилцагчийн итгэх итгэлийг бууруулж болзошгүй байдаг. Хууль шүүхийн ажиллагаа, төрийн болон зохицуулагч байгууллагын арга хэмжээ нь үнэт цаас гаргагчийн бизнес, санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагаа, нэр хүнд болон хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай юм.

Үнэт цаас гаргагч нь мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, татвараас зайлсхийхийн эсрэг хууль тогтоомжийг мөрдөхөөс гадна бусад санхүүгийн байгууллагын нэгэн адил компанийн засаглал, хөдөлмөрийн харилцаа, бизнесийн ёс зүй болон харилцагчийг хамгаалах хууль журмуудад үйл ажиллагаагаа нийцүүлж ажилладаг. Үнэт цаас гаргагч нь өөрийн бизнест тулгарч болох төрийн болон зохицуулагч байгууллагын арга хэмжээ, хууль шүүхийн маргаан болон түүнээс үүдэн гарах үр дагаврыг урьдчилан таамаглаж хэмжихэд хүндрэлтэй байдаг. Тиймээс эдгээр эрсдэлд нарийвчлан эрсдэлийн сан байгуулах боломж хомс бөгөөд хангалттай сан байгуулаагүй үед эрсдэлийн тохиолдол үүсэх нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүү, үйл ажиллагаа, хэтийн төлөв болон нэр хүндэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн удирдлага болон аудиторууд нь жилийн санхүүгийн тайлангийн үеэр хууль эрх зүйн эрсдэлийн улмаас учирч болзошгүй зардлыг урьдчилан тооцоолж, болзошгүй эрсдэлд холбогдох санг төсөвлөж болдог. Хэрэв төсөвлөсөн сан хангалттай биш бол Үнэт цаас гаргагч нь алдагдал хүлээх магадлалтай байдаг. Хууль эрх зүйн эрсдэлийн санг хангалттай байгуулаагүй, тооцооллын алдаа гаргах, шүүх ажиллагааны алдаа зэрэг нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүү, үйл ажиллагаа болон хэтийн төлөвт материаллаг хохирол учруулах магадлалтай байдаг.

Үнэт цаас гаргагчид учрах эрсдэл нь зөвхөн нэхэмжлэгчид нөхөн төлбөр өгснөөр хязгаарлагдахгүй бөгөөд Үнэт цаас гаргагч нь хэдий хуулийн дагуу төлбөр төлөх шаардлагагүй ч өөрийн байгууллагын нэр хүнд, ёс суртахуун болон тухайн харилцагчидтай бизнесийн харилцааг цаашид үргэлжлүүлэхийн тулд нэхэмжлэгчид нөхөн төлбөр төлөхөөр шийдвэр гаргаж болно. Тиймээс эдгээр үйлдэл нь Үнэт цаас гаргагчийн бизнес, санхүү, үйл ажиллагаа болон хэтийн төлөвт ноцтой сөрөг нөлөө үзүүлж болно.

**9.8.6. Мөнгө угаах, хээл хахууль, авлигын эсрэг хууль болон татварын тухай хууль тогтоомж, олон улсын хориг арга хэмжээг дагаж мөрдөөгүйгээс үүдэн Үнэт цаас гаргагчид өндөр хэмжээний торгууль ногдуулах эсхүл байгууллагын нэр хүндэд сөргөөр нөлөөлж улмаар үнэт цаас гаргагчийн бизнес, санхүү болон үйл ажиллагаанд сөрөг нөлөөл үзүүлж болно.**

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх, авлига, хээл хахууль болон татвараас зайлсхийхтэй тэмцэх, эдийн засгийн хориг арга хэмжээг дагаж мөрдөх зэрэгт төрийн зүгээс онцгой анхаарч бодлого журмыг боловсруулан ажилдаг. Эдгээр хууль тогтоомжийн дагуу Үнэт цаас гаргагч нь өөрийн байгууллагад мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх, татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэх холбогдох бодлогыг боловсруулан үйл ажиллагаанд нэвтрүүлсэн байх шаардлагатай байдаг. Тус бодлого журмын дагуу хэвийн бус болон сэжигтэй гүйлгээг илрүүлэх, тайлагнах, эдийн засгийн хориг арга хэмжээг дагаж мөрдөх, авлига хээл хахуультай тэмцэх үүрэг хүлээдэг. Хэдийгээр Үнэт цаас гаргагч нь эдгээр бодлого журмуудыг баталж, ажилтнуудаа холбогдох сургалтыг зохион байгуулдаг боловч ажиллагсдын холбогдох хууль журмын мэдлэг, дотоод бодлого журмуудын биелэлт, хяналт зэргээс хэрэгжилтийн үр дүн шалтгаалж байдаг.

Үнэт цаас гаргагч нь харилцагчаа зохих хууль журмын дагуу бүрэн таньж мэдэж чадаагүй буюу баталгаажуулаагүй, харилцагчийн орлогын эх үүсвэр болон банктай харилцах зорилго, хориг арга хэмжээнд орсон эсэх, болон холбогдох гүйлгээнд хангалттай

хэмжээний хяналт тавьж чадаагүй тохиолдолд дээр дурдсан журам зааврыг зөрчих эрсдэлтэй бөгөөд улмаар нэр хүндийн томоохон эрсдэл үүсэх магадлалтай.

Үнэт цаас гаргагчийн хянан нийцүүлэлтийн хөтөлбөр, хянан нийцүүлэлтийн нэгж дотоод хяналтын бодлого журмууд, удирдлагын хяналт үйл ажиллагаа болон бусад холбогдох үйл ажиллагаа, эрсдэлээс урьдчилан сэргийлэх бусад хүчин чармайлт зэргээс үл хамааран мөнгө угаах терроризмыг санхүүжүүлэх, авлига хээл хахууль татвараас зайлсхийхтэй тэмцэх хууль тогтоомж, олон улсын хориг дагаж мөрдөөгүйгээс үүдэн гарах тодорхой хэмжээний эрсдэл ямагт байдаг. Өөрөө хэлбэл Үнэт цаас гаргагчийн хянан нийцүүлэлтийн хөтөлбөр, хянан нийцүүлэлтийн нэгж дотоод хяналтын бодлого журам үйл ажиллагаа зэргээс үл хамааран харилцагч, ажилтан, бусад этгээдийн зүгээс болгоомжгүй эсхүл хайхрамжгүй байдлаас болж холбогдох хууль журмыг зөрчих эрсдэлтэй байдаг.

Эдийн засгийн хориг арга хэмжээ тогтоосон хууль журмууд нь ихэвчлэн өргөн цар хүрээтэй, дагаж мөрдөхөд нарийн төвөгтэй байдаг бөгөөд сүүлийн жилүүдэд улс орнууд хориг арга хэмжээний дэглэмийг нэмэгдүүлж, бэхжүүлж байна. Эдийн засгийн хориг арга хэмжээ тэлж, Үнэт цаас гаргагч зарим нэг бизнес болон харилцагч талуудыг хамрах тохиолдолд Үнэт цаас гаргагч нь тус бизнесийн үйл ажиллагааг зогсоох, бизнесийн харилцаанаас татгалзах зэрэг арга хэмжээг авах шаардлагатай болно.

Мөн АНУ-ын нутаг дэвсгэрээс бусад газарт дагаж мөрдөх холбогдох улс, хувь хүн, хуулийн этгээдийн эсрэг АНУ-ын тогтоосон эдийн засгийн хориг хэмжээг дагаж мөрдөх, зөрчихөөс урьдчилан сэргийлэхийн тулд Үнэт цаас гаргагч нь үр дүнтэй үйл ажиллагаа, хяналтыг хэрэгжүүлэх шаардлагатай юм.

Бүгд Найрамдах Ардчилсан Солонгос Ард Улс, Исламын Бүгд Найрамдах Иран Улс, болон Оросын Холбооны Улс зэрэг зарим улс орнуудын хувьд АНУ-ын төрийн департмент, АНУ-ын Сангийн яамны гадаадын хөрөнгийн хяналтын газар (OFAC) болон Европын холбооноос хязгаарлалтын арга хэмжээ авч худалдааны хориг тавьсан. 2010 оноос хойш Ираны эсрэг олон улсын (АНУ болон ЕХ-г оролцуулан) өргөн хүрээтэй нэмэлт хориг арга хэмжээнүүд тавигдсаар ирсэн бөгөөд эдгээр нь эдийн засгийн цогц хориг арга хэмжээ болж байна. Ирантай холбоотой тодорхой үйл ажиллагаа явуулсан нь тогтоогдсон АНУ-ын бус санхүүгийн байгууллагад АНУ-ын банкуудаас зээл олгохоос татгалзах, корреспондент банкны харилцаа үүсгэхээс татгалзах, харилцаагаа цуцлах, АНУ-ын санхүүгийн байгууллагуудаар дамжуулан төлбөр төлөх үйлчилгээ үзүүлэхээс татгалзах, мөн АНУ-ын нутаг дэвсгэр дээрх хөрөнгийг битүүмжлэх зэрэг олон төрлийн хязгаарлалтад өртөж болзошгүй юм.

**9.8.7. Үнэт цаас гаргагч болон банкны системийн бусад байгууллагуудыг стресс тест болон бусад цочролын шинжилгээ хийхийг шаардах тохиолдол байдаг. Энэ төрлийн шинжилгээ, стресс тестийн үр дүн нь аль нэг банк, санхүүгийн байгууллагад эсхүл банк, санхүүгийн секторт бүхэлд нь итгэх итгэлийг бууруулж, улмаар Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, зохицуулагч байгууллагын зүгээс албадлагын арга хэмжээ авах хүртэлх сөрөг үр нөлөө үзүүлж болзошгүй.**

Зах зээлийн сөрөг өөрчлөлтүүдэд банкны секторын тогтвортой байдлыг хангах зорилгоор Монголбанкнаас банкны секторт стресс тест болон цочролын шинжилгээг хийдэг. Зохицуулагч байгууллагын зүгээс стресс тестийн үр дүнг олон нийтэд зарласан тохиолдолд банк, санхүүгийн секторт тогтворгүй байдал бий болж аль нэг банк, санхүүгийн байгууллагад эсхүл банк, санхүүгийн секторт бүхэлд нь итгэх итгэлийг бууруулах магадлалтай. Стресс тестийн үр дүн нь Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, санхүүд нөлөөлж, зохицуулагч байгууллагын зүгээс албадлагын арга хэмжээ авах хүртэлх сөрөг үр нөлөө үзүүлэхээс гадна Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг бууруулах, эсхүл эрсдэлийн сан нэмж байгуулснаар Үнэт цаас

гаргагчийн бизнес, үйл ажиллагаа, ашигт ажиллагаа, нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

**9.8.8. Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 9 зэрэг санхүүгийн тайлагналын стандартын нэмэлт өөрчлөлтүүд нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үр дүн, өөрийн хөрөнгийн хүрэлцээнд материаллаг хэмжээний нөлөө үзүүлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч нь Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу санхүүгийн тайлан бэлтгэдэг бөгөөд СТОУС-д тодорхой давтамжтайгаар нэмэлт, өөрчлөлт ордог. Үнэт цаас гаргагч нь шинэ нягтлан бодох бүртгэлийн стандартуудыг мөрдөх шаардлага гарч болох бөгөөд одоогийн нягтлан бодох бүртгэлийн зарчимд өөрчлөлт орсноор Үнэт Цаас гаргагчийн үйл ажиллагаа, санхүүгийн байдалд материаллаг хэмжээний сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Тухайлбал Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт 39 нь СТОУС 9 болж шинэчлэгдсэн нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн тайланд томоохон нөлөө үзүүлсэн. Үнэт Цаас гаргагч нь СТОУС 9-ийн дагуу учирсан алдагдалд бус харин учирч болзошгүй алдагдалд суурилан зээл болон бусад санхүүгийн хэрэгслүүдийн эрсдэлийн сангийн хэмжээг тооцох болсон. Өөрөөр хэлбэл зээлийн эрсдэлийн санг зээлийн насжилтын эхэн үед байгуулах нь зээлийн эрсдэлийн сангийн хэмжээг нэмэгдүүлж, улмаар цэвэр ашиг болон өөрийн хөрөнгийн хэмжээ буурах үндэслэл бий болсон байна.

Санхүүгийн тайлагналын стандарт, бодлого, журамд өөрчлөлт орох нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, цэвэр ашиг, өөрийн хөрөнгийн хүрэлцээнд материаллаг хэмжээний нөлөө үзүүлэх магадлалтай юм.

**9.8.9. Үнэт цаас гаргагч нь татварын тогтолцоо бүрэн тогтворжоогүй орчинд үйл ажиллагаа явуулдаг тул татварын нөхцөл байдалтай эрсдэл үүсэж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч нь татварын тогтолцоо бүрэн тогтворжоогүй орчинд үйл ажиллагаа явуулдаг бөгөөд татвартай холбоотой хууль тогтоомжид өөрчлөлт орох үед дагаж мөрдөх журам, чиглэл нь тодорхойгүй байх тохиолдол үүсдэг. Тодорхой бус байдлаас үүдэн татварын дүрэм журмыг буруу тайлбарлах, алдаатай үйл ажиллагаа явуулах эрсдэлтэй байдаг. Өөрөөр хэлбэл татвартай холбоотой хууль тогтоомжийг буруу тайлбарлаж алдаатай тайлагнах нь татвар ногдох орлогын хэмжээг ахин тодорхойлох, торгууль алданги тооцогдох, улмаар Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагаа, санхүүгийн байдал, хэтийн төлөвт сөрөг нөлөө үзүүлэх магадлалтай. Мөн хууль тогтоомжийн томоохон өөрчлөлт, өөрчлөлтийн тайлбар, хэрэгжилт нь Үнэт цаас гаргагчийг бизнесийн стратегийг өөрчлөх, зардал нэмэгдүүлэх зэрэг сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Татварын зардал нь хүлээгдэж байснаас өндөр гарах зэргээр татвартай холбоотой ямар нэгэн эрсдэл бий болоход ашигт ажиллагаа буурч, Үнэт цаас гаргагчийн бизнес, үйл ажиллагаа, санхүүгийн байдалд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

Монгол Улсын Засгийн газраас татварын хуульд өөрчлөлт оруулж, хадгаламж эзэмшигч санхүүгийн байгууллага нь хувь хүн, хуулийн этгээдийн нэрийн өмнөөс хүүгийн орлогын албан татварыг суутган тооцохоор болсон бөгөөд үүнтэй холбоотойгоор торгууль, захиргааны арга хэмжээний асуудал үүсэж болзошгүй. Монгол Улсын одоогийн мөрдөж буй татварын хууль тогтоомжийн дагуу хадгаламж, хөрөнгө оруулалтаас олсон орлогыг бодит орлого, хөрөнгийн өсөлтөөс үл хамааран тогтмол хэмжээгээр (10%) татвар ногдуулдаг. Хадгаламж, хөрөнгө оруулалтын татварын дэглэмийн өөрчлөлт нь Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны болон тайлагналын системд шаардлагатай өөрчлөлтүүдийг оруулж болзошгүй. Энэ нь үйлчлүүлэгчдийн санхүүгийн үйлчилгээ авах сонголтод нөлөөлж болох бөгөөд Үнэт цаас гаргагчийн орлого, гүйцэтгэл, хэтийн төлөвт нөлөөлж болзошгүй юм.

**9.8.10. Үнэт цаас гаргагчийн үйлчлүүлэгч татвараас зайлсхийсэн тохиолдолд үүнийг Үнэт цаас гаргагчтай холбож тайлбарлаж болзошгүй ба үүнээс үүдэн нэр хүндийн эрсдэл үүсэж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч нь татвараас зайлсхийх эсхүл татвараас зайлсхийхээс урьдчилан сэргийлэхийн тулд харилцагчдын үйл ажиллагаанд холбогдох шалгалтыг хийх үүргийг хүлээх болсон ч татварын тогтолцоотой холбоотойгоор тухайн харилцагчид нь татвараас зайлсхийсэн эсэхийг тодорхойлох боломжгүй нөхцөл байдал үүсэхийг үгүйсгэхгүй. Энэ төрлийн татвартай холбоотой эрсдэл нь Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлөх, торгууль алданги төлөх зэрэг сөрөг үр дагавартай байж болзошгүй.

## 9.9 Үнэт цаас гаргагчийн хувь эзэмшигчдийн бүтэц, нээлттэй хувьцаат компани болох, хувьцаа санал болгохтой холбоотой эрсдэлүүд

**9.9.1. Үнэт цаас гаргагч нь Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн дагуу тавигдаж буй шаардлагыг 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор хангах зорилгоор Хувьцаагаа олон нийтэд нээлттэй хүрээнд санал болгож, нээлттэй хувьцаат компани болсны дараагаар өөрчлөн байгуулагдах шаардлагатай байгаа. Тийнхүү өөрчлөн байгуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлэн баталж, төрийн эрх бүхий байгууллагаас холбогдох зөвшөөрлүүдийг авах замаар шийдвэрлэнэ. Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулахад тулгарч болох хууль тогтоомжийн болон бүртгэл хийлгэх, зөвшөөрөл авах зэрэг захиргааны үйл ажиллагаатай холбоотойгоор үүсэж болох хүндрэл бэрхшээлүүд нь Үнэт цаас гаргагчийн стратеги, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөв, санхүүгийн нөхцөл байдалд ноцтой болон сөргөөр нөлөөлж болзошгүй.**

Аливаа нэг этгээдийн дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших боломжтой хувьцааны нийт хэмжээг Банкны тухай хуулийн нэмэлт, өөрчлөлтийн шаардлагад нийцүүлэхийн тулд Үнэт цаас гаргагч нь одоогийн толгой болон охин компани гэсэн групп компанийн бүтцээ өөрчилж, толгой компанийн одоогийн хувьцаа эзэмшигчдэд Үнэт цаас гаргагчийн хувьцааг шууд байдлаар эзэмшүүлэх замаар Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах шаардлагатай байгаа билээ. Иймээс уг өөрчлөн байгуулах ажиллагааг Үнэт цаас гаргагчийн хувьцааг нээлттэй хүрээнд анх удаа олон нийтэд санал болгосны дараагаар Үнэт цаас гаргагч болон толгой компанийг нэгтгэх замаар хэрэгжүүлэхээр төлөвлөөд байна.

Хувьцааг олон нийтэд анх удаа санал болгосны дараа Үнэт цаас гаргагчийн том хувьцаа эзэмшигч (буюу түүний толгой компани болох ТСН) болон анхдагч зах зээлийн арилжааны үеэр олон нийтэд анх удаа санал болгосон хувьцааг захиалан худалдаж авсан бүхий л шинэ хөрөнгө оруулагчдыг оролцуулан хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах бөгөөд тус хурал нь Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах уг асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Иймд хувьцаа эзэмшигчдийн хуралд бүхий л хувьцаа эзэмшигчид, түүний дотор Үнэт цаас гаргагчийн толгой компани болох ТСН зохих ёсоор оролцож, санал өгнө гэсэн хүлээлттэй байгаа болно. Улмаар Үнэт цаас гаргагчийн зарласан болон гаргасан нийт хувьцааны 75 хувиас илүүг толгой компани болох ТСН эзэмшихээр байгаа тул Монголбанкнаас 2022 оны 3 дугаар сарын 22-ний өдөр ирүүлсэн мэдэгдэлдээ Үнэт цаас гаргагчийг толгой компанитай нэгтгэх нь сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй хэмээн дүгнэсэн тул хувьцаа эзэмшигчдийн хурлаар уг нэгтгэх ажиллагаа буюу хэлцлийг сонирхлын зөрчилтэй хэлцэлд тооцогдохгүй болохыг мөн хүлээн зөвшөөрч, нэгтгэх ажиллагаа буюу хэлцлийг зөвшөөрсөн шийдвэр гаргана гэсэн хүлээлттэй байна.

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах аливаа шийдвэрийг хэрэгжүүлэхийн тулд холбогдох эрх бүхий байгууллагууд, тухайлбал Монголбанк, Санхүүгийн зохицуулах хорооноос холбогдох зөвшөөрөл авсан байх шаардлагатай.

Хэрэв хууль тогтоомжид заасан хугацаанд багтаан, зохих журмын дагуу Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлаас шийдвэрлээгүй, эсхүл тийнхүү гаргасан шийдвэрийг хэрэгжүүлэхээр холбогдох эрх бүхий төрийн байгууллагаас зөвшөөрөл аваагүй тохиолдолд Үнэт цаас гаргагчид төрийн эрх бүхий байгууллагуудын зүгээс аливаа захиргааны арга хэмжээ авах, шийтгэл хүлээлгэх ч боломжтой юм. Түүнчлэн зохицуулагч байгууллагуудын зүгээс саяхан шинээр банкны салбарын хувьцаа эзэмшигчдэд харилцагчийг таньж мэдэх шалгалт (KYC)-г хийж байх шаардлага тавьсан. Хувьцаа эзэмшигчдийн талаарх дээрх мэдээллийг хөрөнгийн биржээр дамжуулан цуглуулах буюу олж авах шаардлагыг тавьж байгаа бөгөөд улмаар арилжааны банкнуудын хувьд дээрх мэдээллийг гаргаж өгөх нь тэдгээрийн хуулиар хүлээсэн бүрэн эрх, үүрэгт төдийлөн хамаарахгүй байгаа хэдий ч, Үнэт цаас гаргагч нь аливаа дутуу мэдээлэл гаргаж өгсөнтэй холбогдуулан хариуцлага хүлээж болзошгүй юм. Хувьцаа эзэмшигчдээс зохих шаардлага хангасан хууль ёсны шийдвэр гаргаагүй, эсвэл Үнэт цаас гаргагчийг өөрчлөн байгуулах ажиллагааг хуулиар тогтоосон хугацаанд зохих ёсоор хийж гүйцэтгээгүй тохиолдолд Монголбанкнаас Үнэт цаас гаргагчийн хөрөнгийн бүтэц дэх шаардлага хангаагүй хувьцааны эзэмшлийг хүлээн зөвшөөрөхөөс татгалзах, өөрийн хөрөнгийн хэмжээг бууруулах зэрэг хязгаарлалтуудыг тавих боломжтой. Хэрэв дээр дурдсан эрсдэлт нөхцөлүүдийн аль нэг нь бодитоор үүсвэл энэ нь Үнэт цаас гаргагчийн стратегийн хэрэгжилтэд ноцтой сөрөг нөлөө үзүүлэхээс гадна Үнэт цаас гаргагчийн нэр хүнд, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөв, санхүүгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлж болзошгүй юм.

**9.9.2. Ирээдүйн ногдол ашгийн төлбөр нь Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдал, үйл ажиллагаа, ногдол ашигтай холбоотой бодлогоос шалтгаалахаас гадна хуулийн болон зохицуулагч байгууллагын хязгаарлалтуудаас хамаарна.**

Үнэт цаас гаргагчийн ногдол ашиг тараах, зохих хэмжээний нөөц бүрдүүлэх чадвар нь холбогдох хууль, тогтоомж болон зохицуулагч байгууллагын хязгаарлалт, өөрийн хөрөнгө болон хөшүүргийн харьцааны шаардлага, заавал байлгах нөөц, санхүү, үйл ажиллагааны үзүүлэлт болон холбогдох татварын хуулиас хамаарах бөгөөд эдгээр хууль, хязгаарлалтууд нь Үнэт цаас гаргагчийг ногдол ашиг хуваарилахад хязгаарлалт тавьж үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг тухай бүр хуваарилах боломжгүй болгох магадлалтай юм.

Түүнчлэн Үнэт цаас гаргагчийн ногдол ашиг хуваарилахтай холбоотой бодлого, хуваарилахаар тооцоолсон ногдол ашгийн хэмжээ нь зөвхөн Төлөөлөн удирдах зөвлөлийн шийдэх асуудал биш бөгөөд зохицуулагч байгууллагын зүгээс Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийг нэмэгдүүлэх шаардлагатай гэж үзвэл ногдол ашгийг хязгаарлах, хориглох боломжтой байдаг.

Ногдол ашиг хуваарилах санал гаргахад өөрийн хөрөнгө, төлбөр түргэн гүйцэтгэх чадварын шаардлага, болон бусад зохицуулагч байгууллагын шаардлага, хязгаарлалтууд, ирээдүйн ашиг, орлого, хуваарилах боломжтой нөөц, санхүүгийн байдал, өсөлт хийх боломж, үнэт цаас гаргагчийн бизнесийн хэтийн төлөв, урт болон богино хугацааны оршин тогтнох чадвар, эдийн засгийн нөхцөл болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс Үнэт цаас гаргагчийн дунд хэмжээний эрсдэлийн төлөвийг сайжруулахад шаардлагатай гэж үзсэн нэмэлт өөрийн хөрөнгө, төрөл бүрийн хүчин зүйлүүдийг харгалзан үздэг. Хэрэв Үнэт цаас гаргагч нь ногдол ашиг хуваарилах боломжгүйд хүрвэл хувьцааны үнэд сөргөөр нөлөөлж болзошгүй.

Зарим тохиолдолд Үнэт цаас гаргагч нь ногдол ашгийг бэлэн мөнгөөр эсхүл хувьцаа хэлбэрээр авах боломжийг хөрөнгө оруулагчдад олгодог. Энэ үед бэлэн мөнгө хэлбэрийг сонгосон хөрөнгө оруулагчдын хувь эзэмшил буурах магадлалтай байдаг.

**9.9.3. Үнэт цаас гаргагч нь ирээдүйд хувьцаа гаргах замаар хөрөнгө татаж болох бөгөөд энэ нь зарим хөрөнгө оруулагчдын хувь эзэмшилд сөргөөр нөлөөлж болзошгүй.**

Үнэт цаас гаргагч нь зохицуулагч байгууллагын болон бусад шаардлагаар нийтэд эсхүл хаалттай байдлаар энгийн хувьцаа нэмэлтээр гаргах, энгийн хувьцаанд хөрвөх боломжтой өрийн болон үнэт цаасны баталгаа гаргах, эдгээр үнэт цаасыг худалдан авах давуу эрх олгох, эсхүл тухайн үед эргэлтэд байгаа энгийн хувьцаатай холбоотой давуу эрхийг хасах замаар хөрөнгө татах боломжтой байдаг. Шинээр гаргах аливаа хувьцааг нээлттэй эсхүл хаалттай арилжсанаас үл хамааран арилжсанаас хойш 6 сарын хугацаанд түгжих боломжтой байдаг ба энэ хугацаанд Үнэт цаас гаргагч нь хувьцааг арилжих, шилжүүлэх, тараахыг боломжгүй байдаг. Нэмж хувьцаа гаргах үйл явц нь хөрөнгө оруулагчдын хувь эзэмшлийг бууруулах тохиолдол (нэмэлт хувьцаанаас худалдан аваагүй хөрөнгө оруулагчдын хувьд) байдаг ба хувьцааны үнийн хэлбэлзлийг мөн үүсгэх магадлалтай.

**9.9.4. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь ирээдүйд их хэмжээгээр хувьцаагаа арилжих болон арилжих магадлал нь энгийн хувьцааны зах зээлийн үнэд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.**

Нээлттэй хувьцаа гаргаж дууссанаар одоогийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 94.99%-ийг эзэмшинэ. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь анхдагч зах зээлийн арилжаа амжилттай хийгдсэнээс хойш 180 хоногийн хугацаанд хувьцааг арилжих болон шилжүүлэх боломжгүйгээр түгжихийг зөвшөөрдөг болович энэхүү хугацаа дууссанаар эзэмшиж буй хувьцаагаа зарах, шилжүүлэх эрх нь нээлттэй болдог. Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч нь өөрийн эзэмшлийн хувьцааг их хэмжээгээр нийтэд арилжих нь энгийн хувьцааны үнийг унагах магадлалтай бөгөөд ирээдүйд Үнэт цаас гаргагч нь нэмэлт хувьцаа гаргах чадамжид сөргөөр нөлөөлж болзошгүй.

Аливаа хөрөнгө оруулагч нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 5-аас дээш хувийг эзэмших тохиолдолд зохицуулагч байгууллагаас /Монголбанкны журмын дагуу/ зөвшөөрөл авах шаардлагатай ба зохицуулагч байгууллагаас эцсийн өмчлөгчийг зохих ёсоор тогтоогоогүй тохиолдолд зөвшөөрөл гарах хугацаа уртсах магадлалтай байдаг. Зөвшөөрөл гараагүй тохиолдолд тус хувьцаа нь Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хэмжээнд сөргөөр нөлөөлж болзошгүй бөгөөд Үнэт цаас гаргагчийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ, стратеги зорилтод хүндрэл үүсгэж болзошгүй.

**9.9.5. Энгийн хувьцааны зах зээлийн үнэ нь зах зээлийн нөхцөл байдал болон үнэт цаас гаргагчийн хянах боломжгүй бусад хүчин зүйлүүдийн сөрөг нөлөөллийн улмаас хэлбэлзэж болзошгүй.**

Доорх хүчин зүйлс нь энгийн хувьцааны зах зээлийн үнэд сөргөөр нөлөөлж үнийн хэлбэлзэл үүсгэж болзошгүй. Үүнд:

- Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны болон санхүүгийн үзүүлэлт, хэтийн төлөв;
- Үнэт цаас гаргагч болон бусад өрсөлдөгчөөс зарласан шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээ;
- Стратегийн хөрөнгө оруулалт, томоохон хэмжээний гэрээ, хэлэлцээр, худалдан авалт;
- Хууль эрх зүйн асуудал, үүнтэй холбоотой олон нийтэд сөрөг мэдээлэл тархах;

- Хөрөнгө оруулагчдын хандлага, үнэт цаас гаргагчийн хувьцааг сонирхох сонирхол өөрчлөгдөх;
- Шинжээчдийн тооцоолсон үнэт цаас гаргагчийн ашиг, орлогын хэмжээ өөрчлөгдөх;
- Бусад санхүүгийн байгууллагуудын шинээр санал болгосон хувьцаа;
- Үнэт Цаас гаргагчийн богино болон дунд хугацааны санхүүгийн үзүүлэлтэд өөрчлөлт орох, эсхүл бусад ижил төрлийн үйл ажиллагаа үзүүлэгчидтэй харьцуулахад хэт зөрүүтэй байх;
- Энгийн хувьцаа, үнэт цаас гаргах, хувьцаа эзэмшигч нь их хэмжээний хувьцаагаа арилжих, өр зээлийн хэмжээ нэмэгдэх зэргээр үнэт цаас гаргагчийн хөрөнгийн бүтцэд өөрчлөлт орох;
- Гүйцэтгэх удирдлага ажлаас гарах, өөрчлөгдөх;
- Үнэт цаас гаргагчийн нэр хүндэд сөргөөр нөлөөлсөн үйл явдал тохиолдох;
- Зах зээл, эдийн засгийн ерөнхий нөхцөл байдал өөрчлөгдөх;
- Банкны салбарын нөхцөл байдал өөрчлөгдөх;
- Холбогдох хууль журамд өөрчлөлт орох, зохицуулагч байгууллагаас авсан арга хэмжээнүүд.

Хөрөнгийн зах зээл нь дахь үнэ болон хэмжээний хэлбэлзэл нь тухайн бүртгэл бүхий байгууллагын санхүү бизнесийн гүйцэтгэлтэй шууд хамаарал бага байгаа ба Үнэт цаас гаргагчийн хувьд мөн адил гүйцэтгэлээс үл хамааран үнийн хэлбэлзэл байж болзошгүй.

**9.9.6. Үнэт цаас гаргагчийн дүрэмд өөрчлөлт оруулах, үнэт цаас гаргагчийн нэр, албан хаяг, зорилгод өөрчлөлт оруулах, томоохон хэмжээний хэлцлийг шийдвэрлэхэд хувьцаа эзэмшигчдийн хурлын олонхын санал шаардлагатай байдаг. Энэ үед зарим асуудлууд нь Үнэт цаас гаргагч болон оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн хэдий ч хувьцаа эзэмшигчдийн хурал дээр олонхын санал авч чадахгүй байх магадлалтай байдаг.**

Хувь эзэмшигчдийн хурлаар Үнэт цаас гаргагчийн дүрэм, нэр, албан хаяг, зорилгод өөрчлөлт оруулах болон томоохон хэмжээний хэлцлийг /дүрэмд заасан/ батлахад хувьцаа эзэмшигчдийн саналын гуравны хоёроос багагүй санал шаардлагатай ба тухайн санал нь Үнэт цаас гаргагчийн нийт гаргасан хувьцааны 50-с дээш хувийг төлөөлөх шаардлагатай байдаг. Энэ үед зарим асуудлууд нь Үнэт цаас гаргагч болон оролцогч талуудын ашиг сонирхолд нийцсэн хэдий ч хувьцаа эзэмшигчдийн хурал дээр дэмжигдэхгүй байх эрсдэлтэй.

**9.9.7. Үнэт цаас гаргагчийн санал болгож буй хувьцааны хоёрдогч зах зээл дээрх идэвх тодорхойгүй байгаа нь үнийн хэт хэлбэлзлийг бий болгох эрсдэлтэй.**

Үнэт цаас гаргагч нь анх удаа нийтэд хувьцааг санал болгож байгаа буюу Үнэт цаас гаргагчийн хувьцааны хоёрдогч зах зээл одоогийн байдлаар бий болоогүй байна. Хувьцааг нийтэд санал болгон арилжаалсны дараагаар хоёрдогч зах зээлийн арилжаа хэрхэн явагдах, хангалттай нийлүүлэлт, эрэлт бий болох эсэхэд ямар нэг таамаг дэвшүүлэх боломжгүй юм. Хэрэв хоёрдогч зах зээлийн арилжааны идэвх сул байх аваас хувьцааны үнийн хэлбэлзэл огцом байх, зэх зээлийн үнийн түвшин доогуур тогтоогдох магадлалтай.

**9.9.8. Санал болгож буй энгийн хувьцааны үнэ анхны үнээс унах эрсдэл ямагт байдаг.**

Үнэт цаасны анх санал болгож буй үнэ нь тухайн үнэт цаасны зах зээлийн бодит үнээс зөрүүтэй байх эрсдэл ямагт байдаг. Энгийн хувьцааны үнэ нь Үнэт цаас гаргагчийн өөрийн

үйл ажиллагаа эсхүл үйл ажиллагаагаа явуулдаг салбар мөн зах зээлийн нөхцөл байдал, Үнэт цаас гаргагчийн хянах боломжгүй бусад хүчин зүйлүүдээс шалтгаалан хэлбэлзэх, савлах, унах магадлалтай ба Үнэт цаас гаргагч нь эдгээр шалтгаануудын улмаас хувьцааны үнийг анх санал болгож буй үнээс унахгүй байна гэдэгт ямар нэг баталгаа өгөх боломжгүй.

**9.9.9. Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилтгүй болсон хувьцааны захиалга болон түүнтэй холбоотой бүх хэлцэл хүчингүйд тооцогдоно.**

Монгол Улсын Хөрөнгийн бирж дээр анх удаа хувьцаа гарган олон нийтэд “ХАС” симбол дор санал болгох албан хүсэлтийг Үнэт цаас гаргагч нь холбогдох зохицуулагч байгууллага болон биржид хүргүүлсэн. Үнэт цаасны танилцуулгын өмнө хэсгүүдэд дурдсаны дагуу холбогдох зөвшөөрөл гарч, бүртгэл хийгдсэнээр үнэт цаасны анхдагч болон хоёрдогч зах зээлийн арилжаа эхлэх болно. Хэрэв ямар нэг нөхцөл байдлын улмаас үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаа амжилтгүй болсон гэж холбогдох байгууллагаас үзсэн тохиолдолд тус өдөр хүртэлх бүхий л хэлцэл, гүйлгээ нь цуцлагдсан гэж үзэх ба хөрөнгө оруулагчдын заасан дансанд захиалга хийсэн мөнгөн хөрөнгийг буцаан шилжүүлнэ. Буцаан шилжүүлэх мөнгөн хөрөнгөд хүү болон алданги тооцохгүй.

**9.9.10. Хувьцаанд хөрөнгө оруулахдаа Төгрөгөөс бусад валютаар арилжаа хийх нь гадаад валютын эрсдэлд оруулах магадлалтай.**

Хувьцааг төгрөгөөр арилжих бөгөөд ногдол ашгийг төгрөгөөр төлнө. Төгрөгөөс бусад валютаар арилжаа хийсэн хөрөнгө оруулагчид нь төгрөгийн ханш унасан тохиолдолд алдагдал хүлээж болзошгүйгээс гадна төгрөгийг бусад валют руу хөрвүүлэх нэмэлт зардал гарна. Хэрэв хөрөнгө оруулагч нь бусад валютаар арилжаа хийх бол санхүүгийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгчээс зөвлөгөө авахыг зөвлөж байна.

# Арав. ОРОЛЦОГЧ ТАЛУУДЫН МЭДЭЭЛЭЛ

## 10.1 Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцож буй этгээдүүдийн ашиг сонирхлын зөрчлийн талаарх мэдэгдэл

Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд дараах талууд оролцсон болно. Үүнд: Райнос Инвестмент ҮЦК ХХК ("Үндсэн андеррайтер"), Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК (Туслах андеррайтер), Өмгөөллийн "Батбаяр энд Партнерс" ХХН (Хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч), БДО Аудит ХХК (Хараат бус үнэлгээчин), Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК (Хараат бус аудитор).

Оролцогч талууд нь үнэт цаас гаргахтай холбоотой хөндлөнгийн үнэлгээ, дүгнэлт болон бусад гэрээт ажлыг СЗХ болон МХБ-ийн баталсан "Үнэт Цаас Бүртгэх Журам"-ийн дагуу хийж гүйцэтгэсэн болно.

Үнэт цаас гаргагч нь Үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцсон талууд буюу үндсэн андеррайтер, туслах андеррайтер, хараат бус үнэлгээчин, хөндлөнгийн аудитор, хуулийн зөвлөх болон тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбогдох этгээдтэй холбоотой тал биш бөгөөд ашиг сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна. Мөн Үнэт цаас гаргах ажиллагаанд оролцогч байгууллагууд нь холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Үнэт цаас гаргагчтай холбоотой үүсч болзошгүй аливаа сонирхлын зөрчлөөс сэргийлэх тухай мэдэгдэл гаргаж, тус тусын тодорхойлох захидал, дүгнэлт тайлангуудад тусгасан болно.

## 10.2 Үндсэн андеррайтер

### 10.2.1 Компанийн танилцуулга

"Райнос Инвестмент ҮЦК" ХХК нь БНСУ-ын хуулийн этгээд Райнос Эссет Менежмент ХХК-ийн 100 хувийн хөрөнгө оруулалттайгаар 2019 онд анх үүсгэн байгуулагдсан бөгөөд Монгол улсын хөрөнгийн зах зээлд амжилттай үйл ажиллагаагаа явуулж байна. "Райнос Инвестмент ҮЦК" ХХК нь Брокер, Дилер, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Гадаад улсын зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах, Номинал дансаар дамжуулан үнэт цаасны брокерын цогц үйлчилгээг Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу эрхэлж байгаа бөгөөд гадаадын хөрөнгийн зах зээлд бонд зуучлах, хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээг үзүүлж эхлээд байна. Үйл ажиллагаа явуулж эхлээд удаагүй боловч манай компани гадаадын зах зээлд арилжаалагдаж буй Монгол Улсын Засгийн Газрын Бонд болон санхүүгийн байгууллагын бондуудад гадаадын хөрөнгө оруулагчдыг амжилттай зуучлаад байна.

"Райнос Инвестмент ҮЦК" ХХК-ний толгой компани болох "Райнос Эссет Менежмент ХХК" нь хувьцаанд хөрвөх нөхцөлтэй бондод хөрөнгө оруулах чиглэлээр мэргэшсэн БНСУ-ын нэр хүндтэй компани юм. Мөн дэлхийн 120 гаруй компаниудад амжилттай хөрөнгө оруулалт хийсэн ба хөгжингүй орнуудад хөрөнгө оруулаад зогсохгүй хөгжиж буй зах зээл тэр дундаа Монголын хөрөнгийн зах зээлд хэд хэдэн хөрөнгө оруулалтыг амжилттай хийгээд байна.

Хүснэгт 48: Үндсэн андеррайтерийн мэдээлэл

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 6481299 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Андеррайтинг, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер |
| **Бүртгэгдсэн хаяг:** | Монгол улс, Улаанбаатар хот 14200, Сүхбаатар дүүрэг-8, Д.Сүхбаатарын талбай-2, Сэнтрал тауэр, 13 давхар, 1308б тоот |

| | |
|---|---|
| Утасны дугаар: | 7510-0575 |
| Имэйл: | info@rhinosinvest.mn |

Райнос Инвестмент ҮЦК ХХК-ийн толгой компани болох Райнос Ассет Менежмент ХХК-ийн Монгол Улсад хийсэн томоохон хөрөнгө оруулалтууд:

- Монголын анхны финтек компани болох ЛэндМН ББСБ-ын IPO-д стратегийн хөрөнгө оруулалт хийсэн.
- Монголын хөрөнгийн зах зээлийн түүхэнд анх удаа 7 тэрбум төгрөгийн бондыг амжилттай босгосон.
- 2017 оноос хойш Солонгосын хөрөнгө оруулалтын сантай хамтран Монголын аж ахуйн нэгжүүдийн өсөлтийг дэмжих зорилгоор нийт 14 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.
- 2017-2019 онд Монгол Улсын Хөгжлийн Банкнаас гаргасан Хадгаламжийн Сертификатад нийт 210.0 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийсэн.
- 2021 онд технологийн гарааны компанид 2.0 сая долларын хөрвөх бондын санхүүжилт олгосон.

## 10.3 Туслах андеррайтер

### 10.3.1 Компанийн танилцуулга

Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК нь 2007 онд үүсгэн байгуулагдсан, брокер, дилер, андеррайтер, IPO, хувийн байршуулалт, хөрөнгө оруулалтын зөвлөх зэрэг олон төрлийн хөрөнгө оруулалтын банкны үйлчилгээг санал болгох зорилготой үнэт цаасны компани юм. Тус компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос тусгай зөвшөөрөл авсан, Монголын Хөрөнгийн Бирж, Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны гишүүн байгууллага юм. Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК нь үүсгэн байгуулагдсан цагаасаа эхлэн Монгол Улсын үнэт цаасны зах зээлд шинэ бүтээгдэхүүн, үйлчилгээг нэвтрүүлэх чиглэлээр ажилласаар ирсэн. Тус компани нь олон улсын зах зээлд брокерын үүрэг гүйцэтгэж байгаа анхны дотоодын үнэт цаасны компани бөгөөд HKEX, LSE, ASX, NYSE зэрэг олон улсын гол биржүүд дээр хувьцааны брокерын үйл ажиллагаа явуулдаг.

Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК Монголын Үнэт Цаасны Арилжаа Эрхлэгчдийн Холбооны "2011 оны шилдэг брокерын компани, "GRAND BULL AWARDS – 2013 оны ШИЛДЭГ ШИНИЙГ САНААЧЛАГЧ" зэрэг шагнал хүртэж байсан бөгөөд, “GRAND BULL AWARDS – ШИЛДЭГ МЭРГЭЖИЛТЭН 2018” шагналаар тус компанийн ерөнхий захирал Б.Өлзийбаяр шагнуулж байсан.

Хүснэгт 49: Туслах андеррайтерийн мэдээлэл

| | |
|---|---|
| Улсын бүртгэлийн дугаар: | 5183855 |
| Үйл ажиллагааны чиглэл: | Андеррайтинг, Хөрөнгө оруулалтын зөвлөх, Брокер, Дилер |
| Бүртгэгдсэн хаяг: | Монгол Улс, Улаанбаатар 14200, СБД, 8-р хороо, Сити Товер, 2506 тоот |
| Утасны дугаар: | 7711-6377 |
| Имэйл: | info@ucc.mn |

Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-ийн хийсэн томоохон хөрөнгө оруулалтууд:

- Монголын уул уурхайн компани анх удаа Хонг Конгийн бирж дээр IPO хийж 750.0 сая ам.долларын санхүүжилтийг олон нийтээс татах үйл ажиллагаанд брокероор ажилласан.
- СиПиЭс Интернэйшнл ХХК-ийн албан ёсны төлөөлөгч бөгөөд Хүнн Коул, Аспайр Маининг, Вояжир Рисорсис, Вулф Петролум, Харанга Рисорсис зэрэг Монголын хэд хэдэн уул уурхайн хайгуулын компаниудын андеррайтераар ажиллаж байсан.
- Ард Кредитийн IPO-д андеррайтераар ажиллахдаа 5.3 тэрбум төгрөг босгосон бөгөөд энэ үед Монгол Улсад анх удаа захиалгын бүртгэлийн аргыг амжилттай нэвтрүүлсэн. Тус IPO-н үед олон нийтээс 7.3 тэрбум төгрөг, стратегийн хөрөнгө оруулагчдаас 2.5 тэрбум төгрөгийн захиалгын хүлээн авч, төлөвлөгөөт захиалгын хэмжээ 300%-иар давсан.
- Төрийн Банк ХК-ийн олон нийтэд анх хувьцааг гаргах ажлын үндсэн андеррайтерээр ажилсан ба нийт 43 сая ширхэг хувьцааг арилжаалж, 25.4 тэр бум төгрөгийн хөрөнгийг олон нийтээс татан төвлөрүүлсэн байна.

### 10.3.2 Андеррайтерын гэрээний тухай

Үндсэн андеррайтер болох Райнос Инвестмент ҮЦК ХХК нь туслах андеррайтер болох Өлзий энд Ко Секьюрити ХХК-тай хамт, 2023 оны 3 дугаар сарын 13-ний өдөр Үнэт цаас гаргагчтай андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээг байгуулсан. Гэрээнд заасны дагуу үндсэн андеррайтер Райнос Инвестмент ХХК болон туслах андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК нь Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон Санхүүгийн Зохицуулах Хорооны холбогдох журмуудын дагуу брокер, дилер, андеррайтер, хөрөнгө оруулалтын зөвлөхийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байгууллагууд юм. Андеррайтерууд нь гэрээнд заасан нөхцөл, болзлын дагуу Үнэт цаас гаргагчийн олон нийтэд хувьцаа гаргах үйл ажиллагаанд оролцохоор тохиролцсон болно.

Андеррайтеруудаас Үнэт цаас гаргагчид үзүүлэхээр тохиролцсон үндсэн үйлчилгээг холбогдох хууль тогтоомжийн дагуу үнэт цаасны танилцуулга бэлтгэх, боломжит хөрөнгө оруулагчдыг тодорхойлох, Үнэт цаас гаргагчийн нэрийн өмнөөс хөрөнгө оруулалтын саналыг танилцуулах гэж гэрээнд тодорхойлсон. Цаашилбал, андеррайтерууд нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3-т заасны дагуу "хөрөнгө оруулагчдад тухайн үнэт цаасыг танилцуулах замаар түүнийг худалдахад шаардлагатай бүх хүчин чармайлт гаргах" хэлбэрээр үнэт цаас гаргах үйл ажиллагаанд оролцохоор тохиролцсон байна.

Гэрээнд заасны дагуу Үнэт цаас гаргагч нь Андеррайтерийн санал болгосон хугацаанд үйлчилгээг шуурхай, бүрэн, хангалттай үзүүлэхэд шаардлагатай гэж үзсэн бүх мэдээлэл, баримт бичиг, шийдвэр, зөвшөөрлийг гаргаж өгөх үүрэгтэй.

## 10.4 Хуулийн Фирм

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН ("Хуулийн фирм") нь 2013 оны 6 дугаар сарын 18-ны өдөр улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн мэргэшсэн бизнесийн Хуулийн фирм юм. Тус Хуулийн фирм нь концесс, төр хувийн хэвшлийн түншлэл (дэд бүтэц - төмөр зам, авто зам, угаах үйлдвэр, барилга, эрчим хүчний салбар), бизнес, компанийн хууль, эрх зүйн түгээмэл тохиолддог асуудлуудаар аж ахуй нэгж, бизнес эрхлэгч, компаниудад хууль зүйн зөвлөх үйлчилгээ үзүүлдэг бөгөөд уул уурхай, барилга, ашигт малтмал, санхүүгийн салбарт мэргэшсэн туршлагатай.

Хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн Зохицуулах Хорооны 2014 оны №72 тоот тогтоолын дагуу авсан бөгөөд үнэт цаасны зах зээлийн оролцогчдод хууль зүйн туслалцаа, хөндлөнгийн дүгнэлт гаргаж өгөх үйлчилгээ үзүүлэх эрхтэй, гадаад, дотоодын хөрөнгийн биржид хувьцаа, өрийн бичиг, хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргахад үнэт цаасны зах зээлийн бүхий л үе шатанд ажиллаж байсан туршлагатай.

Хүснэгт 50: Хуулийн фирмийн мэдээлэл

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 5722292 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Хууль зүйн зөвлөгөө өгөх |
| **Бүртгэгдсэн хаяг:** | Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө-8, Монгол ТВ цамхаг, 10 давхар, 1001-1003 тоот |
| **Утасны дугаар:** | 7711-9008 |
| **Имэйл:** | contact@bnp.mn |

Хуулийн фирмийн ажилласан зарим ажлаас дурдвал:

- Төрийн Банкны IPO,
- Симпл ассет ТЗК-ийн хөрөнгөөр баталгаажсан баталгаат үнэт цаас гаргах ажил;
- Сэнтрал Экспресс Си Ви Эс-ийн /CU/ IPO гаргах;
- МИК ОССК-ийн 250 сая ам.долларын бонд гаргах;
- Эрдэнэс-Тавантолгой ХК-ийн 2 их наяд төгрөг бонд гаргах;
- МИК ОССК-ийн 300 сая ам.долларын бонд гаргах;
- Мандал даатгал-ийн IPO;
- МОСТ Финтек-ийн IPO;
- Тусгай зориулалтын компанийг АПУ ХК-тай нэгтгэх ажил;
- Улаанбаатар БҮК ХК-аас хувьцаа нэмж гаргах, өрийг хувьцаагаар солих ажил;
- МИК ОССК-ийн ипотекийн зээлээр баталгаажсан бонд гаргах зэрэг ажил тус тус хууль зүйн зөвлөгөө, дүгнэлт гаргаж ажилласан.

### 10.4.1 Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний тухай

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН нь Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-тай 2021 оны 10 дугаар сарын 08-ны өдөр байгуулсан №14/21-045 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ болон 2023 оны 01 дүгээр сарын 20-ны өдөр байгуулсан №14/21-045-01 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээний нэмэлт нөхцөлийн дагуу ХасБанк ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэх, улмаар хуулийн дүгнэлт гаргах ажлыг хийхээр тохиролцсон.

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-аас гаргаж өгсөн мэдээлэл, баримт, материалыг шалгаж, СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам", МХБ ТӨХК-ийн "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын хүрээнд Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлтийг бэлтгэхээр тохиролцсон.

## 10.5 Хөндлөнгийн үнэлгээний байгууллага

### 10.5.1 Компанийн танилцуулга

БДО нь аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний дэлхийн тав дахь том сүлжээ юм. Тус компани нь дэлхийн 167 оронд өөрийн 1,728 салбар оффисоор дамжуулан 97,292 гаруй ажилчидтай үйл ажиллагаа явуулж байна. БДО-ийн Монгол дахь оффис 2012 оны 12 сард Улаанбаатар хотноо БДО Монгол Нэртэйгээр Монгол улсын аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээний салбарт 15 жилийн туршлагатай Итгэлт Аудит ХХК-ийн суурин дээр үүсгэн байгуулагдсан. БДО Монгол нь Улаанбаатар хотод байрладаг бөгөөд зөвлөх үйлчилгээний БДО Консалтинг ХХК, аудит ба баталгаажуулах үйлчилгээний БДО Аудит ХХК болон татварын цогц үйлчилгээний БДО Такс ТМЗ ХХК нэрийн дор 2 партнер, 50 орчим ажилчидтай үйл ажиллагаа явуулж байна. Тус компани нь уул уурхай, үйлдвэрлэл, санхүү, техник технологи гэх мэт Монгол улсын гол салбаруудад үйл ажиллагаа эрхэлдэг аж ахуйн нэгжүүдэд үйлчилгээ үзүүлдэг.

Хүснэгт 51: Хөндлөнгийн үнэлгээний байгууллагын мэдээлэл

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 2546442 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Аудит, нягтлан бодох бүртгэл, зөвлөх үйлчилгээ |
| **Бүртгэгдсэн хаяг:** | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р Хороо, Нарны Зам-62, Юнескогийн Гудамж, Юнион Бюлдинг, Б Блок, 15-р давхар, 1502 тоот |
| **Утасны дугаар:** | 7740-4040 |
| **Имэйл:** | info@bdo.mn |

### 10.5.2 Бизнесийн үнэлгээний гэрээний тухай

БДО Аудит ХХК нь 2023 оны 2 сарын 2-ны өдөр Үнэт цаас гаргагчтай байгуулсан Хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх гэрээг байгуулсан байна. Тус гэрээний хүрээнд Олон Улсын Үнэлгээний Стандарт, Монгол Улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, шаардлагын дагуу үнэт цаасны зах зээл дээр шинээр хувьцаа гаргах үйл ажиллагаанд зориулан Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх хөрөнгийн болон бизнесийн үнэлгээ хийх, тайлан гаргахаар тусгасан байна.

Гэрээний хүрээнд Үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчид хөрөнгийн болон бизнесийн үйлчилгээ үзүүлэх хуулийн этгээдийн хувьд эрх бүхий байгууллагуудаас баталсан холбогдох журам, стандартын дагуу Үнэт цаас гаргагчийн нэгтгэсэн бизнесийн үнэлгээ, газар эзэмших, ашиглах эрх болон үл хөдлөх хөрөнгийн 2022 оны 12 сарын 31-ний өдрөөрх бодит үнэ цэнийг тодорхойлох хөрөнгийн үнэлгээ хийх, тэдгээрт тусгагдсан мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг баталгаажуулах, гаргасан дүгнэлтийн хариуцлагыг хүлээн ажиллах, холбогдох ажиллагаа хийх бүрд тэмдэглэл хөтлөх, ажлын явцын үр дүн, гарч болох эрсдэл, нөхцөл байдлын талаар шуурхай мэдээлэл өгөх, гэрээт ажлыг гүйцэтгэх явцад аливаа байдлаар сонирхлын зөрчил үүсэх нөхцөл байдал бий болсон тохиолдолд даруй мэдэгдэх, үйлчлүүлэгчийн эрх, ашиг хууль ёсны сонирхлын эсрэг аливаа үйлдэл хийхгүй байх үүрэг хүлээсэн байна.

Гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагч нь Үнэлгээний компанид гэрээт ажилтай холбоотой Компанийн бизнес төлөвлөгөө, хөрөнгө оруулалтын төлөвлөгөө, удирдлагын дотоод мэдээлэл зэрэг бүхий л мэдээлэл, шаардлагатай нэмэлт баримт, материалыг шаардсан

тухай бүрд нь бүрэн гүйцэд, үнэн зөв гаргаж өгөх бөгөөд гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхэд нь шаардагдах бүх талын дэмжлэг үзүүлэх; үнэлгээний байгууллагыг өөрийн байранд нэвтрүүлэх, уулзалт хийх, дүгнэлт гаргахад шаардлагатай холбогдох мэдээллийг авах, шалгах ажлыг гүйцэтгэх орчноор хангах, тухайн мэдээлэл, баримтыг хариуцсан ажилтнуудыг томилж ажиллуулах, мэдээ, материал, түүний агуулгыг тодорхойлоход туслах зэрэг ажлыг үнэн зөв, цаг хугацаанд нь гүйцэтгэхэд шаардлагатай бусад ажлын зохион байгуулах үүргүүд тус тус багтсан байна.

## 10.6 Хөндлөнгийн Аудитор

### 10.6.1 Компанийн танилцуулга

EY нь 2001 оноос хойш Монгол улсад үйл ажиллагаагаа явуулж байгаа бөгөөд аудит, татвар, зөвлөх үйлчилгээ эрхлэх зөвшөөрлийг Сангийн яамнаас авсан. Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК нь дэлхийн 150 гаруй орны 260,000 гаруй ажилтантай EY Глобал группын гишүүн компани юм. Тус компани Монголын бизнес, эдийн засгийн өсөлтийг дэмжихийн тулд дотоодын болон дэлхийн хэмжээн дэх сайн туршлагууд, нөөц бололцоогоо ашиглан ажилладаг. Олон жилийн турш EY Монголиа нь Монголын уул уурхай, банк санхүү, жижиглэн худалдаа, үйлдвэрлэлийн салбар дахь томоохон байгууллагуудын аудитор, бизнесийн зөвлөхөөр ажиллаж ирсэн.

EY Монголиа-н боловсон хүчин нь Монгол дахь үйлчлүүлэгчдийнхээ хэрэгцээг хангахад шаардлагатай чадвар, туршлагыг эзэмшсэн мэргэжилтнүүд байдаг бөгөөд хөгжиж буй зах зээлд үйлчлүүлэгчдийнхээ өөрчлөгдөж буй хэрэгцээг ойлгож, тохирсон үйлчилгээг үзүүлэх чадвартай дотоодын болон олон улсын мэргэжилтнүүдтэй баг ажиллаж байна.

Хүснэгт 52: Хөндлөнгийн аудиторын мэдээлэл

| | |
|---|---|
| **Улсын бүртгэлийн дугаар:** | 2665247 |
| **Үйл ажиллагааны чиглэл:** | Аудит, татвар, зөвлөх үйлчилгээ |
| **Бүртгэгдсэн хаяг:** | Монгол Улс, Улаанбаатар, Сөүлийн гудамж 21, Найман Зовхис, 200 тоот |
| **Утасны дугаар:** | 7013-4032 |
| **Имэйл:** | Khabylkhairat.Bulanbai@mn.ey.com |

### 10.6.2 Аудитын гэрээний тухай

Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК болон Үнэт цаас гаргач нь 2022 оны 7-н сарын 6-ний өдөр хөндлөнгийн аудитын гэрээн гарын үсэг зурсан. Уг гэрээнд Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Үнэт цаас гаргагчийн санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайланг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартын (“СТОУС”) жишигт нийцүүлэн Аудитын Олон Улсын Стандардын дагуу аудит хийж гүйцэтгэхээр заасан байна.

Аудитын компани нь Аудитын Олон Улсын Стандардын дагуу аудитын үйлчилгээг үзүүлнэ. Энэхүү стандард нь Аудитороос хараат бус байх болон аудиттай хамааралтай ёс зүйн бусад шаардлагуудыг биелүүлж ажиллахыг шаарддаг.

Үнэт цаас гаргагчийн удирдлага нь санхүүгийн тайланг СТОУС-н дагуу үнэн зөв бэлдэх ба тус тайланд агуулагдаж буй Үнэт цаас гаргагчийн хэлцэл, гүйлгээ, санхүүгийн нөхцөл байдлын талаарх мэдээллийг үнэн зөв бүртгэх үүрэгтэй.

Үнэт цаас гаргагчийн удирдлага нь аудитад хамааралтай мэдээллийг Аудиторт гаргаж өгөх, мөн аудитын үйл ажиллагаанд холбоо бүхий Үнэт цаас гаргагчийн ажилтантай чөлөөтэй харилцах боломжийг бүрдүүлэх үүрэгтэй.

# ХАВСРАЛТ 1: Аудитлагдсан санхүүгийн тайлан 2022 он

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

2023 оны 4 дүгээр сарын 5

Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХасБанк ХХК

ХасБанкны Байр
Ерөнхий Сайд Амарын гудамж,
Шуудангийн Салбар # 46, Шуудангийн Хайрцаг 721,
Улаанбаатар 14200
Монгол Улс

Эрхэм хүндэт танаа,

**ХасБанк ХХК ("Банк")**

**Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгүүлэх**

Банкны хувьцаагаа Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анх удаа нээлттэй хүрээнд санал болгож байгаатай холбогдуулан бэлдсэн 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн Үнэт Цаасны Танилцуулга ("ҮЦТ")-ын дагуу бид энэхүү консент бичгийг илгээв.

2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Банкны санхүүгийн тайлангуудад бидний 2023 оны 3 дугаар сарын 15 болон 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр өгсөн аудиторын тайлан дүгнэлтийг дээрх ҮЦТ-д хавсаргахыг мөн манай компанийн нэрийг хийгдсэн ажил агуулгын хүрээнд дурдахыг зөвшөөрч байна.

2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Банкны санхүүгийн тайлангуудыг аудиторын тайлан дүгнэлтийн хамт цаашид "Санхүүгийн мэдээлэл" гэж нэрлэнэ.

Санхүүгийн мэдээллийг зөвхөн бүрэн эхээр нь нийтлэх ба ямар нэгэн өөрчлөлт, засвар оруулахыг хориглоно. Агуулгаас гадуур Санхүүгийн мэдээллийг хэсэгчлэн ашиглахыг хориглох ба Санхүүгийн мэдээллийг дурдах бүртээ ил тод, үнэн зөв илэрхийлэх ёстой.

Энэхүү консент бичгийг дээр дурдсан аудиторын тайланг ямар нэгэн байдлаар шинэчлэх эсвэл шинэчлэн сайжруулахтай холбон тайлбарлаж болохгүй ба тайлан гарсан өдрөөрх тухайн тайланг зориулан гаргасан этгээдээс бусад гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно. Тодруулбал, аливаа хөрөнгө оруулагчид, боломжит хөрөнгө оруулагчид, төрийн байгууллагууд эсвэл бусад оролцогч талууд нь уг аудиторын дүгнэлт тайланд тулгуурлах нь бидний хувьд хамааралгүй болно. Бид үүгээр Үнэт цаасны танилцуулгын агуулга болон/эсвэл Банкны хувьцааг санал болгох, хөрөнгийн бирж дээр бүртгүүлэхтэй холбоотой аливаа хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү захидлыг зөвхөн таны хувийн мэдээлэлд зориулсан болно. Үүнийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нийтлэх, эсвэл ҮЦТ болон түүнтэй холбоотой бусад нийтлэл, мэдээлэлд дурдах ёсгүй бөгөөд өөр зорилгоор ашиглах, тараах, иш татах болон өөрөөр дурдахыг хориглоно.

Хүндэтгэсэн,

Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

АДРИАН ЧУ
Партнер



A member firm of Ernst & Young Global Limited

EY
Building a better working world

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 0 5
БҮРТГЭВ-02

**ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫГ УНШИЖ, САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ДҮН, ХУВИЙГ ХОЛБОГДОХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНТАЙ ХАРЬЦУУЛСАН ХАРИЛЦАН ТОХИРОЛЦСОН ГОРИМ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ**

Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХасБанк ХХК

ХасБанкны Байр
Ерөнхий Сайд Амарын гудамж,
Шуудангийн Салбар # 46, Шуудангийн Хайрцаг 721,
Улаанбаатар хот 14200,
Монгол Улс

*2023 оны 4 дүгээр сарын 5*

Бид ХасБанк ХХК (цаашид “Банк” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрүүдээрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад (цаашид хамтад нь “Аудитлагдсан санхүүгийн тайлангууд” гэх) аудит хийж гүйцэтгэсэн. Аудитлагдсан санхүүгийн тайлангуудын зорилгыг бид тайлангийнхаа “Бусад зүйл” хэсэгт тодорхойлсон.

Эдгээр Аудитлагдсан санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргадаг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу тайлагнагдсан ба бид 2023 оны 3 дугаар сарын 15 болон 2022 оны 3 дугаар сарын 25-ний өдрүүдэд эдгээр Аудитлагдсан санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна хэмээн зөрчилгүй аудитын дүгнэлт өгсөн болно.

*Хамрах хүрээ ба зорилго*

Бид доор дурдсан ажлуудыг Банктай тохиролцсоны үр дүнд Банк хувьцаагаа Монголын хөрөнгийн бирж (МХБ)-д анх удаа гаргахаар төлөвлөж байгаатай холбогдуулан гаргасан 2023 оны 4 дүгээр сарын 5-ний өдрийн "Үнэт цаасны танилцуулга (ҮЦТ)"-т тусгасан түүхэн санхүүгийн мэдээллүүдийг Аудитлагдсан Санхүүгийн Тайлангуудтай харьцуулах ажлуудыг гүйцэтгэх зорилгоор хийсэн бөгөөд энэ тайлан нь өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй байх магадлалтай.



A member firm of Ernst & Young Global Limited

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

EY
Building a better working world

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

2023 оны 4 дүгээр сарын 5

Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХасБанк ХХК

ХасБанкны Байр
Ерөнхий Сайд Амарын гудамж,
Шуудангийн Салбар # 46, Шуудангийн Хайрцаг 721,
Улаанбаатар 14200
Монгол Улс

Эрхэм хүндэт танаа,

**ХасБанк ХХК (“Банк”)**

**Монголын Хөрөнгийн Бирж дээр бүртгүүлэх**

Банкны хувьцаагаа Монголын Хөрөнгийн Бирж дээр олон нийтэд анх удаа нээлттэй хүрээнд санал болгож байгаатай холбогдуулан бэлдсэн 2023 оны 4 дүгээр сарын 5-ны өдрийн Үнэт Цаасны Танилцуулга ("ҮЦТ")-ын дагуу бид энэхүү консент бичгийг илгээв.

2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Банкны санхүүгийн тайлангуудад бидний 2023 оны 3 дугаар сарын 15 болон 2022 оны 3 дугаар сарын 25-ны өдөр өгсөн аудиторын тайлан дүгнэлтийг дээрх ҮЦТ-д хавсаргахыг мөн манай компанийн нэрийг хийгдсэн ажил агуулгын хүрээнд дурдахыг зөвшөөрч байна.

2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлант жилийн Банкны санхүүгийн тайлангуудыг аудиторын тайлан дүгнэлтийн хамт цаашид “Санхүүгийн мэдээлэл” гэж нэрлэнэ.

Санхүүгийн мэдээллийг зөвхөн бүрэн эхээр нь нийтлэх ба ямар нэгэн өөрчлөлт, засвар оруулахыг хориглоно. Агуулгаас гадуур Санхүүгийн мэдээллийг хэсэгчлэн ашиглахыг хориглох ба Санхүүгийн мэдээллийг дурдах бүртээ ил тод, үнэн зөв илэрхийлэх ёстой.

Энэхүү консент бичгийг дээр дурдсан аудиторын тайланг ямар нэгэн байдлаар шинэчлэх эсвэл шинэчлэн сайжруулахтай холбон тайлбарлаж болохгүй ба тайлан гарсан өдрөөрх тухайн тайланг зориулан гаргасан этгээдээс бусад гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно. Тодруулбал, аливаа хөрөнгө оруулагчид, боломжит хөрөнгө оруулагчид, төрийн байгууллагууд эсвэл бусад оролцогч талууд нь уг аудиторын дүгнэлт тайланд тулгуурлах нь бидний хувьд хамааралгүй болно. Бид үүгээр Үнэт цаасны танилцуулгын агуулга болон/эсвэл Банкны хувьцааг санал болгох, хөрөнгийн бирж дээр бүртгүүлэхтэй холбоотой аливаа хариуцлага хүлээхгүй болно.

Энэхүү захидлыг зөвхөн таны хувийн мэдээлэлд зориулсан болно. Үүнийг бүхэлд нь эсвэл хэсэгчлэн нийтлэх, эсвэл ҮЦТ болон түүнтэй холбоотой бусад нийтлэл, мэдээлэлд дурдах ёсгүй бөгөөд өөр зорилгоор ашиглах, тараах, иш татах болон өөрөөр дурдахыг хориглоно.

Хүндэтгэсэн,

Ernst & Young Mongolia Audit LLC
ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК
Мэргэшсэн нягтлан бодогчид

АДРИАН ЧУ
Партнер

1



A member firm of Ernst & Young Global Limited

Building a better
working world

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

**ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫГ УНШИЖ, САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛТЭЙ ХОЛБООТОЙ ДҮН, ХУВИЙГ ХОЛБОГДОХ САНХҮҮГИЙН ТАЙЛАНТАЙ ХАРЬЦУУЛСАН ХАРИЛЦАН ТОХИРОЛЦСОН ГОРИМ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТУХАЙ АУДИТОРЫН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ**

Төлөөлөн Удирдах Зөвлөл
ХасБанк ХХК

ХасБанкны Байр
Ерөнхий Сайд Амарын гудамж,
Шуудангийн Салбар # 46, Шуудангийн Хайрцаг 721,
Улаанбаатар хот 14200,
Монгол Улс

*2023 оны 4 дүгээр сарын 5*

Бид ХасБанк ХХК (цаашид “Банк” гэх)-ийн 2022 оны 12 дугаар сарын 31 болон 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрүүдээрх санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад (цаашид хамтад нь “Аудитлагдсан санхүүгийн тайлангууд” гэх) аудит хийж гүйцэтгэсэн. Аудитлагдсан санхүүгийн тайлангуудын зорилгыг бид тайлангийнхаа “Бусад зүйл” хэсэгт тодорхойлсон.

Эдгээр Аудитлагдсан санхүүгийн тайлангууд нь Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөлөөс гаргадаг Санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (“СТОУС”)-ын дагуу тайлагнагдсан ба бид 2023 оны 3 дугаар сарын 15 болон 2022 оны 3 дугаар сарын 25-ний өдрүүдэд эдгээр Аудитлагдсан санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна хэмээн зөрчилгүй аудитын дүгнэлт өгсөн болно.

*Хамрах хүрээ ба зорилго*

Бид доор дурдсан ажлуудыг Банктай тохиролцсоны үр дүнд Банк хувьцаагаа Монголын хөрөнгийн бирж (МХБ)-д анх удаа гаргахаар төлөвлөж байгаатай холбогдуулан гаргасан 2023 оны 4 дүгээр сарын 5-ний өдрийн "Үнэт цаасны танилцуулга (ҮЦТ)"-т тусгасан түүхэн санхүүгийн мэдээллүүдийг Аудитлагдсан Санхүүгийн Тайлангуудтай харьцуулах ажлуудыг гүйцэтгэх зорилгоор хийсэн бөгөөд энэ тайлан нь өөр зорилгоор ашиглахад тохиромжгүй байх магадлалтай.



A member firm of Ernst & Young Global Limited

EY
Building a better working world

*Банкны үүрэг хариуцлага*

Харилцан Тохирсон Горимын (“ХТГ”)-ын хүрээнд хийж гүйцэтгэх горимуудыг уг гэрээний зорилгод нийцэж буйг Банк хүлээн зөвшөөрч байгаа. ҮЦТ-д толилуулсан мэдээллүүдийн үнэн зөв байдал болон эдгээр хийж гүйцэтгэх горимуудын хангалттай байдлыг Банк хариуцна.

*Бидний үүрэг хариуцлага*

Бид ХТГ-уудыг Холбогдох Үйлчилгээний Олон Улсын Стандарт (ХҮОУС) 4400 (Шинэчлэгдсэн), *Харилцан Тохиролцсон Горим Гүйцэтгэх Гэрээ*-ний дагуу хийж гүйцэтгэсэн. Харилцан тохиролцсон гэрээт ажил нь Банктай тохиролцсон горимуудыг хийж гүйцэтгэх, хийж гүйцэтгэсэн горимуудын бодит үр дүнг тайлагнахыг хэлнэ. Дор тайлбарласан ХТГ-той холбоотой хийгдэх ажил нь энэхүү тайлангийн зорилго эсвэл аливаа бусад зорилгод нийцэх эсэх эсвэл хангалттай эсэх дээр бид тайлбар хийгээгүй болно.

ХТГ-ууд нь Олон Улсын Аудитын Стандарт, Нягтлах Гэрээт Ажлын Олон Улсын Стандарт болон Баталгаажуулалтын Гэрээт Ажлын Олон Улсын Стандартуудын дагуу баталгаажуулалтын гэрээт ажил биш тул, бид аливаа дүгнэлт эсвэл баталгаа өгдөггүй. Хэрэв бид нэмэлт горимууд эсвэл Баталгаажуулалтын гэрээт ажил хийж гүйцэтгэсэн бол бидний анхаарлыг татсан та бүхэнд тайлагнах бусад асуудлууд гарах магадлалтай.

*Бидний хараат бус байдал ба чанарын хяналт*

Харилцан тохиролцсон гэрээт ажлыг гүйцэтгэхдээ бид Нягтлан Бодогчдын Олон Улсын Ёс Зүйн Стандартын Зөвлөл (НБОУЁЗСЗ)-өөс гаргасан Мэргэжлийн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэмд заасан ёс зүйн шаардлагыг дагаж мөрдсөн. Бид Банкны хараат бус аудитор тул санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд мөрдөгдөж буй НБОУЁЗСЗ-ийн хараат бус байдлын шаардлагыг мөн дагаж мөрдсөн.

Манай компани Чанарын хяналтын олон улсын стандарт 1, *Санхүүгийн тайланд аудит хийж, хянан шалгадаг компаниуд болон бусад баталгаажуулалт болон холбогдох үйлчилгээний ажлуудын чанарын хяналтын стандарт*-ыг мөрддөг бөгөөд үүний дагуу ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөх талаар баримтжуулсан бодлого, журмыг багтаасан чанарын хяналтын цогц тогтолцоо, мэргэжлийн стандарт, холбогдох хууль эрх зүйн болон зохицуулалтын шаардлагыг хангаж ажилладаг.

*Гүйцэтгэсэн горимуудын тайлбар*

Бид Банкны хүсэлтийн дагуу **Хавсралт 1**-д харуулсан ҮЦТ-н тодорхой хуудсуудтай (ҮЦТ-ын хэсгүүд) танилцаж, дараах горимуудыг дор тайлбарласны дагуу хийж гүйцэтгэсэн:



A member firm of Ernst & Young Global Limited

Building a better working world

Бид ҮЦТ-д орсон тоон мэдээлэл, харьцаа үзүүлэлтүүдийг Аудитлагдсан санхүүгийн тайлангуудтай харьцуулж, эсвэл шаардлагатай тохиолдолд дээрх тайлангуудын дүнгүүдийг ашиглан дахин тооцоолол хийж, тохирч байгаа тохиолдолд "**А**" үсгээр тэмдэглэн зөрүүтэй тохиолдолд тухайн зөрүүгийн тухай тайлагнав.

ҮЦТ-д толилуулсан хүснэгтүүд болон тодорхой хэсгүүд дэх тоон мэдээллүүд болон харьцаа үзүүлэлтүүд нь Банкны зүгээс тохиромжтой гэж үзсэний дагуу бүхэлчилж эсвэл товчилж толилуулагдсан байна. Дор дурдсан горимуудыг хийж гүйцэтгэхдээ бүхэлчилж эсвэл товчилсон эсэхийг нь харгалзан үзэж шалгасан.

ҮЦТ-д СТОУС-аар тодорхойлогддоггүй (жишээ нь: Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн зарчим ("НББНХЗЗ")-ын бус) зарим нэр томъёонууд ашиглагдсан ба тэдгээрийн харгалзах тоон мэдээлэл ба харьцаа үзүүлэлтүүд нь ҮЦТ-д тодорхойлж, тайлбарласны дагуу тооцоологдсон байна. НББНХЗЗ-ын бус хэмжилтүүдийн тооцооллын арга зүй нь зохистой эсэх тал дээр бид тайлбар хийгээгүй болно.

*Хязгаарлагдмал хэрэглээ*
Энэхүү харилцан тохиролцсон горимын дагуу гүйцэтгэсэн тайлан нь зөвхөн Банк болон холбогдох зохицуулагч байгууллагуудын хэрэглээнд зориулагдсан бөгөөд өөр зорилгоор бусдад ашиглуулахыг хориглоно.

Бид дээр дурьдсан горимуудын хангалттай байдал эсвэл хуулийн тайлбарын талаарх асуудлуудад тайлбар хийхгүй. Мөн бид зөвхөн ҮЦТ-т тусгасан өгөгдлүүд дээр суурилан ХТГ-уудыг хийж гүйцэтгэсэн бөгөөд эдгээр тодруулгууд нь хангалттай эсэх, ямар нэгэн материаллаг баримт, мэдээллийг орхигдуулсан эсэх талаар аливаа тайлбар хийгээгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC
**ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

Баталсан:

**Адриан Чу**
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2023 оны 4 дүгээр сарын 5



A member firm of Ernst & Young Global Limited

ХАСБАНК
УНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГА

СЗХ
2023-05-12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

# Нэг. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧЫН ТУХАЙ

## 1.1 ХасБанкны товч түүх

ХасБанк нь 2001 онд Монгол Улсын хоёр томоохон банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болох “Говийн Эхлэл” ХХК болон “Х.А.С” ХХК-иуд нэгдэн мөн оныхоо 12 сарын 27-ны өдөр Монголбанкнаас арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авснаар ХасБанк нэрээр Монголын банкны салбарт бичил санхүүгийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх зорилгоор хүч түрэн орж ирсэн. Анх 17 ажилтан, 1 сая ам.долларын гарааны хөрөнгөтэйгөөр үйл ажиллагаагаа эхлүүлж байсан бол өдгөө ХасБанкны үйл ажиллагаа өргөжин тэлж 3.9 их наяд төгрөгийн активтай, 1,143 гаруй ажилтантай Монгол Улсын системийн нөлөө бүхий банкнуудын нэг болсон байна.

A

Зураг 1: Түүхэн замнал




Компанийн засаглал, нийгмийн хариуцлагын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээрээ салбартаа жишиг тогтоож буй ХасБанк нь Эх дэлхий, Эрдэнэт хүмүүн, Эрүүл ашгийг эрхэмлэсэн, санхүүгийн зах зээлд бүтээгдэхүүн, үйлчилгээгээрээ тэргүүлэгч банк байх эрхэм зорилгыг өмнөө тавин Монгол орон даяар 74 салбар тооцооны төв, 6,000 гаруй мерчант, 360 гаруй АТМ-аар дамжуулан үйл ажиллагаа явуулж, 1 сая харилцагчдадаа санхүүгийн үйлчилгээг орчин үеийн дэвшилтэт технологи ашиглан хүргэж байна.

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 31

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

# Дөрөв. БАНКНЫ САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

## 4.1 СТОУС-ын дагуух санхүүгийн мэдээллүүд

**Энэхүү бүлэгт агуулагдсан мэдээлэл нь ХасБанк болон түүний нэгж Хаслизингийн (2021 оны 11 дүгээр сараас өмнө ТСН-ийн 100%-ийн охин компани байсан бөгөөд 2021 оны 11 дүгээр сард Үнэт Цаас гаргагчийн шийдвэрээр компанийн тухай хуулийн 20-р зүйлийн дагуу ХасБанканд нэгтгэсэн) санхүүгийн үзүүлэлтийг түүхэнд хугацаанд нөхөж нэгтгэсэн байдлаар толилуулж байгаа болно.**

Үнэт Цаас гаргагчийн 2020, 2021 болон 2022 онуудын санхүүгийн тайланг Эрнст энд Янг Монголия Аудит ХХК аудиталсан бөгөөд тайланг тодруулгын хамт энэхүү Танилцуулгад хавсаргав (Хавсралт 1). СТОУС-ын дагуу бэлтгэсэн санхүүгийн хураангуй орлого, үр дүнгийн тайлан болон санхүүгийн байдлын тайланг дараах байдлаар зэрэгцүүлж харуулав.

Хүснэгт 32: Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын хураангуй тайлан

| сая төгрөгөөр | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 381,757 | 332,086 | 376,659 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (262,487) | (174,330) | (156,332) |
| **Хүүгийн цэвэр орлого** | **119,270** | **157,756** | **220,327** |
| Хураамж ба шимтгэлийн орлого | 23,289 | 26,944 | 30,702 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | (6,390) | (8,019) | (11,289) |
| **Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого** | **16,899** | **18,925** | **19,413** |
| Арилжааны цэвэр ашиг | 2,054 | 6,194 | 16,984 |
| БҮЦАА-д бүртгэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого | 3,255 | 3,602 | 3,350 |
| Үйл ажиллагааны бусад цэвэр орлого/(зардал) | (8,662) | (374) | 3,597 |
| **Үйл ажиллагааны нийт орлого** | **132,816** | **186,103** | **263,671** |
| Зээлийн алдагдлын цэвэр зардал | (19,925) | (4,571) | (9,153) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **112,891** | **181,532** | **254,518** |
| Үйл ажиллагааны зардал | (70,280) | (80,471) | (109,335) |
| Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга | 1,175 | 1,407 | 1,507 |
| **Татварын өмнөх ашиг** | **43,786** | **102,468** | **146,690** |
| Орлогын татварын зардал | (10,102) | (27,205) | (40,851) |
| **Тайлант жилийн ашиг** | **33,685** | **75,263** | **105,839** |
| Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах | 169 | 3,000 | 854 |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого** | **33,854** | **78,263** | **106,693** |

A

Хүснэгт 33: Санхүүгийн байдлын хураангуй тайлан

| сая төгрөгөөр | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| ХӨРӨНГӨ | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 179,505 | 248,313 | 431,342 |
| Монголбанк дахь заавал байлгах нөөц | 186,373 | 214,231 | 255,683 |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | 75,684 | 49,223 | 107,799 |
| Санхүүгийн хэрэгслүүд | 42,356 | 76,289 | 83,897 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 62,983 | 90,001 | 102,765 |
| БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө | | | |
| Өмчийн хэрэгслүүд | 3,610 | 3,613 | 4,682 |
| Хорогдуулсан өртгөөр санхүүгийн хөрөнгө | | | |
| Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 82,528 | 42,487 | 282,232 |

A

ХАСБАНК
УХН4937 2573697

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-05-05
БҮРТГЭВ

| | | | |
|---|---|---|---|
| Өрийн хэрэгслүүд | 1,207,367 | 926,715 | 596,388 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,364,715 | 1,701,558 | 1,900,053 |
| Бусад хөрөнгө | 58,198 | 60,593 | 71,527 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | 3,034 | 134 | 2,063 |
| Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө | 63,559 | 67,214 | 68,221 |
| Биет бус хөрөнгө | 14,706 | 15,453 | 18,895 |
| Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө | 21,260 | - | - |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 3,535 | 4,135 | 5,233 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | **3,369,413** | **3,499,959** | **3,930,780** |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | - | 371 | 1,640 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр | | | |
| Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж | 1,939 | 2,691 | 51,867 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 2,025,471 | 2,252,100 | 2,438,619 |
| Зээлээр авсан санхүүжилт | 937,586 | 768,776 | 857,363 |
| Өрийн үнэт цаас | 10,619 | 8,404 | - |
| Хойшлогдсон нөхцөлт хандив | 10,319 | 9,243 | 7,971 |
| Түрээсийн өр төлбөр | 3,176 | 5,423 | 5,310 |
| Бусад өр төлбөр | 58,300 | 64,250 | 68,482 |
| Орлогын татварын өглөг | 8,771 | 4,706 | 23,840 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **3,056,181** | **3,115,964** | **3,455,092** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Энгийн хувьцаа | 58,626 | 100,000 | 100,000 |
| Нэмж төлсөн капитал | 1,818 | 1,818 | 1,818 |
| Нөөцүүд | 57,852 | 84,602 | 95,708 |
| Хуримтлагдсан ашиг | 194,936 | 197,575 | 278,162 |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | **313,232** | **383,995** | **475,688** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | **3,369,413** | **3,499,959** | **3,930,780** |

A

## 4.2 Удирдлагын зорилгоор (СТОУС-ын бус) бэлтгэсэн санхүүгийн мэдээллүүд

Энэхүү Танилцуулга нь СТОУС-ын тодорхойлолт, ангилал болон томьёоллын дагуу бэлтгэсэн санхүүгийн мэдээллээс гадна удирдлагын мэдээллийн зорилгоор боловсруулсан санхүүгийн үзүүлэлтүүдийг агуулсан болно. Тухайлбал зохицуулагч байгууллагын холбогдох дүрэм, журмын дагуу тооцдог зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд болон Үнэт Цаас гаргагчийн бизнесийн үр дүн, гүйцэтгэлийг хэмжихэд өргөн ашиглагддаг санхүүгийн мэдээллүүд үүнд багтдаг. Мөн энэхүү удирдлагын мэдээллийн зорилгоор ашигладаг санхүүгийн тоо, харьцаа үзүүлэлтүүдийг тооцох аргачлал, тодорхойлолт нь бусад арилжааны банкнууд болон санхүүгийн байгууллагуудын ашиглаж байгаа аргачлалаас өөр байхыг үгүйсгэхгүй бөгөөд банкнуудын санхүүгийн үзүүлэлтүүдийн харьцуулалтыг шууд хийх нь зарим тохиолдолд тохиромжгүй байж болно. Удирдлагын мэдээллийн зорилгоор ашигладаг санхүүгийн үзүүлэлтүүд нь Үнэт Цаас гаргагчийн гүйцэтгэлийг хэмжих болон шийдвэр гаргалтад чухал үүрэгтэй байдаг тул энэхүү Үнэт Цаасны танилцуулгад зарим чухал санхүүгийн үзүүлэлтүүдийг сонгон авч толилуулав.

### 4.2.1 Санхүүгийн гол үзүүлэлтүүд

Үнэт Цаас гаргагчийн санхүүгийн гол үзүүлэлтүүдийг дараах байдлаар хураангуйлан харьцуулав.

Хүснэгт 34. Санхүүгийн гол хэмжүүрүүд

| Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар илэрхийлэв | 2020 оны 12 дугаар сарын | 2021 оны 12 дугаар сарын | 2022 оны 12 дугаар сарын |
|---|---|---|---|

| | 31-ний байдлаар | 31-ний байдлаар | 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн өгөөж* (ROE) | 12.0% | 24.0% | 27.6% |
| Активын өгөөж (aROA) | 1.0% | 2.1% | 2.6% |
| Татварын дараах цэвэр ашиг (СТОУС-ын дагуу) | 33.7 | 75.3 | 105.8 |
| Татварын дараах цэвэр ашгийн жилийн өсөлт | +39.5% | +123.4% | +40.6% |
| Цэвэр хүүгийн маржин** (NIM) | 3.9% | 5.3% | 7.8% |
| Чанаргүй зээлийн хувь (NPL ratio) | 6.3% | 4.4% | 4.0% |
| МБ журам, шаардлагын дагуу байгуулсан ЗТУБАХСан болон чанаргүй зээлийн харьцаа*** | 102.7% | 118.6% | 132.2% |
| Үйл ажиллагааны зардал, орлогын харьцаа**** | 49.9% | 41.9% | 39.9% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 54.9% | 44.3% | 41.1% |

* Тухай оны цэвэр ашгийг оны эхний өөрийн хөрөнгөд харьцуулан тооцсон.
** Тухай оны цэвэр хүүгийн орлогыг хүүгийн орлого олдог дундаж активт харьцуулан.
*** Монголбанкны холбогдох журам, шаардлагын дагуу байгуулсан зээл төлөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан (ЗТУБАХС)-ийн нийт дүнг чанаргүй зээл-санхүүгийн түрээсийн үлдэгдэлтэй харьцуулсан тооцсон.
**** Үйл ажиллагааны зардлыг (хуулийн дагуу ХДКорпорацид улирал бүр төлдөг хадгаламжийн даатгалын шимтгэлийг хассан) үйл ажиллагааны нийт орлогод (цэвэр хүүгийн орлого + хүүгийн бус цэвэр орлого) харьцуулсан.

### 4.2.2 Зохистой харьцааны шалгуур үзүүлэлтын биелэлт

Үнэт Цаас гаргагч нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүдийг тогтмол хангаж, хяналт тавин ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлсэн бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Үнэт Цаас гаргагчийн санхүүгийн үр ашигтай байдал болон өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлт эрс сайжирсан. Энэхүү Танилцуулга бэлтгэх үеийн байдлаар Үнэт Цаас гаргагчийн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээ Монголбанкны тогтоосон байвал зохих түвшнээс харьцангуй өндөр (1 дахин) түвшинд байгаа нь Үнэт Цаас гаргагч цаашид өөрийн хөрөнгөөрөө активын өсөлтийг хангах бүрэн боломжтойг илтгэж байна.

Хүснэгт 35: МБ-аас шаардсан зохистой харьцаа үзүүлэлтүүд

| Тусгайлан өөрөөр заагаагүй бол %-р илэрхийлэв | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа >9%* | 16.9% | 17.4% | 20.1% |
| Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа > 12% | 17.4% | 17.4% | 20.1% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын үзүүлэлт >25% | 54.9% | 44.3% | 41.1% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар) +/-15% | -1.8% | -1.1% | 6.2% |
| Гадаад валютын нээлттэй позиц болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар) +/-40% | -4.2% | -2.2% | 6.9% |
| Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа** <300% | 151.7% | 143.7% | 133.1% |
| Үндсэн хөрөнгө нийт хөрөнгийн харьцаа <8% | 2.5% | 1.7% | 1.7% |
| Хадгаламжийн төвлөрлийн харьцаа*** <25% | 7.0% | 7.1% | 7.7% |

*2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхлэн ХасБанкны эрсдэл даах чадварыг хамгаалах зориулалт бүхий нөөц интервалын шаардлага 3.5 нэгж хувь болсноор ХасБанкны Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн зохистой харьцаа болон нөөц интервалын доод хэмжээ 12.5% байхаар тогтоосон болно. Монголбанкны журмын дагуу нөөц интервалын дээд хэмжээ нь 4 нэгж хувь хүртэл байх боломжтой байдаг.
**Өөрийн хөрөнгийн 5 хувиас дээш дүнтэй активыг өөрийн хөрөнгөд харьцуулсан харьцаа.
***Хамгийн том 10 харилцагчийн харилцах, хадгаламжийн нийлбэрийн нийт актив хөрөнгөд эзлэх хувь.

Мөн Банкны тухай хуульд заасны дагуу Үнэт Цаас гаргагчийн холбогдох этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн үзүүлэлтийг сүүлийн 3 жилийн байдлаар хураангуйлан дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 36: Үнэт Цаас гаргагчийн холбогдох этгээдэд олгосон зээлийн харьцаа үзүүлэлтүүд

| Тусгайлан өөрөөр заагаагүй бол хувиар (%) илэрхийлэв (тухайн оны эцсийн үзүүлэлт) | 2020 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2021 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар | 2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар |
|---|---|---|---|
| Банкны холбогдох нэг этгээд (нэгдмэл сонирхолтой этгээд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 5 хувиас хэтрэхгүй): | | | |
| Банкны нийт хувьцаа эзэмшигчид | 0.0% | 0.0% | 0.0% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 0.2% | 0.1% | 0.1% |
| Банкны бусад холбогдох этгээд | 1.8% | 1.8% | 1.6% |
| Банкны нийт холбогдох этгээдүүд (нэгдмэл сонирхолтой этгээдүүд)-д олгосон зээл болон зээлтэй адилтган тооцох бусад актив (Өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтрэхгүй): | | | |
| Банкны нийт хувьцаа эзэмшигчид | 0.0% | 0.0% | 0.0% |
| Банкны эрх бүхий албан тушаалтан | 0.5% | 0.4% | 0.3% |
| Банкны бусад холбогдох этгээд | 3.6% | 4.5% | 3.8% |

### 4.2.3 Санхүүгийн үзүүлэлтүүд (өмнөх 5 жилийн)

**Энэхүү бүлэгт агуулагдсан мэдээлэл нь ХасБанк болон түүний нэгж Хаслизингийн (2021 оны 11 дүгээр сараас өмнө ТСН-ийн 100%-ийн охин компани байсан бөгөөд 2021 оны 11 дүгээр сард Үнэт Цаас гаргагчийн шийдвэрээр Компанийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн дагуу ХасБанканд нэгтгэсэн) санхүүгийн үзүүлэлтийг түүхэнд хугацаанд нөхөж нэгтгэсэн байдлаар толилуулж байгаа болно.**

2021 болон 2022 онууд нь Ковид-19 цар тахлын нөлөөгөөр бизнес, эдийн засагт олон төрлийн хүндрэлүүд үүсэж, иргэд болон ААН-үүдэд ихээхэн сорилтуудыг дагуулж байсан. Үнэт Цаас гаргагч нь сүүлийн жилүүдэд авч хэрэгжүүлж буй бодлогын арга хэмжээнүүдийн үр дүнд Банкны балансын бүтэц болон ашигт ажиллагаагаа сайжруулан ажилласан.

График 17: Түүхэн цэвэр ашиг, өөгийн хөрөнгийн өгөөж, активын өгөөж



2022 оны татварын дараах цэвэр ашиг 105.8 тэрбум төгрөгт хүрч, өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) 27.6%-д хүрсэн нь түүхэн өндөр үзүүлэлт юм. Ийнхүү ашигт ажиллагаа сайжирсан нь актив пассивын оновчтой бүтцийг бий болгож, бизнесийн үр ашиг болон активын чанараа сайжруулсантай шууд холбоотой.

График 18: Цэвэр хүүгийн маржин, актив, пассивын дундаж хүү




Цэвэр хүүгийн орлогоос гадна 2022 оны хувьд хүүгийн бус орлогын өсөлт ашигт ажиллагаанд ихээхэн нөлөө үзүүлсэн. Банкны хүүгийн бус орлого нь валют арилжаны орлого, картын төлбөр тооцоо, олон улсын төлбөр тооцоо, гадаад худалдааны төлбөр тооцоо болон баталгаа, батлан даалтын орлого, бусад банкны үйлчилгээний орлогоос бүрддэг.

Валют арилжааны хувьд Банк нь аливаа спекуляци шинжтэй арилжаанд оролцдоггүй бөгөөд зөвхөн зохицуулагч байгууллагаас тогтоож өгсөн хязгаарын хүрээнд нээлттэй позицоо үр ашигтай удирдах замаар орлогоо нэмэгдүүлж ажилладаг. 2022 оны тухайд дотоод, гадаад валютын зах ихээхэн хэлбэлзэлтэй, өндөр spread-тэй байсан нь тухайн онд ийнхүү валют арилжааны орлого нэмэгдэхэд нөлөөлсөн байна. Өнгөрсөн 5 жилд банкны картын төлбөр тооцооны дэд бүтцэд оруулсан хөрөнгө оруулалт, ПОС терминал сүлжээний

График 19: Хүүгийн бус орлого



СЗХ 2023 оны 06, 12 өдөр БҮРТГЭВ № 01

2023-05-05 БҮРТГЭВ-02

инфляцын түвшнээс хамаараад банкны симтемийн зээлийн багц жилд 12%-15% өсөх боломжтой гэж харж байна.

- Харин Үнэт Цаас гаргагчийн хувьд зээлийн багцыг жилд 20%-25% өсгөхөөр санхүүгийн төлөөлөлд тусгасан. Энэхүү өсөлт нь Үнэт Цаас гаргагчийн өмнөх хугацааны гүйцэтгэлд үндэслэсэн байхаас гадна энэхүү Танилцуулга бэлдэх үеийн байдлаар зээлийн багцын өсөлтийг хангахад шаардлагатай өөрийн хөрөнгө хүрэлцээ (нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө 2022 оны байдлаар 20.1%) болон шинээр татан төвлөрүүлэхээр тооцсон эх үүсвэрийн боломжид үндэслэн тооцсон болно. Мөн Үнэт Цаас гаргагчийн зээлийн багц 2018 онд 39.3%, 2021 онд 26.2% тус тус өгсөж байсанг дурдах нь зүйтэй юм.
- Зээлийн багцын өсөлтийг хангахын тулд Үнэт Цаас гаргагч нь харилцах, хадгаламжийн үлдэгдлийг жилд 13%-15% өсгөхөөр тооцсон. 2020-2021 онд Монголбанкны бодлогын хүү буурсантай зэрэгцээд банкны системд хадгаламжийн хүү буурч, энэ нь хөрөнгийн зах идэвхжих шалтгаан болж, иргэдийн дунд хувьцааны хөрөнгө оруулалт хийх хандлага нэмэгдсэн. Харин 2022 оны хувьд бодлогын хүү 6%-иас өсөж 13%-д хүрсэн нь банкны системд эх үүсвэрийн өрсөлдөөнийг нэмэгдүүлж байна. Цаашид эдийн засгийн тогтвортой өсөлт хангагдах нөхцөлд түүнийг дагаад иргэдийн хуримтлал өсөх боломжтой гэж тооцож байна.
- Үнэт Цаас гаргагчийн хувьд нэг чухал давуу тал нь олон улсын банк, санхүүгийн байгууллагуудаас урт хугацаатай эх үүсвэр татах боломжтой явдал юм. Тухайлбал 2022 онд 200 гаруй сая ам.долларын урт хугацаатай эх үүсвэр татах хэлцэл хийж, нийт гадаад эх үүсвэрийн боломжит хэмжээг 337 сая ам.долларт хүргээд байна. Мөн ирэх 5 жил нийт гадаад эх үүсвэрийн хэмжээг 660 сая ам.долларт хүргэхээр төлөвлөж байна. Ийнхүү гадаад эх үүсвэрийн хэмжээг нэмэгдүүлэх нь Банкны эх үүсвэрийн бүтцийг хүү, хугацаа болоод хэмжээний хувьд оновчтой удирдах нөхцөлийг бүрдүүлдэгээс гадна харилцагчдынхаа урт хугацаатай зээлийн санхүүжилтийн хэрэгцээг хангах боломжийг нэмэгдүүлдэг. Санхүүгийн төсөөлөлд олон улсын санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлэх ам.долларын урт хуагцаатай бүх эх үүсвэрийг Монголбанкны холбогдох журмын дагуу своп хэлцэл хийж төгрөгт хөрвүүлэхээр тооцсон болно.

Дээр дурдсан урьдач нөхцөл, таамаглалд үндэслэн 2023-2027 онуудын орлого үр дүнгийн тайлангийн төсөөллийг дараах байдлаар харуулав (IPO-р татан төвлөрүүлэх хөрөнгийг оруулахаас өмнөх үеийн байдлаар):

Хүснэгт 37: Орлогын тайлангын төсөөлөл

| Сая төгрөгөөр | 2022 гүйцэтгэл | 2023 төсөөлөл | 2024 төсөөлөл | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2027 төсөөлөл |
|---|---|---|---|---|---|---|
| Хүү орлого | 373,350 | 498,167 | 566,613 | 657,658 | 780,507 | 920,317 |
| Хүү зардал | (155,015) | (267,133) | (299,807) | (354,592) | (422,180) | (510,450) |
| **Цэвэр хүүгийн орлого** | 218,335 | **231,034** | **266,806** | **303,065** | **358,327** | **409,867** |
| Шимтгэл, хураамжийн орлого | 30,201 | 39,480 | 46,392 | 53,294 | 61,148 | 69,676 |
| Шимтгэл, хураамжийн зардал | (11,289) | (12,791) | (14,555) | (16,583) | (18,916) | (21,599) |
| Валют арилжаа, ханшийн тэгшитгэлийн цэвэр орлого | 19,613 | 14,400 | 14,400 | 16,560 | 19,044 | 21,901 |
| Хандивын орлого | 1,507 | 1,800 | 1,200 | 1,200 | 1,200 | 1,200 |
| Бусад орлого | 2,782 | 1,440 | 1,440 | 1,440 | 1,440 | 1,440 |
| **Хүүгийн бус цэвэр орлого** | 42,813 | **44,329** | **48,877** | **55,911** | **63,916** | **72,617** |
| **Үйл ажиллагааны нийт орлого** | 261,148 | **275,364** | **315,684** | **358,976** | **422,243** | **482,484** |
| Эрсдэлийн сангийн зардал | (9,476) | (5,880) | (10,900) | (13,320) | (17,520) | (24,000) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | 251,671 | **269,484** | **304,784** | **345,656** | **404,723** | **458,484** |
| **Үйл ажиллагааны зардал** | (104,982) | **(107,503)** | **(116,569)** | **(126,684)** | **(138,896)** | **(154,606)** |
| Хүний нөөцийн зардал | (66,267) | (65,034) | (70,003) | (75,610) | (81,844) | (90,824) |
| Үйл ажиллагааны бусад зардал | (38,715) | (42,469) | (46,567) | (51,074) | (57,053) | (63,782) |
| **Татварын өмнөх ашиг** | 146,689 | **161,981** | **188,215** | **218,972** | **265,827** | **303,879** |
| Татварын зардал | (40,851) | (39,222) | (46,329) | (54,023) | (65,737) | (75,250) |

A

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Татварын дараах цэвэр ашиг | 105,839 | 122,759 | 141,886 | 164,949 | 200,090 | 228,629 |

2023-2027 оны санхүүгийн төсөөллийн харьцаа үзүүлэлтүүд (IPO-р татан төвлөрүүлэх хөрөнгийг оруулахаас өмнөх үеийн байдлаар):

Хүснэгт 38: Санхүүгийн төсөөллийн харьцаа үзүүлэлтүүд

| % | 2022 гүйцэтгэл | 2023 төсөөлөл | 2024 төсөөлөл | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2027 төсөөлөл |
|---|---|---|---|---|---|---|
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт | 20.1% | 19.4% | 20.8% | 20.8% | 21.0% | 20.9% |
| Нийт өөрийн хөрөнгийн харьцаа үзүүлэлт | 20.1% | 19.4% | 20.8% | 20.8% | 21.0% | 20.9% |
| Өөрийн хөрөнгийн өгөөж (ROE) | 27.6% | 25.8% | 25.0% | 24.49% | 25.1% | 24.2% |
| Активын өгөөж (ROA) | 2.6% | 3.1% | 3.1% | 3.0% | 3.0% | 2.8% |
| Цэвэр хүүний маржин | 7.8% | 7.0% | 6.9% | 6.5% | 6.3% | 6.0% |
| Үйл ажиллагааны зардал, орлогын харьцаа | 39.9% | 38.6% | 36.7% | 35.1% | 32.7% | 31.9% |
| Чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа | 4.0% | 3.5% | 3.3% | 3.2% | 3.1% | 3.1% |
| Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа | 41.1% | 32.7% | 34.9% | 32.9% | 33.0% | 32.2% |

2023-2027 оны санхүүгийн байдлын тайлангийн төсөөллийг дараах байдлаар (IPO-р татан төвлөрүүлэх хөрөнгийг оруулахаас өмнөх үеийн байдлаар):

Хүснэгт 39: Санхүүгийн байдлын тайлангийн төсөөлөл

| *Сая төгрөгөөр* | 2022 гүйцэтгэл | 2023 төсөөлөл | 2024 төсөөлөл | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2027 төсөөлөл |
|---|---|---|---|---|---|---|
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө (цэвэр)** | 676,222 | **414,479** | **637,838** | **723,578** | **834,538** | **943,736** |
| Бэлэн мөнгө | 100,775 | 40,000 | 40,000 | 40,000 | 40,000 | 40,000 |
| МБ-д байршуулсан бэлэн мөнгө | 481,591 | 283,352 | 501,072 | 580,826 | 685,430 | 787,879 |
| Гадаадын банканд байршуулсан бэлэн мөнгө | 85,192 | 91,426 | 97,065 | 103,052 | 109,408 | 116,156 |
| Дотоодын банканд байршуулсан бэлэн мөнгө | 9,069 | - | - | - | - | - |
| Үнэ цэнийн бууралт | (404) | (300) | (300) | (300) | (300) | (300) |
| **Хөрөнгө оруулалт, хадгаламж (цэвэр)** | 973,320 | **1,010,030** | **1,126,560** | **1,192,132** | **1,476,431** | **1,774,337** |
| МБ-д байршуулсан хөрөнгө | 242,784 | 146,282 | 155,305 | 164,883 | 175,053 | 185,850 |
| Бусад банканд байршуулсан хөрөнгө | 49,950 | 20,000 | - | - | - | - |
| ТБҮЦаас | 579,500 | 738,730 | 855,924 | 899,850 | 1,160,910 | 1,433,238 |
| ЗГҮЦаас | - | - | - | - | - | - |
| ИЗБҮЦаас | 73,418 | 82,729 | 93,221 | 105,043 | 118,366 | 133,377 |
| Бусад үнэт цаас | 24,945 | 24,945 | 24,945 | 24,945 | 24,945 | 24,945 |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 9,291 | 3,430 | 3,545 | 3,900 | 4,299 | 4,750 |
| Үнэт цаасны хямдруулалт | (2,329) | (1,847) | (2,140) | (2,250) | (2,902) | (3,583) |
| Үнэ цэнийн бууралт | (4,240) | (4,240) | (4,240) | (4,240) | (4,240) | (4,240) |
| **Зээл ба урьдчилгаа (цэвэр)** | 2,002,758 | **2,510,483** | **3,026,503** | **3,644,938** | **4,392,779** | **5,301,127** |
| Нийт зээл ба санхүүгийн түрээс | 2,054,086 | 2,563,476 | 3,085,563 | 3,712,018 | 4,471,574 | 5,397,547 |
| Чанаргүй зээл ба санхүүгийн түрээс | 81,607 | 90,242 | 102,993 | 118,724 | 138,958 | 165,349 |
| СТОУС-р тооцсон үнэ цэний бууралт | (76,047) | (80,847) | (90,447) | (102,447) | (118,647) | (141,327) |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн авлага | 31,512 | 35,508 | 40,011 | 45,086 | 50,804 | 57,247 |
| Хойшлогдсон зээлийн шимтгэл | (6,793) | (7,654) | (8,625) | (9,719) | (10,952) | (12,341) |
| **ӨБҮХХ (цэвэр)** | 35,217 | **13,104** | **3,120** | **2,760** | **2,400** | **2,040** |
| Бусад хөрөнгө оруулалт | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 |
| Үндсэн хөрөнгө ба биет бус хөрөнгө (цэвэр) | 80,823 | 86,460 | 91,820 | 96,876 | 101,431 | 105,409 |
| Дериватив санхүүгийн хөрөнгө | 107,799 | 104,446 | 95,639 | 105,617 | 217,385 | 392,252 |
| Бусад | 49,959 | 38,432 | 41,350 | 45,179 | 50,193 | 56,747 |
| **НИЙТ АКТИВ** | 3,930,780 | **4,182,117** | **5,027,512** | **5,815,762** | **7,079,839** | **8,580,329** |

| Сая төгрөгөөр | 2022 гүйцэтгэл | 2023 төсөөлөл | 2024 төсөөлөл | 2025 төсөөлөл | 2026 төсөөлөл | 2027 төсөөлөл |
|---|---|---|---|---|---|---|

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| Харилцах, хадгаламж | 2,425,855 | 2,444,295 | 2,760,627 | 3,150,669 | 3,615,573 | 4,080,478 |
| Харилцах | 638,708 | 520,000 | 608,000 | 696,000 | 820,000 | 944,000 |
| Хугацаагүй хадгаламж | 142,278 | 175,000 | 200,000 | 227,500 | 265,000 | 302,500 |
| Хугацаатай хадгаламж | 1,635,464 | 1,739,545 | 1,941,629 | 2,214,570 | 2,516,100 | 2,817,630 |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 9,406 | 9,751 | 10,998 | 12,598 | 14,473 | 16,348 |
| **Бусдаас авсан эх үүсвэр** | **907,593** | **1,069,760** | **1,481,018** | **1,741,069** | **2,388,251** | **3,232,546** |
| Төслийн эх үүсвэрүүд | 134,949 | 129,917 | 137,930 | 146,438 | 155,469 | 165,058 |
| Банк хоорондын эх үүсвэр | 51,857 | - | - | - | - | - |
| Репо | - | - | - | - | - | - |
| Гадаад эх үүсвэр | 720,257 | 939,245 | 1,342,414 | 1,593,873 | 2,231,927 | 3,066,524 |
| Хоёрдогч өглөг | - | - | - | - | - | - |
| Хуримтлуулж тооцсон хүүгийн өглөг | 7,430 | 8,373 | 9,434 | 10,631 | 11,979 | 13,498 |
| Хойшлогдсон эх үүсвэрийн шимтгэл | (6,900) | (7,775) | (8,761) | (9,872) | (11,124) | (12,535) |
| Бусад эх үүсвэр | 13,128 | 14,385 | 16,210 | 18,265 | 20,582 | 23,192 |
| Болзошгүй үүргийн эрсдэлийн сан | 221 | 249 | 280 | 316 | 356 | 401 |
| Дериватив санхүүгийн өр төлбөр | 1,640 | - | - | - | - | - |
| Бусад пассив | 106,656 | 84,980 | 95,872 | 109,554 | 108,583 | 128,616 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** A | **3,455,093** | **3,613,670** | **4,354,007** | **5,019,874** | **6,133,346** | **7,465,233** |
| Хувь нийлүүлсэн хөрөнгө | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 |
| Эрсдэлийн сангийн нөөц | 62,820 | 53,129 | 19,021 | 21,328 | 19,018 | 11,197 |
| Нөөцийн сан | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 |
| Дахин үнэлгээний нэмэгдэл | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 |
| Бусад | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 |
| Тухайн оны ашиг | 105,839 | 122,759 | 141,886 | 164,949 | 200,090 | 228,629 |
| Өмнөх онуудын хуримтлагдсан ашиг | 187,323 | 287,853 | 414,720 | 517,472 | 642,165 | 800,591 |
| Ногдол ашиг | (15,000) | (30,000) | (36,828) | (42,566) | (49,485) | (60,027) |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | **475,688** | **568,447** | **673,505** | **795,888** | **946,494** | **1,115,096** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** A | **3,930,780** | **4,182,117** | **5,027,512** | **5,815,762** | **7,079,839** | **8,580,329** |

Бодит гүйцэтгэлийн үр дүнгийн хүрээнд дээрх хүснэгтэнд харуулсан дүнгүүд нь аудитлагдсан санхүүгийн тайлангаас зөрүүтэй байгаа нь удирдлагын тайлагналын зорилгод нийцүүлэн зарим дүнгүүд дахин ангилагдсантай холбоотой болно.

Санхүүгийн төсөөллийн зорилгоор 2023-2027 онуудад тогтвортой ногдол ашиг тараахаар тооцсон хэдий ч компанийн дүрэм, ногдол ашгийн бодлогын дагуу ногдол ашиг батлах эсэх асуудал нь Хувьцаа Эзэмшигчдийн эрхлэх асуудал бөгөөд Монголбанкнаас холбогдох зөвшөөрөл авсны үндсэнд хэрэгжих боломжтой байдаг. Ногдол ашгийн бодлогыг Хавсралт 2-оос үзнэ үү.

**ХАСБАНК ХХК**
**(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)**

**Аудитлагдсан Санхүүгийн Тайлан**
**2022 оны 12 дугаар сарын 31**

**ХАСБАНК ХХК**

**Санхүүгийн тайлан**
**2022 оны 12-р сарын 31-ээр тасалбар болгосон**

---


Банкны талаарх мэдээлэл ........ 2
Захирлууд ба гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл ........ 3
Хараат бус аудиторын дүгнэлт ........ 4-5
Товчилсон үгсийн жагсаалт ........ 6
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан ........ 7
Санхүүгийн байдлын тайлан ........ 8
Өмчийн өөрчлөлтийн тайлан ........ 9
Мөнгөн гүйлгээний тайлан ........ 10-12
Санхүүгийн тайлангийн тодруулгууд ........ 13-88

**ХАСБАНК ХХК**

**Банкны талаарх мэдээлэл**

| | |
|---|---|
| АЛБАН ХАЯГ: | ХасБанкны Байр<br>Ерөнхий Сайд Амарын гудамж,<br>Сүхбаатар дүүрэг, 8-р хороо<br>Шуудангийн Салбар # 46, Шуудангийн Хайрцаг 721,<br>Улаанбаатар 14200<br>Монгол Улс |
| ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ: | Санжай Гупта<br>Гүмэнжавын Цэвэгжав<br>Нямтайширын Цэлмүүн<br>Анджей Витак<br>Майкл Мадден<br>Баянсаны Уламбаяр<br>Албертус Браггинк<br>Нираж Ведва<br>Ив Жако<br>Сюзанна Херринг Карр (2022 оны 4-р сарын 26-р сонгогдсон)<br>Эрик Версавел (2022 оны 9-р сарын 21-р сонгогдсон)<br>Морис Лам (2022 оны 2-р сарын 4-р огцорсон) |
| НАРИЙН БИЧГИЙН ДАРГА: | Нямсүрэнгийн Мөнхцэлмэг (2022 оны 6-р сарын 6-р сонгогдсон)<br>Дашнямын Ашидмаа (2022 оны 5-р сарын 31-р огцорсон) |
| АУДИТОР: | Эрнст энд Янг Монголиа Аудит ХХК<br>Мэргэшсэн нягтлан бодогчид |

**ХАСБАНК ХХК**

**ЗАХИРЛУУД БА ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ**

ХасБанк ХХК-ийн (цаашид "Банк" гэх) Гүйцэтгэх захирал Гүмэнжавын Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Ганзоригийн Эрдэнэбаяр, бид энэхүү тайлангийн 7-оос 88 дугаар хуудсанд толилуулсан тайлангуудыг холбогдох Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, шударгаар илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.

ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ
(Гүйцэтгэх захирал)

ГАНЗОРИГИЙН ЭРДЭНЭБАЯР
(Санхүү хариуцсан захирал)

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 15

Ernst & Young Mongolia Audit LLC
Suite 200, 8 Zovkhis Building
Seoul Street 21
Ulaanbaatar 14251
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
Fax : +976 11 312042
ey.com

Building a better working world

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

**ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

### Дүгнэлт

Бид ХасБанк ХХК ("Банк")-ийн 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн гол бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв толилуулсан байна.

### Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандарт ("АОУС")-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн үүрэг хариуцлагуудыг энэхүү тайлангийн "*Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*" хэсэгт харуулав. Бид Нягтлан бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан "*Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм*"-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

### Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС-ын дагуу бэлтгэх, үнэн зөв толилуулах ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсвэл татан буулгахаар төлөвлөсөн эсвэл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг гаргахдаа удирдлага нь тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглал хариуцсан этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.

### Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу тайлагналуудаас санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч "АОУС"-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу тайлагналуудыг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу тайлагналууд нь залилан эсвэл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсвэл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

"АОУС"-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсвэл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу тайлагналуудын эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдээлэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу тайлагналыг илрүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-05-05
БҮРТГЭВ-02

EY
Building a better working world

## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

**ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдэд**

---

**Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага (үргэлжлэл)**

- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.

- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойролцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.

- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсвэл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсвэл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.

- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь зөв толилуулгын шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглал хариуцсан этгээдүүдэд мэдэгддэг.

**Бусад зүйл**

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.

Ernst & Young Mongolia Audit LLC
**ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК**
Мэргэшсэн нягтлан бодогчид

| Гарын үсэг зурсан | Баталсан |
|---|---|
| **Буланбай Хабылхайрат** | **Адриан Чу** |
| Захирал | Партнер |

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2023 оны 3 дугаар сарын 15





A member firm of Ernst & Young Global Limited

**Товчилсон үгсийн жагсаалт**

| | |
|---|---|
| ХӨ | Хорогдуулсан өртөг |
| ХББ | Хөрөнгөөр баталгаажсан бонд |
| ХОЗҮХХ | Хөрөнгө оруулалтын зориулалттай үл хөдлөх хөрөнгө |
| МБ | Монголбанк |
| ХБЗА | Хүлээгдэж Буй Зээлийн Алдагдал |
| ҮАХТ | Үр Ашигт Хүүгийн Түвшин |
| БЗЭБХ | Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө |
| БҮЦБДО | Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлого |
| БҮЦАА | Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал |
| ЗГ | Монгол улсын засгийн газар |
| ДНБ | Дотоодын Нийт Бүтээгдэхүүн |
| СТОУС | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд |
| СТОУС 7 | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 7: Санхүүгийн хэрэгслүүдийн тодруулга |
| СТОУС 9 | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 9: Санхүүгийн хэрэгслүүд |
| СТОУС 13 | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 13: Бодит үнэ цэнийн хэмжилт |
| НББОУСЗ | Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл |
| СТОУТХ | Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хороо |
| АҮМ | Алдагдал үүсэх магадлал |
| LIBOR | Лондонгийн банк хоорондын зарласан хүү |
| БДО | Бусад дэлгэрэнгүй орлого |
| ТТБМ | Төлбөр төлөгдөхгүй байх магадлал |
| ИЗББ | Ипотекийн зээлээр баталгаажсан бонд |
| ҮЦСК | Үнэт цаасны санхүүжилтийн корпораци ХХК |
| ЗҮТБХТ | Зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр |
| ХИЭ | Хамгийн Их Эрсдэл |
| МИК | Монголын Ипотекийн Корпораци |
| ЖДҮ | Жижиг, Дунд Үйлдвэрлэл |
| НӨАТ | Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар |

**ХАСБАНК ХХК**

**Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан**
**2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн**

| | Тод-руулга | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|---|
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүү болон түүнтэй адилтгах орлого | 4.1 | 362,440,045 | 322,909,506 |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүү болон түүнтэй адилтгах орлого | 4.2 | 14,218,509 | 9,176,832 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | 4.3 | (156,331,816) | (174,330,045) |
| **Хүүгийн цэвэр орлого** | **4** | **220,326,738** | **157,756,293** |
| Хураамж ба шимтгэлийн орлого | 5 | 30,701,660 | 26,944,135 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | 5 | (11,288,762) | (8,019,386) |
| **Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого** | **5** | **19,412,898** | **18,924,749** |
| Арилжааны цэвэр ашиг | 6 | 16,983,711 | 6,194,516 |
| БҮЦАА-д бүртгэсэн бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого | 7 | 3,349,898 | 3,601,665 |
| Үйл ажиллагааны бусад цэвэр орлого/(зардал) | 8 | 3,597,709 | (374,161) |
| **Үйл ажиллагааны нийт орлого** | | **263,670,954** | **186,103,062** |
| Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал | 9 | (9,153,357) | (4,571,200) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | | **254,517,597** | **181,531,862** |
| Үйл ажиллагааны зардал | 10 | (109,334,959) | (80,470,954) |
| Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга | 22 | 1,506,637 | 1,407,264 |
| **Татварын өмнөх ашиг** | | **146,689,275** | **102,468,172** |
| Орлогын татварын зардал | 11.1 | (40,850,689) | (27,205,297) |
| **Тайлант жилийн ашиг** | | **105,838,586** | **75,262,875** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):** | | | |
| *Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:* | | | |
| Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөцийн өөрчлөлт, татварын дараах | | 854,230 | 2,653 |
| Барилга, байшингийн дахин үнэлгээний олз | | - | 2,997,142 |
| **Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах** | | **854,230** | **2,999,795** |
| **Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого** | | **106,692,816** | **78,262,670** |
| **Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):** | | | |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг | 12 | 105.84 | 75.26 |
| Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг | 12 | 105.84 | 75.26 |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

**ХАСБАНК ХХК**

**Санхүүгийн байдлын тайлан**
**2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх**

| | Тод-руулга | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ** | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 13.1 | 431,341,650 | 248,313,381 |
| Монголбанк дахь заавал байлгах нөөц | 13.2 | 255,682,837 | 214,231,304 |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | 14.2 | 107,798,730 | 49,223,110 |
| Санхүүгийн хэрэгслүүд | 14.1 | 83,897,165 | 76,288,953 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 14.1 | 102,764,818 | 90,000,608 |
| БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө | | | |
| Өмчийн хэрэгслүүд | 15 | 4,682,289 | 3,613,197 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө | | | |
| Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 16.1 | 282,232,458 | 42,487,278 |
| Өрийн хэрэгслүүд | 16.2 | 596,387,687 | 926,714,515 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 16.3 | 1,900,052,627 | 1,701,557,761 |
| Бусад хөрөнгө | 17 | 71,527,286 | 60,592,954 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө | 18 | 2,063,167 | 133,594 |
| Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө | 19 | 68,221,257 | 67,214,011 |
| Биет бус хөрөнгө | 20 | 18,895,588 | 15,452,521 |
| Хойшлогдсон татварын хөрөнгө | 11.2 | 5,232,744 | 4,135,441 |
| **НИЙТ ХӨРӨНГӨ** | | **3,930,780,303** | **3,499,958,628** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| **ӨР ТӨЛБӨР** | | | |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | 14.2 | 1,639,595 | 371,050 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр | | | |
| Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж | 21.1 | 51,866,980 | 2,691,406 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 21.2 | 2,438,619,569 | 2,252,099,731 |
| Зээлээр авсан санхүүжилт | 21.3 | 857,363,227 | 768,775,737 |
| Өрийн үнэт цаас | 21.4 | - | 8,403,663 |
| Хойшлогдсон нөхцөлт хандив | 22 | 7,970,706 | 9,243,242 |
| Түрээсийн өр төлбөр | 23 | 5,310,092 | 5,422,527 |
| Бусад өр төлбөр | 24 | 68,482,406 | 64,250,454 |
| Орлогын албан татварын өглөг | 11.1 | 23,840,068 | 4,705,974 |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | | **3,455,092,643** | **3,115,963,784** |
| **ЭЗДИЙН ӨМЧ** | | | |
| Энгийн хувьцаа | 25 | 100,000,000 | 100,000,000 |
| Нэмж төлөгдсөн капитал | | 1,817,773 | 1,817,773 |
| Нөөцүүд | 26 | 95,708,103 | 84,602,413 |
| Хуримтлагдсан ашиг | | 278,161,784 | 197,574,658 |
| **НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ** | | **475,687,660** | **383,994,844** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ** | | **3,930,780,303** | **3,499,958,628** |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.



176

**ХАСБАНК ХХК**

**Өмчийн өөрчлөлтийн тайлан**
**2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

| | Энгийн хувьцаа мян.төг (Тодруулга 25) | Нэмж төлөгдсөн капитал мян.төг | Нөөцүүд мян.төг (Тодруулга 26) | Хуримтлагд -сан ашиг мян.төг | Нийт эздийн өмч мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **2022 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаар** | **100,000,000** | **1,817,773** | **84,602,413** | **197,574,658** | **383,994,844** |
| Тайлант жилийн ашиг | - | - | - | 105,838,586 | 105,838,586 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | 854,230 | - | 854,230 |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | **-** | **-** | **854,230** | **105,838,586** | **106,692,816** |
| Бэлэн мөнгөөр олгосон ногдол ашиг | - | - | - | (15,000,000) | (15,000,000) |
| Тусгай зориулалттай нөөцөд шилжүүлсэн | - | - | 10,251,460 | (10,251,460) | - |
| **2022 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар** | **100,000,000** | **1,817,773** | **95,708,103** | **278,161,784** | **475,687,660** |
| **2021 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаар** | **58,625,979** | **1,817,773** | **57,851,872** | **194,936,550** | **313,232,174** |
| Тайлант жилийн ашиг | - | - | - | 75,262,875 | 75,262,875 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | - | 2,999,795 | - | 2,999,795 |
| **Нийт дэлгэрэнгүй орлого** | **-** | **-** | **2,999,795** | **75,262,875** | **78,262,670** |
| Бэлэн мөнгөөр олгосон ногдол ашиг | - | - | - | (7,500,000) | (7,500,000) |
| Хувьцаагаарх ногдол ашиг | 41,374,021 | - | - | (41,374,021) | - |
| Тусгай зориулалттай нөөцөд шилжүүлсэн | - | - | 23,750,746 | (23,750,746) | - |
| **2021 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар** | **100,000,000** | **1,817,773** | **84,602,413** | **197,574,658** | **383,994,844** |

Нөөцүүдэд тусгай зориулалтын нөөц багтсан ба уг нөөцийг Монголбанкны шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчид хуваарилах боломжтой (Тодруулга 26).

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХАСБАНК ХХК

**Мөнгөн гүйлгээний тайлан**
**2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

| | Тодруулга | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|---|
| **ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| **Татварын өмнөх ашиг** | | 146,689,275 | 102,468,172 |
| Тохируулга: | | | |
| Үндсэн хөрөнгө борлуулсны гарз /(олз) | 8 | 4,564 | (4,862) |
| Хураан авсан хөрөнгө борлуулсны гарз | 8 | 419,419 | 1,125,540 |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны олз | 8, 18 | (316,337) | (155,981) |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд борлуулсны гарз | 7 | - | 156,913 |
| Валютын ханшийн хэрэгжээгүй гарз /(олз) | 8 | 57,154,258 | (21,922,069) |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн БҮЦ-ийн өөрчлөлт | 8 | (57,307,075) | 26,831,960 |
| Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал | 9 | 6,577,134 | 2,815,312 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн гэрээний өөрчлөлтийн алдагдал | 9 | 3,107,879 | 3,118,563 |
| Зээлээр авсан санхүүжилтийн гэрээний өөрчлөлтийн ашиг | 9 | (531,656) | (1,362,675) |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн БҮЦ-ийн өөрчлөлт | 6, 7 | 1,344,771 | 370,512 |
| Өмчийн хэрэгслүүд борлуулсны олз | 8 | (106,153) | - |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | 10 | 6,285,015 | 6,339,870 |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл | 10 | 3,809,293 | 3,711,714 |
| Биет бус хөрөнгийн хорогдол | 10 | 1,952,099 | 2,910,587 |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз | 10 | 89,955 | 80,098 |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз | 10 | 114,070 | - |
| Барилга, байшингийн дахин үнэлгээний гарз | 10 | - | 868,801 |
| Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт | 8 | (1,126,650) | (3,026,616) |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт | 8 | - | (116,699) |
| Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга | 22 | (1,506,637) | (1,407,264) |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого | 4.1 | (362,440,045) | (322,909,506) |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого | 4.2, 6, 7 | (20,890,312) | (13,885,992) |
| Хүүгийн зардал | 4.3 | 156,331,816 | 174,330,045 |
| Хүлээн авсан хүү | | 305,237,065 | 264,386,797 |
| Төлсөн хүү | | (115,139,635) | (130,131,418) |
| **Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | **129,752,113** | **94,591,802** |
| Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд: | | | |
| Монголбанк дахь заавал байлгах нөөц | | (41,451,533) | (27,858,636) |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | | (257,749,451) | (421,808,737) |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | | 63,790,181 | 21,973,538 |
| Бусад хөрөнгө | | (11,710,564) | 7,729,405 |
| Үйл ажиллагааны өр төлбөрийн өөрчлөлтүүд: | | | |
| Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж | | 49,167,894 | 750,192 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | | 91,833,073 | 229,145,729 |
| Бусад өр төлбөр | | (10,801,508) | (2,361,464) |
| **Үндсэн үйл ажиллагаанд хүлээн авсан /(зарцуулсан) мөнгөн гүйлгээ** | | **12,830,205** | **(97,838,171)** |
| Төлсөн орлогын албан татвар | 11.1 | (23,098,641) | (31,872,211) |
| **Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ** | | **(10,268,436)** | **(129,710,382)** |

ХАСБАНК ХХК

**Мөнгөн гүйлгээний тайлан (Үргэлжлэл)**
**2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

| | Тодруулга | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|---|
| **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Өрийн хэрэгслүүдээс хүлээн авсан хүү | | 60,898,119 | 73,511,422 |
| Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүдийн худалдан авалт | | - | (17,620,921) |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого | | 541,600 | 1,152,004 |
| БҮЦБДО-д бүртгэх өмчийн үнэт цаас борлуулсны орлого | | 176,034 | - |
| Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүд борлуулсны орлого | | 23,831,383 | 1,483,100 |
| Үндсэн хөрөнгө борлуулсны орлого | | 36,774 | 10,027 |
| Үндсэн хөрөнгийн худалдан авалт | 19 | (8,197,714) | (5,380,980) |
| Биет бус хөрөнгийн худалдан авалт | 20 | (5,509,236) | (3,656,575) |
| Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны орлого | 18 | 878,485 | 3,085,797 |
| Хураан авсан хөрөнгө борлуулсны орлого | | 7,576,596 | 19,410,445 |
| **Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ** | | **80,232,041** | **71,994,319** |
| **САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | | |
| Зээлээр авсан санхүүжилтэд төлсөн хүү | | (40,884,194) | (42,300,337) |
| Өрийн үнэт цаасанд төлсөн хүү | | (164,801) | (703,340) |
| Зээлээр авсан санхүүжилтийн татан авалт | | 368,524,931 | 172,827,206 |
| Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт | | (344,835,822) | (334,803,370) |
| Өрийн үнэт цаасын эргэн төлөлт | | (8,262,767) | (2,000,000) |
| Төлсөн ногдол ашиг | | (15,000,000) | (7,500,000) |
| Хүлээн авсан хойшлогдсон нөхцөлт хандив | 22 | 234,101 | 331,540 |
| Түрээсийн үндсэн өр төлбөрийн төлөлт | | (3,965,980) | (3,703,188) |
| **Санхүүгийн үйл ажиллагаанд зарцуулсан мөнгөн гүйлгээ** | | **(44,354,532)** | **(217,851,489)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө** | | **80,503,259** | **(1,285,402)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр өсөлт/(бууралт)** | | **106,112,332** | **(276,852,954)** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | **1,172,353,926** | **1,449,206,880** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 13.3 | **1,278,466,258** | **1,172,353,926** |

ХАСБАНК ХХК

**Мөнгөн гүйлгээний тайлан (Үргэлжлэл)**
**2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн**

**Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүдэлтэй өр төлбөрүүдийн өөрчлөлт:**

| **Түрээсийн өр төлбөр** | **2022 мян.төг** | **2021 мян.төг** |
|---|---|---|
| **1-р сарын 1-нээр** | 5,422,527 | 3,176,591 |
| Нэмэгдсэн мөнгөн бус гүйлгээ | 3,706,778 | 5,393,450 |
| Цуцлагдсан түрээс | (171,252) | - |
| Хүүгийн зардал | 318,019 | 555,674 |
| Төлсөн түрээсийн төлбөр | (3,965,980) | (3,703,188) |
| **12-р сарын 31-нээр** | **5,310,092** | **5,422,527** |

| **Зээлээр авсан санхүүжилт** | **2022 мян.төг** | **2021 мян.төг** |
|---|---|---|
| **1-р сарын 1-нээр** | 768,775,737 | 937,585,863 |
| Шинээр нэмэгдсэн | 368,524,931 | 172,827,206 |
| Эргэн төлөлт | (344,835,822) | (334,803,370) |
| Хүүгийн эргэн төлөлт | (40,884,194) | (42,300,337) |
| Монголбанк болон Засгийн газарт МИК - Давуу эрхтэй ИЗББондоор төлсөн мөнгөн бус хөдөлгөөн | (48,088,000) | (9,500,800) |
| Ханшийн зөрүү | 112,494,895 | (163,970) |
| Хуримтлагдсан хүүгийн зардал | 41,907,336 | 46,493,820 |
| Гэрээний нөхцөл өөрчлөлтийн ашиг | (531,656) | (1,362,675) |
| **12-р сарын 31-нээр** | **857,363,227** | **768,775,737** |

| **Өрийн үнэт цаас** | **2022 мян.төг** | **2021 мян.төг** |
|---|---|---|
| **1-р сарын 1-нээр** | 8,403,663 | 10,618,643 |
| Эргэн төлөлт | (8,262,767) | (2,000,000) |
| Хүүгийн эргэн төлөлт | (164,801) | (703,340) |
| Ханшийн зөрүү | 1,268 | (2,061) |
| Хуримтлагдсан хүүгийн зардал | 22,637 | 490,421 |
| **12-р сарын 31-нээр** | **-** | **8,403,663** |

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно



180

## 1. Банкны мэдээлэл

Тус банкны үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкнаас олгосон 24 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ байна. Тайлант жилд банкны үйл ажиллагааны мөн чанарт өөрчлөлт гараагүй болно.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг хязгаарлагдмал хариуцлагатай компани юм. Банкны албан хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, ХасБанкны байр бөгөөд үйл ажиллагаагаа явуулдаг хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот 14210, Жамъяан гүн гудамж, Олон Улсын Худалдааны Төв (ОУХТ), 16 давхар.

Банкны толгой компани нь Монгол улсад үйл ажиллагаа явуулдаг ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК юм. Толгой компанийн хувьцаа эзэмшигчид нь:

- Монголын Алт Корпораци (МАК) ХХК
- Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)
- ОРИКС Корпораци
- Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)
- Канадын Үндэсний Банк (КҮБ)
- Ронок Партнерс С.А.Р.Л
- Монголиа Файнаншл Сервисез ХХК
- Триодос Фэйр Шэйр Сан
- Нээлттэй Нийгэм Форум
- Улаанбаатар Ротари Клуб
- Магваны Болдоо
- Чулууны Ганболд

Санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн шийдвэрээр батлан гаргасан.

## 2. Тайлан бэлтгэсэн суурь

### 2.1 Тайлан бэлтгэсэн суурь

Санхүүгийн тайлангууд нь санхүүгийн үүсмэл хэрэглүүд, БҮЦБДО бүртгэгдэх өрийн болон өмчийн хэрэглүүд, БҮЦАА бүртгэгдэх санхүүгийн хэрэглүүд, газар ба барилгыг эс тооцвол түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө болон өмчлөх бусад хөрөнгийг дансны үнэ ба борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар бүртгэдэг. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол төгрөгөөр, мянганы оронгоор нарийвчилж тайлагнасан.

Банк нь толгой компанийн хувьцаа эзэмшигчдийн шийдвэрээр зэрэгцээ охин компани болох ХасЛизинг ХХК-тай 2021 оны 11 сарын 13-ний өдрөөр нэгдсэн. Банк ба ХасЛизинг ХХК нь нэг өмчлөгчтэй байсан тул удирдлагын зүгээс 2021 оны 11 сарын 13-ний өдрөөр уг нэгдлийг нийтлэг хяналт доорх бизнесийн нэгдэл гэж тодорхойлон, СТОУС 3 *Бизнесийн нэгдэл* стандартын хүрээнээс гарсан ба нэгдсэн компаниудын тайланг нэгтгэх аргыг буцаан мөрдөх журмыг ашиглан бүртгэлийг хийсэн. Удирдлага өмнөх тайлант үеүдийн санхүүгийн тайлангуудыг дахин тайлагнах нягтлан бодох бүртгэлийг сонгосон тул санхүүгийн тайлангууд нь нэгдсэн өдрийг үл тооцон нэгдэл нь санхүүгийн тайлангийн хамгийн эхний үеэс хийгдсэн мэтээр бэлтгэгдсэн. Банк ба ХасЛизинг ХХК-ийн санхүүгийн тайлангууд нь ижил нягтлан бодох бүртгэлийн бодлогын дагуу бэлтгэгдсэн байсан.

**Мөрдсөн стандарт**

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан санхүүгийн тайлагналын олон улсын стандартууд (СТОУС)-ын дагуу бэлтгэгдсэн болно.

**Санхүүгийн тайлангийн толилуулга**

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дараалаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсхүл хийх төлбөрүүдийн талаарх шинжилгээг Тодруулга 29-т толилуулсан.

Банк нь зөвхөн тухайн санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрүүдийг цэвэр дүнгээр нь барагдуулах хуулиар олгогдсон эрхтэй, мөн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг цэвэр дүнгээр нь барагдуулахаар төлөвлөж байгаа, эсхүл хөрөнгийг ашиглаж өр төлбөрийг барагдуулах бол тэдгээр санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр толилуулах эрхтэй. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсхүл тайлбараар шаардсан эсхүл зөвшөөрснөөс бусад тохиолдолд орлого, зарлагыг дэлгэрэнгүй орлогын тайланд хооронд нь хааж цэвэр дүнгээр тайлагнаж болохгүй, орлого зардлыг цэвэр дүнгээр нь тайлагнасан тохиолдолд Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод энэ тухай тусгайлан тодруулна.

### 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд

Банкны санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайланд орлого ба зардал, хөрөнгө ба өр төлбөр, болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, холбогдох тодруулгуудыг бэлтгэхэд шаардлагатай үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг. Эдгээр тооцоолол, таамаглалын тодорхойгүй байдал нь ирээдүйн тайлант хугацаанд хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулга хийх шаардлагатай болж магадгүй. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөх дүнгүүдийг тодорхойлохдоо үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг.

Тооцоолол болон түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг тогтмол хянадаг болно. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг зөвхөн нөлөөлж байгаа тайлант үед эсхүл ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд нөлөөлөх бол ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд тус тус тусгадаг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн удирдлагын томоохон үнэлэмж, тооцооллыг дор нэгтгэн харуулав.

**Ковид 19**

Ковид 19-ийн тохиолдол 2019 оны сүүлээр анх бүртгэгдэж дэлхий даяар тархсан. 2020 оны 3-р сарын 11-нд Дэлхийн эрүүл мэндийн байгууллага /ДЭМБ/-аас коронавирусыг цар тахал хэмээн мэдэгдсэн.

Ковид 19 цар тахал нь хөрөнгө, өр төлбөртэй холбоотой таамаглал, тооцооллын тодорхой бус байдлыг бий болгож байна. Тиймээс Банк санхүүгийн тайланг уншигчдад санхүүгийн тайланд ашигласан аргачлалыг ойлгоход нь туслах үүднээс нэмэлт тодруулга шаардлагатай эсэхийг үнэлж үзсэн.

## 2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд (Үргэлжлэл)

### Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (ХБЗА) хэмжихэд удирдлага дараах нарийн, чухал тооцоолол болон үнэлэмжийг хийдэг:

- Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт: Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь 1-р түвшинд хамаарах хөрөнгийн хувьд ирэх 12 сард хамаарах хүлээгдэж буй гарзтай тэнцүү байх ба 2 болон 3-р түвшинд хамаарах хөрөнгийн хувьд уг хөрөнгө төлөгдөж дуусах хугацаа хүртэлх гарзтай тэнцүү байна. Хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл их хэмжээгээр өссөн үед хөрөнгө 2-р түвшинд шилждэг. Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг хэрхэн тодорхойлохыг СТОУС 9-д тусгаагүй. Банк нь хөрөнгийн зээлийн эрсдэлийг мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ чанарын болон тоон үзүүлэлт, ирээдүйн эдийн засгийн холбогдох ул үндэслэлтэй мэдээллийг харгалзан үзнэ.
- Зээлийн эрсдэлийн адил төстэй шинж чанараар хөрөнгийг бүлэглэх: Бүлгийн үнэлгээгээр хүлээгдэж буй гарзыг хэмжихдээ санхүүгийн хэрэгслүүдийн эрсдэлийн адил төстэй шинж чанарт үндэслэн хөрөнгүүдийг бүлэглэнэ. Банк бүлэглэсэн хөрөнгийн зээлийн эрсдэлийн шинж чанар адил төстэй хэвээр байгаа эсэхэд байнга хяналт тавина. Хөрөнгийн эрсдэлийн адил төстэй шинж чанар алдагдсанаар тухайн хөрөнгийг өөр бүлэгт оруулах шаардлага бий болно. Хөрөнгийн эрсдэлийн адил төстэй шинж чанар алдагдсан эсэхийг хянаснаар хөрөнгийн шинэ бүлэг/ багц үүсгэх эсхүл хөрөнгийн эрсдэлийн адил төстэй шинж чанарт үндэслэн тухайн хөрөнгийг тохирох бүлэгт шилжүүлж болно.
  Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өсөх (эсхүл зээлийн эрсдэл буурах) үед багцыг дахин бүлэглэх эсхүл багцууд хоорондоо шилжиж болох бөгөөд энэ тохиолдолд 1-р түвшинд хамаарах хөрөнгө 2 болон 3-р түвшинд шилжих эсхүл үүний эсрэгээр шилжих тохиолдол байж болно. Гэхдээ багц хөрөнгийн хувьд өмнө нь хамаарч байсан түвшин хэвээр байгаа боловч багцын эрсдэл өөрчлөгдсөн бол хүлээн зөвшөөрөх эрсдэлийн сангийн хэмжээ өөрчлөгдөнө.
- Бүтээгдэхүүн бүрийн хувьд ирээдүйн эдийн засгийн төсөөллүүдийн хувилбар болон хувилбаруудын холбогдох жинлэлтийг тооцоолох мөн ирээдүйн эдийн засгийн төсөөллүүдийг тодорхойлох: ХБЗА-г хэмжихдээ Банк зах зээлийн ялгаатай хүчин зүйлсийн нөлөөллөөс ирээдүйд үүсэж бий болох өөрчлөлтийн таамаглалуудыг харгалзсан ул үндэслэлтэй мэдээллийг ашигладаг.
- Ирээдүйн мэдээлэл: Банкны ХБЗА-ын загвар нь доорхи эдийн засгийн өгөгдлүүд дээр суурилсан ирээдүйн мэдээлэл дээр тулгуурладаг. Үүнд:
  - ДНБ
  - Инфляц
  - S&P 500

  Ирээдүйн мэдээллийг тусгахдаа Банк эдийн засгийн гурван хувилбарыг авч үздэг (суурь, эерэг ба сөрөг тохиолдол). ХБЗА-ын тооцоололд ашиглаж буй мэдээлэл нь санхүүгийн тайлангийн өдрөөрх зах зээлийн бүх шинж тэмдгийг агуулаагүй байх магадлалтай. Эдгээр ялгаа нь мэдэгдэхүйц материаллаг үед зарим тохиолдолд чанарын тохируулгуудыг түр тохируулгаар хийдэг.
- Төлбөр төлөгдөхгүй байх магадлал: ТТБМ нь ХБЗЭ тооцох гол үзүүлэлт юм. ТТБМ нь өгөгдсөн хугацаанд төлбөр төлөгдөхгүй байх магадлалыг түүхэн мэдээлэл болон ирээдүйн нөхцөл байдлын таамаглал, хүлээлтүүдийг тус тус харгалзан үзсэний үндсэн дээр тооцоолдог.
- Алдагдал үүсэх магадлал: АҮМ нь төлбөр төлөх боломжгүй байдлаас үүсэх алдагдлын тооцоолол юм. АҮМ нь гэрээний дагуу хүлээж авах байсан мөнгөн урсгал ба барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг оролцуулан зээлдүүлэгчийн хүлээн авна гэж тооцоолсон дүнгийн зөрүү байна.

### Санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэн

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийг идэвхтэй зах зээл дээрээс олж авах боломжгүй байгаа үед тэдгээрийг математик загваруудыг ашиглах гэх мэт төрөл бүрийн үнэлгээний техникүүдийг ашиглан тодорхойлно. Тэдгээр загварт хэрэглэх өгөгдлүүдийг ашиглах боломжтой зах зээлийн өгөгдлүүдээс гарган авах ба ашиглах боломжтой зах зээлийн өгөгдөл байхгүй тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Үнэлэмжинд төлбөрийн чадвар, урт хугацаат санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэлбэлзэл, хорогдуулалтын түвшин, урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээ, ТТБМ-ын хувь хэмжээний таамаглалууд гэх мэт мэдээллийг харгалзан үзнэ.

Банк эдгээр үнэлгээг одоогоор хамгийн зөв тооцоолол гэж үзэж байгаа ч Ковид-19 цар тахлын улмаас үүссэн тодорхойгүй байдал нь зах зээлийн тогтворгүй байдлыг ихэсгэж, тухайн жилийн үнэлгээний тодорхойгүй байдлыг өндөр түвшинд хүргэж байна. Зах зээлийн орчны байнгын тодорхойгүй байдал эсхүл гэнэтийн уналт нь илүү тогтворгүй байдал, тасалдал зэрэгт хүргэж энэхүү хүчин зүйлтэй холбоотой суурь таамаглалын мэдэгдэхүйц өөрчлөлт нь эдгээр санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнд материаллаг хэмжээний залруулга үүсгэж болзошгүй байна. Дэлгэрэнгүйг тодруулга 27-оос харна уу.

2023 .05. 12
БҮРТГЭВ

2023 -05- 05
БҮРТГЭВ-02



## 2.3 Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС)

**Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэ СТОУС болон нэмэлт өөрчлөлтүүд**

2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон доорх СТОУС-ууд болон нэмэлт өөрчлөлтүүдээс бусад Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил байна. Эдгээр нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартуудыг нэвтрүүлсний үр дүн болон өөрчлөлтийн нөлөөг доор тайлбарлав. Нэмэлт өөрчлөлт болон тайлбарыг 2022 оноос анхлан мөрдөж эхлэх боловч Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй юм.

Хэрэв өөрөөр заагаагүй бол шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандарт, тайлбарууд нь 2022 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эсхүл түүнээс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болно. Банк нь өөр ямар нэгэн батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартуудыг мөрдөж эхлээгүй байгаа болно.

| Хэрэгжих хугацаа | Шинэ СТОУС болон нэмэлт өөрчлөлтүүд |
|---|---|
| 2022 оны 1-р сарын 1 | • СТОУС 3-ын нэмэлт өөрчлөлт *Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж*<br>• НББОУС 16-ын нэмэлт өөрчлөлт *Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх хөрөнгийн орлого*<br>• НББОУС 37-ын нэмэлт өөрчлөлт *Давагдашгүй гэрээ - Гэрээ биелүүлэх зардал*<br>• СТОУС 1 *Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартыг анх удаа хэрэгжүүлэх*<br>• СТОУС 9 Санхүүгийн хэрэгслүүд - Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх '10 хувь' шалгуур - хураамж<br>• НББОУС 41 Хөдөө аж ахуй *Бодит үнэ цэнийн хэмжилт дэх татвар* |

**НББОУС 16-д оруулсан нэмэлт өөрчлөлт - *Үндсэн хөрөнгө: Зориулалтаар ашиглаж эхлэхээс өмнөх орлого***

Энэхүү өөрчлөлт нь аж ахуйн нэгж байгууллагууд үндсэн хөрөнгийн өртгөөс тухайн хөрөнгийг зориулалтын дагуу ашиглахад шаардлагатай байршил, нөхцөл байдалд нь авчрах явцад үйлдвэрлэсэн бүтээгдэхүүнийг зарж борлуулахаас олсон орлогыг хасахыг хориглосон. Аж ахуйн нэгж нь тухайн бүтээгдэхүүний борлуулалтаас олсон орлого, бүтээгдэхүүнийг үйлдвэрлэхэд гарсан өртгийг тайлант жилийн ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрнө.
Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд буцаан мөрдөх нөхцөлтэй. Өөрөөр хэлбэл, нэмэлт өөрчлөлтийг анх удаа хэрэгжүүлэх үед тухайн өөрчлөлт нөлөөлөх хугацаанаас хойших ашиглалтанд орсон үндсэн хөрөнгөд энэ өөрчлөлтийг тусгана. Энэхүү өөрчлөлт нь санхүүгийн тайланд нь материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж үзэж байна.

**СТОУС 9 Санхүүгийн хэрэгслүүд - *Санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөх '10 хувь' шалгуур-хураамж***

Аж ахуйн нэгжийн бүтэц өөрчлөгдсөн санхүүгийн өр төлбөрийн нөхцөл нь гэрээний анхны нөхцлөөс үлэмж хэмжээгээр ялгаатай эсэхийг үнэлэхэд ашиглагдах хураамжийг нэмэлт өөрчлөлтөөр тодотгосон. Хураамжид зөвхөн зээлдэгч ба зээлдүүлэгчийн хооронд төлсөн эсхүл хүлээн авсан төлбөр орох бөгөөд үүнд нөгөө талын өмнөөс зээлдэгч эсхүл зээлдүүлэгчийн төлсөн буюу авсан төлбөр багтсан болно.

Тайлант хугацаанд Банкны санхүүгийн хэрэгсэлд өөрчлөлт ороогүй тул эдгээр нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлээгүй.

**СТОУС 3-т оруулсан нэмэлт өөрчлөлтүүд - *Үзэл баримтлалын хүрээний зөвлөмж***

Нэмэлт өөрчлөлтүүд нь НББОУС 37 "Нөөц болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө" эсхүл СТОУТХ 21 "Татвар" /тусад нь авч үзсэн бол/-т хамаарах өр төлбөр ба болзошгүй өр төлбөрийн улмаас үүсэж болзошгүй "2 дахь өдөр"-ийн ашиг, алдагдлаас зайлсхийх үүднээс СТОУС 3-н хүлээн зөвшөөрөх зарчимд үл хамаарах заалтыг нэмэлтээр оруулсан. Иймхүү зайлсхийж байгаа нь худалдан борлуулах өдөр одоогийн үүрэг байгаа эсэхийг тодорхойлохын тулд Үзэл баримтлалын хүрээний зөвлөмжийг ашиглахын оронд НББОУС 37 эсхүл СТОУТХ 21-г хэрэглэхийг шаарддаг.

Мөн энэхүү нэмэлт өөрчлөлтүүд нь борлуулалтын өдрөөр хүлээн зөвшөөрөх шалгуур хангаагүй болзошгүй хөрөнгийг тодорхой болгохын тулд СТОУС 3-т шинэ зүйл заалтыг нэмсэн. Шинэчлэгдсэн заалтын дагуу Банк нэмэлт өөрчлөлтийг хүлээн зөвшөөрсөн тайлант жилийн эхлэснээс хойш бизнесийн нэгдэл үүссэн тохиолдолд дээрх нэмэлт өөрчлөлтийг хэрэглэнэ.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр үйлчилнэ. Нэмэлт өөрчлөлтүүд Банканд нөлөөлөхгүй гэж үзэж байна.

ХАСБАНК
184
INVESTMENT LLC
УЛААНБААТАР ХОТ

**2.3 Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС) (Үргэлжлэл)**

**Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэ СТОУС болон нэмэлт өөрчлөлтүүд (Үргэлжлэл)**

**НББОУС 37-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд - *Давагдашгүй гэрээ - Гэрээ биелүүлэх зардал***

Давагдашгүй гэрээ гэдэг нь гэрээний дагуу авахаар хүлээгдэж буй эдийн засгийн үр өгөөжөөс давсан хүлээсэн үүргээ биелүүлэхтэй холбоотой зайлшгүй гарах зардлыг хэлнэ.

Нэмэлт өөрчлөлтүүд нь гэрээг давагдашгүй эсвэл алдагдалтай гэдгийг үнэлэхдээ компани бараа, үйлчилгээ үзүүлэх гэрээнд шууд хамааралтай зардлууд болон гэрээний үйл ажиллагаатай шууд холбоотой зардлын хуваарилалтыг аль алиныг нь багтаана. Ерөнхий болон захиргааны зардал нь гэрээнд шууд хамааралгүй бөгөөд гэрээнд заасны дагуу эсрэг талдаа тодорхой төлбөр тооцоогүй тохиолдолд хасагдана.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь 2022 оны 1-р сарын 1-ний өдрөөс хойших тайлангийн хугацаанд хүчин төгөлдөр болно. Банк эдгээр нэмэлт өөрчлөлтийг анх оруулсан тайлангийн жилийн эхэнд бүх үүргээ биелүүлээгүй байгаа гэрээнд хэрэгжүүлнэ. Банк энэхүү нэмэлт өөрчлөлтийн үр нөлөөг үнэлж байна.

**НББОУСЗ-өөс батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд**

Банкны санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон стандартын тайлбаруудыг дор тодруулсан болно. Банк эдгээр стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэгжиж эхлэх үеэс дагаж мөрдөнө.

| Хэрэгжих хугацаа | Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд |
|---|---|
| 2023 оны 1-р сарын 1 | • СТОУС 17 *Даатгалын гэрээ*<br>• НББОУС 8-ийн нэмэлт өөрчлөлт *Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт*<br>• НББОУС 1 ба СТОУС Практикийн бичиг баримт 2-ын нэмэлт өөрчлөлт *Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг толилуулах нь*<br>• НББОУС 12-ын нэмэлт өөрчлөлт *Нэг ажил гүйлгээнээс үүсч буй хөрөнгө ба өр төлбөрийн хойшлогдсон татвар* |
| 2024 оны 1-р сарын 1 | • СТОУС 16-ын нэмэлт өөрчлөлт *Борлуулаад буцаан түрээслэсэн хөрөнгийн түрээсийн өр төлбөр*<br>• НББОУС 1-ийн нэмэлт өөрчлөлт *Богино хугацаат болон урт хугацаат өр төлбөрийн ангилал* |
| Шийдвэрлэгдээгүй | • СТОУС 10, НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт *Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсхүл хандивласан* хөрөнгө |

**2.3 Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС) (Үргэлжлэл)**

**НББОУСЗ-өөс батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд**

**СТОУС 17 *Даатгалын гэрээ***

2017 оны 5-р сард НББОУСЗ нь даатгалын гэрээний хүлээн зөвшөөрөлт, хэмжилт, тайлагнал болон толилуулгын зарчмуудыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн иж бүрэн шинэ стандарт болох СТОУС 17 Даатгалын гэрээ стандартыг баталсан. СТОУС 17 нь хүчин төгөлдөр болох хугацаанаасаа эхлэн 2005 онд батлагдсан СТОУС 4 Даатгалын гэрээ стандартыг орлоно. СТОУС 17 нь даатгалыг гаргаж буй аж ахуйн нэгжийн төрлөөс үл хамааран бүх төрлийн даатгалын гэрээнд (жишээлбэл, амь насны даатгал, шууд даатгал, давхар даатгал гэх мэт) мөн түүнчлэн тодорхой оцлог бүхий санхүүгийн хэрэгслүүд болон баталгаанд үйлчилнэ. Стандартын хамрах хүрээ нь цөөн хэдэн хязгаарлалттай. СТОУС 17 нь СТОУС 9 эсхүл СТОУС 17-ийн хүрээнд ямар хэрэгслүүд эсхүл бүрэлдэхүүн хэсгүүд орохыг тодорхойлоход нөлөөлж болох даатгалын шинж чанар бүхий банкны бүтээгдэхүүний нягтлан бодох бүртгэлийн шинэ шаардлагыг танилцуулсан.

Даатгалд хамрагддаг зээлийн карт ба түүнтэй адилтгах бүтээгдэхүүнүүд: эдгээр бүтээгдэхүүнийг олгогчдын ихэнх нь СТОУС 9-ийн дагуу санхүүгийн хэрэгслүүд гэж үзэн одоогийн ашиглаж буй бүртгэлийн зарчмыг үргэлжлүүлэх боломжтой болно. СТОУС 17 нь даатгалын гэрээний тодорхойлолтыг хангасан зээлийн картын гэрээг (мөн түүнтэй адилтгах зээлийн эсхүл төлбөрийн нөхцөлтэй бусад гэрээг) гагцхүү аливаа нэг үйлчлүүлэгчтэй байгуулсан гэрээний үнийг тогтоохдоо тухайн үйлчлүүлэгчийн даатгалтай холбоотой эрсдэлийг тусгаагүй тохиолдолд СТОУС 17-ийн хамрах хүрээнд оруулахгүй.

Хэрэв даатгалын нөхцөл нь зээлийн картын гэрээний нөхцлийн нэг хэсэг болж олгогддог тохиолдолд, олгогч нь дараах шаардлагын дагуу бүртгэнэ:

- Даатгалын бүрэлдэхүүн хэсгийг салгаж СТОУС 17-ийн дагуу бүртгэх
- Бусад бүрэлдэхүүн хэсгүүдийг холбогдох бусад стандартууд (жишээлбэл, СТОУС 9, СТОУС 15 Хэрэглэгчидтэй байгуулсан гэрээний орлого эсхүл НББОУС 37 Нөөц, болзошгүй өр төлбөр ба болзошгүй хөрөнгө гэх мэт)-ын дагуу бүртгэнэ.

Даатгалын шинж чанарыг хангасан боловч даатгалын тохиолдол үүсэхэд гэрээний дагуу даатгуулагчийн үүргийг биелүүлэхэд шаардагдах хэмжээгээр нөхөн төлбөрийг хязгаарласан зээлийн гэрээ: Энэ төрлийн зээлийг олгогчид – жишээ нь: нас баралтаас болон чөлөөлөгдсөн зээл - СТОУС 9 эсхүл СТОУС 17-г сонгох боломжтой. Уг сонголт нь эргэлт буцалтгүй бөгөөд багцын түвшинд хийгдэнэ.

СТОУС 17 нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эхлэх эсхүл түүнээс хойших тайлагналын хугацаанд хүчин төгөлдөр болох бөгөөд шаардлагатай тоон үзүүлэлтүүдийг харьцуулна. Хэрэв Банк нь СТОУС 17 анх хэрэгжүүлж эхлэхээс өмнө эсхүл тухайн өдрөөс эхлэн СТОУС 9 болон СТОУС 15 стандартуудыг хэрэгжүүлж эхэлсэн тохиолдолд СТОУС 17-г хугацаанаас нь өмнө мөрдөж эхлэхийг зөвшөөрсөн.

Банк нь СТОУС 17-г хэрэгжүүлснээр санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөллийг үнэлгээг хийж дуусгасан бөгөөд СТОУС 17.7(h)-д заасан зээлийн карт зэрэг банкны зарим бүтээгдэхүүнийг энэхүү хүрээнд хамруулаагүй. 2023 оноос хэрэгжих шинэ стандарт нь Банкны санхүүгийн тайланд ямар нэгэн материаллаг нөлөө үзүүлэхгүй гэж дүгнэсэн.

**НББОУС 8-д оруулсан нэмэлт өөрчлөлтүүд - *Нягтлан бодох бүртгэлийн тооцооллын тодорхойлолт***

2021 оны 2-р сард НББОУСЗ нь НББОУС 8-ийн НББ-ийн тооцооллын тодорхойлолтод нэмэлт өөрчлөлт оруулсан. Энэхүү өөрчлөлтүүд нь НББ-ын тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлт, алдааны залруулга зэргийн хоорондын ялгааг тодорхойлсон. Мөн аж ах ахуй нэгжүүд НББ-ийн тооцооллыг боловсруулахад хэмжилтийн техник болон өгөгдөл хэрхэн хэрэглэгддэгийг тодруулж өгсөн.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсхүл түүнээс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болох бөгөөд НББ-ийн тооцооллын өөрчлөлт, НББ-ийн бодлогын өөрчлөлтүүдэд үйлчилнэ. Холбогдох баримтуудын толилуулсан тохиолдолд эрт хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

**2.3 Шинэ болон шинэчлэгдсэн Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд (СТОУС) (Үргэлжлэл)**

**НББОУСЗ-өөс батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (Үргэлжлэл)**

**НББОУС 1 болон СТОУС Практикийн бичиг баримт 2-*т орсон нэмэлт өөрчлөлтүүд - Нягтлан бодох бүртгэлийн бодлогыг толилуулах нь***

2021 оны 2-р сард НББОУСЗ-өөс НББОУС 1 болон СТОУС Практик тайлагнал 2-т материаллаг байдлын дүгнэлт хийх нэмэлт өөрчлөлтүүд оруулсан. Энэ нь НББ-ийн толилуулгад материаллаг байдлын дүгнэлтийг ашиглах заавар жишээг багтаасан. Нэмэлт өөрчлөлтүүд нь аж ахуйн нэгжүүдэд "гол" нягтлан бодох бүртгэлийн толилуулах шаардлагыг "материаллаг" нягтлан бодох бүртгэлийн бодлогоо ил тод болгох шаардлагаар сольж, аж ахуйн нэгжүүд материаллаг байдлын үзэл баримтлалыг хэрхэн ашиглах талаар зааварчилгааг нэмж оруулснаар илүү хүртээмжтэй нягтлан бодох бүртгэлийн бодлогын тодруулгын гаргахад туслах зорилготой юм.

Нэмэлт өөрчлөлтүүд нь 2023 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсхүл түүнээс хойших тайлант жилийн хугацаанд хүчин төгөлдөр үйлчлэх бөгөөд өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрнө. Практик тайлагнал 2 нь НББ-ийн мэдээлэлд материаллаг байдлын тодорхойлох заавал шаардагдахгүй зааварчилгаар гаргасан тул энэ өөрчлөлтөд хүчин төгөлдөр болох огноо шаардлагагүй болно.

Банк одоогоор энэхүү нэмэлт, өөрчлөлт нь НББ-ийн бодлогын тодруулгад хэрхэн нөлөөлөхийг үнэлж байна.

**НББОУС 12 Орлогын албан татвар – Нэг ажил гүйлгээнээс үүсч буй хөрөнгө ба өр төлбөрийн хойшлогдсон татвар**

НББОУСЗ нь 2021 оны 5 сард НББОУС 12 Орлогын албан татвар-т нэмэлт өөрчлөлт оруулсан. Уг өөрчлөлтөөр НББОУС 12-ын дагуу хойшлогдсон татварын хөрөнгө өр төлбөрийг анх удаа хүлээн зөвшөөрөхөөс чөлөөлөгдөх цар хүрээг нарийвчлан тусгасанаар татвар ногдох орлогоос хасагдах болон татвар ногдох тэнцүү дүнтэй түр зөрүү үүсгэж байгаа гүйлгээнүүдийг чөлөөлөгдөх цар хүрээнд хамааруулахгүй болсон.

Энэхүү нэмэлт өөрчлөлтийг санхүүгийн тайланд толилуулж буй зэрэгцүүлсэн тайлант жилийн эхэнд эсхүл тайлант жилийн эхнээс хойших хугацаанд гарсан гүйлгээнд дагаж мөрдөнө. Мөн, санхүүгийн тайланд толилуулж буй зэрэгцүүлсэн тайлант тайлант хугацааны эхэнд татвар ногдох болон татвар ногдох орлогоос хасагдах түр зөрүү үүсгэж буй түрээс болон татан буулгах үүрэгтэй холбоотой бүх гүйлгээнд хойшлогдсон татварын хөрөнгө (татвар ногдох ашиг хангалттай үед), өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Банк одоогоор энэхүү нэмэлт өөрчлөлт нь НББ-ийн бодлогын тодруулгад хэрхэн нөлөөлөхийг үнэлж байна.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй

**Гадаад валютын ханшийн тэгшитгэл**

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийсэн өдрийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн тайлангийн өдрийн албан ханшаар дахин хөрвүүлдэг. Арилжааны бус үйл ажиллагаанаас үүссэн ханшийн бүх зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд "Үйл ажиллагааны бусад орлого" гэж бүртгэнэ. Түүхэн өртгөөрөө гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлсийг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээрээ гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэн нь тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээр бүртгэх мөнгөн бус зүйлүүдийн дахин хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдалд шууд бусаар хүлээн зөвшөөрдөг мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний валютын ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогод шууд хүлээн зөвшөөрдөг.

**Орлого ба зардлыг хүлээн зөвшөөрөх**

Эдийн засгийн өгөөж нь Банкинд орж ирэх нь тодорхой мөн хэмжих боломжтой үед орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд:

**(i) Хүүгийн цэвэр орлого**

Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа эсхүл БҮЦАА бүртгэхээс бусад тохиолдолд санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого ба зардлыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолон "Хүү болон түүнтэй адилтгах орлого" ба "Хүү болон түүнтэй адилтгах зардал" гэж хүлээн зөвшөөрч цэвэр хүүгийн орлогод тус тус бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүүг тайлант хугацааны бодит үнэ цэнийн өөрчлөлт гэж үзэх бөгөөд "Арилжааны цэвэр алдагдал" болон "Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого"-д толилуулна. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хэрэгслүүд болон хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого эсхүл зардлыг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцоолно.

Үр ашигт хүүгийн түвшин нь ирээдүйн мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаанд эсхүл түүнээс богино хугацааны туршид хорогдуулж санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дансны цэвэр дүнг гаргах хүүгийн хувь болно. Ирээдүйн мөнгөн урсгалыг тооцохдоо санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний бүх нөхцөлүүдийг харгалзан үзнэ.

Тооцоолохдоо санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний бүх нөхцөлүүд (жишээлбэл, урьдчилж төлөх сонголт) болох ирээдүйн зээлийн алдагдлаас бусад тухайн хэрэгслүүдэд шууд хамаарах аливаа төлбөр эсхүл өсөн нэмэгдэх зардал болон үр ашигт хүүгийн түвшинг харгалзан үзнэ.

Үнэ цэн нь буурсан санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүү нь ирээдүйн мөнгөн урсгалыг (хүлээн зөвшөөрөх үед хүлээгдэж буй эрсдэлийн санг оруулна) санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнтэй (ихэнх тохиолдолд худалдан авсан дүнтэй тэнцүү байна) нь тэнцүү болгон хорогдуулах хүү байна. Энэхүү тооцооллоор үр ашигт хүүгийн түвшин өөрчлөгдөнө.

Доор дурдсан 2 нөхцөлөөс бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн дансны нийт дүнгээс үр ашигт хүүгийн хэмжээгээр хүүгийн орлого тооцоолно. (i). Үнэ цэнийн бууралтад орсон (3-р түвшинд хамаарах) санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг дансны нийт үнээс эрсдэлийн санг хассан дүнд үндэслэн үр ашигт хүүгийн хувиар тооцоолон олно. (ii). Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө худалдан авсан эсхүл санхүүгийн хөрөнгийг анх гаргахад үнэ цэнийн бууралтад орсон бол тухайн хөрөнгийн хорогдуулсан өртөг үндэслэн эрсдэлээр тохируулсан хүүгийн хувь хэмжээгээр хүүгийн орлогыг тооцоолно.

**(ii) Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого**

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамж, шимтгэлийн орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсний хариуд Банкны олох төлбөрийн хэмжээг тусгасан хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Гүйцэтгэлийн үүрэг, түүнчлэн тэдгээрийг хангах хугацааг гэрээ байгуулах үед тодорхойлдог. Банкны орлогын гэрээнд доор тайлбарласны дагуу олон гүйцэтгэлийн үүрэг ихэвчлэн байдаггүй. Банк нь харилцагчиддаа үйлчилгээ үзүүлэх үед төлбөрийг нэхэмжлэх бөгөөд ихэнхдээ үйлчилгээ үзүүлсэн даруй эсхүл тодорхой хугацаанд үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг гэрээний хугацаа дууссаны дараа авдаг. Банк нь үйлчилгээгээ харилцагчид шилжүүлэхээс өмнө ихэвчлэн хяналт тавьдаг тул орлогын зохицуулалтын үндсэн үүрэг гэж дүгнэсэн.

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)**

**Орлого ба зардлыг хүлээн зөвшөөрөх (Үргэлжлэл)**

**(ii) Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого (Үргэлжлэл)**

*Санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн хугацааны туршид хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого*

Тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Эдгээр хураамжид хадгаламжийн хайрцгийн шимтгэл орно.

*Гүйлгээний үйл ажиллагаанаас олсон шимтгэлийн орлого*

Гуравдагч этгээдтэй хийсэн хэлцэл, хэлцэлд оролцсоноос үүссэн хураамжийг үндсэн хэлцэл дууссаны дараа хүлээн зөвшөөрнө. Гүйцэтгэлийн тодорхой үүрэг хариуцлагатай холбоотой хураамж буюу хураамжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг гүйцэтгэлийн холбогдох шалгуурыг хангасны дараа хүлээн зөвшөөрнө.

Банк нь өргөн цар хүрээний санхүүгийн үйлчилгээ үзүүлж үүнээсээ шимтгэл ба хураамж авдаг. Банк санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр үр ашигт өгөөжийн нэг хэсэг биш болох бүх шимтгэлийн орлогоо (төлбөрийн картын хураамж, гар утасны үйлчилгээ г.м) цаг тухайд нь гүйцэтгэл биелэгдсэн үед нь бүртгэдэг. Банк өөрийн зээлийн багцын хэсэг болон бусад оролцогчдод хамаарах үр ашигт хүүгийн хэсгүүдээс өөртөө авч үлдээгүй.

*Холбогдох санхүүгийн хэрэгслүүдийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого*

Банкны холбогдох санхүүгийн хэрэгслүүдийн салшгүй хэсэг болох хураамжийн орлого нь: зээл олголтын шимтгэл, олгогдоогүй үйлчилгээний шимтгэл болон зээлтэй холбоотой бусад шимтгэлүүд орно. Эдгээр шимтгэл нь (өсөн нэмэгдэх аливаа зардлын хамт) зээлийн үр ашигт хүүгийн залруулга гэж хүүгийн орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө. Харин татан авахгүй нь бараг тодорхой болсон зээлүүдийн зээлийн үйлчилгээний шимтгэл нь хугацааны эцэст орлогоор хүлээн зөвшөөрөгдөнө.

*Хураамж ба шимтгэлийн зардал*

Хураамжийн зардал нь арилжааны банкинд тогтмол төлдөг үйлчилгээний шимтгэл хураамжийг илэрхийлдэг. Хураамжийн зардлыг бодитоор үйлчилгээ авсан тухай бүрд хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

Тодорхой гүйцэтгэлийн хэмжээтэй холбогдох төлбөрийн бүрэлдэхүүн хэсгүүдийг гүйцэтгэл биелэгдсэн үед нь хүлээн зөвшөөрдөг.

**(iii) Арилжааны цэвэр орлого**

Арилжааны цэвэр орлогод "Арилжаалах зорилгоор эзэмшиж буй" санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн хүүгийн орлого, зардал, бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн бүх олз, гарз болон ногдол ашиг хамаарна.

**(iv) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого**

Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаагаас бусад буюу БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хөрөнгө өр, төлбөрийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн бүх олз гарзыг энэхүү орлогод хамааруулна.
Хейджийн нягтлан бодох бүртгэлийг дагаж мөрдөх сонголт хийгээгүй тохиолдолд эдийн засгийн хейджийн зорилгоор эзэмшиж байгаа үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтөөс үүссэн зөрүүг энэ орлогод хамааруулна.

**Санхүүгийн хэрэгслүүд – анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилт**

Бодит үнэ цэнээр бүртгэж, өөрчлөлтийг нь тухайн жилийн ашиг алдагдлаар тусгадаг санхүүгийн хэрэгслүүдийг анх бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнийг хамгийн сайн тодорхойлох зүйл нь гүйлгээний үнэ байна. Бодит үнэ цэн гүйлгээний үнийн хооронд зөрүү гарсан тохиолдолд анх хүлээн зөвшөөрөлтийн олз, гарзыг зөвхөн дараах тохиолдолд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Адил төрлийн санхүүгийн хэрэгслийг арилжаалдаг зах зээлд сүүлийн үед гарсан гүйлгээний үнийг баримталсан эсхүл үнэлгээний аргачлалаар үнийг тогтоосон ба үнийн орц мэдээллийг зөвхөн ажиглагдахуйц зах зээлээс авсан. Анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгө болон бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх өрийн хэрэгслүүд дэх хөрөнгө оруулалтад хүлээгдэж буй эрсдэлийн санг хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Үүний үр дүнд санхүүгийн тайланд гарз хүлээн зөвшөөрнө.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

**Санхүүгийн хэрэгслүүд – анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилт (Үргэлжлэл)**

**(i) Хүлээн зөвшөөрөх өдөр**

Бүх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийг анх хүлээн зөвшөөрөхдөө арилжаа хийсэн өдөр (Банк тухайн хэрэгслүүдийн гэрээний нэг тал болсон өдөр) хүлээн зөвшөөрнө. Санхүүгийн хөрөнгийг холбогдох хууль тогтоомжинд заасан хугацаа эсхүл зах зээлийн хэлцлээр тогтоосон хугацаанд худалдах эсхүл худалдан авах арилжааг "Хэвийн нөхцөлтэй арилжаа"-нд хамааруулан ойлгоно.

**(ii) Санхүүгийн хөрөнгүүд – Ангилал болон хэмжилт**

Санхүүгийн хөрөнгийн ангилал нь 'ЗҮТБХТ' гэж нэрлэгддэг мөнгөн урсгалын шинжилгээ болон бизнесийн загварын шинжилгээгээр тодорхойлогдоно.

'ЗҮТБХТ'-ийн шалгуурт нийцээгүй санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд бүртгэгдэх санхүүгийн хөрөнгөөр бүртгэнэ.

'ЗҮТБХТ'-ийн шалгуурт нийцсэн санхүүгийн хөрөнгийг бизнесийн загварын шалгуураар үнэлнэ.

Санхүүгийн хөрөнгийн бизнесийн загварын шалгуур гэдэгт дараах ойлголтуудыг хамааруулна. Үүнд:

**Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгө:** Гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах зорилгоор эзэмшиж байгаа бизнесийн загварт хамаарах санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

**БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө:** Гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмшиж байгаа бизнесийн загварт хамаарах санхүүгийн хөрөнгийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ.

**БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хөрөнгө:** Дээрх 2 бизнесийн загварын алинд нь ч хамаарахгүй санхүүгийн хөрөнгийг бодит үнэ цэнийн өөрчлөлт нь ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгийн ангилалд толилуулна.

**(iii) Хорогдуулсан өртгөөр хэмжсэн санхүүгийн хөрөнгүүд**

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө БҮЦ-ээр нь бүртгэх бөгөөд БҮЦ-д санхүүгийн хөрөнгөтэй шууд холбоотой гүйлгээний зардал, зээл олгохтой холбоотой хураамж, шимтгэлүүд багтана. Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрсний дараа хорогдуулсан өртгөөр хэмжих буюу дансны үнэ дээр хуримтлагдсан хүүг нэмж, тайлант хугацааны үндсэн болон хүүгийн төлбөрийг хасаж бүртгэнэ. Эдгээр санхүүгийн хөрөнгүүдийг анх хүлээн зөвшөөрсөн өдрөөс эхлэн ирээдүйд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолно.

Гэрээ зурагдсан өдрөөр тодорхойлсон үр ашигт хүүгийн түвшинд үндэслэн хүүгийн орлогыг тооцоолно.

Энэхүү ангилалд Монголбанк дахь харилцах болон бэлэн мөнгө, харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа, бусад банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах ба хадгаламж, репо хэлцэл, Засгийн газар болон Монголбанкны өрийн бичиг, үнэт цаас багтана.

**(iv) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хөрөнгө**

**Өрийн хэрэгслүүд**

Дараах 2 шалгуурыг хангасан өрийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэнэ: Үүнд:

- Бизнесийн загварын шалгуур: Санхүүгийн хөрөнгийг гэрээний мөнгөн урсгалыг цуглуулах болон худалдан борлуулах зорилгоор эзэмшиж байгаа бизнесийн загвар ("цуглуулах, худалдан борлуулах"). Сүүлийн зорилго нь ач холбогдол багатай боловч бизнесийн загварын салшгүй хэсэг байдаг.
- Мөнгөн урсгалын загварын шалгуур: Санхүүгийн хөрөнгийг хорогдуулсан өртгөөр бүртгэх шалгууртай адил.

Санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө бодит үнэ цэнээр бүртгэх бөгөөд уг хөрөнгөд хамаарах шууд зардлыг бодит үнэ цэнд оруулан тооцно.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

**Санхүүгийн хэрэгслүүд – анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилт (Үргэлжлэл)**

### (iv) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хөрөнгө (Үргэлжлэл)

**Өрийн хэрэгслүүд (Үргэлжлэл)**

Дараах үеүдэд тэдгээрийг бодит үнэ цэнээр нь хэмжиж, бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрнө. Хорогдуулсан өртгөөр бүртгэх өрийн хэрэгслүүдийн ирээдүйд хүлээгдэж буй эрсдэлийн санг тооцдогтой адил БҮЦБДО-д бүртгэгдэх өрийн хэрэгслүүдийн ирээдүйд хүлээгдэж буй алдагдлыг тооцоолно. Өрийн хэрэгслийг худалдан борлуулсан өдрөөр өмнө нь уг хөрөнгөтэй холбоотойгоор бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн дүнг тайлант үеийн ашиг алдагдалд шилжүүлэн бүртгэнэ.

Үүнээс гадна, гэрээ байгуулах үед тодорхойлсон үр ашигт хүүгийн аргыг ашиглан хүүгийн орлогыг тооцоолж орлого, үр дүнгийн тайланд хүлээн зөвшөөрнө.

**Өмчийн хэрэгслүүд**

СТОУС 9-ийн хамрах хүрээнд багтах өмчийн бүх хөрөнгө оруулалтыг санхүүгийн байдлын тайланд бодит үнэ цэнээр нь хэмжинэ. Гэхдээ бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэхээр сонгосон өмчийн хөрөнгө оруулалт үүнд хамаарахгүй. Хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй өмчийн хэрэгслийг өртгөөр нь хэмжих сонголт байхгүй. Өрийн хэрэгслийг худалдан борлуулсан өдрөөр өмнө нь уг хөрөнгөтэй холбоотойгоор бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн дүнг тайлант үеийн ашиг, алдагдалд шилжүүлэн бүртгэхгүй. Хэрэв хүлээн авсан ногдол ашиг нь хөрөнгө оруулалтын өгөөжийг илэрхийлж байгаа бөгөөд өмчөөрх эргэн төлөлт биш бол тайлант үеийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрч бүртгэнэ. Эдгээр хэрэгслүүдэд үнэ цэнийн бууралт тооцохгүй.

Банк нь өмчийн хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэхээр сонгосон.

### (v) Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хөрөнгө

Санхүүгийн хэрэгслүүдийг доор дурдсан нөхцөлд БҮЦАА-д бүртгэх сонголт хийж болно. Үүнд: (а) хэмжилт буюу хүлээн зөвшөөрөлтийн нийцгүй байдлыг арилгах эсхүл багасгах; (б) Банк санхүүгийн хөрөнгө болон өр төлбөрийг бүлэглэн бодит үнэ цэнийн үндсэн дээр удирдах; (в) санхүүгийн өр төлбөр нь нийлмэл санхүүгийн хэрэгслийг агуулсан бөгөөд энэ нь үндсэн гэрээтэй шууд харилцан хамааралгүй байх тохиолдол.

Энэ ангилалд үүсмэл санхүүгийн хэрэгслүүд, ипотекийн зээлээр баталгаажсан бондууд ("ИЗББ"), энгийн эрхтэй хөрөнгөөр баталгаажсан бонд (ХББ) болон МИК Холдинг ХК-н 100% эзэмшдэг охин компаниудад худалдах харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа зэрэг багтана.

### (vi) Зээлээр авсан санхүүжилт, хоёрдогч өглөг ба өрийн үнэт цаас

Зээлээр авсан санхүүжилт, хоёрдогч өглөг болон өрийн үнэт цаас нь гадаад дотоодын санхүүгийн байгууллагын өмнө гэрээгээр хүлээсэн үүрэг юм.

Анхны хүлээн зөвшөөрөлтийн дараа, зээл, хоёрдогч өглөг болон өрийн үнэт цаасыг дараагийн тайлант хугацаанд үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ. Хорогдуулсан өртгийг тооцохдоо зээл авах үеийн хөнгөлөлт, урамшуулал ба үр ашигт хүүгийн нэг салшгүй хэсэг болж буй зардлуудыг авч үзнэ.

Банкны зээлээр авсан болон өрийн үнэт цаасаар авсан санхүүжилтийн шинжилгээг Тодруулга 21.3 болон 21.4-д тус тус толилуулсан.

### (vii) Бусад банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж

Үүнд дотоод ба гадаадын арилжааны банкууд ба Монголбанкнаас гадаад валют болон төгрөгөөр байршуулсан хугацаатай хадгаламж ба бусад банк ба санхүүгийн байгууллагуудын харилцах дансан дахь хадгаламж багтана. (Тодруулга 21.1).
Бусад банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламжийг анх хүлээн зөвшөөрсний дараа үр ашигт хүүгийн аргыг ашиглан хорогдуулсан өртгөөр нь хэмжинэ.

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)**

**Санхүүгийн хэрэгслүүд – анх хүлээн зөвшөөрөх болон дараа үеийн хэмжилт (Үргэлжлэл)**

**(viii) Харилцагчдын харилцах, хадгаламж**

Үүнд харилцагчдын байршуулсан харилцах данс, хугацаагүй болон хугацаатай хадгаламж багтана (Тодруулга 21.2).

Харилцагчдын харилцах, хадгаламжийн өр төлбөрийг анх хүлээн зөвшөөрсний дараа үр ашигт хүүгийн арга ашиглан хорогдуулсан өртгөөр хэмжинэ.

**(ix) Санхүүгийн баталгаа, аккредитив болон олгогдоогүй зээлийн амлалт**

Санхүүгийн баталгааны гэрээ нь өрийн хэрэгслүүдийн гэрээний нөхцөлийн дагуу төлөх төлбөрийг төлөх боломжгүй болсноос үүдэн баталгаа гаргуулагчийн өмнөөс баталгаа гаргагч буюу банк өрийн хэрэгслүүд эзэмшигчид төлбөрийг барагдуулах үүрэг бий болгож буй гэрээ.

Санхүүгийн баталгаа гаргаж өгсний улмаас хүлээн авсан урамшууллыг санхүүгийн тайлангуудад (сангийн хамт) анхлан бүртгэхдээ бодит үнэ цэнээр нь бүртгэнэ. Хэрэв бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх сонголт хийгээгүй ба санхүүгийн хөрөнгийг бусдад шилжүүлснээр санхүүгийн баталгаа үүсээгүй бол санхүүгийн баталгааг дараагийн тайлант үеүдэд доорх 2 дүнгийн аль ихээр нь хэмжинэ.

- СТОУС 9-ийн дагуу тодорхойлсон алдагдлын хэмжээ; болон
- Банкны орлого хүлээн зөвшөөрөх бодлогын дагуу хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан орлогын дүнгээс анх хүлээн зөвшөөрсөн дүнг хассан дүн.

Хүлээн авсан урамшуулалыг ашиг алдагдлын тайлангийн хураамж ба шимтгэлийн цэвэр орлогод хүлээн зөвшөөрөх бөгөөд шулуун шугамын аргаар баталгааны хугацааны туршид хүлээн зөвшөөрнө.

БҮЦАА-аар бүртгэгдээгүй санхүүгийн баталгааны гэрээг санхүүгийн байдлын тайланд (бусад өглөг дотор) эрсдэлийн сангаар тусгаж, дахин хэмжилтийг ашиг, алдагдлын тайланд Үнэ цэнийн бууралтын цэвэр зардалаар толилуулдаг.

Банк санхүүгийн баталгааны гэрээг БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдэд бүртгэх сонголт хийгээгүй болно.

**(x) Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээл олгох үүрэг**

Зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээл олгох үүргийг анх бодит үнэ цэнээр нь хэмжих бөгөөд хэрэв бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх сонголт хийгээгүй бол уг хэрэгслийг дараагийн тайлант үеүдэд доорх 2 дүнгийн аль ихээр нь хэмжинэ:

- СТОУС 9-ийн дагуу тодорхойлсон алдагдлын хэмжээ; болон
- Банкны орлого хүлээн зөвшөөрөх бодлогын дагуу хүлээн зөвшөөрсөн хуримтлагдсан орлогын дүнгээс анх хүлээн зөвшөөрсөн дүнг хассан дүн.

БҮЦАА-аар бүртгээгүй зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээл олгох үүргийг санхүүгийн байдлын тайланд (бусад өглөг дотор) эрсдэлийн сангаар тусгаж, дахин хэмжилтийг ашиг, алдагдлын тайланд Үнэ цэнийн бууралтын цэвэр зардалаар толилуулдаг.

Банк зах зээлийн хүүгээс доогуур хүүтэй зээл олгох үүргийг БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдэд бүртгэх сонголт хийгээгүй болно.

**Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт**

Зээлийн эрсдэлийн үнэ цэнийн бууралтын загвар нь хүлээгдэж буй алдагдал дээр үндэслэнэ. Энэ загвар нь хорогдуулсан өртгөөр эсхүл бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх зээл ба өрийн хэрэгслүүд, бодит үнэ цэнээр нь бүртгээгүй зээл олгох үүрэг болон санхүүгийн баталгаа, мөн дансны авлага хамаарна. Өмчийн хөрөнгө оруулалтад үнэ цэнийн бууралтын гарз хүлээн зөвшөөрөхгүй.



192

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)**

**Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (Үргэлжлэл)**

**Ерөнхий загвар**

Хөрөнгө анх хүлээн зөвшөөрснөөс хойш тухайн хөрөнгөтэй холбоотой зээлдэгчийн зээлийн эрсдэл хэрхэн өөрчлөгдсөн талаарх мэдээлэлд үндэслэн хөрөнгийг 3 “Түвшин”-д ангилах нөхцөлийг Банк тодорхойлсон. Үүнд:

- 12 сард ногдох хүлээгдэж буй алдагдалтай тэнцүү хэмжээний зээлийн эрсдэлийн сан ('Түвшин 1'): Хэрэв тайлангийн өдрөөр, санхүүгийн хэрэгслүүдийн зээлийн эрсдэл нь анх хүлээн зөвшөөрсөн үеэс хойш мэдэгдэхүйц хэмжээгээр өсөөгүй бол энэхүү санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бууралт нь 12 сард ногдох хүлээгдэж буй алдагдалтай тэнцүү байна (ирэх 12 сарын дотор төлбөрийн чадваргүй болох эрсдэлээс үүсэх);
- Үнэ цэнийн бууралтад ороогүй хөрөнгийн төлөгдөж дуусах хугацаа хүртэлх нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал ('Түвшин 2'): Анх хүлээн зөвшөөрсөн үеэс хойш санхүүгийн хэрэгслүүдийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өссөнөөс үүссэн алдагдлын хэмжээ нь нийт хугацааны хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү байна. Гэхдээ тухайн санхүүгийн хөрөнгө нь үнэ цэнийн бууралтад ороогүй байна.
- Үнэ цэнийн бууралтад орсон хөрөнгийн төлөгдөж дуусах хугацаа хүртэлх нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдал ('Түвшин 3'): Хөрөнгийн үнэ цэн буурсан үед алдагдлын дүн нь нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдалтай тэнцүү байна.

Ерөнхий загварыг СТОУС 9-ийн хамрах хүрээнд багтсан бүх хэрэгслүүдэд ашиглах бөгөөд үнэ цэн нь буурсан зээлийг худалдан авснаас бий болсон хөрөнгө болон анх гаргахад үнэ цэнийн бууралтад орсон хөрөнгийн хүлээгдэж буй зээлийн алдагдлыг хялбаршуулсан аргаар хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

СТОУС 9-ийн хүлээгдэж буй зээлийн алдагдлын загвараар түвшин хоорондын уялдаа холбоог сайтар тодорхойлж өгсөн. Жишээ нь: Өмнөх тайлант хугацаанд хөрөнгө төлөгдөж дуусах хүртэлх хугацаанд хүлээгдэж буй зээлийн эрсдэлийн сан байгуулсан байсан ба дараагийн тайлант хугацаанд зээлийн эрсдэл буурсан бол тухайн хөрөнгийг буцаан 1-р түвшинд ангилах буюу 1-р түвшинд хамаарах хүлээгдэж буй зээлийн эрсдэлийн сан байгуулж болох юм.

1 болон 2 дугаар түвшинд хамаарах хөрөнгийн хүүгийн орлогыг дансны нийт дүнд үндэслэн тооцоолно. Харин 3 дугаар түвшинд хамаарах хөрөнгийн хүүгийн орлогыг тооцохдоо дансны цэвэр дүнд буюу дансны нийт дүнгээс зээлийн эрсдэлийн санг хассан дүнд үндэслэн тооцно.

**Төлбөр төлөхгүй байх эрсдэл**

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолохын тулд төлбөр төлөхгүй байх эрсдэл буюу төлбөрийн доголдлыг тодорхойлох нь зүйтэй. Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолох болон зээлийн эрсдэл мэдэгдэхүйцээр өссөн гэх үзүүлэлтэд нөлөө үзүүлэх төлбөр төлөхгүй байх магадлалыг (ТТБМ) ашиглан 12 сарын болон нийт хугацаанд хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцоолдог.
Төлбөр төлөхгүй байх эрсдэл буюу төлбөрийн доголдолд гэдэгт дараах зүйлсийг хамааруулна. Үүнд:

- Үндсэн болон хүүгийн төлбөр 90 хоногоос дээш хэтрэх,
- Харилцагч зээлийн төлбөрөө Банкинд бүрэн төлөхгүй байх магадлалтай.

Банк харилцагчийн зээлийн төлбөрөө төлөх чадвартай байгаа эсэхийг үнэлэхдээ тоон болон чанарын үзүүлэлтийг харгалзан үздэг.

**Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт**

Банк үнэ цэнийн бууралт тооцох хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээнд өссөн эсэхийг байнга хянаж байдаг. Хэрэв зээлийн эрсдэл мэдэгдэхүйцээр өссөн бол Банк хүлээгдэж буй зээлийн алдагдлыг тооцохдоо 12 сард ногдох биш хөрөнгө төлөгдөж дуусах хүртэлх нийт хугацаанд тооцоолно.

Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогоор ашигтай арга буюу тайлант хугацааны эцэст зээлийн эрсдэл "бага" гэж үнэлэгдсэн хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээгээр өсөхгүй гэсэн үзэл баримтлалыг ашиглахыг зөвшөөрдөггүй. Тиймээс банк тайлант хугацаа бүрт үнэ цэнийн бууралт тооцох хөрөнгийн зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээнд өссөн эсэхийг үнэлж үздэг.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

**Хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралт (Үргэлжлэл)**

**Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт (Үргэлжлэл)**

Хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээнд өссөн эсэхийг үнэлэхдээ Банк санхүүгийн хэрэгслүүдийн үлдэх хугацаанд төлбөр төлөгдөхгүй байх эрсдэлийг тухайн санхүүгийн хэрэгслийг анх хүлээн зөвшөөрөх үед тооцоолсон эрсдэлтэй харьцуулна. Энэхүү тооцоололд тоон болон чанарын үзүүлэлт, зээлийн эрсдэлийн түүхэн мэдээлэл болон эдийн засгийн ирээдүйн нөхцөл байдал зэргийг харгалзан авч үзнэ.

Эдийн засгийн нөхцөл байдлыг таамагласан хувилбарууд нь хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх болон дараагийн тайлант үеүдэд төлбөр төлөгдөхгүй байх магадлалыг тодорхойлох суурь болно. Эдийн засгийн нөхцөл байдлыг таамагласан хувилбарууд нь төлбөр төлөгдөхгүй байх өөр, өөр магадлалын хувилбарыг бий болгоно. Эдгээр хувилбаруудын жигнэсэн дундаж магадлалын хувь хэмжээ нь зээлийн эрсдэл мэдэгдэхүйц хэмжээнд өссөн эсэхийг тодорхойлоход ашиглагдана.

**Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон зээлүүд**

Банк нь заримдаа барьцаа хөрөнгийг хураах авахын оронд зээлдэгчийн санхүүгийн хүндрэлийг зохицуулах үүднээс зээлийн үндсэн нөхцөлд хөнгөлөлт, өөрчлөлт оруулдаг.

Зээлдэгчийн одоогийн эсхүл хүлээгдэж буй санхүүгийн хүндрэлээс үүдэн хөнгөлөлт, өөрчлөлтийг Банк хийж болно гэж үздэг бөгөөд зээлдэгч санхүүгийн хувьд хүндрэл учраагүй бол Банк энэхүү хөнгөлөлт, өөрчлөлтийг зөвшөөрөхгүй болно.

Санхүүгийн хүндрэлийг харуулсан үзүүлэлтүүд нь Гэрээг биелүүлээгүй байх эсхүл Зээлийн Эрсдэлийн газруудаас гаргасан үзүүлэлтүүдээр тодорхойлогдоно. Энэхүү өөрчлөлтүүдэд төлбөрийн хугацааг сунгах, зээлийн шинэ нөхцөлийг зөвшөөрөх зэрэг орно.

Гэрээний нөхцөл өөрчлөгдсөний дараа аливаа үнэ цэнийн бууралтыг тооцохдоо өөрчлөлтөөс өмнө тооцоолсон анхны үр ашигт хүүг ашиглан хэмжинэ. Банк нь шинэчилсэн хуваарийн дагуу зээл цаашид хэвийн төлөгдөхийг баталгаажуулан хянадаг.

Зээлийг дахин тохируулж, өөрчилсөн боловч үл хүлээн зөвшөөрөгүй тохиолдолд зээлийн эрсдэл ихээхэн хэмжээгээр нэмэгдсэн гэж үздэг тул зээлийг 2-р шатанд ангилдаг. Хөрөнгө нь 2-р шатанд ангилагдсаны дараа зөвхөн дараах шалгууруудыг хангаж байж өөр шат руу ангилагдах боломжтой:

- Бүх зээлүүд нь хэвийн байх ёстой
- Шинэчилсэн төлбөрийн эргэн төлөлтийн хуваарийн дагуу зургаан сарын хугацаанд тогтмол төлбөрийг хийсэн байх
- Үйлчлүүлэгч хугацаа нь 30 хоногоос хэтэрсэн ямар ч гэрээ байгуулаагүй байх

Гэрээний нөхцөлд өөрчлөлт орсон хөрөнгийн талаархи мэдээллийг 31.2-р тодруулгад тусгасан болно.

**Данснаас хасах**

Банк санхүүгийн хөрөнгө бүхэлдээ эсхүл зарим хэсэг нь эргэн төлөгдөхгүй гэж үзсэн тохиолдолд зээл болон өрийн хэрэгслийг данснаас хасаж бүртгэдэг. Данснаас хасах гэж буй хөрөнгийн төлбөрийг төлөх орлогын эх үүсвэр эсхүл хөрөнгө харилцагчид байхгүй гэдгийг нотолсон тохиолдолд тухайн хөрөнгийг данснаас хасаж бүртгэдэг. Данснаас хасах гэдэг нь өмнө нь хүлээн зөвшөөрсөн хөрөнгийг буцаах гүйлгээ юм.

Гэвч, нягтлан бодох бүртгэлийн онолд данснаас хасах нь эрх зүйн утгаараа харилцагчаас авах өрийг хэрэгсэхгүй болгож байгаа хэрэг биш бөгөөд ирээдүйд харилцагчийн төлбөрийн чадвар сайжирсан тохиолдолд өр төлбөрийг барагдуулахыг шаардах юм. Банк санхүүгийн хөрөнгийг данснаас хасахдаа шүүхийн шийдвэрийг үндэслэдэг. Шийдвэр гүйцэтгэх үйл ажиллагаанаас нөхөн төлбөр хүлээж авбал үүнийг үнэ цэнийн бууралтын олз гэж бүртгэнэ.

### 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

**Санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлт**

**(i) Санхүүгийн хөрөнгө**

Дараах тохиолдолд санхүүгийн хөрөнгийг (эсхүл, санхүүгийн хөрөнгийн зарим хэсгийг эсхүл хоорондоо бүлэг санхүүгийн хөрөнгийн зарим хэсгийг) данснаас хасаж бүртгэнэ. Үүнд:

- Тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрх нь дууссан, эсхүл
- Банк тухайн хөрөнгөөс мөнгөн урсгал хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсхүл "дамжуулан өнгөрөөх" хэлцлийн дагуу хүлээн авсан мөнгөө нийт дүнгээр нь удаан хугацаагаар саатуулахгүйгээр гуравдагч талд төлөх үүрэг хүлээсэн, эсхүл
  - Банк хөрөнгийн бүх эрсдэл ба өгөөжийг шилжүүлсэн, эсхүл
  - Банк тухайн хөрөнгөтэй холбоотой эрсдэл ба өгөөжийг шилжүүлээгүй боловч хөрөнгийн хяналтыг шилжүүлсэн.

Банк хөрөнгөөс мөнгө хүлээн авах эрхээ шилжүүлсэн эсхүл "дамжуулан өнгөрөөх" хэлцэл хийсэн боловч хөрөнгөтэй холбоотой ихэнх эрсдэл, өгөөж болон хяналтыг шилжүүлээгүй тохиолдолд хөрөнгийг Банкны уг хөрөнгөд үргэлжлүүлэн оролцсоор байх хэмжээгээр нь хүлээн зөвшөөрнө. Энэ тохиолдолд Банк холбогдох өр төлбөрийг мөн хүлээн зөвшөөрнө. Шилжүүлсэн хөрөнгө ба холбогдох өр төлбөрийг Банкны хадгалж үлдсэн эрх, үүргийг тусган харуулсан сууриар хэмжинэ.

Энэхүү үргэлжилсэн оролцоо нь шилжүүлсэн хөрөнгийн баталгаа хэлбэртэй байвал оролцоог тус хөрөнгийн анхны бүртгэлийн дүн ба Банкны төлөх шаардлагатай болох хамгийн их дүнгийн аль багаар хэмжинэ.

**(ii) Санхүүгийн өр төлбөр**

Санхүүгийн өр төлбөрийг төлөхөөс чөлөөлөгдсөн, өр төлбөр цуцлагдсан эсхүл хугацаа нь дууссан бол данснаас хасаж бүртгэдэг. Хэрэв одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн зээлдүүлэгч нь хэвээрээ боловч ялгаатай нөхцөлтэй зээлийн гэрээгээр сольсон эсхүл одоо байгаа зээлийн нөхцөл эрс өөрчлөгдсөн бол эдгээр өөрчлөлт шинэчлэлтийг санхүүгийн өр төлбөрийг өмнө бүртгэсэн дүнг данснаас хассан ба шинэ өр төлбөрийн хүлээн зөвшөөрсөн гэж үзнэ. Санхүүгийн өр төлбөрийн анхны бүртгэлийн дүн ба төлсөн дүн хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

**Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд**

Банкны гадаад валютын ханшийн эрсдэлийг удирдах зорилгоор эзэмшиж буй санхүүгийн үүсмэл хэрэгслүүд. Үүсмэл хэрэгслүүдэд гадаад валютын форвард гэрээнүүд болон валютын своп гэрээнүүд багтана. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн дэлгэрэнгүй мэдээллийг тодруулга 14.2 хэсэгт харуулав.

Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн гэрээг байгуулсан өдрөөр бодит үнэ цэнээр нь хүлээн зөвшөөрч, тайлангийн дараах үе бүрт бодит үнэ цэнээр дахин хэмжинэ. Үнэлгээний зөрүүнээс үүссэн олз, гарзыг тайлант үеийн ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө. Үүсмэл санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн өөрчлөлт нь эерэг бол санхүүгийн хөрөнгөөр сөрөг бол санхүүгийн өр төлбөр хүлээн зөвшөөрч бүртгэнэ.

**Бодит үнэ цэнийг тодорхойлох**

Идэвхтэй зах зээл дээр арилжаалагдаж буй санхүүгийн хэрэгслүүдийн санхүүгийн байдлын тайлангийн өдрөөрх бодит үнэ цэн нь аливаа гүйлгээний зардлыг хасаагүй биржийн ханш болон дилерийн үнэ (урт позицийн хувьд нийлүүлэлтийн үнэ, богино позицийн хувьд эрэлтийн үнэ)-н дээр үндэслэнэ.

Идэвхтэй зах зээл дээр бүртгэлгүй санхүүгийн хэрэгслүүдийн хувьд бодит үнэ цэнийг нь тохиромжтой үнэлгээний аргуудыг ашиглан тодорхойлно. Эдгээр аргуудад өнөөгийн үнэ цэнийн аргачлал, зах зээлийн үнийн мэдээлэл нь ажиглагдахуйц адил төстэй санхүүгийн хэрэгслүүдтэй харьцуулах арга, опционы үнэлгээний загвар, зээлийн загвар болон бусад тохиромжтой аргууд багтана.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

**Бодит үнэ цэнийг тодорхойлох (Үргэлжлэл)**

Зах зээл дээрх сүүлийн үеийн арилжааны мэдээлэл эсхүл ашиглаж болохуйц зах зээлийн мэдээлэл байхгүй тохиолдолд зарим төрлийн санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг үнэлгээний арга ашиглан тодорхойлж бүртгэдэг. Тэдгээрийн бодит үнэ цэнийг тодорхойлохдоо бодит зах зээлийн гүйлгээний дүн болон үнийг тооцож үүнээс банк хамгийн тохиромжтой үнэлгээний загварыг ашигладаг. Позиц хаах үнэ, үнэлгээний нэмэх, хасах тохируулга, хөрвөх чадварын зөрүү, тухайн загварын хязгаарлалтууд нь авах зарах үнийн зөрүүг тодорхойлоход нөлөөлөх бөгөөд тэдгээр нөлөөллийн хамрах хүрээгээр загварт тохируулга хийдэг. Түүнчлэн санхүүгийн хэрэгслийг анх бүртгэхдээ эхний өдрийн үнэлгээнээс үүссэн олз, гарзыг хойшлуулан бүртгэх бөгөөд үнэлгээнд ашигласан орц мэдээлэл баттай болсон үед эсхүл хэрэгслүүдийг данснаас хасах үед олз, гарзыг тайлант үеийн ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн шинжилгээ болон бусад шаардлагатай мэдээллийг тодруулга 27-д тусгасан.

**Санхүүгийн хэрэгслүүдийг цэвэр дүнгээр тайлагнах**

Зөвхөн хүлээн зөвшөөрсөн дүнгүүдийг цэврээр барагдуулах хуулиар олгогдсон эрхтэй, тооцоог цэвэр дүнгээр нь барагдуулах, эсхүл хөрөнгийг борлуулж өр төлбөрийг нь барагдуулах ажлыг нэгэн зэрэг хийхээр зэхэж байгаа тохиолдолд л санхүүгийн хөрөнгө ба өр төлбөрүүдийг хооронд нь хааж, цэвэр дүнгээр нь тайлан тэнцэлд толилуулж болно. Мастер үр дүнгийн тооцооны гэрээнүүдийн хувьд энэ нөхцөлүүд ерөнхийдөө хэрэгждэггүй учраас холбогдох хөрөнгө болон өр төлбөрийг нийт дүнгээр нь санхүүгийн байдлын тайланд тус тусад нь толилуулдаг.

**Санхүүгийн хөрөнгө/өр төлбөрийн нөхцөл өөрчлөлт**

***Санхүүгийн хөрөнгө нөхцөл өөрчлөх***

Санхүүгийн хөрөнгийн үнэ цэнийн бууралтын болон зээлийн эрсдэлийн бус шалтгаанаар арилжааны бүтцийн өөрчлөлтийн үйл ажиллагааны үр дүнд гэрээний мөнгөн гүйлгээг дахин тохиролцсон эсхүл өөр хэлбэрээр бүтцийн өөрчлөлт оруулсан тохиолдолд, Банк уг өөрчлөлт нь тухайн санхүүгийн хөрөнгийг данснаас хасахад хүргэсэн эсэхийг тодорхойлох үнэлгээг хийдэг. Санхүүгийн хөрөнгийн хувьд энэхүү үнэлгээ нь чанарын хүчин зүйл дээр суурилдаг.

Банк харилцагчид олгосон зээлийг үл хүлээн зөвшөөрөх эсэхийг үнэлэхдээ доорх нөхцөлүүдийг авч үздэг:

- зээлийн валют өөрчлөгдсөн
- өмчийн шинж чанар тодорхойлогдсон
- бизнесийн түнш өөрчлөгдсөн
- өөрчлөлтийн улмаас ҮТХТ-ийн шалгуур хангахгүй байх

Хэрвээ өөрчлөлт нь мөнгөн урсгалд мэдэгдэхүйц нөлөө үзүүлээгүй бол энэ өөрчлөлтийг үл хүлээн зөвшөөрөх гэж авч үзэхгүй. Мөнгөн урсгалын өөрчлөлтийг анхны үр ашигт хүүгээр хорогдуулсан дүнд үндэслэн Банк үнэ цэнийн бууралтын алдагдал бүртгээгүй бол өөрчлөлтийг нь ашиг, алдагдлын тайланд бүртгэнэ.

***Санхүүгийн өр төлбөрийн нөхцөл өөрчлөх***

Одоо байгаа санхүүгийн өр төлбөрийн нөхцлийн өөрчлөлт нь ихээхэн ач холбогдолтой гэж дүгнэгдээгүй, улмаар данснаас хасахад хүргэхгүй бол санхүүгийн өр төлбөрийн хорогдуулсан өртгийг гэрээнд заасан ирээдүйн тооцоолсон мөнгөн гүйлгээний өнөөгийн үнэ цэнийг тооцоолохдоо санхүүгийн өр төлбөрийн анхны үр ашигт хүүгийн хямдруулалтын аргаар дахин тооцоолно. Үүний үр дүнд гарсан аливаа зөрүүг шууд ашиг, алдагдалд хүлээн зөвшөөрнө.

Банк санхүүгийн өр төлбөрийн хувьд, чанарын хүчин зүйлээс хамаарч, засварласан хямдруулсан өнөөгийн үнэ цэн болон санхүүгийн өр төлбөрийн анхны дансны үнийн хооронд арав буюу түүнээс дээш хувьтай зөрүү гарахад хүргэсэн өөрчлөлтийг мэдэгдэхүйц гэж үзнэ.

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)**

**Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө**

Мөнгөн гүйлгээний тайланд тайлагнасан мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгөнд касс дахь мөнгө, Монголбанкин дахь хязгаарлалтгүй харилцах данс, бусад банкуудад байршуулсан харилцах ба 3 сар түүнээс бага хугацаатай хадгаламжууд орно.

**Үндсэн хөрөнгө**

Тайлант хугацаа бүрийн эцэст үйлчилгээ үзүүлэх эсхүл захиргааны зорилгоор эзэмшиж буй барилга болон газраас бүрдсэн үл хөдлөх хөрөнгийг бодит үнэ цэнээс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан дүнгээр тусгадаг. Бусад бүх үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийг анхны өртгөөс хуримтлагдсан элэгдэл болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг (хэрэв байгаа бол) хассан дүнгээр тусгадаг.

Үйлчилгээ үзүүлэх эсхүл захиргааны зорилгоор ашиглагдах дуусаагүй барилгыг анхны өртгөөс бүртгэгдсэн үнэ цэнийн бууралтыг хассан дүнгээр тусгадаг. Эдгээр дуусаагүй барилгыг ашиглагдах зорилготой нь нийцүүлэн тохирох үндсэн хөрөнгө ба тоног төхөөрөмжийн ангилалд баригдаж дууссан үед нь ангилна. Эдгээр хөрөнгийг ашиглагдах зорилгод хэрэглэх боломжтой болсон үеэс бусад үндсэн хөрөнгүүдийн адил сууриар тооцон элэгдүүлж эхэлнэ.

Дахин үнэлгээг тайлант үе бүрийн дансны үнэ нь бодит үнэ цэнээр байх дүнгээс материаллаг зөрүү үүсгэхээргүй байхаар тогтмол хийгддэг.

Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ нэмэгдсэн бол өсөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрч, дахин үнэлгээний нөөцөд хуримтлуулан бүртгэнэ. Дахин үнэлсэн хөрөнгийг дахин үнэлэх үед үнэлгээ нь өсвөл өмнө нь хүлээн зөвшөөрсөн зардалтай тэнцэхүйц орлого хүлээн зөвшөөрч илүү гарч буй дүнгээр хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийг бүртгэнэ. Дахин үнэлгээний үр дүнд хөрөнгийн дансны үнэ буурсан бол уг бууралтыг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрөх ба дахин үнэлсэн хөрөнгийг дахин үнэлэх үед үнэ цэн нь буурсан бол өмнө нь хүлээн зөвшөөрсөн дахин үнэлгээний нэмэгдлийг бууруулж, уг нэмэгдлээс хэтэрсэн дүнг ашиг алдагдалд хүлээн зөвшөөрнө. Дахин үнэлсэн хөрөнгийг ашиглалтаас хасах эсхүл худалдан борлуулах үед хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн үлдэгдлийг хуримтлагдсан ашиг дансанд хаана.

Үндсэн хөрөнгийн өртөг эсхүл дахин үнэлсэн дүнгээс тэдгээрийн үлдэх өртгийг хассан дүнг шулуун шугамын аргаар, ашиглалтын жилд нь элэгдүүлдэг. Тооцоолсон ашиглалтын жил, үлдэх өртөг болон элэгдлийг бодох аргыг тайлан гаргах өдрөөр хянаж үздэг ба тооцооллыг өөрчлөх шаардлагатай байвал нөлөөллийг нь ирэх жилүүдэд залруулдаг.

Хөрөнгө тус бүрийн өртгийг үлдэх өртөг хүртэл нь, ойролцоолон тооцоолсон дараах ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

| | |
|---|---|
| Барилга | 40 жил |
| Тавилга, эд хогшил | 10 жил |
| Компьютер, техник хэрэгсэл | 3 - 10 жил |
| Тээврийн хэрэгсэл | 10 жил |
| Түрээсийн хөрөнгийн сайжруулалт | Түрээсийн хугацаа болон ашиглалтын хугацааны аль багад |

Үндсэн хөрөнгийг худалдан борлуулах үед эсхүл түүний ашиглалт, борлуулалтаас ирээдүйд эдийн засгийн үр ашиг олохгүй болсон үед үл хүлээн зөвшөөрнө. Үндсэн хөрөнгийн борлуулалтын цэвэр орлого (хэрэв байгаа бол), дансны цэвэр үнэ хоёрын зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрнө.

ХАСБАНК

РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
RHINOS INVESTMENT ÜTSK

2023.05. 12
БҮРТГЭВ

2023-05-05
БҮРТГЭВ-02

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

### Биет бус хөрөнгө

Банкны биет бус хөрөнгөд компьютерын программ хангамж, лиценз, патент, эрхийн өртөг орно.

Зөвхөн биет бус хөрөнгийн өртгийг зохистойгоор хэмжиж болох ба хүлээгдэж буй эдийн засгийн ирээдүйн өгөөж нь Банкинд орж ирэх нь магадлалтай болсон үед л биет бус хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

Тусад нь авсан биет бус хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөхдөө өртгөөр нь бүртгэдэг. Анх хүлээн зөвшөөрсний дараа, биет бус хөрөнгийг хуримтлагдсан хорогдуулалт болон үнэ цэнийн бууралтын алдагдлыг хассан өртгөөр тайланд тусгадаг.

Биет бус хөрөнгийн ашиглалтын хугацаа нь тодорхой эсхүл тодорхой бус эсэхийг үнэлнэ. Ашиглалтын тодорхой хугацаатай биет бус хөрөнгийг эдийн засгийн үр ашигтай хугацааны туршид нь хорогдуулна. Ашиглалт нь тодорхой хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулах хугацаа болон аргыг хамгийн багадаа санхүүгийн жил бүрийн эцэст хянаж үздэг. Хүлээгдэж буй ашиглалтын хугацаа эсхүл хүлээгдэж буй ирээдүйн үр өгөөжийн хэв загварт орсон өөрчлөлтийг хорогдуулалтын хугацаа эсхүл аргын аль тохиромжтойг нь өөрчлөх замаар бүртгэлд тусгах ба уг өөрчлөлтийг нягтлан бодох бүртгэлийн тооцооллын өөрчлөлт гэж үзнэ.

Хязгаарлагдмал хугацаатай биет бус хөрөнгийн хорогдуулалтын зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд биет бус хөрөнгийн үүрэгтэй нь нийцсэн зардлын бүлэгт хүлээн зөвшөөрнө.

Биет бус хөрөнгийн өртгийг дараах ойролцоогоор тооцоолсон ашиглалтын хугацааны туршид, шулуун шугамын аргыг ашиглан, үлдэх өртөг хүртэл нь хорогдуулна. Үүнд:

| | |
|---|---|
| Компьютерын програм хангамж | 1 - 10 жил |
| Патент ба эрхүүд | 1 - 10 жил |

### Түрээс

Хэрвээ ямар нэгэн төлбөрөөр тогтсон хугацааны туршид тодорхой хөрөнгийг ашиглаж, хянах эрх гэрээнд үүссэн бол тухайн гэрээг түрээсийн гэрээ эсхүл уг гэрээнд түрээсийн зүйл агуулагдсан байна гэж үзнэ.

### Түрээслэгч

Гэрээний зүйл тус бүрийн төлбөрийн хуваарилалт

Банк нь түрээсийн зүйл ба нэмэлтээр нэг эсхүл түүнээс дээш түрээс эсхүл түрээсийн бус зүйл агуулсан гэрээний хувьд түрээсийн зүйлийн гэрээ нэг бүрийн төлбөрийг түрээсийн зүйлийн холбогдох нэг бүрийн үнэ ба түрээсийн бус зүйлийн нэг бүрийн үнийн нийлбэр дээр суурилан хуваарилна.

Богино хугацаат түрээс ба бага үнэтэй хөрөнгийн түрээс

Банк нь гэрээ эхэлснээс хойш 12 сар ба түүнээс бага хугацаанд түрээслэх худалдан авах нөхцөлгүй салбар төвүүдийн түрээсийг богино хугацаат түрээсээр хүлээн зөвшөөрнө. Бага үнэтэй хөрөнгийн түрээсийг мөн адил хүлээн зөвшөөрнө. Богино хугацаат түрээсийн төлбөр ба бага үнэтэй хөрөнгийг түрээсийг шулуун шугамын арга эсхүл бусад системчлэгдсэн аргууд дээр суурилан түрээсийн хугацаанд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Ашиглах эрхтэй хөрөнгө

Ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт дараах зүйлс багтана:
- Түрээсийн өр төлбөрийн анх тооцсон дүн;
- Түрээс эхэлснээс эсхүл эхлэхээс өмнө төлсөн түрээсийн төлбөрөөс түрээснээс авсан урамшууллыг хассан дүн;
- Банкнаас анх гарсан шууд зардлууд; болон
- Түрээсийн шаардсан нөхцөлийг бүрдүүлэх зорилгоор тодорхой хөрөнгийг задлах ба нүүлгэх, хөрөнгө байрлах газрыг сэргээх эсхүл тухайн хөрөнгийг сэргээхэд Банкнаас гарсан зардлын тооцоолол.

Ашиглах эрхтэй хөрөнгийг өртгөөс үнэ цэнийн бууралт болон хуримтлагдсан элэгдлийг хассан дүн ба түрээсийн өр төлбөрийн дахин тооцооллын залруулсан дүнгээр тусгадаг.



ХАСБАНК
198

**2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)**

**Түрээс (Үргэлжлэл)**

**Түрээслэгч (Үргэлжлэл)**

Банк нь түрээсийн гэрээ дуусгавар болох үед тодорхой түрээсийн хөрөнгийн өмчлөлийг шилжүүлэн авах бол ашиглах эрхтэй хөрөнгийг түрээс эхэлсэн өдрөөс эхлэн ашиглагдах хугацаа дуусгавар болох хүртэл элэгдүүлнэ. Өөрөөр заагаагүй бол, ашиглах эрхтэй хөрөнгийг тооцоолсон ашиглагдах хугацаа ба түрээсийн хугацааны аль багаар нь шулуун шугамын аргаар элэгдүүлнэ.

Банк нь түрээсийн гэрээ дуусгавар болох үед тодорхой түрээсийн хөрөнгийн өмчлөлийг худалдан авах нөхцөлөө ашиглан шилжүүлэн авах бол ашиглах эрхтэй хөрөнгийн өртөг, үнэ цэнийн бууралт болон хуримтлагдсан элэгдлийн дүнгүүдийг үндсэн хөрөнгөөр бүртгэнэ.

Ашиглах эрхтэй хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн үндсэн хөрөнгө мөр дээр толилуулна.

Банк нь хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө болон бараа материалын тодорхойлолтод нийцээгүй ашиглах эрхтэй хөрөнгийг эдгээр тодорхой хөрөнгийг шилжүүлэн авсантай адил үндсэн хөрөнгө-д толилуулна. Хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө болон бараа материалын тодорхойлолтод нийцсэн ашиглах эрхтэй хөрөнгийг хөрөнгө оруулалтын зориулалттай хөрөнгө болон дуусаагүй хөрөнгө/борлуулах зориулалттай хөрөнгө-д толилуулна.

Буцаан авах түрээсийн барьцаа

Төлөгдсөн буцаан авах түрээсийн барьцааг СТОУС 9 Санхүүгийн хэрэгслүүд-ийн дагуу бодит үнэ цэнээр нь анх хүлээн зөвшөөрнө. Анх хүлээн зөвшөөрсөн бодит үнэ цэнийн залруулга нь нэмэлт түрээсийн төлбөр байх ба ашиглах эрхтэй хөрөнгийн өртөгт оруулан бүртгэнэ.

Түрээсийн өр төлбөр

Банк нь түрээс эхэлсэн өдрөөр төлөгдөөгүй байсан түрээсийн төлбөрийн өнөөгийн үнэ цэнээр түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрсөн. Түрээсийн өр төлбөрийн өнөөгийн үнэ цэнийг тооцоход Банк нь түрээсийн хүүгийн түвшин тодорхойлох боломжгүй үед түрээс эхлэх өдрөөр түрээсийн гэрээний нуугдмал хүү мэдэгдэхгүй бол өсөн нэмэгдэх хүүг ашигласан.

Түрээсийн төлбөрт дараах зүйл багтсан:

- тогтмол төлбөрүүдээс (бодит тогтмол төлбөрүүд) түрээсийн урамшууллыг хассан дүн;
- гэрээ эхлэх өдрөөр үнийн индекс эсхүл ханшийг ашиглан тодорхойлогдсон үнийн индекс эсхүл ханшнаас хамааралтай хувьсах түрээсийн төлбөрүүд;
- үлдэх өртгийн баталгаагаар Банкнаас төлөгдөх боломжтой төлбөрийн дүн;
- худалдан авах нөхцөлтэй үед худалдан авалтын боломжит үнэ;
- түрээсийн гэрээнд Банк нь түрээсийн хугацааг цуцлах эрхтэй үед түрээсийн гэрээг цуцлахад үүсэх торгууль.

Түрээсийн зах зээлийн үнээр хувьсан өөрчлөгдөх түрээсийн төлбөрийг гэрээ эхэлсэн өдрөөр түрээсийн зах зээлийн үнээр анх хүлээн зөвшөөрнө. Үнийн индекс эсхүл ханшнаас хамааралгүй хувьсах түрээсийн төлбөрийг түрээсийн өр төлбөр ба ашиглах эрхтэй хөрөнгийн дүнд оруулахгүй ба түрээсийн төлбөр гарсан тохиолдолд эсхүл нөхцөлд зардлаар хүлээн зөвшөөрнө.

Гэрээ эхэлснээс хойш түрээсийн өр төлбөрийг хүүгийн өсөлт ба түрээсийн төлбөрийн дүнгээр тохируулсан.

Дараах тохиолдолд Банк нь түрээсийн өр төлбөрийг (ашиглах эрхтэй хөрөнгөтэй холбоотой тохирох залруулгын хамт бүртгэж) дахин хэмжинэ:

- Түрээсийн хугацаа өөрчлөгдсөн эсхүл худалдан авах нөхцөлтэй гэрээтэй үед дахин үнэлгээ хийсэн өдрөөрх хорогдуулалтын түвшинг ашиглан хорогдуулсан түрээсийн төлбөрөөр хэмжигдэх түрээсийн өр төлбөрийг дахин үнэлж өөрчлөлт орсон;
- Анх ашигласан хоргдуулалтын түвшинг ашиглан хорогдуулсан түрээсийн төлбөрөөр хэмжигдэх түрээсийн өр төлбөрийг тодорхойлох үед гарсан баталгаат үлдэх өртөг нөлөөлсөн түрээсийн зах зээлийн боломжит төлбөрийн түрээсийн зах зээлийн түвшин өөрчлөгдсөнөөр түрээсийн төлбөр өөрчлөгдсөн.

Түрээсийн өр төлбөрийг санхүүгийн байдлын тайланд тусад нь толилуулж, холбогдох тодруулгыг мөн тусад нь харуулна.



199

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

**Түрээс (Үргэлжлэл)**

Түрээсийн гэрээний нөхцөл өөрчлөлт

Банк нь дараах тохиолдолд түрээсийн нөхцөл өөрчлөлтийг тусдаа түрээсээр бүртгэнэ:

- өөрчлөлт нь нэмэлтээр нэг болон түүнээс дээш тодорхой хөрөнгө ашиглах эрх үүсгэж, түрээсийн зүйлийг нэмэгдүүлсэн; ба
- түрээсийн үзүүлэлтүүд нь түрээсийн гэрээ тус бүр дээр тусгайлан заасан нөхцөл үүссэн үед түрээсийн зүйлийг нэмэгдүүлэхэд хэмжигдэхүйц нэг бүрийн үнээр өссөн.

Банк нь тусдаа түрээсээр бүртгэгдэхгүй түрээсийн нөхцөл өөрчлөлтийн хувьд өөрчлөгдсөн түрээсийн гэрээний хугацааг харгалзан өөрчлөлт орсон өдрөөрх шинэчлэгдсэн хорогдуулалтын түвшинг ашиглан шинэчлэгдсэн түрээсийн төлбөрийг хорогдуулан түрээсийн өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө.

Банк нь түрээсийн өр төлбөр шинэчлэгдсэн тохиолдолд ашиглах эрхтэй хөрөнгийн дүнг тохируулж бүртгэнэ. Өөрчлөгдсөн түрээсийн гэрээнд түрээсийн зүйл ба нэмэлтээр нэг эсхүл түүнээс дээш түрээс эсхүл түрээсийн бус зүйл агуулсан гэрээний хувьд түрээсийн зүйлийн гэрээ нэг бүрийн төлбөрийг түрээсийн зүйлийн холбогдох нэг бүрийн үнэ ба түрээсийн бус зүйлийн нэг бүрийн үнийн нийлбэр дээр суурилан хуваарилна.

**Ажилчдын тэтгэвэр тэтгэмж**

**(i) Богино хугацаат тэтгэмж**

Цалин ба түүнтэй холбогдох бусад зардлуудыг Банкны ажилчдаас холбогдох үйлчилгээг үзүүлсэн тухайн жилд нь зардалд тусгана. Ажилтнуудад ээлжийн амралт зэрэг богино хугацааны чөлөөтэй үед нөхөн олговрыг ажилласан жилийг нь харгалзан олгодог бөгөөд өвчтэй байх хугацааны нөхөн олговрыг цаг тухайд нь олгодог.

**(ii) Тогтоогдсон тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөө**

Монгол Улсын холбогдох хууль, тогтоомжид заасны дагуу Монгол Улсад үйл ажиллагаа явуулж байгаа компаниуд нь Монгол Улсын эрүүл мэнд, нийгмийн даатгалын санд шимтгэл төлнө. Эдгээр шимтгэлийг гарсан хугацаанд нь орлого, үр дүнгийн тайланд зардлаар хүлээн зөвшөөрнө. Банк мөн өөрсдийн байгуулсан тэтгэврийн санд шимтгэл төлдөг. Төлсөн шимтгэлийг ажилтны банкинд ажилласан хугацаанд нь хувь тэнцүүлэн "Тэтгэврийн сангийн зардал" дансанд бүртгэдэг.

**Сангууд**

Банкинд өнгөрсөн үйл явдлын үр дүнд үүссэн өнөөгийн үүрэг хариуцлага (хуулийн эсхүл үүсмэл) байгаа ба уг үүрэг хариуцлагыг биелүүлэхэд эдийн засгийн гадагш урсгал гарах магадлалтай болсон бөгөөд дүнг нь ул үндэслэлтэй тооцоолох боломжтой үед санг хүлээн зөвшөөрнө. Аливаа сантай холбоотой зардлыг дэлгэрэнгүй орлогын тайланд аливаа нөхөн төлбөрийг хассан цэвэр дүнгээр нь толилуулна.



200

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

**Татвар**

**(i) Орлогын албан татвар**

Одоогийн болон өмнөх тайлант хугацааны өнөөгийн албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг татварын байгууллагаас буцаан авахаар хүлээж байгаа эсхүл татварын байгууллагад төлөх дүнгээр хэмжинэ. Энэ дүнг тооцоолоход хэрэглэсэн татварын хувь хэмжээ, татварын хуулиуд нь санхүүгийн байдлын тайлангийн өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байсан.

**(ii) Хойшлогдсон татвар**

Хойшлуулсан орлогын албан татварыг тайлангийн өдрийн байдлаарх хөрөнгө, өр төлбөрийн татварын суурь, тэдгээрийн санхүүгийн бүртгэлийн дүн хоёрын түр зөрүү- ний дүнгээс тайлан тэнцлийн аргыг хэрэглэн тооцдог.

Дараахаас бусад бүх түр зөрүүнүүд дээр хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөрийг хүлээн зөвшөөрнө. Үүнд:

- Хэрэв хойшлуулсан орлогын албан татварын өр төлбөр нь гүүдвиллээс эсхүл бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол

Дараахаас бусад бүх хасагдах түр зөрүүнүүд, ашиглаагүй татварын хөнгөлөлт, ашиглаагүй татварын алдагдлууд дээр хойшлуулсан татварын хөрөнгийг хүлээн зөвшөөрнө.

- Хэрэв хасагдах түр зөрүүтэй холбоотой хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө нь бизнесийн нэгдлийн үеийн бус гүйлгээнээс үүссэн ба гүйлгээ хийх үед нягтлан бодох бүртгэлийн ашиг ба татвар ногдох ашгийн аль алинд нөлөө үзүүлэхгүй хөрөнгө, өр төлбөрийн анхны хүлээн зөвшөөрөлтөөс үүссэн бол

Хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийн бүртгэлийн дүнг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр хянаж үздэг ба энэхүү хөрөнгийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн ашиглахад хангалттай хэмжээний татвар ногдох орлого орж ирэх магадлал буурах үед уг бүртгэлийн дүнг бууруулна. Үл хүлээн зөвшөөрсөн хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг санхүүгийн байдлын тайлангийн өдөр бүр дахин үнэлж үздэг ба хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгийг ашиглахыг зөвшөөрсөн татвар ногдох орлого ирээдүйд орж ирэх магадлалтай болсон үед хүлээн зөвшөөрнө.

Банк нь түрээсийн өр төлбөртэй холбоотой үүссэн татвараас суутгагдах түрээсийн гүйлгээний хувьд ашиглах эрхтэй хөрөнгө ба түрээсийн өр төлбөр тус бүрд НББОУС 12 Орлогын татвар-т заасан шаардлагуудыг ашиглана. Түрээсийн төлбөрөөс давсан ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдлийг цэвэр хасагдах түр зөрүүнд хүлээн зөвшөөрнө.

Нэг татвар төлөгч, нэг татварын байгууллагад хамаарах хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хоорондн нь цэвэршүүлэн тайлагнах хуулиар олгогдсон эрхтэй бол хойшлуулсан орлогын албан татварын хөрөнгө ба өр төлбөрийг хоорондн нь цэвэршүүлэн тайлагнаж болно.

Банк орлогын татварын зохицуулалттай холбоотой аливаа тодорхой бус байдлыг үнэлэхдээ татварын эрх бүхий байгууллага тухайн тодорхой бус байдлыг хүлээн авах эсэх эсхүл орлогын татварын баримтжуулалтад бие даасан байгууллагуудыг оролцуулах шаардлагатай эсэхийг авч үздэг. Эрх бүхий байгууллага татварын тодорхой бус байдлыг хүлээн авсан тохиолдолд орлогын татварыг зохицуулалттай уялдуулан тодорхойлдог ба хүлээн авах боломжгүй нөхцөлд тодорхойгүй байдлаас үүдсэн үр нөлөө бүрийг хамгийн их их магадлалтай дүн эсхүл хүлээгдэж буй үнэ цэнийг ашиглан тусгана.

**Энгийн хувьцааны ногдол ашиг**

Энгийн хувьцааны ногдол ашгийг өр төлбөр гэж хүлээн зөвшөөрөх ба Банкны хувьцаа эзэмшигчид баталсан үед өөрийн хөрөнгөөс хасна. Хугацааны дундуурх ногдол ашгийг зарласан, Банк буцаах аргагүй болсон үед өөрийн хөрөнгөөс хасна.

Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараа батлагдсан тайлант жилийн ногдол ашгийг санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах үйл явдал гэж толилуулна.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

**Эздийн өмчийн нөөцүүд**

Банкны санхүүгийн байдлын тайланд эздийн өмчид бүртгэгдсэн нөөцөд дараах нөөцүүд орно. Үүнд:

Тусгай зориулалттай нөөцийг Монголбанкны шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчид хуваарилагдана. Тусгай зориулалттай нөөцийг Банкны удирдлага эсхүл Монголбанкны журмын дагуу Банкны удирдлагын шийдвэрээр хуримтлагдсан ашгаас шилжүүлж байгуулсан. Тусгай зориулалттай нөөц нь зээлийн болон хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын санг Монголбанкны журам болон СТОУС-ын дагуу тооцоолоход үүссэн зөрүүг илэрхийлдэг. Энэхүү нөөц нь өмчийн бусад хэсэгт бүртгэгдсэн бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчид хуваарилагдана.

“Бусад нөөц” нь Банкны Төлөөлөн Удирдах Зөвлөлийн шийдвэрээр хуримтлагдсан ашгаас шилжүүлсэн дүнг илэрхийлдэг. Бусад нөөцийн зорилгыг одоогийн байдлаар тодорхойлоогүй байна.

**Засгийн газрын нөхцөлт хандив**

Засгийн газрын нөхцөлт хандивыг хүлээн авах нь тодорхой болсон ба дагалдах бүх нөхцөлүүдэд нийцнэ гэж үзэж байгаа үед хүлээн зөвшөөрнө. Нөхцөлт хандив нь зардлын зүйлтэй холбогдож байгаа үед нөхцөлт хандивыг нөхөн олгох хандлагатай зардлуудтай тааруулахад шаардагдах хугацааны туршид орлогоор хүлээн зөвшөөрнө. Нөхцөлт хандив нь хөрөнгөтэй холбогдож байгаа үед үүнийг хойшлуулсан орлогоор хүлээн зөвшөөрөх ба холбогдох хөрөнгийн хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид тэнцүү хэмжээгээр орлогод хүлээн зөвшөөрнө.
Банк мөнгөн бус нөхцөлт хандивыг хүлээн авч байгаа үед хөрөнгө ба нөхцөлт хандивыг нийт нэрлэсэн дүнгээр нь бүртгэх ба хүлээгдэж буй ашиглалтын хугацааны туршид ба холбогдох хөрөнгийн өгөөжийг хэрэглэх хэлбэрээс хамааран жил бүр адил хэмжээтэйгээр орлогын тайлан руу бичнэ. Засгийн газар эсхүл холбогдох байгууллагаас зээл эсхүл төсөөтэй тусламжийг өнөөгийн хэрэгжиж буй зах зээлийн хүүгээс бага хүүтэйгээр олгож эсхүл үзүүлж байгаа үед энэхүү тааламжтай хүүгийн нөлөөллийг засгийн газраас олгож буй нэмэлт нөхцөлт хандив гэж үзнэ.

**Үнэт металл**

Зоос болон соёлын үнэт зүйлсийг өртөг ба цэвэр боломжит үнэ цэнийн аль багаар нь тусгана.

**Хураан авсан хөрөнгүүд**

Хураан авсан хөрөнгүүдийг анхлан тэдгээрийн бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн ба холбогдох зээлийн буцаан авалт хийгдсэн өдрийн байдлаарх үлдэгдэл дүнгийн аль багаар нь хүлээн зөвшөөрөх ба холбогдох зээл ба урьдчилгааг үнэ цэнийн бууралтын сангийнх нь хамт тайлан тэнцэлд үл хүлээн зөвшөөрнө. Дараагийн тайлант хугацаанд хураан авсан хөрөнгийг өртөг ба бодит үнэ цэнээс борлуулалтын зардлыг хассан дүн хоёрын аль багаар нь хэмжиж, “Бусад хөрөнгө”-нд бүртгэнэ.

Банкны бодлого нь хураан авсан хөрөнгүүдийг дотоод үйл ажиллагаандаа ашиглах эсхүл худалдан борлуулахыг тодорхойлдог. Дотоод үйл ажиллагаандаа ашиглахаар тодорхойлогдсон хөрөнгүүд нь холбогдох хөрөнгийн данс руу шилждэг. Худалдан борлуулахаар тодорхойлогдсон хөрөнгүүдийг “Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө”-ийн данс руу шилжүүлдэг. Ашиглалтыг нь банк тодорхойлоогүй хураан авсан хөрөнгүүдийг энэ дансанд бүртгэсэн болно.

**Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө**

Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгийг дансны үнэ болон борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар үнэлнэ. Хураан авсан хөрөнгийг үргэлжлүүлэн ашиглахаас илүү борлуулсанаар үлдэгдэл өртгийг нөхөх боломжтой бол уг хөрөнгийг борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгөд ангилна. Энэ нөхцөлийг хангахын тулд хураан авсан хөрөнгө нь зах зээл дээр тохиромжтой үнээр идэвхтэй арилжаалагдах, хөрөнгө болон худалдах багц нь өөрийн одоо байгаа нөхцөл байдлаараа түргэн борлогдох боломжтой, удирдлага худалдан борлуулахаар төлөвлөж байгаа, нэг жилийн дотор борлуулах магадлал өндөртэй байх ёстой.

**Сегментийн тайлагнал**

Банкны сегментийн тайлагнал нь дараах үйл ажиллагааны сегментэд суурилдаг. Үүнд: иргэдийн банк, бизнесийн банк, лизингийн, хөрөнгө зохицуулалтын хэлтэс.

## 2.4 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлогын хураангуй (Үргэлжлэл)

### Нэгж хувьцаанд ногдох ашиг

Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд олгохоор тооцсон жилийн цэвэр ашгийг тайлант хугацааны туршид гаргасан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулж тооцоолно.

Хорогдуулсан нэгж хувьцаанд ногдох ашгийг энгийн хувьцаа эзэмшигчдэд олгохоор тооцсон жилийн цэвэр ашиг дээр аливаа татварын нөлөөллийг оруулсан хөрвөгч давуу эрхтэй хувьцаа болон хөрвөгч бонд (хорогдуулагч үнэт цаас)-ын хүүг нэмж, уг дүнгээ хэрвээ хорогдуулагч үнэт цааснуудыг бүгдийг нь хөрвүүлсэн тохиолдолд нэмж гаргах байсан энгийн хувьцааны тоог оруулсан энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд харьцуулж тооцоолно.

### Холбоотой талуудтай хийсэн ажил гүйлгээ

Холбоотой талууд гэдэгт Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн, хуулийн этгээдийг хэлнэ. Үүнд:

а. Банктай дараах байдлаар холбогдсон хувь хүн эсхүл тухайн хувь хүний ойрын төрөл садан:
- (i) Банкийг дангаараа эсхүл хамтран хянадаг;
- (ii) Банкинд мэдэгдэхүйц нөлөөлөлтэй; эсхүл
- (iii) Банкны гол удирдах албан тушаалтнуудын нэг.

б. Дараах нөхцөл хангагдаж байвал тухайн хуулийн этгээдийг Банктай холбогдох этгээд гэж үзнэ:
- (i) Тухайн хуулийн этгээд болон Банк нь нэг групп компанийн бүрэлдэхүүнд багтаж байвал (Өөрөөр хэлбэл, толгой компани, охин компани болон толгой компанийн охин компаниуд холбогдох этгээдүүд юм.)
- (ii) Нэг хуулийн этгээд нь нөгөө хуулийн этгээдийн хараат эсхүл хамтарсан үйлдвэр бол (эсхүл, нөгөө хуулийн этгээдийг багтаасан бүлгийн нэг аж ахуйн нэгжийнх нь хараат эсхүл хамтарсан үйлдвэр бол).
- (iii) Хоёр хуулийн этгээд хоёулаа гуравдагч талын хамтарсан үйлдвэр бол.
- (iv) Нэг хуулийн этгээд нь гуравдагч талын хамтарсан үйлдвэр ба нөгөө хуулийн этгээд нь уг гуравдагч этгээдийн хараат компани бол.
- (v) Тухайн хуулийн этгээд нь Банкны ажилчдад зориулсан ажил эрхлэлтийн дараах тэтгэвэр тэтгэмжийн төлөвлөгөө бол. Хэрэв Банк өөрөө ийм төлөвлөгөө болж байвал санхүүжүүлж буй ажил олгогч нь Банкны холбогдох этгээд болно.
- (vi) (а)-д тодорхойлсон хувь хүн тухайн хуулийн этгээдэд хяналт тавьдаг эсхүл хамтран хянадаг бол.
- (vii) (а)(i)-д тодорхойлсон хувь хүн тухайн хуулийн этгээдэд мэдэгдэхүйц нөлөөтэй эсхүл уг хуулийн этгээд (эсхүл түүний толгой компани)-ийн тэргүүлэх удирдлагын гишүүн бол.
- (viii) Хуулийн этгээд, эсхүл түүний бүлгийн аль нэг гишүүн нь Банкны толгой компани эсхүл Банкинд тэргүүлэх удирдлагын боловсон хүчний үйлчилгээг үзүүлдэг бол.

Холбоотой талуудын боломжит хамаарлыг харгалзахдаа зөвхөн эрх зүйн хэлбэрийг биш хамаарлын мөн чанарыг чухалчлан анхаарсан.

Ойрын садан төрөл гэж иргэний гэр бүлийн гишүүн, төрөл, садангийн хүн, тэдгээр нь шууд буюу шууд бус хэлбэрээр хяналтаа хэрэгжүүлдэг хуулийн этгээд, түүний нэгдмэл сонирхолтой этгээд. Холбоотой талуудтай хийсэн материаллаг ажил гүйлгээ болон дансны үлдэгдлийг санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгад толилуулсан бөгөөд Тодруулга 30-аас дэлгэрэнгүйг харна уу.

**3. Сегментийн мэдээлэл**

Удирдлагын зорилгоор Банк нь бүтээгдэхүүн, үйлчилгээн дээрээ суурилан үйл ажиллагааны дараах дөрвөн сегментэд хуваагддаг. Үүнд:

| | |
|---|---|
| Иргэдийн банк | Хувь харилцагчид, жижиг дунд бизнес ба жижиг хэмжээтэй бизнесийн харилцах данс, хадгаламжийн данс, дебет болон кредит карт, хэрэглээний зээл, санхүүгийн түрээс, бичил болон жижиг дунд бизнесийн стандарт зээлийн бүтээгдэхүүн болон эко зээл, эмэгтэй бизнес эрхлэгчдийн зээл гэх мэт дотооддоо хөгжүүлсэн болон сурталчилж буй зээлүүд, банкны дансдын үйлчилгээ болох төлбөр шилжүүлгүүд. |
| Бизнесийн банк | Байгууллагын банкны харилцагчдад үзүүлдэг арилжааны банкны үйл ажиллагаа, үүнд харилцагчдын хэрэгцээ шаардлагад тохирсон зээлийн үйлчилгээнүүд болох эрсдэл хуваах зээл, экспорт/импортын худалдааны санхүүжилт, овердрафтын дансны үйлчилгээ, хөнгөлөлттэй хувиар хийх олон улсын шилжүүлгүүд. |
| Лизинг | Санхүүгийн түрээсийн үйлчилгээ. Багцад голчлон арилжааны болон суудлын тээврийн хэрэгсэл, хуучин машин, эмнэлэгийн болон хөдөө аж ахуйн тоног төхөөрөмж, машин механизм багтдаг. |
| Хөрөнгө болон эх үүсвэрийн удирдлага | Бэлэн мөнгө, гадаад валют, хөрвөх чадварын удирдлага, үнэт цаасны хөрөнгө оруулалт, банк хоорондын арилжаа эсхүл жижгэвтэр банкуудын зах зээлийг бий болгох, хэрэгцээтэй үед арилжаалах бусад санхүүгийн хэрэгслүүд. Мөн актив, пассивын төвлөрсөн удирдлагыг хэрэгжүүлэхийн тулд илүүдэл эх үүсвэрийг хөрөнгө зохицуулах газарт төвлөрүүлдэг. |

Банкны удирдлага нь нөөцийн хуваарилалт, гүйцэтгэлийн үнэлгээний талаар шийдвэр гаргахдаа хэрэглэх зорилгоор өөрийн бизнесийн үйл ажиллагааны үр дүнг тусад нь хянаж байдаг. Сегментийн гүйцэтгэлийг үйл ажиллагааны ашиг, алдагдал (зарим тохиолдолд санхүүгийн тайлангууд дээрх үйл ажиллагааны ашиг алдагдлаас өөрөөр хэмждэг) дээр нь үндэслэн үнэлдэг. Орлогын татварыг банкны түвшинд удирддаг ба сегментүүдэд хуваарилдаггүй.

Удирдлага нь гүйцэтгэлийн хэмжүүр нь нийт орлого, зардал биш цэвэр хүүгийн орлого байдаг учраас хүүгийн орлогыг цэвэр дүнгээр нь тайлагнадаг.

Үйл ажиллагааны сегментүүдийн хооронд шилжих үнэ нь гуравдагч талтай хийж байгаа гүйлгээний нэг адил зарчмаар тооцогддог.

2022 ба 2021 онуудын аль алинд нэг хөндлөнгийн харилцагч эсхүл бизнесийн түнштэй хийсэн гүйлгээний орлого нь Банкны нийт орлогын 10%-иас илүү гараагүй.

**Бүс нутгийн мэдээлэл**

Банкны бүхий л үйл ажиллагаа Монгол Улсад хийгдсэн. Иймд учраас бүс нутгийн мэдээлэл толилуулаагүй.

### 3. Сегментийн мэдээлэл (Үргэлжлэл)

Доорх хүснэгтэнд Банкны 2022 оны үйл ажиллагааны сегментүүдийн орлого, ашиг ба тодорхой хөрөнгө, өр төлбөрийн талаарх мэдээллийг толилуулав.

| | Иргэдийн банк | Бизнес банк | Лизинг | Хөрөнгө болон эх үүсвэрийн удирдлага | Нийт |
|---|---|---|---|---|---|
| | 2022 мян.төг | 2022 мян.төг | 2022 мян.төг | 2022 мян.төг | 2022 мян.төг |
| **Цэвэр орлого** | | | | | |
| Гуравдагч тал | 123,666,335 | 59,952,949 | 32,016,494 | 48,035,176 | 263,670,954 |
| Сегмент хоорондын | 31,397,611 | (18,736,027) | (8,319,441) | (4,342,143) | - |
| **Нийт үйл ажиллагааны орлого** | **155,063,946** | **41,216,922** | **23,697,053** | **43,693,033** | **263,670,954** |
| Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал | (4,334,662) | (1,894,257) | (2,665,471) | (258,967) | (9,153,357) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **150,729,284** | **39,322,665** | **21,031,582** | **43,434,066** | **254,517,597** |
| **Үр дүнгүүд** | | | | | |
| Хүүгийн цэвэр орлого | 105,118,824 | 55,922,711 | 31,688,744 | 30,946,357 | 223,676,636 |
| Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого | 16,560,199 | 2,524,949 | 327,750 | - | 19,412,898 |
| Арилжааны цэвэр ашиг | - | - | - | 15,892,158 | 15,892,158 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | - | - | - | 1,091,553 | 1,091,553 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | (5,109,233) | (510,923) | (153,936) | (510,923) | (6,285,015) |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл | (3,717,112) | - | (92,181) | - | (3,809,293) |
| Биет бус хөрөнгийн хорогдол | (1,626,749) | (162,675) | - | (162,675) | (1,952,099) |
| Үйл ажиллагааны бусад зардал | (75,689,166) | (15,284,576) | (1,614,701) | (4,700,109) | (97,288,552) |
| Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга | - | 1,506,637 | - | - | 1,506,637 |
| Үйл ажиллагааны бусад цэвэр орлого | 1,987,312 | 1,505,289 | - | 105,108 | 3,597,709 |
| Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал | (4,334,662) | (1,894,257) | (2,665,471) | (258,967) | (9,153,357) |
| Сегмент хоорондын | 31,397,611 | (18,736,027) | (8,319,441) | (4,342,143) | - |
| **Татварын өмнөх сегментийн ашиг** | **64,587,024** | **24,871,128** | **19,170,764** | **38,060,359** | **146,689,275** |
| Орлогын албан татварын зардал | (18,053,677) | (6,751,062) | (5,447,423) | (10,598,527) | (40,850,689) |
| **Татварын дараах сегментийн ашиг** | **46,533,347** | **18,120,066** | **13,723,341** | **27,461,832** | **105,838,586** |
| Бусад сегментийн мэдээлэл | | | | | |
| Капитал зардал: | | | | | |
| Үндсэн хөрөнгө | 6,886,080 | 1,205,064 | 106,570 | - | 8,197,714 |
| Бусад биет бус хөрөнгө | 4,627,758 | 809,858 | 71,620 | - | 5,509,236 |
| | **11,513,838** | **2,014,922** | **178,190** | **-** | **13,706,950** |
| **Сегментийн нийт хөрөнгө** | **2,033,619,572** | **425,287,026** | **217,792,310** | **1,254,081,395** | **3,930,780,303** |
| **Сегментийн нийт өр төлбөр** | **2,481,895,553** | **199,162,508** | **19,590,354** | **754,444,228** | **3,455,092,643** |

### 3. Сегментийн мэдээлэл (Үргэлжлэл)

Доорх хүснэгтэнд Банкны 2021 оны үйл ажиллагааны сегментүүдийн орлого, ашиг ба тодорхой хөрөнгө, өр төлбөрийн талаарх мэдээллийг толилуулла.

| | Иргэдийн банк | Бизнес банк | Лизинг | Хөрөнгө болон эх үүсвэрийн удирдлага | Нийт |
|---|---|---|---|---|---|
| | 2021 мян.төг | 2021 мян.төг | 2021 мян.төг | 2021 мян.төг | 2021 мян.төг |
| **Цэвэр орлого** | | | | | |
| Гуравдагч тал | 87,235,727 | 56,440,269 | 16,981,251 | 25,445,815 | 186,103,062 |
| Сегмент хоорондын | 29,787,251 | (19,485,201) | (2,633,650) | (7,668,400) | - |
| **Нийт үйл ажиллагааны орлого** | **117,022,978** | **36,955,068** | **14,347,601** | **17,777,415** | **186,103,062** |
| Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал | (1,361,529) | (2,090,911) | (228,324) | (890,436) | (4,571,200) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **115,661,449** | **34,864,157** | **14,119,277** | **16,886,979** | **181,531,862** |
| **Үр дүнгүүд** | | | | | |
| Хүүгийн цэвэр орлого | 72,256,813 | 48,347,981 | 16,591,974 | 24,161,190 | 161,357,958 |
| Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого | 15,656,102 | 2,908,136 | 360,511 | - | 18,924,749 |
| Арилжааны цэвэр ашиг | - | - | - | 5,378,028 | 5,378,028 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | - | - | - | 816,488 | 816,488 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл | (5,102,658) | (618,606) | - | (618,606) | (6,339,870) |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл | (3,711,714) | - | - | - | (3,711,714) |
| Биет бус хөрөнгийн хорогдол | (2,332,933) | (288,827) | - | (288,827) | (2,910,587) |
| Үйл ажиллагааны бусад зардал | (52,294,200) | (9,965,533) | (2,462,391) | (2,786,659) | (67,508,783) |
| Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга | - | 1,407,264 | - | - | 1,407,264 |
| Үйл ажиллагааны бусад цэвэр (зардал)/орлого | (677,188) | 5,184,152 | 28,766 | (4,909,891) | (374,161) |
| Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал | (1,361,529) | (2,090,911) | (228,324) | (890,436) | (4,571,200) |
| Сегмент хоорондын | 29,787,251 | (19,485,201) | (2,633,650) | (7,668,400) | - |
| **Татварын өмнөх сегментийн ашиг** | **52,219,944** | **25,398,455** | **11,656,886** | **13,192,887** | **102,468,172** |
| Орлогын албан татварын зардал | (18,259,784) | (1,898,708) | (2,007,030) | (5,039,775) | (27,205,297) |
| **Татварын дараах сегментийн ашиг** | **33,960,160** | **23,499,747** | **9,649,856** | **8,153,112** | **75,262,875** |
| Бусад сегментийн мэдээлэл | | | | | |
| Капитал зардал: | | | | | |
| Үндсэн хөрөнгө | 4,512,707 | 795,035 | 73,238 | - | 5,380,980 |
| Бусад биет бус хөрөнгө | 3,070,517 | 540,256 | 45,802 | - | 3,656,575 |
| | **7,583,224** | **1,335,291** | **119,040** | **-** | **9,037,555** |
| **Сегментийн нийт хөрөнгө** | **1,538,902,563** | **343,373,878** | **193,560,060** | **1,424,122,127** | **3,499,958,628** |
| **Сегментийн нийт өр төлбөр** | **2,350,149,620** | **110,864,098** | **81,009,182** | **573,940,884** | **3,115,963,784** |

## 4. Хүүгийн цэвэр орлого

### Хүү болон түүнтэй адилтгах орлого

| | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| **4.1 Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө** | | |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 294,038,650 | 247,740,052 |
| Өрийн хэрэгслүүд | 58,311,299 | 71,182,477 |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 7,359,333 | 3,236,079 |
| Үнэт цаасны санхүүжилтийн корпораци (ҮЦСК) - давуу эрхтэй хөрөнгөөр баталгаажсан бонд (ХББ) | 1,247,474 | 274,960 |
| Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 1,046,277 | 339,848 |
| Урвуу репо хэлцэл | 437,012 | 136,090 |
| | **362,440,045** | **322,909,506** |
| **4.2 БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд** | | |
| Своп арилжааны хүү | 10,015,348 | 7,140,118 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 4,203,161 | 2,036,714 |
| | **14,218,509** | **9,176,832** |
| **Хүү болон түүнтэй адилтгах орлого** | **376,658,554** | **332,086,338** |

### 4.3 Хүү болон түүнтэй адилтгах зардал

| | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| **Хорогдуулсан өртгөөрх болон БҮЦАА-д бүртгэх санхүүгийн өр төлбөр** | | |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 105,721,684 | 107,416,115 |
| Зээлээр авсан санхүүжилт | 41,907,336 | 46,493,820 |
| Своп арилжааны хүү | 6,278,609 | 18,417,743 |
| Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж | 1,773,248 | 428,745 |
| Түрээсийн гэрээний хүүгийн зардал (Тодруулга 19.3) | 318,019 | 555,674 |
| Репо хэлцэл | 309,484 | 109,782 |
| Өрийн үнэт цаас | 22,637 | 490,421 |
| Бусад хүүгийн зардал | 799 | 417,745 |
| | **156,331,816** | **174,330,045** |
| **Хүүгийн цэвэр орлого** | **220,326,738** | **157,756,293** |

## 5. Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого

| | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| **Хураамж ба шимтгэлийн орлого** | | |
| Картын үйлчилгээний хураамж ба шимтгэл | 18,373,247 | 16,261,259 |
| Мөнгөн гуйвуулга, худалдааны санхүүжилт болон бусад үйлчилгээний хураамж | 8,711,913 | 7,340,655 |
| Дансны үйлчилгээний хураамж ба шимтгэл | 3,382,538 | 2,732,088 |
| Зээлийн үйлчилгээний хураамж ба шимтгэл | 233,962 | 610,133 |
| | **30,701,660** | **26,944,135** |
| **Хураамж ба шимтгэлийн зардал** | | |
| Картын гүйлгээний шимтгэл | 7,587,388 | 6,053,768 |
| Банкны үйлчилгээний шимтгэл | 3,651,914 | 1,899,028 |
| Зээлийн үйлчилгээний хураамж ба шимтгэл | 49,460 | 66,590 |
| | **11,288,762** | **8,019,386** |
| **Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого** | **19,412,898** | **18,924,749** |

**5. Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого (Үргэлжлэл)**

| | Иргэдийн банк 2022 мян.төг | Бизнес банк 2022 мян.төг | Лизинг 2022 мян.төг | Нийт 2022 мян.төг |
|---|---|---|---|---|
| **Санхүүгийн үйлчилгээ үзүүлмэгц хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого** | | | | |
| Картын үйлчилгээний хураамж, шимтгэл | 18,373,247 | - | - | 18,373,247 |
| Мөнгөн гуйвуулга, худалдааны санхүүжилт болон бусад үйлчилгээний хураамж | 6,001,607 | 2,375,379 | 327,750 | 8,704,736 |
| Дансны үйлчилгээний хураамж, шимтгэл | 3,382,538 | - | - | 3,382,538 |
| Зээлийн үйлчилгээний хураамж, шимтгэл | 84,392 | 149,570 | - | 233,962 |
| | 27,841,784 | 2,524,949 | 327,750 | 30,694,483 |
| **Санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн хугацааны туршид хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого** | | | | |
| Мөнгөн гуйвуулга, худалдааны санхүүжилт болон бусад үйлчилгээний хураамж | 7,177 | - | - | 7,177 |
| | 7,177 | - | - | 7,177 |
| **Харилцагчтай байгуулсан гэрээний нийт орлого** | **27,848,961** | **2,524,949** | **327,750** | **30,701,660** |

| | Иргэдийн банк 2021 мян.төг | Бизнес банк 2021 мян.төг | Лизинг 2021 мян.төг | Нийт 2021 мян.төг |
|---|---|---|---|---|
| **Санхүүгийн үйлчилгээ үзүүлмэгц хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого** | | | | |
| Картын үйлчилгээний хураамж, шимтгэл | 16,261,259 | - | - | 16,261,259 |
| Мөнгөн гуйвуулга, худалдааны санхүүжилт болон бусад үйлчилгээний хураамж | 4,590,603 | 2,382,196 | 360,511 | 7,333,310 |
| Дансны үйлчилгээний хураамж, шимтгэл | 2,732,088 | - | - | 2,732,088 |
| Зээлийн үйлчилгээний хураамж, шимтгэл | 84,194 | 525,939 | - | 610,133 |
| | 23,668,144 | 2,908,135 | 360,511 | 26,936,790 |
| **Санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн хугацааны туршид хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого** | | | | |
| Мөнгөн гуйвуулга, худалдааны санхүүжилт болон бусад үйлчилгээний хураамж | 7,345 | - | - | 7,345 |
| | 7,345 | - | - | 7,345 |
| **Харилцагчтай байгуулсан гэрээний нийт орлого** | **23,675,489** | **2,908,135** | **360,511** | **26,944,135** |

## 6. Арилжааны цэвэр ашиг

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| Гадаад валютын арилжаа | 14,059,217 | 4,745,788 |
| МИК - Давуу эрхтэй ИЗББ-ын хүүгийн орлого (БҮЦАА) | 1,952,120 | 665,952 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | 1,091,553 | 816,488 |
| МИК - Давуу эрхтэй ИЗББ-ын бодит үнэ цэнийн өөрчлөлт (БҮЦАА) | 25,014 | (85,882) |
| Үнэт металл арилжаа | (144,193) | 52,170 |
| | **16,983,711** | **6,194,516** |

## 7. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого

**БҮЦАА-д заавал бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого (арилжаалах зорилгоор эзэмшиж байгаагаас бусад)**

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| МИК - Энгийн эрхтэй ИЗББ-ын хүүгийн орлого | 4,513,703 | 4,010,813 |
| ҮЦСК - Энгийн эрхтэй ХББ-ын хүүгийн орлого | 205,980 | 32,395 |
| ҮЦСК - Энгийн эрхтэй ХББ-ын бодит үнэ цэнийн өөрчлөлт | (181,539) | (22,678) |
| МИК - Энгийн эрхтэй ИЗББ-ын бодит үнэ цэнийн өөрчлөлт | (1,188,246) | (261,952) |
| Хувийн ХОС-д оруулсан хөрөнгө оруулалт данснаас хассаны алдагдал | - | (156,913) |
| | **3,349,898** | **3,601,665** |

## 8. Үйл ажиллагааны бусад цэвэр орлого/(зардал)

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| Свопын бодит үнэ цэнийн өөрчлөлт | 57,307,075 | (26,831,960) |
| Бусад үйл ажиллагааны орлого | 1,442,060 | 1,760,612 |
| Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын буцаалт (Тодруулга 17) | 1,126,650 | 3,026,616 |
| Түрээсийн орлого | 877,675 | 596,500 |
| БЗЭБХ борлуулсны олз (Тодруулга 18) | 316,337 | 155,981 |
| Өмчийн хэрэглүүд борлуулсны олз | 106,153 | - |
| Үндсэн хөрөнгө борлуулсны (гарз) /олз | (4,564) | 4,862 |
| Хураан авсан хөрөнгө борлуулсны гарз (Тодруулга 17) | (419,419) | (1,125,540) |
| Валютын ханшийн зөрүүний хэрэгжээгүй (гарз) /олз | (57,154,258) | 21,922,069 |
| БЗЭБХ-ийн цэнийн бууралтын буцаалт (Тодруулга 18) | - | 116,699 |
| | **3,597,709** | **(374,161)** |

## 9. Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| **ХБЗА-ын гарз /(буцаалт):** | | |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Тодруулга 16.3) | 5,812,749 | 2,045,628 |
| Гэрээний нөхцөл өөрчлөлтийн алдагдал, цэвэр (Тодруулга 31.2) | 2,576,223 | 1,755,888 |
| Бусад санхүүгийн хөрөнгө (Тодруулга 17) | 305,922 | (445,061) |
| Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж (Тодруулга 16.1) | 258,967 | (21,084) |
| Монголбанк дахь заавал байлгах нөөц (Тодруулга 13.2) | 226,318 | 177,778 |
| Санхүүгийн хэрэгслүүд (Тодруулга 16.2) | 107,202 | 1,193,410 |
| Болзошгүй өр төлбөр ба үүрэг хариуцлага (Тодруулга 24) | (134,024) | (135,359) |
| | **9,153,357** | **4,571,200** |

## 10. Үйл ажиллагааны зардал

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| Боловсон хүчний зардлууд* | 66,185,327 | 40,514,154 |
| Мэдээллийн технологи, сүлжээ болон харилцаа холбооны зардал | 9,224,662 | 6,989,996 |
| Үндсэн хөрөнгийн элэгдэл (Тодруулга 19) | 6,285,015 | 6,339,870 |
| Хадгаламжийн даатгалын зардал | 4,351,077 | 4,066,829 |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл (Тодруулга 19) | 3,809,293 | 3,711,714 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний зардал | 3,265,729 | 2,328,080 |
| Зар сурталчилгаа | 2,415,619 | 1,837,484 |
| Бусад үйл ажиллагааны зардал | 2,018,285 | 1,799,024 |
| Биет бус хөрөнгийн хорогдол (Тодруулга 20) | 1,952,099 | 2,910,587 |
| Хурал, уулзалт болон ажилчдын арга хэмжээ | 1,405,772 | 1,460,694 |
| Бичиг хэргийн зардал | 1,171,040 | 1,004,152 |
| Харуул хамгаалалтын зардал | 1,168,578 | 1,211,942 |
| Ашиглалтын зардал | 1,117,030 | 957,219 |
| Гишүүнчлэл ба аудитын зардал | 901,592 | 754,334 |
| Тээврийн зардал | 873,682 | 609,178 |
| Даатгалын зардал | 691,409 | 710,250 |
| Урсгал засварын зардал | 659,912 | 602,052 |
| Албан томилолтын зардал | 614,268 | 96,178 |
| Бага үнэ цэн бүхий хөрөнгийн түрээсийн зардал (богино хугацаат түрээсийн зардлыг оруулаагүй) (Тодруулга 19.3) | 511,836 | 890,732 |
| Зээл цуглуулалтын зардал | 279,412 | 474,835 |
| Байрны түрээс (Тодруулга 19.3) | 179,400 | 79,147 |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 20) | 114,070 | - |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз (Тодруулга 19) | 89,955 | 80,098 |
| Хандивын зардал | 38,433 | 60,692 |
| Торгууль | 11,464 | 112,912 |
| Үндсэн хөрөнгө үнэлгээний гарз (Тодруулга 19) | - | 868,801 |
| | **109,334,959** | **80,470,954** |
| *** Боловсон хүчний зардлууд** | | |
| Цалин, хөлс болон урамшуулал | 57,907,963 | 35,606,282 |
| Эрүүл мэнд нийгмийн даатгалын шимтгэл | 7,355,620 | 4,219,545 |
| Тэтгэврийн тогтоосон төлөвлөгөөний дагуу хийсэн хуримтлалын хорогдуулга | 587,791 | 541,495 |
| Ажилчдын сургалт | 333,953 | 146,832 |
| | **66,185,327** | **40,514,154** |

СЗХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05
БҮРТГЭВ-02

## 11. Орлогын албан татвар

### 11.1 Орлогын татварын зардал

2021 ба 2022 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон тайлант жилийн орлогын татварын зардлын бүрэлдэхүүнд:

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| **Тайлант жилийн татвар:** | | |
| Тайлант жилийн орлогын татвар | 42,232,735 | 27,806,995 |
| **Хойшлогдсон татвар:** | | |
| Түр зөрүүнээс үүссэн болон буцаасантай холбогдуулан (Тодруулга 11.2) | (1,382,046) | (601,698) |
| Орлогын татварын зардал | **40,850,689** | **27,205,297** |

Банк нь санхүүгийн тайлагналын орлогыг татварын зорилгоор хүлээн зөвшөөрөгдөхгүй ба хасагдахгүй зардлын дүнгээр тохируулан орлогын албан татварын зардлыг тооцдог. Банк нь 6 тэрбум (2021 онд 6 тэрбум) төгрөг хүртэлх албан татвар ногдуулах жилийн орлого олсон бол 10% (2021 онд 10%)-иар, 6 тэрбум (2021 онд 6 тэрбум) төгрөгөөс дээш давсан орлогын дүнгийн 25% (2021 онд 25%)-иар нэмж орлогын албан татвар ногдуулдаг. Засгийн Газрын бондын хүүгийн орлогод албан татвар ногдуулахгүй.

2021 ба 2022 оны 12-р сарын 31-нээр тасалбар болгосон тайлант жилийн татварын зардлыг санхүүгийн тайлангаарх цэвэр ашгаас Банкны үр ашигт татварын хувиар тооцсон тохируулга:

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| Татварын өмнөх ашиг | 146,689,275 | 102,468,172 |
| Татварын хувь хэмжээ болох 25%-иар тооцсон орлогын татварын зардал (2021 онд 25%) | 36,672,319 | 25,617,043 |
| Татварын бага хувь хэмжээний нөлөөлөл | (900,000) | (900,000) |
| Татвар ногдохгүй орлогын нөлөөлөл | (593,256) | (1,081,331) |
| Татвар ногдох орлогоос хасагдахгүй зардлын нөлөөлөл | 5,136,793 | 2,810,179 |
| Тусгай хувь хэмжээгээр татвар ногдох орлогын нөлөөлөл | 508,561 | 759,406 |
| Гадаад улсад суутгуулсан татвар* | 26,272 | - |
| Тайлант жилийн татварын зардал | **40,850,689** | **27,205,297** |

2022 онд үр ашигт орлогын татварын хувь хэмжээ 27.85% (2021 онд 26.55%) байсан.

*Микро Энержи Кредит компанийн хувьцааг борлуулсны орлогод ногдуулсан АНУ болон Монгол Улсын татварын хувь хэмжээний зөрүү.

**Орлогын албан татварын өглөг**

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| Орлогын албан татварын өглөг, 1-р сарын 1-нээр | 4,705,974 | 8,771,190 |
| Тайлант үеийн орлогын татварын зардал | 42,232,735 | 27,806,995 |
| Төлсөн татвар | (23,098,641) | (31,872,211) |
| Орлогын албан татварын өглөг, 12-р сарын 31-нээр | **23,840,068** | **4,705,974** |

### 11.2 Хойшлогдсон татварын хөрөнгө

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| Тайлант жилийн эхний үлдэгдэл | 4,135,441 | 3,534,627 |
| Ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн (Тодруулга 11.1) | 1,382,046 | 601,698 |
| Бусад дэлгэрэнгүй орлогын тайланд хүлээн зөвшөөрсөн | (284,743) | (884) |
| Тайлант жилийн эцсийн үлдэгдэл | **5,232,744** | **4,135,441** |

## 11. Орлогын албан татвар (Үргэлжлэл)

### 11.2 Хойшлогдсон татварын хөрөнгө (Үргэлжлэл)

**Түр зөрүүнд тооцсон хойшлогдсон татварын шинжилгээ**

| 2022 оны 12-р сарын 31-ний өдрөөр | 2022 оны 1-р сарын 1 мян.төг | Ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг | Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн мян.төг | 2022 оны 12-р сарын 31 мян.төг |
|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | (758,945) | (27,789) | - | (786,734) |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл | 44,982 | (26,250) | - | 18,732 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 2,015,077 | (316,859) | - | 1,698,218 |
| Бусад өр төлбөр | | | | |
| Хойшлуулсан урт хугацааны урамшууллын төлөвлөгөө | 216,933 | (201,323) | - | 15,610 |
| Ажиллагсадтай холбоотой хуримтлуулсан зардал | 3,151,737 | 1,703,057 | - | 4,854,794 |
| Хуримтлуулсан зардал | 259,507 | 145,918 | - | 405,425 |
| БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | (688,558) | - | (284,743) | (973,301) |
| Зээлээр авсан санхүүжилт | (105,292) | 105,292 | - | - |
| **Цэвэр хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)** | **4,135,441** | **1,382,046** | **(284,743)** | **5,232,744** |

| 2021 оны 12-р сарын 31-ний өдрөөр | 2021 оны 1-р сарын 1 мян.төг | Ашиг, алдагдлын тайланд хүлээн зөвшөөрсөн мян.төг | Бусад дэлгэрэнгүй орлогод хүлээн зөвшөөрсөн мян.төг | 2021 оны 12-р сарын 31 мян.төг |
|---|---|---|---|---|
| Үндсэн хөрөнгө | (749,272) | (9,673) | - | (758,945) |
| Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл | 32,177 | 12,805 | - | 44,982 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,511,097 | 503,980 | - | 2,015,077 |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд | 1,251,940 | (1,251,940) | - | - |
| Бусад өр төлбөр | | | | |
| Хойшлуулсан урт хугацааны урамшууллын төлөвлөгөө | 405,072 | (188,139) | - | 216,933 |
| Ажиллагсадтай холбоотой хуримтлуулсан зардал | 1,714,922 | 1,436,815 | - | 3,151,737 |
| Хуримтлуулсан зардал | 168,222 | 91,285 | - | 259,507 |
| БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | (687,674) | - | (884) | (688,558) |
| Зээлээр авсан санхүүжилт | (111,857) | 6,565 | - | (105,292) |
| **Цэвэр хойшлогдсон татварын хөрөнгө/(өр төлбөр)** | **3,534,627** | **601,698** | **(884)** | **4,135,441** |

## 12. Нэгж хувьцаанд ногдох ашиг

Доорх хүснэгтээр нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан ашгийн тооцоололд ашигласан орлого болон хувьцааны мэдээллийг үзүүлэв:

| | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| Банкны хувьцаа эзэмшигчдэд ногдох, нийт дэлгэрэнгүй орлого (татварын дараах) | 105,838,586 | 75,262,875 |
| Нэгж хувьцааны үндсэн болон хорогдуулсан ашгийн тооцоололд хэрэглэгдэх энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоо | 1,000,000,000 | 1,000,000,000 |

**Нэгж хувьцаанд ногдох ашиг**

| | 2022<br>төгрөг | 2021<br>төгрөг |
|---|---|---|
| Тайлант жилд банкны хувьцаа эзэмшигчдийн: | | |
| Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг | 105.84 | 75.26 |
| Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг | 105.84 | 75.26 |

Нэгж хувьцаанд ногдох ашгийг тухайн жилийн цэвэр ашгийг тухайн жилийн эргэлтэнд байгаа энгийн хувьцааны жигнэсэн дундаж тоонд хуваан тооцоолсон.

Тайлагналын өдрөөс эхлэн эдгээр санхүүгийн тайлангуудыг бэлтгэж дуусах хүртэл нэгж хувьцаанд ногдох ашгийг дахин тайлагнахыг шаардах энгийн хувьцаа болон боломжит энгийн хувьцаатай холбоотой ажил гүйлгээ гараагүй болно.

## 13. Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

### 13.1 Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах

| | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| Монголбанк дахь харилцах | 225,503,771 | 210,268,128 |
| Монголбанк дах овернайт хадгаламж | 105,063,288 | - |
| Бэлэн мөнгө | 37,049,491 | 36,620,853 |
| Замд яваа мөнгө | 63,725,100 | 1,424,400 |
| | **431,341,650** | **248,313,381** |

### 13.2 Монголбанк дахь заавал байлгах нөөц

| | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| Монголбанк дахь заавал байлгах нөөц | 256,086,933 | 214,409,082 |
| Хасах нь: Монголбанк дахь заавал байлгах нөөцийн үнэ цэнийн бууралт | (404,096) | (177,778) |
| | **255,682,837** | **214,231,304** |

| Үнэ цэнийн бууралтын хасагдуулга | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| Тайлант жилийн эхний үлдэгдэл | 177,778 | - |
| Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9) | 226,318 | 177,778 |
| Тайлант жилийн эцсийн үлдэгдэл | **404,096** | **177,778** |

Монголбанкнаас тавигддаг шаардлагын дагуу Монголбанкинд харилцах данс байршуулдаг. Монголбанкинд байршуулах бэлэн мөнгөний заавал байлгах үлдэгдэл нь хоёр долоо хоногийн туршид харилцагчдын харилцах, хадгаламжийн дундаж үлдэгдлийн төгрөгийн 8.0% ба гадаад валютын 18.0% (2021: 6% ба 18.0%)-иас тус тус багагүй байдаг. 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Банкны заавал байлгах шаардлагатай 14 хоногийн дундаж нөөцийн хэмжээ төгрөгөөр 132,857.84 сая төгрөг (2021: 108,666.43 сая төгрөг) ба гадаад валютаар 123,999.10 сая төгрөг (2021: 105,742.65 сая төгрөг) байсан.

## 13. Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө (Үргэлжлэл)

### 13.3 Бэлэн мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө

| | Тодруулга | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|---|
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 13.1 | 431,341,650 | 248,313,381 |
| Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 16.1 | 282,232,458 | 42,487,278 |
| Монголбанкны үнэт цаас | 16.2 | 577,171,150 | 907,686,267 |
| Хасах нь: Монголбанкнаас зээлээр авсан санхүүжилтэд барьцаалсан Монголбанкны үнэт цаас | | (12,279,000) | (26,133,000) |
| **Нийт мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө** | | **1,278,466,258** | **1,172,353,926** |

**Мөнгөн бус гүйлгээний нэмэлт мэдээлэл**

Тайлант жилд Банк нь 5%-иас 8%-ийн хүүтэй 48,475 сая төгрөг (2021 онд: 42,109 сая төгрөг)-ийн дансны үнэтэй ипотекийн зээлийг МИК-д худалдсанаар 43,627 сая төгрөг (2021 онд: 37,898 сая төгрөг)-ийн давуу эрхтэй транч болон 4,848 сая төгрөг (2021 онд: 4,211 сая төгрөг)-ийн энгийн транчаарх ипотекийн зээлээр баталгаажсан бонд ("ИЗББ")-ыг хүлээн авсан.

Тайлант жилд Банк нь 10.5%-ийн хүүтэй 14,049 сая төгрөг (2021 онд: 10,372 сая төгрөг)-ийн дансны үнэтэй репо санхүүжилтийн зээлийг ҮЦСК-д худалдаж, оронд нь 12,644 сая төгрөгийн (2021 онд: 9,335 сая төгрөг) давуу эрхтэй ХББ, 1,405 сая төгрөгийн (2021 онд: 1,037 сая төгрөг)-ийн энгийн ХББ хүлээн авсан.

## 14. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хэрэгслүүд

### 14.1 Санхүүгийн хөрөнгө

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| Өрийн хэрэгслүүд | | |
| МИК - Энгийн ИЗББ | 49,609,271 | 42,554,601 |
| МИК - Давуу эрхтэй ИЗББ | 29,528,142 | 32,707,952 |
| ҮЦСК –Энгийн ХББ (Тодруулга 16.3) | 4,759,752 | 1,026,400 |
| | **83,897,165** | **76,288,953** |
| БҮЦАА-д бүртгэх харилцагчдад олгосон зээл ба урьчилгаа | **102,764,818** | **90,000,608** |

## 14. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдалд бүртгэх санхүүгийн хэрэгслүүд (Үргэлжлэл)

### 14.2 Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд

Доорх хүснэгтэнд хөрөнгө болон өр төлбөрөөр бүртгэгдсэн санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийг нэрлэсэн үнийн хамтаар харууллаа. Нэрлэсэн үнэ нь санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн суурь болж буй хөрөнгө, жишиг ханш эсхүл индекс байх бөгөөд санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн үнэ цэнийн өөрчлөлтийг хэмжих суурь болно. Нэрлэсэн үнэ нь жилийн эцсийн байдлаарх гүйлгээний дүнг харуулах бөгөөд энэ нь зах зээлийн эрсдэл эсхүл зээлийн эрсдэлийг тодорхойлох үзүүлэлт болж чадахгүй юм.

| | Хөрөнгө 2022 мян.төг | Өр төлбөр 2022 мян.төг | Нэрлэсэн үнэ 2022 мян.төг |
|---|---|---|---|
| Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэгслүүд | | | |
| Хүүгийн түвшний своп хэлцэл | 107,798,730 | 1,639,595 | 760,947,158 |
| | **2021 мян.төг** | **2021 мян.төг** | **2021 мян.төг** |
| Арилжаалах зорилгоор эзэмшиж буй үүсмэл хэрэгслүүд | | | |
| Гадаад валютын своп хэлцэл | 67,308 | - | 8,546,400 |
| Хүүгийн түвшний своп хэлцэл | 49,155,802 | 371,050 | 708,205,507 |
| | **49,223,110** | **371,050** | **716,751,907** |

Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хувьд анхны хөрөнгө оруулалт бага байх буюу эсхүл огт шаардагдахгүй. Хэдий тийм боловч эдгээр санхүүгийн хэрэгслүүд нь ихэвчлэн хөшүүргийн зэргийг өндөрсгөх бөгөөд нилээн тогтворгүй байна. Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэлцлийн хөрөнгө, түвшин, индексийн үнэлгээний жижиг хэмжээний өөрчлөлт нь банкны ашиг, алдагдалд томоохон нөлөө үзүүлж болзошгүй.

Тодруулга 27-д санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн тодруулгыг харуулсан.

## 15. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хөрөнгүүд

| | Бодит үнэ цэн 2022 мян.төг | БҮЦБДО 2022 мян.төг | Бодит үнэ цэн 2021 мян.төг | БҮЦБДО 2021 мян.төг |
|---|---|---|---|---|
| Өмчийн хэрэгслүүд | | | | |
| Хөрөнгийн биржид бүртгэлгүй өмчийн хэрэгслүүд* | 415,108 | (100,491) | 455,988 | (122,241) |
| Хөрөнгийн биржид бүртгэлтэй өмчийн хэрэгслүүд** | 4,267,181 | 3,020,394 | 3,157,209 | 2,187,914 |
| | **4,682,289** | **2,919,903** | **3,613,197** | **2,065,673** |

* Хөрөнгийн биржид бүртгэлгүй өмчийн хэрэгслүүдэд хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй хувийн байгууллагуудад оруулсан хөрөнгө оруулалтууд багтана.
** Хөрөнгийн биржид бүртгэлтэй өмчийн хэрэгслүүд нь Монголын хөрөнгийн бирж дээр бүртгэлтэй МИК-ийн хувьцаа юм.

БҮЦБДО-р бүртгэх өмчийн хэрэгслүүдэд хөрөнгийн бирж дээр бүртгэлгүй байгууллагуудын хувьцаанд оруулсан хөрөнгө оруулалтууд багтана. Банк эдгээр компаниудад хяналтын бус хувь эзэмшдэг. Банк эдгээр хөрөнгө оруулалтуудыг стратегийн шинж чанартай гэж үзэж байгаа тул БҮЦБДО-р бүртгэдэг.

Тайлант жилд Банк ногдол ашиг аваагүй.

Тодруулга 27-д өмчийн хэрэгслүүдийн бодит үнэ цэнийн тодруулгыг харуулсан.

## 16. Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгүүд

### 16.1 Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж

| | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| Монголбанкинд байршуулсан | | |
| Хугацаатай хадгаламж | 138,063,548 | - |
| Гадаадын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан | | |
| Харилцах | 85,191,962 | 40,221,807 |
| Дотоодын банк, санхүүгийн байгууллагад байршуулсан | | |
| Харилцах | 9,068,957 | 2,245,739 |
| Хугацаатай хадгаламж | 50,379,296 | 232,070 |
| Хасах нь: Үнэ цэнийн бууралтын хасагдуулга | (471,305) | (212,338) |
| | **282,232,458** | **42,487,278** |

**Банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламжийн үнэ цэнийн бууралтын хасагдуулга**

| | | |
|---|---|---|
| Тайлант жилийн эхний үлдэгдэл | 212,338 | 233,422 |
| Тайлант жилийн байгуулсан /(буцаасан) (Тодруулга 9) | 258,967 | (21,084) |
| Тайлант жилийн эцсийн үлдэгдэл | 471,305 | 212,338 |

### 16.2 Өрийн хэрэгслүүд

| | 2022<br>мян.төг | 2021<br>мян.төг |
|---|---|---|
| Монголбанкны үнэт цаас (Тодруулга 13.3) | 577,171,150 | 907,686,267 |
| "Эрдэнэс Таван Толгой" ХК-ийн бонд | 12,279,452 | 12,279,452 |
| ҮЦСК - Давуу эрхтэй ХББ (Тодруулга 16.3) | 8,237,697 | 7,942,206 |
| Хасах нь: Үнэ цэнийн бууралтын хасагдуулга | (1,300,612) | (1,193,410) |
| | **596,387,687** | **926,714,515** |

**Өрийн хэрэгслүүдийн үнэ цэнийн бууралтын хасагдуулга**

| | | |
|---|---|---|
| Тайлант жилийн эхний үлдэгдэл | 1,193,410 | - |
| Тайлант жилийн байгуулсан (Тодруулга 9) | 107,202 | 1,193,410 |
| Тайлант жилийн эцсийн үлдэгдэл | **1,300,612** | **1,193,410** |

2022 оны 12 дугаар сарын 31-ний байдлаар, репо санхүүжилтийн зээлийн эх үүсвэрт барьцаалсан Монголбанкны үнэт цаас 12.28 тэрбум төгрөг (2021 онд 26.13 тэрбум төгрөг) байна.

### 16.3 Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

ХИЭТА нь Банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын салшгүй нэг хэсэг бөгөөд 2007 оны 3 дугаар сараас эхлэн үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Энэхүү аргачлалыг зах зээлийн хэвийн орчинд зах зээлийн эрсдэлийг хэмжихэд ашигладаг. Өөрөөр хэлбэл зах зээлийн хэвийн орчинд нөлөө үзүүлж буй эрсдэлийн хүчин зүйлүүдэд гарч буй аливаа өөрчлөлтүүд нь хэвийн тархалттай байна гэж авч үздэг. Банк гадаад валютын позицоос үүсэх нэг өдрийн болзошгүй алдагдлын хэмжээ болох ХИЭТА-ыг 99 хувийн итгэлцлийн түвшинд вариац/ковариацийн аргачлалыг ашиглаж тооцдог. Гадаад валютын позицид үүсч болох ХИЭТА алдагдлын хэмжээг 99 хувийн итгэлцлийн түвшинд тооцоолж гаргасныг дор үзүүлэв. Үүнд:

**Вариац / Ковариац**

| | 2022 мян.төг | 2021 мян.төг |
|---|---|---|
| 12-р сарын 31-ний өдөр | 99,866 | 7,982 |
| Өдрийн дундаж | 102,451 | 23,302 |
| Оны дээд хэмжээ | 435,839 | 165,647 |
| Оны доод хэмжээ | 12,332 | 5,746 |

## 31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

### 31.4 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

### Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэнд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

| Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр | Төгрөг мян.төг | Ам.доллар мян.төг | Евро мян.төг | Бусад мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **2022 оны 12 дугаар сарын 31** | | | | | |
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 129,319,629 | 228,288,657 | 8,614,864 | 65,118,500 | 431,341,650 |
| Монголбанк дахь заавал байлгах нөөц | 132,453,741 | 123,229,096 | - | - | 255,682,837 |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд* | - | 760,947,158 | - | - | 760,947,158 |
| Санхүүгийн хэрэгслүүд | 83,897,165 | - | - | - | 83,897,165 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 102,764,818 | - | - | - | 102,764,818 |
| БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө | | | | | |
| Өмчийн хэрэгслүүд | 4,682,289 | - | - | - | 4,682,289 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө | | | | | |
| Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 50,379,296 | 182,892,009 | 1,452,463 | 47,508,690 | 282,232,458 |
| Өрийн хэрэгслүүд | 596,387,687 | - | - | - | 596,387,687 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,885,604,954 | 14,186,924 | 260,749 | - | 1,900,052,627 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 14,156,415 | 1,706,719 | 32,705 | 133,745 | 16,029,584 |
| **Нийт санхүүгийн хөрөнгө** | **2,999,645,994** | **1,311,250,563** | **10,360,781** | **112,760,935** | **4,434,018,273** |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | | | |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд* | 654,788,023 | - | - | - | 654,788,023 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр | | | | | |
| Бусад банкны харилцах, хадгаламж | 1,005,841 | 50,622,074 | 40,215 | 198,850 | 51,866,980 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 1,826,065,115 | 514,477,524 | 10,144,412 | 87,932,518 | 2,438,619,569 |
| Зээлээр авсан эх үүсвэр | 139,389,759 | 717,973,468 | - | - | 857,363,227 |
| Түрээсийн өр төлбөр | 5,310,092 | - | - | - | 5,310,092 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 22,399,523 | 6,463,747 | 130,570 | 2,825,886 | 31,819,726 |
| **Нийт санхүүгийн өр төлбөр** | **2,648,958,353** | **1,289,536,813** | **10,315,197** | **90,957,254** | **4,039,767,617** |
| **Цэвэр санхүүгийн хөрөнгө/(өр төлбөр)** | **350,687,641** | **21,713,750** | **45,584** | **21,803,681** | **394,250,656** |

** Үүссэн валют тус бүрийн нийт дүнгээр илэрхийлсэн*

## 31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

### 31.4 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

### Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэнд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

| Санхүүгийн хөрөнгө, өр төлбөр | Төгрөг мян.төг | Ам.доллар мян.төг | Евро мян.төг | Бусад мян.төг | Нийт мян.төг |
|---|---|---|---|---|---|
| **2021 оны 12 дугаар сарын 31** | | | | | |
| **Санхүүгийн хөрөнгө** | | | | | |
| Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах | 24,357,667 | 204,624,383 | 14,795,076 | 4,536,255 | 248,313,381 |
| Монголбанк дахь заавал байлгах нөөц | 108,488,656 | 105,742,648 | - | - | 214,231,304 |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд* | 8,613,707 | 708,205,507 | - | - | 716,819,214 |
| Санхүүгийн хэрэгслүүд | 76,288,953 | - | - | - | 76,288,953 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 90,000,608 | - | - | - | 90,000,608 |
| БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө | | | | | |
| Өмчийн хэрэгслүүд | 3,613,197 | - | - | - | 3,613,197 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө | | | | | |
| Бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж | 232,540 | 24,551,750 | 507,033 | 17,195,955 | 42,487,278 |
| Өрийн хэрэгслүүд | 926,714,515 | - | - | - | 926,714,515 |
| Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа | 1,679,737,942 | 20,751,574 | 1,068,245 | - | 1,701,557,761 |
| Бусад санхүүгийн хөрөнгө | 5,269,402 | 1,398,069 | 10,832 | 13,947 | 6,692,250 |
| **Нийт санхүүгийн хөрөнгө** | **2,923,317,187** | **1,065,273,931** | **16,381,186** | **21,746,157** | **4,026,718,461** |
| **Санхүүгийн өр төлбөр** | | | | | |
| БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд | | | | | |
| Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд* | 659,420,754 | 8,546,400 | - | - | 667,967,154 |
| Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр | | | | | |
| Бусад банкны харилцах, хадгаламж | 740,978 | 1,910,779 | 26,236 | 13,413 | 2,691,406 |
| Харилцагчдын харилцах, хадгаламж | 1,814,662,647 | 399,263,760 | 16,368,669 | 21,804,655 | 2,252,099,731 |
| Зээлээр авсан эх үүсвэр | 151,060,255 | 617,715,482 | - | - | 768,775,737 |
| Өрийн үнэт цаас | - | 8,403,663 | - | - | 8,403,663 |
| Түрээсийн өр төлбөр | 5,422,527 | - | - | - | 5,422,527 |
| Бусад санхүүгийн өр төлбөр | 31,664,329 | 3,946,154 | - | 431,746 | 36,042,229 |
| **Нийт санхүүгийн өр төлбөр** | **2,662,971,490** | **1,039,786,238** | **16,394,905** | **22,249,814** | **3,741,402,447** |
| **Цэвэр санхүүгийн хөрөнгө/(өр төлбөр)** | **260,345,697** | **25,487,693** | **(13,719)** | **(503,657)** | **285,316,014** |

** Үүссэн валют тус бүрийн нийт дүнгээр илэрхийлсэн*

### Урьдчилан төлөлтийн эрсдэл

Урьдчилан төлөлтийн нөлөө гэдэг нь Банкны үйлчлүүлэгч болон харилцагч нь хүлээж байснаас өмнө төлбөрөө төлсөн болон төлөхийг хүссэнээс Банкны санхүүгийн үзүүлэлтэнд үзүүлэх нөлөөллийг хэлнэ.

Банк хүүгийн цэвэр орлогод үзүүлэх энэхүү урьдчилан төлөлтийн нөлөөллийг тооцохдоо хялбаршуулсан аргачлалыг хэрэглэдэг.

Үүнд хэрэв бусад бүх хувьсагчдыг тогтмол гэж үзэн эргэн төлөгдөх санхүүгийн хэрэгслүүдийн 20% нь жилийн эхэнд урьдчилан төлөгдсөн тохиолдолд жилийн эцсийн татварын өмнөх ашиг 9,189 сая (2021 онд: 34,497 сая) төгрөгөөр буурахаар байсан байна.

### 31.5 Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь дотоод процесс, хүний нөөц болон системийн үйл ажиллагаа хангалтгүй буюу доголдолтой, эсхүл гадны хүчин зүйлсийн улмаас (үүнд эрх зүйн эрсдэлийг оролцуулан) Банк хүлээж болзошгүй алдагдлыг хэлнэ. Банкны үйл ажиллагааны эрсдэл хариуцсан нэгж нь процесс хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг илрүүлэх, бууруулах чиглэлд хэрэгжүүлж буй хяналтууд нь үр дүнтэй байгаад хяналт тавих, тэдгээрийг заавар, зөвлөмжөөр ханган ажиллах чиг үүрэгтэй байдаг. Түүнчлэн Банк процесст хийгдэх эрсдэлийн үнэлгээ болон түүнд хэрэгжиж буй хяналтын мониторингоор дамжуулан үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилладаг.

## 32. Хөрөнгийн зохистой харьцаа

Банк бизнесийн салшгүй эрсдэлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үр ашигтай удирддаг. Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг. 2022 оны турш Банк нь өөрийн хөрөнгөд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

### Капиталын удирдлага

Банкны капиталын удирдлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба бизнесээ дэмжиж хувь нийлүүлэгчдийн үнэлэмжийг ихэсгэхийн тулд зээлийн эрсдэлийн түвшин болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааны эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтэцдээ залруулга хийдэг байна. Банк капиталынхаа бүтцээ хадгалах эсхүл тохируулахын тулд хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, хувь нийлүүлэгчид хөрөнгийг нь эргүүлэн төлөх, шинээр өөрийн хөрөнгийн хэрэгсэл гаргах, эсхүл өөрийн хөрөнгөд уялдсан үнэт цаас гаргах зэрэг арга замуудыг ашигладаг байна.

### Зохицуулалттай капитал

Монголбанкнаас арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хамгийн багадаа 9% (2021 онд: 9%), өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 12% (2021 онд: 12%)-иас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдэлийн уг шинж чанараар нь тохируулсан актив болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг дараах байдлаар үзүүлэв:

| | 2022 | 2021 |
|---|---|---|
| Өөрийн хөрөнгийн харьцаа | 20.03% | 17.11% |
| Эрсдэлээр жигнэсэн өөрийн хөрөнгийн харьцаа | 20.03% | 17.11% |
| <u>I зэрэглэлийн хөрөнгө</u> | | |
| Энгийн хувьцаа | 100,000,000 | 100,000,000 |
| Нэмж төлөгдсөн капитал | 1,817,773 | 1,817,773 |
| Бусад сан | 11,439,408 | 11,439,408 |
| Хуримтлагдсан ашиг | 278,161,784 | 197,574,658 |
| Нийт I зэрэглэлийн хөрөнгийн дүн | 391,418,965 | 310,831,839 |
| <u>II зэрэглэлийн хөрөнгө</u> | | |
| Бусад | - | - |
| Нийт II зэрэглэлийн хөрөнгийн дүн | - | - |
| **Нийт капитал/капиталын суурь** | **391,418,965** | **310,831,839** |

12-р сарын 31-ний байдлаар эрсдэлээр нь жигнэсэн активуудыг эрсдэлийн ангилал тус бүрээр нь үзүүлбэл:

| | 2022 | | 2021 | |
|---|---|---|---|---|
| % | Актив мян.төг | Эрсдэлээр жигнэсэн мян.төг | Актив мян.төг | Эрсдэлээр жигнэсэн мян.төг |
| 0 | 1,441,034,798 | - | 1,425,202,329 | - |
| 20 | 225,199,784 | 45,039,957 | 54,376,857 | 10,875,371 |
| 50 | 393,721,857 | 196,860,929 | 393,400,654 | 196,700,327 |
| 100 | 1,938,338,900 | 1,657,323,810 | 1,721,651,696 | 1,515,058,682 |
| 150 | 9,254,396 | 13,041,461 | 29,405,807 | 42,835,829 |
| *Тохируулга:* | | | | |
| Үйл ажиллагааны эрсдэлийн харьцаа | | 39,301,988 | | 44,493,353 |
| Гадаад валютын эрсдэлийн харьцаа | | 3,025,625 | | 6,906,415 |
| **Нийт** | **4,007,549,735** | **1,954,593,770** | **3,624,037,343** | **1,816,869,977** |

СЭХ
2023.05.12
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-05-05
БҮРТГЭВ-02

**33. Тайлагналын дараах үйл явдал**

Тайлагналын өдрөөс хойш Банкны үйл ажиллагаанд нөлөөлсөн болон нөлөөлж болох өөр ямар нэг үйл явдал, нөхцөл байдал үүсээгүй болно.

**34. Монгол хэл дээрх орчуулга**

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувилбарыг баримтална.

## ХАВСРАЛТ2: Ногдол ашгийн бодлого

ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөлийн
2023 оны 3 дугаар сарын 15-ны өдрийн
R-2023-19 дүгээр тогтоолын хавсралт

# ХасБанкны Ногдол Ашгийн Бодлого

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ

2023-05-05
БҮРТГЭВ-02

ГАРЧИГ

ХАСБАНКНЫ НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО .......... 3
НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА .......... 3
ХОЁРДУГААР ЗҮЙЛ. НЭР ТОМЬЁО .......... 3
ГУРАВДУГААР ЗҮЙЛ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ .......... 3
ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ .......... 4
ТАВДУГААР ЗҮЙЛ. НОГДОЛ АШГИЙГ ХУВААРИЛАХ, ТӨЛӨХ .......... 4
ЗУРГАДУГААР ЗҮЙЛ. ТАЙЛАГНАХ .......... 5
ДОЛДУГААР ЗҮЙЛ. ХАРИУЦЛАГА .......... 5

ХАСБАНК
УХН 2578697

СЭХ
2023 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2023-05-05
БҮРТГЭВ-02

# ХАСБАНКНЫ НОГДОЛ АШГИЙН БОДЛОГО

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. ЗОХИЦУУЛАХ ХАРИЛЦАА

1.1 Энэхүү бодлогоор ХасБанк /цаашид "Банк" гэх/-ны хувьцаа эзэмшигчдэд хуваарилах ногдол ашгийн хэмжээг тодорхойлох, ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргах, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдээлэх, ногдол ашгийг төлөх, тайлагнахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2 Энэхүү бодлогыг Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Зохицуулагч байгууллагын холбогдох журам, заавар болон Банкны дүрэмд нийцүүлэн боловсруулсан болно.

1.3 Энэхүү бодлогыг Банкны дүрэмд заасны дагуу Хувьцаа эзэмшигчдийн хурлаар баталснаар хүчин төгөлдөр болох бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн саналыг үндэслэн Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нэмэлт өөрчлөлт оруулж болно.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ. НЭР ТОМЬЁО

2.1. Энэхүү бодлогод хэрэглэсэн дараах нэр томьёог Банкны хэмжээнд дараах утгаар нэг мөр ойлгож, хэрэглэнэ:

2.3.1 **"Ногдол ашиг"** гэж холбогдох шийдвэрийн дагуу компанийн татварын дараах цэвэр ашгаас, нэг төрлийн хувьцаанд адил хэмжээгээр мөнгөн хөрөнгө болон бусад хэлбэрээр хуваарилах эд хөрөнгө;

2.3.2 **"Зохицуулагч байгууллага"** гэж хууль тогтоомжид заасан эрх хэмжээний хүрээнд Монголбанк, Санхүүгийн Зохицуулах Хороог;

2.3.3 **"Зарласан өдөр"** гэж төлөөлөн удирдах зөвлөл ногдол ашиг хуваарилах тухай шийдвэр гаргаж зарласан өдрийг тус тус ойлгоно.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ. НОГДОЛ АШИГ ХУВААРИЛАХАД БАРИМТЛАХ ЗАРЧИМ

3.1 Банк нь өөрийн хөрөнгө, хөрвөх чадвар, зохицуулагч байгууллагын нөхцөл шаардлага, ирээдүйн ашиг орлого болон бусад эх үүсвэр, Банкны үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагааг цаашид өргөжин тэлэх боломж, эдийн засгийн болон санхүүгийн ерөнхий чиг хандлага, хувьцаа эзэмшигчдэд ногдол ашиг хуваарилах шаардлага зэрэг болон бусад олон хүчин зүйлийг харгалзан ногдол ашиг олгох эсэхийг харгалзан жил бүр шийдвэр гаргана.

3.2 Компанийн тухай хуульд заасны дагуу Банкны дүрэмд өөрөөр заагаагүй бол ногдол ашиг хуваарилах эсэхийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийг дотор Банкны ТУЗ хэлэлцэж шийдвэрлэсэн байна. Ногдол ашиг хуваарилах эсэхийг зарлах, ногдол ашиг хуваарилах шийдвэрийг Хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.

3.3 Хувьцаа эзэмшигчид нь ТУЗ-ийн шийдвэрлэж, Хувьцаа эзэмшигчдийн баталснаар ногдол ашиг авах эрхтэй.

3.4 Банк нь дараах нөхцөлүүдийг хангасан тохиолдолд татварын дараах цэвэр ашгаас ногдол ашиг хуваарилах шийдвэр гаргаж болно.

3.4.1 Ногдол ашиг хуваарилсны дараа Банк нь төлбөрийн чадвартай байх;

3.4.2 Ногдол ашиг хуваарилсны дараа Банкны өөрийн хөрөнгийн хэмжээ нь банкны дүрэмд тусгасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, давуу эрхийн хувьцааны төлөгдөөгүй ногдол ашиг, түүний татан буулгалтын үнэ зэргийн нийлбэрээс их байх;

3.4.3 Банк нь үнэт цаасаа эргүүлэн худалдаж авах үүргээ биелүүлсэн байх;

3.4.4 Ногдол ашиг хуваарилсны дараа зохицуулагч байгууллагаас Банканд тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтүүд зөрчигдөхгүй байх;

3.4.5 Зохицуулагч байгууллагаас ногдол ашиг хуваарилах талаар урьдчилан зөвшөөрөл авсан байх;

3.4.6 Олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авсан зээлийн гэрээгээр хүлээсэн санхүүгийн үүргүүд (covenant) зөрчигдөхгүй байх.

3.5 Банк нь эргүүлэн худалдаж авсан хувьцаандаа ногдол ашиг хуваарилахгүй бөгөөд давуу эрхийн хувьцаанд ногдол ашиг хуваарилах асуудлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

3.6 Ногдол ашгийн төрөл, хуваарилах цаг хугацаа нь хувьцаа эзэмшигчдийн эрх ашигт нийцсэн байх бөгөөд холбогдох хууль, тогтоомж, болон зохицуулагч байгууллагын журмын шаардлагад нийцсэн байна.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. НОГДОЛ АШГИЙН ХЭМЖЭЭГ ТОДОРХОЙЛОХ

4.1 Банк нь тухайн санхүүгийн жилийн санхүүгийн үр дүн, болон банкны үйл ажиллагааны хэтийн төлөв, үйл ажиллагаа цаашид өргөжин тэлэх боломжид үндэслэн нэгж хувьцаанд хуваарилах ногдол ашгийн хэмжээг энэхүү бодлогын 3.2-т заасан эрх бүхий этгээд буюу хувьцаа эзэмшигчид эцэслэн шийдвэрлэнэ.

## ТАВДУГААР ЗҮЙЛ. НОГДОЛ АШГИЙГ ХУВААРИЛАХ, ТӨЛӨХ

5.1 МонголБанкнаас авсан зөвшөөрлийг үндэслэн Банк нь ногдол ашиг хуваарилахдаа Компанийн тухай хууль, Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангаж ажиллах бөгөөд зохицуулагч байгууллагаас авсан зөвшөөрлийг үндэслэн шийдвэр гаргана.

5.2 Банк нь бүртгэлийн өдрөөр тасалбар болгон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээдээс авсан Банкны хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад үндэслэн ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийг тодорхойлох бөгөөд энэ талаар хувьцаа эзэмшигчдэд мэдэгдэнэ.

5.3 Ногдол ашиг хуваарилах шийдвэрт дараах зүйлсийг тусгасан байна. Үүнд:

5.3.1 Нэгж хувьцаанд ногдох ногдол ашгийн хэмжээ;

5.3.2 Ногдол ашиг төлөх өдөр;

5.3.3 Ногдол ашиг олгох хэлбэр (бэлэн мөнгө, эд хөрөнгө, үнэт цаас);

5.3.4 Ногдол ашгийг тараах хэлбэр (Банк өөрөө, эсхүл эрх бүхий зуучлагч байгууллагаар дамжуулах)

5.3.5 Бүртгэлийн өдрөөр ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалт.

5.4 Ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн тухай мэдээллийг Банкны албан ёсны цахим хуудаст байршуулахаас гадна Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэсэн байдлаар хувьцаа эзэмшигчдэд хүргэх ба дараах мэдээллийг тусгана. Үүнд:

5.4.1 Тухайн төрлийн нэгж хувьцаанд ногдуулан хуваарилахаар шийдвэрлэсэн ногдол ашгийн хэмжээ;

5.4.2 Бүртгэлийн өдөр;

5.4.3 Ногдол ашгийн төлбөрийг олгох хэлбэр;

5.4.4 Ногдол ашгийг тарааж эхлэх огноо;

5.4.5 Банк ногдол ашгийн төлбөрийг хийж гүйцэтгэхдээ өөрөө эсхүл мэргэжлийн зуучлагч байгууллагаар дамжуулах аргын аль нь болох;;Хэрэв ногдол ашиг хуваарилалтыг мэргэжлийн зуучлагч байгууллагаар дамжуулах бол тухайн байгууллагын нэр, хаяг, ажиллах цагийн хуваарь, ногдол ашгийн талаар лавлагаа өгөх утасны дугаар зэргийг мэдээлнэ.

5.5 Компанийн тухай хуульд зааснаар хувьцаа эзэмшигчдийн хурал хойшлогдсон бол хойшлогдсон хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал болон хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийн өдрийг өөрчлөхгүй.

СЗХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 1

2023 -05- 05
БҮРТГЭВ-02

5.6 Ногдол ашиг төлөх өдөр хүртэлх хугацаанд хувьцааны тоо, эсхүл хувьцаа эзэмшилд өөрчлөлт орсон бол бүртгэлийн өдрөөр тасалбар болгон гаргасан хувьцаа эзэмшигчид ногдол ашгийг олгоно.

5.7 Ногдол ашиг хуваарилсны дараа үлдэх татварын дараах цэвэр ашгийг хуримтлагдсан ашиг дансанд үлдээж банкны ирээдүйн өсөлтийг хангахад шаардлагатай өөрийн хөрөнгийн хүрэлцээг бүрдүүлнэ.

5.8 Банк нь ногдол ашгийг төлөхдөө ХасБанкинд данстай хувьцаа эзэмшигчийн хувьд түүний цахим болон бичгээр гаргасан хүсэлтийн дагуу банкин дахь дансанд шилжүүлж, харин Банкинд дансгүй хувьцаа эзэмшигчийн хувьд Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдээр дамжуулан хувьцаа эзэмшигчийн нэр дээр бүртгэлтэй банкны дансанд тус тус шилжүүлэх байдлаар байршуулна.

5.9 Ногдол ашиг төлөх өдөр нь Монголбанкнаас зөвшөөрөл авснаас хойш 15 хоногоос хэтрэхгүй байна.

## ЗУРГАДУГААР ЗҮЙЛ. ТАЙЛАГНАХ

6.1. Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлнэ. Ногдол ашгийн бүртгэлийг санхүүгийн тайлангийн олон улсын стандарт (СТОУС) болон холбогдох бусад журмын дагуу бүртгэж санхүүгийн тайланд тусгана.

## ДОЛДУГААР ЗҮЙЛ. ХАРИУЦЛАГА

7.1 Банкны буруутай үйл ажиллагааны улмаас ногдол ашиг авах эрхтэй хувьцаа эзэмшигчдэд ногдол ашгийг хугацаанд нь төлөөгүй тохиолдолд банк нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн өдөрт 0.1 хувиар хугацаа хожимдуулсан хохирлыг төлөх үүрэгтэй боловч нийт хуримтлагдсан дүн нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50 хувиас хэтрэхгүй байна.

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

## ХАВСРАЛТ3: Хувьцаат компанийн (банкны) дүрмийн төсөл

СЗХ
2023 05. 12
БҮРТГЭВ

2023 -05- 05
БҮРТГЭВ-02



ХАСБАНК

НЭЭЛТТЭЙ ХУВЬЦААТ КОМПАНИЙН

ДҮРЭМ (ТӨСӨЛ)

Огноо:

ХАСБАНК

# ДҮРЭМ

## ГАРЧИГ

1. Нийтлэг үндэслэл

2. Банкны оноосон нэр болон хэлбэр

3. Эрхэм зорилго

4. Банкны тэмдэг

5. Банкны эрхлэх үйл ажиллагаа

6. Банкны хувьцаа эзэмшигчид

7. Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө болон Хувьцаа

8. Банкны удирдлага болон зохион байгуулалт

9. Дотоод аудит болон хяналт

10. Банкийг татан буулгах

11. Банкны үйл ажиллагаанд хориглох зүйлс болон Банкны ажилтанд тавигдах шаардлага

12. Даатгал, Байгаль орчин болон нийгмийн бодлого

13. Бусад

СЗХ
2023 05 12
БҮРТГЭВ



# ХАСБАНКНЫ ДҮРЭМ (ХК)

## НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү дүрэм нь ХасБанк ХК (цаашид "**Банк**" гэх)-ийн удирдлагын бүтэц, зохион байгуулалт, эрхлэх үйл ажиллагаа, эрх үүрэг, хариуцлагыг тогтоон, хяналтыг хэрэгжүүлэх, банкийг өөрчлөн байгуулах, татан буулгахтай холбогдсон харилцааг зохицуулна.

1.2. Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлөөр хувийн, үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хувьцаат компанийн хэлбэртэй, Банкны тухай хуульд заасны дагуу банкны үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөл бүхий арилжааны банк байна.

1.3. Банк нь үйл ажиллагаандаа Монгол Улсын Иргэний хууль, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль, Мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, банкны зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, болон Монгол Улсын Төв Банк ("**Монголбанк**"), Санхүүгийн зохицуулах хороо ("**СЗХ**") болон Монголын Хөрөнгийн Бирж ("**МХБ**")-ээс баталсан дүрэм, журам зэрэг Монгол улсын холбогдох хууль тогтоомж болон энэхүү Дүрмийг тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан байдлаар удирдлага болгон, тэдгээрт нийцүүлж ажиллана.

1.4. Банкны төв байр нь Монгол Улс, Улаанбаатар хотод байрлана.

1.5 Энэхүү Дүрэмд хэрэглэсэн том үсгээр эхлэн бичигдсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:

1.5.1 **"Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль"** гэж 2015 оны 6 дугаар сарын 19-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Нягтлан бодох бүртгэлийн тухай Монгол улсын хуулийг;

1.5.2 **"Эрх бүхий байгууллага"** гэж Монгол Улсын Засгийн газар, түүний төрийн, бүс нутгийн, болон орон нутгийн бүхий л салбар нэгж байгууллага, төр, түүний бүрэн эрхийг хэрэгжүүлэгч гүйцэтгэх, хууль тогтоох, шүүх эрх мэдлийн болон татварын, зохицуулалтын болон захиргааны эрх мэдэл, чиг үүргийг хэрэгжүүлэгч аливаа аливаа агентлаг, алба, нэгж, бие даасан зохицуулагч байгууллага, шүүх, төв банк, болон аливаа бусад этгээд, болон дээр дурдсан этгээд тус бүрийн хувьд тэдгээрийн албан тушаалтан, албан хаагч, болон төлөөлөгчийг;

1.5.3 **"Зөвшөөрөл"** гэж аливаа Эрх бүхий байгууллагаас олгосон тусгай зөвшөөрөл, зөвшөөрөл, бүртгэл, бүртгэлийн баримт бичиг, гэрчилгээ, аливаа бусад зөвшөөрөл эсхүл тэдгээрээс чөлөөлсөнийг гэрчлэх баримт, Банк, зээлдүүлэгч болон хувьцаа эзэмшигчдээс зөвшөөрсөн, эрх олгосон аливаа баримт бичгийг;

1.5.4 **“Холбогдох хууль тогтоомж”** гэж Монгол Улсын соёрхон баталсан буюу нэгдэн орсон олон улсын гэрээ, мөн Монгол Улсын хууль, түүнд нийцүүлэн гаргасан журам, дүрэм, УИХ-ын тогтоол, Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, сайдын тушаал, Эрх бүхий байгууллагаас баталсан журам, заавар, захиргааны хэм хэмжээний акт, Засаг даргын захирамж болон (улсын эсхүл орон нутгийн хэмжээнд) хүчин төгөлдөр мөрдөгдөж буй бусад хууль тогтоох, гүйцэтгэх болон шүүх байгууллагын шийдвэр, хэм хэмжээний актуудыг;

1.5.5 **“Банкны тухай хууль”** гэж 2010 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Банкны тухай хуулийг;

1.5.6 **“Дөрвөн том аудитын компани”** гэж олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн дөрвөн (4) том аудитын компанийг;

1.5.7 **“ТУЗ”** эсхүл **“Төлөөлөн удирдах зөвлөл”** гэж Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийг;

1.5.8 **“Гүйцэтгэх захирлын хөдөлмөрийн гэрээ”** гэж Гүйцэтгэх захирлын эрх, үүрэг, түүний үүрэг хариуцлагын цар хүрээ, хариуцлагаас чөлөөлөгдөх нөхцөл, цалин, урамшуулал болон бусад урамшууллын чанартай олговрын талаар харилцан тохиролцон Банкны Гүйцэтгэх захирал болон Банкны хооронд байгуулагдах гэрээг;

1.5.9 **“Компанийн тухай хууль”** гэж 2011 оны 10 дугаар сарын 06-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Компанийн тухай хуулийг;

1.5.10 **“Татан буулгах комисс”** гэж Холбогдох хууль тогтоомжийг чанд дагаж мөрдөн Банкийг татан буулгах ажиллагааг хэрэгжүүлэх үүрэг бүхий ТУЗ-өөс эсхүл шүүхээс томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс томилсон багийг;

1.5.11 “**Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль**” гэж 2021 оны 5 дугаар сарын 21-ны өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай Монгол улсын хуулийг;

1.5.12 **“Байгаль орчин, нийгмийн бодлого”** гэж ТУЗ-ын тогтоолоор 2018 оны 3-р сарын 28-ны өдрийн R-2018-12 дугаартай өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулан баталсан Банкны байгаль орчин, нийгмийн бодлого, түүнд Банкнаас тухай бүр өөрчлөлт оруулж, шинэчлэн найруулсан эрх зүйн актыг;

1.5.13 **“Толгой компани”** гэж энэхүү Дүрмийг баталсан өдрөөс эхлэн Толгой компанийг Банканд нэгтгэх хүртэл хугацаанд ХасБанкны нийт зарласан болон гаргасан хувьцааны [95]%-тай тэнцэх 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг хувьцааг эзэмшиж буй Монгол Улсын хуулийн

дагуу үүсгэн байгуулагдсан 2595788 тоот регистрийн дугаартай Тэнгэр санхүүгийн нэгдэл ХХК-ийг;

1.5.14 **"СТОУС"** гэж Санхүүгийн тайлагналын олон улсын стандартыг;

1.5.15 **"Дотоод аудитор"** гэж Банкны үйл ажиллагаанд тогтмол аудит хийх зорилгоор ТУЗ-өөс банкны дотоод аудитораар томилогдсон аудиторыг;

1.5.16 "**Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч**" гэж Банкны тухай хуульд тодорхойлсон Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийг;

1.5.17 **"Нэгтгэх ажиллагаа"** гэж Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг биелүүлэх зорилгоор Толгой компанийг Банканд нэгтгэх, үр дүнд нь нэгтгэж байгаа хуулийн этгээд болох Банк үйл ажиллагаагаа хэвээр үргэлжлүүлэн үлдэх, улмаар Толгой компанийн хувьцаа эзэмшигчид Банкны шууд хувьцаа эзэмшигчид болох ажиллагааг;

1.5.18 **"Бүртгэлийн өдөр"** гэж хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн жагсаалтыг гаргах зорилгоор ТУЗ-өөс тогтоосон огноог;

**1.5.19** **"Холбогдох этгээд"** гэж Банкны тухай хуульд заасан дараах утгатай байна, үүнд:

(i) банкны нэгдлийн оролцогч;

(ii) банк, банкны нэгдлийн оролцогчийн хувьцааны тав ба түүнээс дээш хувийг эзэмшдэг хувь хүн, хуулийн этгээд, түүний эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд;

(iii) хувьцааных нь тав болон түүнээс дээш хувийг банк эзэмшдэг хуулийн этгээд;

(iv) хувьцааных тав болон түүнээс дээш хувийг банкны эрх бүхий албан тушаалтан болон тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд эзэмшдэг хуулийн этгээд;

(v) банк, банкны нэгдлийн оролцогчийн эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эхнэр, нөхөр, эцэг, эх, ах, эгч, дүү, хүүхэд;

(vi) банкны эрхлэх үйл ажиллагаанд мэдэгдэхүйц нөлөө үзүүлдэг банктай нэгдмэл сонирхолтой этгээд;

(vii) эрх бүхий албан тушаалтных нь чиг үүргийг банкны эрх бүхий албан тушаалтан давхар гүйцэтгэдэг хуулийн этгээд;

(viii) банкны саналын эрхтэй хувьцааны арав болон түүнээс дээш хувийг эрх бүхий албан тушаалтан нь эзэмшдэг хуулийн этгээд;

(ix) энэ заалтад заасан этгээдтэй нэгдмэл сонирхолтой бусад хувь хүн, хуулийн этгээд;

(x) Монголбанкнаас холбогдох этгээд гэж үзсэн бусад этгээд.

1.5.20 **"Хариуцлага тооцохуйц үйл ажиллагаа"** гэж энэхүү Дүрэм батлагдах өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж буй Олон Улсын Санхүүгийн Корпорацийн Авлигын эсрэг гарын авлагад тус бүрт нь тодорхойлсон Авлига, хээл хахууль, Залилангийн, Албадлагын шинжтэй, Үгсэн тохиролцсон аливаа үйлдэл, үйл ажиллагааг;

1.5.21 **"Үнэт цаасны зах зээлийн тухай хууль"** гэж 2013 оны 5 дугаар сарын 24-ний өдөр батлагдаж, тухай бүр нэмэлт өөрчлөлт орсон Үнэт цаасны зах зээлийн тухай Монгол улсын хуулийг;

1.5.22 **"Хувьцаа"** гэж Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Банкнаас гаргаж, СЗХ болон МХБ-аас зөвшөөрөл олгож, тэдгээрт бүртгүүлсэн, хувьцаа эзэмшигч нарын Банкинд оруулсан хөрөнгө оруулалт болон тэдгээрийн ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцох, санал өгөх, Банкийг татан буулгасны дараа Банкны хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хүлээн авах болон Холбогдох хууль тогтоомжид заасан бусад эрхийг баталгаажуулсан энгийн хувьцааг;

1.5.23 **"Хувь нийлүүлсэн хөрөнгө"** гэж хувьцаа эзэмшигчдийн эзэмшиж буй эргэлтэд гаргасан нийт энгийн болон давуу эрхийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг ойлгох бөгөөд Банкны зарласан боловч гаргаагүй болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа уг хөрөнгөд орохгүй;

1.5.24 **"Ердийн олонх"** гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 50 хувь дээр нэмэх нь 1 тоон хэмжээг;

1.5.25 **"Дийлэнх олонх"** гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 66.67-оос дээш хувийг;

1.5.26 **"Үнэмлэхүй олонх"** гэж тухайн хэрэглэж буй агуулгаас хамааран санал, саналын эрх, хувьцаа эсхүл хувьцаа эзэмшигчдийн нийт тооны 75-аас дээш хувийг;

1.5.27 **"Эцсийн өмчлөгч"** гэж 2013 оны 5 дугаар сарын 31-ны өдөр батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай Монгол Улсын хуульд заасан утгаар ойлгоно.

1.6. Банк нь Холбогдох хууль тогтоомжийн дагуу ТУЗ-ийн шийдвэрээр салбар, тооцооны төв, мөнгөн хадгаламжийн болон валют арилжааны нэгж, төлөөлөгчийн газар байгуулж болно.

## ХОЁРДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ОНООСОН НЭР БОЛОН ХЭЛБЭР

2.1 Банкны оноосон нэр нь Монгол хэлээр "ХасБанк" ХК, Англи хэлээр "XacBank" JSC байна.

2.2 Банк нь хэлбэрийн хувьд нээлттэй хувьцаат компанийн хэлбэртэй байна. ("нээлттэй ХК").

2.3 Банк нь хуулийн этгээд болохын хувьд эрхээ хэрэгжүүлэх, үйл ажиллагаа явуулах, гэрээ, хэлцэл байгуулах зэрэг бүхий л тохиолдолд "нээлттэй ХК" гэсэн товчлолыг ашиглана.

2.4 Банкны албан ёсны бүртгэлтэй хаяг нь:
Монгол Улс, Улаанбаатар хот,
Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Ерөнхий сайд Амарын гудамж,
ХасБанкны төв байр.

2.5 Хувьцаа эзэмшигч өөрөөр зөвшөөрсөн эсхүл Холбогдох хууль тогтоомжоор шаардаагүй бол Банк нь (i) тухайн хувьцаа эзэмшигчийн нэрийг ашигласан эсхүл дурдсан сурталчилгааны материалыг олон нийтэд гаргахгүй, тараахгүй; эсхүл (ii) Хувьцааг олон нийтэд санал болгохтой холбоотойгоор тухайн хувьцаа эзэмшигч нь Банкны эсхүл түүнтэй холбоотой этгээдийн "томоохон хувьцаа эзэмшигч" буюу Банкны "үүсгэн байгуулагч" болохыг дурдсан Хувьцааны танилцуулга баримт бичиг гаргахгүй байх үүрэгтэй.

## ГУРАВДУГААР ЗҮЙЛ. ЭРХЭМ ЗОРИЛГО

3.1. Банкны эрхэм зорилго нь Монгол Улсын иргэд, аж ахуйн нэгж мөн орлого багатай болон алслагдсан хөдөө орон нутагт амьдарч байгаа санхүүгийн үйлчилгээ авах боломжоор хязгаарлагдмал иргэдэд санхүүгийн цогц үйлчилгээг хүргэж, Монгол Улсын нийгэм эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулах болон хувьцаа эзэмшигчдийн хөрөнгийн үнэ цэнийг нэмэгдүүлэхийн зэрэгцээ ашгийн өндөр түвшинтэй, санхүүгийн тогтвортой байгууллага бий болгоход оршино.

## ДӨРӨВДҮГЭЭР ЗҮЙЛ. БАНКНЫ ТЭМДЭГ

4.1 Банк нь өөрийн оноосон нэр, бэлгэдэл бүхий тэмдэгтэй байх бөгөөд албан хэрэгт оршин байгаа газрын хаяг бүхий хэвлэмэл хуудас хэрэглэнэ.

4.2 Тэмдгийг банкнаас гаргаж буй албан ёсны шийдвэр, гэрээ хэлцэл болон дотоодод явуулах албан бичиг, бусад шаардлагатай гэж үзсэн баримт бичгүүдийг баталгаажуулахад хэрэглэнэ.

4.3 Тэмдгийг итгэмжлэгдсэн ажилтан хариуцан, хамгаалагдсан найдвартай газарт хадгална.

## ТАВДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ЭРХЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГАА

5.1 Банк нь Монголбанк болон СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр Банкны тухай хуулиар зөвшөөрсөн дараах банк, санхүүгийн үйл ажиллагааг эрхэлнэ. Үүнд:

5.1.1 мөнгөн хадгаламж;
5.1.2 зээл;

СЗХ
2023 оны 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 1



5.1.3 төлбөр тооцоо;
5.1.4 өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
5.1.5 гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
5.1.6 үнэт металл, эрдэнийн чулуу худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах;
5.1.7 үнэт зүйлс хадгалах;
5.1.8 гадаад төлбөр тооцоо хийх;
5.1.9 үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
5.1.10 санхүүгийн түрээсийн үйлчилгээ үзүүлэх;
5.1.11 хөрөнгө оруулалт, санхүү, банк, зээл, экспорт-импортын санхүүжилтийн асуудлаар зөвлөмж, мэдээлэл өгөх;
5.1.12 даатгалын зуучлагч; болон
5.1.13 Монголбанкнаас зөвшөөрсөн, Холбогдох хууль тогтоомжоор хориглоогүй бусад үйл ажиллагаа.

5.2 Банк нь үүсгэн байгуулагдахад эхний зөвшөөрлөөр аваагүй зарим төрлийн үйл ажиллагааг эрхлэхдээ Монголбанк, СЗХ-нд хүсэлт гарган нэмэлт зөвшөөрөл, тусгай зөвшөөрөл авна.

5.3 Банк нь Холбогдох хууль тогтоомжид заасан эрх эдэлж, үүрэг хүлээнэ.

5.4 Банканд дараах үйл ажиллагаа эрхлэхийг хориглоно:

5.4.1 Тухай бүр нэмэлт, өөрчлөлт оруулан засварласан https://www.un.org/sc/suborg/en/sanctions/un-sc-consolidated-list НҮБ-ын албан ёсны цахим хуудсанд болон бусад байдлаар НҮБ-ын дүрмийн VII бүлгийн 41 дүгээр зүйлийн дагуу НҮБ-ын Аюулгүйн Зөвлөлөөс гаргасан зэвсгийн хориг, эдийн засаг, санхүү, худалдааны хориг арга хэмжээнд орсон аливаа хувь хүн, хуулийн этгээдтэй, эсхүл тэдгээрийн тусын тулд, эсхүл тийнхүү хориг арга хэмжээнд хамаарах аливаа бараа, ажил, үйлчилгээтэй холбоотой, аливаа гэрээ, хэлцэл, гүйлгээ хийх;
5.4.2 Хариуцлага тооцохуйц ажиллагаа явуулах;
5.4.3 Албадлагын шинжтэй үйлдэл хийх буюу гэрээний нэг тал, нөгөө талын үйлдэлд зүй бусаар нөлөөлөх зорилгоор нөгөө тал, түүний эд хөрөнгөд шууд болон шууд бусаар хохирол учруулсан, гэмтээсэн, гэмтээхээр заналхийлсэн үйлдэл хийх;
5.4.4 Үгсэн тохиролцсон үйлдэл хийх буюу аливаа бусад этгээдийн үйл ажиллагаанд зүй бусаар нөлөөлөх зэрэг зүй бус зорилгод хүрэхээр хоёр буюу түүнээс талуудын хоорондын харилцан тохиролцоо хийх;
5.4.5 Авлигын үйл ажиллагаа, үйлдэл хийх явуулах буюу аливаа гуравдагч этгээдийн үйлдэлд зүй бусаар нөлөөлөхийн тулд үнэ бүхий зүйлийг шууд болон шууд бусаар санал болгох, өгөх, хүлээн авах үйлдэл хийх;

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01



5.4.6 Залилангийн үйлдэл хийх буюу эд хөрөнгийн болон эдийн ашиг сонирхлоор, эсхүл хүлээсэн үүргээсээ зайлсхийх зорилгоор санаатай болон болгоомжгүй байдлаар төөрөгдүүлэх, төөрөгдүүлэхийг завдах, төөрөгдүүлсэн мэдээлэл өгөх аливаа үйлдэл, эс үйлдэхүйг үйлдэх;

5.4.7 Банкны эд хөрөнгө болон нөөцийг шамшигдуулах зүй бусаар ашиглах буюу санаатай болон болгоомжгүйгээр Банкны эд хөрөнгө болон аливаа нөөцийг зүй бусаар ашигласан үйлдэл хийх.

5.4.8 Саад учруулсан үйлдэл хийх, үүнд:

5.4.8.1 Банканд хийх хяналт шалгалтад хамаарах аливаа нотлох баримт бичгийг устгасан, хуурамчаар үйлдсэн, өөрчилсөн, нуун дарагдуулсан үйлдэл хийн Банкны хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулах;

5.4.8.2 Хориглосон үйл ажиллагааны хүрээнд Банканд хийгдэх хяналт шалгалтын үйл ажиллагаанд саад учруулах зорилгоор хянан шалгагч нарт хуурамч мэдээлэл өгөх;

5.4.8.3 Банканд хийх хяналт шалгалттай холбоотой аливаа мэдээлэл, баримт бичиг, бүртгэл гаргуулан авах хүсэлтийг биелүүлэхгүй байх;

5.4.8.4 Банканд хийх хяналт шалгалт болон тийнхүү хяналт шалгалтыг явуулахтай холбоотой аливаа мэдээллийг задруулахгүй байх зорилгоор аливаа этгээдийг заналхийлэх, дарамтлах, айлган сүрдүүлэх; эсхүл

5.4.8.5 аудит, шалгалт хийх, мэдээлэл олж авах Гэрээгээр тогтоосон эрхээ хэрэгжүүлэхэд илтэд саад учруулах; болон

5.4.8.6 хулгай хийх буюу бусдын өмчлөлийн хөрөнгийг хууль бусаар олж авах зэрэг хамаарна.

## ЗУРГААДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

6.1 Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд Банкны хувьцааг худалдан авах буюу эзэмших замаар хөрөнгө оруулсан Монгол Улсын болон гадаадын иргэн, хуулийн этгээд, харьяалалгүй хүн банкны хувьцаа эзэмшигч байна. Банкны аль ч хувьцаа эзэмшигч нь Нэгтгэх ажиллагаа дуусгавар болсноос хойш хэдийд ч шууд болон шууд бусаар, дангаар болон өөрийн холбогдох этгээдийн хамт Банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас дээш хэмжээний хувьцааг эзэмшихгүй.

6.2 Холбогдох хууль тогтоомж болон энэхүү Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд Хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулах, эсхүл хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдуулахгүйгээр эчнээ санал хураалтаар саналын хуудсаар санал авах тухай ТУЗ-ийн шийдвэрт заасан Бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн жагсаалтад бүртгэгдсэн хувьцаа эзэмшигч нь саналын эрх бүхий энгийн хувьцаа эзэмшигчийн санал өгөх эрхтэй бүхий л асуудлаар эзэмшиж буй хувьцаа бүртээ нэг саналын эрх эдэлнэ.

СЗХ
он2023 сар05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01



6.3 Банкны нийт гаргасан хувьцааны 10-аас дээш хувийг эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч нь ямар ч үед тодорхой үндэслэл бүхий хүсэлт гаргах замаар Банкны санхүүгийн үйл ажиллагаанд зөвхөн Дөрвөн том аудитын компанийн аль нэгээр ээлжит бус аудит хийлгүүлэхийг шаардах эрхтэй. Хүсэлт гаргасан тухайн хувьцаа эзэмшигч нь тийнхүү түүний хүсэлтийн дагуу шалгалтыг хийсэн аудиторын зардлыг бүрэн хариуцна.

6.4 Банкны гаргасан нийт хувьцааны 5 болон түүнээс дээш хувийг эзэмшиж буй хувьцаа эзэмшигч, түүний дотор Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчид нь нэмэлтээр хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэх асуудал болон ТУЗ болон тооллогын комиссын гишүүнд нэр дэвшүүлэх хүний талаарх саналаа өмнөх санхүүгийн жил дууссанаас хойш 60 хоногийн дотор хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулахаар Банкны ТУЗ эсхүл Гүйцэтгэх захиралд гаргах эрхтэй. Хувьцаа эзэмшигчийн гаргасан санал нь Компанийн тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.3 дахь хэсэгт заасан шаардлагыг хангасан байна.

6.5 Банк нь ногдол ашиг хуваарилсны дараа Холбогдох хууль тогтоомж, Монголбанк, СЗХ-ноос болон олон улсад тогтсон жишгийн дагуу тавигддаг шаардлагыг хангаж байх тохиолдолд ТУЗ-өөс тогтоож, Хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсны үндсэн дээр хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах эрхтэй болно.

6.6 Хувьцаа эзэмшигчид нь Компанийн тухай хуулийн 28 дугаар зүйлд заасны дагуу Банкийг татан буугдсаны дараа өөрийн эзэмшиж буй Хувьцааны тоотой хувь тэнцүүлэн Банкны үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогыг хүлээн авах эрхтэй.

6.7 Хувьцаа эзэмшигч нь Банкны зүгээс хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу хөтлөхөд нь шаардлагатай гэж үзэж хүссэн аливаа мэдээлэл, баримт бичгийг Банканд гаргаж өгнө.

6.8 Дүрмийн 6.7-д заасанаас гадна хувьцаа эзэмшигчид нь Банкны хувьцаа эзэмшигчдийн бүртгэлийг хөтлөх үүрэг бүхий этгээд болон холбогдох брокерууд, үнэт цаасны хадгаламжийн төвд өөрийн нэр болон оршин суугаа хаягийн мэдээллийн өөрчлөлтийг тухай бүр мэдэгдэх үүрэгтэй.

6.9 Хувьцаа эзэмшигчид нь Банкны аливаа үүрэг, хариуцлагыг хариуцан хүлээхгүй бөгөөд Банканд Хувьцаа хэлбэрээр оруулсан хөрөнгө оруулалтынхаа хэмжээгээр алдагдлын эрсдэлийг хүлээнэ.

**Банкийг Нэгтгэх**

6.10 Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг тогтоосон хугацаанд нь бүрэн хангаж биелүүлэх үүднээс Банк нь Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасны дагуу Хувьцаагаа олон нийтэд санал болгосны дараа (“**Хувьцаагаа олон нийтэд санал болгох**”) нэн даруй Толгой компанийг нэгтгэх ажиллагааг эхлүүлнэ. Нэгтгэх ажиллагаа дууссаны дараа Банк нь үйл ажиллагаагаа хэвээр үргэлжлүүлэн явуулах

бөгөөд Толгой компанийн хувьцаа эзэмшигчид нь Банкны шууд хувьцаа эзэмшигчид болно.

6.11 Хувьцааг олон нийтэд санал болгосны дараа Нэгтгэх ажиллагааг хамгийн боломжит богино хугацааны дотор буюу Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд заасны дагуу 2023 оны 12-р сарын 31-ны өдрөөс өмнө хэрэгжүүлж дууссан байна. Төрийн аливаа эрх бүхий байгууллагаас эсхүл хуулийн дагуу дээрх эцсийн хугацааг сунгасан, түр зогсоосон, хойшлуулсан, эсхүл цуцалсан эсэхээс үл хамааран Банк нь Нэгтгэх үйл ажиллагааг 2023 оны 12-р сарын 31-ны өдрөөс өмнө эсхүл хамгийн ойр боломжит хугацаанд гүйцэтгэх зорилготой хэвээр байна.

6.12 Дүрмийн 6.10 – 6.12-д заасныг хэрэгжүүлэх зорилгоор Хувьцаа эзэмшигч, ТУЗ болон Гүйцэтгэх захирал тус бүр нь Нэгтгэх ажиллагаатай холбогдуулан шаардагдах бүхий үйл ажиллагаа, баримт бичиг, болон бусад шаардлагатай зүйлсийг хийж гүйцэтгэх, үйлдэж, гарын үсэг зурж, хүргүүлэх, дээрх үйлдлүүдийг гүйцэтгэхийг Банканд даалгах үүрэгтэй.

**Хувьцаа эзэмшигчдийн тэргүүн ээлжид худалдан авах эрх**

6.13 Хувьцаа эзэмшигч бүр Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлд заасны дагуу Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасны үндсэн дээр Банкны нэмж гаргасан хувьцаа эсхүл хувьцаанд хөрвөх үнэт цаасыг тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй байна.

6.14 Хувьцааг шилжүүлэх тохиолдолд тийнхүү Хувьцааг шилжүүлэх санал гаргах үед хүчин төгөлдөр үйлчилж буй Банкны тухай хууль, болон Монголбанкнаас баталсан дүрэм, журмыг хэлбэрэлтгүй дагаж мөрдөх бөгөөд Компанийн тухай хуулийн 53 болон 54 дүгээр зүйлд заасны дагуу Банкны жижиг хувьцаа эзэмшигчид хувьцаагаа эргүүлэн худалдаж авахыг шаардах эрхтэй хэвээр байна.

6.15 Банк нь хувьцаа эзэмшигч нарт нэмж хувьцаа, үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэдэг журмаар мэдэгдэх бөгөөд уг мэдэгдэлд нэмж гаргах хувьцааны тоо, үнэ, хувьцаа эзэмшигч бүрийн худалдан авч болох хувьцааны тоо, нэмж гаргах хувьцааг худалдан авах нөхцөл, журам зэргийг заасан байна.

6.16 Аливаа холбогдох Зөвшөөрөл, үүний дотор Монголбанк, СЗХ болон МХБ-ийн бүртгэл хийх шийдвэр, зөвшөөрлийг авсны үндсэн дээр Банкны санал болгон шинээр гаргаж буй Хувьцаа, үнэт цаасыг худалдан авах хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь Банкны тухай хуульд заасан хувьцаа эзэмших дээд хязгаарт нийцүүлэн өөрийн эзэмшиж буй Хувьцаанд хувь тэнцүүлэн худалдан авах хүсэлтэй байгаа Хувьцаа болон бусад үнэт цаасны тоог тийнхүү шинээр нэмж Хувьцаа, үнэт цаас гаргах тухай хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарснаас хойш ажлын гучин (30) өдрийн дотор Банканд мэдэгдэнэ. Хэрэв 6.16-д заасны дагуу хувьцаа эзэмшигчид нь Банкнаас санал болгон шинээр гаргаж буй нийт Хувьцаа, үнэт цаасны тоо

хэмжээнээс бага хэмжээний худалдан авах захиалга хийсэн тохиолдолд 6.16-д заасны дагуу Хувьцаа худалдан авахаар захиалсан хувьцаа эзэмшигчдэд тэдний захиалсан Хувьцаа, үнэт цаасны тоогоор худалдан авахыг зөвшөөрөх бөгөөд захиалагдаагүй үлдсэн Хувьцааг Банк нь нээлттэй хөрөнгийн зах зээл дээр шинэ хөрөнгө оруулагчид худалдах эрхтэй. Банкнаас санал болгон шинээр нэмж гаргаж буй Хувьцаа болон бусад үнэт цаасны тооноос давсан хэмжээгээр захиалга ирсэн тохиолдолд санал болгосон нэмэлт Хувьцаа, үнэт цаасыг захиалсан хувьцаа эзэмшигч нарын дунд хувь тэнцүүлэн хуваарилах бөгөөд энэ зүйлд заасан "хувь тэнцүүлэх" гэдгийг Банкны санал болгон шинээр нэмж гаргаж буй Хувьцаа, үнэт цаасыг авах хүсэлтэй тухайн хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй Хувьцааны тоог тийнхүү Хувьцааг шинээр нэмж гаргахаас өмнө эзэмшиж байсан тухайн санал болгосон Хувьцаа, үнэт цаасыг авах хүсэлтэй нийт хувьцаа эзэмшигчдийн Хувьцааны нийт тоонд хувааж тооцсоныг ойлгоно.

### Банкны нөлөө бүхий хувьцаа эзэмшигч

6.17 Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох гэж буй аливаа хувьцаа эзэмшигч нь Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Банканд мэдэгдэж, холбогдох мэдээлэл, баримт бичгийг гаргаж өгөх үүрэгтэй бөгөөд ингэснээр Банк Монголбанкнаас Нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болох урьдчилсан зөвшөөрлийг авах ажилд туслалцаа үзүүлэх боломжтой болно.

6.18 Хэрэв Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчийн эзэмшиж буй Хувьцааны тоо, хэмжээнд аливаа өөрчлөлт орвол, тухайн хувьцаа эзэмшигч нь Холбогдох хууль тогтоомжоор шаардсан холбоотой бүхий л мэдээлэл, баримт бичгийг Банкны тухай хууль болон холбогдох журмын дагуу Монголбанкнаас зөвшөөрөл авах зорилгоор Банканд гаргаж өгөх үүрэгтэй.

6.19 Энэхүү Дүрмийн 6.17 болон 6.18-д заасан Нөлөө бүхий хувьцаа эзэмшигчтэй холбоотой аливаа шийдвэр, хэлцэл нь гагцхүү Монголбанкнаас зөвшөөрөл авснаар хүчин төгөлдөр болно. Банкны тухай хуулийн дагуу энэхүү Дүрмийн 6.17 болон 6.18-д заасныг зөрчин олж авсан Хувьцаа нь саналын эрх болон ногдол ашиг хүртэх аливаа эрхгүй байна.

## ДОЛДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ ХУВЬ НИЙЛҮҮЛСЭН ХӨРӨНГӨ БОЛОН ХУВЬЦАА

7.1 Банкны нийт зарласан хувьцаа нь [***] энгийн хувьцаанаас бүрдэнэ.

7.2 [Дүрэм батлагдсан өдрийн байдлаар Банк нь [***] төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий нийт [***] ширхэг хувьцаа гаргасан].

7.3 Хувьцаа бүр хувьцаа эзэмшигчдийн Банканд оруулсан хөрөнгө оруулалтыг илэрхийлэх бөгөөд Холбогдох хууль тогтоомжийн дагуу санал өгөх, ногдол ашиг авах, Банкийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас орсон орлогоос хүртэх эрхийг гэрчилнэ.

7.4 Хувьцааны тоо нь Хувьцаа эзэмшигчийн санал өгөх, ногдол ашиг хүртэх, алдагдлын хариуцлагыг хүлээх хэмжээг тодорхойлно.

**Банк хувьцаа, үнэт цаас нэмж гаргах, хувьцааг эргүүлэн худалдаж авах**

7.5 Банк нь Холбогдох хууль тогтоомжийн дагуу авбал зохих зохих Зөвшөөрөл, журмын дагуу тухай бүр нээлттэй болон хаалттай захиалгын үндсэн дээр нэмэлт Хувьцаа болон Банкны хувьцаанд хөрвөх үнэт цаас, түүний дотор үндэслэн давуу эрхийн хувьцаа, опцион, вексель зэргийг гаргаж болно.

7.6 Банкнаас Хувьцаа нэмж гаргах, хувьцаа худалдан авах опцион, хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах тухай шийдвэр, түүний нөхцөлийг Банкны хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ.

7.7 Энэхүү Дүрмийн 7.6-д заасны дагуу нэмж гаргах Хувьцаа болон бусад үнэт цаас, хувьцаанд хөрвөх үнэт цаасны нийт тоо хэмжээ, нэрлэсэн үнэ, хүү, хүү төлөх хугацаа, үнэ, эргүүлэн худалдаж авах үнийг ТУЗ тодорхойлж, хувьцаа эзэмшигчдийн хурлаар эцэслэн шийдвэрлэнэ.

7.8 ТУЗ нь үнэт цаас болон Хувьцааны нэрлэсэн үнийг Компанийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжийн дагуу тогтооно.

7.9 Банкны шинээр болон нэмж гаргасан үнэт цаас, болон Хувьцааны төлбөрийг зөвхөн бэлэн мөнгөөр хийнэ.

7.10 Компанийн тухай хуулийн 49 дүгээр зүйлийн 49.10 дахь хэсэгт заасны дагуу Банк нь Монголбанк, МХБ, СЗХ-ноос зөвшөөрөл авсны үндсэн дээр Банкны нийт гаргасан Хувьцааны 5-аас дээш хувийн хувьцаа болон бусад үнэт цаасыг эзэмшигчээс нь эргүүлэн худалдаж авах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ.

7.11 Банк хувьцаанаас бусад үнэт цаасыг бүхэлд нь болон хэсэгчлэн эргүүлэн худалдан авч болно. Хувьцааг эргүүлэн худалдан авч буй тохиолдолд эргүүлэн худалдан авч буй хувьцааны тоо нь тухайн жилд гүйлгээнд байсан нийт хувьцааны дунджийн 25 хувиас хэтэрч болохгүй.

7.12 Банкны эргүүлэн худалдан авсан Хувьцаа нь саналын эрхгүй, Банкны зарласан хувьцааны тоонд нөлөөлөхгүй бөгөөд энэ нь Банкны хувь нийлүүлсэн хөрөнгөд хамаарахгүй халаасны хувьцаанд тооцогдоно. Холбогдох хууль тогтоомжид заасны дагуу Банк нь халаасны хувьцааг дахин гаргаж болно.

7.13 Банк эргүүлэн худалдан авсан Хувьцааны төлбөрийг бэлэн мөнгө, үнэт цаас, худалдагчийн зөвшөөрсөн эд хөрөнгө болон эд хөрөнгийн эрхээр хийж болно.

7.14 Банк нь Нэмж Хувьцаа болон үнэт цаас гаргах, Банкны Хувьцааг эргүүлэн худалдан авах зэрэг, зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Банкны Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд аливаа өөрчлөлт оруулах тохиолдолд Банкны тухай хуулийн дагуу Монголбанкнаас тухай бүр урьдчилан зөвшөөрөл авч, СЗХ, МХБ-д бүртгүүлнэ.

## НАЙМДУГААР ЗҮЙЛ. БАНКНЫ УДИРДЛАГА БОЛОН ЗОХИОН БАЙГУУЛАЛТ

### Хувьцаа эзэмшигчдийн хурал

8.1 Банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна. Хувьцаа эзэмшигчдийн хурал нь Бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн, Банкны нийт гаргасан хувьцааны Ердийн олонх буюу түүнээс дээш хэмжээний Хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон тохиолдолд хүчин төгөлдөр болно. Өмнөх өгүүлбэрт заасан ирц бүрдээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдахгүй бөгөөд дахин хуралдах өдрийг Компанийн тухай хуулийн хувьцаа эзэмшигчдийн хурлыг хойшлуулахтай холбоотой заалтын дагуу зарлан хуралдуулах ба тухайн хойшлуулсан хурал нь Бүртгэлийн өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүртгэлд бүртгэгдсэн, Банкны нийт гаргасан хувьцааны Ердийн олонх Хувьцааг эзэмшиж буй хувьцаа эзэмшигчид оролцсоноор хүчин төгөлдөр болно.

8.2 Хувьцаа эзэмшигчдийн хурал ээлжит болон ээлжит бус байна.

8.3 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг санхүүгийн жил дууссанаас хойш 4 сарын дотор буюу жил бүрийн 4 дүгээр сарын 30-ны өдөр (оролцуулан)-ийн дотор зарлан хуралдуулна. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулаагүй тохиолдолд ТУЗ-ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг зарлан хуралдуулахаас бусад бүх эрх, бүрэн эрх дуусгавар болно.

8.4 Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг болон Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан хувьцаа эзэмшигчдийн хурлын хэлэлцэх асуудал болон ТУЗ-ийн ирэх санхүүгийн жилийн төсвийг батлах асуудал нь гагцхүү Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарна.

8.5 Холбогдох хууль болон Дүрэмд өөрөөр зааснаас бусад тохиолдолд хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь тухайн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцсон хувьцаа эзэмшигчдийн Ердийн олонхийн саналаар хүчин төгөлдөр болно. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож

байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ.

8.6 Дор дурдсан асуудлыг энэхүү Дүрэмд заасан “Стратегийн ач холбогдол бүхий асуудал” гэж үзэх ба эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа, тухайн асуудлаар санал өгөх эрхтэй хувьцаа эзэмшигчдийн Дийлэнх олонхийн саналаар батална. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ. Стратегийн ач холбогдол бүхий асуудлын талаар аливаа шийдвэрийг гагцхүү ТУЗ-өөр хэлэлцсэний дараа хувьцаа эзэмшигчдийн хуралд танилцуулна:

(i) Банкны Хувь нийлүүлсэн хөрөнгийг өсгөх, бууруулах, Хувьцааг хуваах, эсхүл буцаан нэгтгэх, нийт гаргасан Хувьцааны 5 хувиас дээш хувийг эргүүлэн авах зэргээр Банкны өөрийн хөрөнгийн бүтцэд аливаа материаллаг өөрчлөлт оруулах;

(ii) ногдол ашиг тараах болон хуваарилах аливаа шийдвэр;

(iii) СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн хоёр (2) хувиас дээш дүнгээр шинэ компани үүсгэн байгуулах, нэгтгэх, эзэмших, хөрөнгө оруулах аливаа шийдвэр гаргах;

(iv) Нэмж Хувьцаа, хувьцаанд хөрвөх аливаа төрлийн үнэт цаас гаргах (өмнө, эсхүл дараа нь зөвшөөрөл авснаар), аливаа төрлийн Хувьцаа болон үнэт цаас нэмж гаргах зөвшөөрөл олгох, эсхүл Банкны Хувьцаа болон бусад үнэт цаасыг худалдан авах зорилгоор опцион, баталгаа гаргах;

(v) ТУЗ-ийн төсөв, цалин урамшууллын хэмжээг тогтоох, ТУЗ-ийн гишүүдийн тоог ихэсгэх болон багасгах;

(vi) Банкны хувьцааг гадаадын хөрөнгийн биржид бүртгүүлэн худалдах;

(vii) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн хоёр (2) хувиас дээш дүнгээр хадгаламж, зээл, хөрөнгө хуваах зэргээр компанид хөрөнгө оруулах;

(viii) Өөрчлөн байгуулах, нийлэх, өөрчлөх, нэгтгэх буюу нийлүүлэх, Банкийг өөр компани, хуулийн этгээдтэй нэгтгэх, нийлүүлэх, эсхүл өөр компани, хуулийн этгээдийн хөрөнгийг бүхэлд нь эсхүл дийлэнх хэсгийг Банк худалдан авч эзэмших талаар төлөвлөгөө, шийдвэр гаргах;

(ix) Банкны үйл ажиллагаанд аливаа өөрчлөлт оруулах;

(x) Дөрвөн том аудитын компаниас бусад аудитын компаниуд дундаас Хөндлөнгийн аудиторыг сонгох тохиолдолд тийнхүү Банкны Хөндлөнгийн аудиторуудыг томилох, чөлөөлөх;

(xi) Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр Банкны нийт хөрөнгийн 25 хувиас илүү үнэлгээ бүхий аливаа хөрөнгийг худалдах, тээвэрлэх, шилжүүлэх, түрээслүүлэх буюу өөр бусад байдлаар захиран зарцуулах.

8.7 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах шийдвэрийг ТУЗ хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахаар товлосон өдрөөс 40 (дөч)-өөс доошгүй хоногийн өмнө бичгээр гаргах бөгөөд хувьцаа эзэмшигчдийн аливаа хурлын талаарх мэдэгдлийг хувьцаа эзэмшигчдийн хурлыг хуралдуулахаар товлосон өдрөөс 30 (гуч)-аас доошгүй хоногийн өмнө олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан хувьцаа эзэмшигчдэд хүргэх үүрэгтэй.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын зохион байгуулахтай холбоотой бүхий л асуудлууд, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлах, хуралдуулах, бэлтгэх шийдвэр гаргах, хувьцаа эзэмшигчдийн хурлын мэдэгдэл хүргүүлэх, хурлыг зохион байгуулах, хуралдуулах, санал хураалт, санал тооллогын журам болон тооллогын комиссын чиг үүрэг, хувьцаа эзэмшигчдийн хурлын тэмдэглэл хөтлөх, хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр, хурдын тэмдэглэлийг хянан баталгаажуулах, хүргүүлэх зэрэг асуудлыг СЗХ-ноос баталсан Хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргүүлэх тухай журам болон ТУЗ-ийн баталсан холбогдох дотоод журмаар зохицуулна.

8.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлыг биечлэн оролцох хуралдааны эсхүл теле-конференцийн болон бусад ижил төстэй харилцаа холбооны хэрэгслийг ашиглан цахим аль ч хэлбэрээр хуралдуулж болох бөгөөд хурлын дэгийг ТУЗ тогтооно. Хувьцаа эзэмшигчдийн хурал болон харилцаа холбоог Англи хэлээр явуулах бөгөөд энэ тохиолдолд Банк нь орчуулагч, орчуулах төхөөрөмжөөр хангах замаар тухайн хуралд оролцож буй бүх хувьцаа эзэмшигчид нь хурлаар хэлэлцэж буй асуудлыг бүрэн ойлгох, мэдээлэлтэй байлгах нөхцөлийг бүрдүүлнэ.

8.9 Холбогдох хууль тогтоомж эсхүл энэхүү Дүрэмд өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн дарга нь хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргална. ТУЗ-ийн дарга нь өөрийн эзгүй үед хурлыг даргалах этгээдийг нэр дэвшүүлнэ. ТУЗ-ийн дарга тийнхүү нэр дэвшүүлээгүй бол ТУЗ-өөс томилсон этгээд хувьцаа эзэмшигчдийн хурлыг даргална.

8.10 Компанийн тухай хуулиар зөвшөөрсөн хэмжээнд ТУЗ зохимжтой гэж үзсэн бол хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах аливаа асуудлыг хурал хуралдуулахгүйгээр хувьцаа эзэмшигчдээс эчнээ санал хураалт (цаашид **“Эчнээ санал хураалт”** гэх) явуулах замаар шийдвэрлэж болно. Энэхүү Дүрмийн 8.1-д заасан хурлын хүчинтэй ирцэд тавигдах шаардлага

Эчнээ санал хураалт явуулах замаар шийдвэр гаргах болон хойшлуулсан Эчнээ санал хураалтад мөн адил хамаарна.

8.11 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг эчнээ санал хураалтаар орлуулахыг хориглоно.

8.12 Энэхүү Дүрмээр зохицуулагдаагүй бусад асуудлууд, тодруулбал хувьцаа эзэмшигчдийн ээлжит болон ээлжит бус хурлыг зарлан хуралдуулах, хурлын зар болон хэлэлцэх асуудлын жагсаалт хүргүүлэх, тэдгээртэй холбоотой шийдвэр гаргах, хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох, хуралд оролцох эрх, хурлыг хуралдуулах буюу зохион байгуулах, хурлын ирц хүчин төгөлдөр болох, санал хураах, саналын тооллого болон хувьцаа эзэмшигчид эчнээ санал хураалтаар шийдвэр гаргах зэрэг асуудлыг Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлэгт заасны дагуу тодорхойлж шийдвэрлэнэ.

**Төлөөлөн Удирдах Зөвлөл**

8.13 Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих байгууллага нь ТУЗ байна. ТУЗ нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан 12 гишүүнтэй байна (ТУЗ-ын гишүүн чөлөөлөгдсөн эсхүл нас барсан гэх зэрэг онцгой тохиолдлуудад ТУЗ-ын гишүүдийн тоо түр хугацаанд 12-оос бага болсноос бусад үед).

8.14 ТУЗ-ийн гишүүдийн 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь ТУЗ-ийн Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооноос тус бүрийг сонгон нэр дэвшүүлсэн, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанк, СЗХ-ноос заасан шаардлагыг хангасан хараат бус гишүүн байна. Хараат бус гишүүн нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид, үүний дотор зөвхөн эдгээрээр хязгаарлагдахгүйгээр Монголбанк, СЗХ, МХБ-ээс баталсан холбогдох бусад дүрэм, журамд заасан эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

8.15 Холбогдох аргачлал болон Монголбанкны Ерөнхийлөгчийн олгосон зөвшөөрлийн үндсэн дээр хувьцаа эзэмшигчдийн хурал нь СЗХ-оос баталсан журмын дагуу санал хураах кумулятив аргаар ТУЗ-ийн гишүүдийг томилно.

8.16 Энэхүү Дүрэмд заасан хугацаанд хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах үүргээ зохих ёсоор биелүүлж байх тохиолдолд ТУЗ-ийн бүрэн эрх хоёр (2) жилийн хугацаатай байна. ТУЗ-ийн бүрэн эрхийн хугацаанд ТУЗ-ийн гишүүний орон тоо гарсан тохиолдолд Монголбанкны зөвшөөрлийг авч ТУЗ-ийн гишүүнийг орлох этгээдийг дараагийн хувьцаа эзэмшигчдийн хурал хуралдах хүртэл хугацаанд ТУЗ түр томилж, энэ талаар хувьцаа эзэмшигчдэд 14 хоногийн дотор мэдэгдэнэ. Түр томилогдсон гишүүн нь ТУЗ-ийн гишүүний бүхий л эрхийг эдэлж, үүргийг хүлээнэ.

СЗХ
2023 06. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01



8.17 ТУЗ-ийн хурлыг биечлэн оролцох хуралдааны эсхүл теле-конференцийн болон бусад ижил төстэй харилцаа холбооны хэрэгслийг ашиглан цахим аль ч хэлбэрээр хуралдуулж болох бөгөөд хурлын дэгийг ТУЗ тогтооно. ТУЗ-ийн гишүүдийн Дийлэнх олонх оролцсоноор ТУЗ-ийн хурлын хүчинтэйд тооцогдоно. ТУЗ-ийн хурал болон хурлын харилцаа холбоог Англи хэлээр явуулж, тухайн хуралд оролцож буй бүх гишүүд харилцан нэг нэгнээ сонсох нөхцөлийг бүрдүүлж, тийнхүү оролцсоныг хуралд биечлэн оролцсонд тооцно.

8.18 Энэхүү Дүрэм болон Холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн хуралд оролцож байгаа гишүүдийн Дийлэнх олонхийн саналаар шийдвэр хүчин төгөлдөр болох бөгөөд ТУЗ-ийн хурлаас гарсан шийдвэр нь тогтоол хэлбэртэй байна.

8.19 Тогтоолд ТУЗ-ийн дарга гарын үсэг зурж Банкны тэмдгийг дарж баталгаажуулна. ТУЗ-өөс зохимжтой гэж үзсэн бол ТУЗ нь ТУЗ-ийн хурал хуралдуулахгүйгээр ТУЗ-ийн гишүүдээс эчнээ санал хураалт (эчнээ санал хураалт) явуулах замаар шийдвэр гаргаж болно.

8.20 ТУЗ-ийн даргыг нийт гишүүдийн дотроос нийт гишүүний Дийлэнх олонхийн саналаар томилох бөгөөд нэр дэвшигч гишүүний саналыг тооцохгүй. ТУЗ-ийн дарга нь өөрийн эзгүй үед ТУЗ-ийн хурлыг даргалах этгээдийг нэр дэвшүүлнэ. ТУЗ-ийн дарга тийнхүү нэр дэвшүүлээгүй бол ТУЗ-өөс томилсон этгээд ТУЗ-ийн хурлыг даргална.

8.21 ТУЗ-ийн хурлаар хэлэлцэж гаргасан хүчин төгөлдөр шийдвэргүйгээр ТУЗ-ийн дарга эсхүл аль нэг гишүүн нь дангаараа болон зарим гишүүд хамтран ТУЗ-ийн бүрэн эрхийг хэрэгжүүлэх, ТУЗ-ийн бүрэн эрхэд нь хамаарах асуудлаар аливаа шийдвэр гаргах буюу ТУЗ-ийг төлөөлөх эрхгүй. ТУЗ-ийн гишүүн нь ТУЗ-өөс тусгайлсан өгсөн зөвшөөрөлгүйгээр ТУЗ-ийн байр суурийг төлөөлөх эрхгүй.

8.22 ТУЗ нь хуанлийн жилийн улирал тутамд хамгийн багадаа нэг удаа хуралдах бөгөөд шаардлагатай тохиолдолд үзвэл нэмэлт хурал хийж болно.

8.23 Холбогдох хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол ТУЗ-ийн хурал, үйл ажиллагаатай холбоотой журмыг ТУЗ батална.

8.24 ТУЗ-ийн гишүүд нь хуралд оролцож байгаа бүх гишүүд бие биенээ харилцан сонсох боломжтой теле-конференцийн эсхүл түүнтэй адил харилцаа холбооны бусад хэрэгслээр дамжуулан ТУЗ-ийн хуралд оролцож болох бөгөөд тухайн хуралд оролцож буй бүх гишүүд харилцан нэг нэгнээ сонсох нөхцөлийг бүрдүүлж, тийнхүү оролцсоныг хуралд биечлэн оролцсонд тооцно.

8.25 Энэхүү Дүрэм болон ТУЗ-ийн баталсан аливаа дүрэм, журмаар зохицуулагдаагүй ТУЗ, түүний бүрэн эрх, үйл ажиллагаа, хурал, шийдвэртэй холбоотой аливаа асуудлыг Компанийн тухай хуулийн 9 дүгээр бүлэг, холбогдох бусад хууль тогтоомжид мөн ТУЗ-өөс Компанийн Засаглалын

СЭХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01



Кодекст нийцүүлэн ТУЗ-өөс баталсан "ТУЗ-ийн үйл ажиллагааны журам"-д заасны дагуу тодорхойлж зохицуулна.

8.26 ТУЗ нь Банкны тухай хууль болон Компанийн тухай хуульд заасан бүрэн эрхийг хэрэгжүүлэхээс гадна энэхүү Дүрэм болон Компанийн тухай хуульд тухайлан хувьцаа эзэмшигчдийн хуралд харьяалуулснаас бусад дор дурдсан асуудлыг шийдвэрлэх бүрэн эрхтэй байна. Үүнд:

8.26.1 СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн хоёр (2) хувь хүртэлх дүнгээр шинэ компани үүсгэн байгуулах, нэгтгэх, эзэмших, хөрөнгө оруулах аливаа шийдвэр гаргах;

8.26.2 Өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр, СТОУС-ын дагуу хамгийн сүүлд аудитлагдсан Банкны санхүүгийн тайланд үндэслэн Банкны нийт өөрийн хөрөнгийн хоёр (2) хувь хүртэлх дүнгээр хадгаламж, зээл, хөрөнгө хуваах зэргээр аливаа компанид хөрөнгө оруулах;

8.26.3 Дөрвөн том аудитын компаниас аудиторыг сонгох тохиолдолд тийнхүү Банкны хөндлөнгийн аудиторуудыг томилох, чөлөөлөх.

8.27 ТУЗ-ийн Дарга болон гишүүд нь Холбогдох хууль тогтоомжоор хүлээлгэсэн үүрэг, хариуцлагаас гадна дараах үүрэгтэй:

8.27.1 хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд албан үүргээ зохих ёсоор гүйцэтгэх;

8.27.2 Банк, Банкны харилцагчийн эрх ашгийг хувийн болон түүнийг томилсон этгээдийн эрх ашгаас дээгүүр тавих;

8.27.3 нууцаар ашиг хүртэхгүй байх;

8.27.4 сонирхлын зөрчлөөс зайлсхийж, сонирхлын зөрчил үүссэн үед ТУЗ-д мэдээлдэг байх;

8.27.5 банкны өдөр тутмын үйл ажиллагаанд оролцохгүй байх.

8.28 ТУЗ нь ТУЗ-ийн гишүүнийг сонгох, сонгууль явуулах журам, ТУЗ-ийн гишүүн бүрэн эрхээ хэрэгжүүлэх, хурал хуралдуулах буюу зохион байгуулах журам, гишүүдийн бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох үндэслэл, гишүүнийг түр томилох, нөхөн сонгууль явуулах, гишүүдэд тавих шалгуур зэрэг харилцааг зохицуулсан дотоод журмыг Монголбанканд урьдчилан танилцуулан батлуулж мөрдүүлнэ.

**ТУЗ-ийн хороод**

8.29 ТУЗ нь Аудитын, Эрсдэлийн удирдлагын, Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын болон ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн эсхүл Холбогдох хууль

СЗХ 2023 оны 05. 12 өдөр БҮРТГЭВ № 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05

тогтоомжид заасны дагуу байгуулах шаардлагатай бусад хороодтой байна (дангаар нь “**Хороо**”, хамтад нь “**Хороод**” гэх). ТУЗ нь өөрийн бүрэн эрхэд хамаарах зарим асуудлыг хороогоор дамжуулан хэрэгжүүлж болох бөгөөд үүнийг хорооны дүрмээр зохицуулна.

8.30 Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэгт заасны дагуу Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны гишүүдийн 2/3-оос доошгүй нь ТУЗ-ийн хараат бус гишүүн байна.

8.31 Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, болон Монголбанк, СЗХ-ноос баталсан холбогдох бусад дүрэм, журмын дагуу Хороодын гишүүдийг томилох, чөлөөлөх, Хороодын эрх, үүрэг, хариуцлагыг ТУЗ-өөс баталсан холбогдох журмаар зохицуулна.

8.32 Хороо тус бүрийн гишүүний бүрэн эрхийн хугацаа нь тухайн ТУЗ-ийн гишүүний бүрэн эрхийн хугацаа буюу 2 жилийн хугацаанд эсхүл энэхүү хоёр хугацааны аль богино хугацаагаар үргэлжилнэ.

8.33 Хороод нь тухайн Хорооны бүхий л хурлын даргалах даргалагчийг тухайн Хорооны гишүүд дотроосоо сонгоно.

8.34 Хорооноос үүргээ хэрэгжүүлэх зорилгоор шаардсан зохих баримт бичгийг Банк нь гаргаж өгөх үүрэгтэй.

8.35 Хорооны хурлыг хуанлийн жилийн улиралд нэгээс доошгүй удаа эсхүл тухайн нөхцөл байдлаас шалтгаалан үүнээс олон удаа хуралдуулна. Хорооны хуралд тус Хорооны гишүүдийн Ердийн олонх нь биечлэн оролцсоноор хурлын ирцийг хүчин төгөлдөрт тооцно.

8.36 Хороо тус бүрийн үйл ажиллагааны журам, хурлын хүчин төгөлдөр ирц, болон Компанийн тухай хуулиар тухайн Хороонд тусгайлан олгосон эрх, үүргээс бусад бүрэн эрхийг ТУЗ батална.

**Гүйцэтгэх удирдлага**

8.37 Холбогдох аргачлал зааварчилгааны дагуу мөн Монголбанкны Ерөнхийлөгчийн олгосон зөвшөөрлийн үндсэн дээр Банкны өдөр тутмын үйл ажиллагааг ТУЗ-өөс томилогдсон Гүйцэтгэх захирал хууль тогтоомжийн шаардлага болон энэхүү Дүрэмд нийцүүлэн ТУЗ-тэй байгуулсан хөдөлмөрийн гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулж ажиллана.

8.38 Компанийг төлөөлөн ТУЗ-ийн дарга Гүйцэтгэх захиралтай Хөдөлмөрийн гэрээ байгуулах бөгөөд тус гэрээгээр Гүйцэтгэх захирлын эрх, үүргийг тодорхойлон зохицуулна.

8.39 Гүйцэтгэх Захирал нь хэлэлцэж буй асуудлаар саналын эрхтэй ТУЗ-ийн гишүүн байж болох боловч ТУЗ-ийн дарга байж болохгүй.

СЗХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01



8.40 Гүйцэтгэх Захирал нь ТУЗ-ийн дэргэдэх Аудитын болон Засаглал, нэр дэвшүүлэх болон цалин урамшууллын хорооны гишүүн байхыг хориглох ба Гүйцэтгэх захирлыг томилох, сонгох болон чөлөөлөх асуудлаар шийдвэр гаргах, түүнд эрх хэмжээ олгох асуудлаар шийдвэр гаргах болон түүний ажлын гүйцэтгэл хэлэлцэх асуудалд саналын эрхгүй байна.

8.41 Гүйцэтгэх Захирлын үйл ажиллагаанд ТУЗ хяналт тавина. ТУЗ-ийн шийдвэргүйгээр ТУЗ-ийн аль нэг гишүүн Гүйцэтгэх захирлын үйл ажиллагааг хянан шалгах, эсхүл Гүйцэтгэх Захиралд үүрэг, даалгавар өгөхийг хориглоно.

8.42 Гүйцэтгэх Захирал нь банкны эрхлэх үндсэн үйл ажиллагааны хүрээнд, Банкны эрхэм зорилгод нийцсэн зах зээлд өрсөлдөх чадвартай, харилцагчдын хэрэгцээ шаардлагыг хангахуйц үйлчилгээг үр ашигтайгаар түргэн шуурхай үзүүлэх ажлыг бүхий л боломжит нөөц, эх үүсвэрийг ашиглан зөв оновчтой зохион байгуулж ажиллах замаар банкны эдийн засаг, санхүүгийн чадавхийг дээшлүүлэн, хувьцаа эзэмшигчдийн хөрөнгө оруулалтын үнэ цэнийг нэмэгдүүлэх үндсэн үүрэгтэй байна.

8.43 Гүйцэтгэх захирал нь ТУЗ болон Хувьцаа эзэмшигчдийн эрх хэмжээнд хамаарахаас бусад асуудлаар уг албан тушаалд олгогдсон эрх хэмжээ буюу үүрэг, хариуцлагаа бие даан хэрэгжүүлнэ. Хөдөлмөрийн гэрээ, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Холбогдох хууль тогтоомжид заасан болон дараах албан үүрэг, хариуцлагыг хүлээнэ:

8.43.1 Банкны үйл ажиллагаа болон санхүүгийн гүйцэтгэлийн ирээдүйн чиг хандлага, бодлого чиглэлийг тодорхойлох, тогтоох, хэрэгжүүлэх;

8.43.2 Банкны салбар, тооцооны төв, хадгаламжийн касс, валютын арилжааны нэгж, төлөөлөгчийн газар, газар, алба, хэлтсийг удирдан зохион байгуулах;

8.43.3 Банкийг олон нийт, засгийн газар, бусад эрх бүхий байгууллагуудын өмнө төлөөлөх;

8.43.4 Банкны зээл болон хадгаламжийн хүү, үйлчилгээний хураамж, бусад шимтгэлийн хэмжээг тогтоох;

8.43.5 Дүрэм, гэрээ контрактад заасан эрхээ хэрэгжүүлэхдээ, Банкийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх;

8.43.6 шаардлагатай тохиолдолд ТУЗ-ийн хурлыг зарлан хуралдуулах;

8.43.7 Гүйцэтгэх захирал нь өөрийн үйл ажиллагааг ТУЗ-ийн хуралд тогтмол тайлагнана;

8.43.8 Гүйцэтгэх захирал нь Монголбанкнаас тогтоосон болон Банкны тухай хуульд заасан банкны үйл ажиллагааны шалгуур үзүүлэлтийг хангах үүргээ санаатайгаар зөрчсөн, Холбогдох хууль тогтоомжид

нийцээгүй, энэ Дүрэм болон Гүйцэтгэх захирлын хөдөлмөрийн гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй эсхүл дээрх үүргүүдээ ноцтой зөрчсөн тохиолдолд ТУЗ нь Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Гүйцэтгэх захирлыг ажлаас нь чөлөөлж болно.

**Эрх бүхий албан тушаалтан**

8.44 Банк нь дараах эрх бүхий албан тушаалтантай байна:

8.44.1 ТУЗ-ийн дарга;

8.44.2 ТУЗ-ийн гишүүн;

8.44.3 Гүйцэтгэх захирал;

8.44.4 Санхүү хариуцсан захирал/Ерөнхий нягтлан бодогч;

8.44.5 ТУЗ-ийн нарийн бичгийн дарга;

8.44.6 Гүйцэтгэх захиралтай байгуулсан онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний дагуу удирдлагын түвшинд үүрэг гүйцэтгэж байгаа бусад албан тушаалтан.

8.45 Гүйцэтгэх захирлаас итгэмжлэн олгосон эрх, үүргийн хүрээнд гэрээ байгуулах, тодорхой үйлдэл хийх, эсхүл Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд Банкийг гуравдагч этгээдийн өмнө төлөөлсөн нь тухайн ажилтныг эрх бүхий албан тушаалтан гэж үзэх үндэслэл болохгүй.

8.46 Холбогдох хууль тогтоомжид заасан доорх нөхцөлөөс бусад тохиолдолд эрх бүхий албан тушаалтан нь өөрийн хүлээсэн үүргээ зөрчсөнөөс учирсан аливаа хохирлыг Банк, Банкны хувьцаа эзэмшигчдийн өмнө биечлэн хариуцахгүй. Үүнд:

8.46.1 Эрх бүхий албан тушаалтан нь Банк, болон түүний хувьцаа эзэмшигчдийн өмнө хүлээсэн үнэнч байх үүргээ зөрчсөн;

8.46.2 шударга бус үйлдэл, эсхүл санаатай үйлдэл, эсхүл хууль тогтоомжийг санаатайгаар зөрчсөн үйлдэл, эс үйлдэхүй; эсхүл

8.46.3 Хувийн ашиг сонирхлын төлөө болон хувьдаа ашиг олох зорилгоор аливаа хэлцэл хийсэн.

8.47 Эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлагыг багасгах, эсхүл хязгаарлах замаар Холбогдох хууль тогтоомжид аливаа нэмэлт өөрчлөлт орсон тохиолдолд тухайн эрх бүхий албан тушаалтны үүрэг хариуцлага нь тийнхүү нэмэлт өөрчлөлт орсон хуулиар тодорхойлсон хэмжээгээр мөн багасах буюу хязгаарлагдана.

## ЕС ДҮГЭЭР ЗҮЙЛ. ДОТООД АУДИТ БОЛОН ХЯНАЛТ

9.1 Аудитын хороо нь Банкны ТУЗ-ийн баталсан санхүүгийн бодлого болон үйл ажиллагааны журмын хэрэгжилтэд болон нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал хяналт тавьж ажиллана. Аудитын хороо нь ТУЗ-д ажлаа тайлагнана.

9.2 ТУЗ нь өөрийн Аудитын хороогоор дамжуулан Банкны санхүүгийн тайланг баталгаажуулах, Банкны санхүүгийн үйл ажиллагаанд ээлжит иж бүрэн аудитын шалгалт хийх хөндлөнгийн аудиторыг шалгаруулан авч ажиллуулна.

## АРАВ ДУГААР ЗҮЙЛ. БАНКИЙГ ТАТАН БУУЛГАХ

10.1 Банкийг Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр төлөөлүүлэн оролцсон, уг асуудлаар санал өгөх эрх бүхий хувьцаа эзэмшигчдийн Үнэмлэхүй олонхийн саналаар буюу Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Холбогдох бусад хууль тогтоомжид заасан бусад үндэслэл, журмын дагуу татан буулгаж болно.

10.2 Татан буулгах ажиллагааг ТУЗ-өөс эсхүл шүүхийн шийдвэрээр татан буулгах тохиолдолд шүүхээс томилсон хэрэг гүйцэтгэгчээс томилогдсон Татан буулгах комисс хэрэгжүүлнэ.

10.3 Банкийг татан буулгах үед Банкны мөнгөн төлбөрийн үүрэг болон бусад үүрэг гүйцэтгүүлэгчийн өр төлбөрийг барагдуулсны дараа хөрөнгө (үүнд эд хөрөнгө худалдсанаас олсон аливаа орлого багтана) үлдсэн бол аливаа хөрөнгийг Компанийн тухай хуульд заасан журмаар хуваарилна.

10.4 Татан буулгах ажиллагааг Иргэний хууль, Банкны тухай хууль, Компанийн тухай хууль болон бусад Холбогдох хууль тогтоомжид заасан үндэслэл, журмын дагуу гүйцэтгэнэ.

## АРВАН НЭГДҮГЭЭР ЗҮЙЛ. БАНКНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХОРИГЛОХ ЗҮЙЛ, БАНКНЫ АЖИЛТАНД ТАВИГДАХ ШААРДЛАГА

11.1 Банкны үйл ажиллагаанд дор дурдсан хязгаарлалт тавина. Үүнд:

11.1.1 ТУЗ-өөс баталсан төсөвт тусгасан эсхүл ТУЗ-ийн тусгайлан шийдвэр гаргаж зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банк нь шинэ бизнесийн үйл ажиллагаа эрхлэх, шинээр салбар, хуулийн этгээд байгуулахыг хориглоно;

11.1.2 Банкны ТУЗ зөвшөөрснөөс бусад тохиолдолд Банкны төсөвт тусгагдаагүй нэг төсөл буюу тодорхой нэг зорилгоор 500 (таван зуу) сая төгрөгөөс дээш үнийн дүнтэй нэг буюу хоорондоо холбоотой хэд хэдэн хэлцэл хийж, зарлага гаргахыг хориглоно.

11.2 Банкны ажилтнууд нь дараах шаардлагыг хангаж ажиллана. Үүнд:

11.2.1 Аливаа бусад байгууллага, аж ахуйн нэгжийн ашиг сонирхлыг төлөөлөхгүй байх;

11.2.2 Албан үүрэгтээ үнэнч шударга хандаж ажиллах ба банкны үйл ажиллагаа, тогтоосон горимд харш байдлаар өөртөө, гэр бүл, төрөл

СЭХ
2023 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 31



2023 -05- 05

төрөгсөд, болон ажил төрлийн болон хувийн харьцаатай хүмүүст, тэдгээрийн гэр бүл төрөл төрөгсдөд хууль бус давуу байдал олгохгүй байх;

Харилцагчийн данс, зээл, төлбөр тооцоо, бизнесийн ажиллагаатай холбоотой албан баримт бичиг, тоон үзүүлэлт, дотоод дүрэм, журам, заавар нөхцөлүүдийг хууль тогтоомж, дотоод заавар, журамд зааснаас бусад тохиолдолд бусдад танилцуулах, ашиглуулах, нууцлалыг алдагдуулах, хувийн хэрэгцээнд ашиглахгүй байх.

## АРВАН ХОЁРДУГААР ЗҮЙЛ. ДААТГАЛ, БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГМИЙН БОДЛОГО

12.1 Даатгалтай холбоотойгоор Банк нь:

12.1.1 өөрийн бүхий л даатгуулж болох хөрөнгө, Банкны үйл ажиллагаа, хариуцлага мөн хуульд заавал даатгуулахаар заасан аливаа бусад эрсдэлийг салбартаа нэр хүндтэй даатгагчид хувьцаа эзэмшигч нарын хүлээн зөвшөөрсөн нөхцөлөөр даатгуулах буюу өмнө байгуулсан гэрээний хугацааг сунгана. Даатгалын гэрээг Англи хэл дээр байгуулна;

12.1.2 даатгалын гэрээ нэг бүрийг хүчин төгөлдөр хэвээр байлгах үүднээс шаардагдах бүх хураамж, төлбөрийг цаг хугацаанд нь зохих ёсоор төлнө;

12.1.3 тухайн үйл явдлаас хамаарч даатгалын тохиолдлын нөхөн төлбөр авах эрхэд халдаж болзошгүй аливаа үйлдэл, эс үйлдэл хийхгүй байх, хийхийг завдахгүй, үйлдэх мөн эс үйлдэхийг бусдад зөвшөөрөхгүй;

12.1.4 даатгалын тохиолдлын нөхөн төлбөр авах тухай аливаа мэдэгдлийг холбогдох даатгагчид нэн даруй хүргүүлж, нөхөн төлбөрийг гаргуулах талаар бүхий л арга хэмжээг авч ажиллана;

12.1.5 Банкны гаргасан нийт хувьцааны 10% буюу түүнээс дээш хувийг эзэмшигчийн хүсэлтээр даатгалын хүчин төгөлдөр байдлыг нотлох баримт бичгийг гаргаж өгнө;

12.2. Байгаль орчин, нийгмийн бодлоготой холбоотойгоор ТУЗ нь:

12.2.1. Банкны бүх үйл ажиллагаанд даган мөрдвөл зохих Байгаль орчин, нийгмийн бодлогыг батална. Бодлого нь дараах үндсэн асуудлыг тусгасан байна:

(i) Байгаль орчин, нийгмийн бодлогын хүрээнд хөрөнгө оруулахыг хориглосон үйл ажиллагааны дэлгэрэнгүй жагсаалт;

(ii) Банкны зүгээс харилцагч болон түүний үйл ажиллагаанд тавих байгаль орчин, нийгмийн шаардлагууд (Байгаль орчин, нийгмийн шаардлага); болон

(iii) Байгаль орчин, нийгмийн шаардлагыг Банкны үйл ажиллагаанд ханган хэрэгжүүлэх үйл явц.

СЗХ
2023 05 12
БҮРТГЭВ
№ 11



12.2.2. Байгаль орчин, нийгмийн бодлогын хэрэгжилтийг тайлагнах дотоод болон гадаад механизмыг батална; болон

12.2.3. Банкны хөрөнгө оруулалтын үр өгөөжийн үзүүлэлтэд ноцтой нөлөө үзүүлж болзошгүй Байгаль орчин, нийгмийн асуудлаар үүсэх магадлалтай болон тийнхүү үүссэн нөхцөлд үнэлгээ хийх, хяналт тавих журмыг баталж, дээр дурдсан асуудлаар Банкны удирдлага болон ТУЗ-д мэдээлнэ.

12.2.4. Байгаль орчин, нийгмийн бодлогын шинэчлэл, өөрчлөлт болон хэрэгжилтийн талаарх Байгаль орчин нийгмийн тайланг жил бүр бэлтгэн олон нийтэд нээлттэй байршуулна.

12.2.5. ТУЗ-өөс шаардлагатай гэж үзсэн тохиолдолд нь Байгаль орчин, нийгмийн бодлогыг таван жил тутамд хянаж, холбогдох хэсэгт нэмэлт өөрчлөлт оруулна.

## АРВАН ГУРАВДУГААР ЗҮЙЛ. БУСАД

13.1. Банкны санхүүгийн жил нь жил бүрийн 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эхэлж, тухайн жилийн 12 дугаар сарын 31-ний өдөр дуусна.

13.2. Банк нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС болон бусад дүрэм, журмын дагуу аудитлагдсан санхүүгийн тайлан гаргана.

13.3. Энэхүү Дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа гишүүдийн Үнэмлэхүй олонхийн саналаар шийдвэрлэнэ. Хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн болон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр дамжуулан оролцож байгаа хувьцаа эзэмшигч тус бүр нь өөрийн эзэмшиж буй Хувьцаа нэг бүрт нэг саналын эрх эдэлнэ.

13.4. Энэхүү Дүрмээр тухайлан зохицуулаагүй асуудлыг тухайн үед хүчин төгөлдөр үйлчилж буй Холбогдох хууль тогтоомжийн дагуу зохицуулна. Холбогдох хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт орсон бол хувьцаа эзэмшигчдийн эрх, үүргийг хянаж үзэн, тэдгээрт нийцүүлнэ.

13.5. Энэхүү Дүрэм буюу Банкны үйл ажиллагаатай холбоотой аливаа маргааныг Монгол Улсын хуульд заасны дагуу шийдвэрлүүлнэ.

13.6. Тухай бүр нэмэлт өөрчлөлт оруулсан энэхүү Дүрэм нь Банкийг татан буулгах буюу өөрчлөн байгуулагдах хүртэл хүчинтэй байна.

13.7. Энэхүү Дүрмийн эхийг хууль зүйн хувьд Англи болон Монгол хэл дээр нэгэн адил хүчин төгөлдөр үйлдсэн бөгөөд тэдгээрийн хооронд зөрүүтэй байдал үүсвэл Англи хэл дээрх эхийг баримтална.

13.8. Энэхүү Дүрмийг Хувьцаа эзэмшигчдийн 202X оны XX дугаар/дүгээр сарын ...-ны/ний өдрийн хурлаар батлав.

ХАСБАНК

ХасБанк ХК
Улаанбаатар хот

# ХАВСРАЛТ4: Андеррайтерийн дүгнэлт болон тусгай зөвшөөрлийн хуулбар

СЗХ
2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

RHINOS Investment
"РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК" ХХК
Хаяг: Монгол Улс, Улаанбаатар хот, СБД 8-р хороо, Сүхбаатарын талбай-2, Сэнтрал Тауэр 1308б тоот, Утас:7510-0575, Э-шуудан: info@rhinosinvest.mn , УБД: 9019097033

**АНДЕРРАЙТЕРИЙН ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ**

Огноо: 2023 он 04 сар 06 өдөр
Дугаар: 45/23

# ХАСБАНК ХХК-ИЙН НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАЖ БУЙ ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ТАЛААРХ ТОДОРХОЙЛОХ ЗАХИДАЛ

Үндсэн андеррайтер болох Райнос Инвестмент ҮЦК ХХК нь Монгол улсын Компанийн тухай хууль, Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", Монголын хөрөнгийн бирж ТӨХК-ийн 2018 оны 01 сарын 25-ны өдөр баталж, 2020 оны 02 сарын 07-ны өдөр өөрчлөлт оруулсан "Үнэт цаасны бүртгэлийн журам", УИХ-ын 2021 оны 01 сарын 29-ний өдөр баталсан "Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль" болон түүнийг дагаж мөрдөх журам болон бусад холбогдох хууль, дүрэм, журмын дагуу ХасБанк (цаашид "Үнэт цаас гаргагч" эсхүл "Банк" гэх)-ны нийтэд санал болгон анх удаа гаргаж буй энгийн хувьцааны үнэт цаасны танилцуулга болон бусад баримт бичгийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу бэлтгэн хүргүүллээ.

Райнос Инвестмент ҮЦК ХХК (цаашид "Үндсэн андеррайтер" гэх) нь Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 12 сарын 08-ны өдрийн 558 тоот тогтоолоор олгосон Андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийн хүрээнд ХасБанк ХХК (цаашид "Үнэт цаас гаргагч гэх") болон Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК (цаашид "Туслах андеррайтер" гэх) -тай 2023 оны 03 сарын 13-ны өдөр 4/23-017 тоот "Андеррайтерийн үйлчилгээ үзүүлэх гэрээ" байгуулсан болно. Энэхүү гэрээний хүрээнд Үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 01 сарын 11 өдрийн R-2023-02 тоот тогтоол, Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 сарын 05-ны өдрийн SR-2023-06 тоот тогтоолоор тус тус шийдвэрлэсний дагуу Үнэт цаас гаргагчийн нэгж бүр нь 677 төгрөгийн үнэтэй, 52,700,000 (тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг хувьцааг нийтэд санал болгон анх удаа нэмж гаргах замаар нийт 35,677,900,000 (гучин таван тэрбум зургаан зуун далан долоон сая есөн зуун мянга) төгрөгийг татан төвлөрүүлж, нээлттэй хувьцаат компани болох үйл ажиллагааг гүйцэтгэхээр зорин ажиллаж байна.

Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон гаргах хувьцааг анхдагч зах зээлд байршуулахдаа СЗХ-ны "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 7.2-т "*Анхдагч зах зээлийн арилжааг Андеррайтер нь үнэт цаасны танилцуулга материалд заасан арга хэлбэрээр нийтэд санал болгон байршуулж, худалдана*" хэмээн заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжааны систем болон Андеррайтерийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга бүртгэлийн платформоор дамжуулан байршуулна.

Үнэт цаас гаргагчийн шийдвэрийн дагуу үндсэн андеррайтер нь үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон нэмж гаргах энгийн хувьцааны 70%-ийг Стратегийн хөрөнгө оруулагчдад, 30%-

ийг олон нийтэд санал болгохоор хуваарилсан бөгөөд Тогтоосон үнийн аргаар санал болгоно.

Андеррайтер нь үнэт цаасыг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагаар Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 41.4.3 дахь заалтад тодорхойлсноор бүх хүчин чармайлт гаргах хэлбэрээр зохион байгуулах бөгөөд "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын дагуу Үнэт цаас гаргагч болон Туслах андеррайтертай 2023 оны 03 сарын 31 өдөр "Үнэ тогтворжуулах хөтөлбөр хэрэгжүүлэх гэрээ" байгуулан ажиллаж байна.

ХҮНДЭТГЭСЭН,

ДЭД ЗАХИРАЛ Н.ЦЭВЭГМИД

# АНДЕРРАЙТЕРИЙН ДҮГНЭЛТ

ХАСБАНК
Амьдрал - ашид хамтдаа.

## ХАСБАНКНЫ НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ҮНЭТ ЦААСНЫ ТАНИЛЦУУЛГЫН ДҮГНЭЛТ

### Хөрөнгө оруулагчдын анхааралд

Үндсэн андеррайтер нь Үнэт цаас гаргагч болон түүний нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаанд хөндлөнгийн дүгнэлт гарган оролцож буй хууль, аудит, үнэлгээний мэргэжлийн компаниуд болон Үнэт цаас гаргагч, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан, холбоотой этгээдүүдтэй аливаа сонирхлын зөрчилгүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

Үндсэн андеррайтер нь нийтэд санал болгож буй хувьцааг бүртгүүлэхэд үнэт цаасны танилцуулгыг бэлтгэх, хууль, аудитын үйлчилгээ үзүүлэгчийн дүгнэлт, бусад шаардагдах баримт бичгийн бүрдэлд хяналт тавьж ажиллах үүрэгтэй. Үнэт цаасны танилцуулга нь холбогдох бодит эх сурвалжууд, үнэт цаас гаргагч болон энэхүү танилцуулгыг бэлтгэхэд оролцсон мэргэжлийн байгууллагуудын боловсруулсан тайлан дүгнэлтэд үндэслэн бэлтгэгдсэн болно.

Үнэт цаасны танилцуулга нь хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахад шаардлагатай мэдээллийг агуулсан бөгөөд аливаа тайлан, тоон статистик болон бусад мэдээллийн дэлгэрэнгүйг үнэт цаасны танилцуулгын хавсралт хэсэгт багтаасан болно. Үнэт цаасны танилцуулга түүнд тусгагдсан тооцоолол, ирээдүйн төсөөлөл нь хөрөнгө оруулагчдад үнэт цаас гаргагчийн талаар **зөвхөн мэдээлэл** өгөхөд зориулсан бөгөөд, хөрөнгө оруулалт нь ямагт эрсдэлтэй алхам байдгийг ойлгож хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

2023 05 12 өдөр
БҮРТГЭВ

АГУУЛГА


1.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ....6
1.1 Үнэт цаас гаргагчийн танилцуулга....6
1.2 Хуулийн нийцлийн талаар....7
1.2.1 Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувь эзэмшилтэй холбоотой хэсгийн шаардлагыг хангаж байгаа талаар:....7
2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ....9
2.1 Бизнесийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн өнөөгийн байдал....9
2.1.1 Зээлийн зах зээл....9
2.1.2 Хадгаламжийн зах зээл....9
2.1.3 Банкуудын ашигт ажиллагаа....10
2.2 Бизнесийн өсөлт, цаашдын чиг хандлага....10
2.2.1 Хэрэглэгчийн санхүүгийн хэрэглээний зан төлөвийн өөрчлөлт....10
2.2.2 Банкны салбарын ирээдүйн чиг хандлага....11
3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА....13
3.1 Иргэдийн банкны үйл ажиллагаа....13
3.2 Байгууллагын банкны үйл ажиллагаа....13
3.3 Үйл ажиллагааны стратеги....13
4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА....15
4.1 Санхүүгийн тогтвортой байдлыг хангах стратеги....15
4.2 Санхүүгийн үзүүлэлт....15
5.ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ....20
5.1 Нийтэд санал болгон гаргах үнэт цаасны танилцуулгыг хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэнсэн талаар....20
5.2 Нийтэд санал болгон гаргах үнийн тооцоолол....20
5.2.1 Нийтэд санал болгох үнийг тогтоох аргачлалын талаар....20
5.2.2 Банкны бизнес үнэлгээг тооцоолоход ашигласан аргачлалын талаар....21
5.2.3 Олон нийтэд санал болгох үнийг тогтоосон талаар....21
5.3 Эрсдэл....23
5.4 Анхдагч зах зээлд байршуулах....25
5.5 Нийтэд санал болгон гаргах арга, хэлбэр....25
5.5.1 Нийтэд санал болгох хувьцаа....26
5.5.2 Нийтэд санал болгосны дараах хувь хэмжээ....26
5.5.3 Хуваарилах зарчим....26
5.5.4 Андеррайтерийн худалдан авах хэмжээ....27
5.6 Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт....27
5.7 Нэгдсэн дүгнэлт....27

2023.05.12
БҮРТГЭВ
№1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02



## 1. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

# 1.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ТУХАЙ

## 1.1 Үнэт цаас гаргагчийн танилцуулга

ХасБанк нь 2001 онд байгуулагдсан Монгол Улсын ууган банкуудын нэг бөгөөд банк санхүүгийн системийн тогтвортой байдлыг хангахад ач холбогдол бүхий системийн хэмжээний 5[1] том банкны нэг юм.

Үнэт цаасны танилцуулга бэлтгэж байгаа өдрийн байдлаар ХасБанк нь 100 хувь толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн эзэмшилд байна. Тус банкны эцсийн өмчлөгчид нь гадаад болон дотоодын нэр хүнд бүхий нийт 12 хөрөнгө оруулагчдаас бүрдэж байгаа бөгөөд нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийн хамтаар эзэмшиж буй доод хувь 0.09 хувь, дээд хувь 20.00 хувь байна.

ХасБанк нь үүсгэн байгуулагдсан цагаасаа компанийн сайн засаглал, нийгмийн хариуцлагын хүрээнд авч хэрэгжүүлж буй арга хэмжээгээрээ салбартаа жишиг тогтоож ирсэн. Дэлхий нийтийг хамарсан Ковид-19 цар тахлын нөлөөгөөр эдийн засаг, нийгэмд нүүрлэсэн хямралын хүнд хэцүү цаг үеийг ч ХасБанк нь компанийн удирдлагын зөв арга барил, оновчтой шийдвэр гаргалтын үр дүнд амжилттай даван туулсан байна.

ХасБанк нь Монгол орон даяар үйл ажиллагаа явуулж буй 74 салбар нэгж, бизнес үйлчилгээний төвүүд, тэдгээрт ажиллаж буй 1,323 гаруй мэргэшсэн ажилтан, 6,000 гаруй мерчант, 360 гаруй АТМ-аар дамжуулан 1 сая харилцагчдадаа санхүүгийн цогц үйлчилгээг хамгийн сүүлийн үеийн дэвшилтэт технологийг ашиглан хүргэж байна.

ХасБанк нь 2001 онд үүсгэн байгуулагдах үедээ 1 сая ам.долларын активтай байсан бол өдгөө 1.2 тэрбум ам.долларын активтай Монголын системийн нөлөө бүхий банкуудын нэг болтлоо өргөжин тэлсэн байна.

ХасБанкны стратеги, засаглалын давуу тал нь олон улсын санхүүгийн байгууллагуудаас урт хугацаатай ам.долларын эх үүсвэрийг Монгол улсын эдийн засагт оруулж ирэх боломжийг нээж байдаг. Банк нь үүсгэн байгуулагдсан цагаасаа хойш өнөөг хүртэл нийт 1.2 тэрбум гаруй ам.долларын гадаад эх үүсвэрийг олон улсын зах зээлээс татаж чаджээ.

Монгол улсад төдийгүй дэлхий дахинд тулгамдаж буй асуудал болох уур амьсгалын өөрчлөлтийг сааруулахад ХасБанк бодитой хувь нэмэр оруулж, тогтвортой эрчим хүчний салбарт санхүүжилт олгох зорилгоор Эко банкны хэлтсийг Монголын арилжааны банкууд дундаас хамгийн анхлан байгуулсан бөгөөд тус хэлтсээрээ дамжуулан байгаль орчинд ээлтэй төсөл, хөтөлбөрүүдийг санхүүжүүлж байна. Мөн ХасБанк нь нийгмийн хариуцлагаа өндөрт ухамсарлаж Монгол улсын соёлын өвийг дэлгэрүүлэх, хүүхэд залуучуудын эрдэм мэдлэгийг дээшлүүлэх, байгаль орчинг хамгаалж, сэргээх, урлаг спортыг хөгжүүлэх үйл ажиллагааг ивээн тэтгэж ажиллаж байна.

[1] Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн 1-р зүйлд заасны дагуу Монголбанкны ерөнхийлөгчийн 2021.04.19-ний тушаалын дагуу Хаанбанк, Худалдаа хөгжлийн банк, Голомт банк, Төрийн банк, ХасБанкийг "Банкны системд нөлөө бүхий банк" гэж баталсан байна.

## 1.2 Хуулийн нийцлийн талаар

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэхтэй холбогдуулан ХасБанкны үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлт бэлтгэн ажилласан Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН нь дараах дүгнэлтийг гаргасан байна.

"Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК нь Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд тогтоосон шалгуурыг хангаж байна."

### 1.2.1 Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувь эзэмшилтэй холбоотой хэсгийн шаардлагыг хангаж байгаа талаар:

Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журмын дагуу банк нь компанийн хэлбэр, хувь эзэмшлийн хувьд дараах өөрчлөлтүүдийг хуульд заасан хугацаанд хэрэгжүүлнэ. Үүнд:

**(1) Компанийн хэлбэр өөрчлөх:** Банкны системд нөлөө бүхий банк нь 2023 оны 06 сарын 30-ны өдрийн дотор банкыг нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах, харин бусад банкууд нь нээлттэй эсхүл хаалттай хувьцаат компани болж компанийн хэлбэрийг өөрчилсөн байх.

**(2) Хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах:** Аливаа нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийн хамт тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байх. Бүх банкуудын хувьд хуулийн шаардлагыг хэрэгжүүлэх эцсийн хугацаа нь 2023 оны 12 сарын 31-ний өдөр байна.

**ХасБанк нь энэхүү шаардлагыг дараах байдлаар хангаж байна.**

(1) Анх удаа нийтэд санал болгон гаргах хувьцааны үнэт цаасны танилцуулгыг боловсруулан хуульд заасан хугацаанд нээлттэй хувьцаат компани болох бэлтгэл ажлыг хангах хүрээнд энэхүү танилцуулгыг бэлтгэж байна.

(2) ХасБанкны хувьцааг 100 хувь эзэмшиж буй Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьд хамгийн том хувьцаа эзэмшигч нь тус компанийн 20 хувийг эзэмшиж байна. Компанийн тухай хуулийн 20 болон 21-р зүйлд заасны дагуу Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хэмжээнд компанийн бүтцийн өөрчлөлт хийх замаар одоогийн Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь үнэт цаас гаргагчийн зүгээс хувьцаагаа нийтэд санал болгосны дараа шинээр хувьцаа эзэмшигч болох этгээдүүдийн хамт ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болно. **Ийнхүү ХасБанкны хамгийн том хувьцаа эзэмшигч нь нийт хувьцааны 20 хувиас хэтрэхгүй буюу хуулийн шаардлагыг хангах нөхцөл бүрдэх юм.**

## 2.ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ

## 2. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЯВУУЛЖ БУЙ ЗАХ ЗЭЭЛ

### 2.1 Бизнесийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн өнөөгийн байдал

Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн хандлагыг эх үүсвэр, зээл гаргалт болон эцсийн үр дүнг тодорхойлох ашигт ажиллагааны байдлаар авч үзлээ.

#### 2.1.1 Зээлийн зах зээл

Монгол улсын хэмжээнд зээлийн үйл ажиллагаа эрхэлж байгаа банк, санхүүгийн байгууллагуудын нийт зээлийн үлдэгдэл 2022 оны эцсийн байдлаар 24.7 их наяд төгрөгт хүрч, үүнээс 22.0 их наяд төгрөг буюу 88.8%-ийг нь банкны секторын зээл эзэлж байна. 2017-2022 оны хооронд банкны салбарын зээлийн үлдэгдэл жилд дунджаар 11.2%-ийн өсөлттэй явж ирсэн байна. Харин банкны салбарын нийт активын хэмжээ 2017 оноос 2022 оны хооронд жилд дунджаар 9.8%-иар өсч 2022 оны байдлаар 45.9 их наяд төгрөгт хүрсэн байна.

2022 оны 1 сарын байдлаар олон улсын санхүүгийн байгууллагууд ирэх 5 жилийн Монгол улсын эдийн засгийн өсөлтийг 5.1%-7.0% байхаар төсөөлж байсан ба 2022 оны эцсийн гүйцэтгэлээр эдийн засгийн өсөлт 4.5% хүрсэн байна. Мөн 2022 онд дэлхий даяар эрчим хүч, түүхий эд материалын үнэ өссөн нь инфляцийн түвшинд нөлөөлж, ихэнх улс орнууд бодлогын хүүгээ нэмсэн ба 2023 оны дунд хүртэл энэ байдал үргэлжлэх хандлагатай байна хэмээн шинжээчид үзэж байна . Монгол Улсын Эдийн Засгийн Хөгжлийн Яамнаас2023 онд Монгол улсын эдийн засгийн өсөлт 5.0% байхаар төсөөлж буй бөгөөд засгийн газрын зүгээс томоохон төсөл хөтөлбөрүүдийг хэрэгжүүлэх замаар дунд хугацаанд цар тахлын өмнөх эдийн засгийн төвшинд хүрэх зорилтыг тавин ажиллаж байгаа нь дунд хугацаанд банкны салбарт эерэг хүлээлтийг бий болгох төлөвтэй байна.

Монголбанкнаас гаргасан үйл ажиллагаа явуулж буй банкуудын нэгдсэн балансын үзүүлэлтээс үзэхэд аж ахуйн нэгж, бизнесүүдийн зээлийн үлдэгдэл 2022 оны жилийн эцсийн байдлаар 10.1 их наяд төгрөг байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар банкуудын олгосон нийт зээлийг ангилж үзвэл иргэд 48.6%, хувийн байгууллага 42.6%, улсын байгууллага 1.1% тус тус эзэлж байна. Харин хувийн байгууллагуудад олгосон зээлийн үлдэгдлийг голлох салбаруудын эзлэх хувиар нь авч үзвэл худалдааны салбар 34.7%, уул уурхай 10.9%, боловсруулах үйлдвэр 13.8%, барилгын салбар 16.4% байна. Тус салбаруудын чанаргүй зээлийн төвшин харгалзан 8.0%, 24.2%, 21.1%, 22.9% байна. Үүнээс дүгнэхэд худалдааны салбарын жижиг дунд бизнесийн зээлийн чанар харьцангуй сайн байгаа нь харагдаж байна.

#### 2.1.2 Хадгаламжийн зах зээл

2022 оны эцэст иргэд, аж ахуйн нэгжийн харилцахын үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 49.5%-иар өссөн бөгөөд үүнд хувийн байгууллагуудын гадаад валютын харилцах өмнөх оны мөн үеэс 125.4% өсч 4.8 их наяд болсон бол иргэд, аж ахуйн нэгжийн хадгаламжийн үлдэгдэл 9.3%-иар буурсан үзүүлэлттэй байв. Энэ нь гадаад орчны тодорхой бус байдлаас шалтгаалан иргэд, аж ахуйн нэгжүүд гадаад гадаад валют нөөцлөх, хадгалах сонирхол өндөр байсантай холбоотойгоор тайлбарлагдаж байна[2].

[2] https://stat.mongolbank.mn/

Түүнчлэн 2022 оны жилийн эцсийн байдлаар нийт хадгаламжийн хэмжээ 16.7[3] их наяд төгрөг ба үүнд иргэдийн хадгаламж 15.1 их наяд төгрөг буюу 90.7%, хувийн байгууллагын хадгаламж 1.2 их наяд буюу 7.5%-ийг бүрдүүлж байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар, банкуудын нийт эх үүсвэрийн 67.4% орчмыг харилцах, хадгаламж[4], 12.3%-г гадаад эх үүсвэр бүрдүүлж байна.

### 2.1.3 Банкуудын ашигт ажиллагаа

Банкны ашигт ажиллагаа болон үйл ажиллагааны найдвартай байдлыг шинжлэхдээ Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байгаа байдал, өөрийн хөрөнгийн өгөөж, цэвэр хүүний маржин, активын чанар, чанаргүй зээлийн төвшин, эрсдэлийн сангийн нөөц байгуулсан хувь, санхүүгийн эх үүсвэрийн тогтвортой байдал, үйл ажиллагааны орлогод эзлэх үйл ажиллагааны зардал зэрэг голлох үзүүлэлтүүдийг харьцуулан үзэх нь чухал юм. Өөрөөр хэлбэл банк нь нийт хэдэн төгрөгийн актив удирдаж байгаа хэмжээнээс илүүтэй хөрөнгөө хэр үр ашигтай удирдаж чадаж байгаа нь чухал үзүүлэлт билээ.

Монголбанкнаас тогтоосон өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтийг бүх арилжааны банкууд хангаж буй бөгөөд ХасБанк энэхүү үзүүлэлтээрээ тэргүүлж байна. Түүнчлэн арилжааны банкуудын цахим хуудсанд толилуулсан мэдээллээс авч үзэхэд 2022 оны жилийн эцсийн байдлаар системийн нөлөө бүхий 5 банкны чанаргүй зээлийн харьцаа 4.0%-12.9%-ийн хооронд байгаа бол ХасБанкны хувьд 4.0% буюу тус үзүүлэлтээр хамгийн сайн банк нь байна.

2022 оны жилийн эцсийн байдлаарх банкуудын цахим хуудсанд тайлагнасан санхүүгийн мэдээлэл дээр үндэслэн тооцоолон үзэхэд өөрийн хөрөнгийн өгөөж 16.8%-иас 31.9%-ийн хооронд хэлбэлзэж байгаа бөгөөд үүнд ХасБанкны 2022 оны жилийн эхний эздийн өмчид харьцуулан тооцсон өөрийн хөрөнгийн өгөөж 27.6% байна.

Андеррайтерын зүгээс ХасБанкны цэвэр ашиг болон голлох санхүүгийн үзүүлэлтүүд өсөлттэй байгаа нь сүүлийн жилүүдэд тус банкны менежментийн зүгээс хэрэгжүүлсэн оновчтой бодлого, шийдвэр гаргалтын үр дүн хэмээн харж байна. Өөрөөр хэлбэл эдийн засгийн аливаа хүндрэлийг урьдчилан тооцож, эрсдэл өндөртэй эдийн засгийн салбаруудад төвлөрсөн активыг урьдчилан бууруулж, өндөр зардалтай эх үүсвэрийг эргүүлэн төлөх зэргээр үйл ажиллагааны цэвэр орлогоо сайжруулсан, мөн активын өсөлтөөс илүүтэйгээр активын чанарт анхаарсан нь өнөөдөр чанаргүй зээлийн төвшинг хамгийн бага хэмжээнд удирдан ажиллах боломжийг бүрдүүлэн, ашигт ажиллагааг нэмэгдүүлэх суурь хүчин зүйл болжээ хэмээн дүгнэж болохоор байна.

## 2.2 Бизнесийн өсөлт, цаашдын чиг хандлага

Дэлхий даяар банк, санхүүгийн зах зээл эрчимтэй цахимжиж, бизнес загварт өөрчлөлт орох хандлагатай байгаа тул үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн ирээдүйн чиг хандлагын талаар хөрөнгө оруулагчдад мэдээлэл өгөх нь зүйтэй юм.

### 2.2.1 Хэрэглэгчийн санхүүгийн хэрэглээний зан төлөвийн өөрчлөлт

[3] https://stat.mongolbank.mn/
[4] 2022.12.31-ний байдлаар нийт эх үүсвэрт эзлэх хувь нь харилцах 26.7%, хадгаламж 40.7%байна. Банкуудын тайлан, 2022.

Ковид-19 цар тахлын нөлөөгөөр хэрэглэгчдийн санхүүгийн үйлчилгээ авах хэлбэр хурдтай цахимжиж, олон улсын санхүүгийн зах зээлээс ч цахимаар үйлчилгээ авах боломжтой болсон зэрэг нь тэдний санхүүгийн шийдвэр гаргалтад хүчтэй нөлөөлж байна. Ялангуяа төлбөр тооцоо, хэрэглээний зээл, хадгаламж зэрэг санхүүгийн үйлчилгээг цахим хэлбэрээр авах боломж нь хэрэглэгчдийн хүлээлтэд ихээхэн өөрчлөлтийг бий болгож байна.

Манай улсын хувьд 2022 оны 3-р улирлын хуримтлагдсан дүнгээр банкны гар утасны аппаар хийгдсэн гүйлгээний дүн болон тоо хэмжээ 2020 оноос хойш жилд дунджаар харгалзан 16.0%, 18.8%-иар өсөн 80.1 их наяд төгрөг, 324.6 сая ширхэгт хүрсэн байна.[5]

Хэрэглэгчийн зан төлөвийн энэхүү өөрчлөлт нь банк, санхүүгийн байгууллагуудыг цахим шилжилтийг нэвтрүүлэн орлогын шинэ эх үүсвэрийг эрэлхийлэхэд хүргэж байна.

### 2.2.2 Банкны салбарын ирээдүйн чиг хандлага

Дэлхийн эдийн засгийн нөхцөл байдлыг сүүлийн 80 жилийн хугацаанд авч үзэхэд цар тахалтай холбоотой эдийн засгийн зогсонги байдлын дараа өндөр өсөлт үзүүлэх хүлээлттэй байсан ч Украйн-Оросын дайн, түүхий эд, эрчим хүчний үнийн өсөлтийг дагасан инфляцийн нөлөөгөөр 2023 онд дэлхийн эдийн засгийн өсөлт 2.9%[6], 2024 онд 3.1% болж өснө гэж таамагласан байна. Мөн 2023 онд ихэнх улсуудад инфляц өндөр хэвээр үргэлжилж, хүүгийн түвшин нэмэгдэх төлөвтэй байгаа ба нийтэд нээлттэй хувьцаат компани хэлбэрээр үйл ажиллагаа явуулдаг дэлхийн топ банкууд өөрийн хувьцааг халааслах, ногдол ашгаа нэмэгдүүлэх бодлого барих хүлээлт өндөр байна хэмээн дурдсан байна.

Түүнчлэн Digital Banking Report 2021 судалгаанд үндэслэвэл 2025 он гэхэд санхүүгийн үйлчилгээний цахимжилт нэмэгдэх төлөвтэй байгаа буюу банкны нийт хэрэглэгчдийн 64.0% нь мобайл банкаар, 12.0% нь онлайн банкаар, 15.0% нь салбараар, 9.0% нь санхүүгийн зөвлөхөөр дамжуулан үйлчлүүлэх төлөвтэй байна.

Иймд банкууд нэг талаас эдийн засгийн зогсонги, уналттай он жилүүдийн дараах өсөлтөнд бэлдэх, нөгөө талаас Ковид-19 цар тахлын нөлөөгөөр улам бүр мобайл, интернет зэрэг цахим сувгаар үйлчилгээ авах хандлагатай байгаа хэрэглэгчдийн зан төлөвд тохируулан бизнес загвараа эргэн харах зэрэг сорилтуудын өмнө байна хэмээн харж байна.

Цахим шилжилт хурдтай явагдаж буй энэ үед ХасБанк нь үр ашиггүй олон салбар ажиллуулахгүй[7] харин оновчтой цөөн байршилд бүтээмж өндөртэй салбаруудыг удирдан ажиллуулж байгаа нь зардлын үр ашигт байдлыг дээшлүүлж, ашигт ажиллагааг тогтвортой удирдахад эерэг нөлөөтэй байна гэж андеррайтерийн зүгээс үзэж байна.

---

[5] Монголбанк, Хөдөлгөөнт Банкны Тайлан 2019, 2020, 2021, 2022 он

[6] Олон Улсын Валютын Сангийн таамаглаж байгаагаар дэлхийн эдийн засаг 2023 онд 2.9% өсөх хүлээлттэй байна. IMF, World economic outlook update, Jan 2023. https://www.imf.org/en/Publications/WEO/Issues/2023/01/31/world-economic-outlook-update-january-2023

[7] Монголбанкны статистик үзүүлэлтээр 2022 оны 2-р сарын байдлаар манай улсад нийт 11 арилжааны банкны нийт 1391 салбар, тооцооны төв үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд ХасБанкны хувьд 78 салбартай буюу нийт банкны салбарын 5.6%-ийг бүрдүүлж байна.

## 3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# 3. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 3.1 Иргэдийн банкны үйл ажиллагаа

ХасБанкны иргэдийн банкны үйл ажиллагаа нь олон төрлийн хэрэглээний зээл, бичил бизнесийн зээл, жижиг дунд бизнесийн зээл, , орон сууцны зээл болон ногоон зээл зэрэгт төвлөрч байна.

ХасБанк нь технологийн дэвшилтэй хөл нийлүүлэн 2016 оноос цахим шилжилтийг идэвхтэй нэвтрүүлснээр өдгөө банкны төлбөр тооцооны 90 гаруй хувийг цахимаар гүйцэтгэж байна. Үүнд дотоод үйл ажиллагааг автоматжуулахаас гадна, мобайл аппаар дамжуулан харилцагчдын хэрэгцээнд нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг шинэчилсэн дижитал аппликейшнээр дамжуулан 2021 онд нэвтрүүлсний үр дүнд иргэдийн банкны цахим харилцагчдын тоо 26% өсч 252,000 болж чаджээ. Банк нь харилцагчдын хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлд онцгойлон анхаарч ажилладаг.

ХасБанк нь харилцагчдын санхүүгийн зорилгод нийцсэн бүтээгдэхүүн, үйлчилгээг хөгжүүлж, уламжлалт болон цахим сувгаар хүргэх замаар санхүүгийн хүртээмжтэй байдлыг нэмэгдүүлэхэд түлхүү анхаарч байна. Түүнчлэн ХасБанкны хувьд байгаль орчинд ээлтэй хэрэглээ болон нийлүүлэлтийг дэмжсэн эко зээлийн бүтээгдэхүүнийг сурталчлан таниулахад өндөр ач холбогдол өгдөг.

## 3.2 Байгууллагын банкны үйл ажиллагаа

ХасБанк нь Монгол Улсын бизнесийн салбарын санхүүгийн найдвартай түнш байж, харилцагчдын бизнесийн онцлог, санхүүгийн хэрэгцээ шаардлагад нийцсэн оновчтой шийдлийг нэвтрүүлэн, байгууллагын банкны харилцагчдын хэрэгцээ шаардлагад нийцсэн үйлчилгээг үзүүлж байгаа нь Монгол орон даяар бизнес эрхлэгчдийн ХасБанканд итгэх итгэлийг улам нэмэгдүүлж байна.

Олон улсын санхүүгийн байгууллагуудтай хамтран зах зээлд өрсөлдөхүйц уян хатан нөхцөлтэй санхүүжилтийг бизнесүүдэд олгож чаддаг нь ХасБанкны хувьд эрсдэлээ зөв удирдах боломжийг бүрдүүлж өгдөг. Банк өнөөг хүртэл 55 сая ам.долларын урт хугацаатай санхүүжилтийг олон улсын санхүүгийн байгууллагатай хамтран харилцагчиддаа синдикат зээл хэлбэрээр олгожээ. Түүнчлэн цар тахлын үед эдийн засгийн нөхцөл байдал хүнд байсан хэдий ч ХасБанк нь худалдааны санхүүжилтийн гол тоглогчийн байр сууриа хадгалж засаглалын бүтцийн давуу тал дээр тулгуурлан өөрийн харилцагчдаа олон улсын санхүүгийн байгууллагын худалдааны санхүүжилтийн шугам ашиглах боломжоор ханган ажиллажээ.

## 3.3 Үйл ажиллагааны стратеги

2022 оны жилийн эцсийн байдлаар ХасБанкны банкны секторт эзлэх хувь хэмжээ 9.6% орчим байгаа бөгөөд цаашид эдийн засгийн төлөвтэй уялдуулан харилцагчдын эрэлт хэрэгцээнд нийцсэн, харилцагч төвтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санаачлан санал болгох замаар цар хүрээгээ тогтвортой тэлэх төлөвлөгөөтэй байна.

Өөрөөр хэлбэл банк нь урт хугацааны тогтвортой өсөлтийг эрхэмлэж буй тул урт хугацаанд тогтворгүй сегмент, бүтээгдэхүүнийг хязгаарлан, зээлийн багцыг эрсдэл багатай сегмент, салбар, бүтээгдэхүүнүүдэд төвлөрүүлэх, банкны балансыг эдийн засгийн савалгаанаас аль болох хамаарал багатай болгоход анхааран ажиллаж байна.

# 4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

# 4. ҮНЭТ ЦААС ГАРГАГЧИЙН САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

## 4.1 Санхүүгийн тогтвортой байдлыг хангах стратеги

2019 онд шинээр томилогдсон гүйцэтгэх захирал болон түүний менежментийн баг нь банкны урт хугацааны санхүүгийн тогтвортой байдлыг хангахын тулд Банкны стратегийг шинээр боловсруулан, хэд хэдэн арга хэмжээг шуурхай авч ажилласан байна. Энэхүү шинэ стратегийн зорилт нь тогтвортой ашиг орлого, оновчтой балансын бүтэц бий болгоход чиглэсэн байна. Үүнд:

- Ашигт ажиллагаанд суурилсан харилцагчийн сегмент болон бүтээгдэхүүнд анхаарлаа хандуулах
- Эрсдэл өндөртэй эдийн засгийн салбар, харилцагчийн сегмент, бүтээгдэхүүний борлуулалтыг хязгаарлах
- Зээлийн багцын өсөлтийг зөвхөн эрсдэл багатай сегмент, салбар, бүтээгдэхүүнүүдэд төвлөрүүлэх
- Актив пассивын удирдлагыг сайжруулж, долларын илүүдэл пассивыг бууруулах арга хэмжээ авах
- Өндөр хүүтэй гадаад эх үүсвэрүүдийг урьдчилан төлөх замаар эх үүсвэрийн зардлыг бууруулах
- Үйл ажиллагааны зардлаа тогтмол зардлаас хувьсах зардалруу шилжүүлэх.

## 4.2 Санхүүгийн үзүүлэлт

Бид үнэт цаас гаргагчийн санхүүгийн түүхэн үзүүлэлт, ирээдүйн төсөөллийг дараах хүрээнд судалж дүгнэлтээ хүргэж байна. Үүнд: 1) активын бүтэц 2) пассивын бүтэц 3) зохистой харьцааны шалгуур үзүүлэлт 4) активын чанар 5) хөрвөх чадвар 6) ашигт ажиллагаа

### 4.2.1 Активийн бүтэц

2022 оны жилийн эцсийн байдлаар зээлийн болон санхүүгийн түрээсийн багц нийт 1,974 тэрбум төгрөг болж өмнөх оны мөн үеэс даруй 11.1% өссөн ба үүнээс харилцагчдад олгосон зээл 92.5% буюу 1,826 тэрбум төгрөг, лизинг 7.5% буюу 148 тэрбум төгрөг байна.

Үнэт цаас гаргагчийн 2022 оны аудитлагдсан тайланд тусгагдсаны дагуу зээлийн бүтцийг эдийн засгийн салбараар нь авч үзэхэд хэрэглээний зээл тус банкны нийт зээлийн багцад эзлэх хувь 2021 онд 33.5% байсан бол 2022 онд 21.8% болон буурсан ба худалдаа болон хадгаламж барьцаалсан зээл 2021 онд 34.3% байсан бол 2022 онд 38.9% болон тэлж нийт дүнгээр өмнөх оны мөн үеэс 26.1% өссөн байна. Харин барилга, үйлчилгээ, ХАА болон уул уурхайн салбарын нийт зээлийн багцад эзлэх хувь 2021 онд 9.5% байсан бол 2022 онд 14.2% болон өссөн байна. Нийт зээлийн багц 2022 оны жилийн эцсийн байдлаар өмнөх оны мөн үеэс 11.1% өсөхөд худалдааны зээлийн өсөлт (19.6%), хадгаламж барьцаалсан зээлийн өсөлт (38.4%), барилга болон үйлчилгээний салбарт олгосон зээлийн өсөлт (91.4%, 60.2%) голлон нөлөөлжээ.

Банк нь цаашид эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан, банкны активын бүтцийг эдийн засгийн савалгаанаас хамаарал багатай сегмент, салбар, бүтээгдэхүүнүүдэд чиглүүлэх зорилттой байгаа бөгөөд, нийт зээл болон лизингийн багцад эзлэх иргэдийн зээл болон лизингийн хувь хэмжээг 68.0% орчимд удирдах төсөөлөлтэй байна. Банкны ирэх 5 жилийн

төлөвлөгөөнд аж ахуйн нэгж, байгууллагын зээлийн эзлэх хувь 19.6% байгаа нь банк цаашид тогтвортой өсөлтийг хангахын тулд нэмэлт эрсдэл авахыг эрмэлзэхгүй байгаатай холбоотой.

ХасБанк нь 2021 оны 10 сард түүний зэргэлдээ компани болох ХасЛизинг ХХК-тай нэгдэх зөвшөөрлийг Монголбанкнаас авч мөн оны 11 дүгээр сард компанийг Банктай нэгтгэсэн. Энэхүү нэгдлийн үр дүнд банкны санхүүгийн түрээсийн багцын үзүүлэлт нэмэгдэх төсөөлөлтэй байгаа нь нь хөрөнгө оруулагчдын өгөөжид эерэгээр нөлөөлөх хүлээлттэй байна. Үнэт цаас гаргагч нь ирэх 5 жилийн хугацаанд нийт зээлийн багцын орлого болон санхүүгийн түрээсийн орлогыг жилд дунджаар 20.8% өсгөхөөр төлөвлөж байгаа бөгөөд 2022 онд эдийн засгийн тодорхой бус байдалд байсан хэдий ч харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаанаас олсон хүүгийн орлого 13.4% өссөн байдлыг харгалзан үзэхэд банк нь энэхүү өсөлтийг хэрэгжүүлж чадахуйц харагдаж байна.

Хөрвөх чадвартай активын бүтцийг харвал Төвбанкны үнэт цаас, Төвбанканд заавал байлгах нөөц, бусад үнэт цаас болон банк хооронд хийсэн хэлцлүүд голлон бүрдүүлж байна. Банк нь 2022 оны жилийн эцсийн байдлаар Төвбанкны үнэт цаасанд 577 тэрбум төгрөг байршуулсан нь нийт активын 14.7%-ийг эзэлж байна. Ирэх 5 жилд ХасБанк нь хөрвөх чадварын харьцааг 33.1%-с дээш хангаж ажиллахаар төлөвлөсөн байна.

### 4.2.2 Пассивийн бүтэц

2022 оны жилийн эцсийн байдлаар Банкны эх үүсвэрийн 70.6% буюу 2,438 тэрбум төгрөгийг иргэд болон байгууллагын харилцах, хадгаламж бүрдүүлж байна. Ковидийн хуулийн[8] дагуу 2020 оны 04 сарын 29-ний өдрөөр тасалбар болгон цар тахлын хугацаанд харилцах, хугацаагүй хадгаламжийн дансанд хүү тооцохгүй байх зохицуулалт үйлчилсэн, хадгаламжийн хүү буурсан зэргээс үл хамааран 2022 оны жилийн эцсийн байдлаар харилцах, хадгаламжийн нийт дүн өмнөх оны мөн үеэс 8.3%-иар өсжээ. Энэ нь хадгаламжийн хүүнээс үл хамааран, банканд итгэх харилцагчдын итгэл өндөр байгааг харуулж байна.

Банк нь харилцагчдынхаа санхүүгийн сахилга бат, найдвартай байдал, тогтвортой өсөлтийг эрхэмлэж байгаа бөгөөд хадгаламжийн хүүг эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан цаг алдалгүй шинэчлэх, хүүгээр өрсөлдөхгүй байх бодлого барьж байна.

Үнэт цаас гаргагч нь ирэх 5 жилд харилцах, хадгаламжийн хэмжээг жилд дунджаар 11.0%-иар өсгөх төсөөлөлтэй байгаа бөгөөд өмнөх 5 жилийн хугацаанд жилд дунджаар 16.2% өссөн үзүүлэлттэй харьцуулбал энэхүү төлөвлөгөө нь биелэгдэх өндөр магадлалтай юм.

ХасБанкны засаглал, стратегийн давуу тал нь олон улсын санхүүгийн байгууллагуудаас урт хугацааны, уян хатан нөхцөлтэй эх үүсвэр татах боломжийг нээж байдаг. Банк нь 2019-2020 онд хэрэгжүүлсэн эх үүсвэрийн зардлыг бууруулах стратегийн хүрээнд өндөр хүүтэй гадаад эх үүсвэрийг хугацаанаас нь өмнө төлөх, шинээр бага хүүтэй, уян хатан нөхцөлтэй гадаад эх үүсвэрийг татах арга хэмжээг авч ирсэн. Банк нь гадаад эх үүсвэрийг зөвхөн Монголбанктай своп хийх тохиолдолд татах стратеги барьж байгаа бөгөөд 2022 онд олон улсын санхүүгийн байгууллагаас 720 тэрбум төгрөгтэй дүйцэхүйц хэмжээний санхүүжилт татах гэрээг баталгаажуулсан явдал нь өнгөрсөн оны мөн үеэс 12.9% өссөн үзүүлэлт юм.

### 4.2.3 Хөрөнгийн зохистой харьцаа

Банк нь бизнесийн эрсдэлээ өөрийн хөрөнгөндөө тулгуурлан үр ашигтай удирдахын тулд зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтмол

[8] Коронавируст халдвар/КОВИД-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, нийгэм, эдийн засагт үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах тухай

хангаж ажиллах учиртай. Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлт болон нийт өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа үзүүлэлтийг Монголбанкнаас 9.0% ба 12.0% байхаар тус тус зохицуулж өгсөн байдаг. ХасБанкны хувьд энэхүү харьцаа үзүүлэлтүүд нь 2021 оны байдлаар 17.4% ба 17.4%, 2022 оны байдлаар 20.1%, 20.1%-тай буюу харьцангуй өндрөөр давуулан биелүүлж байна

### 4.2.4 Активын чанар

Банк нь 2017-2022 онуудад чанаргүй болон эрсдэх магадлал бүхий активыг бууруулах төлөвлөгөө хэрэгжүүлсний үр дүнд чанаргүй зээлийг 109.9 тэрбум төгрөгөөс 81.6 тэрбум төгрөгт хүртэл бууруулж чадсан байна. Түүнчлэн 2019-2022 онуудад хангалттай активын эрсдэлийн сан байгуулсны үр дүнд Монголбанкны журмын дагуу байгуулсан эрсдэлийн санг чанаргүй зээлтэй харьцуулсан харьцаа үзүүлэлт мөн хугацаанд 89.1%-с 132.2%-д хүрч сайжирсан байна.

Банк нь 2022-2026 онуудын санхүүгийн төсөөлөлдөө эрсдэлийн сангийн зардлыг тогтвортой бага түвшинд удирдахаар тусгасан байна.

2022 оны жилийн эцсийн байдлаар банкны салбарын чанаргүй зээлийн төвшин 9.2%[9] байна. 2022 оны жилийн эцсийн байдлаар ХасБанкны чанаргүй зээлийн төвшин 4.0%-тай байгаа нь банкны салбарт хамгийн сайн үзүүлэлттэй байна.

Ковид-19 цар тахлын улмаас олон улсын төдийгүй дотоодын эдийн засгийн байдал тодорхойгүй болсны улмаас түүний дам нөлөөг урьдчилан тооцоолсны үндсэн дээр зээлийн багцыг эрсдэл багатай эдийн засгийн салбар, харилцагчийн сегмент, бүтээгдэхүүнүүдэд төвлөрүүлэн, банкны балансыг эдийн засгийн савалгаанаас аль болох хамаарал багатай болгох арга хэмжээ авч ажилласан нь ХасБанк чанаргүй зээлийн багцыг харьцангуй бага төвшинд барих боломжийг олгожээ.

Үнэт цаас гаргагч нь ирэх 5 жилийн хугацаанд чанаргүй зээлийн төвшинг дунджаар 3.24% орчимд хадгалахаар зорьж байгаа бөгөөд банкны зээлийн багцын удирдлагын стратеги, өнгөрсөн хугацааны үр дүнгээс авч үзвэл энэ нь биелэх боломжтой төсөөлөл юм.

Түүнчлэн хэдий богино хугацаанд эдийн засгийн тодорхойгүй байдал бий болсон байгаа ч дунд, урт хугацаанд эдийн засгийн өсөлт[10] хүлээгдэж буй суурь таамаглал нь ХасБанкны активын чанар сайжрах төсөөллийг дэмжиж байна.

### 4.2.5 Хөрвөх чадвар

Үнэт цаас гаргагчийн төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа нь 2022 оны жилийн эцсийн байдлаар 41.1% байгаа нь зохицуулагч байгууллагаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болох 25.0%-ийг давуулан биелүүлсэн үзүүлэлттэй байна.

Үнэт цаас гаргагчийн зээлийн багцын чанар, гадаад эх үүсвэр татах нээлттэй боломж, гүйцэтгэх удирдлагын багийн актив пассив болон эрсдэлийн удирдлагын стратегийг харгалзан үзэхэд банкны хувьд цаашдын хөрөнгийн өсөлтийг санхүүжүүлэх эх үүсвэрийн тогтвортой байдлыг хангах бүрэн боломжтой хэмээн дүгнэж байна.

### 4.2.6 Ашигт ажиллагаа

---

[9] https://stat.mongolbank.mn/?r=86

[10] ОУВС, https://www.imf.org/en/News/Articles/2022/10/25/mcs102522-mongolia-staff-concluding-statement-of-the-2022-article-iv-mission#:~:text=The%20scope%20for%20high%2Dquality,(50%20percent%20of%20GDP).

Банкны одоогийн гүйцэтгэх удирдлагын баг нь 2019 оноос эхлэн активын чанар, ашигтай өсөлтөд суурилсан харилцагчийн сегмент болон бүтээгдэхүүнд чиглэх төлөвлөгөө хэрэгжүүлж иржээ. Үүний үр дүнд цэвэр ашиг тогтмол нэмэгдэн 2022 оны жилийн эцсийн байдлаар 105.8 тэрбум төгрөгт хүрч өмнөх оны мөн үеэс 40.5%-иар өссөн үзүүлэлттэй байна. Үүний зэрэгцээ Банк нь ирээдүйд эрсдэлд орж болзошгүй томоохон дүнтэй зээлүүдийг урьдчилан тооцож, 2019-2022 онуудад хангалттай активын эрсдэлийн сан байгуулснаар өөрийн хөрөнгөнд үзүүлэх дарамтыг бууруулсан нь 2020-2022 оны байдлаар нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн хүрэлцээний үзүүлэлтийг 16.9%-с 20.1%-д хүртэл нэмэгдүүлэхэд нөлөөлжээ.

Банкны үйл ажиллагааны ашгийн гол үзүүлэлт болох цэвэр хүүний маржин нь 2019 онд 4.3% байсан бол 2022 онд 7.8% болж сайжирсан байна.

Үнэт цаас гаргагчийн зээл болон санхүүгийн түрээсийн багцын өсөлт, активын чанарын сайжралт, эх үүсвэрийн зардлын бууралт зэргийн үр дүнд цэвэр хүүний орлого аудитлагдсан тайланд дурдсанаар 2022 онд өмнөх оны мөн үеэс 62.6 тэрбум төгрөгөөр буюу 39.7%-р өссөн байна.

Гүйцэтгэх удирдлага нь тогтмол зардлыг хувьсах зардалруу шилжүүлэх, технологид хөрөнгө оруулан үйл ажиллагааны үр ашигт байдлыг сайжруулах замаар тогтмол зардлыг бууруулан ажиллаж байна. Мөн 2022 онд цэвэр хүүний орлого нэмэгдсэн зэргээс шалтгаалан үйл ажиллагааны зардал болон нийт үйл ажиллагааны орлогын харьцаа 2019 оны эхэнд 70.1% байсан бол 2022 онд 41.5% болж сайжирсан байна.

Ковид-19 цар тахлын дараа төрөөс авч хэрэгжүүлсэн мөнгөний бодлогын нөлөөгөөр 2020 оноос зах зээл дээр зээлийн хүү болон мөнгөний захын хөрөнгө оруулалтын өгөөж буурсан хэдий ч 2022 онд эргэж өссөн ба энэ үед ХасБанк нь актив пассивын оновчтой удирдлагыг хэрэгжүүлэх замаар ашигт ажиллагаагаа нэмэгдүүлж, 2022 оны жилийн эхний эздийн өмчид харьцуулан тооцсон өөрийн хөрөнгийн өгөөжийг 27.6%-д хүргэж ажилласан байна.

**Дүгнэлт**

Андеррайтер нь компанийн сайн засаглал, хувьцаа эзэмшигчдийн бүтэц, өнөөгийн санхүүгийн байдал, ТУЗ болон гүйцэтгэх удирдлагын багийн туршлага, ур чадвар, Монголбанкаас тогтоосон зохистой харьцааны бүх талын үзүүлэлтийг өндөр түвшинд давуулан хангаж байгаа байдал, урт хугацааны гадаад эх үүсвэрийг татан төвлөрүүлэх нээлттэй боломж, актив пассивын оновчтой удирдлага, санхүүгийн үзүүлэлтийг урт хугацаанд тогтвортой өсгөх цаашдын стратеги зэргийг харгалзан энэхүү дүгнэлтийг гаргаж байна.

Манай улсын хувьд санхүүгийн салбарын 90 орчим хувийг банкны салбар бүрдүүлдэг учраас аливаа банк нь бизнесийн үйл ажиллагаагаа төлөвлөхдөө эдийн засгийн урт хугацааны төсөөллийг сайтар судалж тусгах нь чухал юм.

Банкны одоогийн гүйцэтгэх удирдлагын баг нь эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан, түргэн шуурхай оновчтой арга хэмжээ авч хэрэгжүүлж, чанаргүй зээлийн түвшинг хамгийн бага байлгаж чадсаны зэрэгцээ, санхүүгийн сахилга баттайгаар банкны санхүүгийн үзүүлэлтүүдийг сайжруулах чадвартай гэдгээ түүхэн үзүүлэлтүүдээр нотолсон билээ. Бид гүйцэтгэх удирдлагын багийн энэхүү чадвар нь цаашид ч санхүүгийн төсөөллийн биелэлтийг хангахад өндөр ач холбогдолтой хэмээн дүгнэж байна.

СЗХ
он сар өдөр
2023 05 12
БҮРТГЭВ
№ 1

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
2023 -05- 0
БҮРТГЭВ-02

RHINOS Investment

## 5.ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

## 5.ҮНЭТ ЦААСНЫ ТУХАЙ

### 5.1 Нийтэд санал болгон гаргах үнэт цаасны танилцуулгыг хууль тогтоомжийн дагуу бэлтгэсэнсэн талаар

Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдөр баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 3.2-т заасны дагуу үнэт цаас гаргагч нь нийтэд санал болгон анх удаа гаргах үнэт цаасны танилцуулга материал, баримт бичгийг зохих шаардлагын дагуу бүрдүүлсэн байна.

Мөн Монголын хөрөнгийн биржийн 2018 оны 01 сарын 25-ны өдөр баталж, 2020 оны 02 сарын 07-ны өдөр нэмэлт өөрчлөлт оруулсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4-р зүйлд заасан үнэт цаасны танилцуулга материалын агуулга, хэлбэрийн дагуу Үнэт цаас гаргагчийн тухай мэдээлэл, үнэт цаасны тухай мэдээлэл, үнэт цаас гаргах ажиллагаанд оролцсон этгээдийн тухай мэдээллээс гадна хөрөнгө оруулагчид мэдээлэх шаардлагатай үнэт цаас гаргагч түүний үйл ажиллагаа, зах зээл, нийгэм эдийн засаг, хууль эрхзүйн орчинтой холбоотой бусад нэмэлт, дэлгэрэнгүй мэдээллийг агуулсан байдлаар бэлтгэсэн байна.

#### Хуулийн компанийн дүгнэлт

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН нь ХасБанкны нийтэд санал болгох хувьцааны үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр эсэх тухайд Хуулийн дүгнэлтийн 8-рт Үнэт цаасны танилцуулгатай танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувь хэмжээ, Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүргийн талаарх мэдээлэл нь Хуулийн фирмд Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ. "Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирм дүгнэж байна." хэмээн дүгнэсэн байна.

### 5.2 Нийтэд санал болгон гаргах үнийн тооцоолол

#### 5.2.1 Нийтэд санал болгох үнийг тогтоох аргачлалын талаар

БДО Аудит ХХК хөндлөнгийн үнэлгээний компани нь Үнэт цаас гаргагчийн үнэлгээг тогтоох гол аргаар "Үлдэгдэл Ашгийн загвар"-ыг ашигласан бөгөөд, энэхүү дүгнэлтээ Жишиг компанийн арга зүйн Үнэ/Биет Данс, Үнэ/Ашиг үржүүлэгч болон Ногдол ашиг хорогдуулах загварыг ашиглан баталгаажуулжээ.

Олон улсад банкны үнэлгээг тогтоохдоо үнэлгээний олон төрлийн аргачлалыг ашигладаг. Манай улсын хувьд хөгжиж буй зах зээл тул улсын нөхцөл байдал, макро эдийн засгийн хүлээгдэж буй өсөлт болон банкны салбарын цаашдын тэлэлт, хөгжиж буй улсуудын болон дотоодын олон нийтэд нээлттэй арилжаалагддаг арилжааны банкуудын санхүүгийн үзүүлэлтүүдийг харьцуулан авч үзэх нь чухал юм. Түүнчилэн үнэт цаас гаргагчийн тухайн зах зээлд эзлэх байр суурь, санхүүгийн төсөөлөл түүнийгээ хэрэгжүүлэх боломж болон бусдаас ялгарах онцлогийг харгалзан үзэх шаардлагатай билээ.

### 5.2.2 Банкны бизнес үнэлгээг тооцоолоход ашигласан аргачлалын талаар

БДО Аудит ХХК нь ХасБанкны бизнес үнэлгээг тооцоолохдоо үнэлгээний орлогын хандлага ба өртгийн хандлагын хосолмол арга болох Үлдэгдэл Ашгийн загварыг үндсэн арга болгон ашигласан байх бөгөөд Орлогын хандлагын Ногдол Ашиг Хорогдуулах загвар болон Зах зээлийн хандлагын Жишиг Компанийн Арга зүйн аргуудыг баталгаажуулах аргууд болгон ашигласан байна.

Үнэлгээний үндсэн арга болох Үлдэгдэл Ашгийн загварт ашигласан суурь төсөөллүүдийг авч үзвэл Өмчийн өртөг 20.3%, дунд хугацааны цэвэр ашгийн дундаж өсөлт 15.7%, урт хугацааны өсөлтийг 5%-р тус тус тооцсон байна. Үүнд Өмчийн өртөг буюу хорогдуулах хувийг 20.3%-р тооцсон байгаа нь үнэт цаасыг олон нийтэд санал болгох үнэт цаасны танилцуулгыг бэлдэж буй өдрийн байдлаар Монголын хөрөнгийн зах зээл дээр үнэт цаасаа санал болгосон бусад арилжааны банкуудын дундаж хорогдуулах хувь болох 16%[12]-с харьцангуй өндөр байгааг дурдах нь зүйтэй.

БДО Аудит ХХК-ийн тооцооллын дагуу нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ 677 төгрөг байхаар үнэлэгдсэн бөгөөд, нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээний тооцоололын дагуу хорогдуулах хувь 1% өсч 21.3% болоход нэгж хувьцааны үнэ цэнэ 620 төгрөг болохоор, хорогдуулах хувь 1% буурч 19.3% болоход нэгж хувьцааны үнэ цэнэ 742 төгрөг хүртэл өсөх боломжтой хэмээн тооцоолжээ.

Түүнчилэн БДО Аудит ХХК нь үнэлгээний тайландаа ХасБанкны аль ч хувьцаа эзэмшигч нь нь Банкны гаргалтуудад дангаараа нөлөөлөх эсвэл дангаараа хяналт тавих боломжгүй буюу хамгийн том хувьцаа эзэмшигч нь тус Банкны 20%-ийг эзэмшдэг бөгөөд ТУЗ-д зөвхөн нэг гишүүн томилсон байх ба засаглалын өндөр стандартыг хэрэгжүүлдэг олон улсын байгууллагууд бөгөөд хоорондоо хамаатай талууд байхгүй тул Хяналтгүй хувь оролцооны хямдруулалтыг тооцохгүй байхаар шийдвэрлэснийг дурдсан байна.

Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн хувь эзэмшилтэй холбоотой хэсгийн шаардлагын дагуу банкны **Хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах хүрээнд** Аливаа нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийн хамт тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20%-с хэтрэхгүй байх бөгөөд хэрэгжүүлэх эцсийн хугацаа нь 2023 оны 12 сарын 31-ний өдөр байхаар заасан.

Харин ХасБанкны хувьд тус банкны хувьцааг 100 хувь эзэмшиж буй Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь үнэт цаас гаргагчийн зүгээс хувьцаагаа нийтэд санал болгосны дараа шинээр хувьцаа эзэмшигч болох этгээдүүдийн хамт ХасБанкны шууд хувьцаа эзэмшигчид болсноор **ХасБанкны хамгийн том хувьцаа эзэмшигч нь нийт хувьцааны 20%-с хэтрэхгүй буюу хуулийн шаардлагыг хангах нөхцөл бүрдэх юм.**

### 5.2.3 Олон нийтэд санал болгох үнийг тогтоосон талаар

СЗХ-ны 2021 оны 06 сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ийн 9.2.1-д заасны дагуу Үнэт цаас гаргагч болон Андеррайтер нь үнэлгээний тайланд үндэслэн, нийтэд санал болгон гаргах хувьцааны санал болгох үнийг хамтран тогтоох боломжтой байдаг. Үнэлгээний хувьд өмчийн өгөөж, үнэ болон биет дансны

[12] Үнэт цаасны танилцуулганд тусгагдсан хорогдуулах хувь: Төрийн банк 16.3%, Голомт банк 15.87%

харьцаа, үнэ болон ашгийн харьцаанаас гадна банкны түүхэн үзүүлэлтүүд, банкны активын чанар, ирээдүйн санхүүгийн төсөөлөл, ногдол ашгийн бодлого болон түүнийгээ хэрэгжүүлэх боломж зэргийг харгалзан үзэх нь чухал билээ.

Түүнчлэн бид нийтэд санал болгох үнийг тогтоохдоо олон нийтэд хүртээмжтэй байх, хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадварын нөхцөл байдал, зах зээлийн багтаамж зэргийг харгалзан үзсэн болно.

Ийнхүү үнэт цаас гаргагчийн ТУЗ-ийн 2023 оны 01 сарын 11-ний өдрийн R-2023-02 тоот тогтоол, мөн Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 сарын 05 -ны өдрийн SR-2023-06 тоот тогтоолын дагуу нэгж хувьцааны үнийг 677 төгрөгөөр тооцон, нийт 52,700,000(тавин хоёр сая долоон зуун мянга) ширхэг хувьцааг нийтэд санал болгон анх удаа гаргаж, нийт 35,677,900,000(гучин таван тэрбум зургаан зуун далан долоон сая есөн зуун мянга) төгрөг татан төвлөрүүлэхийг зөвшөөрсөн байна.

ХасБанк нь 2016-2022 оны цэвэр хүүгийн орлогын жилийн нийлмэл өсөлтийн хувь 13.9% байсан бол 2027 он хүртэл энэхүү өсөлтийг дунджаар 13.4% байлгахаар зорьж буй бөгөөд, 2027 он хүртэл өмчийн өгөөжийг дунджаар 24.9% байлгахаар, чанаргүй зээлийн нийт багцад эзлэх хувийг 2022 оноос тогтмол бууруулан 3.24%-д тогтворжуулан ажиллахаар төлөвлөсөн байна. Энэхүү төсөөлөл болон сүүлийн жилүүдийн гүйцэтгэл дээр үндэслэвэл ХасБанкны үнэлгээний хувьд ашигт ажиллагааны төсөөллийг чухалчилан авч үзэх нь зүйтэй юм.

**Хүснэгт1: Хөрөнгө татан төвлөрүүлсний дараах үнэлгээний тооцоолол**

*Нэгж: сая төгрөг*

| Үзүүлэлт | Аргачлал | Дүн |
|---|---|---|
| Нийт өөрийн хөрөнгө* | (A) | 475,688 |
| Олон нийтээс татан төвлөрүүлэх дүн | (B) | 35,678 |
| Зах зээлийн үнэлгээ | (C) | 712,678 |
| PBR үржүүлэгч | (D)= C/(A+B) | 1.39 |
| | | |
| | | |

* 2022 оны жилийн эцсийн байдлаарх нийт өөрийн хөрөнгө.

**Хүснэгт2: Нэгж хувьцааны үнэлгээний тооцооллын аргачлал**

*Нэгж: '000, ширхэг, төгрөг*

| Үзүүлэлт | Аргачлал | Дүн |
|---|---|---|
| Нийтэд санал болгох нийт үнэлгээ | (A) | 712,678,000 |
| Нийтэд санал болгохоос өмнөх хувьцааны тоо | (B) | 1,000,000 |
| Нийтэд санал болгох хувьцааны тоо | (C) | 52,700 |
| Нийтэд санал болгосны дараах нийт хувьцааны тоо | (D) = (B) + (C) | 1,052,700 |
| Нэгж хувьцааны үнэлгээ | (E) = (A) / (D) | 677 |

**Хүснэгт3:ХасБанкны хувьцааг нийтэд санал болгосны дараах PER[13] санхүүгийн харьцаа:**

*Нэгж: сая төг*

| Үзүүлэлт | Аргачлал | Дүн |
|---|---|---|
| Нийтэд санал болгохоос өмнөх нийт цэвэр ашиг (2022) | (A) | 105,839 |
| Нийтэд санал болгох нийт үнэлгээ | (B) | 712,678 |
| Нийтэд санал болгосны дараах PER үнэлгээ | (B) / (A) | 6.7 |

[13] Компанийн зах зээлийн үнэлгээг нийт цэвэр ашигт хуваасан харьцаа үзүүлэлт буюу хөрөнгийн зах зээл дээр нээлттэй арилжаалагддаг компаниудыг үнэлгээний хувьд жиших үзүүлэлтээр ашигладаг.

## 5.3 Эрсдэл[14]

Банкны энгийн хувьцаанд хөрөнгө оруулах шийдвэр гаргахаас өмнө энэхүү үнэт цаасны танилцуулга, түүний хавсралт болон дор дурдсан эрсдэл, үүсэж болох тодорхой бус байдлуудын талаар анхааралтай уншиж судлахыг зөвлөж байна. Эрсдэлийн хүчин зүйлүүдэд дурдсан аливаа үйл явдал, нөхцөл байдал дангаараа болон хамт үүссэнээр банкны үйл ажиллагаа, үр дүн, санхүүгийн үзүүлэлт, хэтийн төлөвт ноцтой сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Энэ тохиолдолд энгийн хувьцааны ханш буурч, хөрөнгө оруулалтаа бүхэлд нь эсвэл хэсэгчлэн алдаж болзошгүйг анхаарна уу.

### Эрсдэлийн хүчин зүйлүүд

Үнэт цаас гаргагч, түүний хувьцаа эзэмшигчдийн бүтэц, энгийн хувьцаа, түүнийг санал болгох үйл явцтай холбоотой гол эрсдэлүүдийг дор дурдсан болно. Эрсдэлийн хүчин зүйлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг үнэт цаасны танилцуулгын 9-р бүлэг “Эрсдэлийн хүчин зүйлүүд” хэсгээс авна уу.

1. Макро эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал үүсэх эрсдэл
2. Зээлийн эрсдэл ба зээлийн төвлөрлийн эрсдэл
3. Бизнесийн эрсдэл
4. Хөрвөх чадварын эрсдэл
5. Зах зээлийн эрсдэл
6. Үйл ажиллагааны эрсдэл
7. Нэр хүндийн эрсдэл
8. Зохицуулалт, хууль эрх зүйн болон комплайнстай холбоотой эрсдэл
9. Банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, нийтэд энгийн хувьцааг санал болгох болон нийтэд санал болгохтой холбоотой эрсдэлүүд

### 1 Макро эдийн засаг, санхүүгийн тогтворгүй байдал үүсэх эрсдэл

Монгол Улсын макро эдийн засгийн нөхцөл байдал, дэлхийн болон бүс нутгийн эдийн засгийн ирээдүйн төлөв, Ковид-19 цар тахалын нөлөө зэрэг нь банкны бизнес, санхүүгийн үзүүлэлт, үйл ажиллагаа, үр дүнд материаллаг болон материаллаг бус сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
Санхүүгийн зах зээл дэх үймээн, задрал, бүтцийн сорилтууд, тогтворгүй байдал нь банкны санхүүжилт, банкны бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт сөргөөр нөлөөлж болзошгүй.

### 2 Зээлийн эрсдэл ба зээлийн төвлөрлийн эрсдэл

Банк нь зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйн улмаас алдагдал хүлээж эсхүл хэт их зээлийн төвлөрлийн улмаас эрсдэлд өртөж болох ба энэ нь банкны бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагаа болон хэтийн төлөвийн үр дүнд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй юм.

### 3 Бизнесийн эрсдэл

Банк үйл ажиллагааны стратегийг оновчтой төлөвлөж чадаагүйн улмаас ашигтай ажиллах, орлого олох боломжоо алдах эрсдэлтэй ба банкны үйл ажиллагаатай холбоотой хууль тогтоомжид өөрчлөлт орвол банкны зээл болон лизингийн үйлчилгээнд чухал нөлөө үзүүлж,

[14] Эрсдэлийн талаар дэлгэрэнгүй мэдээллийг Үнэт цаасны танилцуулгаас харна уу.

улмаар банкны бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөвт материаллаг болон материаллаг бусаар сөрөг нөлөөлж болзошгүй.

Банкны салбар нь өрсөлдөөн ихтэй зах зээл учир банкуудын өрсөлдөөн зах зээлд эзлэх байр сууринд нөлөөлөх, банкны бизнес, санхүүгийн байдал, ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Мөн банк нь улс төр, хууль эрх зүй, нийгэм, эдийн засгийн болон бусад олон төрлийн эрсдэлд өртөж болох ба санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг банкуудын хувьд бизнесийн загвараа нөхцөл байдалд тохируулан шинэчилж байхгүй бол дунд болон урт хугацаанд тогтвортой ажиллахад эрсдэл учирч болох юм.

**4 Хөрвөх чадварын эрсдэл**

Хөрвөх чадварын эрсдэл нь банкны хөрөнгийн өсөлтийг санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдалд орох болон хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох эрсдэлд оруулж болох ба энэ нь банкны бизнес, санхүүгийн байдал, ашигт ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлж болзошгүй. Банкны эх үүсвэр харилцагчийн харилцах, хадгаламж болон санхүүгийн байгууллагын санхүүжилт дээр тулгуурладаг. Харилцах, хадгаламж татах болон олон улсын санхүүгийн байгууллагаас санхүүжилт авах боломжгүй болвол банкны хөрвөх чадвар, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнд сөргөөр нөлөөлөх эрсдэлтэй.

Банкны зээлжих зэрэглэл буурах эсвэл буурах магадлалтай болох нь санхүүжилт татах чадавхыг бууруулах, холбогдох зардал нэмэгдэхэд нөлөөлж, улмаар хөрөнгө, санхүүжилт, хөрвөх чадвар зэрэгт сөргөөр нөлөөлөх магадлалтай. Иймд банкны зээлжих зэрэглэл буурах эсвэл буурч болзошгүй нөхцөл байдал үүсэх нь банкны үйл ажиллагаа, ашигт ажиллагаа болон санхүүгийн нөхцөл байдал, үр дүнд сөргөөр нөлөөлж болзошгүй.

**5 Зах зээлийн эрсдэл**

Санхүүгийн зах зээл дээрх сөрөг өөрчлөлт болон үнийн хэлбэлзлээс эдийн засгийн үнэ цэн, орлогын хэмжээнд эрсдэл учирч болох ба зах зээлийн хүү, гадаад валютын ханшийн өөрчлөлт нь Банкны бизнес, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээнд ноцтой болон сөргөөр нөлөөлж болзошгүй.
Банкны зээлийн болон санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд нь хүүгийн эрсдэлийг бий болгодог ба хүүгийн хувь хэмжээний өөрчлөлт нь Банкны хүүгийн цэвэр орлогод тэр даруй нөлөөлдөг бол урт хугацаанд Банкны өөрийн хөрөнгөнд нөлөөлдөг байна.

**6 Үйл ажиллагааны эрсдэл**

Банкны үйл ажиллагааны дотоод процесс, хүний нөөц болон системийн үйл ажиллагаа хангалтгүй буюу доголдолтой, эсвэл гадны хүчин зүйлсийн улмаас (үүнд эрх зүйн эрсдэлийг оролцуулан тооцно) эрсдэлд өртөж болзошгүй. Мөн авилга, залилан болон бусад үйл ажиллагаатай холбоотой аливаа эрсдэл нь Банкны санхүүжилт, үйл ажиллагаа, нэр хүнд, санхүүгийн байдал, ашигт ажиллагаа, үр дүнд сөрөг нөлөө үзүүлж болно.

**7 Нэр хүндийн эрсдэл**

Банкны нэр хүндэд хохирол учрах үйл явдлын улмаас орлогын хэмжээнд алдагдал үүсэх, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөв, санхүүгийн байдалд материаллаг болон материаллаг бус сөрөг нөлөө үүсэж болзошгүй.

**8 Зохицуулалт, хууль эрх зүйн болон комплайнстай холбоотой эрсдэл**

Банк нь зохицуулалттай зах зээлд үйл ажиллагаа явуулдаг учир холбогдох хууль, журамд өөрчлөлт орсноор тухайн зохицуулалтыг хангаж ажиллахад шаардлагатай цаг хугацаа, зардлын улмаас эрсдэл үүсэж болно. Мөн холбогдох зохицуулалт, хууль, журмыг дагаж мөрдөөгүйн улмаас бизнесийн үйл ажиллагаа, нэр хүндэд сөрөг нөлөө үзүүлэх эрсдэлтэй. Банкны комплайнсын үйл ажиллагаа болон хууль тогтоомж, тэдгээрийн тайлбарт гарсан өөрчлөлтүүд нь Банкны үйл ажиллагаа, бизнесийн загвар, санхүүгийн байдал, үр дүн болон хэтийн төлөвт материаллаг болон материаллаг бус сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.

**9 Банкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц, хувьцааг санал болгох, санал болгохтой холбоотой эрсдэлүүд**

Банкны тухай хуульд орсон нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөхийн тулд Банк нь энгийн хувьцаагаа олон нийтэд санал болгох үйл ажиллагааг хэрэгжүүлсний дараа хувьцаа эзэмшигчийн бүтцэд өөрчлөлт орно.
Олон нийтэд хувьцаагаа анх удаа санал болгох үйл ажиллагаанд захиргааны болон хууль эрх зүйн хүчин зүйлээс хамаарсан эрсдэл учирч болох ба энэ нь тус банкны төлөвлөгөө, үйл ажиллагааны үр дүн, хэтийн төлөв, санхүүгийн байдалд материаллаг болон материаллаг бусаар сөрөг нөлөө үзүүлж болзошгүй.
Мөн ирээдүйн жижиг хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн энгийн хувьцааг зах зээл дээр их хэмжээгээр нийлүүлснээр хувьцааны зах зээлийн ханшид сөргөөр нөлөөлөх эрсдэл үүсэж болно. Хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлын улмаас банкны үйл ажиллагаанаас үл хамаарч хувьцааны ханш тогтворгүй болох эрсдэл үүсэж болно.
Үүнээс гадна гадаад валютыг төгрөгт хөрвүүлэн хөрөнгө оруулахаар төлөвлөж буй хөрөнгө оруулагчид нь ирээдүйд ханшийн эрсдэлд орж болзошгүй юм.

### 5.4 Анхдагч зах зээлд байршуулах

Андеррайтер нь үнэт цаас гаргагчийн нийтэд анх удаа санал болгож буй хувьцааг анхдагч зах зээлд байршуулахдаа СЗХ-ны “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.2-т “*Анхдагч зах зээлийн арилжааг Андеррайтер нь үнэт цаасны танилцуулга материалд заасан арга хэлбэрээр нийтэд санал болгон байршуулж, худалдана*” хэмээн заасны дагуу Монголын хөрөнгийн биржийн анхдагч зах зээлийн арилжааны захиалга бүртгэлийн платформыг ашиглан, мөн тус журмын 7.12-т “*.....бусад үнэт цаасны компанийн харилцагчдыг захиалга өгч, хувьцаа худалдан авах тэгш боломжоор хангасан байх......*” хэмээн заасны дагуу бусад үнэт цаасны компанийн оролцоог тэгш боломжоор хангаж ажиллана.

### 5.5 Нийтэд санал болгон гаргах арга, хэлбэр

Үнэт цаас гаргагч нь анхдагч зах зээлийн арилжааг Монголын хөрөнгийн биржийн “Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам”-ын 3-р зүйлийн 3.1.3-т заасны дагуу **ТОГТООСОН ҮНИЙН АРГА** -аар олон нийтэд нээлттэй арилжаалах буюу стртегийн хөрөнгө оруулагчид болон олон нийтэд ижил үнийн аргаар санал болгоно.

Нийтэд санал болгож буй хувьцааны 70%-ийг стратегийн хөрөнгө оруулагчдад, 30%-ийг олон нийтэд хуваарилна.

Стратегийн хөрөнгө оруулагч нь үнэт цаас гаргагчийн алсын хараанд итгэн урт хугацаанд хөрөнгө оруулах зорилготой буюу хоёрдогч зах зээлийн арилжаа нээгдсэнээс хойш 6 сарын хугацаанд үнэт цаасаа зах зээлд нийлүүлэхгүй байхыг хүлээн зөвшөөрсөн, 30,000,000

( гучин сая) төгрөгөөс дээш үнийн дүнд хувьцаа худалдан авах захиалга өгсөн хувь хүн болон хуулийн этгээд байна. Стратегийн хөрөнгө оруулагчдын анхдагч зах зээлийн захиалгыг Үндсэн болон Туслах андеррайтераар дамжуулан авах бөгөөд, олон нийтийн анхдагч зах зээлийн захиалгыг МХБ-ийн гишүүн бүх үнэт цаасны компанудаар дамжуулан авна.

### 5.5.1 Нийтэд санал болгох хувьцаа

| | |
|---|---|
| Үнэт цаас гаргагч | ХасБанк ХХК |
| Үнэт цаасны төрөл | Энгийн хувьцаа |
| Хувьцааны нэрлэсэн үнэ | 100 төгрөг |
| Биржид бүртгүүлэх нийт хувьцааны тоо | 1,052,700,000 ширхэг |
| Нэмж гаргах хувь | 5.0062% |
| Нэмж гаргах хувьцааны нийт тоо | 52,700,000 ширхэг |
| Үүнээс: Стратегийн хөрөнгө оруулагчид | 70%: 36,890,000 ширхэг |
| Олон нийт | 30%: 15,810,000 ширхэг |
| Анхдагч зах зээлд санал болгох үнэ | 677 төгрөг |
| Татан төвлөрүүлэх хөрөнгийн хэмжээ | 35,677,900,000 төгрөг |
| Арилжаалах арга хэлбэр | Тогтоосон үнийн арга |

### 5.5.2 Нийтэд санал болгосны дараах хувь хэмжээ

| Нийтэд санал болгохын өмнө | | | Нийтэд санал болгосны дараа | | |
|---|---|---|---|---|---|
| Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо | % | Хувьцаа эзэмшигч | Хувьцааны тоо | % |
| Тэнгэр Санхүүгийн Нэгдэл | 1,000,000,000 | 100.00% | Тэнгэр Санхүүгийн Нэгдэл | 1,000,000,000 | 94.99% |
| | | | Олон нийт | 52,700,000 | 5.01% |
| **Нийт** | **1,000,000,000** | **100.00%** | **Нийт** | **1,052,700,000** | **100.00%** |

### 5.5.3 Хуваарилах зарчим

МХБ-ийн Анхдагч зах зээлийн арилжааны журмын 3.3 дугаарт заасны дагуу нийтэд санал болгож буй 52,700,000 ширхэг энгийн хувьцааны 70 хувь буюу 36,890,000 ширхэг хувьцааг стратегийн хөрөнгө оруулагчдад, 30 хувь буюу 15,810,000 ширхэг хувьцааг олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн байна.

Стратегийн хөрөнгө оруулагч гэдэгт МХБ-ийн "Үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжааны журам"-ын 3.4 дэх хэсэгт заасан шаардлагыг хангасан, үнэт цаас худалдан авч, хөрөнгө оруулалтаа тогтвортой хадгалах, үнэт цаас гаргагчийн ирээдүйн үйл ажиллагаанд хувь нэмрээ оруулах хүсэл эрмэлзэлтэй хөрөнгө оруулагчийг сонгон авч стратегийн хөрөнгө оруулагчид тооцохоор заасан байна.

#### Стратегийн хөрөнгө оруулагчийн хуваарилалт

| Хөрөнгө оруулагч | Нэгж хувьцааны санал болгох үнэ /Төгрөг/ | Хуваарилах хувьцааны тоо ширхэг | ҮЦТХТ-д тусгаарлалт хийх хугацаа | Нэг хөрөнгө оруулагчид хуваарилах доод хэмжээ /Төгрөг/ | Нэг хөрөнгө оруулагчид хуваарилах дээд хэмжээ /Төгрөг/ |
|---|---|---|---|---|---|
| Үнэ цэнтэй харилцагчид | 677.00 | 26,202,289 | 6 сар | 30,000,000 | 1,000,000,000 |

2023 05 12
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE
РАЙНОС ИНВЕСТМЕНТ ҮЦК ХХК
ХАСБАНК

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Үнэт цаас гаргагчийн ажилтнууд | 677.00 | 10,540,000 | 12-24 сар | 1,000,000 | 200,000,000 |
| Үндсэн Андеррайтер | 677.00 | 147,711 | 12 сар | | |
| **Нийт** | | **36,890,000** | | | |

Үүнд үнэт цаас гаргагчийн нөхцлийг хангасан стратегийн хөрөнгө оруулагчдын захиалгыг бүтэн үнийн дүнгээр биелүүлэх зарчмыг баримтлах ба олон нийтийн анхдагч зах зээлийн захиалгын үнийн дүн нь санал болгож буй үнийн дүнгээс давсан тохиолдолд захиалга өгсөн хөрөнгө оруулагчдын тооноос хамаарч тодорхой тооны хувьцааны захиалгыг бүрэн биелүүлж, түүнээс дээш давсан захиалгыг хувь тэнцүүлэх зарчмаар биелүүлнэ.

Бүрэн биелүүлэх захиалгын хэмжээ ба хөрөнгө оруулагчдын тоо

| Хөрөнгө оруулагчдын тоо | Бүрэн биелүүлэх хувьцааны тоо ширхэг | Нэгж хувьцааны үнэ | Бүрэн биелүүлэх захиалгын үнийн дүн |
|---|---|---|---|
| 1 - 5,000 | 3,160 | 677 | 2,139,320 |
| 5,001 - 10,000 | 1,580 | 677 | 1,069,660 |
| 10,001 - 15,000 | 1,050 | 677 | 710,850 |
| 15,001 - 20,000 | 790 | 677 | 534,830 |
| 20,001 - 30,000 | 520 | 677 | 352,040 |
| 30,001 - 40,000 | 390 | 677 | 264,030 |
| 40,001 - 50,000* | 310 | 677 | 209,870 |

*50,001 ба түүнээс дээш тооны хөрөнгө оруулагчид худалдан авах захиалга ирүүлсэн тохиолдолд хувь тэнцүүлэн хуваарилах зарчмыг баримтална.

### 5.5.4 Андеррайтерийн худалдан авах хэмжээ

Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.5.3 болон 7.6-т заасны дагуу Андеррайтер нь хувьцааг анхдагч зах зээлд санал болгон худалдах ажиллагааг идэвхижүүлэх зорилгоор үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцаанаас нийт 100,000,000 /нэг зуун сая/ төгрөгийн үнийн дүнд стратегийн хөрөнгө оруулагчийн нөхцлөөр худалдан авахаар шийдвэрлэсэн байна.

## 5.6 Татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалт

Үнэт цаас гаргагч нь нийтэд хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгон татан төвлөрүүлсэн хөрөнгийг үндсэн үйл ажиллагаа буюу зээлийн болон лизингийн үйлчилгээний эх үүсвэрт ашиглахаар үнэт цаасны танилцуулга материалд тусгасан байна.

## 5.7 Нэгдсэн дүгнэлт

Үндсэн андеррайтер болох Райнос Инвестмент ҮЦК ХХК нь үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаатай танилцан, үнэт цаас гаргагчийн зах зээлд хэрэгжүүлж буй бизнесийн стратеги, үйл ажиллагаа явуулж буй зах зээлийн нөхцөл байдал, түүнд эзлэх үнэт цаас гаргагчийн байр сууриь, зах зээлийн шинжилгээ, хөндлөнгийн мэргэжлийн байгууллагуудын тайлан дүгнэлт, хөрөнгийн зах зээлийн өнөөгийн төлөв байдал, зах зээлийн багтаамж, нийгэм эдийн засгийн төлөв цаашдын хандлага зэргийг судлан шинжилсний үндсэн дээр **Үнэт цаас гаргагчийн "Нийтэд санал болгон анх удаа энгийн хувьцаа гаргах төлөвлөгөө"-нь хэрэгжих боломжтой гэж дүгнэж байна.** Банкуудын хувьд бизнес төлөвлөгөө хэрэгжихэд нөлөөлдөг хамгийн чухал үзүүлэлтүүдийн нэг нь хангалттай эх үүсвэр татаж чадах эсэх

асуудал байдаг билээ. ХасБанк нь 2022 оны 12 сарын 28-ны өдөр Дэлхийн Банкны гишүүн байгууллага болох Олон Улсын Санхүүгийн Корпораци-аас 130 сая ам.доллар хүртэл дүнтэй синдикат зээлийн санхүүжилт авах гэрээнд гарын үсэг зурсан явдал нь ирэх жилийн төлөвлөгөөгөө биелүүлэх үндсэн эх үүсвэрээ баталгаажуулсан явдал болсон байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлаас 2021 оны 01 сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль болон түүнийг дагаж мөрдөх журамд банкны хувьцаа эзэмшлийн төвлөрлийг бууруулах хүрээнд Банкны системд нөлөө бүхий банкны аливаа нэг хувьцаа эзэмшигч дангаараа болон холбогдох этгээдийн хамтаар тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20-с ихгүй хувийг эзэмших бөгөөд энэхүү заалтыг хэрэгжүүлэх эцсийн хугацаа нь 2023 оны 12 сарын 31-ний өдөр байна хэмээн заасан.
ХасБанкны хувьд Банкны системд нөлөө бүхий банкууд дунд энэхүү шаардлагыг хангах нөхцөл бүрдсэн Цорын ганц банк гэдэг нь хөрөнгө оруулагчдын хувьд таатай үзүүлэлт юм.

Нийтэд санал болгон гаргах үнэт цаасны танилцуулгыг бэлтгэж буй өдрийн байдлаар гаргаж буй энэхүү **дүгнэлт нь үнэт цаас гаргагчийн ирээдүйн санхүүгийн төсөөллийн баталгаа болохгүйг** анхаарч хөрөнгө оруулалтын шийдвэрээ гаргахыг зөвлөж байна.

# ХАВСРАЛТ 5: Үнэлгээний компанийн дүгнэлт болон тусгай зөвшөөрөл

XACBANK

2023.05.12

*Нууцлалын гэрээгээр хатуу хязгаарлагдсан*

# ХАСБАНК

## *2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх*
## *Өмчийн үнэлгээний тайлан*
## *(Хөрөнгийн үнэлгээг багтаасан)*

*БДО Аудит ХХК*

*Монгол Улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох БДО Аудит ХХК нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн мөн.*

*Энэхүү тайлан нь Хавсралт I-д заасан Үнэлгээний хязгаарлалтын нөхцөл болон Удирдлагад хаягласан захидалд тусгасан үнэлгээний зорилгын дагуу бэлтгэгдсэн. Таны хэрэгцээнд зориулж энэ тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлж байна. Зөвхөн гарын үсэг зурж, тамга дарсан хувилбар нь хүчин төгөлдөр болно.*



BDO

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ

Монгол улс, Улаанбаатар хот
СБД-1, ЮНЕСКО-гийн гудамж
Нарны зам-62, Юнион Бюлдинг
В блок, 15-р давхар, 1502 тоот

**ХасБанк ХХК**
Улаанбаатар-14210, Жамьян Гуний гудамж-9,
20А шуудангийн салбар, ш/х-72,
Олон Улсын Худалдааны Төвийн ХасБанкны төв байр

ХАСБАНК ХХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Г.ЦЭВЭГЖАВ ТАНАА:

Огноо: 2023 оны 3 дугаар сарын 24-ний өдөр

2023 оны 02 дугаар сарын 02-ны өдөр БДО ба ХасБанкны хооронд байгуулсан Бизнесийн болон Хөрөнгийн үнэлгээ хийх гэрээ (цаашид "Гэрээ" гэх)-нд заасны дагуу бид ХасБанк (цаашид "Банк" эсхүл "ХасБанк" гэх)-ны 2022 оны 12-р сарын 31-ний өдрийн (цаашид "Үнэлгээний өдөр" гэх) нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн үнэлгээ (цаашид "Бизнес" гэх)-г хийж, үнэлгээний тайланг үүгээр танилцуулж байна.

Энэхүү үнэлгээний ажлын даалгавар (цаашид "Үнэлгээ" гэх) нь ХасБанк хувьцаагаа анх удаа олон нийтэд санал болгож, Монголын Хөрөнгийн Биржид бүртгүүлэх ажилд туслах зорилготой байсан. Үнэлгээний олон улсын стандарт 2022-ийн ҮОУС 200 ***Бизнес ба Бизнесийн хувь оролцоо***-ын 20.6(г)-т заасны дагуу бидний энэхүү тайлангаар тайлагнасан үнэ цэнэ нь *"өмчийн бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнэ"* болно.

Энэхүү тайланд хийгдсэн бүх санхүүгийн төсөөллүүд болон хэтийн шинжилгээ нь ХасБанкны банкны бизнесийг хамарсан болно.

Бид үнэлгээний шинжилгээндээ авч үзсэн үнэлгээний үр дүн, дэвшүүлсэн төсөөлөл, арга зүйн тайлбар болон бусад хүчин зүйлсийг энэхүү тайландаа оруулсан болно. Мөн бид ашигласан мэдээллийн эх сурвалж болон ажлын цар хүрээг аливаа хязгаарлалтын хамтаар энэхүү тайлангийн Хавсралт I-с X-т багтаасан. Гэрээний бүх нөхцөл, болзол болон Хавсралтуудад дурдсан хязгаарлалтын нөхцөл нь энэхүү тайлангийн салшгүй хэсэг болно.

Тайланд тусгагдсан холбогдох шинжилгээ нь Банкны удирдлагаас бидэнд өгсөн мэдээлэлд үндэслэсэн. Бид өөрсдийн үнэлгээний дүгнэлтэд мэргэжлийн шүүн тунгаалт болон шийдлүүдийг ашиглан тооцсон тул бусад үнэлгээчид бидэнтэй яг ижил дүгнэлт гаргахгүй байж болно гэдгийг хүлээн зөвшөөрч байна.

Бидэнд банкнаас өгсөн мэдээлэл, тэдгээрийн талаар дэвшүүлсэн үндсэн болон тусгай төсөөллүүдэд суурилан, энэхүү тайланд тооцоолсон үнэ цэнэ нь ул үндэслэлтэй гэж бид дүгнэсэн.

Хэрэв танд аливаа тайлбар эсвэл дэлгэрэнгүй мэдээлэл шаардлагатай бол Г.Баянмөнх (+976 8888 4041, bayanmunkh@bdo.mn), эсхүл Д.Алтансүх (+976 8888 1614, altansukh@bdo.mn) нартай холбогдоно уу.

Таныг хүндэтгэсэн,

Гомбын БАЯНМӨНХ
Үнэлгээний партнер
МНБ, Тэргүүлэх үнэлгээчин
БДО Аудит ХХК

Даланбаярын Алтансүх
Гүйцэтгэх захирал
МНБ, CGMA
БДО Аудит ХХК

СЗХ 2023.05.12 БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

## Тайланд баггсан онцлог үг хэллэг болон үгийн тайлал

| Товчилсон үг | Утга |
|---|---|
| АХБ | Азийн Хөгжлийн Банк |
| БДО Монгол (Бид) | БДО Аудит ХХК; Улсын бүртгэлийн 2546442 регистрийн дугаартай, аудит, үнэлгээний зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл бүхий аж ахуйн нэгж |
| Биет данс(Биет дансны үнэ) | Бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах өмчийн дансны үнээс биет бус хөрөнгийн дансны үнийг хассан дүн. |
| ГШХО | Гадаадын шууд хөрөнгө оруулалт |
| Гэрээ | 2023 оны 02-р сарын 02-ны өдөр БДО болон ХасБанкны хооронд байгуулсан зөвлөх үйлчилгээний гэрээ. |
| Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл | ХасБанкны удирдлагын боловсруулсан тус Банкны 2023-2027 оны санхүүгийн төлөвлөгөө |
| Дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа | Implied P/B харьцаа. Өмчийн үнэлгээний үр дүнг үнэлж буй бизнесийн эздийн өмчид харьцуулсан харьцаа. Тараахаар төлөвлөж буй ногдол ашиг болон үнэлгээ нь IPO-н өмнөх эсвэл IPO-н дараах байдлыг илэрхийлж байгаагаас шалтгаалан эздийн өмчид тохируулга орох тохиолдол байдаг. |
| ЕСБХБ | Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD) |
| ЖААЗ | Жишиг арилжааны арга зүй |
| Жишиг компаниуд | Хавсралт VII-д заасан жишиг компаниуд |
| ЖКАЗ | Жишиг компанийн арга зүй |
| ЖНӨХ (CAGR) | Жилийн нийлмэл өсөлтийн хувь |
| Зах зээлийн хандлага | Зах зээл дээрх өгөгдлөөс үүссэн үнэлгээний үржүүлэгч, өмнөх арилжааны харьцуулалтад үндэслэдэг үнэлгээний хандлага |
| КЖДӨ | Капиталын жинлэсэн дундаж өртөг |
| КХҮЗ | Капитал хөрөнгийн үнэлгээний загвар |

| Товчилсон үг | Утга |
|---|---|
| МБ | Монголбанк |
| МБХ | Монголын Банкны Холбоо |
| МХБ | Монголын Хөрөнгийн Бирж |
| НАХ загвар | Ногдол Ашиг Хорогдуулах загвар нь ирээдүйн ногдол ашгуудыг өмчийн өртгийг ашиглан хорогдуулах замаар өмчийн өнөөгийн үнэ цэнийг тооцоолдог арга / Dividend Discount Model |
| Ойрын ирээдүй | Үйлчлүүлэгчийн бизнесийн үйл ажиллагаар тасралтгүй үргэлжилнэ гэж төсөөлсөн прогнозын хугацаа |
| Орлогын хандлага | Бизнесийн нэгжийн бий болгох ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэд үндэслэдэг үнэлгээний хандлага |
| ОУВС | Олон Улсын Валютын Сан (IMF) |
| ОУСК | Олон Улсын Санхүүгийн Корпорац (IFC) |
| Өмчийн үнэ цэнэ | Компанийн бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарах бизнесийн үнэ цэнэ |
| ӨҮЦ | Өнөөгийн үнэ цэнэ |
| ӨХХХ | Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа |
| ӨХЧМУ | Өмчид хамаарах чөлөөт мөнгөн урсгал буюу компанийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах мөнгөн урсгал (FCFE) |
| СЗХ | Санхүүгийн Зохицуулах Хороо |
| Төгрөг | Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт |
| ТҮЦ | Терминал үнэ цэнэ / Terminal Value |
| ТЦХА | Тохируулсан цэвэр хөрөнгийн арга (ANAV) |
| Удирдлага | ХасБанк ХХК-ийн гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав болон Банкны гүйцэтгэх удирдлагын баг |

## Тайланд багтсан онцлог үг хэллэг болон товчилсон үгийн тайлал

| Товчилсон үг | Утга |
| --- | --- |
| Үлдэгдэл Ашгийн загвар (ҮАЗ) | Энэ арга нь үнэлгээний өдрийн байдлаарх хувьцаа эзэмшигчдийн өмч болон ирээдүйн төсөөллийн хугацааны турших өмчийн өртгөөс давсан өгөөжийн зөрүүний дүнгийн өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг ашиглан компанийн өмчийн үнэ цэнийг тооцоолдог санхүүгийн байгууллагад өргөн хэрэглэгддэг бизнесийн үнэлгээний арга |
| ҮА | Үлдэгдэл ашиг буюу Residual income. Өмчийн өртгийг давсан өмчийн өгөөжид ногдох цэвэр ашгийн хэмжээ. |
| Үнэ/Ашиг харьцаа | Нэгж хувьцааны зах зээлийн үнийг нэгж хувьцаанд ногдох ашигт харьцуулсан харьцаа / Price-to-Earning харьцаа буюу P/E харьцаа |
| Үнэ/Данс харьцаа | Нэгж хувьцааны зах зээлийн үнийг нэгж хувьцааны дансны үнэд харьцуулсан харьцаа / Price-to-Book харьцаа буюу P/B харьцаа |
| Үнэ/Биет Данс харьцаа | Нэгж хувьцааны зах зээлийн үнийг нэгж хувьцааны биет дансны үнэд харьцуулсан харьцаа / Price-to-Tangible Book харьцаа буюу P/TB харьцаа. Зах зээлийн жишиг компаниуд нь ихээхэн биет бус хөрөнгөтэй үед биет бус хөрөнгөд хамаарах үнэ цэнийн нөлөөг арилгахын тулд энэ үржүүлэгчийг хэрэглэдэг. |
| Үнэлгээний баг | Хавсралт IV-т тодорхойлсон БДО Монголын үнэлгээний зөвлөх үйлчилгээний баг |
| Үнэлгээний өдөр | 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдөр |
| ҮОУС | Үнэлгээний олон улсын стандартын консулаас бэлтгэн толилуулдаг Үнэлгээний Олон Улсын Стандарт |
| ХМУ-ын арга | Урьдчилан төсөөлсөн мөнгөн урсгалыг үнэлгээний өдөр хүртэл хорогдуулснаар хөрөнгийн болон бизнесийн өнөөгийн үнэ цэнийг тодорхойлдог хорогдуулсан мөнгөн урсгалын арга (DCF) |
| IPO | Хувьцаагаа олон нийтэд анх удаа санал болгон гаргах (Initial Public Offering) |
| Post-money (IPO-н дараах) | IPO-оор хувьцаа гаргаж хөрөнгө татсаны дараах үр дүн |

| Товчилсон үг | Утга |
| --- | --- |
| Pre-money (IPO-н өмнөх) | IPO-оор хувьцаа гаргаж хөрөнгө татахын өмнөх үр дүн |

СЗХ 2023.05.12 БҮРТГЭВ № 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

323



BDO

## Тайлангийн агуулга


1. Үр дүнгийн хураангуй ... 7
2. Ажлын цар хүрээ ... 10
   - 2.1 Үйлчлүүлэгчийн мэдээлэл ... 11
   - 2.2 Зориулагдсан хэрэглээ ... 12
   - 2.3 Үнэлгээний даалгавар ... 12
   - 2.4 Хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргах үйл ажиллагаа ... 13
   - 2.5 Мэргэшсэн үнэлгээчид ... 13
   - 2.6 Тусгай зохицуулалтууд ... 13
   - 2.7 Үнэ цэнийн суурь ... 14
   - 2.8 Үндсэн төсөөллүүд ... 15
   - 2.9 Тусгай төсөөллүүд ... 16
   - 2.10 Үнэлгээний тайлангийн нягтлан шалгалт ... 16
   - 2.11 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал ... 16
3. Эдийн засаг, салбарын тойм ... 17
   - 3.1 Монгол улсын эдийн засаг ... 18
   - 3.2 Монгол улсын банкны салбарын өнөөгийн нөхцөл байдал ... 21
4. Санхүүгийн мэдээлэл ... 24
   - 4.1 Санхүүгийн мэдээлэл ... 25
5. Үнэлгээний шинжилгээ ... 31
   - 5.1 Үнэлгээний хандлага, аргууд ... 32
   - 5.2 Зах зээлийн хандлага ... 32
   - 5.3 Орлогын хандлага ... 35
     - 5.3.1 Хорогдуулах хувь ... 35
     - 5.3.2 Хяналтгүй хувь оролцооны хямдруулалт ... 40
6. Өмчийн үнэлгээ ... 41
   - 6.1 Орлогын хандлага ... 42
     - 6.1.1 Үлдэгдэл Ашгийн загвар-БДО-ийн дүгнэлт гаргасан хувилбар ... 42
     - 6.1.2 Үлдэгдэл Ашгийн загвар-Банкны бизнес төлөвлөгөөнд суурилсан хувилбар ... 45
     - 6.1.3 Ногдол Ашиг Хорогдуулах загвар ... 47
   - 6.2 Зах зээлийн хандлага ... 49
     - 6.2.1 Жишиг компанийн арга зүй ... 49
   - 6.3 Өмчийн үнэлгээний үр дүн ... 50
     - 6.3.1 IPO-н өмнөх байдлаарх үнэлгээний тооцооллын үр дүн ... 50
     - 6.3.2 IPO-н дараах байдлаарх үнэлгээний тооцооллын үр дүн ... 51
7. Хавсралт ... 53

Хүснэгт 1. ХасБанкны өмчийн зах зээлийн үнэ цэнийн тооцооллын хураангуй үр дүн . 7
Хүснэгт 2. ХасБанкны нийт өмчийн зах зээлийн үнэ цэнийн дүгнэлт гаргасан аргын IPO-ийн өмнөх ба дараах тооцооллын хүрээ ... 8
Хүснэгт 3. ХасБанкны өмчийн зах зээлийн үнэ цэнийн дүгнэлт гаргасан аргын IPO-ийн өмнөх ба дараах тооцооллын үр дүнд хамаарах дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа ... 8
Хүснэгт 4. Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигчид буюу ХасБанкны эцсийн өмчлөгчид ... 11
Хүснэгт 5. 2022 оны 12-р сарын 31 өдрөөрх ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл.... 12
Хүснэгт 6. IPO гаргасны дараах хувьцааны тоо ширхэг ... 13
Хүснэгт 7. Мөнгөний зах зээлийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)... 18
Хүснэгт 8. Жил бүрийн 12 сарын ам.доллартой харьцах төгрөгийн нэрлэсэн хаалтын ханш (2010-2022)... 19
Хүснэгт 9. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл ... 19
Хүснэгт 10. Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс, нэгжээр... 20
Хүснэгт 11. ХасБанкны санхүүгийн үндсэн харьцаанууд... 28
Хүснэгт 12. ХасБанкны санхүүгийн байдлын тайлан (проформа) ... 29
Хүснэгт 13. Хасбанкны орлогын тайлан (проформа) ... 30
Хүснэгт 14. Жишиг компаниудыг сонгох шалгуур ... 33
Хүснэгт 15. Сонгогдсон жишиг компаниуд ба тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүд ... 34
Хүснэгт 16. Эрсдэлгүй хүүгийн тооцоолол ... 36
Хүснэгт 17. Системийн нөлөө бүхий арилжааны банкуудын урт хугацаат хадгаламжийн зарласан хүү... 36
Хүснэгт 18. Жишиг компаниудын хөшүүрэггүй бета ... 38
Хүснэгт 19. Тохируулсан бета-н тооцоолол ... 38
Хүснэгт 20. Өмчийн өртгийн тооцоолол... 38
Хүснэгт 21. Үлдэгдэл Ашгийн загварт ашигласан өсөлтийн төсөөлөл ... 42
Хүснэгт 22. Үлдэгдэл Ашгийн загварт ашиглагдсан санхүүгийн төсөөлөл ... 42
Хүснэгт 23. Үлдэгдэл Ашгийн загварт ашиглагдсан терминал үнэ цэнийн тооцоолол 42
Хүснэгт 24. Үлдэгдэл Ашгийн өнөөгийн үнэ цэнийн тооцоолол ... 42
Хүснэгт 25. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх)... 43
Хүснэгт 26. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх)... 43
Хүснэгт 27. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон өмчийн үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н өмнөх)... 43
Хүснэгт 28. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ ... 43
Хүснэгт 29. Үлдэгдэл Ашгийн загварт ашиглагдсан банкны санхүүгийн төсөөлөл ... 45
Хүснэгт 30. Терминал үнэ цэнийн тооцоолол-Банкны хувилбар ... 45
Хүснэгт 31. Үлдэгдэл Ашгийн өнөөгийн үнэ цэнэ (Банкны хувилбар) ... 45
Хүснэгт 32. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (Банкны хувилбар, IPO-н өмнөх) ... 45
Хүснэгт 33. Үлдэгдэл Ашгийн загвар: Банкны төсөөлөлд суурилсан хувилбараар тооцсон өмчийн үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н өмнөх) ... 46
Хүснэгт 34. Үлдэгдэл Ашгийн загвар: Банкны төсөөлөлд суурилсан хувилбараар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ ... 46
Хүснэгт 35. Ногдол ашгийн төсөөлөл... 47
Хүснэгт 36. Терминал үнэ цэнийн тооцоолол (НАХ загвар) ... 47
Хүснэгт 37. Ногдол ашгийн өнөөгийн үнэ цэнэ (НАХ загвар) ... 47
Хүснэгт 38. НАХ загвараар тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх) ... 47
Хүснэгт 39. НАХ загвараар тооцсон нэгж хувьцааны өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх)... 48
Хүснэгт 40. НАХ загвараар тооцсон хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н өмнөх) ... 48
Хүснэгт 41. НАХ загвараар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н өмнөх)... 48
Хүснэгт 42. Жишиг компаниудын үзүүлэлтүүд ... 49
Хүснэгт 43. Үнэ/Биет Данс үржүүлэгч ашиглан тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх) ... 49
Хүснэгт 44. Үнэ/Ашиг үржүүлэгч ашиглан тооцоолсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх)... 49
Хүснэгт 45. IPO-н өмнөх болон дараах үнэлгээний суурь хувилбаруудын үр дүн ... 51
Хүснэгт 46. Жишиг компаниудын мэдээлэл... 63
Хүснэгт 47. Хувьцаа эзэмшигчдийн өмчийн үнэ цэнэд хийсэн тохируулга ... 66
Хүснэгт 48. Үндсэн хөрөнгө болон Ашиглах эрхтэй хөрөнгийн зах зээлийн тооцоолсон үнэ цэнэ ... 67
Хүснэгт 49. Зах зээлийн үнэ цэнээр үнэлэгдсэн үл хөдлөх хөрөнгийн жагсаалт (сая төгрөгөөр) ... 68

## Графикийн жагсаалт

График 1. ХасБанкны IPO гаргасны дараах өмчийн зах зээлийн үнэ цэнэ (сая төгрөг) .. 9
График 2. ХасБанкны нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (төгрөг) .......... 9
График 3. Дотоодын нийт бүтээгдэхүүн .......... 18
График 4. Экспорт болон импорт (тэрбум доллар) .......... 19
График 5. Банкуудын зах зээлд эзлэх хувь, нийт хөрөнгөөр (2022 оны байдлаар) .......... 21
График 6. Арилжааны банкуудын нийт хөрөнгө (тэрбум төгрөг) .......... 22
График 7. Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг) .......... 22
График 8. Банкуудын чанаргүй зээлийн харьцаа .......... 22
График 9. Банкуудын хувьцаа эзэмшигчдийн өмч (тэрбум төгрөг) .......... 23
График 10. Банкуудын цэвэр ашиг (тэрбум төгрөг) .......... 23
График 11. Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа .......... 23
График 12. Банкуудын хөрвөх чадварын харьцаа .......... 23
График 13. Нийт хөрөнгө болон хувьцаа эзэмшигчдийн өмч (тэрбум төгрөг) .......... 25
График 14. Нийт зээл болон харилцах, хадгаламж (тэрбум төгрөг) .......... 25
График 15. Өр/Өмч харьцаа ба Нийт эх үүсвэрт өөрийн хөрөнгийн эзлэх хувь .......... 26
График 16. Хүүгийн орлого болон зардал (тэрбум төгрөг) .......... 26
График 17. Цэвэр ашиг ба өмчийн өгөөж (тэрбум төгрөг, хувиар) .......... 27
График 18. IPO-н өмнөх ХасБанкны өмчийн зах зээлийн үнэ цэнэ (сая төгрөг) .......... 50
График 19. ХасБанкны IPO-н дараах өмчийн зах зээлийн үнэ цэнэ (сая төгрөг) .......... 52
График 20. ХасБанкны нэгж хувьцааны тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ (төгрөг) ..... 52
График 21. ХасБанкны удирдлага, зохион байгуулалтын бүтэц .......... 62

## 1. Үр дүнгийн хураангуй

### *ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ*

- Тус Банкнаас бидэнд ирүүлсэн тус Банкны IPO-д зориулсан санхүүгийн төсөөллийн хувилбар болон Банкны төсөөллийг зах зээлийн оролцогчийн байр суурьнаас засварласан төсөөллийн хувилбаруудыг ашиглан үнэлгээний орлогын хандлагын Үлдэгдэл Ашгийн загвараар Банкны бүх хувьцаа эзэмшигчдэд хамаарх өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолсон. Үлдэгдэл Ашгийн загварын тооцооллоос гарсан үр дүнг бизнес төлөвлөгөөнд тусгасан Банкны төсөөлөл ашигласан Үлдэгдэл Ашгийн загвар, 2024 оноос эхлэн хуваарилах Банкны ногдол ашгийг төлөвлөгөөг ашиглан НАХ загвар болон Зах зээлийн хандлагын ЖКАЗ-г ашиглан тус тус баталгаажуулсан. Суурь хувилбарын тооцооллын хураангуй үр дүнг Хүснэгт 1-д харуулав.

- Үнэлгээний дүгнэлтийн дээд, доод хүрээг тооцоход дараах алхмуудыг хэрэгжүүлсэн. Үүнд:
  1. ХасБанк ХХК-аас ирүүлсэн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2023-2027)-ийн суурь хувилбар болон 20.3%-ийн хорогдуулах хувь (өмчийн өртөг)-ийг ашиглан үнэлгээний Орлогын хандлагын Үлдэгдэл Ашгийн загвараар IPO гаргахаас өмнөх (pre-money) хувьцаа эзэмшигчдийн өмчийн үнэ цэнийг тооцоолоход 676,950 сая төгрөг байна;
  2. Хувьцаа эзэмшигчийн өмчийн дээд ба доод үнэ цэнийн хязгаарыг тооцохдоо Үлдэгдэл Ашгийн загварт ашигласан орц мэдээллийн хувьд урт хугацааны 5%-ийн тогтмол өсөлттэй үед хорогдуулах хувийг суурь тооцоололд сонгосон 20.3%-иас 1%-иар нэмэгдүүлсэн болон бууруулсан хувилбараар шинжилсэн;
  3. Эцэст нь, бид тус Банкны МХБ дээр шинээр анх удаа хувьцаа гаргах төлөвлөгөөнд үндэслэн IPO гаргасны дараах байдлаарх (post-money) үнэ цэнийн хүрээг тооцсон.

- IPO гаргахын өмнөх байдлаар: ХасБанк ХХК-ийн нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь Үнэлгээний өдрийн байдлаар ойролцоогоор **620,000 сая төгрөгөөс 742,000 сая төгрөгийн хооронд (суурь хувилбар: 677,000 сая төгрөг), нэгж хувьцааны үнэ цэнэ нь 620 төгрөгөөс 742 төгрөгийн хооронд (суурь хувилбараар 677 төгрөг)** байх үндэслэлтэй байна.

*Хүснэгт 1. ХасБанкны өмчийн зах зээлийн үнэ цэнийн тооцооллын хураангуй үр дүн*

| *IPO гаргахын өмнөх үнэлгээ* | *Нэгж* | *Үнэ цэнэ* |
|---|---|---|
| Эрсдэлгүй өгөөжийн хувь хэмжээ | % | 11.95% |
| Өмчийн эрсдэлийн шагнал | % | 10.12% |
| Дахин хөшүүрэгдсэн бета | коэф. | 0.60 |
| Тухайн банканд хамаарах эрсдэлийн шагнал | % | 2.25% |
| **Өмчийн өртөг** | **%** | **20.30%** |
| Урт хугацааны тогтмол өсөлт | % | 5% |
| Өмчийн өгөөж (2023-2027) | % | 24.1%-25.8% |
| Хувьцаа эзэмшигчдийн өмч (Үнэлгээний өдрөөр) | сая төгрөг | 475,687 |
| 2027 он хүртэлх ҮА-ийн өнөөгийн үнэ цэнэ | сая төгрөг | 97,417 |
| Терминал үнэ цэнийн ӨҮЦ | сая төгрөг | 103,846 |
| **100%-ийн өмчийн хувь оролцоонд хамаарах тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх байдлаар)** | сая төгрөг | **676,950** |
| **Бүхэлд шилжүүлснээр** | сая төгрөг | **677,000** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

*Хүснэгт 2. ХасБанкны нийт өмчийн зах зээлийн үнэ цэнийн дүгнэлт гаргасан аргын IPO-ийн өмнөх ба дараах тооцооллын хүрээ*

| *IPO гаргасны дараах үнэлгээ*[1] | *Нэгж* | *Доод хязгаар* | *Суурь үнэлгээ* | *Дээд хязгаар* |
|---|---|---|---|---|
| Өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO гаргахаас өмнө) | сая төгрөг | 620,299 | 676,950 | 741,695 |
| **Бүхэлд шилжүүлснээр** | **сая төгрөг** | **620,000** | **677,000** | **742,000** |
| Хувьцааны тоо | нэгж | | 1,000,000,000 | |
| **Нэгж хувьцааны тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ** | **Төгрөг** | **620** | **677** | **742** |
| **Татан төвлөрүүлэх хөрөнгө** | сая төгрөг | 32,674 | 35,678 | 39,103 |
| **Өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO гаргасны дараа)** | **сая төгрөг** | **652,674** | **712,678** | **781,103** |
| Хувьцааны тоо (IPO гаргасны дараа) | нэгж | | 1,052,700,000 | |
| **Нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ** | **төгрөг** | **620** | **677** | **742** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

### *IPO гаргасны дараах үнэлгээний хүрээ*

- Бид үнэлгээний дүгнэлтэд ашигласан Үлдэгдэл Ашгийн загварын үр дүнг Банкны бизнес төлөвлөгөөнд тусгагдсаны дагуу хэвээр нь тооцоолж өөрсдийн тооцооллыг нягтлахын сацуу, ЖКАЗ-ын Үнэ/Биет Данс, Үнэ/Ашиг үржүүлэгч болон НАХ загварыг ашиглан баталгаажуулсан.

- Бид дараах шалтгааны улмаас ЖКАЗ болон НАХ загварыг үнэлгээний үндсэн арга болгон ашиглаагүй. Үүнд: (i) тус Банктай харьцуулах боломжтой, дотоодын хөрөнгийн биржид бүртгэлтэй банкуудын бирж дээр хувьцаа нь арилжаалагдсан хугацаа хэт богино учраас үнэ нь хангалттай тогтворжоогүй, бүртгэлтэй банкуудын тоо хангалттай олон байгаагүй; ба (ii) тус Банк нь ногдол ашиг тарааж байсан хангалттай урт хугацааны түүхгүй.

*Хүснэгт 3. ХасБанкны өмчийн зах зээлийн үнэ цэнийн дүгнэлт гаргасан аргын IPO-ийн өмнөх ба дараах тооцооллын үр дүнд хамаарах дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа*

| *Дүйцүүлсэн Үнэ /Данс харьцаа* | *Нэгж* | *Доод хязгаар* | *Суурь үнэлгээ* | *Дээд хязгаар* |
|---|---|---|---|---|
| **IPO гаргахаас өмнөх:** | | | | |
| Өмчийн зах зээлийн үнэ цэнэ | сая төгрөг | 620,000 | 677,000 | 742,000 |
| Хувьцаа эзэмшигчдийн өмч | сая төгрөг | 475,687 | 475,687 | 475,687 |
| Дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа | | 1.30x | 1.42x | 1.56x |
| Татан төвлөрүүлэх хөрөнгө | сая төгрөг | 32,674 | 35,678 | 39,103 |
| **IPO гаргасны дараах:** | | | | |
| Өмчийн зах зээлийн үнэ цэнэ | сая төгрөг | **652,674** | **712,678** | **781,103** |
| Хувьцаа эзэмшигчдийн өмч | сая төгрөг | 508,335 | 511,316 | 514,724 |
| Дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа | | 1.28x | 1.39x | 1.52x |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- ***Банкны бизнес төсөвлөлд суурилсан Үлдэгдэл Ашгийн загвар:*** бид Банкнаас ирүүлсэн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан цэвэр ашгийн төсөөллийг бид тэр хэвээр нь ашиглаж Үлдэгдэл Ашгийн загвараар Банкны IPO-ийн дараах 100%-ийн өмчийн үнэ цэнийн хүрээг тооцоолсон. IPO гаргасны дараах нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь Банкны хувилбараар ойролцоогоор 683,000 сая төгрөгөөс 817,000 сая төгрөгийн хооронд, нэгж хувьцааны үнэ цэнэ нь 649 төгрөгөөс 776 төгрөг гэж тооцоолсон.

- ***ЖКАЗ:*** Олон улсын хөрөнгийн биржүүд болон МХБ-д бүртгэлтэй ижил төстэй 15 банкийг жишиг компани болгон сонгосон. IPO гаргасны дараах байдлаар:

    - Жишиг банкуудын Үнэ/Биет Данс үржүүлэгчийн доод ба дээд квартил утгыг ашиглан 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг ойролцоогоор 477,000 сая

[1] *Дээд хязгаарыг хорогдуулах хувийг 1%-иар бууруулахад, доод хязгаар хорогдуулах хувийг 1%-иар өсгөж төсөөлсөн. Аль ч тохиолдолд урт хугацааны тогтмол өсөлт 5% байна;*

төгрөгөөс 644,000 сая төгрөг, нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнийг 453 төгрөгөөс 612 төгрөгийн хооронд байна гэж тооцоолсон.

- Жишиг банкуудын Үнэ/Ашиг үржүүлэгчийн доод ба дээд квартил утгыг ашиглан 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг 574,000 сая төгрөгөөс 1,016,000 сая төгрөг, нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнийг 545 төгрөгөөс 965 төгрөгийн хооронд байна гэж тооцоолсон.

- ***НАХ загвар:*** ХасБанкны Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2023-2027)-д Банк нь жил бүр ногдол ашиг хуваарилахаар төлөвлөсөн байна. Бид тус Банкны хувьцаа эзэмшигчдийн өмчийн үнэ цэнийн хүрээг тооцоолохын тулд энэ тайлангийн 6.1.3 дахь ногдол ашгийн төсөөллийг ашиглан НАХ загвараар үнэ цэнийн хүрээг тооцоолсон. IPO гаргасны дараах нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь ойролцоогоор 632,000 сая төгрөгөөс 781,000 сая төгрөгийн хооронд, нэгж хувьцааны үнэ цэнэ нь 601 төгрөгөөс 742 төгрөг байна гэж тооцоолсон.

- Дээрх баталгаажуулах аргууд нь Үлдэгдэл Ашгийн загвараар тооцоолсон бидний дүгнэлтийг дэмжиж байна.

### *IPO гаргасны дараах Дүгнэлтийн Хураангуй*

- Үнэлгээний өдрөөр, IPO гаргасны дараах байдлаар, ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь ойролцоогоор **652,674 сая төгрөгөөс 781,103 сая төгрөгийн хооронд (суурь хувилбар: 712,678 сая төгрөг)**, нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ[2] нь **620 төгрөгөөс 742 төгрөгийн хооронд (суурь хувилбар: 677 төгрөг)** байх үндэслэлтэй байна.

*График 1. ХасБанкны IPO гаргасны дараах өмчийн зах зээлийн үнэ цэнэ (сая төгрөг)*




*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

*График 2. ХасБанкны нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (төгрөг)*




*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

---

*[2] IPO-н өмнөх болон дараах нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ тэнцүү байна. Харин нийт өмчийн үнэ цэнэ болон дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа өөр байхыг анхаарна уу. Дэлгэрэнгүйг 6.3 хэсгээс үзнэ үү.*

## 2. Ажлын цар хүрээ

## 2.1 Үйлчлүүлэгчийн мэдээлэл

- ХасБанк нь энэхүү үнэлгээний ажлын үйлчлүүлэгч мөн.
- Тус Банк нь Монгол улс, Улаанбаатар-14210, Жамьян Гүний гудамж-9, 20А шуудангийн салбар, ш/х-72, Олон Улсын Худалдааны Төвийн байранд байрладаг.
- ХасБанк нь 2001 онд Монгол Улсын хоёр томоохон банк бус санхүүгийн байгууллага (ББСБ) болох "Говийн Эхлэл ХХК" болон "Х.А.С" ХХК-ийн нэгдсэнээр байгуулагдаж, мөн оныхоо 12 сарын 27-ны өдөр Монголбанкнаас арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан.
- Тус Банкны улсын бүртгэлийн дугаар: 9016001007, регистрийн дугаар: 2578697.
- Тус Банк нь МонголБанкнаас дараах үйл ажиллагаар эрхлэн явуулах зөвшөөрөл авсан байна. Үүнд:
  - i. Мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо;
  - ii. Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах;
  - iii. Үнэт зүйл хадгалах;
  - iv. Санхүү, хөрөнгө оруулалтын чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх;
  - v. Гадаад гүйвүүлгын үйлчилгээ;
  - vi. Гадаад гүйвүүлгын нэмэлт үйлчилгээ;
  - vii. Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах;
  - viii. Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;
  - ix. Үнэт металлын хадгаламж худалдан авах, худалдах, хүлээн авах, байршуулах;
  - x. Зээлийн багц болон бусад санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах;
  - xi. Санхүүгийн түрээсийн гүйлгээ хийх; болон
  - xii. Даатгалын зуучлалын үйлчилгээ.

### *Хувьцаа эзэмшигчид*

- ХасБанкыг Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК 100% эзэмшдэг. Тэнгэр Санхүүгийн Нэгдэл нь нэр хүнд бүхий олон хувьцаа эзэмшигчтэй. Тус Банкны хувьцаа эзэмшигчид нь дэлхийн өнцөг булан бүрд байрладаг олон улсын томоохон санхүүгийн байгууллагууд, гадаад, дотоодын нэр хүндтэй компаниуд, хөрөнгө оруулалтын сангуудаас бүрддэг. Үнэлгээний өдрийн байдлаар хувьцаа эзэмшигчдийн бүрэлдэхүүн нь дараах байдалтай байсан.

*Хүснэгт 4. Тэнгэр Санхүүгийн Нэгдлийн хувьцаа эзэмшигчид буюу ХасБанкны эцсийн өмчлөгчид*

| Хувьцаа эзэмшигчид | Улс | Эзэмшлийн хувь |
|---|---|---|
| Монголын Алт (МАК) ХХК | Монгол | 20.00% |
| Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) | Олон Улс | 17.17% |
| ОРИКС Корпораци (ORIX) | Япон | 16.81% |
| Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD) | Олон Улс | 12.91% |
| Канадын үндэсний банк (NBC) | Канад | 10.52% |
| Ронок Партнерз (Ronoc) | Унгар | 10.15% |
| Монголиа Финаншьл Сервиз (MFS) | Сингапур | 6.63% |
| Триодос Файр Шэйр Фонд (Triodos) | Нидерланд | 3.73% |
| Нээлттэй Нийгэм Форум ТББ | Монгол | 1.59% |
| Улаанбаатар Ротари Клуб ТББ | Монгол | 0.30% |
| Иргэн Магваны Болдоо | Монгол | 0.10% |
| Иргэн Чулууны Ганболд | Монгол | 0.09% |
| **Нийт** | | **100.00%** |

*Эх сурвалж: ХасБанк*

- "Монголын Алт" (МАК) ХХК нь үндэсний хөрөнгө оруулалттай, геологи, уул уурхай, барилгын материал, аялал жуулчлал, хөдөө аж ахуй, гадаад худалдаа, авто тээврийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Монгол Улсын тэргүүлэгч компаниудын нэг юм. Одоогоор МАК нь ХасБанкны хамгийн том хувьцаа эзэмшигч байна.
- Дэлхийн банк группийн нэг хэсэг болох Олон улсын санхүүгийн корпорац (ОУСК) нь 1956 онд Бретон Вуудзийн гэрээгээр байгуулагдсан 185 улс орны гишүүнчлэлтэй (Монгол Улс 1991 оны 2 дугаар сард гишүүнээр элссэн), Дэлхийн Банкны Группийн гишүүн, хувийн хэвшлийг дэмжих зорилгоор үйл ажиллагаа явуулдаг олон улсын хөгжлийн санхүүгийн байгууллага юм. ОУСК нь Банкны хувьцаа эзэмшигч байхаас гадна ХасБанкийг санхүүжилтийн төрөл бүрийн эх үүсвэрээр дэмжиж ирсэн.
- ORIX нь Япон улсад төвтэй банк, санхүү, лизинг, даатгалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, 1964 онд байгуулагдсан, 36 мянга гаруй ажиллагсадтай, дэлхийн 37 оронд салбартай хувьцаат компани юм. ORIX нь Нью Йоркийн хөрөнгийн бирж болон Японы хөрөнгийн биржид бүртгэлтэй.

331



СЗХ
2023 оны 05 сарын 12
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

BDO

- 1991 онд байгуулагдсан Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ) нь хувийн хэвшил, бизнес эрхлэгчдийн хөгжилд дэмжлэг үзүүлэх зорилго бүхий дэлхийн гурван тив, 38 оронд үйл ажиллагаа явуулж буй олон талт банк юм. EBRD нь 71 улс, Европын Холбоо болон Европын Хөрөнгө Оруулалтын Банкны эзэмшилд байдаг.
- Канадын үндэсний банк (NBC) нь анх 1859 онд үүсгэн байгуулагдаж, 1979 оноос Канадын Үндэсний Банк нэртэйгээр арилжааны банкны үйл ажиллагаа явуулж буй хөрөнгийн хэмжээгээрээ Канадын зургаа дахь том арилжааны банк юм. Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй, Канадын Квебек мужийн Монреаль хотод төвтэй банк юм. NBC нь Торонтогийн Хөрөнгийн Биржид бүртгэлтэй.
- Ronoc нь 2007 онд Майкл Маддены үүсгэн байгуулсан, хөрөнгө оруулалт, санхүүгийн үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг, БНУУ-д төвтэй хөрөнгө оруулалтын сан юм. Ронок 2008 оноос эхлэн Монголд хөрөнгө оруулалт хийж эхэлсэн байна.
- Mongolia Financial Services (MFS) нь Монголиа Опортунитиз Фанд ХХК-ийн Сингапур улсад үүсгэн байгуулсан тусгай зориулалттай компани юм.

***Төлөөлөн удирдах зөвлөл***

- ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл:

*Хүснэгт 5. 2022 оны 12-р сарын 31 өдрөөрх ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл*

| # | Нэр | Албан тушаал |
|---|---|---|
| 1 | Санжай Гупта | Дарга |
| 2 | Гүмэнжавын Цэвэгжав | Гүйцэтгэх захирал |
| 3 | Нямтайширын Цэлмүүн | Гишүүн |
| 4 | Майкл Мадден | Гишүүн |
| 5 | Анджей Витак | Гишүүн |
| 6 | Ив Жако | Гишүүн |
| 7 | Албертус Браггинк | Гишүүн |
| 8 | Сюзанна Херринг Карр | Гишүүн |
| 9 | Баянсангийн Уламбаяр | Хараат бус гишүүн |
| 10 | Нираж Вэдва | Хараат бус гишүүн |
| 11 | Эрик Версавел | Хараат бус гишүүн |

*Эх сурвалж: ХасБанк*

- Банкны удирдлагын баг нь Гүйцэтгэх захирал, Санхүү эрхэлсэн захирал, бусад удирдлагын түвшний захирлуудыг багтаасан 8 захирлаас бүрддэг.
- Үнэлгээний өдрийн байдлаар тус банк нь Монгол орон даяар 74 салбар, 1143 ажилтантай байсан.

## 2.2 Зориулагдсан хэрэглээ

- Энэхүү үнэлгээний тайланг Монголын хөрөнгийн бирж дээр ХасБанкны энгийн хувьцааг анх удаа олон нийтэд санал болгон гаргах (IPO гаргах) зориулалтаар хэрэглэнэ.
- Энэхүү үнэлгээний тайлангийн зорилтот хэрэглэгчид нь дараах талууд бөгөөд өөр өөрсдийн шийдвэр гаргах үйл ажиллагаанд зориулан ашиглаж болно. Үүнд:

  i. ХасБанкны одоогийн хувьцаа эзэмшигчид, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, тус Банкны сонгосон андеррайтер нь IPO гаргах үйл явцад зориулан;
  ii. СЗХ нь тус Банкны үнэт цаасыг хөрөнгийн зах зээл дээр гаргах зөвшөөрөл олгох эсэх шийдвэр гаргах зохицуулалтын зорилгоор;
  iii. МХБ нь тус Банкны хувьцааг бүртгэж, биржээр дамжуулан арилжаалах эсэх шийдвэрийг гаргах зорилгоор;
  iv. Ирээдүйн хөрөнгө оруулагчид тус Банкны хувьцаанд хөрөнгө оруулах эсэх шийдвэр гаргах зорилгоор.

- Энэхүү үнэлгээний тайланд тусгагдсан үнэлгээний тооцоолол нь санхүүгийн тайлагнал, аливаа зарга, маргаан болон дээр дурдсанаас бусад зорилгоор хэрэглэхэд зориулагдаагүй болно.

## 2.3 Үнэлгээний даалгавар

- Үйлчлүүлэгч нь ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн өмчийн 100%-ийн хувь оролцооны зах зээлийн үнэ цэнийг хараат бусаар тодорхойлох бизнесийн үнэлгээ хийхийг бидээс хүссэн. Үйлчлүүлэгчийн хүсэлтийн дагуу бид үнэлгээний даалгаврыг дараах байдлаар тодорхойлсон:
  - ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг Үнэлгээний өдрийн байдлаар тодорхойлох;

ХасБанкны бизнесийн зориулалтаар өмчилсөн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг хийсэн бусад үнэлгээчдийн үнэлгээний тайланг магадлан шалгаж, зах зээлийн үнэ цэнээрээ хэмжигдээгүй зарим материаллаг үнэ цэнэ бүхий тодорхой хөрөнгийн үнэлгээг хийж, эдгээр үнэлгээ нь Банкны бизнесийн үнэ цэнэд материаллаг нөлөө үзүүлэх эсэхийг шалгах.

## 2.4 Хувьцаагаа олон нийтэд санал болгон гаргах үйл ажиллагаа

- Тус Банк нь 2023 оны эхний хагас жилд багтаан МХБ-д хувьцаагаа гаргахаар төлөвлөсөн. IPO гаргахад санал болгох энгийн хувьцааны тоо ширхгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг доорх хүснэгтэд харуулллаа.

- Банк IPO гаргалтаар 52,700,000 ширхэг хувьцаа шинээр гаргахаар төлөвлөж байгаа бөгөөд энэ нь одоогийн энгийн хувьцааны тоог 1,000,000,000-аас 1,052,700,000 ширхэг болгон нэмэгдүүлэх юм.

*Хүснэгт 6. IPO гаргасны дараах хувьцааны тоо ширхэг*

| *Хувьцааны тоо ширхэг* | | *хувиар* |
|---|---|---|
| IPO гаргахаас өмнөх хувьцааны тоо | 1,000,000,000 | 94.99% |
| Шинээр нэмж гаргах хувьцааны тоо | 52,700,000 | 5.01% |
| **IPO гаргасны дараах хувьцааны тоо** | 1,052,700,000 | 100.00% |

*Эх сурвалж: ХасБанк*

## 2.5 Мэргэшсэн үнэлгээчид

- БДО Аудит ХХК (бусад улсууд дахь БДО-ийн пүүсүүдээс ялган таних зорилгоор цаашид "БДО Монгол" хэмээн нэрлэнэ) нь үйлчлүүлэгчийн хүсэлтээр ХасБанкны бизнесийн үнэлгээг гүйцэтгэгч хараат бус мэргэжлийн байгууллага болно. Бид өөрийн компанид ажилладаг СЗХ-ны тусгай зөвшөөрөлтэй хөрөнгийн үнэлгээчид болон үнэлгээний мэргэжилтнүүдэд суурилан хөрөнгийн болон бизнесийн үнэлгээний үйл ажиллагаа эрхлэхээс гадна үнэлгээний бус үйлчлүүлэгчдэд аудитын болон бусад зөвлөх үйлчилгээ үзүүлэх мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг, БДО олон улсын сүлжээний Монгол улс дахь гишүүн компани юм.

- Үнэлгээний багийг БДО Монгол-ын үнэлгээ хариуцсан партнер (БДО-ийн дүрмээр партнер хэмээн нэрлэдэг) ноён Г.Баянмөнх удирдан чиглүүлсэн. Үнэлгээний багийн гишүүдийн талаарх мэдээллийг Хавсралт IV-ээс харна уу. Энэ үнэлгээний ажилд тооцооллын болон шинжилгээний аливаа нарийн төвөгтэй нөхцөл байдал үүсэх магадлал бага гэж таамагласан учраас үнэлгээний ажилд аливаа хөндлөнгийн мэргэжилтний туслалцаа аваагүй.

- Монгол улсын Хөрөнгийн үнэлгээний тухай хуульд заасны дагуу БДО Монгол нь энэ үнэлгээний тайланд хариуцлага хүлээх бөгөөд мэргэжлийн хариуцлагаа Номин даатгал ХХК-д даатгуулсан. Мөн түүнчлэн манай мэргэшсэн үнэлгээчид нь өөрсдийн мэргэжлийн үйл ажиллагаагаа Номин даатгал ХХК-д даатгуулсан болно. Даатгалын гэрчилгээний хуулбарыг Хавсралт V-аас харна уу.

- БДО Монгол болон үнэлгээнд оролцсон үнэлгээчид, мөн үнэлгээний туслах ажилтнууд нь ХасБанкинд энэхүү үнэлгээний үйлчилгээнээс өөр үйлчилгээ үзүүлдэггүй, хувьцаа эзэмшдэггүй, үнэлгээний үр дүнд нөлөөлөх аливаа ашиг сонирхлын зөрчилгүй болно. (Үнэлгээний багийн гишүүдийн ашиг сонирхлын зөрчилгүй тухай мэдэгдлийг Хавсралт III-аас үзнэ үү.)

## 2.6 Тусгай зохицуулалтууд

- Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтээс гаргасан Ёс зүйн дүрмийн дагуу бид өөрсдийн үнэлгээний тайланд тусгагдсан үнэ цэнийн талаарх дүгнэлтийг Монголын Мэргэшсэн Үнэлгээчдийн Институтийн Ёс Зүйн Хороо болон бусад эрх бүхий зохицуулагч байгууллагын шаардлагаар хамгаалах эрхтэй.

- Үйлчлүүлэгч тал болох ХасБанк нь арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх дараах тусгай зөвшөөрөлтэй:

  - МонголБанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 610 дугаар тушаалаар олгогдсон: Мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл, Гадаад валют авах, худалдах, хадгалах, хадгалуулах зөвшөөрөл, Үнэт зүйл хадгалах зөвшөөрөл, Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх зөвшөөрөл; 2002 оны 512 дугаар тушаалаар олгогдсон:Гадаад төлбөр тооцоо эрхлэх энгийн зөвшөөрөл; Монголбанкны Ерөнхийлөгчийн 2006 оны 424 дүгээр тушаалаар: гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх нэмэлт зөвшөөрөл, Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах зөвшөөрөл; Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 354 дүгээр тушаал: Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах нэмэлт зөвшөөрөл; Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны А-258 дүгаар тушаал: Үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах нэмэлт зөвшөөрөл; Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-107 дугаар тушаал: Зээл болон санхүүгийн хэрэгслийг худалдах, худалдан авах нэмэлт зөвшөөрөл; Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны А-334 дүгээр тушаал: Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл.

  - Монгол улсын Санхүүгийн зохицуулах хорооны 2016 оны 386 дугаар тогтоол: Даатгалын зуучлалын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл.

СЗХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

## 2.7 Үнэ цэнийн суурь

- Бид энэхүү тайланг бэлтгэхдээ Үнэлгээний олон улсын стандартын консул (ҮОУСК)-ын бэлтгэн толилуулдаг Үнэлгээний олон улсын стандарт (ҮОУС)-ыг даган мөрдсөн. Энэхүү үнэлгээний хүрээнд зах зээлийн үнэ цэнийн суурийг ашигласан бөгөөд дараах байдлаар тодорхойлогдоно.

- Зах зээлийн үнэ цэнэ гэдэг нь ҮОУС 104-ийн 30.1-р мөрөнд тодорхойлсны дагуу "зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа, талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй бөгөөд албан шахалт шаардлагагүйгээр оролцох тохиолдолд арилжаанд оролцоход бэлэн байгаа худалдан авагч ба борлуулагчийн хоорондох харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгө, өр төлбөрийг арилжвал зохино гэж уг үнэлгээний өдрөөр тооцоолсон дүн"-г хэлнэ. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтыг дараах үзэл баримтлалын дагуу ашиглана:

  - "Тооцоолсон дүн" – харилцан хамааралгүй талуудын ажил гүйлгээгээр хөрөнгийн төлөө төлөх мөнгөөр илэрхийлэгдэх үнэ юм. Зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу зах зээлийн үнэ цэнэ нь тухайн зах зээлээс ул үндэслэлтэйгээр олж авч болох, үнэлгээний өдрөөрх хамгийн их магадлалтай үнэ байдаг. Энэ нь борлуулагчийн ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнэ ба худалдан авагчийн ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн давуу талтай үнэ байна. Харин ерөнхий санхүүжилт, борлуулалт ба буцаан түрээслэх тохиролцоо, борлуулалттай холбоотойгоор хэн нэгнээс олгосон тусгай төлбөр, хөнгөлөлт гэх мэт тусгай нөхцөл буюу заалтаар, эсвэл зөвхөн тодорхой нэг өмчлөгч буюу худалдан авагчид хамаарах үнэ цэнийн ямар нэг элементээр нэмэгдүүлэх буюу бууруулах байдлаар тооцоолсон үнийг энэхүү тооцоололд тусгайлан хамруулдаггүй.

  - "Хөрөнгө, болон өр төлбөрийг арилжвал зохино" – гэдэг нь хөрөнгө ба өр төлбөрийн үнэ цэнэ бол урьдчилан тодорхойлсон дүн эсвэл бодит борлуулалтын үнэ биш, харин тооцоолсон дүн байх нөхцөлийг илэрхийлнэ. Энэ нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын бүх элементүүдийг үнэлгээний өдрөөр хангах уг ажил гүйлгээний үнэ байдаг.

  - "Үнэлгээний өдрөөр" – гэдэг нь тухайн үнэ цэнэ уг өдрийн байдлаар гэх мэт тусгай цаг хугацаатай байхыг шаарддаг. Зах зээл ба зах зээлийн нөхцөл байдал нь өөрчлөгдөж болох учраас уг тооцоолсон үнэ цэнэ нь өөр нэг хугацаанд буруу эсвэл тохиромжгүй байж болох юм. Үнэлгээний дүн нь өөр бусад дурын өдрийн биш, харин үнэлгээний тэр өдрийн байдлаарх зах зээлийн төлөв байдал ба нөхцөлүүдийг тусган илэрхийлдэг.

  - "Бэлэн байгаа худалдан авагч" – гэдэг нь худалдан авах сэдэл санаачилгатай боловч тийм албан үүрэг хүлээгээгүй талыг илэрхийлнэ. Уг худалдан авагч нь ямар ч хамаагүй үнээр худалдан авахаар хэт хүссэн эсвэл худалдан авна гэж урьдчилан тодорхойлогдсон этгээдийн аль нь ч биш юм. Мөн худалдан авагч нь оршин байгаа гэдгийг батлан харуулж эсвэл урьдчилан баримжаалж чадахгүй тийм төсөөллийг буюу таамаглалын зах зээлтэй холбоотойгоор биш, харин одоогийн зах зээлийн бодит байдал болон одоогийн зах зээлийн хүлээлтийн дагуу худалдан авах этгээд байдаг. Уг төсөөлсөн худалдан авагч нь зах зээлээр шаардахаас илүү өндөр үнийг төлөхгүй. Одоогийн эзэн нь "тухайн зах зээл"-ийг бүрдүүлэгчдийн нэг болдог.

  - "Бэлэн байгаа борлуулагч" – нь ямар ч хамаагүй үнээр борлуулахаар хэт хүссэн буюу албадлагын дагуу борлуулагч эсвэл одоогийн зах зээлийг ул үндэслэлтэйгээр харгалзан үзэхгүйгээр үнэ тогтоож буй этгээдийн аль нь ч биш юм. Бэлэн байгаа борлуулагч нь зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа нээлттэй зах зээлээс олж авах хамгийн сайн үнэ бүхий зах зээлийн нөхцөлөөр хөрөнгийг борлуулах сэдэл санаачилгатай байдаг, гэхдээ уг сайн үнэ нь хэд ч байж болох юм. Бэлэн байгаа борлуулагч бол таамагласан эзэн бөгөөд жинхэнэ бодит эзний үнэн бодит нөхцөл байдал нь энэхүү хэлэлцүүлгийн хэсэг болохгүй.

  - "Хамааралгүй талуудын ажил гүйлгээ" – нь жишээлбэл, толгой ба охин компаниуд эсвэл газрын эзэн ба хөлслөгч гэх мэт үнийг зах зээлийн шинж, агуулгагүй болгох буюу нэмэгдүүлж болох тийм тухайлсан буюу тусгай харилцан хамааралтай биш байх талуудын хоорондох ажил гүйлгээ юм. Зах зээлийн үнэ цэнээр тооцогдох ажил гүйлгээ нь тус бүрдээ хараат бусаар үйл ажиллагаа явуулж буй холбоогүй талуудын хооронд хийгдэнэ гэж урьдчилан таамагладаг.

  - "Зохих маркетинг, сурталчилгаа хийгдсэний дараа" – гэдэг нь зах зээлийн үнэ цэнийн тодорхойлолтын дагуу ул үндэслэлтэйгээр олж авч чадах хамгийн сайн үнээр борлуулахад нөлөө үзүүлэхийн тулд тухайн хөрөнгийг хамгийн тохиромжтой арга замаар зах зээлд гарган танилцуулахыг хэлнэ. Борлуулагчийн хандан нэвтрэх зах зээлээс хамгийн сайн үнийг олж авахад борлуулалтын арга нь хамгийн тохиромжтой гэж үздэг. Зах зээлд гарган таниулах хугацаа нь тодорхой тогтсон байдаггүй бөгөөд хөрөнгийн төрөл, зах зээлийн нөхцөл байдлаас хамааран өөр өөр байдаг. Цорын ганц шалгуур нь зах зээлд оролцогчдын зохих тоон хэсгийн анхааралд уг хөрөнгийг хандуулах боломж олгох хангалттай хугацаатай байх ёстой.

  - "Талууд тус бүр зохих мэдлэгтэй, бодол төлөвлөгөөтэй" – гэдэг нь тухайн хөрөнгийн төрөл ба шинж чанар, түүний бодит болон боломжит ашиглалт, зах зээлийн төлөв байдлын талаар уг бэлэн байгаа худалдан авагч болон бэлэн байгаа борлуулагчийн аль алинд үнэлгээний өдрийн байдлаар ул үндэслэлтэйгээр мэдээлсэн байна гэсэн

урьдчилсан нөхцөлийг илэрхийлнэ. Талууд тус бүр нь уг ажил гүйлгээ дэх өөрийн хэтийн байр суурины хувьд хамгийн таатамжтай байх үнийг олохын тулд тухайн мэдлэгийг бодол төлөвлөгөөтэйгээр ашиглана гэж урьдчилан төсөөлдөг. Хожмын нэгэн өдрийн урьдчилан харах боломжгүй үр ашгийг биш, харин тухайн үнэлгээний өдөрөөрх зах зээлийн байдлыг лавлагаа болгосноор "бодол төлөвлөгөө"-г үнэлдэг. Жишээлбэл, борлуулагч нь зах зээлийн үнэ буурсан үед хөрөнгийг зах зээлийн өмнөх үнээс бага үнээр борлуулах нь заавал бодол төлөвлөөгүй байна гэсэн үг биш юм. Ийм тохиолдолд энэ нь үнэ өөрчлөгдсөн зах зээл дэх өөр арилжааны хувьд зөв байх бөгөөд бодол төлөвлөгөөтэй худалдан авагч буюу борлуулагч нь тухайн үед бэлэн боломжтой байгаа зах зээлийн хамгийн сайн мэдээллийн дагуу үйл ажиллагаагаа явуулдаг.

- "Албан шахалт шаардлагагүй" – гэдэг нь тал тус бүр уг ажил гүйлгээг хийх сэдэл санаачилгатай боловч түүнийг гүйцэтгүүлэхээр аль ч талыг хүчлээгүй буюу хэт албадан шахаагүй байхыг илэрхийлнэ.

- Үнэлгээний тайланд ашигласан орц мэдээлэл болон эцсийн үр дүнг үнэлгээний тайлангийн туршид тусгайлан заасанаас бусад үзүүлэлтийн хувьд монгол төгрөгөөр, сая төгрөгийн нарийвчлалтайгаар ашиглана. Үнэлгээний валют нь Монгол улсын үндэсний мөнгөн тэмдэгт болох "төгрөг" болно.

## 2.8 Үндсэн төсөөллүүд

- Дараах ерөнхий болон тусгай төсөөллүүдэд үндэслэн, тус Банкны одоогийн болон хэтийн хувьцаа эзэмшигчдэд хамаарах 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолсон. Доор дурдсан төсөөллүүд нь Үнэлгээний өдрийн байдлаар оршин байгаа бодит байдалтай нийцэж байна гэж үзсэн болно. Үүнд:

    - Үнэлгэдэж буй Банк нь дунд хугацаанд өөрийн банкны үйл ажиллагаар тасралтгүйгээр үргэлжлүүлнэ;
    - Үнэлгэдэж буй Банкны тасралтгүй ажиллагаа эсвэл бизнесийн үндсэн чиглэлд ирээдүйн урьдчилан харах боломжтой хугацаа (2023-2027 онуудыг хамарсан прогнозын хугацаа)-нд мэдэгдэхүйц өөрчлөлт орохгүй;
    - ХасБанкнаас бидэнд ирүүлсэн мөнгөн урсгалын төсөөлөл нь тус Банкны болон арилжааны банкны салбарын түүхэн хандлагад суурилсан. Бизнес төлөвлөгөөнд багтсан мэдээллийн агуулга, тооцоолол нь үнэн зөв, бодитой байна гэж төсөөлсөн;
    - Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2023-2027)-д багтсан аливаа тооцоолол нь банкны удирдлагын бэлтгэсэн бизнесийн үйл ажиллагааны хамгийн сайн тооцоололд үндэслэсэн. Тус санхүүгийн төлөвлөгөөнд байгууллагын нөөц ашиглалтыг боломжит хамгийн дээд түвшинд тодорхойлсон бөгөөд эдгээр тооцоолол нь удирдлагын хамгийн сайн мэдлэг, туршлага дээр үндэслэн бэлтгэгдсэн гэж төсөөлсөн. Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөлд ашигласан төсөөллийг Үнэлгээний шинжилгээ хэсгээс дэлгэрүүлнэ үү;
    - Хөдөлмөрийн орц, ажиллах хүчний сургалт, ажил олгогчоос ажилтанд олгох нийгмийн халамжийн зардалд огцом өсөлт гарахгүй. Мөн түүнчлэн ажиллах хүчний мэргэжлийн ур чадварын дутагдал, мэргэжлийн ёс зүйн доголдлоос үүсэх аливаа зарга, маргаан үүсэхгүй;
    - Засгийн газрын бодлого, зохицуулалтын гэнэтийн өөрчлөлт тус Банкны бизнесийн үйл ажиллагаа болон банкны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлд мэдэгдэхүйц нөлөөлөхгүй;
    - Тус Банкны бизнесийн үйл ажиллагаа нь Монголын татварын хуулиар зохицуулагдана;
    - Тус Банкны санхүүгийн тайланд тусгагдсан бизнесийн хэвийн үйл ажиллагаанаас бусад тодруулаагүй хөрөнгө/өр төлбөр эсвэл хэвийн бус үүрэг хариуцлага, Үнэлгээний өдрийн байдлаар шийдвэрлэгдээгүй шүүхийн зарга маргаан зэрэг үнэлгээнд мэдэгдэхүйц нөлөөтэй аливаа болзошгүй зүйл байхгүй;
    - Банкны салбарт мэдэгдэхүйц нөлөөлөх улс төр, эдийн засгийн таагүй нөхцөл прогнозын хугацааны туршид үүсэхгүй.
    - Банк 2022 оны үр дүнгээс 30 тэрбум төгрөгийн ногдол ашиг олгохоор төлөвлөсөн бөгөөд энэхүү төлөвлөсөн ногдол ашгийг зөвхөн одоогийн хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.
    - Банк хувьцаагаа олон нийтэд санал болгосны дараа Банкны одоогийн болон хэтийн хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн хувьцааг чөлөөтэй худалдаж, худалдан авна гэж төсөөлсөн.



BDO

## 2.9 Тусгай төсөөлөл

- Төсөөлсөн төлөв байдал нь Үнэлгээний өдрөөр оршин байгаа бодит байдлаас ялгаатай байх тохиолдолд үүнийг "тусгай төсөөлөл" гэж ҮОУС 104-ийн 200.4-д заасан. Энэхүү үнэлгээний тайлангийн хүрээнд дараах тусгай төсөөллүүдийг хүлээн зөвшөөрсөн. Үүнд:
  - Инфляцын өндөр түвшинтэй өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдлыг харгалзан, үнэлгээний тооцоолол Үнэлгээний өдрийн байдлаарх түүхэн инфляцын түвшинг ашиглахын оронд ОУВС-аас гаргасан Монгол улс болон АНУ-ын инфляцын талаарх 2027 оны эцсийн таамаглалыг ашигласан.

## 2.10 Үнэлгээний тайлангийн нягтлан шалгалт

- БДО Монгол нь үнэлгээний багийн гишүүн бус, туршлагатай, мэргэшсэн үнэлгээчдээр үнэлгээний тайландаа хөндлөнгийн нягтлан шалгалтыг хийлгэдэг.
- Энэхүү үнэлгээний тайланд Монгол Улсын Их Сургуулийн багш, Тэргүүлэх үнэлгээчин П.Баянсан нягтлан шалгалт хийсэн болно.

## 2.11 Үнэлгээний тайлангийн хүчин төгөлдөр байдал

- Үнэлгээний тайлан нь эхлээд Монгол хэл дээр бэлтгэгдсэн бөгөөд өөр хэл рүү орчуулах эрх зөвхөн БДО Монгол-д хадгалагдана. Бид энэхүү үнэлгээний тайланг хэвлэмэл болон цахим хэлбэрээр хүргүүлнэ. Гарын үсэг зурж, тамга дарсан Монгол болон Англи хэл дээрх, хэвлэмэл болон цахим тайлангууд аль аль нь адил хүчин төгөлдөр болно.
- Монгол ба Англи хэл дээрх тайланд зөрүү гарсан тохиолдолд Монгол хэл дээр бэлтгэгдсэн тайланг үндсэн тайлан гэж үзнэ.
- Үнэлгээний тайланг хэсэгчлэн эсвэл бүхэлд нь үнэлгээний зорилгоос өөр зорилгоор хувилж, эсвэл бүрэн/хэсэгчлэн иш татаж ашиглахыг хориглоно.

СЗХ он 2023 сар 05. 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

## 3. Эдийн засаг, салбарын тойм

## 3.1 Монгол улсын эдийн засаг

- КОВИД-19 цар тахал, гадаад орчны таагүй нөхцөл байдал, хилийн хязгаарлалт зэргээс шалтгаалан эдийн засгийн үйл ажиллагаа хумигдаж, үйлдвэрлэлийн зөрүү, ялангуяа уул уурхайн бус үйлдвэрлэлийн зөрүү 2020 оноос хойш тасралтгүй сөрөг түвшинд хадгалагдаж байсан бол тайлант улиралд эерэг болов. Үүнд, нэг талаас нүүрсний экспорт сайжирч, авто замын тээвэрлэлт идэвхэжсэн, импортын өсөлтийг даган худалдаа, бүтээгдэхүүний цэвэр татварын орлого өссөн, нөгөө талаас төмөр замын бүтээн байгуулалтын ажлууд эрчимжиж, барилгын салбарын өсөлтийг тэтгэсэн зэрэг нь гол нөлөөг үзүүлэв.

*График 3. Дотоодын нийт бүтээгдэхүүн*




*Эх сурвалж: Олон улсын валютын сан*

- Хэрэглээний үнийн индекс улсын хэмжээнд 2022 оны 12-р сарын байдлаар өмнөх сараас 1.0 хувиар өсөж, өмнөх оны мөн үе болон оны эхнээс 13.2 хувь өсөв. Ингэж өсөхөд хүнсний бараа, ундаа, усны бүлгийн үнэ дүнгээрээ 15.4 хувь (согтууруулах бус ундааны дэд бүлгийн үнэ 24.2 хувь), согтууруулах ундаа, тамхины бүлгийн үнэ дүнгээрээ 8.1 хувь, хувцас, бөс бараа, гутлын бүлгийн үнэ дүнгээрээ 18.5 хувь, орон сууц, ус, цахилгаан, хийн болон бусад түлшний бүлгийн үнэ дүнгээрээ 15.4 хувь, тус тус өссөн нь голлон нөлөөлсөн байна.

- Энэ оны эхнээс төлбөрийн тэнцлийн алдагдалтай холбоотойгоор M2 мөнгөний өсөлт хурдацтай саарах хандлагатай байсан бол сүүлийн сард гадаад валютын цэвэр орох урсгал бага зэрэг нэмэгдсэн нь M2 мөнгөний өсөлт тогтворжиход голлон нөлөөлжээ.

- Түүнчлэн, мөнгөний нийлүүлэлтэд банкны системийн зээлийн өсөлт эерэг нөлөө үзүүлж, нэмэгдүүлэх чиглэлд нөлөөлж буй хэвээр байна. Тухайлбал, мөнгөний нийлүүлэлт 2022 оны 10 дугаар сарын байдлаар өмнөх жилийн мөн үеэс 0.8 хувиар өсөхөд зээлийн өсөлт 11.3 нэгж хувийн эерэг нөлөө үзүүлсэн. Цаашид мөнгөний хатуу бодлого, төлбөрийн тэнцлийн алдагдал болон зээлийн өсөлт саарч буй нөлөөгөөр мөнгөний нийлүүлэлтийн өсөлт үргэлжлэн алгуур буурч, нам түвшинд хадгалагдах хүлээлттэй байна.

*Хүснэгт 7. Мөнгөний зах зээлийн үзүүлэлтүүд (тэрбум төгрөг)*

| *Тэрбум төгрөг* | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 |
|---|---|---|---|---|---|
| Мөнгөний нийлүүлэлт /M2/ | 19,475 | 20,833 | 24,220 | 27,863 | 29,665 |
| *Жилийн өөрчлөлт %* | *22.8%* | *7.0%* | *16.3%* | *15.0%* | *6.5%* |
| Төгрөгийн хадгаламж | 12,189 | 13,391 | 17,244 | 18,374 | 17,284 |
| *Жилийн өөрчлөлт %* | *28.8%* | *9.9%* | *28.8%* | *6.6%* | *-5.9%* |
| Валютын хадгаламж | 2,273 | 2,667 | 3,401 | 3,059 | 4,694 |
| *Жилийн өөрчлөлт %* | *-9.2%* | *17.3%* | *27.5%* | *-10.0%* | *53.4%* |

*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- 12 сард Монголбанкнаас зарласан ам.доллартой харьцах төгрөгийн нэрлэсэн дундаж ханш өнгөрсөн оны мөн үеэс 582.33 төгрөгөөр нэмэгдэж, өмнөх сартай харьцуулахад 24.86 төгрөгөөр өсөж 3431.29 төгрөг болов. 12-р сард гадаад валютын нөөц 3.4 тэрбум ам.долларт хүрч өнгөрсөн сараас 15.82 хувиар өсөж, оны эхнээс 22.14 хувиар, өнгөрсөн оны мөн үеэс 22.14 хувиар түс түс буурсан үзүүлэлттэй байна.

*Хүснэгт 8. Жил бүрийн 12 сарын ам.доллартой харьцах төгрөгийн нэрлэсэн хаалтын ханш (2010-2022)*

| Он | Хаалтын ханш | Өөрчлөлт |
|---|---|---|
| 2010 | 1,257 | |
| 2011 | 1,396 | 11.1% |
| 2012 | 1,392 | -0.3% |
| 2013 | 1,659 | 19.2% |
| 2014 | 1,888 | 13.8% |
| 2015 | 1,996 | 5.7% |
| 2016 | 2,490 | 24.8% |
| 2017 | 2,427 | -2.5% |
| 2018 | 2,644 | 8.9% |
| 2019 | 2,734 | 3.4% |
| 2020 | 2,850 | 4.2% |
| 2021 | 2,849 | 0.0% |
| 2022 | 3,445 | 20.9% |
| **Жилийн нийлмэл өсөлтийн хувь** | | **8.1%** |

*Эх сурвалж: МонголБанк, БДО Монгол шинжилгээ*

- 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотойгоор хил хаагдсаны үлмаас өсөлт муутай байсан худалдаа 2021 болон 2022 онуудад түүхий эдийн үнийн өсөлт, нийлүүлэлтийн сүлжээ хэвийн байдалдаа орсон зэргээс шалтгаалан мэдэгдэхүйц өссөн байна. 2022 оны 12 сарын байдлаар нийт барааны эргэлт 21,245 сая ам.доллар буюу өмнөх оны мөн үеэс 32 хувиар өссөн бол экспорт өмнөх оны мөн үеэс 36 хувь, импорт 27 хувиар нэмэгдэж гадаад худалдааны тэнцэл 3,836 сая ам.долларын ашигтай гарав.

*График 4. Экспорт болон импорт (тэрбум доллар)*




*Эх сурвалж: Үндэсний статистикийн хороо*

- Доорх хүснэгтэд Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөллийг харуулав. Эдийн засгийн өсөлтийн хэтийн төлөв Орос-Украйны дайн, түүнтэй холбоотой дэлхийн улс орнуудаас авсан хилийн болон эдийн засгийн хориг болон түүхий эдийн зах зээлийн цаашдын нөхцөл байдлаас ихээхэн хамааралтай байгааг тэмдэглэх нь зүйтэй.

*Хүснэгт 9. Монгол улсын эдийн засгийн өсөлтийн төсөөлөл*

| Байгууллага | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Монголбанк | 3.2% | 4.9% | | | |
| ОУВС | 5.0% | 7.0% | 6.0% | 5.5% | 5.0% |
| АХБ | 5.6% | | | | |
| Дэлхийн Банк | 5.8% | 6.8% | | | |

*Эх сурвалж: МонголБанк, ОУВС, АХБ, Дэлхийн банк*

### *Монгол улсын хөрөнгийн зах зээл*

- Хөрөнгийн зах зээлийн гол индекс болох МХБ-ийн ТОП-20 индекс 2021 онд дээд амжилт тогтоож, 130%-иар өссөн байна. Үүний гол шалтгаанууд нь: (i) Ковид-19 дэгдэлтийн эсрэг авсан арга хэмжээнүүдийн улмаас хадгаламжийн хүүгийн түвшин буурсан нь хөрөнгө оруулагчдын хөрөнгийн зах зээлд хөрөнгө оруулах сонирхлыг нэмэгдүүлсэн; (ii) төрөл бүрийн шинэ бүтээгдэхүүний (хувьцаа, компанийн бонд, хөрөнгө оруулалтын сан) хүртээмж нэмэгдсэн; мөн (iii) арилжааны хэмжээ бага хэвээр байгаа. Харин 2022 онд дэлхийн бусад улсуудтай адил уналттай байсан байна.

- Системийн нөлөө бүхий банкууд хувьцаат компани болох хүрээнд Төрийн банк 10 тэрбум төгрөг, Сэндли ББСБ 22.1 тэрбум төгрөгийн дүн бүхий хувьцаануудыг 2022 оны 10 дугаар сард анхдагч зах зээлд анх удаа арилжаалснаас шалтгаалж нийт арилжааны дүн 68.5 тэрбум төгрөгт хүрч идэвхжив. Улмаар хөрөнгийн захын хөрвөх чадварын харьцаа17 3 дугаар улиралд 3 хувьтай байсан бол 10 дугаар сард энэ оны хамгийн өндөр түвшин буюу 10.1 хувьд хүрсэн.

*Хүснэгт 10. Монголын хөрөнгийн биржийн ТОП-20 индекс, нэгжээр*

| *Он* | *Хаалтын ханш* | *Өөрчлөлт* |
|---|---|---|
| 1997 | 356 | |
| 1998 | 235 | -34.0% |
| 1999 | 256 | 8.8% |
| 2000 | 470 | 83.8% |
| 2001 | 814 | 73.2% |
| 2002 | 934 | 14.7% |
| 2003 | 896 | -4.1% |
| 2004 | 586 | -34.6% |
| 2005 | 1,019 | 74.0% |
| 2006 | 2,031 | 99.3% |
| 2007 | 10,256 | 405.0% |
| 2008 | 5,583 | -45.6% |
| 2009 | 6,190 | 10.9% |
| 2010 | 14,760 | 138.4% |
| 2011 | 21,688 | 46.9% |
| 2012 | 17,715 | -18.3% |
| 2013 | 16,302 | -8.0% |
| 2014 | 14,854 | -8.9% |
| 2015 | 12,898 | -13.2% |
| 2016 | 12,456 | -3.4% |
| 2017 | 20,737 | 66.5% |
| 2018 | 21,467 | 3.5% |
| 2019 | 19,622 | -8.6% |
| 2020 | 19,286 | -1.7% |
| 2021 | 44,412 | 130.3% |
| 2022 | 37,566 | -15.4% |
| **ЖНӨХ (1997-2022) - 25 жил** | | **19.6%** |

*Эх сурвалж: МонголБанк, БДО Монгол шинжилгээ*

## 3.2 Монгол улсын банкны салбарын өнөөгийн нөхцөл байдал

- Монгол улсад одоогийн байдлаар 12 арилжааны банк, 1 хөгжлийн банк, 522 банк бус санхүүгийн байгууллага, 209 хадгаламж зээлийн хоршоо, 17 даатгалын компани, 55 үнэт цаасны компани үйл ажиллагаа явуулж байна. Нийт хөрөнгийн хувьд авч үзвэл арилжааны банкууд санхүүгийн салбарын 90 орчим хувийг бүрдүүлж байна.

- Төрийн банкнаас бусад арилжааны банкуудыг дотоод, гадаадын хувийн хөрөнгө оруулагчид эзэмшдэг. Арилжааны банкууд нь Монгол улсын хэмжээнд 1400 гаруй салбар, 16 мянга гаруй ажилтантайгаар үйл ажиллагаа явуулж байна.

- Гадаадын таван банк (ING, SMBC, MUFG, Bank of China, ICBC) Монгол улсад төлөөлөгчийн газраа байгуулсан боловч одоогоор Монгол улсад банкны үйлчилгээ явуулаагүй байна.

- Арилжааны 12 банкнаас 5 нь системийн нөлөө бүхий банк гэж тооцогддог. Үүнд: Хаан банк, Худалдаа Хөгжлийн Банк, Голомт банк, Хас банк, Төрийн банкууд ордог. Эдгээр банкуудын нийт хөрөнгө нь арилжааны банкуудын нийт хөрөнгийн 91 орчим хувийг бүрдүүлж байна.

*График 5. Банкуудын зах зээлд эзлэх хувь, нийт хөрөнгөөр (2022 оны байдлаар)*




*Эх сурвалж: Банкуудын албан ёсны цахим хуудас, Монголбанк*

***Хууль эрх зүйн орчин***

- Монгол улсын банкны салбар нь Төв банк болон арилжааны банк гэсэн шатлалтай. 1991 онд "Банкны хууль" батлагдсанаар Монгол улсын хоёр шатлалт банкны тогтолцооны суурь тавигджээ.

- Монголбанк нь Монгол улсын хэмжээнд мөнгөний бодлогыг боловсруулж хэрэгжүүлэх эрх бүхий Монгол улсын Төв Банк юм. Төв банк нь Төв банк /Монголбанк/-ны тухай хуулийн дагуу арилжааны банкуудыг хянан шалгах чиг үүргийг мөн хэрэгжүүлдэг.

- Арилжааны банкуудын үйл ажиллагааг зохицуулдаг гол хууль нь Банкны тухай хууль юм. Банкны салбарыг зохицуулдаг бусад хуулиудад Эрдэнэсийн сангийн тухай, Банк дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай, Зээлийн мэдээллийн тухай, Төлбөр тооцоог үндэсний мөнгөн тэмдэгтээр гүйцэтгэх тухай, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, Валютын зохицуулалтын тухай зэрэг хууль, тогтоомж, заавар журмууд үйлчилж байна.

- УИХ-аас 2021 болон 2022 онуудад Банкны тухай хуульд дараах томоохон нэмэлт, өөрчлөлтүүдийг оруулсан. Үүнд:
  - Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байна.
  - "Банкны системд нөлөө бүхий банк" гэж банкны хөрөнгө, өр төлбөрийн хэмжээ, төлбөрийн систем дэх гүйлгээний нийт дүнд эзлэх хувь, банкны үндсэн үйл ажиллагаа, санхүүгийн тогтолцоо дахь хамаарал зэрэг шалгуурыг нэгэн зэрэг баримтлан банкны тогтолцоонд нөлөөтэй гэж Монголбанкнаас тогтоосон банкийг ойлгоно.
  - Банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компани байна. Бусад банк нь хувьцаат компанийн хэлбэртэй байна (өөрөөр хэлбэл нээлттэй эсвэл хаалттай хэлбэртэй).

- Тодруулбал, дээрх нэмэлт, өөрчлөлтөөр арилжааны банкуудаас дараах зүйлсийг биелүүлэх шаардлагатай болж байна. Үүнд:
  - Системийн нөлөө бүхий 5 банк нь бүгд 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор МХБ-д бүртгүүлж, нээлттэй хувьцаат компани болсон байх ёстой;
  - Бүх арилжааны банкуудын хувьд 2023 оны эцэс гэхэд хувьцаа эзэмшлийн бүтцээ төрөлжүүлэх ёстой бөгөөд ингэснээр аль нэг бүлэг холбогдох этгээдүүд аль ч банкны 20 хувиас бага хувийг эзэмшдэг болох ёстой.
  - Банкны төлөөлөн удирдах зөвлөл нь ес ба түүнээс дээш гишүүнтэй байх ба түүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

### Салбарын үзүүлэлтүүд

- 2022 онд Монголын банкны салбарын хувьд түүхэн үзүүлэлтүүдээ шинэчилсэн жил бай сан бөгөөд нийт актив, нийт хувьцаа эзэмшигчдийн өмч, нийт цэвэр ашиг зэрэг үзүүлэлтүүд бүгд өндөр өсөлттэй байжээ.
- 2020 оноос Засгийн газар болон Монголбанкны зүгээс Ковид-19-ийн эсрэг авч хэрэгжүүлж байсан арга хэмжээнүүд 2022 оноор дуусгавар болж байгаа бөгөөд ингэснээр банкны салбарын бизнесийн орчин эргэн хэвийн горимдоо шилжиж байна гэж үзэж болохоор байна.
- 2022 оны байдлаар банкны салбарын нийт актив түүхэн дээд түвшин буюу 45.8 их наяд төгрөг болж, 2021 онтой харьцуулахад 4.7 их наяд төгрөг (11.4%)-өөр өссөн байна.

*График 6. Арилжааны банкуудын нийт хөрөнгө (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Монголбанк, БДО Монгол шинжилгээ*

- 2022 оны байдлаар арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэл 22 их наяд төгрөгт хүрч, 2021 оныхоос 6.5%-иар өссөн байна.

*График 7. Арилжааны банкуудын нийт зээлийн үлдэгдэл (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Монголбанк, БДО Монгол шинжилгээ*

- 2022 оны байдлаар банкны салбарын хэмжээнд нийт чанаргүй зээлийн хэмжээ 9.2% байсан нь 2021 оны 10%-аас буурсан үзүүлэлт юм.

*График 8. Банкуудын чанаргүй зээлийн харьцаа*




*Эх сурвалж: Монголбанк, БДО Монгол шинжилгээ*



СЗХ 2023 .05. 12 БҮРТГЭВ №

- 2022 оны байдлаар арилжааны банкуудын нийт өөрийн хөрөнгө 4.9 их наяд төгрөгт хүрч, 2021 оныхоос 21%-аар өссөн байна.

*График 9. Банкуудын хувьцаа эзэмшигчдийн өмч (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Монголбанк, БДО Монгол шинжилгээ*

- 2022 онд банкны салбарын цэвэр ашиг түүхэн дээд түвшин буюу 1,036 тэрбум төгрөг болж, 2021 оны жилийн гүйцэтгэлээс 80.3%-иар өссөн байна.

*График 10. Банкуудын цэвэр ашиг (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: Монголбанк, БДО Монгол шинжилгээ*

- Банкны салбарын нийт активын хэмжээ хурдацтай өсөхийн хэрээр таван том банкны өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа 2021 оны түвшнээс өссөн бөгөөд Монголбанкнаас тогтоосон 12%-ийн шаардлагыг бүгд хангаж байна.

*График 11. Банкуудын өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа*




*Эх сурвалж: Монголын банкуудын холбоо, БДО Монгол шинжилгээ*

- Системийн ач холбогдол бүхий таван банк бүгд Монголбанкнаас тогтоосон хөрвөх чадварын 25%-ийн шаардлагыг хангаж байна.

*График 12. Банкуудын хөрвөх чадварын харьцаа*




*Эх сурвалж: Монголын банкуудын холбоо, БДО Монгол шинжилгээ*

## 4. Санхүүгийн мэдээлэл

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-05-05
БҮРТГЭВ-02

## 4.1 Санхүүгийн мэдээлэл

***Нийт хөрөнгө ба өөрийн хөрөнгө***

- 2016-2022 онуудын хооронд ХасБанкны үйл ажиллагаа өргөжин тэлж, нийт активын хэмжээ 9.2%-ийн ЖНӨ-өөр өссөн бол 2022-2027 онуудад 16.9%-ийн ЖНӨ-тэй байхаар Банк төсөөлөл дэвшүүлсэн байна. Банкны өөрийн хөрөнгийн чанарыг сайжруулах хүчин чармайлтын үлмээс 2020 онд нийт актив 6%-иар буурсан ч 2021 оны эцсийн байдлаар цар тахлын өмнөх түвшинд хүртэл сэргэж, 2022 онд өмнөх оноос 12.3%-ийн өсөлт үзүүлсэн байна. ХасБанкны нийт актив 2027 он хүртэл 16.9%-ийн ЖНӨХ-иар 8.6 их наяд төгрөгт хүрч өсөх хэмжээн төсөөлсөн байна.

*График 13. Нийт хөрөнгө болон хувьцаа эзэмшигчдийн өмч (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: ХасБанк*

***Харилцагчид олгосон зээл ба харилцагчийн харилцах, хадгаламж***

- Харилцагчдад олгосон нийт зээл болон харилцагчдаас татан төвлөрүүлсэн харилцах, хадгаламжууд 2016-2022 оны хооронд харгалзан 9% ба 16.2%-ийн ЖНӨ-тэй байсан бол 2022-2027 онуудад харгалзан 21.5% ба 11%-ийн ЖНӨ-тэй байх хүлээлттэй байна. Сүүлийн жилүүдэд банкны системийн хөрвөх чадвар нэмэгдэхийн хэрээр актив дахь төв банкны үнэт цаасны хэмжээ нэмэгдэж, хадгаламжийн өсөлт нь зээлийн өсөлтөөс давж ирсэн бол ирэх жилүүдэд зээлийн өсөлтөд гол анхаарлаа хандуулах төсөөлөлтэй байна.

*График 14. Нийт зээл болон харилцах, хадгаламж (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: ХасБанк*

### Бусдаас татан төвлөрүүлсэн эх үүсвэр ба хөшүүрэг

- ХасБанк нь 2017 онд нийт эх үүсвэрийн 7%-ийг өөрийн хөрөнгөөр санхүүжүүлдэг Өр/Өмч харьцаа нь 13.3х-тай өндөр хөшүүрэгтэй банк байсан бол 2022 оны эцэст нийт өөрийн хөрөнгө нь нийт эх үүсвэрийн 12.4%-д хүрч, Өр/Өмчийн харьцаа 7.0х-д хүрсэн ба цаашид 2027 оны эсэх гэхэд нийт эх үүсвэрт өөрийн хөрөнгийн эзлэх хувь 13.2%-д хүрч, Өр/Өмч харьцааг 6.6х-д хүргэх хүлээлттэй байна.

*График 15. Өр/Өмч харьцаа ба Нийт эх үүсвэрт өөрийн хөрөнгийн эзлэх хувь*




*Эх сурвалж: ХасБанк*

### Цэвэр хүүгийн орлого

- ХасБанк 2021 онд 154 тэрбум төгрөгийн цэвэр хүүгийн орлого олсон нь нийт хүүгийн орлогын 47%-ийг эзэлж байсан бол 2022 онд 218 тэрбум төгрөгийн цэвэр хүүгийн орлого олсон нь нийт хүүгийн орлогын 58%-ийг бүрдүүлжээ. 2021 ба 2022 оны үр дүн нь тус Банкны түүхэн дээд амжилт байжээ.

- Хүүгийн орлогын дийлэнх хувь (76%-79%)-ийг харилцагчдад олгосон зээл, урьдчилгаа, 16%-22%-ийг үнэт цаасны хөрөнгө оруулалт бүрдүүлж байна. Банкны удирдлагын хэрэгжүүлж буй өрийн удирдлагын арга хэмжээ болон өртөг өндөртэй өр төлбөрийг бууруулах арга хэмжээ нь 2021-2022 оны хүүгийн зардлыг мэдэгдэхүйц хэмжээгээр бууруулахад нөлөөлсөн.

- ХасБанк нь 2022 онд 218 тэрбум төгрөгийн цэвэр хүүгийн орлоготой ажилласны нөлөөгөөр 2016 оноос хойш 13.9%-ийн ЖНӨ-тэй ажилласан ба 2027 онд цэвэр хүүгийн орлогыг 410 тэрбум төгрөг болгон нэмэгдүүлэхийн тулд жилийн дундаж өсөлт 13.4%-д байхаар хүлээгдэж байна.

*График 16. Хүүгийн орлого болон зардал (тэрбум төгрөг)*




*Эх сурвалж: ХасБанк*



СЗХ 2023 05 12 БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05
346

- ХасБанк 2021 онд 75 тэрбум, 2022 онд 106 тэрбум төгрөгийн цэвэр ашигтай ажилласан бөгөөд 2027 он хүртэл цэвэр ашгийг жилд дунджаар 16%-иар өсгөж, 229 тэрбум төгрөгт хүргэхээр төлөвлөжээ. 2017 оноос хойших өмчийн өгөөж сүүлийн дараалсан хоёр жилд 24%-27.6%-д хүрснээр 2017-2022 оны хоорондох хугацааны өмчийн өгөөж дунджаар 16.1% болсон бол үүнийг 2027 он хүртэл жилд дунджаар 24.9% байлгахаар төлөвлөсөн байна.

*График 17. Цэвэр ашиг ба өмчийн өгөөж (тэрбум төгрөг, хувиар)*




*Эх сурвалж: ХасБанк*

***Бусад санхүүгийн үзүүлэлтүүд***

- Хүснэгт 11-т ХасБанкны санхүүгийн гол харьцааны үзүүлэлтүүдийг харуулав.

- **Зохистой харьцаа**. ХасБанк өнгөрсөн хугацаанд Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуурыг тогтмол хангаж ирсэн байна. Зээлийн багцын эрсдэлийг бууруулж, төгрөгийн харилцах, хадгаламжийн хэмжээ нэмэгдсэнээр хөрвөх чадварын харьцаа сүүлийн жилүүдэд тогтмол сайжирсаар ирсэн. Мөн нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа болон өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа нь Монголбанкны шаардлагаас хавьгүй өндөр байна.

- **Чанаргүй зээлийн харьцаа.** Монгол улс төлбөрийн тэнцлийн хямралд орсон 2016 оны үед тус Банкны чанаргүй зээлийн харьцаа хамгийн өндөр буюу 9.7%-д хүрч байсан. 2020 онд Ковид-19-ийн улмаас чанаргүй зээл дахин өсөж 6.3%-д хүрсэн ч 2022 онд буурч 4.0% болжээ.

- **Ногдол ашиг.** Тус Банк 2020 оны цэвэр ашгаас 2021 онд анх удаа 7.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэдээ олгосон бол 2021 оны ашгаас 2022 онд 15 тэрбум төгрөг хуваарилсан ба 2022 оны ашгаас 2023 онд 30 тэрбум төгрөг хуваарилахаар төлөвлөсөн.

- Банк ирээдүйд жил бүр цэвэр ашгийн 30% хүртэл дүнг ногдол ашигт хуваарилах хүлээлттэй байна.





СЭХ 2023.05.12 БҮРТГЭВ № 01

2023-05-05

BDO

*Хүснэгт 11. ХасБанкны санхүүгийн үндсэн харьцаанууд*

| *Хувиар* | | | *Түүхэн гүйцэтгэл* | | | | | | *Урьдчилсан төсөөлөл* | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | *2017* | *2018* | *2019* | *2020* | *2021* | *2022* | *2023* | *2024* | *2025* | *2026* | *2027* |
| **Зохистой харьцаа** | | | | | | | | | | | |
| Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгийн харьцаа | 11.2% | 9.9% | 12.0% | 16.9% | 17.4% | 20.1% | 19.4% | 20.8% | 20.8% | 21.0% | 20.9% |
| Өөрийн хөрөнгийн хүрэлцээний харьцаа | 16.8% | 15.7% | 15.9% | 17.4% | 17.4% | 20.1% | 19.4% | 20.8% | 20.8% | 21.0% | 20.9% |
| Хөрвөх чадварын харьцаа | 43.9% | 29.5% | 37.4% | 54.9% | 44.3% | 41.1% | 32.7% | 34.9% | 32.9% | 33.0% | 32.2% |
| | | | | | | | | | | | |
| **Өсөлт** | | | | | | | | | | | |
| Хүүний орлогын өсөлт | 10.1% | 19.5% | 5.7% | 1.9% | -14.5% | 13.2% | 33.4% | 13.7% | 16.1% | 18.7% | 17.9% |
| Цэвэр хүүний орлогын өсөлт | -25.6% | -3.5% | 45.8% | 2.7% | 42.9% | 42.2% | 5.8% | 15.5% | 13.6% | 18.2% | 14.4% |
| Нийт хадгаламжийн өсөлт | 37.7% | 16.3% | 16.7% | 3.3% | 15.9% | 4.9% | 6.4% | 11.6% | 14.1% | 13.6% | 12.0% |
| Нийт хөрөнгийн өсөлт | 34.5% | 2.6% | 12.0% | -5.6% | 3.9% | 12.3% | 6.4% | 20.2% | 15.7% | 21.7% | 21.2% |
| Нийт өмчийн өсөлт | 10.9% | 19.5% | 9.4% | 11.3% | 22.6% | 23.9% | 19.5% | 18.5% | 18.2% | 18.9% | 17.8% |
| | | | | | | | | | | | |
| **Үйл ажиллагааны харьцаа** | | | | | | | | | | | |
| Өмчийн өгөөж | 12.0% | 11.8% | 9.4% | 12.0% | 24.0% | 27.6% | 25.8% | 25.0% | 24.5% | 25.1% | 24.2% |
| Хөрөнгийн өгөөж | 0.8% | 0.8% | 0.7% | 1.0% | 2.1% | 2.6% | 3.1% | 3.1% | 3.0% | 3.0% | 2.8% |
| Цэвэр хүүний маржин | 3.5% | 2.9% | 4.3% | 3.9% | 5.3% | 7.8% | 7.0% | 6.9% | 6.5% | 6.3% | 6.0% |
| Өр ба хөрөнгийн харьцаа | 93.1% | 91.9% | 92.1% | 90.7% | 89.0% | 87.9% | 86.4% | 86.6% | 86.3% | 86.6% | 87.0% |
| Зээл ба харилцах, хадгаламжийн харьцаа | 113.0% | 128.5% | 104.8% | 72.8% | 82.7% | 84.7% | 104.9% | 111.8% | 117.8% | 123.7% | 132.3% |
| Чанаргүй зээлийн харьцаа | 7.5% | 4.8% | 4.4% | 6.3% | 4.4% | 4.0% | 3.5% | 3.3% | 3.2% | 3.1% | 3.1% |
| Зээлийн эрсдэлийг нөхөх харьцаа (МБ) | 82.3% | 86.8% | 90.1% | 102.7% | 118.6% | 132.2% | 118.1% | 112.9% | 107.2% | 100.3% | 92.5% |
| Ногдол ашиг төлөлтийн харьцаа | | | | 22.3% | 19.9% | 28.3% | 30.0% | 30.0% | 30.0% | 30.0% | 30.0% |
| Ногдол ашиг төлөлт (тэрбум төгрөг) | | | | 7.5 | 15 | 30 | 36.8 | 42.6 | 49.5 | 60.0 | 68.6 |

*Эх сурвалж: ХасБанк,* БДО Монгол шинжилгээ

*Хүснэгт 12. ХасБанкны санхүүгийн байдлын тайлан (проформа)*

| *сая төгрөг* | Түүхэн гүйцэтгэл | | | | | | Урьдчилсан таамаглал | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
| **ХӨРӨНГӨ** | | | | | | | | | | | |
| Бэлэн мөнгө (цэвэр) | 561,851 | 610,698 | 821,415 | 418,663 | 505,012 | 676,222 | 414,479 | 637,838 | 723,578 | 834,538 | 943,736 |
| Хөрөнгө оруулалтын багц (цэвэр) | 902,547 | 269,920 | 586,936 | 1,278,560 | 1,003,023 | 973,320 | 1,010,030 | 1,126,560 | 1,192,132 | 1,476,431 | 1,774,337 |
| Зээл болон урьдчилгаа (цэвэр) | 1,404,043 | 1,997,697 | 1,883,081 | 1,415,101 | 1,791,558 | 2,002,758 | 2,510,483 | 3,026,503 | 3,644,938 | 4,392,779 | 5,301,127 |
| Эргүүлэн татсан хөрөнгө (цэвэр) | 80,843 | 80,360 | 54,760 | 52,701 | 37,523 | 35,217 | 13,104 | 3,120 | 2,760 | 2,400 | 2,040 |
| Өмчийн хөрөнгө оруулалт (цэвэр) | 2,452 | 3,332 | 3,384 | 3,610 | 3,613 | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 | 4,682 |
| Үндсэн хөрөнгө (цэвэр) | 48,804 | 81,489 | 75,323 | 73,411 | 76,099 | 80,823 | 86,460 | 91,820 | 96,876 | 101,431 | 105,409 |
| Дериватив хөрөнгө | 82,732 | 112,042 | 99,390 | 75,684 | 49,223 | 107,799 | 104,446 | 95,639 | 105,617 | 217,385 | 392,252 |
| Бусад хөрөнгө | 26,210 | 33,243 | 46,540 | 51,682 | 33,907 | 49,959 | 38,432 | 41,350 | 45,179 | 50,193 | 56,747 |
| **Нийт хөрөнгө** | **3,109,481** | **3,188,781** | **3,570,829** | **3,369,413** | **3,499,959** | **3,930,780** | **4,182,117** | **5,027,512** | **5,815,762** | **7,079,839** | **8,580,329** |
| **ЭЗДИЙН ӨМЧ БА ӨР ТӨЛБӨР** | | | | | | | | | | | |
| Харилцах, хадгаламж | 1,294,756 | 1,586,587 | 1,829,885 | 2,014,787 | 2,236,069 | 2,425,855 | 2,444,295 | 2,760,627 | 3,150,669 | 3,615,573 | 4,080,478 |
| Зээлсэн эх үүсвэр | 1,562,133 | 1,284,294 | 1,381,883 | 950,147 | 780,049 | 907,593 | 1,069,760 | 1,481,018 | 1,741,069 | 2,388,251 | 3,232,546 |
| Бусад эх үүсвэр | 6,442 | 9,368 | 13,660 | 11,283 | 16,445 | 13,128 | 14,385 | 16,210 | 18,265 | 20,582 | 23,192 |
| Балансын гадуурх зүйлсийн үнэ цэнийн бууралт | 0 | 355 | 233 | 490 | 355 | 221 | 249 | 280 | 316 | 356 | 401 |
| Дериватив өр төлбөр | 5,478 | 4,256 | 5,227 | 729 | 371 | 1,640 | - | - | - | - | - |
| Бусад өр төлбөр | 25,393 | 46,732 | 58,563 | 78,745 | 82,675 | 106,656 | 84,981 | 95,873 | 109,555 | 108,584 | 128,616 |
| **Нийт өр төлбөр** | **2,894,201** | **2,931,592** | **3,289,451** | **3,056,181** | **3,115,964** | **3,455,093** | **3,613,670** | **4,354,007** | **5,019,874** | **6,133,346** | **7,465,233** |
| Энгийн хувьцаа | 60,444 | 60,444 | 60,444 | 60,444 | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 | 101,818 |
| Нөөц | 8,531 | 21,938 | 17,604 | 28,818 | 52,569 | 62,820 | 53,129 | 19,021 | 21,328 | 19,018 | 11,197 |
| Халаасны хувьцаа | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 | 11,439 |
| Дахин үнэлгээний нөөц | 0 | 15,703 | 15,625 | 15,531 | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 | 18,529 |
| Бусад нөөц | 1,471 | 1,855 | 1,894 | 2,063 | 2,066 | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 | 2,920 |
| Тайлант жилийн ашиг | 23,363 | 25,473 | 24,151 | 33,685 | 75,263 | 105,838 | 122,759 | 141,886 | 164,949 | 200,090 | 228,629 |
| Хуримтлагдсан ашиг | 110,031 | 120,337 | 150,222 | 161,252 | 129,812 | 187,323 | 287,852 | 414,720 | 517,471 | 642,165 | 800,590 |
| Ногдол ашиг | - | - | - | - | - 7,500 | - 15,000 | - 30,000 | - 36,828 | - 42,566 | - 49,485 | - 60,027 |
| **Нийт эздийн өмч** | **215,279** | **257,189** | **281,378** | **313,232** | **383,995** | **475,687** | **568,446** | **673,505** | **795,888** | **946,493** | **1,115,095** |
| **Нийт эздийн өмч ба өр төлбөр** | **3,109,481** | **3,188,781** | **3,570,829** | **3,369,413** | **3,499,959** | **3,930,780** | **4,182,117** | **5,027,512** | **5,815,762** | **7,079,839** | **8,580,329** |

*Эх сурвалж: ХасБанк*

СЭХ 2023 05 12 БҮРТГЭВ № 01
MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

*Хүснэгт 13. Хасбанкны орлогын тайлан (проформа)*

| сая төгрөг | 2017 | 2018 | 2019 | 2020 | 2021 | 2022 | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Түүхэн гүйцэтгэл | | | | | Урьдчилсан таамаглал | | | |
| Хүү болон түүнтэй адилтгах орлого | 299,668 | 357,960 | 378,331 | 385,583 | 329,678 | 373,350 | 498,167 | 566,613 | 657,658 | 780,507 | 920,317 |
| Хүү болон түүнтэй адилтгах зардал | (225,274) | (286,187) | (273,660) | (278,136) | (176,092) | (155,015) | (267,133) | (299,807) | (354,592) | (422,180) | (510,450) |
| **Хүүний цэвэр орлого** | **74,395** | **71,772** | **104,671** | **107,447** | **153,586** | **218,335** | **231,034** | **266,806** | **303,065** | **358,327** | **409,867** |
| Хураамж ба шимтгэлийн орлого | 13,432 | 18,595 | 22,928 | 22,849 | 26,921 | 30,200 | 39,480 | 46,392 | 53,294 | 61,148 | 69,676 |
| Хураамж ба шимтгэлийн зардал | (2,449) | (4,416) | (7,333) | (6,380) | (8,019) | (11,289) | (12,791) | (14,555) | (16,583) | (18,916) | (21,599) |
| Валютын арилжааны орлого | 2,316 | 4,988 | 5,715 | 5,841 | 5,167 | 19,613 | 14,400 | 14,400 | 16,560 | 19,044 | 21,901 |
| Тусламжийн орлого | 500 | 1,383 | 1,695 | 1,175 | 1,407 | 1,507 | 1,800 | 1,200 | 1,200 | 1,200 | 1,200 |
| Бусад орлого | 1,306 | 1,125 | 2,041 | 1,242 | 2,362 | 2,782 | 1,440 | 1,440 | 1,440 | 1,440 | 1,440 |
| **Хүүний бус цэвэр орлого** | **15,106** | **21,675** | **25,046** | **24,727** | **27,838** | **42,813** | **44,329** | **48,877** | **55,911** | **63,916** | **72,617** |
| **Үйл ажиллагааны нийт орлого** | **89,501** | **93,447** | **129,717** | **132,174** | **181,424** | **261,148** | **275,364** | **315,684** | **358,976** | **422,243** | **482,484** |
| Зээлийн алдагдлын зардал | 2,117 | 7,955 | (29,319) | (22,072) | (2,551) | (9,476) | (5,880) | (10,900) | (13,320) | (17,520) | (24,000) |
| **Үйл ажиллагааны цэвэр орлого** | **91,618** | **101,402** | **100,398** | **110,102** | **178,872** | **251,672** | **269,484** | **304,784** | **345,656** | **404,723** | **458,484** |
| **Үйл ажиллагааны зардал** | **(67,258)** | **(74,005)** | **(69,220)** | **(66,315)** | **(76,404)** | **(104,982)** | **(107,503)** | **(116,569)** | **(126,684)** | **(138,896)** | **(154,606)** |
| Хүний нөөцийн зардал | (34,027) | (34,796) | (33,744) | (33,088) | (40,662) | (66,267) | (65,034) | (70,003) | (75,610) | (81,844) | (90,824) |
| Захиргааны зардал | (33,231) | (39,209) | (35,476) | (33,228) | (35,742) | (38,715) | (42,469) | (46,567) | (51,074) | (57,053) | (63,782) |
| **Татварын өмнөх ашиг** | **24,360** | **27,397** | **31,178** | **43,786** | **102,468** | **146,690** | **161,981** | **188,215** | **218,972** | **265,827** | **303,879** |
| ААН-ийн орлогын албан татвар | (997) | (1,924) | (7,027) | (10,102) | (27,205) | (40,851) | (39,222) | (46,329) | (54,023) | (65,737) | (75,250) |
| **Тайлант үеийн цэвэр ашиг** | **23,363** | **25,473** | **24,151** | **33,685** | **75,263** | **105,839** | **122,759** | **141,886** | **164,949** | **200,090** | **228,629** |

*Эх сурвалж: ХасБанк*

## 5. Үнэлгээний шинжилгээ

## 5.1 Үнэлгээний хандлага, аргууд

- Бид ХасБанкны нийт хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолохдоо үнэлгээний тохиромжтой хандлага, аргуудыг шүүн тунгааж, хамгийн тохиромжтой гэж мэргэжлийн түвшинд авч үзсэн аргыг сонгосон.

- ХасБанкны үндсэн үйл ажиллагааны чиглэл нь арилжааны банкны үйл ажиллагаа бөгөөд энэ бизнесийн чиглэлээс өөр аливаа үйл ажиллагаа, түүнээс бий болсон материаллаг орлого түүхэн тайлант хугацаанд үүсээгүй.

- ХасБанкны бизнесийг үнэлэхдээ бид үнэлгээний орлогын хандлага ба өртгийн хандлагын хосолмол арга болох Үлдэгдэл Ашгийн загварыг сонгон, Банкны удирдлагаас бэлтгэн ирүүлсэн бизнес төлөвлөгөөний цэвэр ашгийн төсөөлөлд шинжилгээ хийж, илэрхий хэлбэлзэлтэй төсөөлөлд бага зэрэг засвар оруулах замаар Банкны хэтийн хувьцаа хувьцаа эзэмшигчдэд хамаарах 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийг тооцоолж дүгнэлт гаргасан.

- Харин Банкнаас ирүүлсэн цэвэр ашгийн төсөөлөлд ямар нэгэн залруулга хийлгүйгээр Үлдэгдэл Ашгийн загварт ашиглан тооцоолсон Банкны нийт хувьцаа эзэмшигчдэд хамаарах 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнийн тооцооллыг үнэлгээний дүгнэлтийг дэмжих нэг хувилбар болгон харуулсан.

- Үүнээс гадна, Орлогын хандлагын Ногдол Ашиг Хорогдуулах (НАХ) загвар болон Зах зээлийн хандлагын ЖКАЗ-н Үнэ/Биет Данс, Үнэ/Ашиг үржүүлэгчийг баталгаажуулах аргууд болгон ашигласан.

- Бид үнэлгээнд Зах зээлийн хандлага болон Орлогын хандлагыг дараах үндэслэлээр ашигласан:

  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, догол мөр 20.2 буюу 20.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд **зах зээлийн хандлагыг** ихэвчлэн ашигладаг. Зах зээлийн хандлага нь бизнесийн хувьд хамгийн бодитой, ул үндэслэлтэй үнэ цэнийн дүгнэлт гаргах боломж олгодог. Учир нь энэ аргын үед бизнесийн үнийн мэдээлэл нь бэлэн олдоцтой байгаа, ижил буюу жиших боломжтой бизнесийн орц мэдээлэлд үндэслэдэг.

  - Бизнес ба бизнесийн хувь оролцоо нь ҮОУС 105 Үнэлгээний хандлагууд ба аргууд, догол мөр 40.2 буюу 40.3-ын шалгуурыг ямагт хангадаг тул эдгээр хөрөнгийн үнэлгээнд **орлогын хандлагыг** тогтмол хэрэглэдэг. Мөн түүнчлэн, Банк нь ойрын ирээдүй (прогнозын хугацаа)-д бизнесийн үйл ажиллагаагаа тасралтгүй үргэлжлүүлнэ гэж төсөөлөх боломжтой. Иймээс тасралтгүй хугацаанд уг бизнесийн бий болгож чадах эдийн засгийн өгөөж буюу мөнгөн урсгалд үндэслэн Хорогдуулсан Мөнгөн Урсгал (ХМУ)-ын загварыг ашиглах боломжтой.

## 5.2 Зах зээлийн хандлага

- Бизнес дэх өмчийн хувь оролцоог үнэлэхдээ зах зээлийн хандлага нь үнэлж буй бизнесийн санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, түүхэн ба хүлээгдэж буй санхүүгийн гүйцэтгэлийг: (1) ижил эсхүл төсөөтэй бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулдаг, (2) эдийн засаг, байгаль орчны, улс төрийн ижил эрсдэлүүдэд өртдөг, (3) хөрөнгө оруулагчийн дараагийн сонголт байх боломжтой компаниудын зах зээлийн үнэлгээ болон бодит арилжааны мэдээлэлтэй харьцуулдаг.

- Зах зээлийн хандлагад түгээмэл хэрэглэгддэг хоёр арга байдаг нь:
  - **Жишиг Компанийн Арга Зүй (ЖКАЗ)**: Энэ арга нь нээлттэй чөлөөт зах зээлд идэвхтэй арилжаалагддаг, бизнесийн ижил салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хувьцааны зах зээлийн үнээс тооцсон зах зээлийн үржүүлэгчийг ашигладаг. Үнэлж буй бизнесийн санхүүгийн гүйцэтгэлийг илтгэх хэмжүүрт тохирох үржүүлэгчийг сонгосноор арилжаалагдахуйц цөөнхийн сонирхлоор үнэ цэнэ тодорхой болдог. Хэрэв үнэлгээний зорилго нь бизнес дэх хяналтын багцын үнэ цэнийг тодорхойлох бол хяналттай хувь оролцооны урамшууллыг нэмж өгөх шаардлагатай.

  - **Жишиг Арилжааны Арга Зүй (ЖААЗ):** Энэ аргыг мөн "арилжааны арга" эсвэл "нэгдэл ба худалдан авалтын арга" гэж нэрлэдэг. Жишиг арилжаагаар зах зээлийн үнэ цэнийг тооцохдоо ижил бизнесийн салбарт үйл ажиллагаа явуулдаг компаниудын хяналтын эрхтэй буюу их дүнтэй арилжаанаас үүссэн үржүүлэгч ашигладаг. Энэ тохиолдолд ихэвчлэн арилжаалагдахуйц хяналтын эрхтэй сонирхлоор зах зээлийн үнэ цэнэ тодорхой болдог. Хэрэв хөрөнгийн биржээс гадуурх их дүнтэй арилжааны мэдээлэл ашиглах тохиолдолд, цөөнхийн хувь оролцоог үнэлэхийн тулд хөрвөх чадваргүйн эсхүл хяналтгүйн хямдруулалтыг хасаж өгөх тохиолдол байдаг.

- Бид өөрсдийн дотоодын мэдээллийн сан болон албан ёсны төлбөртэй мэдээллийн эх сурвалж болох Pitchbook Data-д үндэслэн үнэлгээний шинжилгээнд ЖКАЗ-г авч үзсэн. Бид эдгээр мэдээллийн санг ашиглан олон улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй ижил төсөөтэй хангалттай олон компаниудын зах зээлийн мэдээллийг олж авсан тул ЖААЗ-г ашиглаагүй.

### *Жишиг компани сонгох шалгуур*

- Бид жишиг компанийн арга зүйг ашиглахдаа банкны салбарт хамгийн түгээмэл ашиглагддаг Үнэ/Данс (P/B) болон Үнэ/Ашиг (P/E) үржүүлэгчийг ашигласан.
- Бид АНУ-д төвтэй PitchBook Data, Inc. компанийн дата баазыг ашиглан олон улсын хөрөнгийн зах зээл дэх банкуудаас жишиг банкуудыг дараах шалгуурыг ашиглан сонгосон:

*Хүснэгт 14. Жишиг компаниудыг сонгох шалгуур*

| # | Шалгуур | Сонгогдсон банкуудын тоо | Тайлбар |
|---|---|---|---|
| 1 | Зүүн Европ эсвэл Азид төвтэй арилжааны банкууд | 225 | Бид бүрэн бус өгөгдөлтэй компаниудыг сонголтоос хассан. |
| 2 | Сүүлийн 12 сарын өмчийн өгөөж 10%-иас дээш байх. | 69 | ХасБанкны өмчийн өгөөж 2016-2022 онд дунджаар 16.1% байсан. |
| 3 | Шри Ланка, Пакистан БНХАУ зэрэг улсын арилжааны банкуудыг хассан | 50 | Төлбөрийн тэнцлийн хямралтай байгаа Шри Ланка, Пакистан зэрэг улсыг хассан. БНХАУ-ын банкны салбарын хяналт, зохицуулалт хатуу, мөн дийлэнхэд нь Хятадын Засгийн газар эсвэл төрийн өмчит байгууллагууд хувьцаа эзэмшдэг. |
| 4 | Нийт актив нь 30 тэрбум ам.доллар ба түүнээс дээш банкуудыг хассан. | 23 | ХасБанкны нийт актив нь ойролцоогоор 1.2тэрбум ам.доллар бөгөөд Монгол улсын тав дах том банк юм. Тиймээс бид хэт том, өсөлт нь удааширсан банкуудыг хассан. |
| 5 | Зарим орны жижиг банкууд болон үнийн мэдээлэл нь хэт савлагаа (P/B<0.5 г.м)-тай байх магадлалтай банкнуудыг хассан. | 13 | Хэт олон төлөөлөлтэй болон хэт савлагаатай мэдээлэл бүхий Индонез, Филиппин, Вьетнамын зарим банк хасагдсан. |
| 6 | МХБ-д бүртгэгдсэн банкуудыг нэмсэн | 15 | МХБ-д бүртгэлтэй, Монгол улсын системийн Голомт ба Төрийн Банк гэсэн 2 банкийг нэмсэн. |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Дээрх шалгуурын үр дүнд бид Хүснэгт 15-д жагсаасан 15 банкийг жишиг компаниар сонгосон.

*Хүснэгт 15. Сонгогдсон жишиг компаниуд ба тэдгээрийн үндсэн үзүүлэлтүүд*

| # | Жишиг компаниуд | Улс | Нийт хөрөнгө Сая.дол | Өмчийн дүн Сая.дол | Өмчийн өгөөж хувь | Үнэ/Бүтэм Данс харьцаа | Үнэ/Ашиг харьцаа | Өр/Өмч харьцаа | Татвар хувь | Өмчийн Бета харьцаа | Хөрөнгийн Бета харьцаа |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Moneta Money Bank | Чех | 14,864 | 1,202 | 17.4 | 1.34 | 5.94 | 11.19 | 18.85 | 0.67 | 0.07 |
| 2 | Bank of Maharashtra | Энэтхэг | 29,354 | 1,847 | 11.8 | 1.34 | 7.94 | 14.33 | 37.71 | 0.83 | 0.08 |
| 3 | Equitas Holdings | Энэтхэг | 3,724 | 438 | 10.3 | 0.97 | 15.05 | 0.61 | 26.92 | 1.57 | 1.09 |
| 4 | Bank Tabungan Negara | Индонез | 25,569 | 1,418 | 14.9 | 0.73 | 5.10 | 14.28 | 18.40 | 1.60 | 0.13 |
| 5 | HS Holdings | Япон | 4,363 | 444 | 31.5 | 0.67 | 3.89 | 5.20 | 37.05 | 0.35 | 0.08 |
| 6 | Halyk Savings Bank | Казакстан | 29,574 | 3,951 | 32.5 | 0.74 | 2.44 | 6.14 | 12.88 | 0.62 | 0.10 |
| 7 | Bank Handlowy w Warszawie | Польш | 14,624 | 1,470 | 16.7 | 1.14 | 5.70 | 7.44 | 22.45 | 0.65 | 0.10 |
| 8 | Banca Transilvania | Румын | 28,035 | 2,001 | 20.5 | 1.24 | 5.47 | 12.02 | 11.86 | 0.81 | 0.07 |
| 9 | BRD Groupe Societe Generale | Румын | 14,123 | 1,240 | 17.6 | 1.32 | 5.20 | 10.06 | 17.61 | 0.80 | 0.09 |
| 10 | Kiatnakin Bank | Тайланд | 13,906 | 1,414 | 16.0 | 1.39 | 6.78 | 7.11 | 19.39 | 0.87 | 0.13 |
| 11 | Aeon Thana Sinsap | Тайланд | 2,618 | 590 | 19.4 | 2.01 | 10.70 | 3.08 | 20.23 | 1.09 | 0.32 |
| 12 | Military Commercial | Вьетнам | 27,539 | 3,041 | 28.7 | 1.34 | 5.57 | 7.17 | 20.04 | 0.96 | 0.14 |
| 13 | Sacombank | Вьетнам | 23,656 | 1,549 | 11.9 | 1.17 | 11.00 | 13.60 | 25.82 | 1.00 | 0.09 |
| 14 | Төрийн Банк | Монгол | 1,209 | 143 | 24.4 | 1.01 | 5.10 | 7.43 | 22.13 | | |
| 15 | Голомт Банк | Монгол | 2,591 | 245 | 16.9 | 1.25 | 10.30 | 9.58 | 34.76 | | |
| | **1-р квартил** | | | | **15.42** | **0.99** | **5.15** | **6.63** | **18.63** | **0.67** | **0.08** |
| | **Медиан** | | | | **17.44** | **1.24** | **5.70** | **7.44** | **20.23** | **0.83** | **0.10** |
| | **3-р квартил** | | | | **22.45** | **1.34** | **9.12** | **11.60** | **26.37** | **1.00** | **0.13** |

*Эх сурвалж: PitchBook Data, БДО Монгол шинжилгээ*

- Сонгогдсон компаниудын талаарх дэлгэрэнгүй мэдээллийг Хавсралт VII-оос харна уу.

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

## 5.3 Орлогын хандлага

- Ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнийн шинжилгээг нийтэд нь Хорогдуулсан Мөнгөн Урсгал (Discounted Cash Flow)-ын шинжилгээ гэж нэрлэдэг. Энэ арга нь ирээдүйн мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнүүдийн нийлбэр нь бизнесийн үнэ цэнийг илтгэнэ гэсэн үзэл баримтлалд суурилдаг. Энэ арга зүйг ашиглахын тулд ирээдүйн мөнгөн урсгалын хүлээгдэж буй дүнг тохиромжтой капиталын өртөг (хорогдуулах хувь)-өөр хорогдуулдаг.

- ХМУ-ын үндсэн хэд хэдэн хувилбар байдаг:

  - Бизнест хамаарах чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Firm)-ын загвар – нь бизнест хамаарах нийт чөлөөт мөнгөн урсгалыг ашиглан нийт бизнесийн үнэ цэнийг тодорхойлдог;
  - Өмчид хамаарах чөлөөт мөнгөн урсгал (Free Cash Flow to Equity)-ын загвар – нь өмчид хамаарах нийт чөлөөт мөнгөн урсгалыг ашиглан өмчийн үнэ цэнийг тодорхойлдог;
  - Үлдэгдэл Ашгийн загвар (өмчийн үнэлгээнд Residual Income model гэж нэрлэдэг ба харин байгууллагын хэмжээний үнэлгээнд эдийн засгийн нэмүү үнэ цэнийн загвар буюу Англиар Economic Value Added model гэж арай өргөн утгаар нэрлэдэг) - нь өмчийн дансны үнэ цэнэ болон ирээдүйн жил бүрийн өмчийн өртгөөс давсан өмчийн өгөөжид ногдох үлдэгдэл ашгуудын өнөөгийн үнэ цэнийн нийлбэрийг тооцдог. Жил бүрийн үлдэгдэл ашгийг тухайн жилийн өмчийн өгөөж болон өмчийн өртгийн хоорондын зөрүүгээр тооцно. Өөрөөр хэлбэл, ирээдүйд эерэг Үлдэгдэл Ашиг үүсгэж байж л компанийн үнэлгээ дансны үнээсээ өндөр байна гэсэн үг юм;
  - Ногдол Ашиг Хорогдуулах загвар (НАХ загвар буюу Dividend Discount Model) - нь санхүүгийн байгууллагын үнэ цэнийг тооцохдоо ирээдүйн ногдол ашгийг өмчийн өртгөөр хорогдуулж тооцдог. Энэ арга нь ойлгоход хялбар, түгээмэл хэрэглэгддэг боловч жил бүрийн ногдол ашгийн хэлбэлзэл өндөртэй, эсхүл ногдол ашиг тараадаггүй компанийг үнэлэхэд тохиромжгүй байдаг.

- Хэдийгээр Бизнест хамаарах чөлөөт мөнгөн урсгал болон Өмчид хамаарах чөлөөт мөнгөн урсгал нь үнэлгээнд түгээмэл хэрэглэгддэг боловч эдгээр нь санхүүгийн салбарын компаниудыг үнэлэхэд тохиромжгүй байдаг.

- Үлдэгдэл Ашгийн загвар нь дансны үнэ нь ойр ойрхон хэмжигдэж, шинэчлэгдэж байдаг банк, санхүүгийн байгууллагуудын үнэлгээнд түгээмэл хэрэглэгддэг. Бид энэхүү үнэлгээний ажилд Үлдэгдэл Ашгийн загварыг үнэлгээний үндсэн арга болгон ашигласан.

- НАХ загвар нь жил бүр тогтмол ногдол ашиг тарааж ирсэн, цаашид ч тараахаар төлөвлөж буй компаниудыг үнэлэхэд хамгийн тохиромжтой байдаг. ХасБанкны хувьд 2021 оноос ногдол ашиг тарааж эхэлсэн тул бид НАХ загварыг үнэлгээний үндсэн аргаар сонгоогүй, харин Үлдэгдэл Ашгийн загварын үр дүнг баталгаажуулах зорилгоор ашигласан.

- Үлдэгдэл Ашгийн загвар нь дараах байдлаар илэрхийлэгдэнэ:

$$Equity\,Value = BV_0 + \frac{(ROE_1 - r)\times BV_0}{(1+r)^1} + \frac{(ROE_2 - r)\times BV_1}{(1+r)^2} + \cdots$$

*Энд:*

| | | |
|---|---|---|
| $BV_0$ | = | *Үнэлгээний өдрийн эздийн өмч (book value);* |
| $ROE$ | = | *Өмчийн өгөөж (return on equity);* |
| $r$ | = | *Өмчийн өртөг (хорогдуулах хувь).* |

### 5.3.1 Хорогдуулах хувь

- Хэрэв ХМУ-ын аргад ашиглаж буй мөнгөн урсгал нь зөвхөн өмчид хамааралтай (тухайлбал, Үлдэгдэл Ашгийн загвар болон НАХ загвар) бол өмчийн өртөг (cost of equity)-ийг хорогдуулах хувь болгон ашиглах нь зохистой. Өмчийн өртгийг тооцоолоход Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвар (КХҮЗ, Capital Asset Pricing Model, CAPM)-ыг ашиглах нь түгээмэл байдаг.

- Өмчийн өртгийг Өргөтгөсөн Капитал Хөрөнгийн Үнэлгээний Загвар (extended-CAPM)-ийг ашиглан тооцсон:

$$K_e = R_f + \beta_l \cdot (R_m - R_f) + CSP$$

*Энд:*

| | | |
|---|---|---|
| $K_e$ | = | *Өмчийн өртөг (cost of equity);* |
| $R_f$ | = | *Эрсдэлгүй хүүгийн түвшин;* |
| $\beta_l$ | = | *Өмчийн бета;* |
| $R_m$ | = | *Өмчийн зах зээлийн өгөөж;* |
| $(R_m - R_f)$ | = | *Өмчийн эрсдэлийн шагнал;* |
| $CSP$ | = | *Компанийн тусгайлсан эрсдэлийн шагнал.* |

### *Эрсдэлгүй хүүгийн түвшин ($R_f$)*

- Эрсдэлгүй хүүгийн түвшин нь өмчийн өртгийн нэг чухал хэсэг юм.
- Аливаа улсын эрсдэлгүй хүүгийн түвшинг ихэнх тохиолдолд тухайн улсын Засгийн газрын үндэсний мөнгөн тэмдэгтээр гаргасан урт хугацаат бондын өгөөжөөр илэрхийлдэг. ХМУ-ын загварт эрсдэлгүй өгөөжийг 5 эсхүл 10 жилийн хугацаатай бондын өгөөжөөр илэрхийлэх нь түгээмэл байдаг хэдий ч одоогоор зах зээл дээр Монгол улсын Засгийн газрын төгрөгөөр гаргасан урт хугацаат бонд байхгүй байна.
- Тиймээс, бид олон улсын зах зээл дээр арилжаалагдаж буй Монгол улсын Засгийн газрын ам.долларын 10 жилийн хугацаатай бондыг сонгон авч тооцоололдоо ашигласан бөгөөд Фишерийн тэгшитгэлийг ашиглан төгрөгийн эрсдэлгүй хүүг тооцоолсон:

$$R_f = i + P_M - P_{US}$$

*Энд:*

| | | |
|---|---|---|
| $i$ | = | *"Century бонд" (2031)-ын хугацааны эцэс хүртэлх өгөөж;* |
| $P_M$ | = | *Монгол улсын инфляцын дундаж хүлээлт;* |
| $P_{US}$ | = | *АНУ-ын инфляцын дундаж хүлээлт.* |

- Century бонд нь Монгол улсын Засгийн газраас олон улсын зах зээл дээр гаргасан, 2031 онд хугацаа нь дуусах бонд юм. 2022 оны 12-р сарын 31-ний байдлаар дуусгавар хугацаа хүртэлх хүлээгдэж буй жилийн дундаж өгөөж (yield-to-maturity) нь 8.05% байна.
- Инфляцын хүлээлтийн хувьд ОУВС-гийн Монгол болон АНУ-ын инфляцын түвшингийн төсөөллийг ашигласан ба 2027 оны эцэст Монгол улсын инфляцын төсөөлөл 6.0%, АНУ-ын инфляцын төсөөлөл 2.1% байна гэж таамаглажээ.

*Хүснэгт 16. Эрсдэлгүй хүүгийн тооцоолол*

| *Эрсдэлгүй хүүгийн тооцоолол* | *%* | *Эх сурвалж* |
|---|---|---|
| Засгийн газрын бондын өгөөж (ам.доллар, 10 жил) | 8.05% | Bloomberg |
| Монгол улсын инфляцын төсөөлөл | 6.00% | ОУВС 2027 оны төсөөлөл |
| АНУ-ын инфляцын төсөөлөл | 2.10% | ОУВС 2027 оны төсөөлөл |
| **Төгрөгийн эрсдэлгүй хүүгийн түвшин** | **11.95%** | |

*Эх сурвалж: Bloomberg, ОУВС, БДО Монгол шинжилгээ*

- Бид дээрх тооцоог Монголын арилжааны банкууд дахь төгрөгийн урт хугацаат хадгаламжийн жинлэсэн дундаж хүүг ашиглан шалгасан. 20 сая төгрөгөөс доош үлдэгдэлтэй бүх хадгаламжийн дансыг Хадгаламжийн даатгалын корпорацаас даатгадаг тул дийлэнх хугацаатай хадгаламжийн данс бодит байдал дээр эрсдэлгүй гэж хэлж болно.

*Хүснэгт 17. Системийн нөлөө бүхий арилжааны банкуудын урт хугацаат хадгаламжийн зарласан хүү*

| | *Нэрлэсэн хүүгийн хувь* |
|---|---|
| Хаан Банк | 12.3% |
| Худалдаа Хөгжлийн Банк | 13.0%-13.5% |
| Голомт Банк | 12.5% |
| Төрийн Банк | 12.5%-12.8% |
| Хас Банк | 12% |

*Эх сурвалж: Банкуудын цахим хуудас*

- Дээрх хүснэгтээс харахад нэг жилээс дээш хугацаатай төгрөгийн хадгаламжийн дансны жилийн дундаж хүү 12%-иас 13% орчимд байсан нь Хүснэгт 16-д харуулсан тооцооллын үр дүнг дэмжиж байна.

### *Бета ($\beta$)*

- Бета нь компанийн хувьцаанд агуулагдаж буй системийн шинжтэй эрсдэлийн хэмжүүр бөгөөд түүнийг тооцохдоо тухайн хувьцааны өгөөж болон хувьцааны индексээр хэмжсэн зах зээлийн өгөөжийн хамаарлыг ашиглан тооцдог.

- Хувьцаа нь бирж дээр арилжаалагддаг компанийн өмчийн (хөшүүргэтэй) бета (levered beta)-г дараах томьёогоор тооцоолдог:

$$\beta_i = \frac{\sigma_{im}}{\sigma_m^2}$$

*Энд:*

| | | |
|---|---|---|
| $\beta_i$ | = | *i компанийн хөшүүргэтэй бета;* |
| $\sigma_{im}$ | = | *i компанийн хувьцааны ханш болон зах зээлийн индексийн ковариац;* |
| $\sigma_m^2$ | = | *Зах зээлийн индексийн дисперс.* |

- Дээрх томьёог ашиглан тооцсон жишиг компаниудын хөшүүрэгдсэн бета нь тухайн компани тус бүрийн капиталын бүтэц (хөшүүрэг)-ийг агуулсан байгаа тул бид дараах томьёог ашиглан хөшүүргийн нөлөөг арилгасан.

- Хөрөнгийн (хөшүүрэггүй) бета (unlevered beta)-г тооцох томьёо:

$$\beta_u = \frac{\beta_l}{\left[1 + \left(\frac{Debt}{Equity}\right) \cdot (1 - Tax)\right]}$$

*Энд:*

| | | |
|---|---|---|
| $\beta_u$ | = | *Хөшүүрэггүй бета (хөрөнгийн бета);* |
| $\beta_l$ | = | *Хөшүүрэгтэй бета (өмчийн бета);* |
| $Debt/Equity$ | = | *Өр /Өмч харьцаа (Debt/Equity ratio);* |
| $Tax$ | = | *Татварын хувь (Effective tax rate).* |

- Бид сонгосон компани тус бүрийн хөшүүргийн харьцаа болон аж ахуйн нэгжийн орлогын албан татварын хувь хэмжээг ашиглан хөшүүрэггүй бетаг тооцоолсон. Сонголтоос бетагүй эсхүл сөрөг бетатай тохиолдлыг хассан. Дараа нь бид сонгосон зах зээлийн хөшүүрэггүй бетаны медианаар ХасБанкны хөшүүрэггүй бетаг тооцсон.

- Хүснэгт 15-д сонгосон ижил төстэй компаниудын жагсаалтаас Бета тооцоход ашиглах 13 гадаадын банкны жагсаалтыг холбогдох статистикийн хамт доор харуулав. Бид банк бүрийн хөшүүрэггүй бета болон тэдгээрийн медианыг тооцоолсон бөгөөд үүнийг ХасБанкны хувьд хөшүүрэггүй бета болгон ашигласан:

*Хүснэгт 18. Жишиг компаниудын хөшүүрэггүй бета*

| # | Жишиг компаниуд | Ур ашигт татварын хувь | Өр/өмч харьцаа | Бета (5 жил) | Хөшүүрэггүй бета |
|---|---|---|---|---|---|
| 1 | Moneta Money Bank | 18.85 | 11.19 | 0.67 | 0.07 |
| 2 | Bank of Maharashtra | 37.71 | 14.33 | 0.83 | 0.08 |
| 3 | Equitas Holdings | 26.92 | 0.61 | 1.57 | 1.09 |
| 4 | Bank Tabungan Negara | 18.40 | 14.28 | 1.60 | 0.13 |
| 5 | HS Holdings | 37.05 | 5.20 | 0.35 | 0.08 |
| 6 | Halyk Savings Bank | 12.88 | 6.14 | 0.62 | 0.10 |
| 7 | Bank Handlowy w Warszawie | 22.45 | 7.44 | 0.65 | 0.10 |
| 8 | Banca Transilvania | 11.86 | 12.02 | 0.81 | 0.07 |
| 9 | BRD Groupe Societe Generale | 17.61 | 10.06 | 0.80 | 0.09 |
| 10 | Kiatnakin Bank | 19.39 | 7.11 | 0.87 | 0.13 |
| 11 | Aeon Thana Sinsap | 20.23 | 3.08 | 1.09 | 0.32 |
| 12 | Military Commercial | 20.04 | 7.17 | 0.96 | 0.14 |
| 13 | Sacombank | 25.82 | 13.60 | 1.00 | 0.09 |
| | **Медиан буюу голч утга** | 20.83 | 7.44 | 0.83 | **0.10** |

*Эх сурвалж: PitchBook Data, БДО Монгол шинжилгээ*

- Хөрөнгийн бета нь тухайн хөрөнгө оруулалт бүхэлдээ хувьцаагаар санхүүжиж байгаа нөхцөлд шаардлагатай өгөөжийн хэмжээг тусгах зорилгоор капиталын бүтцээс өрийн нөлөөг хассан бета юм. Тиймээс бид сонгон авсан капиталын бүтцээр бета-г дахин өргөтгөж, хөшүүрэгдсэн буюу өмчийн бета-г тооцоолох шаардлагатай. Ингэж тооцоолсон бета нь үнэлгээ хийж буй компанийн санхүүгийн хөшүүргийн түвшинг тусгайлан тохируулсан зах зээлийн суурь бета болдог. Бета-г дахин өргөтгөх томьёо дараах байдалтай байна:

$$\beta_l = \beta_u \cdot \left[1 + \left(\frac{Debt}{Equity}\right) \cdot (1 - Tax)\right]$$

*Энд:*

| | | |
|---|---|---|
| $\beta_l$ | = | *Дахин хөшүүрэгдсэн бета (өмчийн бета);* |
| $\beta_u$ | = | *Хөшүүрэггүй бета (хөрөнгийн бета);* |
| $Debt/Equity$ | = | *Өр/Өмч харьцаа;* |
| $Tax$ | = | *Татварын ур ашигт хувь.* |

- ХасБанкны бета-н тооцооллыг доор харуулав:

*Хүснэгт 19. Тохируулсан бета-н тооцоолол*

| Хөшүүрэгдсэн бета | Утга | Эх сурвалж |
|---|---|---|
| Хөшүүрэггүй бета | 0.10 | Хүснэгт 18 |
| Өр/Өмч харьцаа | 7.04 | Үнэлгээний өдрийн Өр/Өмч харьцаа |
| Татварын хувь | 25% | 2023-2027 оны санхүүгийн төсөөллийн дундаж |
| **Тохируулсан бета** | **0.60** | |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

**Өмчийн өртөг ($K_e$)**

- Өргөтгөсөн КХҮЗ загварыг ашиглан тооцоолсон ХасБанкны өмчийн өртөг дараах байдалтай байна:

*Хүснэгт 20. Өмчийн өртгийн тооцоолол*

| Өмчийн өртгийн тооцоолол | | Эх сурвалж |
|---|---|---|
| Эрсдэлгүй хүүгийн түвшин | 11.95% | Хүснэгт 16 |
| Тохируулсан бета | 0.60 | Хүснэгт 19 |
| Өмчийн эрсдэлийн шагнал | 10.12% | Проф. Дамодаран[3], БДО Монгол шинжилгээ (2023/01/05) |
| Тусгайлсан эрсдэлийн шагнал | 2.25% | БДО Монгол шинжилгээ |
| **Өмчийн өртөг** | **20.30%** | |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

[3] Country Default Spreads and Risk Premiums, January 5, 2023 https://pages.stern.nyu.edu/~adamodar/

- Өмчийн эрсдэлийн шагналд Нью Йоркийн Их Сургуулийн профессор Асват Дамодараны тооцоолсон Монгол улсын Өмчийн эрсдэлийн шагналыг ашигласан. Проф. Дамодаран дэлхийн улс орнуудын өмчийн эрсдэлийн шагналыг тухайн улсуудын зээлжих зэрэглэлд суурилан тооцоолж өөрийн веб хуудаст нийтэлдэг бөгөөд энэ нь үнэлгээний практикт түгээмэл хэрэглэгддэг эх сурвалж юм. Проф. Дамодаран Мүүдийс агентлагийн "B3" зээлжих зэрэглэлтэй бүх улсад тогтмол нэг credit default swap-ийн хувь ашигласан байсныг бид Монгол улсын Засгийн газрын бондын бодит credit default spread-ийн хувийг ашиглан сайжруулсан.

- Тусгайлсан эрсдэлийн шагналыг Банкнаас ирүүлсэн мэдээлэл, хорогдуулах хувь болон үнэлгээний тооцооллын мэдээллийн үйлчилгээ үзүүлдэг Valutico-ийн аргачлалыг ашиглан тооцоолсон.

- Дээрх тооцооллуудад үндэслэн дүгнэхэд, хувьцаанд хөрөнгө оруулагчид Үнэлгээний өдрийн байдлаар ХасБанкны хувьцаанд хөрөнгө оруулалт хийхийн тулд хамгийн багадаа жилийн 20.30%-ийн өгөөж шаардахаар байна.

### 5.3.2 Хяналтгүй хувь оролцооны хямдруулалт

- Хувьцааг худалдан авч буй этгээд компанийн хяналтын багцыг авах, эсвэл нөлөө бүхий хувьцаа эзэмшигч болохын тулд хувьцааны зах зээлийн үнээс дээгүүр үнэ төлөхөд бэлэн байгаа тохиолдолд бизнесийн үнэлгээний үр дүн дээр хяналттай хувь оролцооны шагналыг нэмж өгөх шаардлагатай байдаг. Үүний эсрэгээр, тооцоолсон үнэ цэнэ нь хяналттайн урамшууллыг агуулж байгаа боловч үнэлгээний ажил нь цөөнхийн оролцооны үнэ цэнийг тооцоолох зорилготой байгаа тохиолдолд хяналтгүй хувь оролцооны хямдруулалтаар тохируулах шаардлагатай байдаг. Зах зээлийн нөхцөл байдал болон ашигласан өгөгдлөөс шалтгаалан хөгжсөн зах зээл дэх хяналтгүй хувь оролцооны хямдруулалт ойролцоогоор 15%-аас 25%-ийн хооронд байдаг.[4]

- Доорх зурагт үнэлгээний хяналттай хувь оролцооны шагнал болон хяналтгүй хувь оролцооны хямдруулалтын өөр өөр түвшнүүдийг харуулж байна:




- ХасБанкны хувьд бид доорх шалтгаануудын улмаас хяналтгүй хувь оролцооны хямдруулалтыг тооцохгүй байхаар шийдвэрлэсэн:
  - Хүснэгт 6-д үзүүлсэн Банкны аль ч хувьцаа эзэмшигч Банкны шийдвэр гаргалтуудад чухал нөлөө эсвэл хяналт тавих боломжгүй. Хамгийн том хувьцаа эзэмшигч тус Банкны 20%-ийг эзэмшдэг бөгөөд ТУЗ-д зөвхөн нэг гишүүн томилсон байгаа;
  - ОУСК болон ЕСБХБ зэрэг компанийн засаглалын өндөр стандартыг хэрэгжүүлдэг нэр хүндтэй олон улсын санхүүгийн байгууллагууд тус Банкны хувьцаа эзэмшигчид байна;
  - 12 хувьцаа эзэмшигчдийн дунд хоорондоо холбоо хамаатай талууд байхгүй.

[4] "Control Premiums: A Deep Dive Into The New Data On Invested Capital Premiums" тайлан





СЗХ 2023.05.12-ны өдөр БҮРТГЭВ № 01

## 6. Өмчийн үнэлгээ

## 6.1 Орлогын хандлага

### 6.1.1 Үлдэгдэл Ашгийн загвар-БДО-ийн дүгнэлт гаргасан хувилбар

***Үлдэгдэл Ашгийн загварт ашигласан өсөлтийн төсөөлөл***

- Бид өнгөрсөн жилүүдийн ХасБанкны санхүүгийн гүйцэтгэл болон арилжааны банкны салбарын гүйцэтгэлээрх өсөлт, тус Банк нь системийн банкууд дотор хэмжээгээр тавд эрэмбэлэгдэж байгаа нөхцөл байдал зэргийг харгалзсан. Дараах хүснэгтэд харуулсанчлан дунд хугацаанд цэвэр ашгийн өсөлт хамгийн ихдээ 16.3%-д хүрч, үлдэх хугацаанд Монгол улсын эдийн бодит өсөлтийн түвшинд хадгалагдана гэсэн төсөөллийг үнэлгээний дүгнэлт гаргасан Үлдэгдэл Ашгийн загварын үнэлгээний тооцоолold ашигласан.

*Хүснэгт 21. Үлдэгдэл Ашгийн загварт ашигласан өсөлтийн төсөөлөл*

| | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 | Терминал хугацаа |
|---|---|---|---|---|---|---|
| Цэвэр ашгийн өсөлт | 16.0% | 15.6% | 16.3% | 16.3% | 14.3% | |
| Үлдэх хугацааны өсөлт | | | | | | 5% |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

***Үлдэгдэл Ашгийн загварын үнэлгээний үр дүн***

- Бид өөрсдийн үнэлгээний шинжилгээ болон ХасБанкны удирдлагаас ирүүлсэн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2023-2027)-д суурилан тус Банкны ирээдүйн Үлдэгдэл Ашгийг тооцоолж, өмчийн зах зээлийн үнэ цэнийг тодорхойлсон. Үлдэгдэл Ашгийн загварыг ашиглан үнэ цэнийг тооцохдоо 35-р хуудсан дахь томьёог ашигласан.
- Мөнгөн урсгалын төсөөлөл нь Банкны удирдлагаас бидэнд ирүүлсэн Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2023-2027)-д суурилсан.
- Бид хорогдуулах хувийг Үнэлгээний өдрөөр тооцоолсон өмчийн өртөг болох 20.30%-аар сонгосон.
- Бид прогнозын хугацааны туршид өмчийн өртгөөс давсан Үлдэгдэл Ашиг (residual income)-ийг жил бүрийн өмчийн өгөөж ба өмчийн өртгийн зөрүүгээс тооцсон.

*Хүснэгт 22. Үлдэгдэл Ашгийн загварт ашиглагдсан санхүүгийн төсөөлөл*

| сая төгрөг | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Цэвэр ашиг | 122,759 | 141,886 | 164,949 | 191,761 | 219,112 |
| Эздийн өмч | 561,618 | 660,939 | 776,403 | 908,138 | 1,061,516 |
| Өмчийн өгөөж | 25.81% | 25.26% | 24.96% | 24.70% | 24.13% |
| Өмчийн өртөг | 20.30% | 20.30% | 20.30% | 20.30% | 20.30% |
| Үлдэгдэл өгөөж | 5.51% | 4.96% | 4.66% | 4.40% | 3.83% |
| **Үлдэгдэл ашиг** | 26,194 | 27,877 | 30,779 | 34,152 | 34,760 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- 2027 оноос хойших хугацааны хувьд, бизнесийн терминал үнэ цэнэ (terminal value) буюу эцсийн мөнгөн урсгалыг Гордоны өсөлтийн загвар ашиглан тодорхойлсон. Ингэхдээ урт хугацааны өсөлтийг Хүснэгт 21-д харуулсанчлан 5%-тай тэнцүү гэж авсан.

*Хүснэгт 23. Үлдэгдэл Ашгийн загварт ашиглагдсан терминал үнэ цэнийн тооцоолол*

| сая төгрөг | |
|---|---|
| Хорогдуулах хувь | 20.30% |
| Урт хугацааны өсөлт | 5% |
| 2027 оны Үлдэгдэл ашиг | 34,760 |
| **Терминал үнэ цэнэ (2027 онд)** | **238,552** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- 2023-2027 оны Үлдэгдэл Ашиг болон терминал үнэ цэнүүдийн өнөөгийн үнэ цэнийг дараах байдлаар тооцсон:

*Хүснэгт 24. Үлдэгдэл Ашгийн өнөөгийн үнэ цэнийн тооцоолол*

| сая төгрөг | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Үлдэгдэл ашиг | 26,194 | 27,877 | 30,779 | 34,152 | 34,760 |
| Терминал үнэ цэнэ | | | | | 238,552 |
| Хорогдуулах үе | 0.5000 | 1.5000 | 2.5000 | 3.5000 | 4.5000 |
| Хорогдуулах хүчин зүйл | 0.9117 | 0.7579 | 0.6300 | 0.5237 | 0.4353 |
| **Үлдэгдэл Ашгийн ӨҮЦ** | 23,882 | 21,128 | 19,390 | 17,885 | 15,132 |
| **Терминал үнэ цэнийн ӨҮЦ** | | | | | 103,846 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Үлдэгдэл Ашгийн загварын үр дүнгээс дүгнэхэд, Үнэлгээний өдрөөр, IPO-н өмнөх байдлаар ХасБанкны нийт өмчийн зах зээлийн үнэ цэнэ **676,950 сая төгрөг** байна.

*Хүснэгт 25. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх)*

| *сая төгрөг* | |
|---|---|
| 2022 оны эцсээрх өмчийн дүн | 475,687 |
| 2027 он хүртэлт Үлдэгдэл ашгийн ӨҮЦ | 97,417 |
| Терминал үнэ цэнийн ӨҮЦ | 103,846 |
| **Нийт өмчийн зах зээлийн тооцоолсон үнэ цэнэ** | **676,950** |
| **Бүхлээр** | **677,000** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон ХасБанкны нэгж хувьцаанд ногдох зах зээлийн тооцоолсон үнэ цэнэ **677 төгрөг** байна.

*Хүснэгт 26. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (IPO-н өмнөх)*

| *сая төгрөг* | |
|---|---|
| Нийт өмчийн зах зээлийн тооцоолсон үнэ цэнэ | 677,000 |
| Энгийн хувьцааны тоо | 1,000,000,000 |
| **Нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (төгрөг)** | **677** |
| *(Дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа =1.42x)* | |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

### Мэдрэмжийн шинжилгээ

- Инфляцын түвшин өндөр байгаа өнөөгийн эдийн засгийн орчин, Ковид-19-ын дараах эдийн засагт учирсан савлагаа, дэлхийг хамарсан дайны нөхцөл байдлын эдийн засагт үзүүлэх нөлөөнөөс үүссэн эдийн засгийн тогтворгүй байдал үргэлжилж байгаа нөхцөлийг харгалзан бид үнэлгээний үр дүнг тодорхой интервалтайгаар санал болгох нь зүйтэй гэж үзсэн.

- Зэргэлдээ хүснэгт нь хорогдуулах хувийн болон урт хугацааны тогтмол өсөлтийн хувийн өөрчлөлтөд тооцоолсон үнэ цэнэ хэр мэдрэмжтэй байгааг харуулсан мэдрэмжийн шинжилгээ юм.

*Хүснэгт 27. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон өмчийн үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н өмнөх)*

| | Зах зээлийн үнэ цэнэ (сая төгрөг) | Урт хугацааны өсөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3% | 4% | 5% | 6% | 7% |
| Хорогдуулах хувь | 18.3% | 787,498 | 800,931 | 816,384 | 834,349 | 855,495 |
| | 19.3% | 721,411 | 730,891 | 742,000 | 754,125 | 768,576 |
| | 20.3% | 663,195 | 669,651 | 677,000 | 685,270 | 694,841 |
| | 21.3% | 611,540 | 615,667 | 620,000 | 625,538 | 631,508 |
| | 22.3% | 565,410 | 567,733 | 570,325 | 573,234 | 576,524 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээг доор харуулав:

*Хүснэгт 28. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ*

| | Нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (төгрөг) | Урт хугацааны өсөлт | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| | | 3% | 4% | 5% | 6% | 7% |
| Хорогдуулах хувь | 18.3% | 787 | 801 | 816 | 834 | 855 |
| | 19.3% | 721 | 731 | 742 | 754 | 769 |
| | 20.3% | 663 | 670 | 677 | 685 | 695 |
| | 21.3% | 612 | 616 | 620 | 626 | 632 |
| | 22.3% | 565 | 568 | 570 | 573 | 577 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

### Дээд хязгаар – Өмчийн өртөг 1%-иар буурах хувилбар

- Дээрх мэдрэмжийн шинжилгээний хүснэгтээс бид 5%-ийн урт хугацааны өсөлтийн хувьтай, 19.3%-ийн хорогдуулах хувьтай байх үеийн Үлдэгдэл Ашгийн загварын хувилбарыг үнэлгээний интервалын дээд хязгаараар авахаар шийдсэн. Монгол улс нь өсөлтийн өндөр үе шатандаа яваа хөгжиж буй эдийн засаг тул урт хугацааны өсөлтийг 5%-тай тэнцүү гэж авах, хөрөнгийн зах зээл дээрх суурь хүүгийн түвшин буцаж



СЭХ 2023 он 05 сар 12 өдөр БҮРТГЭВ № 01

тогтворжиход өмчийн өртөг өнөөгийн түвшнээс хамгийн багадаа 1% буурах магадлал өндөр учраас энэ төсөөлөл үндэслэлтэй гэж үзэж байна.

- Энэ хувилбарын дагуу, ХасБанкны IPO хийхээс өмнөх байдлаар Үлдэгдэл Ашгийн загварыг ашиглан тооцсон хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнэ **741,695 буюу бүхлээр 742,000 сая төгрөг,** харин нэгж хувьцааны үнэ цэнэ **742 төгрөг** байна.

***Доод хязгаар - Өмчийн өртөг 1%-иар өсөх хувилбар***

- Өмнөх мэдрэмжийн шинжилгээний хүснэгтээс бид 5%-ийн урт хугацааны өсөлтийн хувьтай, 21.3%-ийн хорогдуулах хувьтай байх үеийн Үлдэгдэл Ашгийн загварын хувилбарыг үнэлгээний интервалын доод хязгаараар авахаар шийдсэн. Монгол улс нь өсөлтийн өндөр үе шатандаа яваа хөгжиж буй эдийн засаг тул урт хугацааны өсөлтийг 5%-тай тэнцүү гэж авах үндэслэлтэй ба хөрөнгийн зах зээл дээрх суурь хүүгийн түвшин буцаж тогтворжихгүй улам муудах тохиолдолд өмчийн өртөг өнөөгийн түвшнээс хамгийн багадаа 1% өсөх магадлал өндөр учраас энэ төсөөлөл магадлалтай гэж үзэж байна.

- Энэ хувилбарын дагуу, ХасБанкны IPO хийхээс өмнөх байдлаар Үлдэгдэл Ашгийн загварыг ашиглан тооцсон хувьцаа эзэмшигчдийн нийт өмчийн зах зээлийн үнэ цэнэ **620,299 буюу бүхлээр 620,000 сая төгрөг**, харин нэгж хувьцааны үнэ цэнэ **620 төгрөг** байна.

СЗХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05
БҮРТГЭВ-02

### 6.1.2 Үлдэгдэл Ашгийн загвар-Банкны бизнес төлөвлөгөөнд суурилсан хувилбар

- Бид ХасБанкнаас ирүүлсэн бизнес төлөвлөгөөнд тусгагдсан цэвэр ашгийн төсөөллийг ямар нэгэн засваргүйгээр ашиглан Үлдэгдэл Ашгийн загвараар хийх үнэлгээг тооцоолсон. Банкнаас ирүүлсэн санхүүгийн төсөөллийг доор харуулав:

*Хүснэгт 29. Үлдэгдэл Ашгийн загварт ашиглагдсан банкны санхүүгийн төсөөлөл*

| сая төгрөг | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Цэвэр ашиг | 122,759 | 141,886 | 164,949 | 200,090 | 228,629 |
| Эздийн өмч | 561,618 | 660,939 | 776,403 | 916,466 | 1,076,507 |
| Өмчийн өгөөж (ROE) | 25.81% | 25.26% | 24.96% | 25.77% | 24.95% |
| Өмчийн өртөг | 20.30% | 20.30% | 20.30% | 20.30% | 20.30% |
| Зөрүү | 5.51% | 4.96% | 4.66% | 5.47% | 4.65% |
| **Үлдэгдэл ашиг** | **26,194** | **27,877** | **30,779** | **42,480** | **42,586** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Банкнаас ирүүлсэн бизнес төлөвлөгөөнд суурилсан төсөөллийн хүрээнд терминал үнэ цэнийн тооцооллыг доор харуулав:

*Хүснэгт 30. Терминал үнэ цэнийн тооцоолол-Банкны хувилбар*

| сая төгрөг | |
|---|---|
| Хорогдуулах хувь | 20.3% |
| Урт хугацааны өсөлт | 5% |
| 2027 оны Үлдэгдэл Ашиг | 42,586 |
| **Терминал үнэ цэнэ (2027)** | **292,260** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Банкны бизнес төсөөллийн хүрээнд Үнэлгээний өдрийн байдлаар өнөөгийн үнэ цэнийн тооцооллыг зэргэлдээ хүснэгтээр харуулав:

*Хүснэгт 31. Үлдэгдэл Ашгийн өнөөгийн үнэ цэнэ (Банкны хувилбар)*

| сая төгрөг | 2023 | 2024 | 2025 | 2026 | 2027 |
|---|---|---|---|---|---|
| Үлдэгдэл ашиг | 26,194 | 27,877 | 30,779 | 42,480 | 42,586 |
| Терминал үнэ цэнэ | | | | | 292,260 |
| Хорогдуулах үе | 0.500 | 1.500 | 2.500 | 3.500 | 4.500 |
| Хорогдуулах хүчин зүйл | 0.9117 | 0.7579 | 0.6300 | 0.5237 | 0.4353 |
| **Үлдэгдэл ашгийн ӨҮЦ** | 23,882 | 21,128 | 19,390 | 22,246 | 18,539 |
| **Терминал үнэ цэнийн ӨҮЦ** | | | | | 127,225 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Банкны бизнес төлөвлөгөөнд суурилсан төсөөллөөр, Үлдэгдэл Ашгийн загварын тооцооллоор, ХасБанкны Үнэлгээний өдрөөрх хувьцаа эзэмшигчдийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь **708,098 сая төгрөг**, нэгж хувьцааны үнэ цэнэ нь **708 төгрөг** байна.

*Хүснэгт 32. Үлдэгдэл Ашгийн загвараар тооцсон өмчийн зах зээлийн үнэ цэнэ (Банкны хувилбар, IPO-н өмнөх)*

| сая төгрөг | |
|---|---|
| 2022 оны 12 сарын 31-ний өмчийн дүн | 475,687 |
| 2027 он хүртэлх Үлдэгдэл ашгийн ӨҮЦ | 105,185 |
| Терминал үнэ цэнийн ӨҮЦ | 127,225 |
| **Нийт хувьцааны зах зээлийн үнэ цэнэ** | **708,098** |
| Энгийн хувьцааны тоо | 1,000,000,000 |
| **Нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (төгрөг)** | **708** |
| *(Дүйцүүлсэн Үнэ/Данс харьцаа = 1.49x)* | |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

СЭХ
он 2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01



BDO

### Мэдрэмжийн шинжилгээ

- Доорх хүснэгт нь хорогдуулах хувь болон урт хугацааны тогтмол өсөлтийн хувийн өөрчлөлтөд тооцоолсон үнэ цэнэ хэр мэдрэмжтэй байгааг харуулсан мэдрэмжийн шинжилгээ юм.

*Хүснэгт 33. Үлдэгдэл Ашгийн загвар: Банкны төсөөлөлд суурилсан хувилбараар тооцсон өмчийн үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ (IPO-н өмнөх)*

| | Зах зээлийн үнэ цэнэ (сая төгрөг) | Урт хугацааны өсөлт 3% | 4% | 5% | 6% | 7% |
|---|---|---|---|---|---|---|
| Хорогдуулах хувь | 18.3% | 821,133 | 836,595 | 854,381 | 875,060 | 899,399 |
| | 19.3% | 752,067 | 763,256 | 776,010 | 790,682 | 807,740 |
| | 20.3% | 691,247 | 699,155 | 708,098 | 718,291 | 730,017 |
| | 21.3% | 637,302 | 642,672 | 648,702 | 655,519 | 663,291 |
| | 22.3% | 589,145 | 592,540 | 596,327 | 600,579 | 605,387 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

- Нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээг доор харуулав:

*Хүснэгт 34. Үлдэгдэл Ашгийн загвар: Банкны төсөөлөлд суурилсан хувилбараар тооцсон нэгж хувьцааны үнэ цэнийн мэдрэмжийн шинжилгээ*

| | Нэгж хувьцааны зах зээлийн үнэ цэнэ (төгрөг) | Урт хугацааны өсөлт 3% | 4% | 5% | 6% | 7% |
|---|---|---|---|---|---|---|
| Хорогдуулах хувь | 18.3% | 821 | 837 | 854 | 875 | 899 |
| | 19.3% | 752 | 763 | 776 | 791 | 808 |
| | 20.3% | 691 | 699 | 708 | 718 | 730 |
| | 21.3% | 637 | 643 | 649 | 656 | 663 |
| | 22.3% | 589 | 593 | 596 | 601 | 605 |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

### Банкны бизнес төлөвлөгөөнд суурилсан хувилбарын үнэ цэнийн хүрээ

- Дээрх мэдрэмжийн шинжилгээний хүснэгтээс дүгнэхэд, Банкны бизнес төлөвлөгөөнд суурилсан Үлдэгдэл Ашгийн загвараар тус Банкны 100%-ийн өмчийн зах зээлийн үнэ цэнэ нь **648,702 сая төгрөгөөс 776,010 сая** (суурь төсөөллөөр 708,098 сая төгрөг) төгрөгийн хооронд байна.

- Энэ хувилбарын дагуу, ХасБанкны IPO хийхээс өмнөх байдлаар Үлдэгдэл Ашгийн загварыг ашиглан тооцсон хувьцаа эзэмшигчдийн нэгж хувьцааны үнэ цэнэ нь **649 төгрөгөөс 776 төгрөг** (суурь төсөөлөл: 708 төгрөг)-ийн хооронд байна.

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

### 6.1.3 Ногдол Ашиг Хорогдуулах загвар

- Банкны Дунд Хугацааны Санхүүгийн Төсөөлөл (2023-2027)-д тусгаснаар, ХасБанк нь олон нийтийн компани болсноор жил бүр ногдол ашиг тараахаар төлөвлөжээ.

| 34 | Налайх т.т | 662.0 | 308.6 | 307.5 | 616.1 |
| 35 | Бор-Өндөр т.т | 302.0 | 208.2 | 71.1 | 279.3 |
| 36 | Увс 25-р т.т | 168.0 | 221.3 | 12.6 | 233.8 |
| 37 | Дорноговь салбар | 300.0 | 202.5 | 282.4 | 484.9 |
| 38 | БГД 13-р хороо т.т | 287.0 | 550.4 | 17.5 | 567.9 |
| 39 | БЗД 11-р хороо 6-р байр зогсоол | 490.7 | 232.3 | 67.1 | 299.3 |
| 40 | БЗД 11-р хороо 8-р байр зогсоол | 512.0 | 242.4 | 70.0 | 312.4 |
| 41 | Цогтцэций т.т | 53.5 | 117.2 | - | 117.2 |
| 42 | Цогтцэций орон сууц | 48.0 | 88.5 | 10.7 | 99.2 |
| 43 | Хөтөл т.т | 66.7 | 72.9 | 2.8 | 75.7 |
| 44 | Замын-Үүд т.т | 60.6 | 74.1 | 3.1 | 77.3 |
| 45 | Цогтцэций орон сууц | 30.0 | 55.3 | 6.7 | 62.0 |
| 46 | Цогтцэций орон сууц | 30.0 | 55.3 | 6.7 | 62.0 |
| 47 | Цогтцэций орон сууц | 29.0 | 53.5 | 6.4 | 59.9 |
| 48 | Цогтцэций орон сууц | 29.0 | 53.5 | 6.4 | 59.9 |
| 49 | Цогтцэций орон сууц | 19.0 | 35.0 | 4.2 | 39.3 |
| 50 | Цогтцэций орон сууц | 19.0 | 35.0 | 4.2 | 39.3 |
| 51 | Цогтцэций орон сууц | 19.0 | 35.0 | 4.2 | 39.3 |
| 52 | Цогтцэций орон сууц | 19.0 | 35.0 | 4.2 | 39.3 |
| 53 | БЗД 6-р хороо, 8в-101б | 114.7 | 504.4 | 12.9 | 517.4 |
| 54 | БЗД 11-р хороо | 540.0 | 280.7 | 231.5 | 512.2 |
| | Барилын дүн | | 20,835.8 | 8,287.1 | 31,027.1 |

388



BDO

| # | Үндсэн хөрөнгийн нэр | Хэмжээ м2 | Бодит үнэ цэнэ | Үнэ цэнийн тохируулга | Тооцоолсон зах зээлийн үнэ цэнэ |
|---|---|---|---|---|---|
| | *Барилгажсан газар* | | | | |
| 1 | Төв байр | 2,750.0 | 14,558.7 | 2,256.7 | 16,815.4 |
| 2 | Хөвсгөл 17-р т.т | 810.0 | 228.4 | 63.4 | 291.7 |
| 3 | Өмнөговь 45-р т.т | 750.0 | 28.7 | 23.6 | 52.3 |
| 4 | Цайз т.т | 216.0 | 128.3 | 0.4 | 128.7 |
| 5 | Дархан т.т | 1,600.0 | 150.4 | 361.0 | 511.4 |
| 6 | Архангай 14-р т.т | 980.0 | 108.3 | - | 108.3 |
| 7 | Дорноговь 39-р т.т | 142.0 | 53.2 | - | 53.2 |
| 8 | Увс т.т | 410.0 | 55.1 | - | 55.1 |
| 9 | 5 шар т.т | 3,655.0 | 233.2 | 1,420.7 | 1,653.9 |
| 10 | Сэлэнгэ 32-р т.т | 550.0 | 49.1 | 28.0 | 77.1 |
| 11 | Хэнтий т.т | 1,000.0 | 85.4 | - | 85.4 |
| 12 | Ховд т.т | 1,350.0 | 77.0 | - | 77.0 |
| 13 | Говь-Алтай т.т | 500.0 | 70.8 | - | 70.8 |
| 14 | Сэлэнгэ т.т | 1,435.0 | 107.4 | 93.8 | 201.2 |
| 15 | Булган т.т | 1,920.0 | 60.3 | - | 60.3 |
| 16 | Багануур т.т | 435.0 | 29.2 | 3.7 | 32.9 |
| 17 | Өвөрхангай т.т | 1,308.0 | 90.5 | 93.6 | 184.1 |
| 18 | Дундговь т.т | 1,400.0 | 91.4 | - | 91.4 |
| 19 | Хархорин т.т | 1,500.0 | 68.3 | - | 68.3 |
| 20 | Төв аймаг т.т | 400.0 | 27.5 | - | 27.5 |
| 21 | Өмнөговь т.т | 1,228.0 | 73.7 | - | 73.7 |
| 22 | Тосонцэнгэл т.т | 728.0 | 42.5 | - | 42.5 |
| 23 | Налайх т.т | 662.0 | 100.6 | 26.2 | 126.9 |
| 24 | Бор-Өндөр т.т | 1,564.0 | 39.1 | - | 39.1 |
| 25 | Дорноговь салбар | 300.0 | 43.4 | - | 43.4 |
| 26 | БЗД 11-р хороо | 9,992.0 | 252.2 | 118.5 | 370.7 |
| | ***Барилгажсан газар эзэмших эрх*** | | **16,852.3** | **4,489.7** | **21,342.0** |
| | ***Нийт үл хөдлөх хөрөнгө*** | | **37,688.1** | **12,776.8** | **52,369.1** |

*Эх сурвалж: БДО Монгол шинжилгээ*

### *Үнэлгээчдийн дүгнэлт:*

Бид ХасБанкны үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн үнэ цэнийг ижил төстэй зориулалттай үл хөдлөх хөрөнгийн ойролцоо байршил дахь зах зээлийн мэдээлэлд хийсэн шинжилгээгээр цуглуулсан үнийн мэдээлэлд суурилан үнэлгээний олон улсын стандартаар зөвшөөрдөг зах зээлийн хандлагаар тооцоолж, Банкны нягтлан бодох бүртгэлд тусгагдсан дансны үнэтэй харьцуулан дүн шинжилгээ хийсний үндсэн дээр тухайн дансны үнэд зохих тохируулга хийсэн.

389



СЭХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

**ДЭЛГЭРЭНГҮЙ МЭДЭЭЛЭЛ:**

**ГОМБЫН БАЯНМӨНХ**

**+976 8888 4041**

**+976 7740 4040**

[illegible]

**ДАЛАНБАЯРЫН**

**АЛТАНСҮХ**

**+976 8888 1614**

**+976 7740 4040**

[illegible]

*Монгол улсын хязгаарлагдмал хариуцлагатай компани болох 2546449 бүртгэлийн дугаартай БДО Монгол нь Их Британийн Нэгдсэн Вант Улсын БДО Интернэшнл Лимитедийн гишүүн бөгөөд хараат бус гишүүнчлэлийн хэлбэртэй БДО олон улсын сүлжээний гишүүн пүүс мөн. Гишүүнчлэлийн жагсаалтад бүртгэгдсэн албан ёсны хаягаар БДО Монгол нь Монгол улс, Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг, Нарны зам – 62, Юнеско гудамж, Юнион бюлдинг, 1502 тоотод байрладаг. БДО Монгол нь Санхүүгийн зохицуулах хорооноос мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэх тусгай зөвшөөрөл авсан, зохицуулалттай аж ахуйн нэгж мөн.*

БДО нь БДО сүлжээ болон БДО–ийн гишүүн пүүс бүрийн брэнд нэр юм.

**www.bdo.mn**

# ХАВСРАЛТ 6: Хуулийн фирмийн дүгнэлт болон тусгай зөвшөөрлийн хуулбар

Нууц баримт
Эх хувь

ӨМГӨӨЛЛИЙН БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХН

Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Чингисийн өргөн чөлөө - 15, Монгол ТВ цамхаг, 10-р давхар, 1001-1003 тоот, Утас/Факс: (+976) 7711 9008, Цахим шуудан: contact@bnp.mn. Веб: www.bnp.mn

ХАСБАНК ХХК
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ
ТАНАА

Огноо: 2023.04.06
Дугаар: BNP-22/23
Утга: Хуулийн дүгнэлт

ХАСБАНК
Амьдрала - ашид хамтдаа.

# ХАСБАНК ХХК-ИЙН НИЙТЭД САНАЛ БОЛГОН АНХ УДАА ГАРГАЖ БУЙ ХУВЬЦААГ НИЙТЭД САНАЛ БОЛГОХЫГ ЗӨВШӨӨРСӨН ҮНЭТ ЦААСНЫ БҮРТГЭЛД БҮРТГҮҮЛЭХТЭЙ ХОЛБОГДУУЛАН БЭЛТГЭСЭН ХУУЛИЙН ДҮГНЭЛТ

Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН (цаашид "**Хуулийн фирм**" гэх) нь танай компанитай 2021 оны 10 сарын 08-ны өдөр байгуулсан №14/21-045 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ болон 2023 оны 01 сарын 20-ны өдөр байгуулсан №14/21-045-01 тоот Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ (хамтад нь "**Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээ**" гэх)-ний нэмэлт нөхцөлийн дагуу ХасБанк ХХК (цаашид "**ХасБанк ХХК**", "**Үнэт цаас гаргагч**" эсхүл "**Банк**" гэх)-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэхэд шаардагдах хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэх, улмаар хуулийн дүгнэлт гаргах ажлыг хийхээр тохиролцсон. Уг ажилтай холбогдуулан Хуулийн фирмийн зүгээс Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн бирж ХК (цаашид "**Монголын хөрөнгийн бирж**" гэх)-аас баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-д заасан асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, хуулийн дүгнэлт (цаашид "**Хуулийн дүгнэлт**" гэх)-ийг бэлтгэж үүгээр хүргүүлж байна. Хүлээн авна уу.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь ХасБанк ХХК, түүний эрх бүхий албан тушаалтан болон төрийн эрх бүхий гуравдагч этгээдээс бусад этгээдийн хувьд нууц материалд тооцогдоно. Зөвшөөрөл аваагүй этгээд болон бусад эрх олгогдсон этгээд аливаа хэлбэрээр энэхүү нууц материалд агуулагдсан мэдээ, мэдээллийг хэсэгчлэн болон бүтнээр нь бусдад дамжуулсан, цааш түгээсэн, түгээх нөхцөл боломжийг бүрдүүлсэн, задруулсан бол үүссэн үр дагаврыг бүрэн хариуцахыг анхаарна уу.

Тус Хуулийн фирм нь энэхүү ХасБанк ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргах хувьцааг үнэт цаасны бүртгэлд бүртгүүлэх үйл ажиллагаанд оролцож байгаа андеррайтерийн компани болох тэргүүлэх андеррайтер Райнос Инвестмент ҮЦК ХХК, дэд андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК, үнэлгээний компани БДО Аудит ХХК болон Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК, тэдгээрийн эрх

392



Өмгөөллийн Батбаяр энд Партнэрс ХХН, бизнесийн хуулийн фирм нь үнэт цаасны зах зээлийн оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэх зөвшөөрлийг Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны №72 тоот тогтоолын дагуу авсан болно.

бүхий албан тушаалтан, холбоотой этгээдүүдтэй аливаа байдлаар харилцан хамааралгүй бөгөөд ашиг сонирхлын хувьд холбоогүй болохыг үүгээр мэдэгдэж байна.

### Хуулийн дүгнэлт гаргах үндэслэл, ажлын даалгавар

ХасБанк ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа гаргаж буй хувьцааг нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлд болон хөрөнгийн биржийн бүртгэлд бүртгүүлэх, Банкны хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болгож байгаатай холбогдуулан Хуулийн фирм нь Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг ... хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, ... тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна", 10.7 дахь хэсэгт "... хууль зүйн дүгнэлт нь тухайн үнэт цаасны танилцуулгын салшгүй хэсэг байна" болон Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны №225 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 11 дүгээр зүйлийн 11.14 дэх хэсэг, Монголын хөрөнгийн биржийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2018 оны №2018/01 тоот тогтоолоор батлагдсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэгт заасныг тус тус үндэслэн дараах асуудлуудыг Үнэт цаас гаргагч үйл ажиллагаандаа мөрдөж, хангаж буй эсэхэд хөндлөнгийн дүн шинжилгээ хийж, Хуулийн дүгнэлт гаргаж өгөхөөр тохиролцсон. Үүнд:

(i) Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх;

(ii) Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдал;

(iii) Банкны дүрэм, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат Банкны дүрмийн төсөл, бусад дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх;

(iv) Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, Банкны үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх;

(v) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх;

(vi) Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн зэргээр үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд нь бодитой, сөргөөр нөлөөлж болохуйц нөхцөл буй эсэх;

(vii) Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх;

(viii) Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх;

(ix) Банкны толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагчийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох;

(x) Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх;

(xi) Үнэт цаас гаргагч татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх.

393

СЭХ
он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр хүлээсэн Ажлын даалгаварт багтсанаас бусад асуудлаар Хуулийн фирм хууль зүйн зөвлөгөө, туслалцаа үзүүлээгүй болно.

### Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргаж байгаа хувьцааны тухай

Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зохицуулалт болон Банкны дүрмээс үзвэл[1] хуулийн этгээдийн хэлбэрийг өөрчлөх замаар Банкийг өөрчлөн байгуулах, хувьцаа нэмж гаргах замаар хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрийн дагуу шийдвэрлэх зохицуулалттай байна.

Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн хурлын №SGR-2023-02 тоот тогтоолоор ХасБанк ХХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн байна. Түүнчлэн Хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн № SGR-2023-02 тоот Нийтэд санал болгох зорилгоор ХасБанк ХХК-аас хувьцаа нэмж гаргах тухай тогтоолоор нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 52,700,000 (тавин хоёр сая долоон зуун мянган)

---

[1] **Иргэний хууль (2002).**

31 дүгээр зүйл.**Хуулийн этгээдийг өөрчлөн байгуулах**

31.1.Хуулийн этгээдийн хөрөнгийг өмчлөгч буюу түүнээс эрх олгосон байгууллага, түүнчлэн үүсгэн байгуулах баримт бичгээр эрх олгосон байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийг хуульд заасан журмын дагуу нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

**Компанийн тухай хууль (2011).**

18 дугаар зүйл.**Компанийг өөрчлөн байгуулах**

18.1.Компанийг энэ хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах, өөрчлөх замаар өөрчлөн байгуулж болно.

31 дүгээр зүйл.**Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх**

31.1.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд өөрчлөлт оруулах тухай бүрд компанийн дүрэмд өөрчлөлт оруулна.

31.2.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:

31.2.1.нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах;

31.2.2.хувьцаа нэмж гаргах замаар өсгөх;

31.2.3.өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.

62 дугаар зүйл.**Хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрх**

62.1.Дараах асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ:

62.1.1.компанийн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу компанийн дүрмийн шинэчилсэн найруулгыг батлах;

62.1.2.нийлүүлэх, нэгтгэх, хуваах, тусгаарлах буюу өөрчлөх замаар компанийг өөрчлөн байгуулах;

62.1.3.компанийн өрийг хувьцаагаар солих, хувьцаа нэмж гаргах, түүний тоог тогтоох;

62.1.4.компанийн хэлбэрийг өөрчлөх;

**Банкны тухай хууль (2010).**

28 дугаар зүйл.**Банкийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулах, татан буулгах үндсэн нөхцөл**

28.1.Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд банкийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно.

29 дүгээр зүйл.**Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал**

29.2.Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал дараах асуудлыг хэлэлцэж шийдвэрлэнэ:

29.2.1.банкны дүрэм батлах, уг дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах буюу түүний шинэчилсэн найруулгыг батлах;

29.2.2.хувь нийлүүлсэн хөрөнгийн бүтэц, хэмжээг өөрчлөх;

29.2.4.банкийг өөрчлөн байгуулах.

**ХасБанк ХХК-ийн дүрэм (2022.10.21).**

**Найм.Банкны удирдлага, зохион байгуулалт**

8.5.1.Дор дурдсан нөхцөлүүдийг энэ дүрэмд заасан Стратегийн асуудал гэж үзэх ба эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн, эсхүл төлөөллөөр оролцож байгаа тухайн асуудлаар санал өгөх эрхтэй Толгой компанид эзэмшиж буй хувьцааны 75-аас доошгүй хувийн саналаар батална. Стратегийн асуудлыг хувьцаа эзэмшигчдэд танилцуулж санал хураалт явуулахаас өмнө ТУЗ-д заавал танилцуулж, батлуулсан байна *(2011 оны 05 сарын 26-ны өдрийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар өөрчилсөн, 2022 оны 10 сарын 21-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн SR-2022-13 болон SR-2022-14 тоот тогтоолоор өөрчлөлт оруулсан)*.

(i).Банк нэмж хувьцаа гаргах, хувьцааг хуваах, эсхүл буцаан нэгтгэх, хувь нийлүүлсэн хөрөнгийг багасгах, гаргасан хувьцааг эргүүлэн авах зэргээр банкны өөрийн хөрөнгийн бүтцэд аливаа материаллаг өөрчлөлт оруулах;

(ii).Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах;

(iv).Аливаа төрлийн хувьцаа, хөрөнгө буюу үнэт цаас гаргах (өмнө, эсхүл дараа нь зөвшөөрөл авснаар), нэмэлт хөрөнгө хуваарилах, аливаа төрлийн үнэт цаас нэмж гаргах зөвшөөрөл олгох, эсхүл банкны хөрөнгө, бусад үнэт цаасыг худалдан авах зорилгоор опцион, баталгаа гаргах;

(viii).Нэгдэх, өөрчлөн байгуулах, нийлэх, банкийг өөр компани, нэгжид нэгтгэх буюу нийлүүлэх, өөр компани нэгжийн хөрөнгийн дийлэнх хэсгийг банк худалдан авч эзэмших талаар төлөвлөгөө, шийдвэр гаргах.

СЭХ
он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ширхэг энгийн хувьцааг нэмж гарган Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох, шинээр гаргах хувьцааны нөхцөлийг тогтоож шийдвэрлэсэн байна. Үнэт цаас гаргагчийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн №SGR-2023-02 тоот шийдвэрээс үзвэл Банкны нийт гаргасан 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаа эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигчдийн 100 (нэг зуун) хувийн саналаар шийдвэрлэсэн шийдвэр байх тул хувьцаа эзэмшигчдийн шийдвэр нь хүчин төгөлдөр бөгөөд Банкны эрх барих дээд байгууллага нь өөрийн бүрэн эрхийн хүрээнд гаргасан шийдвэр байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Улмаар Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 2023 оны 04 сарын 05-ны өдөр №SGR-2023-06 тоот тогтоолын дагуу Банкны шинээр нэмж гаргаж буй 52,700,000 (тавин хоёр сая долоон зуун мянган) ширхэг хувьцааны нийтэд санал болгох нэг бүрийн үнийг 677 (зургаан зуун далан долоон) төгрөгөөр тогтоосон байна.

Банкны тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1 дэх хэсэгт “Монголбанк зөвшөөрөл олгосон тохиолдолд банкийг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрээр өөрчлөн байгуулж, татан буулгаж болно” гэж банкийг өөрчлөн байгуулах үндсэн нөхцөлийг хуульчилсан. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.22 дахь заалтад “нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэл” гэж энэ хуульд заасан журмын дагуу Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгохыг зөвшөөрсөн үнэт цаасны бүртгэлийг хэлнэ” гэж заасан байх бөгөөд мөн зүйлийн 4.1.21 дэх заалтад “нийтэд санал болгох гэж Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон журмын дагуу үнэт цаасаа 50 (тавь)-аас дээш тооны этгээдэд санал болгон худалдахаар мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдэгдэхийг хэлнэ” гэж заасан байна. Эдгээр хуулийн зохицуулалтын дагуу Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах замаар компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болохыг зөвшөөрсөн тохиолдолд ХасБанк ХХК-ийн хэлбэр өөрчлөгдөн хувьцаат компани болж Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК нь үнэт цаасаа нийтэд чөлөөтэй арилжих, арилжихыг санал болгох эрхтэй гэж Хуулийн фирмээс үзсэн болно.

Үнэт цаас гаргагчийн нийтэд санал болгон анх удаа гаргасан хувьцааг үнэт цаасны бүртгэл болон арилжаа эрхлэх байгууллагын бүртгэлд бүртгэхийг зөвшөөрсөн тохиолдолд холбогдох хууль тогтоомжид заасан нөхцөл, журмын дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулж, Банкны дүрмийн шинэчилсэн найруулгын төслийг хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж баталж, улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэхийг Хуулийн фирмээс зөвлөж байна.

### Товчилсон үгсийн товъёг

Хуулийн дүгнэлт гаргахад ашигласан товчилсон үгсийг дараах утгаар ойлгож хэрэглэнэ үү. Үүнд:

*Үсгийн дараалаар:*

| | |
|---|---|
| КТХ | Компанийн тухай хууль |
| ТУЗ | Төлөөлөн удирдах зөвлөл |
| ХК | Хувьцаат компани |
| ХХК | Хязгаарлагдмал хариуцлагатай компани |
| ХХН | Хязгаарлагдмал хариуцлагатай нөхөрлөл |

### Дүн шинжилгээ хийсэн арга, аргачлал

Энэхүү дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ Үнэт цаас гаргагчтай Хууль зүйн зөвлөх үйлчилгээний гэрээгээр тохиролцсон асуудлын хүрээнд Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн баримт материалд үндэслэх зарчмыг баримталсан болно.

Дүн шинжилгээг хийхдээ хараат бус байх зарчмыг баримталсан бөгөөд Хуулийн дүгнэлт гаргахад ашиглах эх сурвалжийг сонгохдоо хөндлөнгийн гуравдагч этгээдээс олгосон/тодорхойлсон лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг болон гуравдагч этгээдтэй

395

СЗХ
2023-05-12
БҮРТГЭВ
№ 01

2023-05-05
БҮРТГЭВ-02

байгуулсан, солилцсон зэргээр Үнэт цаас гаргагчаас хараат бусаар баталгаажсан үйл баримтад үндэслэгдсэн байхыг удирдлага болгож ажилласан.

Хууль тогтоомжоор тодорхойлсон төрийн эрх бүхий байгууллагын бүрэн эрхэд хамаарах асуудлаар болон гадаад улсын хуулийг хэрэглэх асуудлаар Хуулийн фирм дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргаагүй бөгөөд холбогдох лавлагаа, тодорхойлолтыг гаргуулан авч дүн шинжилгээндээ ашигласан болохыг тусгайлан анхаарч Хуулийн дүгнэлтэд дурдагдаагүй асуудлаар Үнэт цаас гаргагчаас, лавлагаа тодруулга бүхий албан бичигт дурдагдсан асуудлаар тухайн шатны төрийн эрх бүхий байгууллагаас тодруулж лавлана уу.

Хууль тогтоомжид тусгагдсан хэм хэмжээ, заалт, нөхцөл, журмыг тодорхойлж ойлгохдоо хууль зүйн ач холбогдол бүхий үг, үгс, утгыг Улсын Дээд шүүхийн гаргасан албан ёсны тайлбар, түүнд тодорхойлсон утгын дагуу, хэрэв тухайн нөхцөлд хэрэглэх албан ёсны тайлбар, практик байхгүй нөхцөлд хууль зүйн шинжлэх ухаанд түгээмэл тогтсон утга агуулгыг ашигласан бөгөөд ердийн хэрэглээний оноосон нэрийг тухайн үгийн хэлзүйн шууд утга агуулгаар ойлгон, ашиглаж тайлбарласан.

Үнэт цаас гаргагчийн шилжүүлэн өгсөн цаасан болон электрон хэлбэртэй баримт бичигт агуулагдаж байгаа эх болон хуулбар баримт материал, тэдгээрт агуулагдаж байгаа мэдээлэл, хөндлөнгийн эрх бүхий байгууллагын гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолт, баримт бичиг, түүнд агуулагдсан мэдээ, мэдээлэл, баримт, үйл баримтыг үнэн, зөв, хууль ёсны, хүчин төгөлдөр гэж үзэж ашигласан.

Хөндлөнгийн эрх бүхий байгууллагуудаас гаргуулан авсан лавлагаа, тодорхойлолт нь үнэн зөв бөгөөд дурдагдсан үйл баримт нь Хуулийн дүгнэлт гаргах өдрийг хүртэл хугацаанд хэвээр хадгалагдаж байгаа гэж үзсэн.

Хуулийн фирм нь төрийн эрх бүхий байгууллагаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтод тусгагдсан оноосон нэр томьёонууд харилцан адилгүй тусгагдсан байсныг нэг ижил формат, стандартад оруулж илэрхийлсэн болно.

Хуулийн дүгнэлтэд дурдсан хуулийн этгээдүүдийн оноосон нэрийг улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн оноосон нэрээр, төрийн эрх бүхий байгууллагуудын нэрийг тухайн лавлагаа, тодорхойлолт, албан бичигт ашиглагдсан оноосон нэрээр ашиглаж хэрэглэсэн болно.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн.

**Хуулийн фирмийн мэдэгдэл**

Хуулийн фирм нь дүн шинжилгээг Үнэт цаас гаргагчийн хүлээлгэн өгсөн баримт бичиг, материал, тэдгээрт агуулагдсан баримтат мэдээллийн хүрээнд хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагчаас үнэн зөв, бүрэн мэдээлэл өгсөн, холбогдох шилжүүлж өгсөн баримт бичгүүд нь үнэн зөв, хүчин төгөлдөр, жинхэнэ эх эсхүл жинхэнэ эхээс хуулбарлагдсан гэж үзэж, ашигласан болно.

Энэхүү Хуулийн дүгнэлт нь хөндлөнгийн дүн шинжилгээ хийсэн баримт бичиг бөгөөд Үнэт цаас гаргагч, түүнээс хүлээн авсан бусад этгээдийн хувьд заавал дагаж мөрдөх, мөрдөхийг шаардах эрх, үүрэг, хариуцлага үүсгэхгүй, хууль зүйн туслалцаа, зөвлөгөө үзүүлсэнд тооцогдохгүй.

Хуулийн фирм нь Гэрээгээр хүлээсэн ажлын даалгаварт тусгагдсанаас бусдаар Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт, хувьцаа хуваах, хувьцаа эзэмшигчдийн бүтцийн өөрчлөлт болон Хас Лизинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг ХасБанк ХХК-д шилжүүлэн нэгтгэсэнтэй холбоотой өмнөх асуудлаар тусгайлан дүн шинжилгээ хийгээгүй болохыг анхаарна уу.

396

СЗХ
он 2023 сар 05 өдөр 12
БҮРТГЭВ
№ 31

Хуулийн дүгнэлтийг зөвхөн энд дурдагдсан зорилгоор хийж гүйцэтгэсэн бөгөөд Үнэт цаас гаргагч нь өөр бусад зорилгоор ашиглах, хэсэгчлэн болон бүхлээр нь нийтэд дэлгэх, түгээх болон Хуулийн фирмийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөлт оруулахыг хориглоно.

Хуулийн дүгнэлтэд ашигласан баримт бичиг, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд Хуулийн дүгнэлт гаргасан өдрөөс хойш аливаа өөрчлөлт орсон бол Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй.

Хуулийн фирм нь илэрхий үг үсэг, утга найруулгын зөрүүнээс бусдаар Үнэт цаас гаргагчийн шилжүүлж өгсөн баримт бичгийн материалд агуулагдаж байгаа дараах асуудлыг үнэн зөв гэж үзэж дүгнэлт гаргасан болно. Үүнд:

- *Баримт бичигт агуулагдсан хүсэл зориг, гол санаа, дурдсан/дурдагдсан асуудал нь үндэслэлтэй, үнэн зөв, хууль ёсны дагуу илэрхийлэгдсэн, хүчин төгөлдөр;*
- *Баримт бичгүүд нь цаг хугацаандаа үйлдэгдсэн, үнэн, зөв, бүрэн, гарын үсэг зурсан этгээд нь хуулийн дагуу албан ёсоор төлөөлөх эрхтэй;*
- *Хуулийн дүгнэлт гаргах иш үндэслэл болсон баримт материалд дурдагдсан нөхцөл байдал нь Хуулийн дүгнэлт гаргаснаас хойш эсхүл тухайн баримт бичгийг үйлдсэн огноо, хугацаанаас хойш өөрчлөгдөөгүй бөгөөд аливаа байдлаар талуудын эрх ашигт сөргөөр нөлөөлөх үйл явдал үүсээгүй;*
- *Аливаа дарагдсан тэмдэг (тамга) нь үнэн, зөв, жинхэнэ, эрх бүхий ашиглах эрхтэй этгээдийн зөвшөөрлөөр дарагдсан.*

**Энэхүү Хуулийн дүгнэлт нь ХасБанк ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй үнэт цаасанд гаргасан аливаа төрлийн амлалт, баталгаанд тооцогдохгүй болохыг анхаарна уу.**

Үнэт цаас гаргагчийн бичгээр тавьсан хүсэлтийг үндэслэн Хуулийн фирм нь шаардлагатай гэж үзвэл Хуулийн дүгнэлтийн талаар гуравдагч этгээдэд нэмэлт тайлбар, тодруулга өгөх боломжтой болохыг дурдаж байна. Хуулийн фирмийн зүгээс өгөх нэмэлт тайлбар, тодруулга нь Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргасан ажлын даалгаварт тусгаснаас бусад асуудлаар нэмэлт дүн шинжилгээ хийх, тайлбар өгөх үүрэг үүсгэхгүй болно.

Хуулийн фирм нь дүн шинжилгээ хийхэд ашиглагдсан лавлагаа, тодорхойлолт, Үнэт цаас гаргагчийн гаргаж өгсөн аливаа баримт, материалд дурдагдсан үйл баримт, нөхцөл байдал Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөн аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Монгол Улсын хууль тогтоомж, хэм хэмжээний актаар тогтоосон нөхцөл, журмын хүрээнд бэлтгэсэн бөгөөд гадаад улсын хууль тогтоомж, хэм хэмжээг тайлбарлах, хэрэглэх, ашиглахтай холбоотой асуудал багтаагүй болохыг илэрхийлж байна.

### Хууль тогтоомж, хэм хэмжээний акт

Хуулийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэхдээ энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэж өгөх өдрийн байдлаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомж, тэдгээрийг дагалдаж батлагдсан холбогдох хэм хэмжээний актуудыг үндэслэл болгон бэлтгэсэн.

### Дүн шинжилгээ, дүгнэлт

Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн эрх зүйн байдал, хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн талаар тодруулж авч үзлээ.

ХасБанк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 10 сарын 21-ний өдрийн №SR2022-14 тоот шийдвэрээр Банкны дүрмийн нэмэлт, өөрчлөлтийг баталсан бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2022 оны 11 сарын 25-ны өдөр бүртгэгдсэн байх тул тус дүрмийг хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Банкны дүрэм ("Дүрэм") гэж үзлээ.

ХАСБАНК
УХН4937 2578697

397

СЭХ
2023 .05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Банкны Дүрмийн 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт "Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлөөр хувийн, үүсгэн байгуулагдсан хэлбэрээр хязгаарлагдмал хариуцлагатай[2], банкны үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нийтлэг[3] арилжааны банк юм" гэж Банк өөрийн эрх зүйн байдлыг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувьд Үнэт цаас гаргагчийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.5 дахь хэсэгт "Банкны зарласан хувь нийлүүлсэн хөрөнгө нь 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөг байх бөгөөд энэ нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэнэ", 7.5 [1] дэх хэсэгт "Банкны гаргасан хувьцаа нь нэг бүр 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг буюу хувь нийлүүлсэн хөрөнгө нь 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөг байна", 1 дүгээр зүйлийн 1.6.4 дэх заалтад "толгой компани гэж Банкны гаргасан хувьцааны 100 хувийг эзэмшиж буй ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ойлгоно" гэж тус тус тусгасан байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны 03 сарын 03-ны өдрийн №23900002000820 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК нь нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд 1 (нэг) хувьцаа эзэмшигчтэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани болохыг тодорхойлсон байна.

Хуулийн фирм нь энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар ХасБанк ХХК-ийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй Дүрэм болон хөндлөнгийн гуравдагч этгээдээс олгосон лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн баримт материал, тэдгээрт агуулагдсан мэдээлэлд дүн шинжилгээ хийж энэхүү Хуулийн дүгнэлтийг бэлтгэлээ.

**Нэг. Үнэт цаас гаргагч нь хуулийн дагуу үүсгэн байгуулагдаж, бүртгэгдсэн эсэх, Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх болон үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлаар:**

Иргэний хууль[4], Банкны тухай хууль[5] болон Зөвшөөрлийн тухай хуулийн[6] хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зохицуулалтаас үзвэл банк, түүний салбар байгуулах, банкны үйл ажиллагаа

---

[2] **Компанийн тухай хууль (2011).**
3 дугаар зүйл.**Компани, түүний хэлбэр**
3.1.Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь тодорхой тооны хувьцаанд хуваагддаг, өөрийн тусгайлсан эд хөрөнгөтэй, үндсэн зорилго нь ашгийн төлөө хуулийн этгээдийг компани гэнэ.
3.2.Хувьцаа нь тухайн компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлд оролцох эрхийг нотлох бөгөөд харин компанийн эд хөрөнгийг тусгайлан өмчлөх эрхийг нотлохгүй.
3.3.Хувьцаа эзэмшигчийн эрхийг энэ хууль болон компанийн дүрмээр тогтоох бөгөөд хувьцаа эзэмшигч нь ногдол ашиг авах, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хэлэлцэж байгаа асуудлаар санал өгөх, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх зэрэг үндсэн эрх эдэлнэ.
3.4.Компани нь хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат компани гэсэн хэлбэртэй байна.
3.5.Хязгаарлагдмал хариуцлагатай компани гэж хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгө нь хувьцаанд хуваагдаж, түүнийг захиран зарцуулах эрх нь хууль болон компанийн дүрмээр хязгаарлагддаг компанийг хэлнэ.
[3] **Банкны тухай хууль (2010).**
4 дүгээр зүйл.**Банкны төрөл**
4.1.Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлөөр төрийн, хувийн болон холимог; үйл ажиллагаа явуулах хэлбэрээр нийтлэг ба төрөлжсөн байж болно.
[4] **Иргэний хууль (2002).**
26 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар**
26.1.Хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар улсын бүртгэлд бүртгүүлснээр үүсч, хуульд заасан журмын дагуу татан буугдаж, улсын бүртгэлээс хасагдсанаар дуусгавар болно.
[5] **Банкны тухай хууль (2010).**
18 дугаар зүйл.**Банк үүсгэн байгуулах**
18.2.Банк, түүний салбар байгуулах, гадаад улсад банк, банкны салбар байгуулахад Монголбанкны зөвшөөрөл авна.
[6] **Зөвшөөрлийн тухай хууль (2022).**
8.1 дүгээр зүйл.**Тусгай зөвшөөрлийн жагсаалт**

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

эрхлэх үйл ажиллагааг Монголбанкны зөвшөөрөлтэйгөөр үүсгэн байгуулж, Банкны тухай хуульд заасан журмын дагуу тусгай зөвшөөрөл авсан банкийг хуулийн этгээдийн бүртгэлийн газарт бүртгүүлснээр[7] хуулийн этгээдийн иргэний эрх зүйн чадвар үүсэх хуулийн зохицуулалттай байна.

Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн зохицуулалтын дагуу компанийн хэлбэрээр үйл ажиллагаа эрхэлж байгаа хуулийн этгээд нь улсын бүртгэлийн байгууллагад мэдээллээ бүртгүүлэх бөгөөд хуулийн этгээд бүхэн хувийн хэрэгтэй байхаар зохицуулсан[8]. Тус зохицуулалтыг үндэслэн Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сан дахь ХасБанк ХХК-ийн хувийн хэргээс лавлагааг гаргуулан авч дүн шинжилгээ хийлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн хуулбар лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч нь үүсгэн байгуулагчдын 1999 оны 08 сарын 23-ны өдрийн шийдвэрээр “Хөгжлийн Алтан Сан” (Х.А.С) оноосон нэртэй, хязгаарлагдмал хариуцлагатай компани хэлбэрээр үүсгэн байгуулагдаж, Монголбанкны Ерөнхийлөгчийн 1999 оны 09 сарын 16-ны өдрийн №447 тоот тушаалаар зээлийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл олгогдсон бөгөөд хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газарт 1999 оны 09 сарын 17-ны өдөр бүртгэгдсэн байна. Улмаар ХасБанк ХХК нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 12 сарын 27-ны өдөр №610 тоот банк байгуулах зөвшөөрөл авсны дагуу арилжааны банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг 2001 оны 12 сарын 28-ны өдөр хуулийн этгээдийн бүртгэлийн газар бүртгэгдсэн байна.

ХасБанк ХХК-ийг үүсгэн байгуулагдах үед хүчин төгөлдөр үйлчилж, мөрдөгдөж байсан 1996 онд батлагдаж 2010 оны 01 сарын 28-ны өдрийн хуулиар хүчингүй болсонд тооцогдсон Банкны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт “банкны эрх барих байгууллага нь хувь нийлүүлэгчдийн хурал байна”, одоогийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа Банкны тухай хуулийн

---

2.Банк, банкнаас бусад санхүүгийн үйлчилгээний чиглэлээр доор дурдсан үйл ажиллагааг тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх бөгөөд дараах этгээд олгоно:
2.1.Банк байгуулах - Монголбанк.
[7] **Банкны тухай хууль (2010).**
25 дугаар зүйл.**Банкийг бүртгэх**
25.1.Энэ хуулийн 18-22 дугаар зүйлд заасан журмын дагуу Монголбанкнаас тусгай зөвшөөрөл авсан банк улсын бүртгэлд бүртгүүлнэ.
[8] **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2018).**
4 дүгээр зүйл.**Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**
4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
4.1.4."**хуулийн этгээдийн хувийн хэрэг**" гэж улсын бүртгэлийн мэдээллийн санд цаасан болон цахим хэлбэрээр байгаа, энэ хуулийн 10 дугаар зүйлд заасан мэдээллийн бүрдлийг;
4.1.6."**хуулийн этгээдийн мэдээлэл**" гэж хуулийн этгээдийн хувийн хэрэгт агуулагдаж байгаа энэ хуулийн 10.1-д заасан болон бусад мэдээллийг;
10 дугаар зүйл.**Хуулийн этгээдийн хувийн хэргийн агуулга**
10.1.Хуулийн этгээдийн хувийн хэрэг дараах мэдээллийг агуулна:
10.1.1.хуулийн этгээдийн нэр, регистрийн болон хувийн хэргийн дугаар;
10.1.2.хуулийн этгээдийн төрөл, хэлбэр, үйл ажиллагааны чиглэл;
10.1.3.хуулийн этгээдийн ерөнхий захиргаа оршин байгаа газрын албан ёсны хаяг, хэрэв байнгын ажиллагаатай ерөнхий захиргаа байхгүй бол тухайн хуулийн этгээдийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх эрх бүхий этгээдийн оршин байгаа газрын хаяг;
10.1.4.хуулийн этгээдийг шинээр байгуулах, эсхүл өөрчлөн байгуулах, татан буулгах тухай;
10.1.5.үүсгэн байгуулагчийн талаарх мэдээлэл;
10.1.6.үүсгэн байгуулах баримт бичиг;
10.1.7.өөрчлөн байгуулах замаар шинээр байгуулагдах болон үйл ажиллагаа нь зогссон хуулийн этгээд тус бүрийн эрх залгамжлалын талаар;
10.1.8.хуулийн этгээдийн мэдээлэлд оруулсан өөрчлөлтийн тухай мэдээлэл, түүнийг бүртгэсэн он, сар, өдөр;
10.1.9.компанийн хувьд үүсгэн байгуулах баримт бичигт заасан хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ;
10.1.10.хуулийн этгээдийн гүйцэтгэх удирдлагын овог, эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, иргэний үнэмлэхийн хуулбар, гадаадын иргэн бол паспортын хуулбар;
10.1.11.хуулийн этгээд нь салбар, төлөөлөгчийн газартай бол түүний оршин байгаа газрын албан ёсны хаяг, эрх бүхий этгээдийн иргэний үнэмлэхийн хуулбар;
10.1.12.хуулийн этгээдийн эрх барих этгээдийн гишүүдийг сонгосон, өөрчилсөн тухай үүсгэн байгуулагчийн шийдвэр, хурлын тэмдэглэл;
10.1.13.төрийн эрх бүхий байгууллагын шийдвэрээр хуулийн этгээдийн улсын бүртгэлд хориг тавьсан, цуцалсан тухай баримт бичиг, хяналтын улсын байцаагчийн дүгнэлт, шийтгэлийн хуудас;
10.1.14.хуулийн этгээдийн эцсийн өмчлөгч болон түүний хувьцаа, хувь оролцоо, саналын эрхийн талаарх мэдээлэл.

399

ХАСБАНК

Нууц баримт
Эх хувь

СЗХ
он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-05-05

29 дүгээр зүйлийн 29.1 дэх хэсэгт “банкны эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна” гэж заасныг үндэслэн Банкны эрх барих дээд байгууллага хувьцаа эзэмшигчдийн хурлаас ХасБанкийг үүсгэн байгуулжээ гэж үзлээ.

Монголбанкны 2023 оны 02 сарын 03-ны өдрийн №А-10/138 тоот Мэдээлэл хүргүүлэх тухай албан бичгээс үзвэл ХасБанк ХХК-д Монголбанкнаас Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үйлчилгээ, өөрийн нэрийн өмнөөс баталгаа, батлан даалт гаргах, гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах, үнэт зүйл хадгалах, гадаад төлбөр тооцоо эрхлэх, үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа, зээл болон санхүүгийн бусад хэрэгслийг худалдах, худалдан авах, үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийг олгосон, эдгээр зөвшөөрлүүд нь хүчин төгөлдөр бөгөөд Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалт болон Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журмын биелэлт, заавал байлгах нөөц болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг ханган ажилласан болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан хуулийн зохицуулалт, баримт материалын хүрээнд Хуулийн фирм нь ХасБанк ХХК-ийг хуульд тогтоомжид нийцүүлэн үүсгэн байгуулж, бүртгүүлсэн байна гэж дүгнэлээ.

ХасБанк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 06 сарын 22-ны өдрийн №SR-2021-13 тоот тогтоолоор Хас Лизинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг ХасБанк ХХК-д шилжүүлж, нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 10 сарын 15-ны өдрийн №А-1/№1024 тоот албан бичгээр Хас Лизинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг ХасБанк ХХК-д шилжүүлэн нэгтгэхэд татгалзах зүйлгүй болохыг мэдэгдсэний дагуу Хас Лизинг ХХК-ийн үйл ажиллагааг зогсоож, түүний эрх, үүрэг, хариуцлагыг ХасБанк ХХК-д шилжүүлж нэгтгэх замаар өөрчлөн байгуулагдсаныг 2021 оны 11 сарын 01-ний өдөр улсын бүртгэлд бүртгэгдсэн байгааг дурдаж байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2017 оны 10 сарын 30-ны өдрийн №А-276 тоот тушаалаар банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээг 2021 оны 12 сарын 31-ний өдрөөс эхлэн 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөг байхаар тогтоож шийдвэрлэсэн. Компанийн тухай хууль болон Банкны тухай хуулийн хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа зохицуулалтаас үзвэл[9] хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг компанийн дүрэмд тусгах хуулийн зохицуулалттай байдаг. ХасБанк ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 11 сарын 02-ны өдрийн №SR-2021-17 тоот ХасБанк ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийг нэмэгдүүлэх, шинэ хувьцаа гаргах, зарласан хувьцааны тоог нэмэгдүүлэх, Дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулах тухай шийдвэрээр ХасБанк ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг нэмэгдүүлж нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэтэй 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй болгохоор шийдвэрлэж, тус хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлтийг 2021 оны 11 сарын 29-ний өдөр хуулийн этгээдийн улсын бүртгэлд бүртгэгдсэн байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны 03 сарын 03-ны өдрийн №23900002000820 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК нь нэг

[9] **Компанийн тухай хууль (2011).**
31 дүгээр зүйл. **Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг өөрчлөх**
31.2.Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэрт үндэслэн дор дурдсан хэлбэрээр өөрчилж болно:
31.2.1.нэгж хувьцааны нэрлэсэн үнийг өсгөх, эсхүл бууруулах;
31.2.2.хувьцаа нэмж гаргах замаар өсгөх;
31.2.3.өөрийн гаргасан хувьцааг эргүүлэн худалдан авч, хүчингүй болгох замаар бууруулах.

ХАСБАНК

400

бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд дараах 1 (нэг) хувьцаа эзэмшигчийн эзэмшилд байна. Үүнд:

*Хүснэгт №01. ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн бүтэц.*

| № | Хувьцаа эзэмшигч | Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр) | Хувьцааны тоо (ширхгээр) | Нийт дүн (төгрөгөөр) | Хувь хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1. | ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК | 100 | 1,000,000,000 | 100,000,000,000 | 100.00% |
| НИЙТ | | 100 | 1,000,000,000 | 100,000,000,000 | 100.00% |

Иймд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Монголбанкнаас тогтоосон шаардлагад нийцсэн бөгөөд хуулийн этгээдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгөд оруулсан өөрчлөлттэй холбоотойгоор гаргасан өөрчлөлт хийх үндэслэл болсон тогтоол, шийдвэр, Банкны дүрмийн нэмэлт, өөрчлөлт нь холбогдох хуульд нийцсэн, бичгээр хийгдсэн, гарын үсэг зурах эрхтэй этгээд баталсан, хүчин төгөлдөр баримт бичиг байх бөгөөд тухай бүр хуулийн этгээдийн бүртгэлийн байгууллагад бүртгэгдсэн байна гэж дүгнэлээ.

Банкны оршин байгаа газрын хувьд Компанийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.4 дэх хэсэгт[10] заасны дагуу түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлогдох бөгөөд Банкны хаягийн өөрчлөлтийг бүртгэх байгууллагад бүртгүүлэх хуулийн зохицуулалттай. Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн одоогийн оршин байгаа газар буюу үйл ажиллагаа эрхлэн явуулах албан ёсны хаягийн хувьд Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, өөрийн байр-00 хаягаар хуулийн этгээдийн бүртгэлд бүртгэгдсэн байна.

Үнэт цаас гаргагчийг итгэмжлэлгүйгээр төлөөлөх этгээд буюу Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Г.Цэвэгжав бүртгэлтэй байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 04 сарын 29-ний өдрийн №А-1/387 тоот албан тоотоор ирүүлсэн зөвшөөрөл болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 05 сарын 08-ны өдрийн №R-2019/19 тоот тогтоолоор Гүмэнжавын Цэвэгжав нь ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилогдсон бөгөөд Гүйцэтгэх захирлаар томилогдсон бүртгэлийг хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнд 2019 оны 05 сарын 22-ны өдөр бүртгэгдэж, тэмдэглэгдсэн байгааг дурдаж байна.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч нь холбогдох хууль тогтоомжийн дагуу үүсгэн байгуулагдаж, улсын бүртгэлд бүртгэгдсэн бөгөөд Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ нь Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж байна.**

Үнэт цаас гаргах шийдвэр нь хуулийн дагуу гарсан эсэх асуудлын хувьд ХасБанк ХХК-ийг нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах тухай тогтоолыг Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн хурлын №SGR-2023-02 тоот тогтоол болон ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн хурлын №SR-2023-02 тоот тогтоолоор тус тус гаргасан байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын тус тогтоолын дагуу Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 61.1.7 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 62.1.2 дахь заалт, 62.1.4 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдөр батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх

[10] Компанийн тухай хууль (2011).
10 дугаар зүйл.Компанийн оноосон нэр, оршин байгаа газар
10.4.Компанийн оршин байгаа газар, шуудангийн хаягийг түүний ерөнхий захиргаа байршин байгаа газраар тодорхойлно.
10.5.Компанийн хаягийн өөрчлөлтийг Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуульд заасны дагуу бүртгэх байгууллагад бүртгүүлнэ.

401

СЗХ
он 2023 сар 05 . 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

STOCK EXCHANGE
2023-05-05

заалт, ХасБанк ХХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, 8.5.1 (ii) дэх дэд заалт, 8.5.1 (vi) дахь дэд заалт, 8.5.1 (viii) дахь дэд заалт, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн зарим хувьцаа эзэмшигчдийн хооронд 2023 оны 03 сарын 17-ны өдөр байгуулагдсан Хувьцаа эзэмшигчдийн хамтын ажиллагааны гэрээ болон ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 сарын 27-ны өдөр хуралдсан хурлын шийдвэрийг тус тус үндэслэн хувьцаа нийтэд санал болгох замаар ХасБанк ХХК-ийг хязгаарлагдмал хариуцлагатай компаниас нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулахаар шийдвэрлэсэн байна. Тус хувьцаа эзэмшигчдийн хурлын тогтоолоор хувьцаа нийтэд санал болгох ажлын хэрэгжүүлж дууссаны дараа ХасБанк ХХК-ийн бүх эрх, үүрэг, хариуцлагыг ХасБанк нээлттэй ХК-д шилжүүлэх болон ХасБанк ХК-ийн дүрмийн төслийг батална шийдвэрлэсэн байна.

Улмаар Нийтэд санал болгох зорилгоор ХасБанк ХХК-аас хувьцаа нэмж гаргах тухай тогтоолыг Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн хурлын №SGR-2023-03 тоот тогтоол болон ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 03 сарын 27-ны өдрийн хурлын №SR-2023-03 тоот тогтоолыг тус тус гаргасан байна. Хувьцаа эзэмшигчдийн хурлын тус тогтоолын дагуу Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 43 дугаар зүйл, 55 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, 62.1.8 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдөр батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, ХасБанк ХХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.10.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх хэсэг, 8.5.1 (i) дэх дэд заалт, 8.5.1 (iv) дахь дэд заалт, 8.5.1 (vi) дахь дэд заалт, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн хуралдсан хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 100.00% хувийн эзэмшлийн охин компани болох ХасБанк ХХК-ийг Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу 2023 оны 06 сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах шаардлагатай болохыг тэмдэглэн нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 52,700,000 (тавин хоёр сая долоон зуун мянган) ширхэг энгийн хувьцаа нэмж гарган Монголын Хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох, шинээр гаргах хувьцааны нөхцөлийг тогтоож шийдвэрлэсэн байна.

Мөн Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн хурлын №SGR-2023-04 тоот тогтоол болон ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2023 оны 03 сарын 27-ны өдрийн хурлын №SR-2023-04 тоот тогтоолоор Банкны одоогийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь хувьцаа нийтэд санал болгохтой холбоотойгоор нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах давуу эрхийг хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсэн байгааг дурдаж байна.

Хувьцаа эзэмшигчдийн хурлын дээр дурдсан шийдвэрийн үндэслэлийг дүгнэж үзвэл Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 61 дүгээр зүйлийн 61.1.5 дахь заалт, 61.1.7 дахь заалт, 62 дугаар зүйлийн 62.1.1 дэх заалт, 62.1.2 дахь заалт, 62.1.4 дэх заалт, 69 дүгээр зүйлийн 69.1 дэх хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдөр батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, ХасБанк ХХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, 8.5.1(ii) дахь заалт, 8.5.1 (vi) дахь дэд заалт, 8.5.1 (viii) дахь дэд заалтад тус тус нийцсэн байна гэж үзлээ.

402

Нууц баримт
Эх хувь

Улмаар Үнэт цаас гаргагчийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн 2023 оны 04 сарын 05-ны өдрийн хурлын №SGR-2023-06 тоот ХасБанк ХХК-ийн нийтэд санал болгох хувьцааны үнэ тогтоох болон бусад холбогдох нэмэлт нөхцөлийг батлах тухай тогтоол болон ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 04 сарын 05-ны өдөр №SR-2023-06 тоот Нийтэд санал болгон гаргах хувьцааны үнэ тогтоох болон бусад холбогдох нэмэлт нөхцөлийг батлах тухай тогтоол гаргасан байна. Тус тогтоолоос үзвэл Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 43 дугаар зүйл, 55 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, 62.1.8 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдөр батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, ХасБанк ХХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.10.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, 8.5.1 (i) дэх дэд заалт, 8.5.1 (iv) дахь дэд заалт, 8.5.1 (vi) дахь дэд заалтыг тус тус үндэслэн БДО Аудит ХХК-аас ирүүлсэн хөрөнгийн үнэлгээний тайланг үндэслэн Банкны шинээр нэмж гаргаж буй 52,700,000 (тавин хоёр сая долоон зуун мянган) ширхэг энгийн хувьцааны нэг бүрийн үнийг 677 (зургаан зуун далан долоон) төгрөгөөр тогтоож, нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн дүнг 35,677,900,000 (гучин таван тэрбум зургаан зуун далан долоон сая есөн зуун мянган) төгрөгөөр тогтоож, нэмж гаргасан хувьцааг хуваарилах зарчим, андеррайтерийн үүргийг баталсан байна.

Тогтоолын үндэслэлийг дүгнэж үзвэл Банкны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2 дахь хэсэг, 20 дугаар зүйлийн 20.4 дэх хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.8 дахь хэсэг, 43 дугаар зүйл, 55 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3 дахь хэсэг, 62.1.8 дахь хэсэг, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 10 дугаар зүйл, 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 06 сарын 11-ний өдөр батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэг, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.1 дэх заалт, ХасБанк ХХК-ийн Дүрмийн 7 дугаар зүйлийн 7.10.4 дэх заалт, 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, 8.5.1 (i) дэх дэд заалт, 8.5.1 (iv) дахь дэд заалт, 8.5.1 (vi) дахь дэд заалтад тус тус нийцсэн байна.

Улсын Их Хурлаас 2021 оны 01 сарын 29-ний өдөр Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд тус нэмэлт, өөрчлөлтөөр банкны системд нөлөө бүхий банк нь нээлттэй хувьцаат компанийн хэлбэрээр үйл ажиллагаагаа эрхлэхээр тогтоож өгсөн. Түүнчлэн 2021 оны 01 сарын 29-ний өдөр баталсан Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулиар тус нэмэлт, өөрчлөлт хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан банк 2023 оны 06 сарын 30-ны өдрийн дотор холбогдох хуулийн дагуу компанийн хэлбэрээ өөрчилсөн байхаар зохицуулж хуульчилсан. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 04 сарын 19-ний өдрийн №А-105 тоот Банкны системд нөлөө бүхий банкны жагсаалтыг шинэчлэн батлах тухай тушаалаар ХасБанк, Төрийн банк, Хаан банк, Худалдаа, Хөгжлийн банк, Голомт банк гэх 5 (таван) арилжааны банкийг системд нөлөө бүхий банк гэж тооцжээ.

Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас эдгээр хуулийн зохицуулалтын дагуу системд нөлөө бүхий банканд тавигдсан шаардлагыг хангах зорилгоор нээлттэй хувьцаат компанийн төрлөөр зохион байгуулагдах, нэмж хувьцаа гарган олон нийтэд санал болгохоор шийдвэрлэсэн байна.

Иймд компанийг нээлттэй хувьцаат компанийн төрлөөр өөрчлөн зохион байгуулах, нэмж хувьцаа гаргах, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг тогтоох эрх нь Банкны эрх барих дээд байгууллага хувьцаа эзэмшигчдийн хурлын бүрэн эрхэд хамаарах бөгөөд дээр дурдсан тогтоолын дагуу Банк энгийн хувьцаа нэмж гаргах, Монголын хөрөнгийн биржээр олон нийтэд нээлттэй худалдах, нээлттэй хувьцаат компани болгон өөрчлөн байгуулах ажлыг холбогдох хууль

403

тогтоомжийн дагуу зохион байгуулахаар Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-аас шийдвэрлэсэн байх тул ХасБанк ХХК-ийг нээлттэй хувьцаат компанийн төрлөөр зохион байгуулах, хувьцаа нэмж гаргах, хувьцааг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан олон нийтэд санал болгох шийдвэрийг хуулийн дагуу гарсан байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

Мөн энэхүү шалгуур асуултын хүрээнд Хуулийн фирм нь Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журмын 2 дугаар зүйлийн 2.6.1 дэх заалтад заасан Үнэт цаас гаргагчийн улсын бүртгэл, татвар төлөгчийн болон нийгмийн даатгалын шимтгэл төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байгаа эсэх асуудлыг тодруулж төрийн эрх бүхий байгууллагад хандан дэлгэрэнгүй лавлагаа, тодорхойлолт гаргаж өгөхийг хүссэн.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны 03 сарын 03-ны өдрийн №23900002000820 тоот лавлагаа болон Банкны хуулийн этгээдийн улсын бүртгэлийн гэрчилгээнээс үзвэл Компанийн үүсгэн байгуулах баримт бичиг, оршин байгаа хаягийн өөрчлөлт, хувьцаа эзэмшигчдийн өөрчлөлт, гүйцэтгэх удирдлагын мэдээлэл, үүсгэн байгуулагчийн мэдээлэл, эцсийн өмчлөгчийн мэдээлэл, эрхлэх үйл ажиллагааны мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн мэдээлэл болон өөрчлөн байгуулагдсан мэдээлэл бүртгэгдэж, тэмдэглэсэн байх тул Үнэт цаас гаргагч нь холбогдох бүртгэлийг улсын бүртгэлд бүртгүүлсэн байна гэж үзэх үндэслэлтэй гэж үзлээ.

Монголын татварын албаны 2023 оны 03 сарын 02-ны өдрийн №23.1003.2e4394e7-c36c-4096-80c5-bb5e1d48c794 тоот аж ахуйн нэгж, байгууллагын цахим лавлагаа, тодорхойлолтыг үндэслэн Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч нь холбогдох татварын албанд бүртгэлтэй, татвар төлөгчийн бүртгэлтэй холбоотой зөрчил байхгүй байна гэж үзсэн болно.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 01 сарын 03-ны өдрийн №O2313Y33Z000021578380 тоот ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК нь аж ахуйн нэгж, байгууллагын нийгмийн даатгалын бүртгэлд №000021578 тоот бүртгэлийн дугаараар бүртгэгдсэн бөгөөд нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй гэсэн тодорхойлолтыг үндэслэн нийгмийн даатгалын байгууллагад бүртгэлтэй холбоотой зөрчил байхгүй байна гэж үзсэн.

ХасБанк ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас гаргуулан авсан лавлагаа, тодорхойлолтын эх хувийг энэхүү Хуулийн дүгнэлтэд хавсаргасан бөгөөд **Хавсралт №10. "ХасБанк ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолт"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

**Дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч нь хуулийн этгээдийн улсын бүртгэлийн байгууллага, татвар, нийгмийн даатгалын байгууллагад бүртгүүлсэн байх бөгөөд бүртгэлтэй холбоотой аливаа зөрчил байхгүй байна гэж үзлээ.**

**Хоёр. Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлагын байдлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т заасан шаардлага хангасан эсэх, тэдгээрийн удирдах чадвар, дадлага туршлага болон тохиромжтой этгээдийг тодорхойлох журамд заасан шаардлага хангаж байгаатай холбоотойгоор тус Банкнаас гаргаж өгсөн баримт материалд үндэслэн дүн шинжилгээ хийлээ.

404

СЭХ
2023 .05 .12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХасБанк ХХК-ийн эрх барих дээд байгууллага болох Хувьцаа эзэмшигчдийн 2020 оны 03 сарын 31-ний өдрийн хурлын №SR-2020-05 тоот тогтоолоор Г.Цэвэгжавыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр Гүйцэтгэх захирлын бүрэн эрхийг хэрэгжүүлэх хугацаагаар сонгосон байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2021 оны 03 сарын 31-ний өдрийн хурлын №SR-2021-05 тоот тогтоолоор Майкл Мадден, №SR-2021-06 тоот тогтоолоор Н.Цэлмүүн, №SR-2021-07 тоот тогтоолоор Анджей Витак, №SR-2021-08 тоот тогтоолоор Санжай Гупта, №SR-2021-09 тоот тогтоолоор Албертус Браггинк нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр, №SR-2021-03 тоот тогтоолоор Нираж Вэдваг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2 (хоёр) жилийн хугацаатайгаар тус тус сонгосон байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 04 сарын 26-ны өдрийн хурлын №SR-2022-05 тоот тогтоолоор Сюзанна Хэрринг Карр, №SR-2022-06 тоот тогтоолоор Ив Жако нарыг Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүнээр, №SR-2022-07 тоот тогтоолоор Б.Уламбаярыг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2 (хоёр) жилийн хугацаатайгаар тус тус сонгосон байна.

Хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 10 сарын 21-ний өдрийн хурлын №SR-2022-11 тоот тогтоолоор Эрик Версавелийг Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээр 2 (хоёр) жилийн хугацаатайгаар сонгосон байна.

ХасБанк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 сарын 28-ны өдрийн хурлын №R-2019-17 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Санжай Гуптаг сонгосон байгааг дурдаж байна.

**Төлөөлөн удирдах зөвлөл**

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хүчин төгөлдөр мөрдөгдөж буй хуулийн зохицуулалтын хүрээнд үзвэл Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1[11] дэх хэсэгт “Банк төлөөлөн удирдах зөвлөлтэй байна”, 31.2[12] дахь хэсэгт “Банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш гишүүнтэй байна”, 33 дугаар зүйлийн 33.1[13] дэх хэсэгт “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна”, 32.3[14] дахь хэсэгт “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь энэ хуулийн 32.1-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг банкнаас бичгээр урьдчилан ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай банкинд мэдэгдэнэ”, Компанийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2[15] дахь хэсэгт “Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно” гэж нарийвчлан зохицуулсан.

Хуулийн зохицуулалтын дагуу авч үзвэл Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.10 дахь хэсэгт “Хувьцаа эзэмшигчдийн хурлын чөлөөт цагт Банкны эрх барих байгууллага нь Төлөөлөн удирдах зөвлөл байх ба Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 9-12 гишүүнтэй байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн бүрэлдэхүүний 1/3-ээс доошгүй нь хараат бус

---

[11] **Банкны тухай хууль (2010).**
31 дүгээр зүйл.**Банкны төлөөлөн удирдах зөвлөл**
31.1.Банк төлөөлөн удирдах зөвлөлтэй байна.
[12] 31.2.Банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш гишүүнтэй байна.
[13] 33.1.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.
[14] 32.3.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь энэ хуулийн 32.1-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг банкнаас бичгээр урьдчилан ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай банкинд мэдэгдэнэ.
[15] **Компанийн тухай хууль (2011).**
77 дугаар зүйл.**Төлөөлөн удирдах зөвлөлийг сонгох, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийг хугацаанаас нь өмнө дуусгавар болгох**
77.2.Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүний бүрэн эрхийн хугацаа дараа жилийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдах өдрөөр дуусгавар болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг улируулан сонгож болно.

СЭХ
2023 . 05 . 12
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

гишүүн байна", 8.11 дэх хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөлийг гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 2 (хоёр) жил байх ба мөн хугацаагаар улируулан сонгож болно" гэж заасан байх бөгөөд эдгээр зохицуулалт нь дээрх хууль тогтоомжид нийцсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, бүтцийн хувьд авч үзвэл Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар ХасБанк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл нь дараах бүрэлдэхүүнтэй байна. Үүнд:

*Хүснэгт №02. ХасБанк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд.*

| № | Овог, нэр | Төлөв |
|---|---|---|
| 1. | Санжай Гупта | Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга |
| 2. | Гүмэнжавын Цэвэгжав | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 3. | Нямтайширийн Цэлмүүн | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 4. | Майкл Мадден | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 5. | Ив Жако | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 6. | Анджей Витак | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 7. | Албертус Браггинк | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 8. | Сюзанна Хэрринг Карр | Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн |
| 9. | Нираж Вэдва | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн |
| 10. | Баянсаны Уламбаяр | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн |
| 11. | Эрик Версавел | Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн |

### Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга

**Санжай Гупта** нь 2017 оны 03 сараас ХасБанк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ)-ийн гишүүнээр, 2019 оны 03 сараас ТУЗ-ийн даргаар томилогдон ажиллаж байна. Тэрээр Делигийн их сургуулийн Сэинт Стивингийн коллежийг Физикийн Бакалавр, Делигийн их сургуулийн Менежмент удирдлагын факултетыг Бизнесийн удирдлагын магистр (МВА) зэрэгтэй тус тус төгссөн. Тэрээр 1981 оноос 2001 оны хооронд Банк оф Америка (Bank of America)-ын БНЭУ, Англи болон Хонг Конг дахь салбаруудад ажилласан. Тус хугацаанд тэрээр БНЭУ дахь Байгууллагын Банк хариуцсан захирал, Европ, Ойрх Дорнод, Африкийн бүсийн (ЕОДА) салбарын Эрсдэлийн Удирдлага хариуцсан захирал, ЕОДА-ын Бүтэцлэгдсэн Зээл хариуцсан захирал, Ази дахь Хөрөнгө Оруулалтын Банк хариуцсан захирал зэрэг албан тушаал хашиж байсан. Мөн тэрээр 2001 оноос 2015 оны хооронд Кредит Агриколь Групп (Credit Agricole Group)-ын Ази, Номхон Далай, Европ, Ойрх Дорнод болон Африкийн бүс нутаг дахь салбаруудад Байгууллагын Бизнес хариуцсан захирал, Бүтэцлэгдсэн Зээл хариуцсан захирал, Глобал Эрчим Хүч Салбарын захирал зэрэг албан тушаалд ажилласан туршлагатай.

### Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд

**Гүмэнжавын Цэвэгжав** нь 2019 оны 05 сараас ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирал, 2020 оны 03 сараас ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр 2011 оноос өнөөг хүртэлх хугацаанд ХасБанк ХХК-ийн Ерөнхий захирал, Иргэдийн банк хариуцсан захирал, Санхүү хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал, ХасЛизинг ХХК-ийн Гүйцэтгэх захирал, Тэнгэр Даатгал ХХК-ийн ТУЗ-ийн дарга, ТэнГэр Санхүүгийн Нэгдэл Санхүү хариуцсан захирал, Гүйцэтгэх захирал зэрэг албан тушаалд тус тус ажиллаж байсан. Мөн Гүмэнжавын Цэвэгжав нь АНУ дахь томоохон компаниудад ажиллаж байсан туршлагатай. Тэрээр АНУ-ын Колорадогийн Их Сургуулийг бакалавр, Рэгис Их Сургуулийг бизнесийн удирдлагын магистр (МВА) зэрэгтэй төгссөн.

**Нямтайширын Цэлмүүн** нь Монголын Алт Корпораца (МАК)-аас нэр дэвшиж, 2012 оны 08 сараас ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр Монголын Алт Корпораци (МАК)-д Ерөнхийлөгчийн албан тушаал хашдаг бөгөөд хөрөнгө оруулалт, бизнесийн салбарын арвин туршлагатай. Мөн тэрээр Худалдаа, хөгжлийн банкны иргэдийн банкны салбарт

406

СЭХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ажиллаж байсан. Нямтайширын Цэлмүүн нь АНУ-ын Индиана мужийн Валпараисо Их Сургуулийг бизнесийн удирдлагын чиглэлээр төгссөн бөгөөд Хонг Конг дахь Стэнфордын Их сургуулийн Санхүүгийн инженерингийн хөтөлбөрт хамрагдаж суралцсан.

**Майкл Мадден** нь Ронок Партнерсаас нэр дэвшиж, 2009 оны 05 сараас ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрбээр банк санхүү, төлбөр тооцооны салбарт нийт 30 гаруй жил ажилласан туршлагатай бөгөөд энэ хугацаанд Американ Экспресс (American Express), ОХУ дахь Ренессанс Кредит (хэрэглээний санхүүжилтийн банк), Ронок (үүсгэн байгуулагч), олон улсын Гүйцэтгэх захирлуудад зөвлөх үйлчилгээ үзүүлдэг Тенео зэрэг байгууллагуудад гүйцэтгэх удирдлагын түвшинд ажиллаж байсан. Мөн хөгжиж буй зах зээл бүхий 40 улсад бизнесийн зөвлөгөө өгөх, бизнесийн байгууллага удирдаж байсан туршлагатай. Майкл Мадден нь финтек, төлбөр тооцоо, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг Ронок компанийн гүйцэтгэх захирлын албан тушаалд, Тенео компанид тэрээр АНУ-д үйлчилгээ үзүүлэх эрх бүхий Санхүүгийн зөвлөх бөгөөд ТУЗ-ийн дарга, дэд ерөнхийлөгчийн албан тушаалд ажилладаг. Майкл Мадден нь Ирландын Лаймерик хотын Удирдлагын коллежийг аж үйлдвэрийн инженерийн дипломтой төгссөн.

**Ив Жако** нь Канадын Үндэсний Банкнаас нэр дэвшиж, 2016 онд ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр Францын Эссек их сургуулийн дипломтой бөгөөд АНУ-ын Вартонгийн их сургуулийн тэтгэлэгт хамрагдан докторын зэргийг санхүүгийн чиглэлээр хамгаалсан байна. Тэрээр банк санхүүгийн салбарт тасралтгүй ажиллаж байгаа бөгөөд ЭйЭксЭй Групп (AXA Group) болон Бред Банк Групп (Bred Bank Group) зэрэг) гэх зэрэг иргэдийн банк, санхүүгийн зах зээл, хөрөнгийн удирдлага, байгууллагын банк, активын удирдлага зэрэг чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хэд хэдэн банк санхүүгийн байгууллагад ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал, дэд захирлын албан тушаалд ажиллаж байсан. Тэрээр одоо Канадын Үндэсний Банкны тэргүүн дэд ерөнхийлөгч, ЭйБиЭй Банкны (ABA Bank), ЭйТиЭй АйТи (ATA IT), Наткан Интернейшнл (NATCAN International) зэрэг байгууллагуудын ТУЗ-ийн даргаар ажиллаж байна. Мөн тэрээр Библос Банкны (Byblos Bank) ТУЗ-ийн гишүүн юм.

**Анджей Витак** нь Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (ЕСБХБ)-наас нэр дэвшиж, 2019 оны 02 сараас ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр банк санхүүгийн салбарт 30 гаруй жил ажилласан туршлагатай нэгэн бөгөөд Украин, Узбекистан зэрэг улс дахь ЕСБХБ-ны суурин төлөөлөгч, орлогчоор ажиллаж байсан. Мөн тэрээр ОХУ, Польш, Монгол, хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан орнууд болон зүүн Европ дахь улс орнууд дахь байгууллагуудад ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан. Одоогоор ЕСБХБ-ны чанаргүй актив, эрсдэлтэй зээлийн удирдлагын чиглэлийн төслүүдэд бие даасан зөвлөхөөр ажиллаж байна. Анджей Витак нь Польш Улсын Силезия их сургуулийг хууль зүйн магистр зэрэгтэй төгссөн.

**Албертус Браггинк** нь ОРИКС Корпораци (ORIX Corporation)-аас нэр дэвшиж, 2020 оны 06 сараас ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Албертус Браггинк нь Нидерландын хамгийн том санхүүгийн байгууллагуудын нэг болох Rabobank-д 30 жил ажилласан туршлагатай мэргэшсэн банкир юм. Тэрээр 2004-2016 оны хооронд тус банкны гүйцэтгэх удирдлагын түвшинд санхүү болон эрсдэлийн удирдлага чиглэлээр ажиллаж байсан. Одоо тэрээр ОРИКС Корпорациас гадна Нидерланд болон бусад улс орны хэд хэдэн байгууллагад ТУЗ-ийн зөвлөхөөр ажиллаж байна. Албертус нь Нидерландын Твенте (Twente) технологийн их сургуулийн Бизнесийн удирдлагын магистр болон докторын зэрэгтэй.

**Сюзана Херринг Карр** нь ОУСК-аас нэр дэвшиж, 2022 оноос ХасБанкны ТУЗ-ийн гишүүнээр томилогдон ажиллаж байна. Тэрээр хөгжиж буй санхүүгийн зах зээлд 30 гаруй жил ажилласан туршлагатай банкир юм. Түүний арвин туршлага нь хөрөнгө оруулалтын бүтэц, багцын удирдлага, зээлийн бодлогоос эхлээд хөгжлийн нөлөөлөл, хэмжилт, компанийн засаглал хүртэлх өргөн хүрээг хамарсан. Тэрээр 2018 оноос Бүгд Найрамдах Серби улсад төвтэй ПроКредит Банк (ProCredit Bank), 2018-2019 онуудад Люксембургт төвтэй Бичил Санхүүжилтийг Сайжруулах Хөтөлбөрийн (Microfinance Enhancement Facility) зэрэгт тус тус ТУЗ-ийн гишүүнээр ажиллаж байсан. Тэрээр 2020

Нууц баримт
Эх хувь

СЗХ
2023 05. 12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05
БҮРТГЭВ-02

оноос хойш Бичил Санхүүжилтийг Сайжруулах Хөтөлбөрийн хөрөнгө оруулалтын хорооны гишүүнээр ажиллаж байна. Үүнээс өмнө тэрээр 1996-2016 онуудад ОУСК-д хэд хэдэн удирдах албан тушаалд ажиллаж байсан. Үүнд Хөрөнгө оруулалт хариуцсан захирал, Корпорацийн бизнес технологи хариуцсан захирал, Бизнес төлөвлөлт, захиргаа хариуцсан захирал, Зээлийн бодлогын хэлтсийн дарга, Санхүүгийн зах зээл болон багц хариуцсан захирал зэрэг албан тушаалууд багтана. Тэрээр Дьюкийн их сургуулийг Эдийн засгийн бакалаврын зэрэгтэй төгссөн.

**Нираж Вэдва** нь 2018 оны 06 сараас ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тэрээр 34 жил банкны салбар мэдээллийн технологийн чиглэлээр Энэтхэг Улсын хөрөнгийн биржид бүртгэлтэй Тек Махиндра (Tech Mahindra), Швейцар Улсын Теменос (Temenos) болон Нуклеус Софтвэр (Nucleus Software) зэрэг компаниудад гүйцэтгэх удирдлагын түвшинд ажиллаж байсан туршлагатай. Тэрээр 2019 оны 06 сард мэдээлэл технологийн зөвлөх үйлчилгээний чиглэл бүхий Асерелик ЭфЗи ХХК-ийг Арабын Нэгдсэн Эмират улсад үүсгэн байгуулсан бөгөөд тус компанийн гүйцэтгэх захирлаар ажиллаж байна. Мөн тэрээр олон улсын хэд хэдэн технологийн компаниудад зөвлөхөөр ажилладаг байна. Нираж Вэдва нь Энэтхэгийн Дели хотын Их Сургуулийг бакалавр зэрэгтэй, Индира Ганди-гийн нэрэмжит Их Сургуулийг магистрын зэрэгтэй тус тус төгссөн.

**Баянсаны Уламбаяр** нь ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүн бөгөөд Говь Бизнес Финанс ХХК-ийн зөвлөхөөр ажилладаг. Тэрээр Токио хотод Леман Бродерс, Номура Секьюритис зэрэг хөрөнгө оруулалтын банкнуудад ажиллаж байсан ба Монгол Улсад эргэж ирээд Драпер Капитал, Композит Капитал зэрэг хөрөнгө оруулалтын сангуудад хөрөнгө оруулалтын чиглэлээр ажиллаж байсан. Тэрээр хөрөнгө оруулалтын банкны чиглэлээр ажиллахаас өмнө Сони корпорацид судалгаа хөгжүүлэлтийн инженерээр ажиллаж байсан туршлагатай. Б.Уламбаяр нь Токиогийн Технологийн Их Сургуулийг бакалавр болон магистрын зэрэгтэй, АНУ-ын Чикагогийн Их Сургуульд бизнесийн удирдлагын чиглэлээр суралцаж, Бизнесийн удирдлагын магистр (MBA)-ын зэрэгтэй тус тус төгссөн.

**Эрик Версавел** нь 2022 оны 10 сараас ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүнээр сонгогдон ажиллаж байна. Тэрээр Ай Эн Жи Бизнесийн хамтын үйлчилгээний Шри Ланка Улсын Коломбо салбарт Ерөнхий менежерээр ажилладаг. Тэрээр 1989 онд анх Бельги Улсын Брюссель хотын Ай Эн Жи банкинд ажиллаж эхэлсэн бөгөөд Англи, Өмнөд Солонгос, Хятад, Индонез, Украйн, Монгол Улсуудад удирдах түвшний ажил эрхэлж байсан. Эрик Версавел нь Бельгийн Антверпийн Их Сургуульд хуулийн магистр, Сингапур Улсын төлөөлөн удирдах зөвлөлийн институтийг удирдах ажилтны дипломтой тус тус төгссөн.

**Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод**

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.1 дэх хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөл нь шаардлагатай гэж үзвэл тодорхой асуудал эрхэлсэн байнгын болон түр хороог байгуулж болно”, Банкны тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5. дахь хэсэгт “Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн нь аудитийн болон эрсдэлийн удирдлагын хороонд ажиллаж, эдгээр хорооны асуудал болон Компанийн тухай хуульд заасан сонирхлын зөрчилтэй хэлцлийг батлахад заавал оролцож, санал өгнө” 34 дүгээр зүйлийн 34.3 дахь хэсэгт “Гүйцэтгэх удирдлага нь төлөөлөн удирдах зөвлөлийн аудитын, цалин урамшууллын, нэр дэвшүүлэх хорооны гишүүн байхыг хориглох бөгөөд гүйцэтгэх захирлыг сонгох, томилох, чөлөөлөх, түүний бүрэн эрхийг тогтоох, хяналт тавихтай холбоотой асуудлаар шийдвэр гаргахад саналын эрхгүй байна” гэж заасан байна.

ХасБанк ХХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.19 дэх хэсэгт “Төлөөлөн удирдах зөвлөл нь Эрсдэлийн удирдлагын, Зээлийн, Аудитын болон Төлөөлөн удирдах зөвлөлөөс шаардлагатай гэж үзсэн бусад хороодтой байж болно” гэж заасан байх бөгөөд Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн Дүрмийн зохицуулалт нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд нийцсэн байна гэж үзэх үндэслэлтэй байна.

408

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

Үнэт цаас гаргагч нь Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх (i) Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо; (ii) Аудитын хороо; болон (iii) Эрсдэлийн удирдлагын хороодтой байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 12 сарын 08-ны №R-2021-41 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Майкл Мадден, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Албертус Браггинк, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Анджей Витак, Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Санжай Гупта, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Нямтайширийн Цэлмүүн нарыг тус тус сонгосон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны 02 сарын 05-ны өдрөөс 2022 оны 02 сарын 14-ний өдрийн хооронд зохион байгуулагдсан хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Баянсаны Уламбаярыг сонгосон байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 сарын 24-ний №R-2020-14 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ив Жако, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Анджей Витак, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Албертус Браггинк, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Нираж Вэдва, 2022 оны 04 сарын 26-ны өдрийн №R-2022-25 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Сюзанна Хэрринг Карр, 2022 оны 11 сарын 14-ний өдрийн №R-2022-47 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Эрик Версавел нарыг тус тус сонгосон байна.

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 06 сарын 24-ний №R-2020-14 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны даргаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Ив Жако, гишүүдээр Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Нямтайширийн Цэлмүүн, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Албертус Браггинк, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Баянсаны Уламбаяр, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Нираж Вэдва, 2022 оны 04 сарын 26-ны өдрийн №R-2022-25 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүн Сюзанна Хэрринг Карр, 2022 оны 11 сарын 14-ний өдрийн №R-2022-47 тоот тогтоолоор Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн Эрик Версавел нарыг тус тус сонгосон байна.

### Эрх бүхий албан тушаалтан

Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйлийн 84.1 дэх хэсэгт "Компанийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлагын багийн гишүүн, гүйцэтгэх захирал, санхүүгийн албаны дарга, ерөнхий нягтлан бодогч, ерөнхий мэргэжилтэн, төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга зэрэг компанийн албан ёсны шийдвэрийг гаргахад болон гэрээ, хэлцэл хийхэд шууд болон шууд бусаар оролцдог этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалтанд тооцно" гэж хуульчилсан байдаг бөгөөд хуулийн этгээд өөрийн үүсгэн байгуулах баримт бичиг буюу дүрмээрээ илүү нарийвчлан тодорхойлох эсхүл албан тушаалаар нэр заан тодорхойлох боломжийг олгосон. ХасБанк ХХК-ийн дүрмийн 8 дугаар зүйлийн 8.32 дахь хэсэгт[16] Банкны албан ёсны шийдвэрийг гаргахад оролцдог албан тушаалтныг эрх бүхий албан тушаалтанд тооцохоор тусгасан. ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 сарын 10-ны өдрийн №А-120 тоот тушаалаар батлагдсан

---

[16] ХасБанк ХХК-ийн дүрэм (2022.10.21).
Найм.Банкны удирдлага, зохион байгуулалт
8.32.Банкны албан ёсны шийдвэрийг гаргахад оролцдог дараах албан тушаалтныг эрх бүхий албан тушаалтанд тооцно:
8.32.1. Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга;
8.32.2. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн;
8.32.3. Гүйцэтгэх захирал;
8.32.4. Санхүү хариуцсан захирал/Ерөнхий нягтлан бодогч;
8.32.5. Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга;
8.32.6. Гүйцэтгэх захиралтай онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулан гүйцэтгэх удирдлагын түвшний ажил үүрэг гүйцэтгэж буй албан тушаалтан.

ХасБанк ХХК-ийн бүтэц, зохион байгуулалтыг шинэчлэн батлах тухай тогтоол болон Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд ирүүлсэн баримт материалд үндэслэн дараах эрх бүхий албан тушаал буюу ажлын байр, орон тоо ХасБанк ХХК-ийн бүтцэд байна гэж үзлээ. Үүнд:

*Хүснэгт №03. Эрх бүхий албан тушаалын ажлын байрны мэдээлэл.*

| № | Овог, нэр | Албан тушаал | Орон тоо |
|---|---|---|---|
| 1. | Гүмэнжавын Цэвэгжав | Гүйцэтгэх захирал | 1 |
| 2. | Ганзоригийн Эрдэнэбаяр | Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал | 1 |
| 3. | Энэбишийн Уламбаяр | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал | 1 |
| 4. | Бавааны Еркин | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал | 1 |
| 5. | Серикжаны Дауренбек | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Лизинг хариуцсан захирал | 1 |
| 6. | Илия Авромав | Эрсдэл хариуцсан захирал | 1 |
| 7. | Хүрэлбаатарын Өнөрбат | Мэдээллийн технологи хариуцсан захирал | 1 |
| 8. | Ганзоригийн Зул | Үйл ажиллагаа хариуцсан захирал | 1 |
| 9. | Нямсүрэнгийн Мөнхцэлмэг | Хууль хариуцсан захирал бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга | 1 |

Гүйцэтгэх удирдлага

Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.3 дахь хэсэгт "Хувь хүн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлж байгаа тохиолдолд уг этгээд нь гүйцэтгэх захирал байна", Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3.2 дахь заалтад "Монголбанкны зөвшөөрснөөр банкны гүйцэтгэх удирдлагыг томилох", 34 дүгээр зүйлийн 34.2[17] дахь хэсэгт Гүйцэтгэх захирал нь (i) Банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай байх; (ii) Банк, банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой этгээд биш байх; (iii) Бусад банк, түүний нэгдэл, эсхүл банктай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх; (iv) Монголбанкны эрх бүхий албан тушаалтнаар сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаагүй байх; (v) Мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулаагүй байх; болон (vi) банкны хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй байх гэх шаардлагыг хангаж байхаар хуульчилсан байна.

Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.24 дэх хэсгээс үзвэл "Банкны өдөр тутмын үйл ажиллагааг Төлөөлөн удирдах зөвлөлөөс томилогдсон Гүйцэтгэх захирал хууль тогтоомж, Банкны Дүрэм болон Төлөөлөн удирдах зөвлөлтэй байгуулсан гэрээнд заасан эрх хэмжээний хүрээнд удирдан зохион байгуулна", 8.25 дахь хэсэгт "Төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх захирлыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилно" гэж тусгасан.

[17] Банкны тухай хууль (2010).
34 дүгээр зүйл.Банкны гүйцэтгэх удирдлага
34.2.Гүйцэтгэх удирдлага нь энэ хуулийн 32.1.1-32.1.6-д заасан шалгуураас гадна дараахь шалгуурыг хангасан байна:
34.2.1.банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;
34.2.2.банк, банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;
34.2.3.бусад банк, түүний нэгдэл, эсхүл банктай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;
34.2.4.Монголбанкны эрх бүхий албан тушаалтнаар сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаагүй байх;
34.2.5.мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулаагүй байх;
34.2.6.банкны хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй.

2023 .05. 12

2023 -05- 05
БҮРТГЭВ-02

Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, ХасБанк ХХК-ийн Дүрэм, Гүйцэтгэх захирлын анкет болон тэдгээрт холбогдох баримт материалаас үзэхэд Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн гүйцэтгэх удирдлагыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав хэрэгжүүлж байна.

ХасБанк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 03 сарын 27-ны өдрийн ээлжит хурлын Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр Монголбанкны Ерөнхийлөгчөөс 2019 оны 04 сарын 29-ний өдрийн №A-1/387 тоот албан тоотоор ирүүлсэн зөвшөөрөл болон ХасБанк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2019 оны 05 сарын 08-ны өдрийн №R-2019/19 тоот тогтоолоор Гүмэнжавын Цэвэгжавыг ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын албан тушаалд томилсон байна.

Монголбанкны Ерөнхийлөгчийн зөвшөөрөл болон Гүйцэтгэх захирал Гүмэнжавын Цэвэгжавын гаргаж өгсөн холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байгаа тухай Баталгаанд үндэслэн Банкны Гүйцэтгэх захирал нь хууль тогтоомжид заасан шаардлагыг хангаж байна гэж Хуулийн фирмээс дүгнэсэн болно.

**Бусад эрх бүхий албан тушаалтан**

ХасБанк ХХК-ийн гаргаж өгсөн мэдээлэлд үндэслэж үзвэл эрх бүхий албан тушаал буюу ажлын байранд дараах албан тушаалтнууд томилогдон ажиллаж байна. Үүнд:

| | |
|---|---|
| § Ганзоригийн Эрдэнэбаяр | ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 01 сарын 15-ны өдрийн №A/56 тоот тушаалаар ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна. |
| § Энэбишийн Уламбаяр | ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 сарын 31-ний өдрийн №A-119 тоот тушаалаар ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна. |
| § Бавааны Еркин | ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 сарын 31-ний өдрийн №A-121 тоот тушаалаар ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна. |
| § Серикжаны Дауренбек | ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 11 сарын 01-ний өдрийн №A-1134 тоот тушаалаар ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Лизинг хариуцсан захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна. |
| § Илия Авромав | ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2019 оны 10 сарын 15-ны өдрийн №A-1221 тоот тушаалаар Эрсдэл хариуцсан захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна. |
| § Хүрэлбаатарын Өнөрбат | ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны 02 сарын 03-ны өдрийн №A-72 тоот тушаалаар Мэдээллийн технологи хариуцсан захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна. |
| § Ганзоригийн Зул | ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2020 оны 01 сарын 31-ний өдрийн №A-120 тоот тушаалаар Үйл ажиллагаа хариуцсан захирал албан тушаалд томилогдон ажиллаж байна. |
| § Нямсүрэнгийн Мөнхцэлмэг | ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 06 сарын 03-ны өдрийн №A/609 тоот тушаалаар Хууль хариуцсан захирал бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга албан тушаалд томилогдон ажиллаж байна. |

411

Хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа хууль тогтоомжийн зохицуулалт болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтанд тавигддаг шаардлагын хүрээнд Хуулийн фирм нь Компанийн эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкет, тэдгээрийн мэдлэг чадварыг тодорхойлох баримт материалыг гаргаж өгөхийг хүссэн. Хуулийн фирм нь Банкнаас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлагыг дараах хүснэгтээр дэлгэрүүлэн авч үзлээ.

***Хүснэгт №04. ХасБанк ХХК-ийн эрх бүхий албан тушаалтан Компанийн тухай хууль, Компанийн засаглалын кодекст тавигдсан шаардлагыг хангасан эсэх мэдээлэл.***

| № | Эрх бүхий албан тушаал | Эрх бүхий албан тушаалтны нэрс | Компанийн тухай хууль (КТХ) | | | | Компанийн засаглалын кодекс (КЗК) |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан эсэх Тийм/Үгүй/N/A* | Төрийн болон нутгийн захиргааны байгууллагад удирдах албан тушаал хашдаг эсэх Тийм/Үгүй | Ял шийтгэл эдэлж байгаа болон эдэлж байсан эсэх Тийм/Үгүй | ТУЗ-ийн гишүүн, Гүйцэтгэх удирдлагыг хувь хүн хэрэгжүүлдэг эсэх Тийм/ Үгүй/ N/A | КЗК 1.2 дахь хэсгийн Тайлбар 1 хэсэгт заасныг хангасан эсэх Тийм/Үгүй/ N/A |
| **Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд** | | | | | | | |
| 1. | ТУЗ-ийн дарга | Санжай Гупта | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 2. | ТУЗ-ийн гишүүн | Гүмэнжавын Цэвэгжав | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 3. | ТУЗ-ийн гишүүн | Нямтайширийн Цэлмүүн | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 4. | ТУЗ-ийн гишүүн | Майкл Мадден | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 5. | ТУЗ-ийн гишүүн | Ив Жако | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 6. | ТУЗ-ийн гишүүн | Анджей Витак | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 7. | ТУЗ-ийн гишүүн | Албертус Браггинк | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 8. | ТУЗ-ийн гишүүн | Сюзанна Хэрринг Карр | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 9. | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Нираж Вэдва | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 10. | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Баянсаны Уламбаяр | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 11. | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Эрик Версавел | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| **Хоёр. Бусад эрх бүхий албан тушаалтан** | | | | | | | |
| 12. | Гүйцэтгэх захирал | Гүмэнжавын Цэвэгжав | Тийм | Үгүй | Үгүй | Тийм | Тийм |
| 13. | Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал | Ганзоригийн Эрдэнэбаяр | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 14. | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал | Энэбишийн Уламбаяр | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 15. | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал | Бавааны Еркин | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 16. | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Лизинг | Серикжаны Дауренбек | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |

412

СЭХ
2023 оны 05 сарын 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | хариуцсан захирал | | | | | | |
| 17. | Эрсдэл хариуцсан захирал | Илия Авромав | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 18. | Мэдээллийн технологи хариуцсан захирал | Хурэлбаатарын Өнөрбат | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 19. | Үйл ажиллагаа хариуцсан захирал | Ганзоригийн Зул | N/A | Үгүй | Үгүй | N/A | N/A |
| 20. | Хууль хариуцсан захирал бөгөөд Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга | Нямсүрэнгийн Мөнхцэлмэг | Тийм | Үгүй | Үгүй | N/A | N/A |

***N/A**: Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодексийн дагуу Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтанд тусгайлан тавигдсан шаардлагад үндэслэн шалгах шаардлагагүй гэж үзсэн этгээдийн харгалзах нүдэнд тус тэмдэглэгээг оруулсан болно. Хуулийн фирм.

***Хүснэгт №05. ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн гишүүд Банкны тухай хуульд тавигдсан шаардлагыг хангасан эсэх мэдээлэл.***

| № | Эрх бүхий албан тушаалтны нэрс | Банкны тухай хууль 32 дугаар зүйлийн 32.1-32.7 дах хэсэг | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | Зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өртэй эсэх (Тийм/Үгүй) | Эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байсан эсэх (Тийм/Үгүй) | Ес зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкийг удирдахад харшлах эсэх (Тийм/Үгүй) | Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын сонирхлын зөрчилтэй эрх бүхий албан тушаалтан эсэх (Тийм/Үгүй) | Зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх (Тийм/Үгүй) | Санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээж байсан эсэх (Тийм/Үгүй) | ТУЗ-ийн гишүүд нь Банкны тухай хуулийн 32.7-д заасан туршлагатай эсэх (Тийм/Үгүй) |
| Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд | | | | | | | | |
| 1. | ТУЗ-ийн дарга Санжай Гупта | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 2. | ТУЗ-ийн гишүүн Гүмэнжавын Цэвэгжав | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 3. | ТУЗ-ийн гишүүн Нямтайширийн Цэлмүүн | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 4. | ТУЗ-ийн гишүүн Майкл Мадден | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 5. | ТУЗ-ийн гишүүн Ив Жако | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 6. | ТУЗ-ийн гишүүн Анджей Витак | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 7. | ТУЗ-ийн гишүүн Албертус Браггинк | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 8. | ТУЗ-ийн гишүүн Сюзанна Хэрринг Карр | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 9. | ТУЗ-ийн хараат бус гишүүн | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |

СЗХ
он сар өдөр 2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

| | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | Нираж Вэдва | | | | | | | |
| 10. | ТУЗ-ийн хараат бус гишүүн Баянсаны Уламбаяр | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |
| 11. | ТУЗ-ийн хараат бус гишүүн Эрик Версавел | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Тийм |

*Хүснэгт №06. ХасБанк ХХК-ийн ТУЗ-ийн хараат бус гишүүд Банкны тухай хуульд тавигдсан шаардлагыг хангасан эсэх мэдээлэл.*

| № | Эрх бүхий албан тушаалтны нэрс | Банкны тухай хууль 33 дугаар зүйлийн 33.1-33.8 дахь хэсэг | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | ТУЗ-ийн хараат бус гишүүн нь 33.3.1-т заасан туршлагатай эсэх (Тийм/Үгүй) | Тухайн банк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч эсэх (Тийм/Үгүй) | Банк, түүний нэгдлийн оролцогчид төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан эсэх (Тийм/Үгүй) | Банкны үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүссэн эсэх (Тийм/Үгүй) | Төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаг эсэх (Тийм/Үгүй) | Эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан төлбөрийн чадваргүй болж байсан эсэх (Тийм/Үгүй) | Банкны тухай хуулийн 33.3.2-33.3.3-т заасан этгээдийн холбогдох этгээд эсэх (Тийм/Үгүй) |
| Нэг. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд | | | | | | | | |
| 1. | ТУЗ-ийн хараат бус гишүүн Нираж Вэдва | Тийм | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй |
| 2. | ТУЗ-ийн хараат бус гишүүн Баянсаны Уламбаяр | Тийм | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй |
| 3. | ТУЗ-ийн хараат бус гишүүн Эрик Версавел | Тийм | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй | Үгүй |

Дээр дурдсан хүснэгт дэх мэдээлэл болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалд үндэслэн Үнэт цаас гаргагчийн төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага болон эрх бүхий албан тушаалтан нь холбогдох хууль тогтоомж болон Компанийн засаглалын кодекст заасан шаардлага хангасан эсэх асуудлыг дэлгэрүүлэн авч үзэж, дараах байдлаар дүгнэлээ.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байх шаардлагыг Компанийн тухай хуулийн 75.8 дахь хэсэгт[18] хуульчилсан байх бөгөөд Банкнаас Хуулийн фирмд ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн зохистой засаглалын сургалтад хамрагдсан талаарх мэдээллээс үзвэл Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүд, Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нар нь Компанийн засаглалын сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна гэж үзэх үндэслэлтэй байна.

[18] Компанийн тухай хууль (2011).
75 дугаар зүйл.Төлөөлөн удирдах зөвлөл
75.8.Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн дарга нь компанийн засаглалын чиглэлээр сургалтад хамрагдаж, гэрчилгээ авсан байна.

414

СЭХ
он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ

Эрх бүхий албан тушаалтны хувьд Компанийн тухай хуулийн 84 дүгээр зүйл[19] болон Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1 дэх хэсэг[20], 33.3 дахь хэсэг[21], 34.2 дахь хэсэг[22] нарийвчлан тусгасан шаардлагуудын хүрээнд Банкнаас ирүүлсэн эрх бүхий албан тушаалтны эрхэлж байгаа ажил, албан тушаал, анкет, баримт бичигт тусгагдсан мэдээлэл, эрх бүхий албан тушаалтнуудын гаргаж өгсөн дээрх хуулийн шаардлагыг хангаж байгаа тухай Баталгаанд үндэслэн Үнэт цаас гаргагчийн эрх бүхий албан тушаалтнууд нь хуульд заасан шаардлагыг хангаж байна гэж Хуулийн фирмээс дүгнэсэн болно.

Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн ажлын туршлага, мэргэшсэн дадлага, туршлагын шаардлагын талаар Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.7 дахь хэсэгт "дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс таваас доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан туршлагатай" байх, 33.3.1 дэх заалтад "банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай" байх бөгөөд Үнэт

---

[19] **Компанийн тухай хууль (2011).**
84 дүгээр зүйл.**Компанийн эрх бүхий албан тушаалтан**
84.3.Дараах этгээдийг компанийн эрх бүхий албан тушаалд ажиллахыг хориглоно:
84.3.1.хуульд өөрөөр заагаагүй бол төрийн болон нутгийн захиргааны байгууллага, цэрэг, цагдаа, шүүх, прокурорын байгууллагад удирдах албан тушаал хашдаг;
84.3.2.ял шийтгэл эдэлж байгаа.

[20] **Банкны тухай хууль (2010).**
32 дугаар зүйл.**Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн**
32.1.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн дараахь шалгуурыг хангасан байна:
32.1.1.зээл, батлан даалт, баталгааны гэрээгээр хүлээсэн хугацаа хэтэрсэн аливаа өргүй;
32.1.2.эдийн засаг, өмчлөх эрх, олон нийтийн аюулгүй байдал, ашиг сонирхол, авлига, үндэсний болон хүн төрөлхтний аюулгүй байдал, энх тайвны эсрэг гэмт хэрэгт ял шийтгүүлж байгаагүй;
32.1.3.ёс зүйн болон бизнесийн нэр хүнд нь банкийг удирдахад харшлахгүй байх;
32.1.4.санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагын эрх бүхий албан тушаалтан бол сонирхлын зөрчилгүй, банкны шийдвэр гаргах үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөхөөргүй байх;
32.1.5.зөрчлийн улмаас банк ба банк бус санхүүгийн байгууллагын тусгай зөвшөөрөл хүчингүй болох үед эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байсан бол тусгай зөвшөөрлийг хүчингүй болгосноос хойш гурван жил өнгөрсөн байх;
32.1.6.санхүүгийн зах зээлд мэргэжлийн үйл ажиллагаа эрхэлдэг байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажиллаж байх үедээ Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээсэн бол үүнээс хойш гурван жил өнгөрсөн байх.
32.1.7.дээд боловсролтой, банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүй, мэдээллийн технологи, компанийн засаглалын чиглэлээр мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүнээс таваас доошгүй жил банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаал хашсан туршлагатай байх.

[21] **Банкны тухай хууль (2010).**
33 дугаар зүйл.**Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**
33.3.1.банк, санхүү, эдийн засаг, хууль эрх зүйн чиглэлээр дээд боловсролтой, мэргэшсэн, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан туршлагатай;
33.3.2.тухайн банк, түүний нэгдлийн оролцогчийн нөлөө бүхий хувьцаа эзэмшигч биш байх;
33.3.3.тухайн банк, түүний нэгдлийн оролцогчид сүүлийн таван жилийн хугацаанд төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнээс бусад эрх бүхий албан тушаалтан, сүүлийн гурван жилийн хугацаанд бусад ажилтнаар тус тус ажиллаж байгаагүй
33.3.4.тухайн банкны үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтээс хамаарч урамшуулал авч байгаагүй, авдаггүй байх;
33.3.5.банкны үйл ажиллагаа, гүйцэтгэх удирдлагад хяналт тавихад саад учруулах аливаа нөхцөл байдал үүсээгүй байх;
33.3.6.төрийн, улс төрийн болон төрийн жинхэнэ албан тушаал хашдаггүй байх;
33.3.7.эрх бүхий албан тушаалтнаар нь ажиллаж байсан хуулийн этгээд дампуурсан, төлбөрийн чадваргүй болсон нь тухайн этгээдээс аливаа хэлбэрээр шалтгаалаагүй нь нотлогдсон байх;
33.3.8.энэ хуулийн 33.3.2-33.3.3-т заасан этгээдийн холбогдох этгээд биш байх.

[22] **Банкны тухай хууль (2010).**
34 дүгээр зүйл.**Гүйцэтгэх удирдлага.**
34.2.1.банк, санхүү, эдийн засгийн дээд боловсролтой, мэргэжлээрээ 10-аас доошгүй жил ажилласан, үүний таваас доошгүй жилд банк, санхүүгийн байгууллагад эрх бүхий албан тушаалтнаар ажилласан, мэргэжлийн дадлага туршлагатай;
34.2.2.банк, банкны хувьцаа эзэмшигч, төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнтэй сонирхлын зөрчилгүй, нэгдмэл сонирхолтой этгээд биш байх;
34.2.3.бусад банк, түүний нэгдэл, эсхүл банктай харилцан хамаарал бүхий санхүүгийн бус үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн эрх бүхий албан тушаалтан биш байх;
34.2.4.Монголбанкны эрх бүхий албан тушаалтнаар сүүлийн хоёр жилийн хугацаанд ажиллаагүй байх;
34.2.5.мэргэжлийн үйл ажиллагаа явуулах эрхээ хасуулаагүй байх;
34.2.6.банкны хууль тогтоомж, Монголбанкны шийдвэрийг ноцтой зөрчиж байгаагүй.

цаас гаргагчаас ирүүлсэн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, бусад дурдагдсан эрх бүхий албан тушаалтнуудын мэдээлэл, анкетад үндэслэн Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүд, гүйцэтгэх удирдлага, бусад дурдагдсан эрх бүхий албан тушаалтнууд нь санхүү, эдийн засаг, инженер, бизнесийн удирдлагын чиглэлээр мэргэшсэн бөгөөд эдгээр албан тушаалтнууд нь удирдах албан тушаал эрхлэхэд шаардагдах мэргэжлийн боловсрол, хөдөлмөр эрхлэлтийн түүхтэй байна гэж үзлээ.

Иймд Үнэт цаас гаргагчийн Төлөөлөн удирдах зөвлөл, гүйцэтгэх удирдлага, эрх бүхий албан тушаалтан нь Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1 дэх хэсэгт "Банк төлөөлөн удирдах зөвлөлтэй байна", 31.2 дахь хэсэгт "Банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш гишүүнтэй байна", 33 дугаар зүйлийн 33.1 дэх хэсэгт "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна", 32.3[23] дахь хэсэгт "Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь энэ хуулийн 32.1-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг банкнаас бичгээр урьдчилан ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай банкинд мэдэгдэнэ", Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэгт "Компанийн дүрэмд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөлийн даргыг төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн дотроос нийт гишүүний олонхын саналаар сонгоно", 83 дугаар зүйлийн 83.2 дахь хэсэгт "Компанийн дүрэмд гүйцэтгэх удирдлагыг багаар хэрэгжүүлэхээр заагаагүй бол хувь хүн хэрэгжүүлнэ", Компанийн тухай хуулийн 83 дугаар зүйлийн 83.4 дэх хэсэгт "Компанийн гүйцэтгэх удирдлагыг хэрэгжүүлэгч этгээд нь төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн байж болох бөгөөд төлөөлөн удирдах зөвлөлийн дарга байхыг хориглоно" гэсэн холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагыг тус тус хангаж байна гэж үзлээ.

**Гурав. Банкны дүрэм, үнэт цаасаа анх удаа нийтэд санал болгон гаргаж байгаа компанийн хувьд хувьцаат компанийн дүрмийн төсөл, бусад дотоод дүрэм, журмууд нь холбогдох хууль тогтоомж, Санхүүгийн зохицуулах хорооноос баталсан "Компанийн засаглалын кодекс"-т нийцсэн эсэх асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд Банкны үйл ажиллагааг зохицуулж байгаа хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа дүрэм, журамд дүн шинжилгээ хийлээ. Банкнаас Хуулийн фирмд ирүүлсэн материалаас үзвэл нийт 268 (хоёр зуун жаран найман) дүрэм, журам хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Мөн эдгээр дүрэм, журмыг хэрэгжүүлэх зорилгоор баталсан нийт 75 (далан таван) зааврыг Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд ирүүлсэн байна. Банкны дүрэм, журмын жагсаалтыг **Хавсралт №01. "ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын жагсаалт"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

*Хүснэгт №07. ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын жагсаалтын тоон үзүүлэлт.*

| № | Дүрэм, журмын нэр, төрөл | Нийт |
|---|---|---|
| 1. | Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам | 22 |
| 2. | Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журам | 19 |
| 3. | Банкны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам | 105 |
| 4. | Санхүү, нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам | 38 |
| 5. | Хөрөнгийн удирдлага ба худалдан авалтад хамаарах дүрэм, журам | 14 |
| 6. | Эрсдэлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам | 49 |
| 7. | Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам | 4 |
| 8. | Харилцагчийн үйлчилгээнд хамаарах дүрэм, журам | 6 |
| 9. | Эрх зүйн баримт бичиг боловсруулалтад хамаарах журам | 7 |
| 10. | Бусад дүрэм, журам | 4 |
| | НИЙТ | 268 |

[23] 32.3.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь энэ хуулийн 32.1-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг банкнаас бичгээр урьдчилан ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай банкинд мэдэгдэнэ.

416

СЗХ
он 2023 сар 05 13 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

Хуулийн фирм нь ХасБанк ХХК-аас тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэж үзэн ирүүлсэн нийт дүрэм, журмын хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө дүрэм, журмаар зохицуулж байгаа харилцаанд үндэслэн дараах шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

(i) Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Компанийн засаглалын кодекс, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 сарын 09-ний өдрийн №А-143 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 03 сарын 22-ны өдрийн №А-86 тоот тушаалаар батлагдсан Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журам болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Компанийн засаглалын кодексд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

(ii) Хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журам нь Хөдөлмөрийн тухай хууль, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Байгууллагын нууцын тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хууль, Компанийн хөдөлмөрийн дотоод журам, ХасБанк ХХК-ийн хүний нөөцийн талаар баримтлах бодлогод тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

(iii) Банкны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаа буюу Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт заасан мөнгөн хадгаламж, гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах, үнэт зүйл хадгалах, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх, гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа, өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах, үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах, зээл болон санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа, даатгалын зуучлагчийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам нь Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Монголбанкны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

(iv) Санхүү нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Монголбанкны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

(v) Хөрөнгийн удирдлага ба худалдан авалтад хамаарах дүрэм, журам нь Банкны тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 12 сарын 06-ны өдрийн №А-295 тушаалаар батлагдсан Банкны заавал байлгах нөөцийг тогтоох, тооцох, хяналт тавих журамд тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж мөрдүүлсэн эсэх;

(vi) Эрсдэлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам нь Банкны тухай хууль, Компанийн засаглалын кодекс болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль болон Монголбанкны дүрэм, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

(vii) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам нь Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 сарын 21-ний өдрийн №А-26 тоот тушаалаар батлагдсан Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журамд тус тус нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

417

СЗХ
он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

(viii) Харилцагчийн үйлчилгээнд хамаарах дүрэм, журам нь Банкны тухай хууль болох холбогдох хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн эсэх, агуулга нь хууль, тогтоомжид нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх;

(ix) Эрх зүйн баримт бичиг боловсруулалтад хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль зэрэг баримт бичиг боловсруулалтын үйл ажиллагааны стандартуудыг мөрдлөг болгон ажилласан эсэх, агуулга нь журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж мөрдүүлсэн эсэх;

(x) Бусад ангилалд хамаарах дүрэм, журам нь холбогдох хууль, тогтоомжид нийцсэн эсэх, агуулга нь хууль, журамд харшилсан эсэх, эрх бүхий этгээд баталж, мөрдүүлсэн эсэх.

Үнэт цаас гаргагч нь Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Банканд мөрдөгдөж байгаа нийт 268 (хоёр зуун жаран найман) дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байна. Эдгээр дүрэм, журам нь баталсан этгээдээс шалтгаалж ялгаатай байдлаар дугаарлагддаг байна. Үүнд:

*Хүснэгт №08. ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд мөрдөгдөж буй дүрэм, журмын дугаарлалтын индекс.*

| № | Дүрэм, журам баталсан этгээд | Шийдвэр, тогтоол, тушаалын дугаарлалтын эхлэл |
|---|---|---|
| 1. | ТэнГэр Санхүүгийн Нэгдэлийн Төлөөлөн удирдах зөвлөл | GR |
| 2. | ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл | R |
| 3. | Гүйцэтгэх захирал | А |
| 4. | Үйл ажиллагаа хариуцсан захирал | Б |
| 5. | Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал | А-2 |
| 6. | Эрсдэл хариуцсан захирал | А-7 |
| 7. | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал | А-4 |
| 8. | Ерөнхий аудитор | Б-1 |
| 9. | Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Лизинг хариуцсан захирал | Б-2 |

Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 01 сарын 20-ны өдрийн №42 тоот тушаалаар батлагдсан Банкны эрхзүйн баримт бичигийг бүртгэх тухай журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт "Банк нь эрх зүйн баримт бичгийн[24] 2 (хоёр) хувь (албан ёсны эх хувь, түүний баталгаажуулсан хуулбарын нэг хувь)-ийг баталсан тухай тушаалын хамт, түүнийг батлснаас хойш ажлын 10 (арван) өдрийн дотор Монголбанкны хуулийн хэлтэст албан бичгээр, эсхүл урьдчилж бичгээр мэдэгдсэн цахим хаягаас цахим хэлбэрээр ирүүлнэ" гэж заасан байна. Өөрөөр хэлбэл Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх гадагш чиглэсэн дүрэм, журам болон засаглалд хамаарах дүрэм, журмыг тухай бүр Монголбанканд хүргүүлж, бүртгүүлэхээр заасан байна. Энэ талаар Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчаас тодруулахад Банк нь энд дурдсан эрхзүйн актуудыг тухай бүр Монголбанканд журмын дагуу хүргүүлж бүртгүүлдэг бөгөөд Монголбанкнаас эрхзүйн актыг хүлээн авч бүртгэсэн тухай ХасБанк ХХК-д албан бичгээр буцаан мэдэгддэг талаар болон ийнхүү мэдэгдсэн Монголбанкны 2019-2022 онд хамаарах нийт 11 (арван нэгэн) албан бичгийг Хуулийн фирмд ирүүлсэн болно. Эндээс дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч нь Банкны үйл ажиллагааны тусгай зөвшөөрлөөр гүйцэтгэх гадагш чиглэсэн дүрэм, журам болон засаглалд хамаарах дүрэм, журам, тэдгээрт орсон нэмэлт, өөрчлөлтийг тухай бүр Монголбанканд хүргүүлж, бүртгүүлэн ажиллаж байгаа бөгөөд Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 01 сарын 20-ны өдрийн №42 тоот тушаалаар батлагдсан Банкны эрх зүйн баримт бичгийг бүртгэх тухай журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна гэж үзэх үндэслэлтэй байна.

(i) <u>Компанийн засаглалд хамаарах дүрэм, журам</u>

ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн 2022 оны 10 сарын 21-ний өдрийн хурлаар Банкны дүрмийг баталсан байна. Хуулийн фирмээс ХасБанк ХХК-ийн дүрэм нь Компанийн тухай

[24] Банкны эрхзүйн баримт бичгийг бүртгэх тухай журам (2011).
Нэг.Нийтлэг үндэслэл.
1.3. Энэхүү журамд заасан нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
1.3.1. "Банкны эрхзүйн баримт бичиг" гэж Монголбанкнаас олгосон тусгай зөвшөөрөл бүхий банкнаас өөрийн үйл ажиллагаандаа мөрдүүлэхээр гаргасан, үйлчлэл нь байнга давтагдах шинжтэй, гадагш чиглэсэн, хэм хэмжээ тогтоосон шийдвэрийг;

418

хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 сарын 09-ний өдрийн №А-143 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журамд тус тус нийцэж байгаа эсэхэд дараах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Дүрмийн 8 дугаар зүйлд заасны дагуу хувьцаа эзэмшигчдийн хурлаар Банкны тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь хэсэг болон Компанийн тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасныаас гадна Төлөөлөн удирдах зөвлөлийн тухайн жилийн төсвийг батлах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэнэ. Түүнчлэн Банкны дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5 дахь хэсэгт Компанийн тухай хууль болон энэхүү дүрэмд өөрөөр заагаагүй бол хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр нь хуралд биечлэн болон төлөөллөөр оролцсон тухайн асуудлаар саналын эрхтэй хувьцаа эзэмшигчдийн ердийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно гэж заасан нь Компанийн тухай хуулийн 63 дугаар зүйлийн 63.5[25] дахь хэсэгт заасантай нийцэж байна. Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтад стратегийн асуудлыг тодруулж, эдгээр асуудлыг хувьцаа эзэмшигчдийн хуралд биечлэн эсхүл төлөөллөөр оролцож байгаа тухайн асуудлаар санал өгөх эрхтэй толгой компанид эзэмшиж буй хувьцааны 75 (далан таван) хувиас доошгүй хувийн саналаар батална гэж тусгажээ. Өөрөөр хэлбэл стратегийн асуудлыг зөвхөн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдвэрлэхээр Дүрэмдээ тусгасан байна. Стратегийн асуудал гэдэгт Банкны дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах, Банкны өдөр тутмын үйл ажиллагаанд хамааралгүйгээр Банкны төсөвт тусгагдаагүй дүнтэй хөрөнгийг худалдах, тээвэрлэх, шилжүүлэх, түрээслүүлэх буюу өөр бусад байдлаар захиран зарцуулах зэрэг асуудлыг хамааруулж ойлгохоор байна. Иймд Дүрмийн энэхүү заалт нь агуулгын хувьд Компанийн тухай хууль болон Банкны тухай хуулийг зөрчөөгүй байна гэж үзлээ.

Мөн Дүрэмд Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн бүрэн эрхийн хугацаа нь 2 (хоёр) жил байх бөгөөд төлөөлөн удирдах зөвлөл нь 9-12 (есөөс арван хоёр) гишүүнтэй байх, тэдгээрийн 3 (гурав) болон түүнээс дээш гишүүн нь хараат бус гишүүн байхаар заасан нь Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.2 дахь хэсэг[26] болон 33 дугаар зүйлийн 33.1[27] дэх хэсэгт заасантай нийцэж байна. Дүрмийн 8 дугаар зүйлийн 8.25 дахь хэсэгт төлөөлөн удирдах зөвлөл нь Гүйцэтгэх захирлыг Монголбанкны Ерөнхийлөгчтэй зөвшилцсөний үндсэн дээр томилно гэж заасан нь Банкны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.3 дахь хэсэгт заасан Банкны төлөөлөн удирдах зөвлөл нь Монголбанкны зөвшөөрснөөр банкны гүйцэтгэх удирдлагыг томилно гэсэнтэй нийцэж байна.

ХасБанк ХХК-ийн Дүрэм нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болон Банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан тусгавал зохих зүйлийг тусгасан, агуулгын хувьд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 сарын 09-ний өдрийн №А-143 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журамд нийцсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Хуулийн фирм нь Банкнаас ирүүлсэн засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны 2022 оны 05 сарын 09-ний өдрийн №А-143 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журам, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 03 сарын 22-ны өдрийн №А-86 тоот тушаалаар батлагдсан Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүнийг нэр дэвшүүлэх, томилох, чөлөөлөх журамд нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

---

[25] **Компанийн тухай хууль (2011).**
63 дугаар зүйл.**Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох**
63.5.Энэ хууль болон компанийн дүрэмд заасныаас дээгүүр хувь тогтоогоогүй, эсхүл хуульд өөрөөр заагаагүй бол төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол гүйцэтгэх удирдлага/-ийн гишүүдийг сонгохоос бусад асуудлаар гаргах шийдвэр хуралд саналын эрхтэй оролцож байгаа хувьцаа эзэмшигчдийн олонхын саналаар хүчин төгөлдөр болно.
[26] **Банкны тухай хууль (2010).**
31 дүгээр зүйл.**Банкны төлөөлөн удирдах зөвлөл**
31.2.Банкны төлөөлөн удирдах зөвлөл ес ба түүнээс дээш гишүүнтэй байна.
[27] 33 дугаар зүйл.**Төлөөлөн удирдах зөвлөлийн хараат бус гишүүн**
33.1.Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй хувь нь хараат бус гишүүн байна.

СЗХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

Банкны засаглалд хамаарах дүрэм, журмаас онцгойлон дурдвал Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 сарын 30-ны өдрийн №R-2021-23 тоот тогтоолоор Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг баталсан байна. Тус журмын 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад "төлөөлөн удирдах зөвлөл нь 9-12 гишүүнтэй байна", 3.2 дахь хэсэгт "төлөөлөн удирдах зөвлөлийн нийт гишүүний гуравны нэгээс доошгүй нь хараат бус гишүүн байна" гэж заасан нь Банкны тухай хууль болон Банкны Дүрэмд заасантай тус тус нийцэж байна. Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгохдоо Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хорооны саналыг үндэслэж хувьцаа эзэмшигчдийн хурлаас сонгохоор заасан байна. Тус журмын 4 дүгээр зүйлийн 4.8 дахь хэсэгт сонгогдсон болон улиран сонгогдсон төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнийг Монголбанкинд бүртгүүлнэ гэж заасан нь Банкны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3[28] дахь хэсэгт заасантай нийцэж байна. Түүнчлэн журмын 11 дүгээр зүйлд төлөөлөн удирдах зөвлөл нь (i) засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо; (ii) аудитын хороо; болон (iii) эрсдэлийн удирдлагын хороо гэсэн байнгын хороодтой байхаар заасан байна. Эдгээр Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх хороод нь зорилго, эрх үүргээ тодорхойлсон дүрэмтэй байх ба хороо тус бүрийн дүрмийг төлөөлөн удирдах зөвлөл жил бүр хянаж, санал болгох өөрчлөлтийг танилцуулна гэж Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмын 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэгт заасан байна. Үнэт цаас гаргагчаас Хуулийн фирмд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 06 сарын 30-ны өдрийн №GR-2021-22 тоот тогтоолоор батлагдсан ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшүүлэх, сонгох бодлого, ХасБанк ХХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн 2006 оны 06 сарын 20-ны өдрийн №R-2006-20 тоот тогтоолоор батлагдсан Эрсдэлийн удирдлагын хорооны журам, Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2004 оны 07 сарын 29-ний өдрийн №R-2004-16-07 тоот тогтоолоор батлагдсан Аудитын бодлогыг тус тус ирүүлсэн байна. Түүнчлэн Банк нь Төлөөлөн удирдах зөвлөлийн хурлаар Санхүүгийн эрсдэлийн удирдлагын бодлого, Зээлийн хорооны журам, Гүйцэтгэх хорооны журмыг тус тус баталж мөрдүүлсэн нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, ХасБанк ХХК-ийн дүрэмд нийцсэн байна.

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2013 оны 06 сарын 10-ны өдрийн №А-689 тоот тушаалаар ХасБанк ХХК-ийн хороодын ажиллах нийтлэг журмыг баталсан байна. Энэхүү журамд заасан хороо нь Гүйцэтгэх захирлын тушаалаар томилогддог бөгөөд тус журмаар гүйцэтгэх захирлаас Банкны зорилт, өөрийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхтэй холбогдсон асуудлаар шийдвэр гаргахад мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгөх, удирдлагын түвшинд шийдвэр гаргах чиг үүрэг бүхий ажиллаж байгаа хороодын үйл ажиллагааны зарчим, бүтэц, бүрэлдэхүүн, ажлын зохион байгуулалт, эрх үүрэг, хорооны хуралд асуудал оруулах, хурлын бэлтгэл ажлыг хангах, хурлын дэг, хурлаас шийдвэр гаргах, гарсан шийдвэрийн биелэлтийг хангахтай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна. Тус журмын 2 дугаар зүйлийн 2.1.1 дэх заалтад хороодын бүтцийг ерөнхий чиг үүргийн хувьд (i) Гүйцэтгэх удирдлагын хороо; (ii) Эрсдэлийн удирдлагын хороо; болон (iii) Аудитын асуудал эрхэлсэн хороо гэж, чиглэлийн хувьд (i) Зээлийн асуудал эрхэлсэн хороо; (ii) Актив пассивын асуудал эрхэлсэн хороо; (iii) Бизнес хөгжлийн асуудал эрхэлсэн хороо; (iv) Тендерийн асуудал эрхэлсэн хороо; (v) Сонгон шалгаруулалтын асуудал эрхэлсэн хороо; (vi) Шагналын асуудал эрхэлсэн хороо; болон (vii) Тусгай активын асуудал эрхэлсэн хороо байхаар заасан байна. Банк нь Актив пассивын удирдлагын хорооны ажиллах журам, Эрсдэлийн удирдлагын хорооны ажиллах журмыг тус тус батлан мөрдүүлсэн нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд нийцсэн байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 03 сарын 23-ны өдрийн №145 тоот Компанийн засаглалын кодексийг шинэчлэн батлах тухай тогтоолд заасны дагуу нээлттэй хувьцаат компани, даатгагч, банк бус санхүүгийн итгэлцлийн үйлчилгээ болон хөрөнгө оруулалтын менежментийн

[28] Банкны тухай хууль (2010).
32 дугаар зүйл. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн
32.3. Банкны төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүнд нэр дэвшиж байгаа этгээд нь энэ хуулийн 32.1-д заасан шалгуурыг хангаж байгаа эсэхийг банкнаас бичгээр урьдчилан ирүүлсэн мэдээлэлд үндэслэн Монголбанк тогтоож, энэ тухай банкинд мэдэгдэнэ.

СЗХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

үйл ажиллагаа эрхэлдэг компанид тус тус үүрэг болгож бусад компаниудад зөвлөсөн байна. Хувьцаат компанийн хувьд компанийн засаглалын дүрэм, журмаа Компанийн тухай хууль болон Компанийн засаглалын кодекст нийцүүлэн батлах үүрэг хүлээнэ. Иймд Банкны анхдагч зах зээлийн арилжаа амжилттай явагдаж хувьцаат компани болсноор Компанийн засаглалын кодекст заасан компанийн засаглалтай холбоотой дараах дүрэм, журмыг баталж ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөсөн. Үүнд:

(i) Компанийн засаглалын кодексийн 3 дугаар зүйлийн 3.1 дэх заалтад заасан Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журам;
(ii) Компанийн засаглалын кодексийн 5 дугаар зүйлийн 5.4 дэх заалтад заасан Комплайнсын хяналтын заавар;
(iii) Компанийн засаглалын кодексийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх заалтад заасан Бусад оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах талаар бодлого;
(iv) Компанийн засаглалын кодексийн 7 дугаар зүйлийн 7.4 дэх заалтад заасан Компанийн ажилтнуудын санал, хүсэлт, гомдлыг хүлээн авч шийдвэрлэх журам;
(v) Компанийн засаглалын кодексийн 9 дүгээр зүйлийн 9.3 дахь заалтад заасан Хувьцаа эзэмшигчдийн хурлыг зарлан хуралдуулах тухай журам.

Хуулийн дүгнэлтийг гүйцэтгэх явцад Үнэт цаас гаргагчаас нэмж ирүүлсэн баримт материалаас үзвэл ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 01 сарын 23-ны өдөр батлагдсан №А-160 тоот тушаалаар Компанийн засаглалын кодексийг дагаж мөрдөхтэй холбоотойгоор хийгдэх ажлын нарийвчилсан төлөвлөгөөг баталж, дээр дурдсан засаглалын холбогдох дүрэм, журмыг батлан гаргаж, үйл ажиллагаанд хэрэгжүүлэхээр ажиллаж байгааг дурдаж байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл ХасБанк ХХК-ийн Дүрэм болон засаглалд хамаарах дүрэм, журам нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкнаас мөрдвөл зохих дүрэм, журамд нийцсэн байна.

(ii) <u>Хөдөлмөрийн харилцаа хүний нөөцөд хамаарах журам</u>

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар Банкны дотоод үйл ажиллагаанд хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байх бөгөөд эдгээр журмаас онцгойлон дурдвал Үнэт цаас гаргагч нь Хөдөлмөрийн тухай хуулийн 122 дугаар зүйлийн 122.1 дэх хэсэгт[29] заасан ажил олгогч нь хууль тогтоомжид нийцүүлэн хөдөлмөрийн дотоод журам баталж мөрдүүлнэ гэж заасны дагуу Гүйцэтгэх захирлын 2022 оны 02 сарын 16-ны өдрийн №А-154 тоот тушаалаар Банкны Хөдөлмөрийн дотоод журмыг шинэчлэн баталсан байна. Энэхүү журмаар ажилтныг сонгон шалгаруулах, хөдөлмөрийн гэрээ байгуулах, ажил олгогч болон ажилтны эрх, үүрэг, ажлын цаг, ээлжийн амралт, ажилтанд олгох цалин хөлс, урамшуулал, тэтгэмж, нөхөн олговор, эд хөрөнгийн хариуцлага, ажилтанд нөлөөллийн арга хэмжээ авах, сахилгын шийтгэл ногдуулах, хөдөлмөр эрхлэлтийн харилцааг дуусгавар болгох, ажилтны гомдлыг шийдвэрлэх асуудлыг тус тус тодорхойлон тусгасан байна. Тухайлбал Хөдөлмөрийн дотоод журмын 16 дугаар зүйлийн 16.8 дахь хэсэгт[30] ажилтан хөдөлмөрийн гэрээг цуцлах саналаа ажлын 20 (хорин) өдрийн өмнө удирдах ажилтанд албан ёсоор мэдэгдэхээр заасан байна. Энд дурдсан ажлын 20 (хорин) өдөр гэдгийг хуанлийн өдөрт шилжүүлбэл нийт 28 (хорин найман) өдөр болж байна. Энэ нь Хөдөлмөрийн тухай

---

[29] **Хөдөлмөрийн тухай хууль (2021).**
122 дугаар зүйл.**Хөдөлмөрийн дотоод журам**
122.1.Ажил олгогч ажилтны төлөөлөгчийн саналыг харгалзан хууль тогтоомжид нийцүүлэн тухайн аж ахуйн нэгж, байгууллагын хэмжээнд үйлчлэх хөдөлмөрийн дотоод журмыг баталж мөрдүүлнэ.
[30] **ХасБанк ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам (2022).**
16 дугаар зүйл. **Хөдөлмөр эрхлэлтийн харилцаа дуусгавар болгох, хөдөлмөрийн гэрээг цуцлах**
16.8. Ажилтан нь хөдөлмөрийн гэрээг өөрийн санаачилгаар цуцлах тухайгаа өөрийн удирдах ажилтанд ажлын 20 өдрийн өмнө албан ёсоор мэдэгдэнэ.

СЭХ
он 2023 сар 05. 17 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2 дахь хэсэг[31] болон 79.3 дахь хэсэгт[32] тус тус нийцэж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт "Хөдөлмөрийн эрхийн маргаан таслах орон тооны бус байнгын ажиллагаатай комиссыг 20 ба түүнээс дээш ажилтантай аж ахуйн нэгж, байгууллагад байгуулна" гэж заасны дагуу Банкны Хөдөлмөрийн дотоод журмын 17 дугаар зүйлд маргаан таслах комиссын бүтэц, эрх үүрэг, гомдол хүлээн авах, шийдвэрлэх хугацаа гэх мэтийг тодорхой заасан байх бөгөөд журмын 17.9 дэх хэсэгт[33] маргаан таслах комисс нь ажил олгогчийн болон ажилтны тэнцүү тооны төлөөллөөс бүрдэхээр заасан байна.

Иймд Банкнаас ирүүлсэн хөдөлмөрийн дотоод журам, хөдөлмөрийн харилцаа, хүний нөөцөд хамаарах дүрэм, журмууд нь Хөдөлмөрийн тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомжид нийцсэн байна гэж үзлээ.

(iii) <u>Банкны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам</u>

Үнэт цаас гаргагч нь тасалбар болгосон өдрийн байдлаар Банкны хэмжээнд хүчин төгөлдөр мөрдөгдөж буй, тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах нийт 105 (нэг зуун таван) дүрэм, журмыг Хуулийн фирмд ирүүлсэн байна.

*Хүснэгт №09. ХасБанк ХХК-ийн тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмын тоон үзүүлэлт.*

| № | Дүрэм, журмын нэр, төрөл | Нийт |
|---|---|---|
| 1. | Мөнгөн хадгаламжид хамаарах дүрэм, журам | 3 |
| 2. | Зээлийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журам | 30 |
| 3. | Төлбөр тооцооны үйлчилгээнд хамаарах дүрэм, журам | 37 |
| 4. | Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргахад хамаарах дүрэм, журам | 11 |
| 5. | Гадаад валют худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулахад хамаарах дүрэм, журам | 2 |
| 6. | Үнэт металл, эрдэнийн чулуу худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулахад хамаарах дүрэм, журам | 4 |
| 7. | Үнэт зүйл хадгалахад хамаарах дүрэм, журам | 1 |
| 8. | Гадаад төлбөр тооцооны үйлчилгээнд хамаарах дүрэм, журам | 12 |
| 9. | Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авахад хамаарах дүрэм, журам | 3 |
| 10. | Даатгалын зуучлалд хамаарах дүрэм, журам | 2 |
| | НИЙТ | 105 |

Эдгээр дүрэм, журмаас онцгойлон дурдвал ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 10 сарын 20-ны өдрийн №А-1525 тоот тушаалаар Банкны Харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүний ерөнхий журмыг баталсан байна. Тус журмаар ХасБанк ХХК-аас үзүүлэх харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүн, үйлчилгээнд баримтлах бодлого, үйл ажиллагааны ерөнхий чиглэл болон хэрэгжүүлэгч нэгжүүд, тэдгээрийн эрх үүргийг тодорхойлохтой холбогдсон харилцааг зохицуулсан байна. Журмын 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт харилцах хадгаламжийн бүтээгдэхүүний хувьд (i) Харилцах данс; (ii) Хугацаагүй хадгаламж; (iii) Хугацаатай хадгаламж гэсэн ерөнхий ангилалтай байхаар заасан байна. Мөн тус журмаар хэрэгжүүлэгч нэгжүүдийн үүрэг хариуцлагыг тодорхойлохдоо (i) Харилцах, хадгаламжийн үйлчилгээг үзүүлэх нэгдүгээр бүс (салбар, тооцооны төвүүд, түүнд дэмжлэг үзүүлэх нэгжүүд); (ii) Хамгаалалтын хоёрдугаар бүс (Эрсдэл, Аюулгүй байдал хариуцсан нэгжүүд); (iii) Хамгаалалтын гуравдугаар бүс (Дотоод аудитын газар) гэсэн дараалаар салбар тооцооны төв харилцагчийн хүсэлтийг хүлээн авч, гэрээ байгуулахаас эхлэн гэрээ дуусгавар болох бүхий л үе шатанд эрсдэлийг удирдан хянах, үнэлэх

---

[31] **Хөдөлмөрийн тухай хууль (2021).**
79 дүгээр зүйл.**Хөдөлмөр эрхлэлтийн харилцааг ажилтны санаачилгаар цуцлах**
79.2. Ажилтан хөдөлмөр эрхлэлтийн харилцааг цуцлах тухай ажил олгогчид бичгээр мэдэгдсэн өдрөөс хойш 30 хоног өнгөрмөгц ажлын байраа орхих эрхтэй бөгөөд энэ тохиолдолд хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдсанд тооцно.
[32] 79.3.Энэ хуулийн 79.2-т заасан хугацаанаас өмнө хөдөлмөр эрхлэлтийн харилцаа цуцлагдах хугацааг ажилтан ажил олгогчтой тохиролцож болно.
[33] **ХасБанк ХХК-ийн Хөдөлмөрийн дотоод журам** (2022).
17 дугаар зүйл.**Гомдол гаргах, гомдлыг шийдвэрлэх**
17.9. Маргаан таслах комисс нь ажил олгогчийн болон ажилтны тэнцүү тооны төлөөллөөс бүрдсэн байх бөгөөд гомдлыг шийдвэрлэх үйл ажиллагаанд талуудын төлөөлөгч тэгш эрх, үүрэгтэй оролцоно.

422

СЗХ
он 2023 сар 05 өдөр 12
БҮРТГЭВ
№ 01

үүргийг шат дараалалтайгаар гүйцэтгэн ажилладаг байна. Ийнхүү харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүний ерөнхий журмыг батлан мөрдүүлсэн нь Банкны тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан холбогдох журамд нийцсэн байна.

Түүнчлэн Банкны Зээлийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмаас зээлийн журмыг зориулалтын хувьд авч үзэж дараах байдлаар ангиллаа. Үүнд:

(i) Бизнесийн зээлийн журам;
(ii) Иргэдэд орон сууц худалдан авах, барьж дуусгахад зориулан олгох зээлийн журам;
(iii) Уул уурхайн зээлийн журам;
(iv) Үнэт металл худалдан авах, хадгалах, барьцаалан зээл олгох үйл ажиллагааны журам;
(v) Барилга байгууламжийн зээлийн журам;
(vi) Гадаад улсад оршин суугч Монгол Улсын иргэдэд орон сууц худалдан авахад зориулан олгох зээлийн журам;
(vii) Бэлтгэн нийлүүлэгчдэд зориулсан зээлийн үйл ажиллагааны журам.

Банкны зээлийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмаас онцгойлон авч үзвэл ХасБанк ХХК-ийн Эрсдэл хариуцсан захирлын 2022 оны 02 сарын 07-ний өдрийн №A7-116 тоот тушаалаар Тусгай активын үйл ажиллагааны журмыг баталсан байна. Тус журмаар Банкны ажилтан нь Монгол Улсад хүчин төгөлдөр мөрдөж байгаа хууль тогтоомж, Банкны бусад эрх зүйн актын хүрээнд зээл, түүнтэй адилтгах активыг тусгай актив болгон шилжүүлэх, тусгай активыг төлүүлэхтэй холбогдсон үйл ажиллагаа, түүний дэс дараалал, ажилтнуудын гүйцэтгэх үүргийг тодорхойлжээ. Журамд зааснаар Банкны салбар, нэгжээс чанаргүй активыг барагдуулахаар ажилласан боловч үр дүн гараагүй, цаашид ажиллахад хүндрэлтэй, 20 (хорин) сая төгрөгөөс дээш үлдэгдэл бүхий актив нь ашиг сонирхлын зөрчилтэй, 181 (нэг зуун наян нэгэн) хоногоос дээш хугацаа хэтэрсэн, шүүх, шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт шилжүүлсэн, орон нутгийн салбар, нэгжийн зээлдэгчийн оршин суух хаяг Улаанбаатар хотод шилжсэн зэрэг дөрвөн нөхцөлийн аль нэгийг хангаж байгаа тохиолдолд активыг Тусгай актив хариуцсан нэгж болон салбар, нэгжийн тохиролцсоноор Тусгай актив хариуцсан нэгжид шилжүүлэхээр байна.

Тусгай актив хариуцсан нэгжийн захирал нь салбар нэгжийн хүсэлтийг хянаж үзээд, тусгай актив болгон хүлээн авах эсэх талаар шийдвэрийг ажлын 5 (таван) хоногийн дотор гаргаж, хэрэв хүлээн авсан тохиолдолд салбар нэгжээс шаардлагатай баримт материалыг гаргуулан зээлийн нөхцөл байдал, ажиллах цар хүрээнээс хамаарч, ажилтанд эсхүл багт хариуцуулан ажиллуулах талаар шийдвэр гаргахаар байна. Улмаар тусгай активыг хариуцан авсан баг, ажилтан нь зээлдэгчид хугацаа хэтэрсэн зээлийн төлбөрийг тогтоосон хугацаанд төлөхийг, тогтоосон хугацаанд төлөөгүй тохиолдолд зээлийн гэрээг нэг талын санаачилгаар цуцлах талаар мэдэгдэх, тогтоосон хугацаанд зээлийг төлөөгүй тохиолдолд шүүхэд нэхэмжлэл гаргах талаар мэдэгдэх, улмаар шүүхэд нэхэмжлэл гаргах, шүүхээс хэргийг эцэслэн шийдвэрлэсэн бол албадан гүйцэтгүүлэх захирамж гаргуулж, шийдвэр гүйцэтгэх ажиллагааг эхлүүлэх зэрэг ажиллагааг хийхээр байна. Ийнхүү ажиллагааны үр дүнд тусгай активын зөрчил арилан активд хэвийн болсон тохиолдолд тусгай актив хариуцсан нэгжийг харьялах хариуцсан захирал болон Тусгай актив нэгжийн захирал захирлын хамтарсан шийдвэрээр салбар, тооцооны төвд буцаан шилжүүлэхээр байна. Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн дээр дурдсан зээлийн үйл ажиллагаанд хамаарах дүрэм, журмууд нь Банкны тухай хууль, Банк эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан холбогдох журамд нийцсэн байна.

Банкны Төлбөр тооцооны үйлчилгээнд хамаарах дүрэм, журмаас онцгойлон авч үзвэл Банкны Гүйцэтгэх захирлын 2017 оны 08 сарын 11 өдрийн №A-1107 тоот тушаалаар Банк хооронд хийгдэх гүйлгээний ерөнхий журмыг баталсан байна. Тус журмаар харилцагчийн хүсэлтээр салбар, тооцооны төв болон цахим сувгаар дамжуулан банк хоорондын төлбөр тооцооны үйлчилгээ

423

СЗХ
2023 оны 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023-05-05

үзүүлэх, түүнтэй холбоотой бусад харилцаа, үйл ажиллагаанд баримтлах бодлого, ерөнхий чиглэл, стратеги, зарчим, хамгаалалтын бүсүүд, тэдгээрийн хүлээх үүрэг хариуцлагыг зохицуулсан байна. Түүнчлэн хэрэгжүүлэгч нэгжүүдийн үүрэг, хариуцлагыг тодорхойлохдоо (i) Хамгаалалтын нэгдүгээр бүс (салбар, тооцооны төв, түүнд дэмжлэг үзүүлэх нэгжүүд); (ii) Хамгаалалтын хоёрдугаар бүс (Төв албаны банк хоорондын гүйлгээ хариуцсан нэгжүүд); (iii) Хамгаалалтын гуравдугаар бүс (Дотоод аудитын газар) гэсэн дараалаар салбар, тооцооны төв харилцагчийн гүйлгээ илгээх хүсэлтийг хүлээн авч, гүйлгээний шимтгэл төлүүлэхээс эхлэн гүйлгээний үлдэгдлийг шалган баталгаажуулах хүртэлх бүхий л үе шатанд эрсдэлийг удирдан хянах, үнэлэх үүргийг шат дараалалтайгаар гүйцэтгэн ажиллахаар заасан байна.

ХасБанк ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирлын 2017 оны 07 сарын 16-ны өдрийн №А5-963 тоот тушаалын №1 дүгээр хавсралтаар банк хоорондын их дүнтэй гүйлгээ дамжуулах, хүлээн авах үйл ажиллагааны журам, №2 дугаар хавсралтаар банк хоорондын бага дүнтэй гүйлгээ дамжуулах, хүлээн авах үйл ажиллагааны журмыг тус тус баталсан байна. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2021 оны 05 сарын 25-ны өдрийн №А-128 дугаар тушаалаар батлагдсан Автомат клирингийн хаус системийн дүрэм шинэчлэн батлагдсан бөгөөд банк хоорондын их дүнтэй гүйлгээ дамжуулах, хүлээн авах үйл ажиллагааны журмаар ХасБанк ХХК болон бусад банк хооронд хийгдэх 5,000,000 (таван сая) төгрөгөөс дээш дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог, банк хоорондын бага дүнтэй гүйлгээ дамжуулах, хүлээн авах үйл ажиллагааны журмаар 5,000,000 (таван сая) төгрөг, түүнээс бага үнийн дүнтэй гүйлгээний төлбөр тооцоог Монголбанкны санхүүгийн дундын сүлжээг ашиглан илгээх, дамжуулах, хүлээн авах үйл ажиллагааг зохицуулахаар тус тус заасан байна.

Үнэт цаас гаргагчаас ируулсэн төлбөр тооцооны (мөнгөн хөрөнгийн шилжүүлэг) үйлчилгээнд хамаарах дүрэм, журмууд Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан холбогдох журамд нийцсэн байна.

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2004 оны 09 сарын 27-ны өдрийн №589 тоот тушаалаар Батлан даалт гаргах журмыг батлан мөрдүүлсэн байна. Энэхүү журмаар Банк нь өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд төлбөр гүйцэтгэхээр батлан даалт гаргах үйл ажиллагаатай холбогдон үүсэх харилцааг зохицуулсан байна. Журмын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт батлан даалт нь (i) эх үүсвэртэй (банкин дахь харилцах данс болон хадгаламжийн дансанд тодорхой хугацаагаар байршуулсан эх үүсвэрт үндэслэн гаргаж байгаа бол); болон (ii) эх үүсвэргүй гэсэн ангилалтай байхаар заасан байна. Түүнчлэн Банк нь үнэт зүйлстэй холбоотойгоор хууль бус үйл ажиллагаа, байгаль орчинд хор нөлөөтэй бизнес, төрөөс тогтоосон үйл ажиллагааны стандартыг хангаагүй бизнест батлан даалт гаргахгүй байхаар зохицуулсан. Батлан даалтын үйл ажиллагааны хяналт шалгалтыг Банкны Дотоод аудитын албанаас хийж гүйцэтгэн, төлөөлөн удирдах зөвлөлд жил бүр тайлагнаж байхаар журамласан нь Банкны тухай хууль, холбогдох бусад хууль, тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна.

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2009 оны 04 сарын 21-ний өдрийн №А-323 тоот тушаалаар Үнэт зүйл хадгалах үйлчилгээний журмыг баталсан байна. Энэхүү журмаар Банкнаас иргэн, хуулийн этгээдийн үнэл зүйлийг Банкны тусгай зориулалтын өрөөнд байрлуулсан үнэт зүйл хадгалах хайрцаг эзэмшүүлэх, хайрцаг тус бүрд Үнэт зүйл хадгалах үйлчилгээ үзүүлэх гэрээ байгуулан хадгалахаар зохицуулсан байна. Журмын хэрэгжилтэд Банкны Дотоод аудитын газар хяналт тавьж ажиллахаар зохицуулсан байна.

Нэгтгэн дүгнэж үзвэл Банкны тусгай зөвшөөрөлтэйгөөр эрхлэх үйл ажиллагааны буюу мөнгөн хадгаламж, гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах, үнэт зүйл хадгалах, хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх, гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа, өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах, үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах, зээл болон санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах, санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа, даатгалын зуучлагчийн үйл

СЗХ
2023 .05 .12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ажиллагаанд хамаарах дүрэм, журмууд нь Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн байна.

(iv) Санхүү, нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журам

Банкнаас Хуулийн фирмд ирүүлсэн санхүү нягтлан бодох бүртгэлд хамаарах дүрэм, журмууд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Татварын ерөнхий хууль, Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай хууль, Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль, Нийгмийн даатгалын тухай хууль, Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн байна.

(v) Хөрөнгийн удирдлага ба худалдан авалтад хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн хөрөнгийн удирдлага ба худалдан авалтад хамаарах дүрэм, журмаас онцгойлон дурдвал Бэлэн мөнгөний нөөцийн дээд хэмжээг тогтоох мөрдүүлэх хянах журмыг ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2018 оны 08 сарын 08-ны өдрийн №А-1054 тоот тушаалаар баталсан байна. Энэхүү журмаар ХасБанк ХХК-ийн мөнгөн хөрөнгийн урсгалыг төлөвлөх, хөдөлгөөнийг удирдах, салбар, тооцооны төвийн касс дахь бэлэн мөнгөний нөөцийн дээд хэмжээг тогтоох, мөрдүүлэх, түүнд хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Журмын 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт салбар, тооцооны төв нь бэлэн мөнгөний нөөцийг хангах зорилгоор бусдаас татан төвлөрүүлсэн хөрөнгийн тодорхой хэсэгт тэнцэх мөнгөн хөрөнгийг өөрийн касст төвлөрүүлэх ба энэхүү бэлэн мөнгөний нөөцийн дээд хэмжээг хагас жил тутамд Хөрөнгө зохицуулах газрын саналыг үндэслэн Гүйцэтгэх захирлын тушаалаар шинэчлэн тогтоохоор заасан байна. Харин салбар, тооцооны төвийн бэлэн мөнгөний нөөцийн өдөр тутмын хяналтыг Хөрөнгө зохицуулах газар хэрэгжүүлж, хяналт тавих үүрэгтэйгээр журамласан байна.

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2022 оны 08 сарын 30-ны өдрийн №А-925 тоот тушаалаар Худалдан авалтын ерөнхий журмыг баталсан байна. Энэхүү журмаар Банкны бизнесийн үйл ажиллагаанд ашиглагдах бараа, материал, тоног төхөөрөмжийн худалдан авалт, үндсэн хөрөнгийн сайжруулалт, засварын ажил, техникийн болон мэргэжлийн үйлчилгээ авах ажиллагааг зохион байгуулах, оролцогч нэгжүүд тэдгээрийн чиг үүрэг, худалдан авах ажиллагаанд мөрдөх эдийн засгийн үр ашигтай, ил тод, байгаль орчинд ээлтэй байх зэрэг үндсэн зарчмыг тодорхойлох, ажиллагааны хэрэгжилт, гүйцэтгэлийг тооцож, тайлагнахтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Журмын 4 дүгээр зүйлийн 4.5 дахь хэсэгт зааснаар худалдан авах бараа, ажил, худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төсөв, шинж чанар, нөхцөлөөс хамаарч худалдан авалтын аргууд нь (i) харьцуулсан судалгааны; (ii) сонгон шалгаруулалтын; (iii) тусгай горимын; (iv) нэг удаагийн шинжтэй, дахин давтагдахгүй, 10 (арван) сая хүртэлх төгрөгийн бараа, материал авах гэсэн худалдан авалтын аргуудыг ашиглахаар заасан байна. Түүнчлэн худалдан авалтын үйл ажиллагааны хэрэгжүүлэгч нэгж, дотоод хяналтын тогтолцооны зохион байгуулалтыг тодорхойлохдоо (i) Хамгаалалтын нэгдүгээр бүс (Худалдан авалт хариуцсан нэгж, Санхүү бүртгэл хариуцсан нэгж, Салбар, тооцооны төвийн нягтлан бодогч); (ii) Хамгаалалтын хоёрдугаар бүс (Санхүү удирдлага, хариуцсан нэгж); (iii) Хамгаалалтын гуравдугаар бүс (Дотоод аудитын газар) гэсэн дараалаар худалдан авалтын нэгдсэн төлөвлөгөө боловсруулах, уг төлөвлөгөөний дагуу худалдан авах үйл ажиллагаа эхлэн захиалсан барааг хүлээн авах хүртэлх бүхий л үе шатанд эрсдэлийг удирдан хянах, Банкны хэмжээнд төсвийн үйл ажиллагаа үр ашигтай, хэвийн явагдаж байгаа эсэхэд дүгнэлт өгөх үүргийг шат дараалалтайгаар гүйцэтгэн ажиллахаар журамлажээ. Худалдан авалтын аргаас хамаарч ХасБанк ХХК-ийн Үйл ажиллагаа хариуцсан захирлын 2017 оны 07 сарын 16-ны өдрийн №А5-966 тушаалаар батлагдсан Тусгай нөхцөлөөр худалдан авалтын үйл ажиллагааны журам, Сонгон шалгаруулалтын үйл ажиллагааны журам, Шууд худалдан авалтын

СЭХ 2023 05 12
БҮРТГЭВ № 01

авалтын үйл ажиллагааны журам, Үнийн харьцуулсан судалгааны аргаар зохион байгуулах худалдан авалтын үйл ажиллагааны журмыг тус тус батлан мөрдүүлсэн нь Иргэний хууль болон Банкны тухай хуульд нийцсэн байна.

(vi) Эрсдэлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Банкны эрсдэлийн удирдлага болон мэдээллийн аюулгүй байдалд хамаарах дүрэм, журмаас онцгойлон дурдвал ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2015 оны 11 сарын 04-ний өдрийн №А-1224 тоот тушаалаар Шүгэл үлээх бодлогыг баталсан байна. Энэхүү бодлогоор Банкны нэр төр, бүтээгдэхүүн үйлчилгээ, өмч хөрөнгө, үйл ажиллагаа, Банкны ажилтантай холбоотойгоор хууль тогтоомж, Банкны дотоод дүрэм, журам, Ёс зүйн дүрэм ба Сонирхлын зөрчлийн журам, ёс зүйн хэм хэмжээ зэргийг зөрчсөн аливаа үйлдлийн талаар Банкны ажилтан болон хөдөлмөрийн гэрээнээс бусад төрлийн гэрээгээр ажиллаж байгаа ажилчид мэдээлэх буюу “шүгэл үлээх”, мэдээллийг хүлээн авах, шийдвэрлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулахаар заасан байна. Түүнчлэн мэдээлэл өгсөн ажилтны нууцыг чандлан хадгалж, хамгаалах, мэдээлэлд дурдсан асуудал нь гэмт хэргийн шинжтэй бол хууль хяналтын байгууллагад хандах, хувийн ашиг сонирхол, өш хонзонд хөтлөгдөн хуурамч мэдээлэл гаргасан ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах, мэдээлэл болон мэдээлэл өгсөн ажилтны нууцыг задруулсан ажилтанд сахилгын шийтгэл ногдуулах зэрэг онцлог зохицуулалтуудыг журамласан байна. Эдгээр харилцааг зохицуулсан уг журам нь банкны асуудлыг тогтоох, түүнийг ямар нэг болгоомжлол, айж эмээх зүйлгүйгээр мэдээлэх, цаг хугацаанд нь шийдвэрлэх зэрэг хүний нөөцийн бодлогын ач холбогдолтой байх тул Хөдөлмөрийн тухай хуульд нийцсэн байна.

(vii) Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэхэд хамаарах дүрэм, журам

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн хүрээнд ХасБанк ХХК-аас Гүйцэтгэх захирлын 2022 оны 09 сарын 09-ний өдрийн №А-985 тоот тушаалаар ХасБанк ХХК-ийн Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журмыг баталсан байна. Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.1 дэх заалтад[34] зааснаар Банк нь 20,000,000 (хорин сая) төгрөг, түүнээс дээш үнийн дүнтэй бэлэн мөнгөний болон гадаад төлбөр тооцооны гүйлгээний тухай мэдээллийг мэдээлэх үүрэгтэй. Үүний хүрээнд Үнэт цаас гаргагчаас баталсан дүрэм, журмууд нь Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2019 оны 01 сарын 21-ний өдрийн №А-26 тоот тушаалаар батлагдсан Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам, 2022 оны 12 сарын 01-ний өдрийн №А-335 тоот тушаалаар батлагдсан Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд газар дээрх хяналт шалгалт хийх журам болон Банкны мөнгө угаах, терроризмыг болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх үйл ажиллагаанд зайнаас хяналт тавих журамд тус тус нийцэж байна.

(viii) Харилцагчийн үйлчилгээнд хамаарах дүрэм, журам

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Банкны харилцагчийн үйлчилгээнд хамаарах дүрэм, журмаас онцгойлон авч үзвэл ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2017 оны 09 сарын 28-ны өдрийн №А-1375 тоот тушаалаар Харилцагчийг хамгаалах ерөнхий журмыг баталсан байна. Энэхүү журам нь бизнесийн ёс зүй, Банкны хариуцлагатай үйл ажиллагаанд харилцагчийг хамгаалах зарчмуудыг баримтлахад чиглэх бөгөөд банк нь (i) Бүтээгдэхүүн үйлчилгээг зохистойгоор хөгжүүлэх, хүргэх; (ii) Хэт их хэмжээний өр зээлээс урьдчилан сэргийлэх; (iii) Ил тод

[34] Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013).
4 дүгээр зүйл.Мэдээлэх үүрэгтэй этгээд
4.1. Дараах этгээд энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан гүйлгээний талаар энэ хуулийн 16.1-д заасан Санхүүгийн мэдээллийн албанд мэдээлэх үүрэгтэй:
4.1.1. банк.

426

байдал; (iv) Хариуцлагатай үнэ тогтоох; (v) Харилцагчтай шударга, хүндэтгэлтэй харилцах; (vi) Харилцагчийн мэдээллийн нууцлал; (vii) Гомдол шийдвэрлэх тогтолцоо гэх зарчмуудыг харилцагчид үйлчлэхдээ баримтлан ажиллахаар заасан байна. Мөн түүнчлэн харилцагчийг хамгаалах үйл ажиллагааны хэрэгжүүлэгч нэгжүүдийг (i) Хамгаалалтын 1 дүгээр бүс (бизнесийн нэгжүүд); (ii) Хамгаалалтын 2 дугаар бүс (эрсдэл хариуцсан захирал); (iii) Хамгаалалтын 3 дугаар бүс (дотоод аудитын газар)-ийг тус тус тодорхойлсон байна.

(ix) <u>Эрх зүйн баримт бичиг боловсруулалтад хамаарах дүрэм, журам</u>

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Банкны эрхзүйн баримт бичиг боловсруулалтад хамаарах дүрэм, журмаас Гэрээний төсөл боловсруулах, бүртгэл хөтлөх, гүйцэтгэлд хяналт тавих журмыг онцгойлон авч үзлээ. Энэхүү журам нь ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2005 оны 12 сарын 26-ны өдрийн №А-1018 тоот тушаалаар батлагдсан бөгөөд Банкны төв алба болон салбар тооцооны төвийн ажилчид нь бусад хуулийн этгээд, иргэнтэй байгуулах гэрээний төсөл боловсруулахад тавигдах шаардлага, гэрээнд зайлшгүй тусгах зүйлс, гэрээний төслийг хянах, гадны байгууллага иргэдээс ирүүлсэн гэрээний төсөлд санал өгөх, гэрээ байгуулах, бүртгэл хөтлөх гүйцэтгэлд нь хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулсан байна. Уг журмын 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт зааснаар гэрээний төсөл боловсруулагч нь төслөө боловсруулж дуусмагц холбогдох албан тушаалтнаас санал авч, ирүүлсэн саналыг Банкны Хуулийн хэлтэс өгч хянуулсны үндсэн дээр гэрээний нөгөө талын саналыг тусгадаг байна. Ийнхүү гэрээний харилцан тохиролцсон нөхцөл бүхий гэрээнд Банкийг төлөөлж Гүйцэтгэх захирал, эсхүл түүнээс эрх олгогдсон албан тушаалтан гарын үсэг зурахаар зохицуулсан байна. Уг журмаар заасан гэрээний бүрдэл, гэрээ байгуулах үе шат, хяналтын процесс, гэрээ байгуулагдсаны дараагаар гэрээг дугаарлах бүртгэх, хадгалах үйл ажиллагаа нь Иргэний хууль, болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна.

<u>Бусад дүрэм, журам</u>

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн бусад дүрэм, журам нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, дүрэм, журамд нийцсэн байна.

<u>ХасБанк ХК-ийн Дүрмийн төсөл</u>

Үнэт цаас гаргагч нь нээлттэй хувьцаат компани болохтой холбогдуулан “ХасБанк нээлттэй хувьцаат компанийн дүрэм”-ийн төслийг Хуулийн фирмд ирүүлсэн. Энэхүү дүрмээр Банкны удирдлагын бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагаа, эрх, үүрэг, хариуцлага, хяналт, Банкны бүтцийн өөрчлөлттэй холбогдсон харилцааг зохицуулсан байна.

Тус дүрмийн төслөөс үзвэл Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэгт заасан компанийн дүрэмд заавал тусгах зүйл буюу (i) Банкны оноосон нэр, түүний хэлбэрийг тодорхойлсон товчилсон ялгах тэмдэглэгээ; (ii) Банкны гаргасан хувьцааны тоо, тэдгээрийн төрөл, нэрлэсэн үнэ; (iii) Банкны хувьцаа эзэмшигчдийн хурал; (iv) төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн тоо; болон (v) Банкны үйл ажиллагааны чиглэл болон Банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1 дэх хэсэгт заасан (i) Банкны хувь нийлүүлсэн хөрөнгө; (ii) Банкны удирдлага, зохион байгуулалтын бүтэц; болон (iii) төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журам зэргийг бүрэн тусгасан байна.

Тухайлан дурдвал дүрмийн төслийн 6 дугаар зүйлийн 6.11 дэх хэсэгт Банкны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт[35] заасныг хангах үүднээс Банк анх удаа хувьцаагаа олон нийтэд санал болгосны дараа Банк болон ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь нэгтгэх ажиллагааг нэн даруй эхлүүлэх бөгөөд ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцаа эзэмшигчид нь ХасБанк ХК-ийн

[35] Банкны тухай хууль (2010).
36 дугаар зүйл.Банкны хувьцааг эзэмших зөвшөөрөл олгох
36.1.Аливаа этгээд дангаараа болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байна.

СЭХ 2023 оны 05 сарын 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05

хувьцаа эзэмшигч болно гэж тусгасан байна. Түүнчлэн дүрмийн төслийн 6 дугаар зүйлийн 6.12 дахь хэсэгт заасны дагуу энд дурдсан нэгтгэх ажиллагааг Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 5 дугаар зүйлд[36] заасны дагуу 2023 оны 12 сарын 31-ний өдрийн дотор багтаан өөрчлөн байгуулахаар тусгасан байна.

Дүрмийн төслийн 8 дугаар зүйлийн 8.13 дахь хэсэг болон 8.14 дэх хэсэгт Банкны Төлөөлөн удирдах зөвлөл нь 9-12 гишүүнтэй байх бөгөөд нийт гишүүний 1/3 (гуравны нэг)-ээс доошгүй нь хараат бус гишүүн байх, Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүн болон хараат бус гишүүн нь тус тус Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд заасан шаардлагыг хангасан байхаар заасан. Мөн дүрмийн төслийн 8 дугаар зүйлийн 8.29 дэх хэсэгт Төлөөлөн удирдах зөвлөл нь (i) Аудит; (ii) Эрсдэлийн удирдлага; болон (iii) Засаглал, нэр дэвшүүлэх, нөхөн олговрын хороо болон шаардлагатай гэж үзсэн болон холбогдох хуульд заасан бусад хороодтой байхаар заасан байна.

Иймд ХасБанк ХК-ийн дүрмийн төсөл нь Компанийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2 дахь хэсэг болон Банкны тухай хуулийн 21 дүгээр зүйлд заасан тусгавал зохих зүйлийг тусгасан, агуулгын хувьд Компанийн тухай хууль, Банкны тухай хууль болон Монголбанкны Ерөнхийлөгчийн 2022 оны 05 сарын 09-ний өдрийн №А-143 тоот тушаалаар батлагдсан Банкны зохистой засаглалын зарчмын хэрэгжилтийн хяналт, шалгалтын журамд нийцсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

<u>Ногдол ашгийн бодлогын төсөл</u>

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн ХасБанк ХХК-ийн Ногдол ашгийн бодлогын төсөлтэй танилцахад тус бодлогын 3 дугаар зүйлийн 3.2 дахь хэсэгт заасны дагуу ногдол ашиг хуваарилах эсэх шийдвэрийг санхүүгийн жил дууссанаас хойш 50 (тавин) хоногийн дотор Банкны Төлөөлөн удирдах зөвлөлөөр хэлэлцэн шийдвэрлэхээр заасан байна. Энэ нь Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.5 дахь хэсэгт[37] нийцсэн байна.

Ногдол ашгийн бодлогын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Ногдол ашгийн хуваарилалтын тайланг Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14 дэх хэсэгт заасны дагуу ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш 15 (арван таван) өдрийн дотор Санхүүгийн зохицуулах хороонд хүргүүлэхээр заасан байна. Энэ талаар Компанийн тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.14 дэх хэсэгт заасан хувьцаат компани нь ногдол ашиг хуваарилалтын тайланг ногдол ашиг хуваарилж дууссан өдрөөс хойш ажлын 15 (арван таван) өдрийн дотор гаргаж, Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоосон хугацаанд уг хороо болон үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад хүргүүлнэ гэж заасантай нийцэж байна гэж үзлээ. Түүнчлэн Ногдол ашгийн бодлогын 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт Банкнаас ногдол ашгийг хугацаанд нь хуваарилаагүй бол хугацаа хэтэрсэн хоног тутамд гүйцэтгээгүй үүргийн 0.1%-ийн алданги төлөх бөгөөд энэ нь гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнгийн 50%-аас хэтрэхгүй байхаар тусгасан нь холбогдох хуульд нийцэж байна гэж үзлээ.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн Ногдол ашгийн бодлогын төсөл нь Компанийн тухай хууль болон Банкны тухай хууль, зохицуулагч байгууллагаас гаргасан дүрэм, журамд тус тус нийцэж байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Нэгтгэн дүгнэвэл Банкны дотоод үйл ажиллагаандаа мөрдөж байгаа 268 (хоёр зуун жаран найман) дүрэм, журам болон Дүрмийн төсөл нь Иргэний хууль, Компанийн тухай хууль, Банкны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Зээлийн мэдээллийн тухай хууль, Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хууль, Валютын зохицуулалтын тухай**

[36] Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хууль (2021).
5 дугаар зүйл.Энэ хууль хүчин төгөлдөр болохоос өмнө байгуулагдсан банк Банкны тухай хуулийн 36.1-д заасан шаардлагыг 2023 оны 12 сарын 31-ний өдрийн дотор хангасан байна.
[37] Компанийн тухай хууль (2011).
46 дугаар зүйл.Ногдол ашиг хуваарилах
46.5.Төлөөлөн удирдах зөвлөл нь санхүүгийн жил дууссанаас хойш 50 хоногийн дотор ногдол ашиг хуваарилах эсэх талаар хэлэлцэн шийдвэрлэсэн байна.

428

СЗХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ № 01
2023-05-05

хууль, Үндэсний төлбөрийн системийн тухай хууль, Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаалаар батлагдсан Банкны хэмжээнд дагаж мөрдвөл зохих дүрэм, журамд тус тус нийцсэн, эрх бүхий этгээдээс баталж мөрдүүлсэн байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

**Дөрөв. Бусадтай байгуулсан худалдах болон худалдан авах, бэлтгэн нийлүүлэх, зээлийн гэрээ болон үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ нь холбогдох хууль тогтоомжид нийцсэн эсэх, компанийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлөх үр дагавар байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдөр (цаашид "**Гэрээг тасалбар болгосон өдөр**" гэх)-өөр тасалбар болгон Банкны бусадтай бичгээр байгуулсан гэрээний жагсаалтыг гаргуулан авч жагсаалтаас өөрсдийн тогтоосон загварчлалын дагуу санамсаргүй түүврийн аргаар сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Өөрөөр хэлбэл гэрээний жагсаалтаас эхнээсээ хоёр дахь гэрээ болон жагсаалтын дундах гэрээг сонгон он тус бүрээс авч үзсэн болно. Ингэхдээ мөнгөн хадгаламжийн гэрээ болон харилцах дансны гэрээний жагсаалттай танилцсан ба тухайн төрлийн гэрээний батлагдсан эх хувь болон түүний хувийн хэрэгтэй танилцаагүй болно. Учир нь Банкнаас баталсан мөнгөн хадгаламжийн болон харилцах дансны гэрээний загварын дагуу Банкны салбар, тооцооны төвүүдэд нэг ижил төрлийн гэрээг олон давтамжтайгаар байгуулдаг тул тухайн батлагдсан гэрээний төсөлтэй танилцсан болно. "Хадгаламжийн гэрээ" хэсгээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Банкнаас ирүүлсэн баримт материалаас үзвэл дурдсан хугацаанд нийт 1,085,974 (нэг сая наян таван мянга есөн зуун далан дөрвөн) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

***Хүснэгт №10. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор бусадтай бичгээр байгуулсан нийт хүчин төгөлдөр гэрээний тоон үзүүлэлт.***

| № | Гэрээ, хэлцлийн мэдээлэл | 2020.01.01 – 2021.01.01 | 2021.01.01 – 2022.01.01 | 2022.01.01 – 2023.01.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Хүчин төгөлдөр гэрээ | 82,019 | 198,130 | 805,825 | 1,085,974 |
| | НИЙТ | | | | 1,085,974 |

Түүнчлэн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрөөс өмнө буюу 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 482,855 (дөрвөн зуун наян хоёр мянга найман зуун тавин таван) гэрээ байна. Иймд гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 1,568,829 (нэг сая таван зуун жаран найман мянга найман зуун хорин есөн) гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байгааг дурдаж байна. Үүнд:

***Хүснэгт №11. Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж буй гэрээний төрлийн тоон үзүүлэлт.***

| № | Гэрээний нэр, төрөл | 2020.01.01-ний өдрөөс өмнө | 2020.01.01 – 2021.01.01 | 2021.01.01 – 2022.01.01 | 2022.01.01 – 2023.01.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Мөнгөн хадгаламжийн гэрээ | - | - | - | - | - |
| 2. | Харилцах дансны гэрээ | 478,348 | 52,465 | 57,036 | 88,852 | 676,701 |
| 3. | Зээлийн гэрээ | 4,399 | 29,479 | 140,868 | 716,602 | 891,348 |
| 4. | Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ | 11 | 2 | 4 | 11 | 28 |
| 5. | Сонирхлын зөрчилтэй хэлцэл | 7 | 6 | 4 | 5 | 22 |
| 6. | Бусад гэрээ | 90 | 67 | 218 | 355 | 730 |
| | НИЙТ | 482,855 | 82,019 | 198,130 | 805,825 | 1,568,829 |

429

Нууц баримт
Эх хувь

Хуулийн фирм нь ХасБанк ХХК-аас Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэж ирүүлсэн зээлийн гэрээний жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар гэрээнүүдийг сонгон авч гэрээний хүчин төгөлдөр байдал буюу хуульд заасан агуулга болон хэлбэрийн шаардлага хангасан эсэхэд дүгнэлт өгөхдөө гэрээ байгуулах журам, гэрээний зүйл, гэрээгээр зохицуулж байгаа харилцаанд үндэслэн дараах шалгуурыг удирдлага болголоо. Үүнд:

(i) Банк үндсэн үйл ажиллагааг эрхлэн явуулахад шаардагдах мөнгөн хадгаламжийн гэрээ нь Банкны тухай болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн хоёрдугаар бүлгийн 10-16 дугаар зүйл[38], Иргэний хууль (цаашид "ИХ" гэх)-ийн 454-455 дугаар зүйлд[39] заасан нөхцөл болон мөнгөн хадгаламжийн гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;

(ii) Зээлийн гэрээний хувьд Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн дөрөвдүгээр бүлгийн 19-27 дугаар зүйл[40], ИХ-ийн 281-283 дугаар зүйл[41], 451-453 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон

---

[38] **Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).**
10 дугаар зүйл.**Мөнгөн хадгаламж**
11 дүгээр зүйл.**Мөнгөн хадгаламжийн гэрээ**
12 дугаар зүйл.**Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа**
13 дугаар зүйл.**Мөнгөн хадгаламжийн хүү**
14 дүгээр зүйл.**Хадгалуулагч, хадгалагчийн эрх, үүрэг**
15 дугаар зүйл.**Мөнгөн хадгаламжийн данс**
16 дугаар зүйл.**Мөнгөн хадгаламжид холбогдох гүйлгээний талаарх зохицуулалт.**

[39] **Иргэний хууль (2002).**
454 дүгээр зүйл.**Мөнгөн хадгаламжийн гэрээ**
454.1.Мөнгөн хадгаламжийн гэрээгээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нь хадгалуулагчийн мөнгийг хадгалах, хадгалуулсан мөнгийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг хүлээнэ.
454.2.Мөнгөн хадгаламжийн гэрээнд хадгалалтын хугацаа, хүүгийн хэмжээ, түүнийг тооцох журам, гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүйгээс талуудын хүлээх хариуцлагыг тусгана.
454.3.Хуульд өөрөөр заагаагүй бол мөнгөн хадгаламжийн гэрээг хадгаламжийн дэвтэр, хадгаламжийн сертификат болон хуульд заасан бусад арга хэрэгслийг ашиглан бичгээр байгуулна.
454.4.Хадгалуулагч хэдийд ч гэрээг цуцалж, хадгалуулсан мөнгөө хүүгийн хамт буцаан авах эрхтэй.
454.5.Хуульд өөрөөр заагаагүй бол банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд хадгалуулагчийн мөнгөн хадгаламжийн нууцыг хадгалах, холбогдох гүйлгээний талаархи мэдээллийг задруулахгүй байх үүрэгтэй.
454.6.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мөнгөн хадгаламжийг даатгуулж болно.
454.7.Банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааг хуулиар зохицуулна.
454.8. Мөнгөн хадгаламжийн гэрээгээр хадгалуулсан мөнгөө шаардахад хөөн хэлэлцэх хугацаа хамаарахгүй.
455 дугаар зүйл.**Мөнгөн хадгаламжийн гэрээний хугацаа**
455.1.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой буюу тодорхой бус хугацаагаар байгуулна.
455.2.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол хадгалагч нь хадгалуулагчийн хүссэн цагт түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүүг төлөх үүрэгтэй.
455.3.Мөнгөн хадгаламжийн гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол банк уг хугацаа дуусханы дараа хадгалуулагчийн анхны шаардлагаар хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх бөгөөд гэрээнд заасан хугацаа дууссан боловч хадгалуулагч мөнгөө буцаан авах шаардлага тавиагүй бол уг гэрээг цаашид тодорхой бус хугацаагаар сунгасанд тооцно.
455.4.Тодорхой хугацаагаар байгуулсан гэрээг банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий этгээд нэг талын санаачилгаар өөрчлөх, хугацаанаас нь өмнө цуцлах эрхгүй.

[40] **Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).**
19 дүгээр зүйл.**Банк, эрх бүхий хуулийн этгээдийн зээлийн үйл ажиллагаа**
20 дугаар зүйл.**Зээлийн гэрээ**
21 дүгээр зүйл.**Зээлийн хүү**
22 дугаар зүйл.**Зээлийн хувийн хэрэг**
23 дугаар зүйл.**Зээлийн батлан даалт**
24 дүгээр зүйл.**Зээлийн барьцаа**
25 дугаар зүйл.**Зээлийг хугацаанаас нь өмнө буцаан төлөх**
26 дугаар зүйл.**Зээл төлүүлэх**
27 дугаар зүйл.**Зээлийг ангилах**

[41] **Иргэний хууль (2002).**
281 дүгээр зүйл.**Зээлийн гэрээ**
281.1.Зээлийн гэрээгээр зээлдүүлэгч нь зээлдэгчийн өмчлөлд мөнгө буюу төрлийн шинжээр тодорхойлогдох бусад эд хөрөнгө шилжүүлэх, зээлдэгч нь шилжүүлэн авсан эд хөрөнгөтэй ижил төрөл, тоо, чанар, хэмжээний эд хөрөнгө буюу мөнгийг тохирсон хугацаанд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.
282 дугаар зүйл.**Зээлийн гэрээний хүү**

430

СЭХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуульд заасан зээлийн гэрээ болон зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан барьцааны гэрээний гол нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, барьцааг холбогдох эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, зээл олгох шийдвэр Банкны дотоод дүрэм, журамд заасны дагуу гарсан эсэх, холбогдох хууль тогтоомжид заасан хэлбэрийн шаардлага хангасан эсэх;

(iii) Гадаад улсын хууль тогтоомжийг удирдлага болгохоор заасан гэрээний хүчин төгөлдөр байдалд дүгнэлт өгөөгүй бөгөөд Банк нь хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болохын өмнө гэрээний нөгөө талд заавал мэдэгдэх эсэх, зөвшөөрөл авах эсэх;

(iv) Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээний хувьд ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.1 дэх хэсэгт[42] заасан түрээсийн гэрээний гол нөхцөл болон Үл хөдлөх эд хөрөнгө түрээслэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлсэн эсэх (үл хөдлөх эд хөрөнгийн хэсэгчлэн түрээслэх гэрээнд энэхүү шаардлага хамаарахгүй);

(v) Худалдах, худалдан авах гэрээний хувьд ИХ-ийн 243-261 дүгээр зүйлд заасан нөхцөл болон худалдах, худалдан авах гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;

(vi) Ажил гүйцэтгэх гэрээний хувьд ИХ-ийн хуулийн 343 дугаар зүйлийн 343.1 дэх хэсэгт[43] заасан ажил гүйцэтгэх гэрээний гол нөхцөл болон ажил гүйцэтгэх гэрээнд тусгавал зохих бусад нөхцөлийг гэрээнд тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх;

(vii) Даатгалын гэрээний хувьд ИХ-ийн 431 дүгээр зүйлийн 431.4 дэх хэсэгт[44] заасан нөхцөл болон холбогдох даатгалын хуулиудад заасан нөхцөлийг тусгасан эсэх, агуулга нь хуульд харшилсан эсэх, батлагдсан загварын дагуу бичгээр байгуулсан эсэх (батлагдсан загвараар байгуулах даатгалын гэрээний хувьд), талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга тэмдгээр баталгаажуулсан эсэх.

---

282.1.Зээлийн гэрээгээр талууд хэлэлцэн тохиролцож хүү тогтоож болно.
282.2.Хүүгийн хэмжээ нь зээлдэгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд илт хохиролтойгоор тогтоогдсон бол түүний хүсэлтээр шүүх зээлийн хүүг багасгаж болно.
282.3.Хуульд өөрөөр заагаагүй бол хүү тогтоосон бол зээлийн гэрээг бичгээр хийнэ. Энэ шаардлагыг хангаагүй бол хүү авах эрхээ алдана.
282.4.Мөнгө буюу эд хөрөнгийг зээлдэгчид шилжүүлэн өгснөөр зээлийн гэрээг байгуулсанд тооцно.
283 дугаар зүйл.**Зээлийн гэрээний хугацаа**
283.1,Зээлийн гэрээгээр зээлийг буцааж төлөх хугацаа тогтоогоогүй бол зээлдүүлэгчийн шаардсанаар түүнийг буцааж төлөх бөгөөд ийнхүү шаардсанаас хойш нэг сарын дотор зээлдэгч үүргээ биелүүлнэ.
283.2.Зээлийн гэрээгээр хүү тогтоогоогүй бол зээлдэгч хугацаанаас нь өмнө зээлийг буцаан өгч болно.
283.3.Зээлийн гэрээгээр хүү тогтоосон бол гагцхүү талууд урьдчилан тохирсон буюу зээлдүүлэгч зөвшөөрсөн тохиолдолд зээлийг хүүгийн хамт хугацаанаас өмнө буцаан өгч болно.
283.4.Гэрээнд өөрөөр заагаагүй бол зээлийн хүүг жил тутам төлнө.
[42] **Иргэний хууль (2002).**
318 дугаар зүйл.**Түрээсийн гэрээ**
318.1.Түрээсийн гэрээгээр түрээслүүлэгч нь түрээслэгчийн эзэмшил, ашиглалтад аж ахуйн үйл ажиллагаа явуулах болон дүрэмд заасан зорилгоо биелүүлэхэд нь зориулж тодорхой хөрөнгө шилжүүлэх, түрээслэгч нь гэрээгээр тохирсон түрээсийн төлбөрийг төлөх үүргийг тус тус хүлээнэ.
[43] **Иргэний хууль (2002).**
343 дугаар зүйл.**Ажил гүйцэтгэх гэрээ**
343.1.Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.
[44] **Иргэний хууль (2002).**
431 дүгээр зүйл.**Даатгалын гэрээ**
431.4.Даатгалын гэрээнд дараах нөхцөлийг тусгана:
431.4.1. даатгалын зүйл;
431.4.2. даатгалын эрсдэлийн төрөл;
431.4.3. даатгалын үнэлгээний хэмжээ;
431.4.4. даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;
431.4.5. даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;
431.4.6. даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;
431.4.7. гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.

СЗХ он 2023 сар 05 12 өдөр БҮРТГЭВ № 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

## Нэг. Мөнгөн хадгаламж, харилцах данс, банкны баталгаа, аккредитив нээх гэрээ

Банкнаас бусадтай байгуулсан бүх төрлийн мөнгөн хадгаламжийн гэрээ, харилцах дансны гэрээ, аккредитив нээх гэрээнд дүн шинжилгээ хийхдээ Иргэний хууль, Банкны тухай хууль болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийг баримталлаа. Мөн ХасБанк ХХК-ийн зүгээс хадгаламжийн үйл ажиллагаатай холбоотой баталсан дараах дүрэм, журмыг удирдлага болголоо. Үүнд:

(i) Гүйцэтгэх захирлын 2017 оны №А-1525 тоот тушаалаар баталсан Харилцах, хадгаламжийн бүтээгдэхүүний ерөнхий журам;
(ii) Гүйцэтгэх захирлын 2021 оны №А-481 тоот тушаалаар баталсан Ирээдүйн саятан мөнгөн хадгаламжийн үйл ажиллагааны журам;
(iii) Гүйцэтгэх захирлын 2012 оны №А-646 тоот тушаалаар баталсан Онлайн хадгаламжийн үйл ажиллагааны заавар;
(iv) Гүйцэтгэх захирлын 2012 оны №А-425 тоот тушаалаар баталсан Хадгаламжийн сертификатын журам;
(v) Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирлын 2017 оны №А4-1878 тоот тушаалаар баталсан Харилцагчид данс нээх, дагалдах үйлчилгээнд бүртгэх үйл ажиллагааны журам;
(vi) Гүйцэтгэх захирлын 2006 оны №А-818 тоот тушаалаар баталсан Аккредитивийн журам;
(vii) Гүйцэтгэх захирлын 2004 оны №589 тоот тушаалаар баталсан Батлан даалт гаргах журам;
(viii) Бусад холбогдох дүрэм, журам.

Банкны иргэн болон хуулийн этгээдтэй байгуулсан (i) хугацаатай болон хугацаагүй мөнгөн хадгаламжийн гэрээ; (ii) харилцах дансны гэрээ, аккредитив нээх гэрээ; болон (iii) банкны баталгаа гаргах гэрээ нь холбогдох хууль тогтоомж, Банкны дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүн шинжилгээ хийлээ.

### (i) Мөнгөн хадгаламжийн гэрээ

Хуулийн фирм нь тус Банкинд хадгаламж эзэмшиж буй иргэн, хуулийн этгээдийн хувийн мэдээллийг хамгаалах үүднээс хүчин төгөлдөр үйлчилж байгаа нэг ч мөнгөн хадгаламжийн гэрээний мэдээлэлтэй танилцаагүй бөгөөд ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирлын 2021 оны №А2/640 тоот "Иргэн болон байгууллагатай байгуулах харилцах, хадгаламжийн гэрээний маягтуудыг шинэчлэн батлах тухай" тушаалын хавсралтаар баталсан мөнгөн хадгаламжийн гэрээний загвар төслүүдтэй танилцсан.

Банк нь зөвхөн иргэнтэй "ХасБанкны үйлчилгээ үзүүлэх мастер гэрээ" (цаашид "**Мастер гэрээ**" гэх)-г байгуулдаг ба хадгаламжийн гэрээг тусад нь байгуулж тус Мастер гэрээнд хавсаргадаг байна. Мастер гэрээний дагуу тухайн иргэнд харилцах данс нээх, зээлийн эрх нээх, дагалдах үйлчилгээнд бүртгэх, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, цахим үйлчилгээ үзүүлэх, хугацаатай болон хугацаагүй мөнгөн хадгаламжийн үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох мөн талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлж өгдөг байна.

Банк нь хугацаатай болон хугацаагүй мөнгөн хадгаламжийн гэрээнд өөрийн зарласан хүүг баримтлах талаар тусгасан ба мөнгөн хөрөнгөө хадгалуулж буй иргэн, хуулийн этгээд уг зарласан хүүг хүлээн зөвшөөрсөн байхаар гэрээнд тусгасан байна. Энэ нь Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэг, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсгийн зохицуулалттай тус тус нийцэж байна. Хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээнд Банк нь нийтэд зарласан хадгаламжийн хүү, хүү тооцох аргачлалд хагас жил тутам өөрчлөлт оруулах эрхтэй байхаар заасан байна. Өөрөөр хэлбэл Банк нь хугацаатай мөнгөн хадгаламжийн хүүг жилд 2 удаа өөрийн санаачилгаар өөрчилж болохоор байна. Энэ нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.2 дахь хэсэгт хугацаатай хадгаламжийн хүүгийн хэмжээ нь хадгаламжийн гэрээнд өөрөөр заах болохоор зүйлчилсэн байна.

432

СЭХ
2023 05 12
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

Иргэний хуулийн 454 дүгээр зүйлийн 454.3 дахь хэсэгт заасны дагуу мөнгөн хадгаламжийн гэрээг хуульд өөрөөр заагаагүй бол хадгаламжийн дэвтэр, сертификат зэргийг ашиглан бичгээр байгуулахаар заасан байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.4 дэх хэсэгт мөнгөн хадгаламжийн гэрээг бичгээр байгуулахаас гадна мөн цахим хэлбэрээр байгуулж болохоор тусгасан. Банк нь мөнгөн хадгаламжийн гэрээг бичгээр болон цахим хэлбэрээр байгуулж байгаа нь хуулийн дээрх шаардлагад нийцэхээс гадна Банкны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсгийг хангаж байна гэж дүгнэлээ.

Мөнгөн хадгаламжийн гэрээнд мөнгөн тэмдэгтийн төрөл, жилийн хүүгийн хэмжээ, хүү бодох аргачлал, гэрээний хугацаа, гэрээг хугацаанаас нь өмнө цуцлахад хүүгийн өөрчлөлт болон түүнийг бодох аргачлал зэргийг тусгасан нь Иргэний хуулийн 454 дүгээр зүйлийн 454.2 дахь хэсэг болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт заасан шаардлагыг тус тус хангаж байна. Хадгаламжийн гэрээний дагуу үүссэн мөнгөн хадгаламжийн дансыг харилцах дансны зориулалтаар ашиглахгүй байх тухай гэрээнд заасан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсэгтэй нийцэж байна. Тус хуулийн 12 дугаар зүйлийн 12.7 дахь хэсэгт хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээг Банк нь өөрийн санаачилгаар цуцлах эрхгүй байхаар зохицуулсан ба хугацаатай мөнгөн хадгаламжийн гэрээнд Банкны санаачилгаар цуцалж болох тухай заалт тусгаагүй байна.

Хугацаагүй мөнгөн хадгаламжийн гэрээний хувьд Банкны зүгээс хадгаламжийн хүүг өөрчилсөн тохиолдолд энэ тухай нийтэд мэдээлснээс хойш 30 (гуч) хоногийн дараа гэрээнд заасан хүүгийн хэмжээ өөрчлөгдсөнд тооцохоор зохицуулалт оруулсан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.3 дахь хэсэгтэй нийцсэн байна.

Мастер гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад Банк нь тухайн иргэний харилцах болон мөнгөн хадгаламжийн данс дахь мөнгөн хөрөнгийг хураамж төлж даатгуулах үүрэг хүлээсэн нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн шаардлагыг хангаж байна.

**(ii) Харилцах дансаар дамжуулан шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэх гэрээ, аккредитив нээх гэрээ**

Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Банк нь нийт 168,458 (нэг зуун жаран найман мянга дөрвөн зуун тавин найман) ширхэг харилцах дансны гэрээг иргэн, хуулийн этгээдтэй байгуулсан байна. Хуулийн фирмийн зүгээс хувь хүн, хуулийн этгээдтэй байгуулсан харилцах дансны гэрээ болон түүний хувийн хэрэг нэг бүрийг үзэж танилцаагүй. Учир нь харилцах дансны гэрээг Банкнаас баталсан гэрээний загварын дагуу ижил нөхцөл журмаар байгуулдаг тул Харилцах дансаар дамжуулан шилжүүлгийн үйлчилгээ үзүүлэх гэрээний батлагдсан загвартай танилцсан болно. Хувь хүн болон хуулийн этгээдтэй байгуулах харилцагчид үйлчилгээ үзүүлэх Мастер гэрээ болон харилцах дансны гэрээний загварыг хамгийн сүүлд ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны №А4-805 тоот тушаал, 2021 оны №А2-640 тоот “Иргэн болон байгууллагатай байгуулах харилцах, хадгаламжийн гэрээний маягтуудыг шинэчлэн батлах тухай” тушаалын хавсралтаар тус тус шинэчлэн баталсан байна.

Банк зөвхөн иргэнтэй “ХасБанкны үйлчилгээ үзүүлэх мастер гэрээ”-г байгуулдаг ба харилцах дансны гэрээг тусад нь байгуулж тус мастер гэрээнд хавсаргадаг байна. Мастер гэрээний дагуу тухайн иргэнд харилцах данс нээх, зээлийн эрх нээх, дагалдах үйлчилгээнд бүртгэх, төлбөр тооцооны үйлчилгээ үзүүлэх, цахим үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний хураамж, шимтгэлийн хэмжээг тогтоох мөн талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлж өгдөг байна. Тухайн иргэнд харилцах данс нээхдээ Банк нь Гүйцэтгэх захирлын 2017 оны №А4-1878 тоот тушаалаар баталсан

ХАСБАНК

KHAN INVESTMENT BANK LLC
УЛААНБААТАР ХОТ

СЭХ
он 2023 сар 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05
БҮРТГЭВ-02

"Харилцагчид данс нээх, дагалдах үйлчилгээнд бүртгэх үйл ажиллагааны журам"-ыг удирдлага болгож ажиллахаар зохицуулалт хийсэн байна.

ХасБанк ХХК-ийн үйлчилгээ үзүүлэх мастер гэрээний 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалтад Банк нь харилцагчийн хүсэлтийг үндэслэн түүний харилцах данснаас гүйлгээ хийхээр зохицуулсан байна. Ингэхдээ тухайн харилцагч иргэн өөрийн биеэр банкинд хандан хүсэлт гаргах эсхүл цахим хэлбэрээр нууц код ашиглан гүйлгээ хийх хүсэлтээ гаргаж болохоор заасан байна. Мөн Банк нь шаардлагатай тохиолдолд аюулгүй байдлыг хангах үүднээс өндөр дүнтэй гүйлгээг хянах, баталгаажуулах арга хэмжээ авч болохоор байна. Дээрх зохицуулалт нь ИХ-ийн 445 дугаар зүйлийн 445.1, 445.4-6 дахь хэсэг[45] болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1-3 дахь заалтыг[46] тус тус хангаж байна. Үйлчилгээ үзүүлэх мастер гэрээнд Банкны хүлээх үүргийг 4 дүгээр зүйлийн 4.1.1-13 дахь заалтад дэлгэрүүлэн заасан ба энэ нь ИХ-ийн 446 дугаар зүйлийн 446.1.1-7 дахь заалт[47] болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийцэж байна. Харилцах дансаар шилжүүлэг хийхэд Банкны авах шимтгэлийн хэмжээг Үйлчилгээ үзүүлэх мастер гэрээнд хавсралтаар зааж өгсөн байх бөгөөд Банк шимтгэл авч байгаа нь ИХ-ийн 445 дугаар зүйлийн 445.7 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.3 дахь хэсэг болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсгийг зөрчөөгүй байна. Үйлчилгээ үзүүлэх мастер гэрээний 4 дүгээр зүйлийн 4.1.8 дахь заалтад Банк нь тухайн иргэний харилцах болон мөнгөн хадгаламжийн данс дахь мөнгөн хөрөнгийг хураамж төлж даатгуулах үүрэг хүлээсэн нь Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай хуулийн шаардлагыг хангаж байна.

Харилцах дансны гэрээнд дансны мөнгөн тэмдэгтийн төрөл, данс нээсэн мөнгөн дүн, жилийн хүү, хүү бодох аргачлал, данс нээх доод үлдэгдлийн хэмжээ, гэрээ хүчин төгөлдөр болох огноо, данс хаах нөхцөл зэргийг нөхөж оруулах байдлаар гэрээнд тусгасан байна.

ИХ-ийн 445 дугаар зүйлийн 445.3 дахь хэсэгт[48] аккредитивийг бэлэн бусаар хийх төлбөр тооцооны хэрэгслийн нэг гэж тодорхойлсон байна. Аккредитив нээх гэрээнд Банк нь

---

[45] **Иргэний хууль (2002).**
445 дугаар зүйл.**Төлбөр тооцооны гэрээ**
445.1.Төлбөр тооцооны гэрээгээр банк, эрх бүхий бусад хуулийн этгээд /цаашид "төлбөр тооцоо гүйцэтгэгч" гэх/ нь иргэн болон хуулийн этгээд /цаашид "харилцагч" гэх/-ийн бэлэн бусаар хийх төлбөр тооцоог гүйцэтгэх үүрэг хүлээнэ.
445.4.Төлбөр тооцоо гүйцэтгэгч нь харилцагчийн өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гэрээнд заасны дагуу төлбөр тооцоог гүйцэтгэнэ.
445.5.Хуульд өөрөөр заагаагүй бол дансан дахь мөнгөн хөрөнгөө захиран зарцуулах харилцагчийн эрхийг төлбөр тооцоо гүйцэтгэгч хязгаарлах, хянах эрхгүй.
445.6.Банк, эрх бүхий хуулийн этгээд нь харилцагчийн төлбөр тооцооны баримтын бүрдүүлбэрийг шалгах эрхтэй.
[46] **Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль (2021).**
17 дугаар зүйл.**Мөнгөн хөрөнгийн шилжүүлэг хийх**
17.1.Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчтай байгуулсан гэрээ, түүний даалгавар, зөвшөөрлийг үндэслэн шилжүүлгийг хийнэ.
17.2.Банк, эрх бүхий хуулийн этгээд харилцагчийн шилжүүлгийг төлбөрийн даалгаврыг шалгасны үндсэн дээр харилцагчийн мөнгөн хөрөнгийн дүнд багтаан хийнэ.
17.3.Төлбөрийн даалгавар нь бичгийн болон цахим хэлбэртэй байж болно.
[47] **Иргэний хууль (2002).**
446 дугаар зүйл.**Төлбөр тооцоо гүйцэтгэгчийн үүрэг**
s446.1.Төлбөр тооцоо гүйцэтгэгч дараах үүрэгтэй:
446.1.1.бэлэн болон бэлэн бус төлбөр тооцооны нягтлан бодох бүртгэлийг хөтлөх;
446.1.2.гэрээнд заасан хугацаанд харилцагчид түүний дансны талаар мэдээлэл, дансны хуулга өгөх;
446.1.3.харилцагчийн данснаас түүний өгсөн үүрэг буюу зөвшөөрлийн үндсэн дээр гүйлгээ хийх;
446.1.4.хуульд заасннаас бусад тохиолдолд данс, гүйлгээтэй холбоотой нууцыг задруулахгүй байх;
446.1.5.алдаатай хийсэн мөнгөн төлбөрийн гүйлгээг залруулж, харилцагчийг хохиролгүй болгох;
446.1.6.харилцагчийн хэвийн үйл ажиллагааг алдагдуулахгүй байх;
446.1.7.хуульд заасан бусад үүрэг.
[48] **Иргэний хууль (2002).**
445 дугаар зүйл.**Төлбөр тооцооны гэрээ**
445.3.Бэлэн бусаар хийх төлбөр тооцоог төлбөрийн даалгавар, аккредитив, инкасс, чек, вексель, төлбөрийн карт, электрон төлбөр тооцоо, зээлжих эрх, зээлээр хийх төлбөр тооцоо болон төлбөр тооцооны бусад хэрэгслээр гүйцэтгэж болно.

ХАСБАНК

СЗХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

харилцагчийн хүсэлтээр аккредитив нээх, аккредитивийн төлбөр төлөх өдөр харилцах дансанд төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгөнөөс төлөх, харилцагч уг дансандаа мөнгөн хөрөнгө төвлөрүүлээгүй тохиолдолд харилцагчтай байгуулсан Зээлийн эрх нээх гэрээний дагуу зээл олгож, аккредитивийн төлбөр тооцоог гүйцэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна гэж заасан байна. Аккредитив нээх, төлбөрийг шилжүүлэхтэй холбоотой харилцаанд Олон Улсын худалдааны танхимаас 2007 оны 07 сарын 01-ний өдөр шинэчлэн баталсан "Аккредитивийн нэгдсэн журам (Uniform Customs and Practice for Documentary Credits 600)"-ыг мөрдөхөөр тусгасан байна. Энэ тухай ИХ-ийн 449 дүгээр зүйлийн 449.3 дахь хэсэгт "Аккредитивийн төлбөр тооцоог гүйцэтгэхэд олон улсад хэрэглэгддэг нийтлэг зохицуулалт, ажил хэргийн хүрээнд тогтсон заншлыг баримтална" гэж зүйлчилсэн байдаг. Мөн ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2006 оны №А-818 тоот тушаалаар баталсан "Аккредитивийн журам"-ын 1 дүгээр зүйлийн 1.2 дахь хэсэгт "аккредитивийн төлбөр, тооцоог гүйцэтгэхтэй холбоотой, энэхүү журамд заагаагүй бусад асуудлыг Иргэний хууль болон Олон Улсын худалдааны танхимаас гаргасан Аккредитивийн нэгдсэн жураар зохицуулна" гэж заасан байна. Хуулийн фирмийн зүгээс аккредитив нээх гэрээг Иргэний хууль болоод бусад холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд хянасан болно.

Аккредитивийн эрх нээх гэрээ нь төлбөр тооцооны гэрээний нэгэн төрөл болохын хувьд ИХ-ийн 445-449 дүгээр зүйлд заасан хуулийн шаардлагуудыг хангасан байхаас гадна Банк нь аккредитивийн төлбөр гүйцэтгэх өдрийг харилцагчид тухай бүр мэдэгдэж аккредитивийн төлбөрийг төлөх үүрэг хүлээхээр гэрээнд заасан байна. Аккредитивийн эрх нээх гэрээнд талууд гарын үсэг зурж тамга, тэмдэг даран нотариатаар баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно гэж заасан ба талууд үүргээ бүрэн биелүүлж дуусcанаар гэрээг дуусгавар болсонд тооцно гэсэн байна.

**(iii) Баталгаа гаргах гэрээ**

Баталгаа гаргах гэрээнд "Банк харилцагчийн хүсэлтээр баталгаа гаргах, гаргасан баталгааны дагуу төлбөр гүйцэтгэх, баталгааны дагуу үүрэг гүйцэтгүүлэгчид төлсөн төлбөрийг харилцагчаар төлүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулна" гэж заасан нь ИХ-ийн 457 дугаар зүйлийн 457.1 дэх хэсэгтэй[49] агуулгын хувьд нийцэж байна. Банк нь харилцагчийн хүсэлтээр тендерийн, гүйцэтгэлийн, урьдчилгаа төлбөрийн, төлбөрийн, амжилтын гурвалжин гэсэн төрлийн баталгаануудыг гаргадаг байна. Баталгаа гаргах гэрээнд баталгааны хэмжээ, гэрээний хугацаа, зориулалт зэргийг тодорхой заахаас гадна харилцагчийн хүсэлт болоод баталгаа хүлээн авагчийн тавьсан нөхцөлийг харгалзан Баталгааг албан бичиг байдлаар үйлдэхээр заасан байна.

Баталгаа гаргасны шимтгэлийг баталгааны төрлөөс хамааран тодорхой хувиар тооцон гэрээнд заах ба баталгаа гаргасан өдрөөс эхлэн баталгааны хүчинтэй хугацаа дуусах өдөр хүртэл баталгааны үнийн дүнгээс бодон жилийн 365 (гурван зуун жаран таван) хоногт хуваж ашигласан хоногоор бодохоор гэрээнд оруулсан байна. Мөн баталгааны үнийн дүн, шимтгэлийн хувь хэмжээ, бодолт, үйлчилгээний хураамж зэргийг тодорхой заан талууд баталгаажуулж Баталгаа гаргах гэрээнд хавсаргадаг байна.

Банк нь баталгаа хүлээн авагчаас баталгаанд заасан нөхцөлийн дагуу төлбөрийн шаардлага хүлээн авсан тохиолдолд уг төлбөрийн шаардлага, дагалдах баримт бичгүүд нь шаардлага хангасан эсэхийг шалгасны үндсэн дээр төлбөрийг 3 хоногийн дотор гүйцэтгэх тухай харилцагчид нэг өдрийн дотор мэдэгдэнэ. Дээрх бичиг баримтууд нь холбогдох шаардлага хангаж буй тохиолдолд төлбөр гүйцэтгэхээр товлосон өдөр харилцагчийн өмнөөс баталгаа хүлээн авагчид төлбөрийг гүйцэтгэхээр Баталгаа гаргах гэрээнд заажээ. Энэ нь ИХ-ийн 457 дугаар зүйлийн 457.2, 7, 8 дахь заалттай нийцэж байна.

[49] **Иргэний хууль (2002).**
457 дугаар зүйл.**Банкны баталгааны гэрээ**
457.1.Банкны баталгааны гэрээгээр банк нь үүрэг гүйцэтгүүлэгчийн бичгээр тавьсан шаардлагаар үүрэг гүйцэтгэгчийн өмнөөс мөнгөн төлбөрийг гүйцэтгэх, үүрэг гүйцэтгэгч нь баталгаа гаргагч банкинд төлбөр төлөх үүргийг тус тус хүлээнэ.

СЗХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

Баталгаа гаргах гэрээний нөгөө тал болох харилцагч нь баталгааг гэрээнд зааснаас өөр зориулалтаар ашиглахгүй байх үүрэгтэй. Мөн баталгаа хүлээн авагчид төлбөр гүйцэтгэсэн талаар Банкнаас мэдэгдэл хүлээн авснаас хойш 1 хоногийн дотор төлбөрийг ямар нөхцөл, хэлбэрээр буцаан төлөх тухай хариуг албан бичгээр өгнө гэж гэрээнд заасан байна. ИХ-ийн 457 дугаар зүйлийн 457.15 дахь хэсэгт "Банк, үүрэг гүйцэтгүүлэгчийн өмнө хүлээсэн үүргээ гүйцэтгэж төлсөн мөнгийг үүрэг гүйцэтгэгчид сөрөг нэхэмжлэл гаргах замаар буцаан авах журмыг баталгаа гаргагч болон үүрэг гүйцэтгэгч гэрээгээр харилцан тохиролцоно" гэж хуульчилсан байна. Иймд харилцагч нь батлан даалтын гэрээнд заасан арга замаар төлбөрийг буцаан төлөх үүрэг хүлээх ба энэ нь ИХ-ийн холбогдох заалттай нийцэж байна.

Баталгаа гаргах гэрээнд талууд гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болох ба харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

**Дүгнэж үзвэл ХасБанк ХХК-ийн мөнгөн хадгаламжийн, харилцах дансны, аккредитив нээх болон баталгаа гаргах гэрээ нь холбогдох хууль тогтоомж болон Банкны дотоод дүрэм, журамд нийцсэн гэж үзэж байна. Мөнгөн хадгаламжийн гэрээ болон харилцах дансны гэрээ нь Банкны салбар болон тооцооны төвүүдээр дамжин хийгдсэн байх ба тухайн салбар, тооцооны төвийн захирал гэрээнд гарын үсэг зурж, тэмдэг даран баталгаажуулсан байна. Гүйцэтгэх захирлын тушаалаар холбогдох албан тушаалтанд гэрээ байгуулах эрх олгох, мөн урьд байгуулагдсан гэрээнд Банкийг төлөөлөн гарын үсэг зурсан этгээдийн гэрээ байгуулсан ажилтны бүрэн эрхийг Иргэний хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт заасныг үндэслэн зөвшөөрсөн байх тул Иргэний хуулийн 68 дугаар зүйлийн 68.1 дэх хэсэгт[50] заасны дагуу тухайн гэрээ, хэлцлийг хүчин төгөлдөр гэж дүгнэлээ.**

Хоёр. Зээлийн гэрээ

Банкнаас бусадтай байгуулсан бүх төрлийн (i) зээлийн гэрээ, барьцаат зээлийн гэрээ, зээлийн шугамын гэрээ, овердрафтын гэрээ; (ii) батлан даалтын гэрээ; (iii) барьцааны гэрээ; (iv) ипотекийн гэрээ; болон (v) фидуцийн гэрээнд дүн шинжилгээ хийхдээ Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийг баримталлаа. Мөн ХасБанк ХХК-ийн зүгээс зээлийн үйл ажиллагаатай холбоотой баталсан дараах дүрэм журмуудыг удирдлага болголоо. Үүнд:

(i) Зээлийн бодлого, 2006 оны №R-2006-11 дугаартай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан;

(ii) Зээлийн үйл ажиллагааны журам, 2017 оны №А7-1855 дугаартай Эрсдэл хариуцсан захирлын тушаалаар батлагдсан;

(iii) Зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам, 2023 оны №А7-189 дугаартай Эрсдэл хариуцсан захирлын тушаалаар батлагдсан;

(iv) ХасБанкны ТУЗ-ийн Зээлийн хорооны журам, 2006 оны №20 дугаартай Төлөөлөн удирдах зөвлөлийн тогтоолоор батлагдсан;

(v) Иргэдийн зээлийн стандарт 2017 оны №А7-1855 дугаартай Эрсдэл хариуцсан захирлын тушаалаар батлагдсан;

(vi) Иргэдэд орон сууц худалдан авах, барьж дуусгахад зориулан олгох зээлийн журам, 2012 оны №762 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан;

(vii) Монгол Улсын Засгийн газраас хэрэгжүүлж буй Орон сууцны ипотекийн санхүүжилтийн журмын хүрээнд олгох орон сууцны зээлийн үйл ажиллагааны заавар, 2020 оны №А4-1145

---

[50] Иргэний хууль (2002).
68 дугаар зүйл.Төлөөлөх бүрэн эрхгүй этгээдийн хийсэн хэлцэл
68.1.Төлөөлөх бүрэн эрхгүй этгээд бусдын нэрийн өмнөөс гуравдагч этгээдтэй дур мэдэн хэлцэл хийсэн бол уг хэлцэл хүчин төгөлдөр байх эсэх нь төлөөлүүлсэн этгээдийн зөвшөөрлөөс шалтгаална.

СЭХ
2023 05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

дугаартай Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирлын тушаалаар батлагдсан;

(viii) Бичил бизнесийн бүлгийн зээл олгох заавар, 2012 оны №А-339 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан;

(ix) Бизнесийн зээлийн журам, 2011 оны №А-520 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан;

(x) Жижиг дунд бизнесийн болон корпорэйт зээлийн стандарт, 2017 оны №А7-1855 дугаартай Эрсдэл хариуцсан захирлын тушаалаар батлагдсан;

(xi) Барилга байгууламжийн зээлийн журам, 2014 оны №А-572 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан;

(xii) Аккредитивийн журам, 2006 оны №А-818 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан;

(xiii) Овердрафтын журам, 2012 оны №А-1094 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар батлагдсан;

(xiv) Ажилтны зээлийн журам, 2019 оны ТУЗ-ийн дэргэдэх Эрсдэлийн удирдлагын хорооны тогтоолоор батлагдсан.

Энэхүү бүлэгт Банкны иргэн болон хуулийн этгээдтэй байгуулсан бүх төрлийн зээлийн гэрээг хууль тогтоомж, Банкны дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх болно.

Банкнаас ирүүлсэн жагсаалтаас үзвэл зөвхөн дурдсан хугацаанд нийт 886,949 (найман зуун наян зургаан мянга есөн зуун дөчин есөн) зээлийн гэрээ байгуулагдсанаас тасалбар болгосон өдрийн байдлаар 157,607 (нэг зуун тавин долоон мянга зургаан зуун долоон) зээлийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Үүнд:

*Хүснэгт №12. Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай бичгээр байгуулсан нийт зээлийн гэрээний тоон үзүүлэлт.*

| № | Гэрээ | 2020.01.01 – 2021.01.01 | 2021.01.01 – 2022.01.01 | 2022.01.01 – 2023.01.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 1. | Зээлийн гэрээ | 29,479 | 140,868 | 716,602 | 886,949 |
| 2. | Дуусгавар болсон гэрээ | | | | 729,342 |
| | ХҮЧИН ТӨГӨЛДӨР НИЙТ ГЭРЭЭ | | | | **157,607** |

Банкнаас иргэн хуулийн этгээдтэй байгуулсан зээлийн гэрээг зээлийн бүтээгдэхүүний төрлөөр ангилан авч үзвэл дараах байдалтай байна. Үүнд:

*Хүснэгт №13. Сүүлийн 3 (гурван) жил дотор бусадтай бичгээр байгуулсан нийт зээлийн гэрээний ангилал, тоон үзүүлэлт.*

| № | Гэрээ | 2020.01.01 – 2021.01.01 | 2021.01.01 – 2022.01.01 | 2022.01.01 – 2023.01.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|
| 1. | "Жайка" зээл | 6 | 7 | 1 | 14 |
| 2. | "LS-ээс LG-рүү шилжсэн" зээл | 2 | 23 | 45 | 70 |
| 3. | Автомашин худалдан авах зээл | 169 | 655 | 176 | 1,000 |
| 4. | Ажиллагсдын зээл | 176 | 734 | 1,285 | 2,195 |
| 5. | Ажлын байр дэмжих зээл | - | 2,823 | 40 | 2,863 |
| 6. | Бизнесийн зээл /ААН/ | 33 | 67 | 172 | 272 |
| 7. | Бизнесийн зээл /иргэн/ | 7 | 2 | 16 | 25 |
| 8. | Бичил зээл /ААН/ | 17 | 30 | 39 | 86 |
| 9. | Бичил зээл /иргэн/ | 2,485 | 3,381 | 5,044 | 10,910 |
| 10. | Яамнаас олгох зээл | 1 | 1 | - | 2 |
| 11. | ЖДҮ зээл /ААН/ | 10 | 4 | - | 14 |
| 12. | Жижиг бизнесийн зээл /ААН/ | 114 | 187 | 148 | 449 |
| 13. | Жижиг бизнесийн зээл /иргэн/ | 878 | 1,482 | 1,602 | 3,962 |

437

Нууц баримт
Эх хувь

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 14. | Жижиг бизнесийн зээл /төсөл/ | - | 4 | 7 | 11 |
| 15. | Зээлийн шугам нээх | 25 | 101 | 1,780 | 1,906 |
| 16. | Кредит картын зээл | 427 | 556 | 5,416 | 6,399 |
| 17. | Овердрафтын эрх нээх | 7 | 4 | 92 | 103 |
| 18. | "Органи Монгол" зээл | 6 | - | 3 | 9 |
| 19. | Орон сууц худалдан авах зээл | 1,011 | 1,574 | 1,281 | 3,866 |
| 20. | Өрхийн зээл | 232 | 312 | 418 | 962 |
| 21. | "ПОС" зээл | 8 | 2 | 494 | 504 |
| 22. | "Репо" зээл | - | 113 | 11 | 124 |
| 23. | Лизингийн зээл | 67 | 759 | 481 | 1,307 |
| 24. | Хадгаламж барьцаалсан зээл | 13,253 | 92,937 | 654,318 | 760,508 |
| 25. | Худалдан авалтын зээл | 246 | 727 | 461 | 1,434 |
| 26. | Цалингийн зээл | 10,210 | 34,320 | 43,126 | 87,656 |
| 27. | "Эко" зээл | 89 | 60 | 102 | 251 |
| 28. | "Эко" зээлийн шугам | - | 3 | 44 | 47 |
| | НИЙТ | 29,479 | 140,868 | 716,602 | 886,949 |

ХасБанк ХХК-аас ирүүлсэн гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй зээлийн гэрээний жагсаалтаас санамсаргүй түүврийн аргаар 139 (нэг зуун гучин есөн) гэрээг сонгон авч үзэж танилцлаа. Энэхүү гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №02. "ХасБанк ХХК-ийн хуулийн этгээд, хувь хүнтэй байгуулсан зээлийн гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу. Мөн гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж буй зээлийн гэрээнүүдээс хамгийн өндөр дүн бүхий 53 (тавин гурван) зээлийн гэрээ болон түүний дагалдах гэрээнүүдийг үзэж танилцсан. Энэхүү өндөр дүн бүхий зээлийн гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №03. "ХасБанк ХХК-ийн хуулийн этгээдтэй байгуулсан өндөр дүн бүхий зээлийн гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Банк нь үйл ажиллагаа явуулахдаа харилцагчдаа арьсны өнгө, хүйс, гэр бүлийн байдал, шашин шүтлэг, нийгмийн байдал болон гарал үүслээр нь ялгаварлан гадуурхахгүй байх тухай "Зээлийн бодлого"-доо тодорхой тусгасан байна. Мөн зээлийн үйл ажиллагааг Банкны эрхэм зорилго, зорилтод нийцүүлэн нэн тэргүүнд бага орлоготой, алслагдсан хөдөө орон нутагт амьдардаг, санхүүгийн үйлчилгээнд хамрагдах боломжоор хязгаарлагдмал иргэд, бизнесийн байгууллагад Банкны шинэлэг үйлчилгээгээр тасралтгүй хангах чиглэл баримтална гэжээ. Зээлийн үйл ажиллагааг дараах чиглэлээр ангилан, ангилал бүрээр зээлийн бүтээгдэхүүнийг төрөлжүүлсэн байна. Үүнд:

(i) **Бизнесийн:** бичил зээл, хөгжлийн зээл, бөөний зээл, санхүүгийн түрээс, үл хөдлөх хөрөнгө барьцаалсан бизнесийн зээл, зээлийн шугам;
(ii) **Хэрэглээний:** цалингийн зээл, санхүүгийн түрээс, орон сууцны зээл, овердрафт;
(iii) **Хөдөөгийн зээл:** малчны зээл, ургацын зээл, хөдөө аж ахуйн зээл;
(iv) **Төсөл, хөтөлбөр** (МУ-ын ЗГ болон ОУ-ын байгууллагуудын санхүүжүүлж буй төсөл, хөтөлбөр): Ядуурлыг бууруулах, Амьжиргааны түвшинг сайжруулах, Ажил эрхлэлтийг дэмжих, Хүмүүнлэгийн хөтөлбөр, Байгаль орчныг хамгаалах, дэмжих хөтөлбөр, Эдийн засгийн хөгжлийн хөтөлбөр;
(v) **Тусгай нөхцөлтэй:** зээлийн үндсэн бүтээгдэхүүнээс гадуур тусгай нөхцөлтэй зээл.

Банк нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 28 (хорин найман) төрлийн зээлийн бүтээгдэхүүнийг санал болгож гэрээ байгуулсан ба гэрээ байгуулахдаа "Зээлийн бодлого"-д заасны дагуу хот болон хөдөө орон нутгийн зээлдэгчид, бизнесийн байгууллагууд, шашны болон төрийн бус байгууллагууд, Монгол болон бусад үндэстэн ястан, гадаадын байгууллагуудад санал болгосон байна.

438

СЭХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны №А-625 тоот тушаалаар Банкны хэмжээнд хийгдэж буй зээлийн гэрээнүүд болон аккредитив, барьцаа, батлан даалт, ипотекийн гэрээнүүдийн загварыг, 2022 оны №А-1001 тоот тушаалаар зээлийн шугамын гэрээ, зээлийн гэрээ, ипотекийн гэрээ, жижиг бичил бизнесийн гэрээ, фидуцийн гэрээ, батлан даалтын гэрээ, барьцаат зээлийн гэрээ, бизнесийн зээлийн гэрээ, барьцаат зээлийн гэрээ, барьцааны гэрээ, эх үүсвэргүй аккредитив нээх, баталгаа гаргах гэрээ, эх үүсвэргүй баталгаа гаргах гэрээнүүдийн загварыг, 2022 оны №А-1087 тоот тушаалаар зээлийн эрх нээх гэрээний загварыг тус тус шинэчлэн баталсан байна.

**(i) Зээл, барьцаат зээл, зээлийн шугам, овердрафтын гэрээ**

ИХ-ийн 281-285 дугаар зүйлд зээлийн гэрээний зохицуулалтыг заасан ба 451-453 дугаар зүйлд банкнаас зээл олгох гэрээний зохицуулалтыг нэмж тусгасан байдаг. Мөн Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19-26 дугаар зүйлд банкны зээлийн үйл ажиллагаа, зээлийн гэрээ, зээлийн хувийн хэргийн талаарх зохицуулалтыг илүү нарийвчлан заасан байна.

Банк нь иргэн, хуулийн этгээдтэй байгуулах зээлийн гэрээгээр тодорхой хугацаа, хүү, үүргийн гүйцэтгэлийг хангах арга, зориулалттайгаар мөнгөн хөрөнгө зээлдүүлэх, зээлдэгч зээлийг хүү, тооцогдсон бол нэмэгдүүлсэн хүүгийн хамт эргэн төлөхтэй холбоотой талуудын эдлэх эрх, хүлээх үүрэг хариуцлагыг тодорхойлж зохицуулсан байна. Зээлийн хүүгийн хувь хэмжээ нь зээлийн бүтээгдэхүүнээс хамааран харилцан адилгүй байж болохоор Банк өөрөө тогтоосон хэдий ч зээлийн гэрээнд жилийн буюу 365 хоногт тогтмол байхаар заасан байна. Нэмэгдүүлсэн хүүний хувьд хүүгийн 20%-иар тооцож авахаар зээлийн гэрээнд тусгажээ. Дээрх заалтууд нь ИХ-ийн 282 дугаар зүйлийн 282.1, 452 дугаар зүйлийн 452.1-2 дахь хэсэг, Банкны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1 дэх заалт, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3, 20 дугаар зүйлийн 20.2.5-7 дахь хэсэгтэй нийцэж байна. Банк нь зээлийн хүүгийн хувь хэмжээг өөрчлөх бол тогтсон хугацааны өмнө зээлдэгчид түүний цахим шуудан, гар утсаар мэдэгдэх эсхүл өөрийн Банкны болон Монголбанкны албан ёсны цахим хуудаст мэдээлэл нийтэлснээр мэдэгдсэнд тооцож өөрчлөгдсөн хүүгийн хувь хэмжээ, тухайн өдрийн байдлаарх зээлийн үлдэгдэл зэргийг Банкинд хадгалагдаж байгаа гэрээний холбогдох хавсралтад тэмдэглэнэ гэж зээлийн гэрээнд заасан байна. Улмаар уг тэмдэглэл хийгдсэнээс хойш 5 хоногийн дотор эргэн төлөлтийн хуваарийн төлбөрийн хэмжээг шинэчлэн тогтоохоор зохицуулсан байна.

Зээлийн гэрээнд зээлийн дүн, валютын төрөл, гэрээний хугацаа, зээлийн зориулалт, тухайн зээлийн данс, зээлийн данснаас олголт хийх хэлбэр, талуудын оршин байгаа, оршин суугаа газрын хаягийн мэдээлэл зэргийг оруулахаар заасан нь Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.1-12 дугаар заалтыг хангаж байна. Зээлийн гэрээнд зээлдэгч нь авсан зээлээ хугацаанаас нь өмнө төлөх эрхтэй байхаар заасан нь ИХ-ийн 283 дугаар зүйлийн 283.3 дахь хэсэг болон Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-2 дугаар заалтыг хангажээ. ИХ-ийн 222 дугаар зүйлийн 222.5-д хүүгээс анз тооцохгүй байх тухай заасан. Өөрөөр хэлбэл зээлдэгч нь үүргээ гүйцэтгэх хугацаа хэтрүүлсэн тохиолдолд нэмэгдүүлсэн хүүг төлөх ба нэмж анз төлөхгүй. Зээлийн гэрээнд зөвхөн нэмэгдүүлсэн хүүгийн талаар заасан ба ямар нэгэн анзын талаар дурдаагүй нь хуулийн дээрх зохицуулалттай нийцэж байна. Банк нь зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангах арга болгож барьцааны гэрээ, ипотекийн гэрээ, фидуцийн гэрээ, батлан даалтын гэрээнээс аль нэгийг байгуулах эсхүл дурдсан бүх гэрээг байгуулж болохоор заасан байна. Эдгээр гэрээ нь тусдаа бие даасан зохицуулалттай бөгөөд зээлийн гэрээний салшгүй нэг хэсэг юм. Мөн зээлдэгч хүсвэл зээлийн гэрээг нотариатаар гэрчлүүлж болох ба дээрх дагалдах гэрээг төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх, холбогдох хураамж болон гарах зардлыг зээлдэгч хариуцахаар гэрээнд заасан байна.

2023.05.12
он сар өдөр
БҮРТГЭВ
№ 01

Банкны барьцаат зээлийн гэрээ нь зээлийн гэрээтэй ижил зохицуулалттай болович зээлийн зориулалтын дагуу худалдан авсан хөрөнгөө барьцаалуулдаг онцлогтой. Мөн барьцаа хөрөнгийг даатгуулж даатгалын хураамжийг зээлдэгч тал хариуцахаар барьцаат зээлийн гэрээнд заасан байна. Хэрэв гэрээний хугацаанд даатгалын тохиолдол үүсвэл даатгагчаас олгох нөхөн төлбөрөөс тэргүүн ээлжид зээлдэгчээс банкны өмнө гүйцэтгээгүй үүргийн үнийн дүнг үл маргах журмаар суутган төлүүлэхээр зохицуулсан байна. Барьцаат зээлийн гэрээнд үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар барьцааны гэрээ, фидуцийн гэрээ, ипотекийн гэрээ, батлан даалтын гэрээг байгуулж болохоор заасан. ХасБанк ХХК-ийн зүгээс мөн хадгаламж барьцаалсан зээлийн бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгож гэрээ байгуулдаг ба уг гэрээ нь зохицуулалтын хувьд барьцаат зээлийн гэрээтэй ижил байна.

Банк нь зээлийн шугамын гэрээгээр зээлдэгчид тодорхой хугацаанд зээлийн эрхийн дээд хэмжээг зааж өгөх байдлаар зээл авах эрхийг олгодог. Энэ хугацаанд зээлдэгч нь зээлийн эрхийн хэмжээнд багтаан зээл авах буцаан төлөх харилцааг хэдэн ч удаа үүсгэж болдог онцлогтой. Мөн энгийн зээлийн гэрээнээс ялгаатай нь зээлийн шугамын данснаас зарлагын гүйлгээ хийснээр зээлийг олгосонд тооцдог ба ашиглаагүй зээлийн эрхийн үлдэгдэлд жилийн буюу 365 хоногт тогтмол хувиар шимтгэл төлдөг. Зээлийн шугамын гэрээний бусад зохицуулалт нь зээлийн гэрээтэй ижил байна. Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.4 дэх хэсэгт зээлийг зээлийн шугам хэлбэрээр олгож болохоор зохицуулсан байна.

Овердрафт нь нэг төрлийн зээл ба гэрээгээр тогтоосон эрхийн хэмжээнд зээлдэгч нь өөрийн харилцах данс эсхүл төлбөрийн картын дансны үлдэгдлээс илүү хэмжээгээр зарлагын гүйлгээ хийх, тухайн дансанд хийсэн орлогоор эргэн төлөлт хийх нөхцөлтэй зээлийн эрх юм. Банкны овердрафтын гэрээний гол онцлог нь өрхийн санхүүгийн хэрэглээ, хэрэглээний худалдан авалт зэрэг бага дүнтэй түргэн шуурхай хийгддэг гүйлгээнд түлхүү ашиглагддаг. Овердрафтын гэрээг иргэн, хуулийн этгээдийн аль алинтай нь байгуулж болох ба гэрээгээр зээлжих эрхийн дээд хэмжээ, хугацаа, валютын төрөл, хүү, нэмэгдүүлсэн хүү, шимтгэл, үүргийн гүйцэтгэлийг хангах арга зэргийг тогтоож өгсөн нь ИХ-ийн 451-453 дугаар зүйл, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хуулийн 19-27 дугаар зүйлтэй нийцэж байна.

**(ii) Батлан даалтын гэрээ**

Банкны Батлан даалтын гэрээгээр зээлийн гэрээний дагуу төлбөрийн үүрэг хүлээсэн зээлдэгч үүргээ зөрчсөн буюу үүргээ хугацаандаа гүйцэтгээгүй эсхүл үүргээ гүйцэтгэж чадахгүй нь илт болсон тохиолдолд батлан даагч нь Банкны шаардлагын дагуу төлбөрийн үүргийг хамтран хариуцахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулна.

ИХ-ийн 459 дүгээр зүйлийн 459.3-т батлан даалтын гэрээнд батлан даагчийн хүлээх хариуцлагын дээд хэмжээг заана гэсэн байна. Мөн хуулийн 460 дугаар зүйлийн 460.4 дэх хэсэгт батлан даагч нь батлан даалтын гэрээнд заасан хэмжээгээр хариуцлага хүлээнэ гэсэн байна. Батлан даалтын гэрээнд зээлийн гэрээний үүргийг бүхэлд нь батлан даагч талаас шаардаж болохоор Банкны зүгээс оруулсан байна. Батлан даалтын гэрээнд батлан даагчийн хамтран хариуцах үүргийн хэмжээ нь зээлийн үндсэн төлбөр, хүүгийн төлбөр, нэмэгдүүлсэн хүүгийн төлбөр, барьцаа хөрөнгийг хадгалах, хамгаалах, засвар үйлчилгээ хийх, тээвэрлэх, худалдан борлуулахтай холбоотой Банкнаас гарсан зардал, зээлийн гэрээтэй холбоотой үүссэн маргааныг шүүхээр шийдвэрлүүлэхтэй холбоотойгоор Банкинд учирсан хохирол, зардал, Банкнаас гарсан бусад зардлуудын нийлбэр дүнтэй тэнцүү байхаар заасан байна. Гэрээний энэхүү заалт нь ИХ-ийн 460 дугаар зүйлийн 460.5 дахь хэсэгт заасан зохицуулалттай зөрчилдөхгүй байна. Хэрэв зээлдэгч зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ хугацаанд нь биелүүлээгүйн улмаас батлан даагч нь батлан даалтын гэрээний дагуу зээлдэгчийн хүлээсэн үүргийг бүрэн биелүүлсэн бол зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг зээлдэгчээс шаардах бүх эрх батлан даагчид шилжихээр байна.

440

СЭХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

Батлан даалтын гэрээнд зээлдэгч үндсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд батлан даагчид энэ тухай мэдэгдэх үүргийг Банк хүлээхээр байна. Мөн батлан даагч нь ямар ч тохиолдолд зээлдэгчийн зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн биелэлтийн талаарх мэдээллийг Банкнаас авах эрхтэй Банк нь зээлдэгчийн хүлээсэн үүрэг болон үүргийн биелэлтийн талаарх үнэн зөв мэдээллийг гаргаж өгөх үүрэг хүлээсэн байна. Энэ нь ИХ-ийн 462 дугаар зүйлийн 462.1-2 дугаар заалтын дагуу байна. Уг гэрээнд зээлдэгч нь зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргээ биелүүлээгүй тухай мэдэгдлийг батлан даагчид өөрт нь бичгээр гардуулсан, утсаар мэдэгдсэн, гэрийн хаягаар эсхүл түүний цахим шуудангаар илгээснийг Банк мэдэгдэл хүргүүлсэн, батлан даагч мэдэгдэл хүлээн авсанд тооцохоор заасан байна. Мөн зээлийн гэрээнд орсон өөрчлөлтийг тухай бүр батлан даагчид мэдээлэх үүргийг Банк хүлээсэн ба зээлийн гэрээнд өөрчлөлт орсон нь батлан даагч батлан даалтын гэрээгээр хүлээсэн үүргээс чөлөөлөгдөх үндэслэл болохгүй юм.

Батлан даалтын гэрээгээр зохицуулагдаагүй, орхигдсон бусад асуудлыг Монгол Улсын Иргэний хуульд заасны дагуу зохицуулахаар гэрээнд тусгасан байна.

**(iii) Барьцааны гэрээ (хөдлөх эд хөрөнгө болон эрх)**

Барьцааны гэрээгээр Банк болон зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний төлбөрийн үүргээ зээлдэгч тал нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалуулагч нь барьцааны хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасны дагуу хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Барьцааны гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулах ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг бичгээр байгуулна гэж заасан бол Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1 дэх хэсэг болон 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт зааснаар барьцааны гэрээг бичгээр байгуулах ба талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн барьцааны эрх үүснэ гэж зүйлчилсэн байна. Барьцааны гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

ИХ-ийн 154 дүгээр зүйлийн 154.1 дэх хэсэг болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт барьцааны зүйлийг иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа эсхүл ирээдүйд бий болох эд хөрөнгө болон бусдын өмчлөлд шилжүүлж болох эд хөрөнгийн эрх байж болно гэж заасан. Тэгвэл Банкны зүгээс боловсруулсан барьцааны гэрээнд барьцааны зүйлийг барьцаалуулагчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй хөдлөх эд хөрөнгө болон эрх, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйлийг хамтад нь ойлгохоор тусгасан байна. Барьцааны гэрээг байгуулах үед барьцаа хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа бол хамтран өмчлөгч тус бүрээс холбогдох зөвшөөрлийг авч баталгаажуулан барьцааны гэрээнд хавсаргахаар зохицуулсан байна.

ИХ-ийн 156 дугаар зүйл болон Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлд[51] барьцааны гэрээнд заавал тусгах агуулгыг заасан ба ХасБанк ХХК-ийн байгуулж буй барьцааны гэрээнд дээрх бүх агуулга багтсан байна.

[51] **Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).**
10 дугаар зүйл.**Барьцааны гэрээний агуулга**
10.1.Барьцааны гэрээг Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд дараах зүйлийг тусгана:
10.1.1.барьцаалагч болон барьцаалуулагч нь иргэн бол эцэг /эх/-ийн нэр, өөрийн нэр, регистрийн дугаар, оршин суугаа газрын хаяг, хуулийн этгээд бол оноосон нэр, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн дугаар, оршин байгаа газрын хаяг;
10.1.2.барьцаагаар хангах үүрэг, гэрээ байгуулах үед мэдэгдэж байгаа бол барьцаагаар хангагдах шаардлагын хэмжээ;
10.1.3.барьцаалагч, барьцаалуулагч талууд гэрээндээ барьцаагаар хангах үүргийг ирээдүйд үүсэх, эсхүл өөрчлөгдөж болохоор тохиролцсон бол түүнийг тодорхойлох журам, бусад нөхцөл;
10.1.4.барьцааны зүйлийн тодорхойлолт, түүний нэг бүрийн, эсхүл төрлийн шинжээр тодорхойлогдох байдал;
10.1.5.барьцааны гэрээний үргэлжлэх хугацаанд барьцааны зүйлийг эзэмшилдээ байлгах тал;
10.1.6.барьцааны гэрээ байгуулсан он, сар, өдөр.
10.2.Дараах этгээдийн талаар энэ хуулийн 10.1.1-д заасан мэдээллийг барьцааны гэрээнд тусгана:

441

СЗХ 2023 .05 сар 12 өдөр БҮРТГЭВ № 01

Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцаа хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотой төлсөн татвар, хураамж болон Банкнаас гарсан зардал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр барьцааны гэрээнд оруулсан байна. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.2 дахь заалтад барьцааны гэрээнд барьцаагаар хангагдах шаардах үүргийн хэмжээг тусгана гэж заасныг гэрээний дээрх заалт хангаж байна.

Барьцааны гэрээнд барьцаа хөрөнгийг барьцаалуулагч нь өөрийн эзэмшилд байлган бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах ба барьцаа хөрөнгийг барьцааны гэрээний хугацаанд даатгуулах үүргийг хүлээлгэсэн байна. Харин Банк нь барьцаа хөрөнгийн барьцааны мэдэгдэл, тэмдэглэлийг цахим мэдээллийн санд бүртгүүлж барьцааг баталгаажуулах үүрэг хүлээсэн. Энэ тухай Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2 дахь хэсэгт зүйлчилсэн байна.

Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдын өмчлөлд шилжүүлэх мөн барьцааны зүйлийг бусдад давхар барьцаалах эрхтэй байх ба энэ тохиолдолд барьцаалагч талд заавал мэдэгдэх үүрэгтэй байхаар барьцааны гэрээнд заажээ. Барьцаалуулагч талын бас нэгэн үүрэг нь тухайн шилжүүлж буй хөрөнгөнд барьцааны үүрэг дагалдаж буйг барьцааны зүйлийг шилжүүлэн авч буй талд мэдэгдэх юм. Иймхүү мэдэгдээгүйгээс үүдэн гарах үр дагаврыг Банк хариуцахгүй байхаар заажээ. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.1 дэх хэсэгт барьцаалуулагч барьцааны зүйлийг худалдах, арилжих, бэлгэлэх зэргээр захиран зарцуулах эрхтэй байхаар заасан ба энэ тохиолдолд барьцаалагч талд мэдэгдэхээр зохицуулсан байна. Мөн хуулийн 24 дүгээр зүйлийн 24.1 дэх хэсэгт барьцааны зүйлийн өмчлөгч өөрчлөгдсөн тохиолдолд уг хөдлөх эд хөрөнгийн барьцааны эрх хэвээр хадгалагдана гэж заасан байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд Банк нь барьцаа хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ зээлдэгчид зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа зааж, барьцаанаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдлийг барьцаалуулагч талд мэдэгдэхээр барьцааны гэрээнд заасан байна. Энэ нь ИХ-ийн 158 дугаар зүйл, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 47-49 дугаар зүйлтэй нийцэж байна. Банк нь барьцааны зүйлээс үүргийн гүйцэтгэлийг хангуулахдаа иймхүү ажиллагаа эхлүүлсэн тухай тэмдэглэлийг цахим мэдээллийн санд оруулж, бүртгэлээр баталгаажсан бусад барьцаалагчид мэдэгдэхээр гэрээнд зохицуулсан байна. Өөрөөр хэлбэл барьцааны зүйлийг цаашид худалдан борлуулах тухай бусад барьцаалагчид мэдэгдэнэ гэсэн үг юм. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 50 дугаар зүйлд мэдэгдэлтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан заасан ба гэрээний дээрх заалт нь нийцэж байгааг тэмдэглэж байна. Барьцааны зүйлийг хэд хэдэн этгээд барьцаалсан байж болох ч хамгийн түрүүнд барьцаалсан этгээд барьцааны зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй байдаг. Энэ тухай ИХ-ийн 158 дугаар зүйлийн 158.1 дэх хэсэгт “Барьцааны зүйл нь хэд хэдэн этгээдэд барьцаалагдсан бол хамгийн түрүүнд түүнийг барьцаалсан этгээд уг зүйлийг борлуулахыг шаардах эрхтэй” гэж тодорхойлсон байна.

---

10.2.1.үүрэг гүйцэтгэгч нь барьцаалуулагч биш бол үүрэг гүйцэтгэгчийн;
10.2.2.барьцааны зүйл нь дундын хөрөнгө бол дундаа өмчлөгчдийн;
10.2.3.үүрэг гүйцэтгүүлэгч буюу барьцаалагч нь хэд хэдэн этгээд бол үүрэг гүйцэтгүүлэгчдийн.
10.3.Барьцааны гэрээнд барьцаалагч, барьцаалуулагч, эсхүл тэдгээрийн төлөөлөгч гарын үсэг зурж, баталгаажуулсан байна.
10.4.Бичгээр байгуулаагүй барьцааны гэрээ хүчин төгөлдөр бус байна.

СЗХ
2023 .05 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05

Банк нь барьцааны зүйлийг худалдан борлуулах зохицуулалтыг ИХ-ийн 159 дүгээр зүйл[52], Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 54 дүгээр зүйлд[53] заасантай нийцүүлэн барьцааны тухай хуульд заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно гэж заасны дагуу нотариатаар гэрчлүүлж холбогдон гарах зардлыг барьцаалуулагч тал хариуцахаар зохицуулжээ.

**(iv) Ипотекийн гэрээ (үл хөдлөх эд хөрөнгийн барьцаа)**

Ипотекийн гэрээгээр Банк болон зээлдэгч нарын хооронд байгуулсан зээлийн гэрээний төлбөрийн үүргээ зээлдэгч тал нь гүйцэтгээгүй, зохих ёсоор гүйцэтгээгүй бол барьцаалуулагч нь барьцааны үл хөдлөх хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хууль болон гэрээнд заасны дагуу хангахтай холбоотой талуудын хооронд үүсэх харилцааг зохицуулдаг. Ипотекийн гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг даран баталгаажуулж улсын бүртгэлд бүртгүүлснээр хүчин төгөлдөр болох ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1-2 болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсэг, 12 дугаар зүйлийн 12.1 дэх хэсэгт үл хөдлөх эд хөрөнгө барьцаалсан гэрээг заавал бичгээр байгуулж бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн байхыг шаардсан ба талуудын хооронд байгуулсан гэрээнд үндэслэн барьцааны эрх үүснэ гэж тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт заасан байна. Ипотекийн гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

ИХ-ийн 154 дүгээр зүйлийн 154.1 дэх хэсэг болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.1 дэх хэсэгт барьцааны зүйлийг барьцаалуулагчийн өмчлөлд байгаа ИХ-ийн 84.3 дахь хэсэгт заасан үл хөдлөх эд хөрөнгө, түүнтэй холбоотой эрх байна гэж заажээ. Тэгвэл Банкны зүгээс боловсруулсан ипотекийн гэрээнд барьцааны зүйлийг барьцаалуулагчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй үл хөдлөх эд хөрөнгө, түүний бүрдэл хэсэг, дагалдах зүйл, засан сайжруулалтыг хамтад нь ойлгохоор тусгасан байна. Ипотекийн гэрээг байгуулах үед барьцаа хөрөнгийн хувьд гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байгаа бол хамтран өмчлөгч тус бүрээс холбогдох зөвшөөрлийг авч баталгаажуулан ипотекийн гэрээнд хавсаргахаар зохицуулсан байна.

---

[52] **Иргэний хууль (2002).**
159 дүгээр зүйл.**Барьцааны зүйлийг худалдах**
159.1.Хууль буюу гэрээнд өөрөөр заагаагүй бол барьцааны зүйлийг энэ хуульд заасан журмын дагуу дуудлага худалдаагаар худалдана.
159.2.Барьцаалуулагч шаардсан бол барьцааны зүйлийг худалдахын өмнө түүний үнэлгээг шинжээчээр тогтоолгож болох бөгөөд холбогдох зардлыг барьцаалуулагч хариуцна.
159.3.Барьцааны зүйлийг худалдах ажиллагаанд барьцааны зүйлийн өмчлөгч оролцож, уг зүйлээ худалдан авах санал гаргаж болно.
159.4.Барьцааны зүйлийн үнийг төлөөгүй тохиолдолд худалдан авах эрхээ алдахыг дуудлага худалдаанд оролцогчдод тайлбарласан байвал зохино.
159.5.Барьцааны зүйлийг хууль ёсоор, шударгаар олж авсан этгээдэд барьцааны зүйл эрхийн хязгаарлалтгүйгээр шилжинэ.
[53] **Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).**
54 дүгээр зүйл.**Барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилах**
54.1.Барьцааны зүйлийг энэ хуулийн 53 дугаар зүйлд заасны дагуу худалдан борлуулахтай холбогдон гарсан зардлыг төлсний дараа барьцаалагч нь барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг өөрийн болон бусад барьцаалагчийн барьцааны шаардлагыг энэ хуульд заасан дарааллын дагуу хангаж, үлдэгдлийг нь барьцаалуулагчид олгоно.
54.2.Энэ хуулийн 54.1-д зүйлд заасны дагуу барьцааны зүйлийг худалдан борлуулснаас олсон орлогыг хуваарилахаас 10-аас доошгүй хоногийн өмнө энэ хуулийн 50.3-т заасан этгээдэд орлого хуваарилах он, сар, өдөр, газар, орлого хуваарилахад гаргах шаардлага, нотлох баримтыг хүргүүлж болох хаягийн талаарх мэдэгдлийг хүргүүлэх бөгөөд уг мэдэгдлийг энэ хуулийн 50.3-т заасан мэдэгдэлтэй хамт, эсхүл тусад нь хүргүүлж болно.
54.3.Барьцаалагч энэ хуулийн 54.1-д заасны дагуу барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилахдаа дараах дарааллыг баримтална:
54.3.1.барьцааны зүйлийг эзэмшилдээ авах, хадгалах, худалдан борлуулахтай холбогдон гарсан бодит зардал;
54.3.2.энэ хуульд заасан өөрөөс өмнөх дарааллын шаардлага;
54.3.3.барьцааны эрхийг хэрэгжүүлж байгаа барьцаалагчийн өөрийн шаардлага;
54.3.4.барьцааны зүйлийг борлуулснаас олсон орлогыг хуваарилахаас өмнө энэ хуулийн 54.2-т заасан мэдэгдэл, нотлох баримт ирүүлсэн дарааллын хувьд дараах бусад барьцаалагчийн шаардлага.

СЭХ
оны 2023 сар 05 . 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

ИХ-ийн 156 дугаар зүйл болон Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлд[54] ипотекийн гэрээнд заавал тусгах агуулгыг заасан ба ХасБанк ХХК-ийн байгуулж буй ипотекийн гэрээнд дээрх бүх агуулга багтсан байна.

Барьцаа хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үндсэн зээлийн хэмжээ, хүү, нэмэгдүүлсэн хүү, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, улсын тэмдэгтийн хураамж, нөхөн төлүүлэх, шүүхийн зардал, барьцаа хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал, уг эд хөрөнгөтэй холбоотой төлсөн татвар, хураамж болон Банкнаас гарсан зардал, хохирлын хэмжээ зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр ипотекийн гэрээнд оруулсан байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.1 дэх заалтад барьцааны гэрээнд барьцаагаар хангагдах шаардах үүргийн хэмжээг тусгана гэж заасныг гэрээний дээрх заалт хангаж байна.

Ипотекийн гэрээнд барьцаа үл хөдлөх хөрөнгийг барьцаалуулагч нь өөрийн эзэмшилд байлган бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах ба барьцаа үл хөдлөх хөрөнгийг барьцааны гэрээний хугацаанд даатгуулах үүргийг хүлээлгэсэн байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 22 дугаар зүйлд даатгалд даатгуулах эсэхийг талууд гэрээгээр тохиролцохоор нээлттэй үлдээсэн байна. Мөн ипотекийн гэрээ, барьцаалбар зэргийг бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцааг баталгаажуулах үүргийг барьцаалуулагч хүлээсэн. Энэ тухай ИХ-ийн 166 дугаар зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 12 дахь хэсгийг зүйлчилсэн байна.

Барьцаалуулагч нь барьцааны зүйлийг худалдах, арилжих, бэлэглэх зэргээр бусдын өмчлөлд шилжүүлэх мөн барьцааны зүйлийг бусдад давхар барьцаалах эрхтэй байх ба энэ тохиолдолд барьцаалагч талд заавал мэдэгдэх үүрэгтэй байхаар ипотекийн гэрээнд заажээ. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 20 дугаар зүйлд зааснаар “Барьцаалуулагч барьцааны зүйлийг зориулалтынх нь дагуу ашиглах эрхтэй” байна. Харин 30 дугаар зүйлд барьцааны зүйлийг гуравдагч этгээдэд түрээслэх, хөлслөх, үнэ төлбөргүйгээр түр ашиглуулах зорилгоор бусдын эзэмшилд шилжүүлэх эрхтэй байхаар заажээ. Хэрэв энэ эрхийг хязгаарласан гэрээний нөхцөл байгаа бол тухайн нөхцөл хүчин төгөлдөр бус байхаар зүйлчилсэн байна. Мөн хуулийн 28 дугаар зүйлд барьцааны зүйлийг өмчлөлдөө шилжүүлэн авсан этгээд өмнөх барьцаалуулагчийн эрх, үүргийг хэрэгжүүлэхээр зүйлчилсэн байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй, зээлийн гэрээний хугацаа дууссан тохиолдолд Банк нь барьцаа хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ зээлдэгчид зээлийн гэрээний үүргийг гүйцэтгэх хугацаа зааж, барьцаанаас үүргийн гүйцэтгэлийг хангуулах тухай мэдэгдлийг барьцаалуулагч талд мэдэгдэхээр ипотекийн гэрээнд заасан байна. Энэ нь ИХ-ийн 174 дугаар

---

[54] **Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай (2009).**
11 дүгээр зүйл.**Барьцааны гэрээний агуулга**
11.1.Барьцааны гэрээ (цаашид "гэрээ" гэх)-г Иргэний хуулийн нийтлэг журам, энэ хуулийг баримтлан бичгээр байгуулах бөгөөд түүнд Иргэний хуулийн 156.2-т зааснаас гадна дараах зүйлийг тусгана:
11.1.1.барьцаагаар хангагдах шаардлага, түүний хэмжээ, хэрэв үнэ буюу төлбөрийн хэмжээг урьдчилан тогтоогоогүй бол түүнийг тодорхойлох журам;
11.1.2.барьцаагаар хангагдах үүргийг гүйцэтгэх хугацаа, үүрэг нь өөр гэрээнд үндэслэсэн бол уг гэрээний талууд, гэрээг байгуулсан он, сар, өдөр, түүнтэй холбоотой бусад нөхцөл;
11.1.3.барьцааны зүйлийн байршил, тухайн зүйл нь барьцаалуулагчийн өмч мөн болохыг нотлох баримт, эд хөрөнгийн өмчлөх эрхийг бүртгэсэн байгууллагын нэр, өмчлөх эрхийн гэрчилгээний дугаар;
11.1.4.барьцааны зүйлийг өөр этгээдэд барьцаалуулсан эсэх тухай лавлагаа;
11.1.5.барьцаагаар хангагдах үүргийг хэсэгчлэн гүйцэтгэх бол төлбөр гүйцэтгэх хугацаа, давтамж, хэмжээ, эсхүл тэдгээрийг тодорхойлох журам;
11.1.6.барьцааны шаардлагыг хангах журам;
11.1.7.барьцаалагчийн эрх нь барьцаалбараар гэрчлэгдэх эсэх тухай заалт;
11.1.8.барьцааны зүйл нь үл хөдлөх эд хөрөнгөтэй холбоотой эрх бол тухайн эрхийг олж авсан гэрээний үндсэн нөхцөл, хугацаа;
11.1.9.барьцааны зүйлтэй холбоотой гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх;
11.1.10.бусад.
11.2.Хуульд заасан бөгөөд талууд гэрээгээр тохиролцсон бол барьцааны зүйлээс шаардлагыг шүүхээс гадуур хангаж болно.
11.3.Энэ хуулийн 11.2-т заасан гэрээнд барьцааны зүйлийг шүүхээс гадуур худалдах аргын талаар нарийвчлан заана.

2023 05 12
БҮРТГЭВ
№ 01
МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

зүйл[55], Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 41-42 дугаар зүйлтэй[56] нийцэж байна. Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.3 дахь хэсэгт "Барьцаалагч нь тухайн эд хөрөнгөөс үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар шаардахын өмнө бусад барьцаалагчид энэ тухай бичгээр мэдэгдэх үүрэгтэй" байхаар зүйлчилсэн байна. Хуулийн энэ зохицуулалтыг ипотекийн гэрээнд тусгаагүй ч Банкны зүгээс хуулийн хүрээнд ийнхүү мэдэгдэх үүрэг хүлээх юм. Ипотекийн гэрээнд барьцааны зүйлээс үүргийг хангах дараах аргуудыг зааж талууд чөлөөтэй сонгож болохоор заажээ. Үүнд шүүхийн журмаар, шүүхээс гадуур шууд худалдах, шүүхээс гадуур дуудлага худалдаагаар худалдах зэрэг юм. Ипотекийн гэрээнд барьцааны зүйлийг худалдах дээрх аргуудыг задлан арга тус бүрээр зохицуулалтыг тусгасан ба энэ нь ИХ-ийн 175-181 дүгээр зүйл, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хуулийн 45-52 дугаар зүйлтэй нийцэж байгааг тэмдэглэж байна.

ИХ-ийн 156 дугаар зүйлийн 156.1 дэх хэсэгт барьцааны гэрээг нотариатаар гэрчлүүлж болно гэж заасан бол ипотекийн гэрээнд нотариатаар гэрчлүүлж холбогдон гарах зардлыг барьцаалуулагч тал хариуцахаар зохицуулжээ.

**(v) Фидуцийн гэрээ**

Үүргийн гүйцэтгэлийг хангуулах аргуудын нэг нь фидуцийн гэрээ юм. Фидуцийн гэрээгээр үүрэг гүйцэтгэгч нь мөнгөн хөрөнгө төлөх үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлдэг онцлогтой. Банк нь фидуцийн гэрээний загварыг 2022 оны №А-1001 дугаартай Гүйцэтгэх захирлын тушаалаар өөрчлөн найруулсан байна.

Банкны фидуцийн гэрээнд "үүрэг хүлээгч нь Банктай байгуулсан зээлийн гэрээгээр хүлээсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор өөрийн өмчлөлийн хөдлөх эд хөрөнгийг Банкны өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч нь зээлийн гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэсэн тохиолдолд Банк уг эд хөрөнгийг түүний өмчлөлд буцаан шилжүүлэхтэй холбоотой харилцаанд талуудын эдлэх эрх, хүлээх үүргийг тодорхойлно" гэсэн байна. Энэ нь ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.1 дэх хэсэгт[57] заасантай нийцэж байна.

---

[55] **Иргэний хууль (2002).**
174 дүгээр зүйл.**Үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах**
174.1.Ипотекийн шаардлагыг хангах хугацааг үүрэг гүйцэтгэгч хэтрүүлсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч нь үл хөдлөх эд хөрөнгийг худалдахыг шаардах эрхтэй.
174.4.Ипотекийн зүйлийг шүүхийн бус журмаар худалдан борлуулах журмыг хуулиар тогтооно.

[56] **Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль (2009).**
41 дүгээр зүйл.**Үүргийн гүйцэтгэлийг шаардах**
41.1.Үүрэг гүйцэтгэгч болон барьцаалуулагч нь үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор биелүүлээгүй бол барьцаалагч нь үүргийн гүйцэтгэлийг шаардах эрхтэй.
41.2.Энэ хуулийн 41.1-д заасан барьцаалагчийн шаардлагыг биелүүлээгүй бол үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулахаар барьцааны зүйлийг худалдахыг шаардах эрхтэй.
41.3.Барьцааны зүйлийг давхар барьцаалсан бол барьцаалагч нь энэ хуулийн 41.2-т заасан эрхээ хэрэгжүүлэхдээ бусад барьцаалагч болон барьцаалуулагчид, барьцаалуулагч нь гуравдагч этгээд бол үүрэг гүйцэтгэгчид, барьцааны зүйл нь түрээсийн зүйл бол түрээслүүлэгчид урьдчилан мэдэгдэх үүрэгтэй.
42 дугаар зүйл. **Барьцаалуулагчид мэдэгдэл хүргүүлэх**
42.1.Барьцаалагч нь энэ хуулийн 41.1-д заасны дагуу үүргийн гүйцэтгэлийг шаардах тухайгаа барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгчид бичгээр мэдэгдэнэ.
42.2.Барьцаалуулагч болон үүрэг гүйцэтгэгч нь мэдэгдэлд заасан хугацаанд хариу өгөөгүй бол барьцаалагч нь энэ тухай улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлж барьцаалуулагч болон тухайн барьцааны зүйлтэй холбоотой эрхээ бүртгүүлсэн гуравдагч этгээдэд үүргийн гүйцэтгэлийг барьцааны зүйлээс хангуулах тухайгаа бичгээр мэдэгдэнэ.
42.3.Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдэлд 30 хоногийн дотор барьцаалуулагч хариу өгөөгүй буюу үүргээ биелүүлээгүй бол барьцаалагч нь барьцааны зүйлийг худалдах ажиллагааг эхлүүлнэ.
42.4.Энэ хуулийн 42.2-т заасан мэдэгдлийн маягт болон мэдэгдлийг хүргүүлэх журмыг бүртгэлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллага батална.

[57] **Иргэний хууль (2002).**
235 дугаар зүйл.**Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээ (фидуци)**
235.1.Үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар эд хөрөнгө өмчлөлд шилжүүлэх гэрээгээр (цаашид "фидуци" гэх) үүрэг хүлээгч нь мөнгө төлөх үндсэн үүргийн гүйцэтгэлийг хангах зорилгоор хөдлөх эд хөрөнгийг үүрэг гүйцэтгүүлэгчийн өмчлөлд шилжүүлэх, үүрэг хүлээгч үндсэн үүргээ хугацаанд гүйцэтгэсэн тохиолдолд үүрэг гүйцэтгүүлэгч уг эд хөрөнгийг түүнд буцаан өгөх үүргийг тус тус хүлээнэ.

СЗХ
2023 он 05 сар 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

Фидуцийн гэрээг талууд бичгээр байгуулж гарын үсэг зурж тамга, тэмдэг дарах баталгаажуулах ба зээлийн гэрээний нэг хэсэг байхаар заасан байна. ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.5 дахь хэсэгт фидуцийн гэрээг хуульд өөрөөр заагаагүй бол бичгээр байгуулна гэж заасан байна. Фидуцийн гэрээнд харилцан тохиролцож нэмэлт, өөрчлөлт оруулах, цуцлах, дуусгавар болгох, маргаан гарсан тохиолдолд харилцан тохиролцож шийдвэрлэх, маргаанаа шүүхээр шийдвэрлүүлэх эрх нь талуудад нээлттэй байхаар тусгасан байна.

Фидуцийн гэрээнд фидуцийн хөрөнгө гэж үүрэг хүлээгчийн хууль ёсны өмчлөлийн эрхийн болон биет байдлын доголдолгүй хөдлөх эд хөрөнгө бөгөөд бусдад барьцаалуулаагүй, шилжүүлээгүй, гуравдагч этгээдийн эд хөрөнгийн эрх байхгүй байна гэж тодорхойлжээ. Фидуцийн хөрөнгийг дундаа хамтран өмчлөгч байгаа бол фидуцийн гэрээнд мөн гарын үсэг зуруулахаар заасан байна.

Фидуцийн хөрөнгөөр хангагдах шаардлагын хэмжээг зээлийн гэрээний дагуу хүлээсэн үүргийн нийт дүн, барьцаа хөрөнгийг худалдан борлуулахад гарсан зардал, фидуцийн хөрөнгийг арчлан хамгаалахад гарсан зардал болон Банкнаас гарсан зардал зэргийн нийлбэрээр хэмжигдэхээр фидуцийн гэрээнд оруулсан байна.

Фидуцийн гэрээнд үүрэг хүлээгч нь зээлийн гэрээний дагуу зээл олгогдохоос өмнө фидуцийн хөрөнгийг Банкны өмчлөлд шилжүүлэх, эрх бүхий байгууллагад бүртгүүлж гэрчилгээ авах, даатгуулах зэрэг арга хэмжээг авч холбогдон гарах зардлыг хариуцахаар заасан байна. Хэрэв эдгээр үүргийг гүйцэтгээгүй бол Банк нь зээлийн гэрээний дагуу зээл олгохоос татгалзах эрхтэй байхаар уг гэрээнд тусгасан байна. Фидуцийн гэрээний хугацаанд фидуцийн хөрөнгийг үүрэг хүлээгч тал нь эзэмших ашиглах эрхтэй байхаар заасан ба бүрэн бүтэн байдал болоод засвар үйлчилгээг хариуцах үүрэг хүлээнэ. ИХ-ийн 235 дугаар зүйлийн 235.2 дахь хэсэгт фидуцийн хөрөнгийг гэрээнд заасан бол үүрэг хүлээгч ашиглах эрхтэй байж болохоор заасан байна. Мөн фидуцийн хөрөнгийг ашиглах явцад үүрэг гүйцэтгэгч нь фидуцийн хөрөнгийг гэмтээсэн, устгасан бол ижил төрлийн эсхүл өөр эд хөрөнгөөр сольж Банкны өмчлөлд шилжүүлнэ. Үүрэг хүлээгч нь фидуцийн хөрөнгийг эзэмших, ашиглах явцдаа гуравдагч этгээдийн эд хөрөнгөд хохирол учруулсан бол үүсэн гарах үр дагаврыг бие даан бүрэн хариуцахаар фидуцийн гэрээнд зохицуулсан байна.

Зээлдэгч нь үүргээ гүйцэтгээгүй эсхүл гэрээний үүргээ ноцтой зөрчсөн тохиолдолд Банк нь фидуцийн хөрөнгөөс үүргийг хангуулах эрхтэй болох ба ингэхдээ үүрэг гүйцэтгэгчээс фидуцийн хөрөнгийг бодитоор гаргуулан авна. Фидуцийн хөрөнгийг Банк хүлээн авах үнэлгээ болон фидуцийн хөрөнгийн бодит үнэлгээ хэт зөрүүтэй гэж үзвэл дуудлага худалдаагаар худалдуулах санал гаргаж болно. Энэ тохиолдолд Банк нь өдөр тутмын сонин ашиглан нийтэд нээлттэй байдлаар дуудлага худалдаагаар худалдах санал болгох бөгөөд зар гарснаас хойш 1 сарын дотор дуудлага худалдаанд оролцох санал ирээгүй, дуудлага худалдаа болоогүй, анхны үнээс дээш саналыг нэг ч оролцогч санал болгоогүй бол Банк нь өөрийн үнэлгээгээр үл маргах журмаар авахаар фидуцийн гэрээнд заасан байна.

**Дүгнэж үзвэл ХасБанк ХХК-ийн зээлийн гэрээ болон үүргийн гүйцэтгэлийг хангах бусад гэрээ нь Иргэний хууль, Банкны тухай хууль, Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, мөнгөн хөрөнгийн шилжүүлэг, зээлийн үйл ажиллагааны тухай хууль, Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль, Үл хөдлөх эд хөрөнгийн барьцааны тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна. Эдгээр гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Банкны Гүйцэтгэх захирлын 2020 оны №А-288 дугаартай *“ХасБанкийг төлөөлөн гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эрхийн хэмжээ”* тушаалаар баталгаажуулсан байна.**

**Гурав. Банкны үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад гэрээ**

Үнэт цаас гаргагчийн зүгээс гэрээг тасалбар болгох өдрийн байдлаар иргэн, хуулийн этгээд, төрийн байгууллагатай байгуулсан бусад 1,343 (нэг мянга гурван зуун дөчин гурван) гэрээ

446

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

байгаагаас хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 640 (зургаан зуун дөчин) гэрээний мэдээллийг өгсөн ба дурдсан хугацаанаас өмнө байгуулсан боловч хүчин төгөлдөр үйлчилж байгаа 52 (тавин хоёр) гэрээг нийлүүлэн нийт 692 (зургаан зуун ерэн хоёр) гэрээг Хуулийн фирмийн зүгээс үзэж танилцлаа. Эдгээр гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Банкны зүгээс бусадтай байгуулсан үйл ажиллагаанд ач холбогдол бүхий бусад гэрээ гэдэгт (i) худалдах, худалдан авах гэрээ; (ii) үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ; (iii) ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ; (iv) даатгалын гэрээ; болон (v) бусад гэрээнүүд багтах ба Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээнүүдийг хууль тогтоомж, Банкны дотоод үйл ажиллагаанд мөрдөгдөж байгаа дүрэм, журамд нийцсэн эсэхэд дүгнэлт өгөх болно.

**(i) Худалдах, худалдан авах гэрээ**

Банкны бусадтай байгуулсан худалдах, худалдан авах гэрээний хувьд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар 104 (нэг зуун дөрөв) гэрээ хүчин төгөлдөр үйлчилж байна. Эдгээр гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны №А-225 тоот *"Банкны дотоод үйл ажиллагаанд хэрэглэх зарим төрлийн гэрээний загварыг шинэчлэн батлах тухай"* тушаалын хавсралтаар эд хөрөнгө, тээврийн хэрэгсэл, орон сууц, үл хөдлөл эд хөрөнгө худалдах, худалдан авах гэрээний төслүүдийг шинэчлэн баталсан байна. Зарим тохиолдолд Банк нь өөрийн боловсруулсан гэрээний төслийг ашиглалгүй гэрээний нөгөө талаас боловсруулсан төслийн дагуу худалдах худалдан авах гэрээг байгуулсан байна. Ингэхдээ заавал Банкны хуульч гэрээг хянаж тэмдэг даран хянасан болохоо баталгаажуулдаг байна.

Банкнаас боловсруулсан худалдах, худалдан авах гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

(i) Эрхийн болон биет байдлын доголдолгүй барааг Банкны өмчлөлд шилжүүлэх төлбөрийг гэрээнд заасны дагуу шилжүүлэхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах;
(ii) Барааны шинж чанар, загвар, тоо ширхэг, үзүүлэлт, иж бүрдэл, бүрэн бүтэн байдал, баталгаа, үйлдвэрлэгчийн мэдээлэл, ашиглалтын байдал, элэгдэл зэрэг дэлгэрэнгүй мэдээллийг оруулж хавсаргах;
(iii) Барааг нийлүүлэх хугацаа, хүргэх газар, барааны сав баглаа боодол, тээвэрлэх нөхцөл, барааг хүлээн авах, хүлээлгэн өгөх журам;
(iv) Талуудын эрх, үүрэг;
(v) Барааг нийлүүлэх үед болон хүлээн авсны дараа доголдолтой эсхүл гэрээнд заасан шаардлагыг хангахгүй болох нь илэрхий болсон үед талуудын авах арга хэмжээний талаар;
(vi) Баталгаат хугацааны явцад гарсан эвдрэл, гэмтлийг хэрхэн шийдвэрлэх талаар;
(vii) Гэрээний үнэ, төлбөр төлөх журам;
(viii) Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хэмжээ, анз;
(ix) Гэрээг цуцлах нөхцөл, болон бусад.

Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болохоор худалдах худалдан авах гэрээнд заасан ба ИХ-ийн 243-257 дугаар зүйлд худалдах худалдан авах гэрээний зохицуулалттай нийцэж байна.

**(ii) Үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээ**

ХасБанк ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнээс үзвэл нийт 152 (нэг зуун тавин хоёр) түрээсийн гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр түрээсийн гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

447

СЗХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023-05-05

Хуулийн фирмээс үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг хуульд нийцсэн эсэхийг шалгахдаа Банкны түрээсэлж буй байр, талбайн хэмжээгээр үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ гарсан тохиолдолд түрээсийн гэрээг ИХ-ийн 318 дугаар зүйлийн 318.3 дахь хэсэгт заасны дагуу улсын бүртгэлийн газрын бүртгүүлэх хуулийн зохицуулалтыг үндэслэл болгон авч үзлээ.

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны №А-225 тоот *"Банкны дотоод үйл ажиллагаанд хэрэглэх зарим төрлийн гэрээний загварыг шинэчлэн батлах тухай"* тушаалын хавсралтаар үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээний төслүүдийг шинэчлэн баталсан байна. Зарим тохиолдолд Банк нь өөрийн боловсруулсан гэрээний төслийг ашиглалгүй гэрээний нөгөө талаас боловсруулсан төслийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээг байгуулсан байна. Ингэхдээ заавал Банкны хуульч гэрээг хянаж тэмдэг даран хянасан болохоо баталгаажуулдаг байна.

Банкнаас боловсруулсан үл хөдлөх эд хөрөнгийн түрээсийн гэрээнд дараах зохицуулалтуудыг оруулсан байна. Үүнд:

(i) Түрээслүүлэгчийн өөрийн өмчлөлийн үл хөдлөх эд хөрөнгийн нийт талбайгаас тодорхой талбайг албан тасалгаа, үйлчилгээний зориулалтаар эзэмшиж, ашиглуулахаар түрээслэгчид шилжүүлэх гэрээгээр тохирсон төлбөрийг төлөхтэй холбогдон үүсэх харилцааг зохицуулах;
(ii) Түрээслүүлэх үл хөдлөх эд хөрөнгийн байрлал, хэмжээ, ашиглалтын нөхцөл;
(iii) Гэрээний үргэлжлэх хугацааг тодорхой зааж гэрээний хугацаа дуусахад хэрхэн сунгах нөхцөл;
(iv) Түрээсийн төлбөрийг тодорхой зааж, хэрхэн төлөх, үнэ өөрчлөгдөх тохиолдолд хэрхэн шийдвэрлэх;
(v) Түрээсийн хөрөнгөтэй холбогдон гарах урсгал зардлыг хэрхэн хуваарилах, түрээсийн хөрөнгийн засан сайжруулсан тохиолдолд тухайн зардлыг хэрхэх;
(vi) Талуудын эрх, үүрэг;
(vii) Түрээсийн хөрөнгийг хүлээлгэн өгөх, хүлээн авах журам;
(viii) Талуудын хүлээх хариуцлага, хариуцлагын хязгаарлалт, анз;
(ix) Гэрээг хугацаанаас нь өмнө цуцлах нөхцөл болон бусад.

Гэрээнд зааснаар Түрээслүүлэгч тал нь гэрээг Улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлэх холбогдон гарах зардлыг хариуцах ба хэрэв энэ үүргээ хэрэгжүүлээгүй бол холбогдон гарах үр дагаврыг дангаар хариуцахаар заасан байна. Хэдийгээр түрээсийн гэрээг түрээслүүлэгч тал холбогдох төрийн эрх бүхий байгууллагад бүртгүүлэх үүрэг хүлээж байгаа боловч ийнхүү бүртгүүлээгүй бол гэрээ хүчин төгөлдөр бусад тооцогдох эрсдэлтэй. Иймд Банкны зүгээс тухайн гэрээ бүртгэгдсэн эсэхийг лавлаж хэрэв үгүй бол бүртгүүлэх тал дээр анхаарал хандуулах шаардлагатай. Талуудын эрх бүхий төлөөлөгчид гэрээнд гарын үсэг зурж тамга, тэмдэг дарснаар хүчин төгөлдөр болохоор уг гэрээнд заасан ба ИХ-ийн 318-320 дугаар зүйлд заасан зохицуулалттай нийцэж байна.

**(iii) Ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээ**

Гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Банкны бусадтай байгуулсан хүчин төгөлдөр үйлчилж байгаа ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2021 оны №А-225 тоот *"Банкны дотоод үйл ажиллагаанд хэрэглэх зарим төрлийн гэрээний загварыг шинэчлэн батлах тухай"* тушаалын хавсралтаар ажил гүйцэтгэх гэрээ болон хөлсөөр ажиллах гэрээний хэд хэдэн төслүүдийг шинэчлэн баталсан байна. Зарим тохиолдолд Банк нь өөрийн боловсруулсан гэрээний төслийг ашиглалгүй гэрээний нөгөө талаас боловсруулсан төслийн ажил гүйцэтгэх, хөлсөөр ажиллах гэрээг байгуулсан байна. Ингэхдээ заавал Банкны хуульч гэрээг хянаж тэмдэг даран хянасан болохоо баталгаажуулдаг байна.

Банк нь тухайн байгуулсан гэрээг "Ажил гүйцэтгэх гэрээ", "Үйлчилгээ үзүүлэх гэрээ", "Хамтран ажиллах гэрээ" гэж нэрлэсэн байх боловч гэрээний шинж чанар болон үүргээс хамаарч

448

ИХ-ийн 359 дүгээр зүйлд[58] заасан "Хөлсөөр ажиллах гэрээ"-ний онцлогийг агуулсан байх тул түүгээр зохицуулагдах тохиолдол бий. Мөн зарим нэг төрлийн "Хамтын ажиллагааны гэрээ", "Хамтран ажиллах гэрээ" нь ИХ-ийн 343 дугаар зүйлд[59] заасан "Ажил гүйцэтгэх гэрээ"-ний хүрээнд зохицуулагдахаар байна. Өөрөөр хэлбэл холимог гэрээний хувьд тухайн гэрээний оноосон нэрнээс илүүтэй гэрээний гүйцэтгэлд илүү төсөөтэй тухайн төрлийн гэрээг зохицуулсан хуулийн хэм хэмжээг анхаарах шаардлагатай. Энэ тухай ИХ-ийн 198 дугаар зүйлийн 198.5 дахь хэсэгт тодорхой заасан байна.

Эдгээр ажил гүйцэтгэх гэрээ нь ИХ-ийн 343 дугаар зүйл болон 359 дүгээр зүйлд заасан агуулгын шаардлагыг хангасан, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан байх тул гэрээнд тавигдах агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

### (iv) Даатгалын гэрээ

ХасБанк ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээнээс үзвэл нийт 51 (тавин нэгэн) даатгалын гэрээ гэрээ хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Эдгээр даатгалын гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Банк нь ажиллагсдын гэнэтийн ослын даатгал, хариуцлагын даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгал, олон улсын эрүүл мэндийн даатгал, эрүүл мэндийн даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, эд хөрөнгийн даатгал, үл хөдлөх эд хөрөнгийн даатгал зэрэг гэрээнүүдийг байгуулж эрсдэлийг хязгаарласан байна. Энд дурдсан даатгалын гэрээ нь ИХ-ийн 431 дүгээр зүйлийн 431.4[60] дэх хэсэгт заасан агуулгын шаардлагыг хангасан, бичгээр байгуулж, талуудыг төлөөлөх эрх бүхий этгээд гарын үсэг зурж, тамга, тэмдгээр баталгаажуулсан байх тул даатгалын гэрээнд тавигдах агуулгын болон хэлбэрийн шаардлагыг хангасан байна гэж үзлээ.

### (v) Бусад гэрээ

ХасБанк ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан бөгөөд гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа бусад гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №04. "ХасБанк ХХК-ийн үйл ажиллагаанд чухал ач холбогдол үзүүлэх бусад хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Бусад төрлийн гэрээнд нууц хадгалах гэрээ, тодорхой төрлийн төлбөрийн карт гаргахад хамтран ажиллах, сургалтын төлбөрийг хариуцах гэрээ, АТМ машин түр байршуулах гэрээ, төрийн байгууллагатай байгуулдаг тодорхой төрлийн гэрээ, санамж бичиг зэрэг гэрээнүүд багтаж байна.

---

[58] **Иргэний хууль (2002).**
359 дүгээр зүйл.**Хөлсөөр ажиллах гэрээ**
359.1. Хөлсөөр ажиллах гэрээгээр ажиллагч нь тохиролцсон ажил, үйлчилгээг гүйцэтгэх, ажиллуулагч хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.
359.2. Энэ гэрээний зүйл нь бүх төрлийн ажил, үйлчилгээ байж болно.

[59] **Иргэний хууль (2002).**
343 дугаар зүйл.**Ажил гүйцэтгэх гэрээ**
343.1. Ажил гүйцэтгэх гэрээгээр ажил гүйцэтгэгч нь захиалагчийн буюу өөрийн материалаар гэрээнд заасан ажил гүйцэтгэх, захиалагч нь уг ажлын үр дүнг хүлээн авч, хэлэлцэн тохирсон хөлс төлөх үүргийг тус тус хүлээнэ.

[60] **Иргэний хууль (2002).**
431 дүгээр зүйл.**Даатгалын гэрээ**
431.4. Даатгалын гэрээнд дараах нөхцөлийг тусгана:
431.4.1. даатгалын зүйл;
431.4.2. даатгалын эрсдэлийн төрөл;
431.4.3. даатгалын үнэлгээний хэмжээ;
431.4.4. даатгалын хугацаа, түүнийг дахин сунгах нөхцөл;
431.4.5. даатгалын хураамжийн хэмжээ, түүнийг төлөх хугацаа;
431.4.6. даатгагч, даатгуулагчийн эрх, үүрэг, хариуцлага;
431.4.7. гэрээг дүгнэх, цуцлах, түүнд өөрчлөлт оруулах нөхцөл.

СЭЗ 2023 05 12 өдөр БҮРТГЭВ № 01

Дүгнэж үзвэл ХасБанк ХХК-ийн иргэн, хуулийн этгээдтэй байгуулдаг худалдах, худалдан авах гэрээ, түрээсийн гэрээ, ажил гүйцэтгэх гэрээ, даатгалын гэрээ болон бусад гэрээ нь Иргэний хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нийцсэн хүчин төгөлдөр гэрээ байна. Эдгээр гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулах эрхийг Гүйцэтгэх захирлын 2020 оны №А-288 дугаартай "ХасБанкийг төлөөлөн гэрээ байгуулах эрх бүхий албан тушаалтан, тэдгээрийн эрхийн хэмжээ" тушаалаар баталгаажуулсан байна.

**Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээ, тэдгээрийн хэрэгжилтийн тухай.**

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд буюу 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэлх Банкны бусадтай бичгээр байгуулсан, Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээг гаргуулан авч хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа гэрээг сонгон авч дүн шинжилгээ хийлээ. Компанийн тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.1 дэх хэсэгт "Тухайн компаниас хувьцаа эзэмшигчдэд эзэмшүүлсэн буюу гаргасан нийт давуу эрхийн болон энгийн хувьцааны нэрлэсэн үнийн дүнг компанийн хувь нийлүүлсэн хөрөнгө гэх бөгөөд компанийн хувь нийлүүлсэн хөрөнгөд тухайн компанийн зарласан болон эргүүлэн худалдаж авсан халаасны хувьцаа хамаарахгүй" гэж заасан байна.

ХасБанк ХХК нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээнд 3 (гурван) удаа өөрчлөлт орж, улсын бүртгэлд бүртгүүлсэн байх тул хувь нийлүүлсэн хөрөнгийн өөрчлөлт тухай бүрд Үнэт цаас гаргагчийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувийг дараах байдлаар тооцлоо. Үүнд:

***Хүснэгт №14. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (таван) хувь (төгрөгөөр).***

| № | Хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ (төгрөгөөр) | 2015.12.16 - 2021.09.20 | 2021.09.20 - 2021.11.02 | 2021.11.02-2021.12.31 |
|---|---|---|---|---|
| 1. | Хувь нийлүүлсэн хөрөнгө | 55,342,753,311 | 58,625,979,311 | 100,000,000,000 |
| 2. | Хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 хувь | 2,767,137,665 | 2,931,298,965 | 5,000,000,000 |

Үнэт цаас гаргагч нь гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар байгуулсан, Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн нийт 65 (жаран таван) гэрээний мэдээллийг Хуулийн фирмд жагсаалтаар гаргаж өгсөн. Энэ жагсаалтаас гэрээг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр үйлчилж байгаа болон дурдсан хугацаанаас өмнө байгуулсан боловч хүчин төгөлдөр үйлчилж байгаа 28 (хорин найман) гэрээний мэдээллийг үзэж танилцлаа. Эдгээр гэрээний мэдээлэлтэй **Хавсралт №05. "ХасБанк ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээнүүд нь гадны банк, хөрөнгө оруулалтын сан болон санхүүгийн байгууллагуудаас авсан зээлийн гэрээ байна. Мөн эдгээр зээлийн гэрээг Банкнаас баталсан зээлийн гэрээний төслөөр бус зээл олгогч талаас боловсруулсан гэрээний төслөөр байгуулсан байна. Бүрэн Скор ЗМС ХХК-ийн 2023 оны 02 сарын 10-ны өдрийн Зээлийн мэдээллийн лавлагаанаас үзвэл ХасБанк ХХК нь төлөгдөж дуусаагүй өр төлбөр байхгүй болохыг тодорхойлсон байна.

***Хүснэгт №15. Компанийн хувь нийлүүлсэн хөрөнгийн 5 (тав) болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн гэрээний төрлийн тоон үзүүлэлт.***

| № | Зээлийн гэрээ | 2020.01.01 -ээс өмнө | 2020.01.01 – 2021.01.01 | 2021.01.01 – 2022.01.01 | 2022.01.01 – 2023.01.01 | Нийт |
|---|---|---|---|---|---|---|
| 1. | Хүчин төгөлдөр гэрээний тоо | 11 | 2 | 4 | 11 | 28 |

450

Нууц баримт
Эх хувь

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 2. | Дуусгавар болсон гэрээний тоо | 17 | 11 | 9 | | 37 |
| | | | НИЙТ | | | 65 |

Эдгээр зээлийн гэрээнд бусад улсын хууль тогтоомжийг удирдлага болгохоор заасан бөгөөд талуудын хооронд маргаан гарсан тохиолдолд гадны хууль тогтоомжийг мөрдлөг болгон өөр улс оронд маргаанаа шийдвэрлүүлэхээр заасан байна. Иймд Хуулийн фирмийн зүгээс эдгээр гэрээний хүчин төгөлдөр байдал, зохицуулалтын талаар үнэлэлт, дүгнэлт өгөхгүй ба Банк нь хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болохын тулд гэрээний дагуу нөгөө талдаа мэдэгдэх, зөвшөөрөл авах шаардлагатай эсэхийг нягталсан болно. Үүнд:

(i) Green climate fund, 2017 он, Зээлийн гэрээ;
(ii) Зээлийн батлан даалтын сан, 2017 он, Хугацаатай хадгаламжийн гэрээ;
(iii) European Bank for Reconstruction and Development, 2018 он, Зээлийн гэрээ;
(iv) European Bank for Reconstruction and Development, 2019 он, Зээлийн гэрээ;
(v) DEG-Deutsche Investitions-Und Entwickicklungsgesellschaft BMH, Finnish Fund for Industrial Cooperation Ltd, SIFEM AG, International Finance Corporation, Societe de promotion et de participation pour la cooperation economique, 2019 он, Зээлийн гэрээ;
(vi) Green climate fund, 2019 он, Зээлийн гэрээ;
(vii) International Investment Bank, 2019 он, Зээлийн гэрээний 21 дугээр зүйл;
(viii) INFOFIN CVSO, 2019 он, Зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг;
(ix) Raisin Bank AG, 2019 он, Зээлийн гэрээний 6 дугаар зүйл;
(x) Asian development bank, 2019 он, Зээлийн гэрээний 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг;
(xi) Nederlandse financiaring-maatschappij voor ontiwikkelingslanden N.V, International bank for economic co-operation, The OPEC fund for international development, 2019 он, Зээлийн гэрээний 18 дугаар зүйлийн 6 дахь хэсэг болон болон 7 дахь хэсэг;
(xii) European Bank for Reconstruction and Development, 2020 он, Зээлийн гэрээ;
(xiii) Baobab Secutities Limited, 2020 он. Зээлийн гэрээ;
(xiv) Incofin CVSO CVBA-SO, 2021 он, Зээлийн гэрээний 12 дугаар зүйлийн 12.5 дахь хэсэг;
(xv) ResponsAbility Global Micro and SME Finance Fund, 2021 он, Зээлийн гэрээний 6 дугаар зүйл;
(xvi) Global Climate Partnership Fund S.A, 2021 он, Зээлийн гэрээний 17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсэг;
(xvii) European Bank for Reconstruction and Development, 2021 он, Зээлийн гэрээ;
(xviii) DWM Income Funds S.C.A – SICAV SIF, 2022 он, Зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг;
(xix) European Bank for Reconstruction and Development, 2022 он, Зээлийн гэрээ;
(xx) DWM Income Funds S.C.A – SICAV SIF, 2022 он, Зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.b дэх хэсэг;
(xxi) ACTIAM Financial Inclusion Fund & DWM Asset Management LLC, 2022 он, Зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.b дэх хэсэг;
(xxii) Microfinance Initiative for Asia (MIFA) Debt Fund SA, SICAV SIF, 2022 он, Зээлийн гэрээний 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг болон 6.6 дахь хэсэг;
(xxiii) Nederlandse Financierings-Maatshhappij voor Ontwikkelingslanden N.V, 2022 он, Зээлийн гэрээний 6 дугаар зүйлийн 6.1.0 дэх заалт;
(xxiv) Blueorchard Invest S.a.r.l, 2022 он, Зээлийн гэрээний 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг болон 6.6 дахь хэсэг;
(xxv) Blueorchard Invest S.a.r.l, 2022 он, Зээлийн гэрээний 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг болон 6.6 дахь хэсэг;
(xxvi) INCOFIN CVSO, IIV Mikrofinanzfonds, 2022 он, Зээлийн гэрээний 5 дугаар зүйлийн 5.3 дахь хэсэг;
(xxvii) Micro, Small and Medium Enterprises Bonds S.A, 2022 оны, Зээлийн гэрээний 3 дугаар зүйлийн 3.e.ii дэх заалт;
(xxviii) International Finance Corporation, 2022 он, Зээлийн гэрээ.

ХасБанк ХХК нь хэлбэрээ өөрчлөн хувьцаат компани болохын өмнө заавал нөгөө талдаа бичгээр мэдэгдэж хариу авсан байхыг дээрх гэрээнүүдийн дагуу шаардаж байна. Энд заасан үүргийнхээ дагуу Банк нь Зээлдүүлэгч талд албан бичгээр хүргүүлсэн мэдэгдэл болон ирсэн хариу

451

СЗХ
оны 2023 сарын 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

бичгийг Хуулийн фирмд хуулбар байдлаар гаргаж өгсөн. Тус материалаас үзвэл өнөөдрийн байдлаар 8 (найман) Зээлдүүлэгчээс зөвшөөрсөн хариу ирсэн байна. Эдгээр мэдээлэлтэй Хавсралт **№05. "ХасБанк ХХК-ийн хувь нийлүүлсэн хөрөнгийн тав болон түүнээс дээш хувьтай тэнцэх хэмжээний үнийн дүн бүхий үүрэг хүлээсэн хүчин төгөлдөр гэрээний мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

**Иймд ХасБанк ХХК нь гэрээний үүргээ хэрэгжүүлэн хувьцаат компани болох замаар Банкны хэлбэрийг өөрчлөх талаар албан ёсны мэдэгдлийг үлдсэн 20 (хорин) зээлдүүлэгчид хүргүүлж хариу авсан байхыг Хуулийн фирмийн зүгээс зөвлөж байна.**

**Тав. Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний болон сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль, тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх:**

Хуулийн фирм нь энэхүү шалгуур үзүүлэлтийн хүрээнд 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд ХасБанк ХХК-ийн бусадтай бичгээр байгуулсан гэрээ, хэлцэл дотор их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан хэдий ч 2023 оны 01 сарын 01-ний өдрийн байдлаар дуусгавар болоогүй хэрэгжиж байгаа их хэмжээний хэлцэл болон сонирхлын зөрчилтэй хэлцэл байгаа эсэх, байгаа нөхцөлд Компанийн тухай хуулийн дагуу хийгдсэн эсэх асуудлыг судалж үзлээ.

**(i) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн их хэмжээний хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:**

Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлийн 87.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй) болон 87 дугаар зүйлийн 87.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагчийн дүрмийн 19 дүгээр зүйлийн 19.1.1 дэх заалтад "хэлцэл хийхийн өмнөх сүүлийн балансын активын нийт дүнгийн 25 хувиас дээш зах зээлийн үнэтэй эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийг худалдах, худалдан авах, захиран зарцуулах болон барьцаалахтай холбогдсон хэлцэл, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн хэлцэл (компанийн өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон хэлцэл үүнд хамаарахгүй)" болон 19 дүгээр зүйлийн 19.1.2 дахь заалтад "компанийн урьд гаргасан энгийн хувьцааны 25 хувиас дээш хэмжээний энгийн хувьцаа, энгийн хувьцаа авах эрхийн бичиг буюу энгийн хувьцаанд хөрвөх үнэт цаас гаргах, эсхүл хоорондоо шууд холбоотой хэд хэдэн гаргалт"-ыг их хэмжээний хэлцэлд тооцохоор заасан байна.

Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-аас Хуулийн фирмд ирүүлсэн аудитын байгууллагаар баталгаажсан санхүүгийн тайлангаас балансын нийт актив[61] болон балансын активын 25 хувийн дүнг тооцож үзвэл дараах хэмжээтэй байна. Үүнд:

*Хүснэгт №16. Балансын активын 25%-ийн тоон үзүүлэлт.*

| № | Гэрээний нэр, төрөл | Тухайн улирлын балансын нийт актив (төгрөгөөр) | Тухайн улирлын балансын активын 25% (төгрөгөөр) |
|---|---|---|---|
| 1. | 2020 оны 1 улирал | 3,428,577,690 | 857,144,423 |
| 2. | 2020 оны 2 улирал | 3,419,097,155 | 854,774,289 |
| 3. | 2020 оны 3 улирал | 3,399,787,023 | 849,946,756 |

[61] "Балансын нийт актив" гэдэгт Санхүү байдлын тайлангийн 2.4 дэх мөр (хэвтээ үзүүлэлт) буюу "Өр төлбөр ба Эздийн өмч" гэсэн үзүүлэлтийн эцсийн үлдэгдэл гэсэн харгалзах баганад (босоо үзүүлэлт) байгаа мөнгөн хөрөнгийг тооцох ойлгосон болно. Хуулийн фирм.

452

| | | | |
|---|---|---|---|
| 4. | 2020 оны 4 улирал | 3,243,691,307 | 810,922,827 |
| 5. | 2021 оны 1 улирал | 3,271,386,628 | 817,846,657 |
| 6. | 2021 оны 2 улирал | 3,388,001,142 | 847,000,285 |
| 7. | 2021 оны 3 улирал | 3,434,969,134 | 858,742,283 |
| 8. | 2021 оны 4 улирал | 3,499,958,628 | 874,989,657 |
| 9. | 2022 оны 1 улирал | 3,501,227,949 | 875,306,987 |
| 10. | 2022 оны 2 улирал | 3,515,417,483 | 878,854,371 |
| 11. | 2022 оны 3 улирал | 3,537,072,282 | 884,268,071 |
| 12. | 2022 оны 4 улирал | 3,930,780,303 | 982,695,076 |

Дээрх хүснэгтэд тусгагдсан Үнэт цаас гаргагчийн хэлцэл хийхийн өмнөх балансын сүүлийн балансын активын 25 хувийн дүн болон Компаниас ирүүлсэн гэрээ, хэлцэл, мэдээлэлд үндэслэж үзвэл Компани нь дурдсан хугацааны дотор их хэмжээний их хэмжээний хэлцэл байхгүй байна.

ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 сарын 09-ний өдрийн №1/748 тоот Хуулийн фирмд ирүүлсэн Батламж гаргах тухай албан бичгээс үзвэл ХасБанк ХХК нь сүүлийн 3 (гурван) жилийн хугацаанд Компанийн тухай хуулийн 87 дугаар зүйлд тодорхойлсон их хэмжээний хэлцэл байгуулагдаагүй (Банкны өдөр тутмын үндсэн үйл ажиллагаатай холбогдсон гэрээ, хэлцэл хамаараагүй) болохыг тодорхойлсон байна.

Иймд Хуулийн фирмийн зүгээс ХасБанк ХХК-ийн Батламж гаргах тухай албан бичигт үндэслэн гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар ХасБанк ХХК нь их хэмжээний хэлцэл байгуулаагүй байна гэж дүгнэлээ.

**(ii) Сүүлийн 3 (гурван) жилийн дотор хийгдсэн сонирхлын зөрчилтэй хэлцэл нь холбогдох хууль тогтоомжийн дагуу хийгдсэн эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-аас 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд бусадтай бичгээр байгуулсан нийт гэрээ, хэлцлийн дотор сонирхлын зөрчилтэй хэлцэл байгуулагдсан эсэх, байгуулагдсан нөхцөлд Компанийн тухай хууль болон Банкны тухай хуулийн дагуу хийгдсэн эсэхийг судалж үзлээ.

Компанийн тухай хуулийн 89 дүгээр зүйлийн 89.1 дэх хэсэгт “Компанийн энгийн хувьцааны 20 буюу түүнээс дээш хувийг дангаараа, эсхүл түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшиж байгаа хувьцаа эзэмшигч, компанийн эрх бүхий албан тушаалтан, түүнтэй нэгдмэл сонирхолтой этгээд нь өөрийн ажиллаж байгаа болон хувьцааг нь эзэмшиж байгаа компанитай Компанийн тухай хуульд тодорхойлсон харилцаанд орсон бол компанитай, эсхүл түүний хараат болон охин компанитай сонирхлын зөрчилтэй хэлцэл хийх этгээдэд тооцогдоно” гэж тодорхой заасан байна.

Сонирхлын зөрчилтэй хэлцлийн хувьд Компанийн тухай хуулийн 92 дугаар зүйлийн 92.1 дэх хэсэгт заасан журмын дагуу байгуулдаг бөгөөд тус хэсэгт “сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхийг зөвшөөрөх тухай шийдвэрийг уг хэлцлийг хийх талаар сонирхлын зөрчилгүй төлөөлөн удирдах зөвлөл (байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал)-ын гишүүдийн олонхын саналаар гаргана”, 92 дугаар зүйлийн 92.2 дахь хэсэгт “Сонирхлын зөрчилтэй хэлцлээр худалдах, худалдан авах, захиран зарцуулах эд хөрөнгө, эд хөрөнгийн болон мөнгөөр үнэлж болох бусад эрхийн зах зээлийн үнэ, үйлчилгээний хөлсний хэмжээг энэ хуулийн 55 дугаар зүйлд заасан журмын дагуу төлөөлөн удирдах зөвлөл тогтооно”, Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.9 дэх хэсэгт[62] “Банкнаас холбогдох этгээдтэй хийх хэлцэл нь банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй байж болохгүй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд холбогдох хуульд заасан шаардлага, журмыг баримтална” гэж тодорхойлсон байна. Өөрөөр

[62] **Банкны тухай хууль (2010).**
17 дугаар зүйл.**Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт**
17.9.Банкнаас холбогдох этгээдтэй хийх хэлцэл нь банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй байж болохгүй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцэл хийхэд холбогдох хуульд заасан шаардлага, журмыг баримтална.

СЗХ
2023 05. 12
БҮРТГЭВ
№ 01

хэлбэл Банкны холбогдох этгээдтэй хийх хэлцэл нь Банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй байж болохгүй бөгөөд сонирхлын зөрчилтэй хэлцлийн үнийг Төлөөлөн удирдах зөвлөл тогтоох бөгөөд хэлцэл хийх зөвшөөрлийг сонирхлын зөрчилгүй Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийн олонхын саналаар зөвшөөрөл олгохоор хуулиар зохицуулсан байна.

ХасБанк ХХК-ийн зүгээс 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс 2023 оны 01 сарын 01-ний өдрийг хүртэл хугацаанд байгуулагдсан гэрээ, хэлцлийн жагсаалт болон Банкнаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэж үзвэл нийт 22 (хорин хоёр) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байгуулснаас тасалбар болгосон өдрийн байдлаар 15 (арван таван) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл хүчин төгөлдөр үйлчилж байна. Түүнчлэн 2020 оны 01 сарын 01-ний өдрөөс өмнө байгуулагдсан бөгөөд гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар хүчин төгөлдөр хэрэгжиж байгаа 7 (долоон) сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцэл байна. Иймд гэрээ, хэлцлийг тасалбар болгосон өдрийн байдлаар нийт 22 (хорин хоёр) сонирхлын зөрчилтэй хэлцэл хүчин төгөлдөр хэрэгжиж байна. Банкны Төлөөлөн удирдах зөвлөлийн 2022 оны №R-2022-27 тоот тогтоол, №R-2022-28 тоот тогтоол, №R-2022-35 тоот тогтоол, №R-2022-44 тоот тогтоол, №R-2022-48 тоот тогтоолоор тус 22 (хорин хоёр) сонирхлын зөрчилтэй хэлцэл хийснийг баталгаажуулсан байна. Эдгээр хүчин төгөлдөр хэрэгжиж буй сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн жагсаалт, гэрээний талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт №06. "ХасБанк ХХК-ийн сонирхлын зөрчилтэй гэрээ, хэлцлийн мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзэж танилцана уу.

**Дүгнэж үзвэл ХасБанк ХХК-аас нэгдмэл сонирхолтой этгээдтэй байгуулсан хүчин төгөлдөр хэрэгжиж буй 22 (хорин хоёр) сонирхлын зөрчилтэй хэлцлийг Банкны төлөөлөн удирдах зөвлөлөөс баталгаажуулсан тул холбогдох хуульд нийцсэн гэж үзэх үндэслэлтэй байна. Цаашид сонирхлын зөрчилтэй хэлцлийг Компанийн тухай хууль болон Банкны тухай хуульд заасан журмын дагуу хэлцэл хийх зөвшөөрлийг тухай бүр авч ажиллахыг Хуулийн фирмээс зөвлөж байна.**

**Зургаа. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийнллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, асуудлаар:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн зүгээс үйл ажиллагаа эрхлэхдээ хууль тогтоомжид заасны дагуу төрийн эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авахыг шаардсан буюу тодорхой төрлийн аж ахуйн үйл ажиллагааг тогтоосон хугацаа нөхцөл, шаардлагын дагуу эрхлэн явуулах эрхийг үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз гэсэн шалгуурын хүрээнд ойлгож дүн шинжилгээ хийлээ.

Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК нь Монголбанкнаас 2001 оны 12 сарын 27-ны өдөр олгосон №24 дугаартай "Банкны зөвшөөрлийн гэрчилгээ" тусгай зөвшөөрөл авсны үндсэн дээр банкны үйл ажиллагааг эрхэлж байна.

Хуулийн дүгнэлт гарах өдрийн байдлаар ХасБанк ХХК нь Монголбанкнаас олгосон 11 (арван нэгэн) тусгай зөвшөөрөл болон Санхүүгийн зохицуулах хорооноос олгосон 1 (нэг) тусгай зөвшөөрөл буюу нийт 12 (арван хоёр) тусгай зөвшөөрлийг эзэмшиж байна. Үүнд:

***Хүснэгт №17. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн мэдээлэл.***

| № | Тусгай зөвшөөрлийн үйл ажиллагааны төрөл | Тусгай зөвшөөрөл олгосон огноо, шийдвэрийн дугаар | Хүчинтэй эсэх Тийм/ Үгүй Лавлагааны огноо, дугаар |
|---|---|---|---|
| 1. | Мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл | Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал 2001.12.27 №610 | Тийм Монголбанк 2023.02.03 №А-10/138 |
| 2. | Гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах зөвшөөрөл | | |

454

СЗХ 2023 оны 05 сарын 12 өдөр БҮРТГЭВ № 01

MONGOLIAN STOCK EXCHANGE 2023-05-05 БҮРТГЭВ-02

| | | | |
|---|---|---|---|
| 3. | Үнэт зүйл хадгалах зөвшөөрөл | | |
| 4. | Хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөмж, мэдээлэл өгөх | | |
| 5. | Гадаад төлбөр тооцоо эрхлэх энгийн зөвшөөрөл | Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал 2002.10.28 №512 | |
| 6. | Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх нэмэлт зөвшөөрөл | Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал 2006.09.26 №424 | |
| 7. | Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа батлан даалт гаргах зөвшөөрөл | Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал 2006.09.26 №424 | |
| 8. | Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл | Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал 2011.06.17 №354 | |
| 9. | Үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах нэмэлт зөвшөөрөл | Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал 2013.12.30 №А-258 | |
| 10. | Зээл болон санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах нэмэлт зөвшөөрөл | Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал 2016.05.05 А-№107 | |
| 11. | Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл | Монголбанкны Ерөнхийлөгчийн тушаал 2016.12.07 №А-334 | |
| 12. | Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл | Санхүүгийн зохицуулах хорооны тогтоол 2012.12.26 №386 | Тийм Санхүүгийн зохицуулах хороо 2023.01.26 №9/266 |

Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз түүний эрх зүйн хүчин төгөлдөр байдалд учирч болзошгүй аливаа эрсдэл, төрийн эрх бүхий байгууллагаас цуцлах бодит үндэслэл байгаа эсэх талаар Банкны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэг, 16 дугаар зүйлийн 16.1.1 дэх заалт, 16.1.2 дахь заалт, 27 дугаар зүйлийн 27.1 дэх хэсэг[63], Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.3 дахь заалт, 24 дүгээр зүйлийн 24.5 дахь хэсэг, Зөвшөөрлийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, 6.2 дахь

[63] Банкны тухай хууль (2010).
16 дугаар зүйл.**Банкинд тавих шаардлага**
16.1.Банк дараах шаардлагыг хангаж ажиллана:
16.1.1.заавал байлгах нөөц, төлбөр түргэн гүйцэтгэх чадварыг Монголбанкнаас тогтоосон журмын дагуу зохих хэмжээ, хэлбэрээр хангахын зэрэгцээ хадгаламж эзэмшигч, харилцагчийн мөнгөн хөрөнгийг бүрэн байлгаж, тэдгээрийн анхны шаардлагаар гаргаж өгөх, шилжүүлэх;
16.1.2.хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, активын эрсдэл, зээл төлөгдөхөд учирч болзошгүй алдагдлаас хамгаалах сан, эх үүсвэрийн төвлөрөл, гадаад валютын болон бусад зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг Монголбанкнаас тогтоосон журам, шийдвэрийн дагуу биелүүлэх;
27 дугаар зүйл.**Банк байгуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох**
27.1.Монголбанк нь банк байгуулах тусгай зөвшөөрлийг дараах үндэслэлээр хүчингүй болгож нийтэд зарлана:
27.1.1.хуульд заасны дагуу банкийг татан буулгах тухай эрх бүхий байгууллагын шийдвэр гарсан;
27.1.2.энэ хуульд өөрөөр заагаагүй бол банк төлбөрийн чадваргүй болсон, эсхүл төлбөрийн чадваргүй болох гарцаагүй нөхцөл байдал үүссэн тухай Монголбанкны шийдвэр гарсан, эсхүл хувь нийлүүлсэн хөрөнгийн доод хэмжээний шаардлагыг биелүүлээгүй бол;
27.1.3.банк байгуулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь банкийг бүртгүүлснээс хойш илэрсэн;
27.1.4.банкийг улсын бүртгэлд бүртгүүлснээс хойш нэг жилээс дээш хугацаанд банкны үйл ажиллагаа эрхлээгүй;
27.1.5.банкны хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээ, бүтцэд өөрчлөлт оруулахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн;
27.1.6.банк энэ хуулийн 48 дугаар зүйлд заасан арга хэмжээг хэрэгжүүлээгүй, шаардлагыг биелүүлээгүй нь банкны үйл ажиллагаа, төлбөрийн чадварыг алдагдуулахад хүргэх ноцтой нөхцөл байдал үүсгэсэн.
27.1.7.энэ хуулийн 7.2.8, 7.2.10-т заасан харилцагчид хамаарах мэдээллийг татварын албанд гаргаж өгөөгүй үйлдэл нь харилцагчийн татвар төлөхөөс зайлсхийх, зугтах нөхцөл болсон нь тогтоогдож, энэ зөрчил хоёр ба түүнээс дээш удаа давтагдсан бол.

СЭХ
2023 он 05. 12 сар
БҮРТГЭВ
№ 01

хэсэг[64], Валютын зохицуулалтын тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.3.5 дахь заалт[65], Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.2.3 дахь заалт[66], Банк байгуулах тусгай зөвшөөрлийн журмын 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэг, Банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийн журмын 6 дугаар зүйлд заасан үндэслэл байгаа эсэхийг Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материал болон эрх бүхий байгууллагаас ирүүлсэн лавлагаа, тодорхойлолтод тулгалт хийхэд илэрсэн зөрчилгүй болохыг дурдаж байна.

Монголбанкны 2023 оны 02 сарын 03-ны өдрийн №Б-10/138 тоот лавлагаанаас үзвэл ХасБанк ХХК-д олгогдсон 11 (арван нэгэн) тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан хязгаарлалт болон Банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг тогтоох, түүнд хяналт тавих журмын биелэлт, заавал байлгах нөөц болон Монголбанкнаас тогтоосон зохистой харьцааны шалгуур үзүүлэлтийг хангаж ажилласан болохыг тодорхойлсон байна.

Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 01 сарын 26-ны өдрийн №9/266 тоот албан бичгээс үзвэл ХасБанк ХХК-д олгосон Даатгал зуучлагчийн үйл ажиллагаа 1 (нэг) тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тус тусгай зөвшөөрлийг түдгэлзүүлэх, хүчингүй болгох болон албадлагын аливаа арга хэмжээ аваагүй болохыг тодорхойлсон байна.

Иймд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа Монголбанк болон Санхүүгийн зохицуулах хорооноос олгогдсон тусгай зөвшөөрөл нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох аливаа нөхцөл үүсээгүй байна гэж Хуулийн фирмийн зүгээс үзлээ.

---

[64] **Зөвшөөрлийн тухай хууль (2022).**
6.1 дүгээр зүйл.**Зөвшөөрлийг түдгэлзүүлэх, сэргээх**
1.Эрх бүхий этгээд дараах тохиолдолд зөвшөөрлийг гурван сар хүртэл хугацаагаар түдгэлзүүлнэ:
1.1.зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хангахгүй болсон нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
1.2.хуульд заасан мэдээ, тайланг хугацаанд нь гаргаж өгөөгүй, эсхүл буруу гаргасан;
1.3.зөвшөөрөл олгосноос хойш хоёр жилийн хугацаанд үйл ажиллагаа эрхлээгүй, эсхүл үйл ажиллагаагаа зогсоосон.
2.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1-д заасан үндэслэл байгаа тухай зөвшөөрөл эзэмшигчид урьдчилан мэдэгдэж, мэдэгдлийг хүргүүлсэн он, сар, өдрийг тэмдэглэлд тусгана.
3.Энэ зүйлийн 2-т заасан мэдэгдлийг хүлээн авснаас хойш зөвшөөрөл эзэмшигч ажлын 10 өдрийн дотор зөвшөөрлийг нь түдгэлзүүлэх үндэслэлгүй гэж үзсэн тухай тайлбар, холбогдох баримт бичгийг эрх бүхий этгээдэд ирүүлээгүй бол зөвшөөрлийг түдгэлзүүлнэ.
4.Эрх бүхий этгээд зөвшөөрлийг түдгэлзүүлсэн тухай шийдвэрийн талаар зөвшөөрөл эзэмшигч болон харьяалах татварын албанд ажлын хоёр өдрийн дотор бичгээр мэдэгдэнэ.
5.Эрх бүхий этгээд энэ зүйлийн 1-д заасан үндэслэл, нөхцөл, шаардлага арилсан тохиолдолд зөвшөөрөл эзэмшигчийн хүсэлтийг үндэслэн зөвшөөрлийг сэргээнэ.
6.2 дугаар зүйл.**Зөвшөөрлийг хүчингүй болгох**
1.Зөвшөөрлийг дараах тохиолдолд хүчингүй болгоно:
1.1.зөвшөөрөл эзэмшигч хүсэлт гаргасан;
1.2.зөвшөөрлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлөө арилгаж, зөвшөөрлийг сэргээлгэх тухай хүсэлтийг ирүүлээгүй;
1.3.зөвшөөрөл эзэмшигч нийтийн эрх ашиг, хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдал, хүрээлэн байгаа орчин, үндэсний аюулгүй байдалд сөрөг нөлөө үзүүлсэн, их хэмжээний хохирол учруулсан нь эрх бүхий байгууллагын шийдвэрээр тогтоогдсон;
1.4.зөвшөөрөл эзэмшигч зөвшөөрлийн нөхцөл, шаардлагыг хоёр буюу түүнээс дээш удаа зөрчсөн;
1.5.зөвшөөрөл, түүнийг баталгаажуулсан баримт бичгийг хуульд зааснаас бусад тохиолдолд худалдсан, бэлэглэсэн, барьцаалсан болон бусад хэлбэрээр шилжүүлсэн;
1.6.зөвшөөрлийг авахдаа хуурамч баримт бичиг бүрдүүлсэн нь тогтоогдсон;
1.7.зөвшөөрөл эзэмшигч иргэн бол иргэний эрх зүйн бүрэн чадамжгүйд тооцогдсон, хуулийн этгээд бол дампуурсан, эсхүл татан буугдсан;
1.8.Улсын тэмдэгтийн хураамжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.6-д заасан хугацаанд улсын тэмдэгтийн хураамжийг төлөөгүй. _/Энэ заалтыг 2023 оны 01 сарын 06-ны өдрийн хуулиар нэмсэн./_
1.9.хуульд заасан бусад.
[65] **Валютын зохицуулалтын тухай хууль (1994).**
17 дугаар зүйл.**Валютын хяналтын байгууллагын үүрэг, улсын байцаагчийн бүрэн эрх**
3.Улсын байцаагч нь валютын хяналтын үүргээ биелүүлэхдээ дараах бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:
5.хуулийн заалтыг зөрчсөн бол гадаад төлбөр, тооцоо хийх, валютын гүйлгээ эрхлэх зөвшөөрлийг цуцлах талаар валютын хяналтын Улсын ерөнхий байцаагчид санал тавих.
[66] **Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013).**
23 дугаар зүйл.**Хууль тогтоомж зөрчигчид хүлээлгэх хариуцлага**
23.2.3.энэ хуулийн 4.1-д заасан этгээдийн үйл ажиллагаа явуулах зөвшөөрлийг түдгэлзүүлэх, эсхүл хэсэгчлэн болон бүхэлд нь хязгаарлах, зогсоох, түдгэлзүүлэх, үйл ажиллагааны зөвшөөрөл, тусгай зөвшөөрлийг хүчингүй болгох санал гаргах.

456

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

Хуулийн фирмийн зүгээс Үнэт цаас гаргагч нь аливаа зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг эзэмшдэг эсэх, тэдгээр нь хүчин төгөлдөр эсэх, тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн асуудлаар Оюуны өмчийн газраас ирүүлсэн лавлагаа болон Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн мэдээлэлд үндэслэн ХасБанк ХХК-ийн нэр дээр олгогдсон зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээсэн эсэх талаар дэлгэрүүлэн авч үзлээ.

Оюуны өмчийн газрын 2023 оны 01 сарын 30-ны өдрийн №3/76 тоот тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК-ийн нэр дээр 34 (гучин дөрвөн) зохиогчийн эрхэд хамаарах бүтээл болон 18 (арван найман) барааны тэмдэг бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн бөгөөд ХасБанк ХХК-ийн нэр дээр олгогдсон шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, ашигтай загварын патент байхгүй болохыг тодорхойлсон байна. Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэгдэж эрхийн хамгаалалт хийгдсэн зохиогчийн эрх болон барааны тэмдгийн мэдээллийг **Хавсралт №07. "ХасБанк ХХК-ийн нэр дээр бүртгэгдсэн зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг, оюуны өмч"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй зохиогчийн эрх болон барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсэгт[67] заасны дагуу хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн[68] 2023 оны 02 сарын 16-ны өдрийн байдлаар бүртгэлээс хайлт хийж үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй зохиогчийн эрх болон барааны тэмдгийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна. Иймд ХасБанк ХХК-ийн нэр дээр бүртгэгдэж, эрхийн хамгаалалт хийгдсэн 18 (арван найман) барааны тэмдэг, 34 (гучин дөрвөн) зохиогчийн эрх нь хүчин төгөлдөр бөгөөд Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлд үндэслэн үзэхэд Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй зохиогчийн эрх, барааны тэмдэг нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр олгогдсон үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл, лиценз, зохиогчийн эрх, патент, бараа, үйлчилгээний тэмдэг нь хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгүй байна гэж дүгнэлээ.**

**Долоо. Үнэт цаас, үл хөдлөх болон бусад эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар:**

Банкны тухай хуулийн хүчин төгөлдөр хэрэгжиж буй зохицуулалтын дагуу банк Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах[69] үйл ажиллагаа эрхлэх зохицуулалттай байна.

Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК нь Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 06 сарын 17-ны өдрийн №354 тоот тушаалын дагуу үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах тусгай зөвшөөрөл авсан бөгөөд ХасБанк ХХК нь 2023 оны 01 сарын 24-ний өдрийн байдлаар үнэт цаасны зах зээлд

---

[67] Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны тухай хууль (2015).
7 дугаар зүйл.Барьцааны зүйл
7.1.Иргэний гүйлгээнээс хасагдаагүй бусдын өмчлөлд шилжүүлж болох бодитой байгаа, эсхүл ирээдүйд бий болох хөдлөх эд хөрөнгө, бүх төрлийн хувьцаа, үнэт цаас, шаардах эрх, шинжлэх ухаан, утга зохиол, урлагийн бүх төрлийн бүтээл, шинэ бүтээл, бүтээгдэхүүний загвар, барааны тэмдэг, ашигтай загвар болон бусад хөдлөх эд хөрөнгө, эдийн бус хөрөнгө нь барьцааны зүйл байж болно.
[68] https://mpr.gov.mn/
Энэхүү цахим хуудас нь зөвхөн тодорхой өмчлөгийн хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн хувьд барьцааны эрх үүссэнийг олон нийтэд нээлттэй мэдэгдэх болон барьцааны эрхийн дараалыг тогтоох зорилготой. Цахим мэдээллийн санг улсын хэмжээнд үүсгэх, түүний тасралтгүй үйл ажиллагаа, хадгалалт, хамгаалалт, найдвартай байдлыг Улсын бүртгэлийн ерөнхий газар (УБЕГ) хариуцна.
[69] Банкны тухай хууль (2010).
6 дугаар зүйл.Банкны эрхлэх үйл ажиллагаа
6.1.Банк Монголбанкны зөвшөөрөлтэйгээр дараах үйл ажиллагаа эрхэлнэ:
6.1.9.үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах;

457

арилжаалагдах боломжтой (i) Монголын Ипотекийн Корпораци ОССК ХХК, түүний үүсгэн байгуулсан тусгай зориулалтын компаниар дамжуулан гаргасан Орон сууцны ипотекийн зээлээр баталгаажсан 40 (дөчин) бонд; (ii) Монголбанкнаас мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх зорилгоор хуулиар олгогдсон эрх, үүргийн дагуу гаргасан богино хугацаатай 7 (долоон) төрлийн үнэт цаас; болон (ii) бонд, хувьцаагаар хөрөнгө оруулалт болон зээлээр баталгаажсан 12 (арван хоёр) үнэт цаас буюу нийт үнэт цаасны зах зээлд арилжаалагдах боломжтой 59 (тавин есөн) санхүүгийн хэрэгсэл эзэмшдэг байна. Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа эдгээр үнэт цаасны талаарх мэдээллийг **Хавсралт №08. "Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үнэт цаасны талаар дэлгэрэнгүй мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү.

Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа үнэт цаасны дүнг Банкны тухай хуульд заасан банкны үйл ажиллагаанд тавьсан хязгаарлалтын хувьтай[70] харьцуулж үзэхэд (i) Банкны өөрийн хөрөнгийн 20 (хорин) хувиас илүүгүй; (ii) нэг компанийн гаргасан хувьцааны 10 (арван) хувиас илүүгүй; болон (iii) хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авсан нийт дүн 50 (тавин) хувиас тус тус хэтрээгүй байна.

Үнэт цаас гаргагчийн эзэмшиж буй үнэт цаас, санхүүгийн хэрэгсэлд аливаа үүргийн гүйцэтгэл хангах үүрэг хүлээсэн эсэх, барьцааны эрх үүсгэсэн эсэх талаар Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сангаас [71] Банкны регистрийн дугаараар шалгаж үзэхэд аливаа үүрэг ногдуулсан мэдээлэл илрээгүй болно. Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцаа нь барьцаалагч, барьцаалуулагчийн хооронд байгуулсан гэрээний үндсэн дээр үүсэж болдог тул барьцааны эрхийг заавал улсын бүртгэлд бүртгүүлэх үүрэг хүлээдэггүй. Иймд Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн мэдээлэл болон Улсын бүртгэлийн ерөнхий газрын цахим мэдээллийн сангийн мэдээлэлд үндэслэн ХасБанк ХХК-ийн 59 (тавин есөн) үнэт цаас эзэмших эрх нь хүчин төгөлдөр бөгөөд Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн хэлцэл хийгдээгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газар, Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн 2023 оны 01 сарын 25-ны өдрийн эд хөрөнгө бүртгэлтэй эсэх лавлагаанаас үзвэл ХасБанк ХХК-ийн эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлд бүртгэгдсэн, эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээтэй 207 (хоёр зуун долоон) үл хөдлөх эд хөрөнгө байна. Үүнээс 58 (тавин найман) үл хөдлөх хөрөнгө нь Банкны өмчлөлийн орон байр, барьцаалаагүй хөрөнгө гэдэг мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Тус асуудлын хүрээнд Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчийн дээр бүртгэгдсэн 58 (тавин найман) үл хөдлөх эд хөрөнгийн талаар тодруулж холбогдох нийслэл болон орон нутгийн төрийн эрх бүхий байгууллагаас лавлагаа, тодорхойлолт хүсэж гаргуулж авсан. Үнэт цаас гаргагчийн өмчлөлд байгаа үл хөдлөх хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт №09. "ХасБанк ХХК-ийн өмчлөх эрх бүхий үл хөдлөх эд хөрөнгө, эзэмших эрх бүхий газар болон хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл"** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй үл хөдлөх хөрөнгө нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлын хувьд Улсын бүртгэлийн ерөнхий газрын мэдээллийн нэгдсэн сангийн [72] лавлагаанаас үзвэл 58 (тавин найман) үл хөдлөх хөрөнгөд барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна.

[70] **Банкны тухай хууль (2010).**
17 дугаар зүйл.**Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт**
17.4.Энэ хуулийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна. Үүнд Засгийн газар, Төв банкны үнэт цаас, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа хамаарахгүй.
17.5.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах нийт дүн банкны өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтэрч болохгүй.
[71] https://mpr.gov.mn/
[72] Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын Бүртгэлийн Ерөнхий газрын даргын 2021 оны №А/395 дугаар тушаалын 2 дугаар хавсралт Маягт №Э-3.

458

СЭХ
2023 05. 12
БҮРТГЭВ
№ 01

Иймд Үнэт цаас гаргагчаас гаргаж өгсөн баримт мэдээлэл, нийслэл болон орон нутгийн төрийн эрх бүхий байгууллагын лавлагаанд үндэслэн Үнэт цаас гаргагчийн өмчлөлд байгаа 58 (тавин найман) үл хөдлөх хөрөнгийн өмчлөх эрх нь хүчин төгөлдөр, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна гэж үзлээ.

Үнэт цаас гаргагчийн эзэмшилд нийт 24 (хорин дөрвөн) эзэмших эрхтэй газар[73] байгаа талаарх мэдээллийг Хуулийн фирмд ирүүлсэн. Үнэт цаас гаргагчийн эзэмших эрхтэй газрын талаар дэлгэрэнгүй мэдээллийг **Хавсралт №09.“ХасБанк ХХК-ийн өмчлөх эрх бүхий үл хөдлөх эд хөрөнгө, эзэмших эрх бүхий газар болон хөрөнгийн талаарх дэлгэрэнгүй мэдээлэл”** хүснэгтээс дэлгэрүүлэн танилцана уу.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Газар зохион байгуулалт, геодези, зураг зүйн газрын Газрын нэгдмэл сангийн удирдлагын цахим системийн мэдээллийн сан болон төрийн эрх бүхий байгууллагын лавлагаанд үндэслэж үзвэл Үнэт цаас гаргагчийн эзэмшилд байгаа эдгээр 24 (хорин дөрвөн) эзэмших эрхтэй газрын эрхийг барьцаанд тавьсан болон үүрэг ногдуулсан хэлцэлд бүртгүүлж, эрхийн гэрчилгээнд барьцаалсан тухай тэмдэглэл хийлгээгүй болохыг тодорхойлсон байна. ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 сарын 09-ний өдрийн №1/748 тоот Батламж бичгээр “ХасБанк ХХК-ийн байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулах зорилгоор үүрэг гүйцэтгүүлэгчтэй үл хөдлөх болон хөдлөх хөрөнгийн барьцааны гэрээ, батлан даалтын гэрээ болон баталгааны гэрээ байгуулаагүй, өөрийн өмчлөлөөр бусдын өмнө үүрэг хүлээгээгүй” болохыг тодорхойлсон байна.

Иймд Үнэт цаас гаргаж өгсөн баримт мэдээлэл, эрх бүхий албан тушаалтны батламж, нийслэл болон орон нутгийн төрийн эрх бүхий байгууллагын лавлагаанд үндэслэн Үнэт цаас гаргагчийн 24 (хорин дөрвөн) газар эзэмших эрх нь хүчин төгөлдөр, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээгээгүй байна гэж үзлээ.

Үнэт цаас гаргагчийн тээврийн хэрэгслийн хувьд ХасБанк ХХК-ийн Гүйцэтгэх захирлын 2023 оны 02 сарын 09-ны өдрийн №1/749 тоот Батламж гаргах тухай албан бичгээс үзвэл Үнэт цаас гаргагчийн өмчлөлд бөгөөд үндсэн хөрөнгөөр эзэмшиж, ашигладаг нийт 67 (жаран долоон) тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байх бөгөөд Банк нь Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.2 дахь заалтад заасан “зээл” болон 6.1.10 дэх заалтад заасан санхүүгийн түрээсийн үйл ажиллагааны тусгай зөвшөөрлийн хүрээнд харилцагчтай байгуулсан зээлийн гэрээний үүргийн гүйцэтгэлийг хангуулахаар байгуулсан Фидуцийн гэрээ болон Санхүүгийн түрээсийн гэрээний дагуу нийт 4,143 (дөрвөн мянга нэг зуун дөчин гурван) тээврийн хэрэгслийг өмчлөлдөө шилжүүлж, Автовээврийн үндэсний төвд бүртгэл хийлгэсэн байна.

Автотээврийн үндэсний 2023 оны 02 сарын 06-ны өдрийн №045 тоот Тээврийн хэрэгслийн лавлагаанаас үзвэл ХасБанк ХХК-ийн нэр дээр 4,210 (дөрвөн мянга хоёр зуун арван) тээврийн хэрэгсэл бүртгэлтэй байгааг тодорхойлсон байна.

Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслүүд нь аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх талаар Хөдлөх эд хөрөнгө болон эдийн бус хөрөнгийн барьцааны мэдэгдлийн бүртгэх цахим мэдээллийн сангийн бүртгэлээс[74] үзвэл Үнэт цаас гаргагчийн нэр дээр бүртгэлтэй тээврийн хэрэгслийн барьцаатай холбоотой мэдээлэл байхгүй болохыг дурдаж байна.

[73] **Газрын тухай хууль (2002).**
3 дугаар зүйл.**Хуулийн нэр томьёо**
3.1 Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог дор дурдсан утгаар ойлгоно:
3.1.1.“газар” гэж газрын гадаргуу, түүний хөрс, ой, ус, ургамал бүхий орон зайн давхаргыг;
3.1.3.“газар эзэмших” гэж газрыг гэрээнд заасан зориулалт, нөхцөл, болзлын дагуу хуулиар зөвшөөрсөн хүрээнд өөрийн мэдэлд байлгахыг;
3.1.4.“газар ашиглах” гэж хуулиар зөвшөөрсөн хүрээнд газар өмчлөгч, эзэмшигчтэй байгуулсан гэрээнд заасны дагуу газрын аль нэг ашигтай чанарыг нь гаргаж хэрэглэхийг;
[74] https://mpr.gov.mn/search

459

Нууц баримт
Эх хувь

Хуулийн фирмийн зүгээс өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгийн хувьд тусгайлан дүгнэлт хийгээгүй бөгөөд шалгуур асуултын хүрээнд Үнэт цаас гаргагчийн эзэмшиж байгаа эд хөрөнгө өмчлөх эрх нь хүчин төгөлдөр эсэх, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангах үүрэг хүлээсэн эсэх асуудлаар холбогдох баримт материал, төрийн эрх бүхий байгууллагын баримт материал дээр үндэслэн дүн шинжилгээ хийсэн болохыг дурдаж байна. Түүнчлэн өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй бусад хөрөнгө болон Хөрөнгийн үнэлгээний тайлан болон Үнэт цаас гаргагчийн санхүү байдлын тайланд тусгагдсан хөдлөх хөрөнгийн өмчлөх эрхийг баталгаажуулах боломжгүй тул хөрөнгөтэй холбоотой асуудлаар Үнэт цаас гаргагчаас тодруулж асууна уу.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн эзэмшил/өмчлөлд байгаа дурдсан хөрөнгө өмчлөх эрх хүчин төгөлдөр бөгөөд тэдгээрийн хугацаа дуусах, цуцлагдах нөхцөл байдал үүсээгүй, аливаа үүргийн гүйцэтгэлийг хангуулах үүрэг хүлээгээгүй байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.**

**Найм. Үнэт цаасыг бүртгүүлэх танилцуулгад тусгагдсан хууль зүйн мэдээлэл нь хүчин төгөлдөр баримтаар нотлогдож байгаа эсэх асуудлын хувьд үзвэл:**

Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.6 дахь хэсэгт "Үнэт цаасны танилцуулгад тусгасан мэдээллийн үнэн зөв, хүчин төгөлдөр эсэхийг энэ хуулийн 33.2.1 дэх заалтад заасан хууль зүйн зөвлөгөө үзүүлэх үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр, санхүүгийн мэдээлэл нь үнэн зөв эсэхийг энэ хуулийн 33.2.3 дахь заалтад заасан аудитын үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээдээр тус тус хянуулж, дүгнэлт гаргуулна" гэж заасны дагуу тус Хуулийн фирм нь Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан мэдээллүүдийг нягталж нийтэд илэрхий мэдээ баримт, төрийн болон эрх бүхий байгууллагуудаас гаргаж өгсөн лавлагаа, тодорхойлолтууд, Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримт бичигт харьцуулсан дүн шинжилгээ хийсэн.

Хуулийн фирм нь тэргүүлэх андеррайтер компани болох Райнос Инвестмент ҮЦК ХХК, дэд андеррайтер Өлзий энд Ко Капитал ҮЦК ХХК-ийн бэлтгэсэн Үнэт цаасны танилцуулгатай танилцаж дүн шинжилгээ хийсэн бөгөөд Үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий Үнэт цаас гаргагчийн оноосон нэр, оршин байгаа газрын шуудангийн болон холбоо барих хаяг, хуулийн этгээдийн улсын бүртгэлийн болон регистрийн дугаар, бүртгэсэн он, сар, өдөр, хувьцаа эзэмшигчдийн мэдээлэл, хувь нийлүүлсэн хөрөнгийн хувь хэмжээ, Үнэт цаас гаргагчийн бүтэц, зохион байгуулалт, эрх бүхий албан тушаалтны талаарх мэдээлэл, зарласан болон гаргасан үнэт цаасны тоо, төрөл, нэрлэсэн үнэ болон өөрийн хөрөнгийн хэмжээ, нийтэд санал болгож байгаа үнэт цаасаар гэрчлэгдэх эрх, үүргийн талаарх мэдээлэл нь Хуулийн фирмд Үнэт цаас гаргагчийн зүгээс гаргаж өгсөн баримттай нийцэж байх тул үнэн зөв тусгагдсан байна гэж үзлээ.

Эдгээр дурдсан хууль зүйн ач холбогдолтой мэдээллээс бусад Үнэт цаас гаргагчийн санхүүгийн үзүүлэлт, борлуулалтын хэмжээ, ашиг, алдагдал зэрэг бизнесийн үйл ажиллагаа, Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны тухай болон Үнэт цаас гаргагчийн зах зээлийн төлөвлөгөө зэрэг агуулагдсан эдийн засгийн ерөнхий мэдээлэл, салбарын үзүүлэлт, Үнэт цаас гаргагчийн талаар олон нийтэд ил, тодорхой үйл баримт, үйл ажиллагааны болон санхүүгийн тайланд тусгагдсан баталгаажуулах боломжгүй тоон үзүүлэлт болон хараат бус байгууллагуудын хийсэн дүн шинжилгээ, санхүүгийн тооцоолол, нийтэд санал болгож байгаа үнэт цаасыг арилжих нөхцөл, журам, төрийн эрх бүхий байгууллагаас гаргасан шийдвэр зэрэг мэдээлэлд Хуулийн фирмийн зүгээс дүн шинжилгээ хийгээгүй болохыг дурдаж байна.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагчийн үнэт цаасны танилцуулгад тусгагдсан хууль зүйн ач холбогдол бүхий мэдээлэл нь үнэн зөв, хүчин төгөлдөр байна гэж Хуулийн фирм дүгнэж байна.**

**Ес. Компанийн толгой, охин, хараат, зэрэгцээ компанийн талаарх мэдээлэлд үндэслэн Үнэт цаас гаргагч компанийн хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох асуудлын хувьд үзвэл:**

Компанийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх хэсэгт "Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 20-50 хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой

460

оны 2023 сарын 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

этгээдтэй хамтран эзэмшиж байгаа тохиолдолд уг компанийг хараат компани гэнэ", 6.3 дахь хэсэгт Компанийн нийт гаргасан энгийн хувьцааны 50-аас дээш хувийг өөр (толгой) компани дангаараа буюу нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран эзэмшдэг бие даасан компанийг охин компани гэнэ", 6.15 дахь хэсэгт "Нэг толгой компанийн хараат болон охин компаниуд, эсхүл нэг этгээд дангаараа болон нэгдмэл сонирхолтой этгээдтэй хамтран хувьцааных нь хяналтын багцыг эзэмшдэг компаниудыг зэргэлдээ компани гэнэ", Банкны тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалтад "банкны нэгдлийн толгой компани гэж банкны нэгдэл болон түүнд хамаарах оролцогчийг удирддаг компанийг ойлгоно", 17 дугаар зүйлийн 17.4 дэх хэсэгт "Энэ хуулийн 17.5-д[75] зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна. Үүнд Засгийн газар, Төв банкны үнэт цаас, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа хамаарахгүй", 36 дугаар зүйлийн 36.1 дэх хэсэгт "Аливаа этгээд дангаар болон холбогдох этгээдийн хамт эзэмших банкны хувьцаа, хувьцаанд хамаарах үнэт цаасны хэмжээ тухайн банкны нийт гаргасан хувьцааны 20 хувиас хэтрэхгүй байна" гэж тус тус хуульчилсан байна.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материалаас үзвэл энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар ХасБанк ХХК нь аливаа хараат болон охин компанигүй байна.

Компанийн тухай хуулийн зохицуулалтын дагуу компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байх бөгөөд хувьцаа эзэмшигчид нь хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигч саналын нэг эрхтэй оролцдог үндсэн зохицуулалттай байдаг[76]. Үнэт цаас гаргагчийн эцсийн өмчлөгч этгээдийг тодорхойлох асуудлын хүрээнд Хуулийн фирм нь ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хурлаар шийдэгдэж байгаа аливаа асуудлаар саналын давуу эрхтэй, эцсийн шийдвэрийг гаргахад саналын давуу эрхээрээ шууд нөлөөлөх боломжтой хувьцаа эзэмшигчийг жинхэнэ хяналтыг хэрэгжүүлэгч, эцсийн өмчлөгч[77] этгээд гэж тооцож авч үзэж тогтоохыг зорьсон.

---

[75] **Банкны тухай хууль (2010).**
17 дугаар зүйл.**Банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт**
17.4.Энэ хуулийн 17.5-д зааснаас бусад тохиолдолд банкны худалдан авах үнэт цаасны нийт дүн нь **банкны өөрийн хөрөнгийн 20 хувиас хэтэрч болохгүй бөгөөд нэг компанийн гаргасан хувьцааны 10 хувиас дээшгүй байна.** Үүнд Засгийн газар, Төв банкны үнэт цаас, зээлийн мэдээллийн үйл ажиллагаа эрхэлдэг хуулийн этгээдийн хувьцаа хамаарахгүй.
17.5.Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас худалдан авах нийт дүн банкны өөрийн хөрөнгийн 50 хувиас хэтэрч болохгүй.
[76] **Компанийн тухай хууль (2011).**
59 дүгээр зүйл.**Хувьцаа эзэмшигчдийн хурал**
59.1.Компанийн эрх барих дээд байгууллага нь хувьцаа эзэмшигчдийн хурал байна.
63 дугаар зүйл.**Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр хүчин төгөлдөр болох**
63.1.Хувьцаа эзэмшигчдийн хурлаар хэлэлцэж байгаа асуудлыг санал хураалтаар шийдвэрлэхэд энгийн хувьцаа эзэмшигч энэ хуулийн 34 дүгээр зүйлд, давуу эрхийн хувьцаа эзэмшигч энэ хуулийн 35 дугаар зүйлд заасан саналын эрх эдэлнэ.
63.2.Хуульд өөрөөр заагаагүй бол нэг хувьцаа саналын нэг эрхтэй байна.
34 дүгээр зүйл.**Компанийн энгийн хувьцаа эзэмшигчийн эрх**
34.1.Компанийн энгийн хувьцаа эзэмшигч нь дараах эрх эдэлнэ:
34.1.1.хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцож, хурлаар хэлэлцэж байгаа бүх асуудлаар өөрийн эзэмшлийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн санал өгөх;
34.1.2.давуу эрхийн хувьцааны ногдол ашиг төлсний дараагаар компанийн төлөөлөн удирдах зөвлөл /байхгүй бол хувьцаа эзэмшигчдийн хурал/-өөс тогтоосон хэмжээгээр ногдол ашиг авах;
34.1.3.компанийг татан буулгах үед энэ хуулийн 28 дугаар зүйлд заасан журмын дагуу үлдсэн эд хөрөнгийг худалдсанаас олсон орлогоос хувь хүртэх.
[77] **Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль (2018).**
4 дүгээр зүйл.**Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**
4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
4.1.11."эцсийн өмчлөгч" гэж Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хуулийн 3.1.6-д заасныг.
**Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013).**
3 дугаар зүйл.**Хуулийн нэр томьёоны тодорхойлолт**
3.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томьёог доор дурдсан утгаар ойлгоно:
3.1.6."**эцсийн өмчлөгч**" гэж:
/Энэ заалтыг 2018 оны 04 сарын 26-ны өдрийн хуулиар өөрчлөн найруулсан./
3.1.6.а.харилцагч нь хуулийн этгээд бол тухайн хуулийн этгээдийн хөрөнгийн дийлэнх хэсгийг дангаараа, эсхүл бусадтай хамтран өмчилж байгаа, эсхүл тухайн хуулийн этгээдийн үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл өөрийн үйлдлийг бүрдээр

ХАСБАНК

Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн дүрмээс үзвэл нэг бүр нь 100 (нэг зуун) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 1,000,000,000 (нэг тэрбум) ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх нийт 100,000,000,000 (нэг зуун тэрбум) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд Банкны гаргасан хувьцааны 100 хувийг ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК эзэмшиж байна. Үүнд:

*Хүснэгт №18. ХасБанк ХХК-ийн хувьцааны тоо хэмжээ, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл.*

| № | Хувьцаа эзэмшигч | Нэгж хувьцааны үнэ (төгрөгөөр) | Хувьцааны тоо (ширхэгээр) | Нийт дүн (төгрөгөөр) | Хувь хэмжээ |
|---|---|---|---|---|---|
| 1. | ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК | 100 | 1,000,000,000 | 100,000,000,000 | 100.00% |
| | НИЙТ | 100 | 1,000,000,000 | 100,000,000,000 | 100.00% |

Хүснэгт дэх ХасБанк ХХК-ийн хувьцаа эзэмшигчийн хувь эзэмшлийн мэдээллээс үзвэл Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт энгийн хувьцааны 100 хувьд ногдох хувьцааг ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК хуулийн этгээд эзэмшиж байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны 01 сарын 25-ны өдрийн №23900002000305 тоот лавлагаа болон ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн дүрмээс үзвэл ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нэг бүр нь 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 25,000,000 (хорин таван сая) ширхэг зарласан хувьцаатай бөгөөд 1,000 (нэг мянган) төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 16,584,644 (арван зургаан сая таван зуун наян дөрвөн мянга зургаан зуун дөчин дөрвөн) ширхэг гаргасан хувьцаанаас бүрдэх нийт 16,584,644,000 (арван зургаан тэрбум таван зуун наян дөрвөн сая зургаан зуун дөчин дөрвөн мянган) төгрөгийн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй бөгөөд дараах 12 (арван хоёр) хувьцаа эзэмшигчдийн эзэмшилд байна. Үүнд:

*Хүснэгт №19. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцааны тоо хэмжээ, хувьцаа эзэмшигчийн мэдээлэл.*

| № | Хувьцаа эзэмшигч | Хувь хэмжээ |
|---|---|---|
| 1. | Монголын Алт Корпораци (МАК) ХХК | 20.00% |
| 2. | Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC) | 17.17% |
| 3. | ОРИКС Корпораци (ORIX) | 16.81% |
| 4. | Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD) | 12.91% |
| 5. | Канадын Үндэсний Банк (NBC) | 10.52% |
| 6. | Ронок Партнерз | 10.15% |
| 7. | Монголия Файнэншл Сервисиз | 6.63% |
| 8. | Триодос Фэйр Шэйр Фанд | 3.73% |
| 9. | Нээлттэй Нийгэмлэг Хүрээлэн | 1.59% |
| 10. | Улаанбаатар Ротари Клуб | 0.30% |
| 11. | Магваны Болдоо | 0.10% |
| 12. | Чулууны Ганболд | 0.09% |
| | НИЙТ | 100.00% |

ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК нь Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн цорын ганц хувьцаа эзэмшигч байна. ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн хувьцааг Монголын Алт Корпораци (МАК-20.00%), Олон Улсын Санхүүгийн Корпораци (IFC-17.17%), Орикс Корпораци (ORIX-16.81%), Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк (EBRD-12.91%), Канадын Үндэсний Банк (NBC-10.52%), Ронок Партнерз (Ronoc-10.15%), Монголия Файнэншл Сервисиз (MOF-6.63%), Триодос Фейр Шейр

төлөөлүүлэн хийлгэж байгаа, эсхүл хуулийн этгээдийг болон уг хуулийн этгээдээс хийх аливаа хэлцэл, түүнийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдах замаар тухайн хуулийн этгээдийг өмчилж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
3.1.6.б.харилцагч нь хувь хүн бол тухайн хүний үйлдэл, үйл ажиллагааг удирдан чиглүүлж, эсхүл тухайн хүнээр өөрийн үйлдлийг төлөөлүүлэн хийлгэж үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг;
3.1.6.в.хөрөнгийг удирдах хэлцлийн хувьд тухайн хөрөнгө итгэмжлэн удирдах хэлцлийн үндсэн дээр үр шим, ашиг орлогыг хүртэж байгаа хүнийг.

462

Фанд (Triodos-3.73%), Нээлттэй Нийгэмлэг Хүрээлэн (Open society forum-1.59%), Улаанбаатар Ротари клуб ТББ (Rotary-0.30%), иргэн М.Болдоо (0.10%) болон иргэн Ч.Ганболд (0.09%) нарын 12 хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу эцсийн өмчлөгчийг бүртгүүлсэн байх үүрэгтэй. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын Улсын бүртгэлийн мэдээллийн нэгдсэн сангийн Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн 2023 оны 03 сарын 03-ны өдрийн №23900002000820 тоот лавлагаанаас үзвэл Үнэт цаас гаргагчийн цор ганц хувьцаа эзэмшигч ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК, түүний хувьцаа эзэмшигч нараас хамгийн өндөр хувь хэмжээгээр эзэмшигч Монголын Алт Корпораци ХХК (ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК 20%)-ийн хувьцаа эзэмшигч болох Монгол Улсын иргэн Б.Нямтайшир (МАК ХХК-ийн 60%) болон Монгол Улсын иргэн Д.Хулан (МАК ХХК-ийн 40%) нарыг эцсийн өмчлөгчөөр бүртгүүлсэн байна.

Хуулийн фирмээс дээр дурдсан холбогдох хуулийн зохицуулалт болон Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн лавлагаанд үндэслэж үзвэл Монгол Улсын иргэн Б.Нямтайшир болон Монгол Улсын иргэн Д.Хулан нарыг Үнэт цаас гаргагчийн хувьд улсын бүртгэлийн байгууллагад бүртгүүлсэн эцсийн өмчлөгчид гэж дүгнэлээ.

**Арав. Үнэт цаас гаргагч нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэг, иргэн, захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байсан эсэх асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь энэхүү асуудлын хүрээнд Банкнаас Монгол Улсын арбитрын хэрэг, иргэний болон захиргааны хэрэгт хариуцагчаар оролцсон, оролцож байгаа эсэх болон эрүүгийн хэрэгт яллагдагч, шүүгдэгч, иргэний хариуцагчаар оролцсон болон оролцож байгаа эсэх талаар төрийн байгууллагаас ирүүлсэн лавлагааны хариу болон Банкнаас ирүүлсэн материал дээр үндэслэн хэргийн шалтгаан, үр дүнд хуулийн дүн шинжилгээ хийлээ.

(i) **Банк нь Монгол Улсын арбитрт энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хариуцагчаар оролцсон болон оролцож байгаа эсэх асуудлаар:**

Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын дэргэдэх Монголын Олон улсын арбитрын 2023 оны 01 сарын 23-ны өдрийн №4/136 тоот лавлагааны хариу албан бичгээс үзвэл тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт ХасБанк ХХК нь хариуцагчаар оролцоогүй байна.

Улаанбаатар хотын Худалдааны Танхимын дэргэдэх Арбитрын 2023 оны 01 сарын 24-ний өдрийн №А-23/07 тоот тодорхойлолтоос үзвэл тус арбитраар хянан шийдвэрлэгдсэн болон арбитрын ажиллагаа явагдаж байгаа хэрэгт ХасБанк ХХК нь хариуцагчаар оролцоогүй байна.

Захиргааны хэргийн шүүхийн хувьд захиргааны акт, захиргааны хууль бус үйл ажиллагаатай холбоотой эрх зүйн маргааныг хянан шийдвэрлэдэг. Өөрөөр хэлбэл захиргааны хэргийн шүүх нь захиргааны байгууллагын хууль бус үйл ажиллагааны улмаас эрх, хууль ёсны ашиг сонирхол нь зөрчигдсөн хүн, хуулийн этгээдийн нэхэмжлэлийн шаардлагаар тодорхойлогдох захиргааны байгууллагыг хариуцагчаар татан захиргааны хэрэг үүсгэдэг. Хариуцагч захиргааны байгууллагыг Захиргааны ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт "Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно"[78] гэж тодорхойлсон байна. Иймд ХасБанк ХХК нь захиргааны хэрэгт

[78] **Захиргааны ерөнхий хууль (2015).**
5 дугаар зүйл.**Захиргааны байгууллага**
5.1.Нийтийн ашиг сонирхлыг илэрхийлэн захирамжилсан шийдвэр гаргадаг дараах нийтийн эрх зүйн этгээдийг захиргааны байгууллага гэж ойлгоно:
5.1.1.төрийн гүйцэтгэх эрх мэдлийг хэрэгжүүлдэг төв, орон нутгийн бүх байгууллага;
5.1.2.хууль тогтоомжийг биелүүлж, захирамжилсан шийдвэр гаргадаг Засгийн газрын бус бие даасан агентлаг, түүнтэй адилтгах нийтийн эрх зүйн бусад байгууллага;
5.1.3.захиргааны чиг үүргийг хууль болон нийтийн эрх зүйн гэрээний үндсэн дээр шилжүүлэн авсан этгээд;
5.1.4.үйлчилгээг нь нийтээс заавал хэрэглэдэг төрийн ба холимог өмчийн сургууль, эмнэлэг, хэвлэл мэдээлэл, харилцаа холбоо, тээвэр, эрчим хүчний зэрэг байгууллагын захиргаа;

463

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭЛ
№ 01

хариуцагчаар оролцсон болон оролцож байгаа эсэх асуудлын хувьд Банк нь захиргааны байгууллагад хамаарахгүй тул захиргааны хэрэгт хариуцагчаар оролцох боломжгүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

(ii) **Банк нь Эрүүгийн хэргийн шүүх болон Иргэний хэргийн шүүхэд энэхүү Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар хариуцагчаар татагдан оролцсон болон оролцож байгаа эсэх асуудлаар:**

Хуулийн фирм нь Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн материал болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архив, Банкны оршин байгаа газар буюу Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар болон Банкны салбар, тооцооны төв оршин байгаа газар буюу 21 (хорин нэгэн) аймаг дахь Шүүхийн Тамгын газар, Улаанбаатар хотын 9 (есөн) дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газаас тус тус ирүүлсэн лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Банк хариуцагчаар оролцсон (i) шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэрэг; болон (ii) шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа хэрэг гэсэн 2 (хоёр) төрөлд ангилж дүн шинжилгээ хийлээ. Үүнд:

**Банк хариуцагчаар оролцсон шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн хэргийн талаар:**

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материал болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архив, 21 (хорин нэгэн) аймгийн Шүүхийн тамгын газраас ирүүлсэн лавлагаа, тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК нь хэргийн хариуцагчаар оролцон шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн нийт 36 (гучин зургаан) хэрэг байна.

Банк нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт татагдаж байсан эсэх талаар 21 (хорин нэгэн) аймгийн Шүүхийн тамгын газарт хүргүүлсэн лавлагааны хариу болон Улаанбаатар хотын 9 (есөн) дүүрэг болох Баянзүрх, Сүхбаатар, Чингэлтэй, Баянгол, Хан-Уул, Сонгинохайрхан, Багануур, Багахангай, Налайх дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхээс ирүүлсэн лавлагааны хариу, Банкнаас ирүүлсэн баримт материалаас үзвэл тасалбар болгосон өдрийн байдлаар ХасБанк ХХК нь аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт татагдаж байгаагүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн баримт материал болон Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архив, Сүхбаатар дүүргийн иргэний хэргийн анхан шатны шүүх, 21 (хорин нэгэн) аймгийн Шүүхийн тамгын газраас ирүүлсэн лавлагаа, тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК нь нийт 36 (гучин зургаан) иргэний хэрэгт хариуцагчаар оролцсон байна. Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архив болон Шүүхийн тамгын газраас ирүүлсэн лавлагаа, тодорхойлолттой **Хавсралт №10. "ХасБанк ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолт"** хэсгээс дэлгэрүүлэн танилцана уу.

Банк хариуцагчаар оролцон шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн хэргийг төрлөөр ангилж, тоон үзүүлэлтийг гаргавал гэрээнээс үүдэлтэй 26 (хорин зургаан) хэрэг, хөдөлмөрийн 9 (есөн) маргаан, гэм хорыг арилгахтай холбоотой 1 (нэг) хэрэг байна.

*Хүснэгт №20. Банкны Иргэний хэргийн хариуцагчаар оролцон шүүхийн шатанд эцэслэн шийдвэрлүүлсэн хэрэг маргааны шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байдлын тоон үзүүлэлт.*

| № | Шүүхийн шийдвэр/шүүгчийн захирамжийн утга | Гэрээнээс үүдэлтэй маргаан | Хөдөлмөрийн маргаан | Гэм хорыг арилгахтай холбоотой хэрэг |
|---|---|---|---|---|
| 1. | Нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангасан | 7 | 2 | - |
| 2. | Хариуцагчийн зөвшөөрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон | 2 | - | - |
| 3. | Зохигчийн эвлэрлийг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон | 5 | 7 | - |
| 4. | Нэхэмжлэгч нэхэмжлэлийн шаардлагаасаа татгалзсаныг баталж, хэргийг хэрэгсэхгүй болгосон | 3 | - | - |

5.1.5.нутгийн өөрөө удирдах байгууллага болон шийдвэр, үйл ажиллагаанд нь захиргааны хэргийн шүүхэд гомдол гаргахаар хуульд тусгайлан заасан байгууллага.

464

СЗХ
2023 05 17
БҮРТГЭВ
№ 01

| | | | | |
|---|---|---|---|---|
| 5. | Нэхэмжлэлийг буцаасан | 1 | - | - |
| 6. | Нэхэмжлэлийг бүхэлд нь хэрэгсэхгүй болгосон | 7 | - | 1 |
| 7. | Нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэргийг хэрэгсэхгүй болгосон | 1 | - | - |
| | НИЙТ | 26 | 9 | 1 |

Үнэт цаас гаргагчийн хариуцагчаар оролцсон нийт 36 (гучин зургаан) иргэний хэрэг маргаан байгаагаас 26 (хорин зургаан) хэрэг нь зээлийн гэрээ, барьцааны гэрээ, түрээсийн гэрээ, худалдах, худалдан авах гэрээнээс үүдэлтэй хэрэг байх бөгөөд эдгээрээс 10 (арван) хэргийн хувьд нэхэмжлэгч нэхэмжлэлээсээ татгалзсан, хариуцагч нэхэмжлэлийн шаардлагыг хүлээн зөвшөөрсөн, зохигч эвлэрсэн, нэхэмжлэлийн шаардлагыг хариуцагч биелүүлсэн үндэслэлээр шүүхээс хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. Бусад 16 (арван зургаан) хэргийн хувьд 7 (долоон) хэргийг Иргэний хуулийн 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр хүчин төгөлдөр бусад тооцож, 7 (долоон) хэргийг нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож, 1 (нэг) хэргийг нэхэмжлэгч нар шүүх хуралдаанд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хүрэлцэн ирээгүй гэсэн үндэслэлээр нэхэмжлэлийг буцааж, 1 (нэг) хэргийг хамтран хариуцагчийн хаяг тодорхойгүй үндэслэлээр нэхэмжлэлийг хүлээн авахаас татгалзаж, хэрэгсэхгүй болгон тус тус шийдвэрлэсэн байна.

Үнэт цаас гаргагчтай хөдөлмөр эрхлэлтийн харилцаанд орсон ажилтан, иргэнээс нэхэмжлэгчээр оролцсон хэргийг хөдөлмөрийн маргаан гэж үзсэн бөгөөд Банк нь 9 (есөн) хөдөлмөрийн хэрэгт хариуцагчаар оролцсон байна. Хөдөлмөрийн маргааны 8 (найм) нь ажлаас халсан Банкны Гүйцэтгэх захирлын тушаалыг хүчингүй болгуулж, урьд эрхэлж байсан ажилд эгүүлэн тогтоолгох, ажилгүй байсан хугацааны цалинтай тэнцэх олговор гаргуулах, нийгмийн болон эрүүл мэндийн даатгалын шимтгэлийг төлүүлж, дэвтэрт бичилт хийлгэх нэхэмжлэлийн шаардлагатай хэрэг байх бөгөөд эндээс 7 (долоон) хэрэг дээр Банкны зүгээс нэхэмжлэгч талтай эвлэрэн хэлэлцсэн тул шүүхээс хэргийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэсэн байна. Харин ажилд эгүүлэн тогтоолгох нэхэмжлэлийн шаардлага бүхий үлдсэн 1 (нэг) хэрэг болон нийгмийн даатгалын шимтгэл нөхөн төлүүлж, ажилгүйдлийн тэтгэмж гаргуулах 1 (нэг) хэргийг тус тус шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хангаж шийдвэрлэсэн байна. Үлдсэн 1 (нэг) хэргийн тухайд гэм хорыг арилгуулах нэхэмжлэлийн шаардлага бүхий хэрэг байсныг шүүхээс нэхэмжлэлийн шаардлагыг бүхэлд нь хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн иргэний хэргээс онцгойлон дурдвал Үнэт цаас гаргагчийн зүгээс нийт хэргийн ойролцоогоор гуравны нэг хувьд нэхэмжлэгч талтай эвлэрэн хэлэлцэж, тухай бүр шүүхээр эвлэрлийг батлуулж, хялбаршуулсан журмаар шийдвэрлүүлсэн нь нэхэмжлэлийн үндэслэл, хууль хэрэглээний байдлыг урьдчилан таамагласны үндсэн дээр Банкны эрх ашигт нийцүүлсэн, үр дүнтэй аргыг хэрэглэж хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцсон байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.

**Банк хариуцагчаар оролцсон шүүхийн шатанд хэлэлцэгдэж байгаа хэргийн талаар:**

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн материал болон Банкны оршин байгаа газар буюу Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар болон Банкны салбар, тооцооны төв оршин байгаа газар буюу 21 (хорин нэгэн) аймаг дахь Шүүхийн тамгын газар, Улаанбаатар хотын төвийн 9 (есөн) дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газраас ирүүлсэн лавлагаа, тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК-ийн хэргийн хариуцагчаар оролцон шүүхээр хянан шийдвэрлэгдэж байгаа нийт 11 (арван нэгэн) хэрэг байна.

Банк аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт яллагдагч, шүүгдэгч, иргэний хариуцагчаар оролцож байгаа эсэх талаар Улаанбаатар хотын төвийн 9 (есөн) дүүргийн Эрүүгийн хэргийн анхан шатны шүүхийн тамгын газарт хүргүүлсэн лавлагааны хариу, 21 (хорин нэгэн) аймгийн Шүүхийн тамгын газарт хүргүүлсэн лавлагааны хариу болон Банкнаас ирүүлсэн баримт материалаас үзвэл тасалбар болгосон өдрийн байдлаар ХасБанк ХХК нь аж ахуйн үйл

СЗХ
2023 05. 12
БҮРТГЭВ
№ 01

ажиллагааны эсрэг гэмт хэрэгт татагдаагүй, Эрүүгийн хэргийн шүүхэд хэлэлцэгдэхээр хүлээгдэж байгаа хэрэг байхгүй гэж үзэх үндэслэлтэй байна.

Үнэт цаас гаргагчаас ирүүлсэн материал болон Банкны оршин байгаа газар буюу Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхийн тамгын газар, Шүүхийн ерөнхий зөвлөлийн Шүүхийн тусгай архиваас ирүүлсэн лавлагаа, тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК нь нийт 11 (арван нэгэн) иргэний хэрэгт хариуцагчаар оролцож байна.

*Хүснэгт №21. Банкны Иргэний хэргийн хариуцагчаар оролцон шүүхийн шатанд хэлэлцүүлж байгаа хэргийн тоон үзүүлэлт.*

| № | Нэхэмжлэлийн шаардлага | Анхан шатны шүүх | Давж заалдах шатны шүүх | Хяналтын шатны шүүх |
|---|---|---|---|---|
| 1. | Хэлцэл хүчин төгөлдөр бусад тооцуулах, хэлцлийн дагуу шилжүүлсэн мөнгө болон хөрөнгийг буцаан гаргуулах | 5 | - | - |
| 2. | Барьцааны гэрээ дуусгавар болсон тул үл хөдлөх хөрөнгийг барьцаанаас чөлөөлөхийг даалгах | 1 | - | - |
| 3. | Үндэслэлгүйгээр хөрөнгөжсөн төлбөрийг буцаан гаргуулах | 1 | - | - |
| 4. | Гэм хорыг арилгуулах | 1 | - | - |
| 5. | Гэрээ цуцлагдсантай холбоотойгоор дэнчин буцаан гаргуулах | 1 | - | - |
| 6. | Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ажиллагаа дуусгавар болсныг тогтоолгох, гүйцэтгэх хуудас ирүүлэхгүй байх тухай | 1 | - | - |
| 7. | Зээлийн мэдээллийн санд нийлүүлсэн мэдээллийг залруулахыг даалгах | 1 | - | - |
| | НИЙТ | 11 | - | - |

Дээр дурдсан хүснэгтэн мэдээллээс үзвэл Банк хариуцагчаар оролцсон иргэний 7 (долоон) хэрэг Сүхбаатар дүүргийн Иргэний хэргийн анхан шатны шүүхээр, үлдсэн 4 (дөрвөн) хэрэг Сонгинохайрхан дүүргийн болон орон нутгийн иргэний хэргийн анхан шүүхээр хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна. Өөрөөр хэлбэл энэхүү Хуулийн дүгнэлтийг гаргах өдрийн байдлаар Банк хариуцагчаар оролцсон нийт 11 (арван нэгэн) иргэний хэрэг анхан шатны шүүхийн хянан шийдвэрлэх ажиллагаанд байна.

**Нэгтгэн дүгнэж үзвэл Банк нь захиргааны хэрэгт хариуцагчаар татагдаж байгаагүй (хуулийн дагуу хариуцагчаар татагдах боломжгүй) бөгөөд аж ахуйн үйл ажиллагааны эсрэг гэмт хэрэгт аливаа хэлбэрээр татагдаж байгаагүй гэж үзэх үндэслэлтэй байна.**

Үнэт цаас гаргагч нь нийт 36 (гучин зургаан) иргэний хэрэгт хариуцагчаар оролцож, шүүхээр эцэслэн шийдвэрлүүлсэн байна. Түүнчлэн Хуулийн дүгнэлт гаргах өдрийн байдлаар Үнэт цаас гаргагчийн нийт 11 (арван нэгэн) хэрэг иргэний хэргийн анхан шатны шүүх дээр хэлэлцэгдэхээр хүлээгдэж байна.

**Арван нэг. Үнэт цаас гаргагч нь татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх асуудлын хувьд үзвэл:**

Хуулийн фирм нь ХасБанк ХХК-ийн татвар, нийгмийн даатгал болон шүүхийн шийдвэр гүйцэтгэх газарт өр төлбөртэй эсэх болон бусдын өмнө хүлээсэн өр төлбөртэй эсэх асуудлыг нягталж харьяа төрийн эрх бүхий байгууллагаас дэлгэрэнгүй лавлагаа, тодорхойлолт гаргуулан авлаа. Үнэт цаас гаргагчийн эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолтыг **Хавсралт №10. "ХасБанк ХХК-тай холбогдуулан эрх бүхий байгууллагаас авсан лавлагаа, тодорхойлолт"** хүснэгтээс дэлгэрүүлэн үзнэ үү. Үүнд:

Монголын татварын албаны 2023 оны 03 сарын 02-ны өдрийн №23.1003.2e4394e7-c36c-4096-80c5-bb5e1d48c794 тоот аж ахуйн нэгж, байгууллагын цахим лавлагаа, тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК нь 1,216,977,362.44 (нэг тэрбум хоёр зуун арван зургаан сая есөн зуун далан долоон мянга гурван зуун жаран хоёр төгрөг дөчин дөрвөн мөнгө) төгрөгийн дутуу төлөлттэй бөгөөд 15,095,161,451.15 (арван таван тэрбум ерэн таван сая нэг зуун жаран нэгэн мянга дөрвөн зуун тавин нэгэн төгрөг арван таван мөнгө) илүү төлөлттэй болохыг тодорхойлсон байна.

466

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2023 оны 01 сарын 03-ны өдрийн №O2313Y33Z000021578380 тоот ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэл төлөлтийн тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК нь нийгмийн даатгалын шимтгэлийн өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар, Шийдвэр гүйцэтгэх албаны 2023 оны 01 сарын 23-ны өдрийн №0005087 тоот тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК нь шүүхийн шийдвэрээр бусдад төлөх өр төлбөргүй болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гаалийн ерөнхий газрын 2023 оны 01 сарын 23-ны өдрийн №S0VA-F7BZFVVI-X5F4 тоот лавлагаанаас үзвэл ХасБанк ХХК нь Гаалийн тухай хууль болон холбогдох хууль тогтоомжийг зөрчөөгүй болохыг тодорхойлсон байна.

Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Гаалийн ерөнхий газрын 2023 оны 01 сарын 23-ны өдрийн №ILVD-Y5QM-80RJ-7KYT тоот тодорхойлолтоос үзвэл ХасБанк ХХК нь тодорхойлолт гаргах өдрийн байдлаар гаалийн байгууллагад өргүй болохыг тодорхойлсон байна.

Иймд дээр дурдсан төрийн эрх бүхий байгууллагын лавлагаа, тодорхойлолтод үндэслэн Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК нь дээр дурдсан татварын дутуу төлөлтөөс бусдаар нийгмийн даатгал, шийдвэр гүйцэтгэх газарт болон бусдад төлөх өр төлбөргүй байна гэж Хуулийн фирмээс үзлээ.

Нэгдсэн дүгнэлт

**Нэгтгэн дүгнэж үзвэл Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК нь Санхүүгийн зохицуулах хороо болон Монголын хөрөнгийн биржийн Үнэт цаасны бүртгэлийн журамд тогтоосон шалгуурыг хангаж байна гэж Хуулийн фирмээс дүгнэлээ.**

**Үнэт цаас гаргагч ХасБанк ХХК-ийн нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргах замаар компанийн хэлбэрийг өөрчлөн нээлттэй хувьцаат компани болохыг Санхүүгийн зохицуулах хорооноос зөвшөөрсөн тохиолдолд энэхүү Хуулийн дүгнэлтэд тусгасан хувьцаат компанийн хувьд хуулиар тогтоосон нөхцөл, журмыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлж ажиллахыг зөвлөж байна.**

---------ooOoo--------

СЭХ
он 2023 оны 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 0 5

Хариуцлага хязгаарлах тухай

Энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаанд бүхэлд нь өгсөн үнэлэлт, дүгнэлтэд тооцогдохгүй бөгөөд зөвхөн нийтэд санал болгон анх удаа хувьцаа гаргахтай холбогдуулан төрийн байгууллагын тавьсан шаардлагын хүрээнд буюу дээр дурдагдсан асуудлуудын хүрээнд хязгаарлагдана.

Энэхүү Хуулийн дүгнэлтийг Үнэт цаас гаргагчийн хүсэлтээр, түүнээс тодорхойлсон ажлын даалгаврыг үндэслэн Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомж, дүрэм, журмын хүрээнд Үнэт цаас гаргагчийн нэр дээр хаяглан хүргүүлсэн болно. Үнэт цаас гаргагч, түүнээс эрх олгогдсон этгээдийн зөвшөөрөлгүйгээр энэхүү Хуулийн дүгнэлтийг бүхэлд нь болон хэсэгчлэн салган авч ашиглах, түгээх, дамжуулахыг хориглоно.

ХасБанк ХХК, түүний холбоо, хамааралтай этгээд, тэдгээрийн эрх бүхий албан тушаалтан энэхүү Хуулийн дүгнэлтийг харилцан тохиролцсоноос бусад зорилгоор ашигласан, түгээсэн, бусдад танилцуулсан, тайлбарласан, хэсэгчлэн задруулсан, нийтэд ил болгосноос үүсэх асуудлаар Хуулийн фирм хариуцлага хүлээхгүй бөгөөд энэхүү Хуулийн дүгнэлт нь Үнэт цаас гаргагчийн бизнесийн үйл ажиллагаа болон анх удаа нийтэд санал гаргаж буй үнэт цаасанд гаргасан аливаа баталгаанд тооцогдохгүй.

Хуулийн фирм нь хараат бус байх, гаргаж өгсөн баримт материалын хүрээнд дүн шинжилгээ хийх зарчмыг баримтлан хөндлөнгийн дүн шинжилгээг хийж гүйцэтгэсэн тул дүн шинжилгээнд хамруулах шаардлагатай чухал үйл баримт, Компаниас орхигдуулсан аливаа бусад гол баримт, материал, буруу дутуу, худал мэдээлэл гаргаж өгсөн, дүн шинжилгээ хийхэд ашигласан лавлагаа, тодорхойлолт бусад баримт материалд дурдагдсан хууль зүйн ач холбогдолтой аливаа нөхцөл, байдал дүн шинжилгээ хийснээс хойш Хуулийн фирмд мэдэгдэлгүйгээр өөрчлөгдсөнөөс үүдэн гарах аливаа асуудлаар хариуцлага хүлээхгүй болно.

ХҮНДЭТГЭСЭН,

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ Д.ХУЛАН

БАТБАЯР ЭНД ПАРТНЭРС ХХН УЛААНБААТАР ХОТ

СЗХ
оны 2023 сарын 06. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

# ХАВСРАЛТ 7: Хувьцаа гаргах тухай ТУЗ-ийн Хурлын тогтоол

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05-
БҮРТГЭВ-02

ХАСБАНК

# ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

20 23 оны 01 сарын 11 өдөр № R-2023-02 Улаанбаатар хот

Нийтэд санал болгохоор
хувьцаа нэмж гаргах тухай

Банкны тухай хуулийн 4.2 болон 20.4 дэх хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 17.1, 23.1, 23.2, 38.8 дахь хэсэг, 43, 55 дугаар зүйл, 62.1.1, 62.1.3 болон 62.1.8 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, 10 болон 11 дүгээр зүйл, Санхүүгийн Зохицуулах Хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1 дэх хэсэг болон ХасБанкны Дүрмийн 7.10.4, 8.5.1, 8.5.1.(i), 8.5.1.(ii), 8.5.1(iv), 8.5.1.(vi) дэх заалтын дагуу, ХасБанк ХХК (“**ХасБанк**”)-ийн Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”) 2023 оны 1 дүгээр сарын 9-ний өдөр болон 2023 оны 1 дүгээр сарын 11-ний өдөр тус тус хуралдсан хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн,

**ТЭМДЭГЛЭХ нь:**

1. ХасБанк ХХК (“**ХасБанк**”)-ийг Банкны тухай хуулийн 4.2 дахь хэсэг болон Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэртэйгээр өөрчлөн байгуулах (“**Нийтэд хувьцаа санал болгох**”) шаардлагатай болохыг;

2. Банкны тухай хуулийн 4.2 дахь хэсэг болон Банкны тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн 4 дүгээр зүйлд нийцүүлэхийн тулд Монголын Хөрөнгийн Бирж дээр Нийтэд хувьцаа санал болгох замаар ХасБанкийг хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-иас нээлттэй хувьцаат компани (ХК) болгон өөрчлөн байгуулахыг ТУЗ R-2023-01 дугаар Тогтоолоор Компанийн Хувьцаа эзэмшигчдэд санал болгосныг;

3. Энэхүү Тогтоолын дээрх заалтыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор ТУЗ нь Монголын Хөрөнгийн Бирж дээр дараах нөхцлөөр ХасБанкны энгийн хувьцааг нийтэд нэмж гаргах (“**Шинэ энгийн хувьцаа**”)-ыг Хувьцаа эзэмшигчдэд санал болгож буй:

| | | |
|---|---|---|
| 1. | Нийтэд санал болгох хувьцааны тоо | 52,700,000 ширхэг энгийн хувьцаа |
| 2. | Хувьцааны нэрлэсэн үнэ | 100 төгрөг |
| 3. | Нэгж хувьцааны үнэ | Хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлт гарсны дараа Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлогдоно. |
| 4. | Нийтээс татан төвлөрүүлэх мөнгөн хөрөнгийн дүн | Хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлт гарсны |



ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

| | | |
|---|---|---|
| | | дараа Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлогдоно. |
| 5. | Хувьцаа худалдах, захиалга авах нөхцөл | Монголын Хөрөнгийн Бирж дээр нийтэд санал болгож худалдана. |
| 6. | Нийтэд хувьцаа гаргахаар төлөвлөж буй огноо | 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдөр эсхүл түүнээс өмнө |
| 7. | Татан төвлөрүүлсэн мөнгөн хөрөнгийн зарцуулалт | Зээл болон санхүүгийн түрээсийн багцыг өсгөх |
| 8. | Хувьцааны үнэ тогтворжуулах хугацаа | СЗХ-ны журмын дагуу нийтэд хувьцаа гаргасны дараа нэг сар |
| 9. | Нийтэд санал болгох нийт хувьцаанаас андеррайтерийн худалдан авах хувь хэмжээ | Хараат бус үнэлгээний байгууллагын дүгнэлт гарсны дараа Компанийн тухай хуулийн 55 дугаар зүйлд заасны дагуу тодорхойлогдоно. |

4. Хувьцаа эзэмшигчид зөвшөөрсөн тохиолдолд, ТУЗ нь ийнхүү дараах шийдвэрийг батлах хүсэлтэй болохыг тус тус дурдав.

**ТОГТООХ нь:**

1. Дээр тусгагдсан нөхцлөөр ХасБанкны Шинэ энгийн хувьцааг нэмж гаргах асуудлыг хувьцаа эзэмшигчдэд батлуулахаар санал болгосугай.

2. Хувьцаа эзэмшигчид зөвшөөрсөн тохиолдолд, Нийтэд хувьцаа санал болгохтой холбоотойгоор ХасБанкны гаргах энгийн хувьцаанаас ХасБанкны цор ганц хувьцаа эзэмшигч болох ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК (**"ТСН"**), ТСН-ийн хувьцаа эзэмшигчид Компанийн тухай хуулийн 38.8 дахь хэсэг болон 62.1.8 дахь заалт, ХасБанкны Дүрмийн 7.10.4 дэх заалтын дагуу тэргүүн ээлжид худалдан авах эрхээ шууд болон шууд бусаар хэрэгжүүлэхгүй байхаар шийдвэрлэсүгэй.

3. Энэхүү тогтоолын 1 дүгээр хавсралтаар СЗХ болон Монголбанканд хүргүүлж, Нийтэд санал болгох хувьцааны танилцуулгад хавсаргах ХасБанк нээлттэй ХК-ийн Дүрмийн төслийг Хувьцаа эзэмшигчдэд батлуулахаар санал болгосугай.

4. Холбогдох баримт бичгүүдийг үйлдэх, гарын үсэг зурах, Монголбанк, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын хөрөнгийн бирж, Монголын үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн газар болон бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх, бүртгүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг ХасБанкны ТУЗ-ийн дарга Санжай Гупта, Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав, Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Санхүү хариуцсан захирал Г.Эрдэнэбаяр нарт тус тус даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА — САНЖАЙ ГУПТА

ХУУЛЬ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ БӨГӨӨД ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА — Н.МӨНХЦЭЛМЭГ

СЗХ он 2023 сар 05 өдөр 12 БҮРТГЭВ № 01

ХАСБАНК УХН 4937 2573697

# ХАВСРАЛТ 8: Хувьцаа гаргах тухай Хувьцаа Эзэмшигчдийн Хурлын тогтоол

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 01

# ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

ХАСБАНК

20 23 оны 04 сарын 05 өдөр №SR-2023-06 Улаанбаатар хот

Нийтэд санал болгон гаргах хувьцааны үнэ тогтоох болон бусад холбогдох нэмэлт нөхцөлүүдийг батлах тухай

Банкны тухай хуулийн 4.2 болон 20.4 дэх хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын 4 дүгээр зүйл, Компанийн тухай хуулийн 38.8 дахь хэсэг, 43, 55 дугаар зүйл, 62 дугаар зүйлийн 62.1.3, 62.1.8 дахь заалт, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 6.1 дэх хэсэг, 10 болон 11 дүгээр зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны 2021 оны 6 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан Үнэт цаасны бүртгэлийн журмын 3.1 дэх хэсэг, Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК (“**ТСН**”)-ийн Дүрмийн 5.1.1 дэх заалт, ХасБанк ХХК (“**ХасБанк**”)-ийн Дүрмийн 7.10.4, 8.5.1, 8.5.1(i), 8.5.1(iv), болон 8.5.1(vi) дэх заалтын дагуу, ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурлын 2023 оны 4 дүгээр сарын 05-ны өдөр хуралдсан хурлаар хэлэлцээд гарсан шийдвэрийг үндэслэн:

**ТЭМДЭГЛЭХ нь:**

1. Банкны тухай хуулийн 4.2 дахь хэсэг, Банкны тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийг дагаж мөрдөх журмын 4 дүгээр зүйлд заасны дагуу ХасБанкийг 2023 оны 6 дугаар сарын 30-ны өдрийн дотор нээлттэй хувьцаат компани хэлбэрээр өөрчлөн байгуулах (“**Хувьцаа нийтэд санал болгох**”) шаардлагатай болохыг;

2. ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хурал SR-2023-02 болон SR-2023-03 тоот тогтоолыг тус тус баталж ХасБанкны хуулийн этгээдийн хэлбэрийг хязгаарлагдмал хариуцлагатай компани (ХХК)-иас нээлттэй хувьцаат компани (ХК) болгон өөрчлөн байгуулах, мөн Хувьцаа нийтэд санал болгох зорилгоор 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 52,700,000 ширхэг энгийн хувьцаа ("**Шинэ энгийн хувьцаа**") гаргахаар шийдвэрлэснийг;

3. ХасБанкны Төлөөлөн удирдах зөвлөл (“**ТУЗ**”)-ийн R-2023-20 тоот тогтоолын дагуу “БДО Аудит” ХХК-иас ирүүлсэн хөндлөнгийн үнэлгээний тайланг үндэслэн Шинэ энгийн хувьцааны нийтэд санал болгох үнэ болон бусад нэмэлт нөхцөлүүд ("**Нэмэлт нөхцөл**")-ийг ХасБанкны Хувьцаа эзэмшигчдийн хуралд доорх байдлаар санал болгосныг:

| **Шинэ энгийн хувьцаа** | | |
|---|---|---|
| 1. | Нэгж хувьцааны үнэ | 677.00 ₮ (төгрөг) |
| 2. | Нийтээс татан төвлөрүүлэх хөрөнгийн дүн | 35,677,900,000.00 ₮ (төгрөг) |
| 3. | Андеррайтерийн үүрэг | 100,000,000.00 ₮ (төгрөг) |
| 4. | Хуваарилах зарчим | Тус тогтоолын 1 дүгээр хавсралтад заасны дагуу нийтэд санал болгох нийт хувьцааны 70%-ийг стратегийн хөрөнгө оруулагчдад, 30%-ийг олон нийтэд санал болгоно. |



ХасБанкны төв байр,
Ерөнхий сайд Амарын гудамж,
Шуудангийн салбар-20А, Ш/Х-72,
Улаанбаатар-14200, Монгол улс.

Лавлах: 1800-1888
Утас: 7577-1888
Веб: www.xacbank.mn
И-мэйл: info@xacbank.mn

ТОГТООХ нь:

1. Дээрх Нэмэлт нөхцөлийн дагуу ХасБанкны Шинэ энгийн хувьцааг зарлаж гаргасугай.

2. Холбогдох баримт бичиг, өргөдөл, хүсэлтийг үйлдэх, гарын үсэг зурах, МонголБанк, Санхүүгийн Зохицуулах Хороо, Монголын Хөрөнгийн Бирж болон бусад эрх бүхий байгууллагад хүргүүлэх зэрэг шаардлагатай арга хэмжээг авч ажиллахыг Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжав нарт чиглэл болгон даалгахын зэрэгцээ ийнхүү хэрэгжүүлэхэд шаардлага бүхий холбогдох эрхийг олгосугай. Хувьцаа нийтэд санал болгох үйл явцад аливаа материаллаг өөрчлөлт орвол түүнийг хянах, батлах эрх нь Төлөөлөн Удирдах Зөвлөл болон Хувьцаа Эзэмшигчдийн хуралд хадгалагдах болохыг дурдсугай.

3. Тус тогтоолын 1 дүгээр хавсралтаар баталсан хуваарилах зарчмын дагуу Шинээр гаргах энгийн хувьцааг хөрөнгө оруулагчдад хуваарилах эрх, мөн түүнчлэн урьдчилан тооцоолоогүй нөхцөл байдалд шуурхай шийдвэр гаргах эрхийг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд олгосугай. Хуваарилалтын аливаа шийдвэрийг ХасБанкны эрх ашигт нийцүүлэхийг, мөн түүнчлэн яаралтай нөхцөл байдалд гаргасан шуурхай шийдвэрүүдийн талаар Төлөөлөн Удирдах Зөвлөлд нэн даруй тайлагнахыг Гүйцэтгэх захирал Г.Цэвэгжавд даалгасугай.

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ХУРЛЫН ДАРГА САНЖАЙ ГУПТА

СЗХ 2023.05.12 өдөр БҮРТГЭВ № 01

ХАСБАНК УХН4937 2578697

СЗХ
2023 .05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

МОНГОЛЫН ХӨРӨНГИЙН БИРЖ
MONGOLIAN STOCK EXCHANGE
2023 -05- 05

# ХАВСРАЛТ 9: Үнэт цаас гаргагчийн тусгай зөвшөөрлийн хуулбар

СЗХ
2023 он 05 сар 12 өдөр

# МОНГОЛ УЛС

Монгол Банк

**МОНГОЛБАНК**

# БАНКНЫ ЗӨВШӨӨРЛИЙН ГЭРЧИЛГЭЭ

*2001 оны 12 дугээр сарын 27 - ны өдөр* *Дугаар 24* *Улаанбаатар хот*

Монгол улсын Банкны тухай хуулийн 17 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, Монголбанкны Ерөнхийлөгчийн 2000 оны 375 тоот тушаалаар батлагдсан "Банк, түүний нэгж байгуулах зөвшөөрлийн журам"-ыг үндэслэн .......... ХАС-ТЭ Групп" ...-д ... Хас" ... оноосон нэр бүхий банк байгуулах зөвшөөрөл олгов.

Монголбанкны бүртгэлийн дугаар ... 32 ...

242

*/Энэхүү Гэрчилгээ нь хавсралтын хамт хүчинтэй/.*

2023 05 22 ... Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ... нотариат ...
Нотариат ...

**ЕРӨНХИЙЛӨГЧ** **О.ЧУЛУУНБАТ**

ХААН БАНК

СЭХ
он 2023 сар 05. 12 өдөр
БҮРТГЭВ
№ 01

2023 -05- 05

. .24. . . . ТООТ

# ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

*/ Энэхүү хавсралт нь гэрчилгээгүй бол хүчингүй/*

242

СЗХ
2023.05.12 өдөр
БҮРТГЭВ
№01

MONGOLIAN STOCK EXCHANGE
2023.05.05
БҮРТГЭВ-02

# ГЭРЧИЛГЭЭНИЙ ХАВСРАЛТ

**Банкны нэр:** Хас банк

**Банкны хаяг:** Сүхбаатар дүүрэг, 5-р хороо
Ерөнхий сайд Амарын гудамж
Тусгаар ХХЯ-ны баруун талд

*Нэг: "Хас" банкны эрхлэх үйл ажиллагааны талаархи тэмдэглэл*

1. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2001 оны 12 сарын 27-ны өдрийн 610 тоот тушаалаар "Хас" банкинд Банкны тухай хуулийн 6 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасан мөнгөн хадгаламж, зээл, төлбөр тооцоо үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг олгов.

2. Бусад:
1) гадаад валют худалдан авах, худалдах, хадгалах, хадгалуулах
2) үнэт зүйл хадгалах
3) хөрөнгө оруулалт, санхүүгийн чиглэлээр зөвлөгөө, мэдээлэл өгөх
4) Гадаад төлбөр тооцоо эрхлэх тусгай зөвшөөрөл (МБЕ-ийн 2002 оны 572 тоот тушаал)
5. Гадаад төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх нэмэлт зөвшөөрөл (МБЕ-ийн 2006 оны 424 тоот тушаал)
6. Өөрийн нэрийн өмнөөс гуравдагч этгээдэд баталгаа, батлан даалт гаргах зөвшөөрөл (МБЕ-ийн 2006 оны 424 тоот тушаал)
7. Үнэт цаас гаргах, худалдах, худалдан авах үйл ажиллагааны нэмэлт зөвшөөрөл (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 06 сарын 17-ны өдрийн 354 дүгээр
8. Үнэт металл худалдах, худалдан авах, хадгалах, хадгалуулах (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2013 оны 12 дугаар сарын 30-ны А-258 дугаар
9. Зээл болон санхүүгийн хэрэгсэл худалдах, худалдан авах нэмэлт зөвшөөрөл (Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016.5.5-ны өдрийн А-107 дугаар тушаал)
10. Санхүүгийн зохицуулах хорооны 2012.[illegible].26-ны өдрийн 336 дугаар тогтоолоор Даатгалын зуучлагчийн үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл
11. Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016.12.27-ны А-334 дүгээр тушаалаар "Санхүүгийн түрээсийн үйл ажиллагаа" эрхлэх зөвшөөрөл



242

СЗХ
2023.05.12
БҮРТГЭВ
№ 51

STOCK EXCHANGE
2023-05-05

## Хоёр: Банкны нэгж, түүний байршлын талаархи тэмдэглэл

| д/д | Нэгжийн төрөл | Ямар шийдвэрийг үндэслэн бүртгэсэн | Дугаар | Нэгжийн байршил, Хаяг |
|---|---|---|---|---|
| 1. | Дорноговь салбар | Монгол банкны Ерөнхийлөгчийн 2011он 1дүгээр сарын 03ны өдрийн [illegible] дугаар тушаал | | Дорноговь аймаг Сайншанд сум |
| 2. | Чингэлтэй салбар | —— " —— | | Чингэлтэй дүүргийн 5 дугаар хороо |
| 3. | Хэнтий салбар | —— " —— | | Хэнтий аймаг |
| 4. | Сансар салбар | —— " —— | | Баянзүрх дүүргийн 16 дугаар хороо |
| 5. | Сонгино хайрхан салбар | —— " —— | | Сонгино хайрхан дүүргийн 12 дугаар хороо |
| 6. | Дархан салбар | —— " —— | | Дархан-Уул аймаг |
| 7. | Хан-Уул салбар | —— " —— | | Хан-Уул дүүргийн 3 дугаар хороо |
| 8. | Сэлэнгэ салбар | —— " —— | | Сэлэнгэ аймаг, Сүхбаатар сум |
| 9. | Өвөрхангай салбар | —— " —— | | Өвөрхангай аймаг |
| 10. | Орхон салбар | —— " —— | | Орхон аймаг |
| 11. | Завхан салбар | —— " —— | | Завхан аймаг, Улиастай сум, |
| 12. | Баянгол салбар | —— " —— | | Баянгол дүүргийн 13 дугаар хороо |
| 13. | Хөвсгөл салбар | —— " —— | | Хөвсгөл аймаг, Мөрөн сум, |
| 14. | Өмнөговь салбар | —— " —— | | Өмнөговь аймаг, Даланзадгад, |
| 15. | Баянхонгор салбар | —— " —— | | Баянхонгор аймаг, Баянхонгор сум |
| 16. | Дорнод салбар | —— " —— | | Дорнод аймаг, Чойбалсан хот |
| 17. | Ховд салбар | —— " —— | | Ховд аймаг, Жаргалант хот |
| 18. | Увс салбар | —— " —— | | Увс аймаг Улаангом сум |
| 19. | Баян-Өлгий салбар | —— " —— | | Баян-Өлгий аймаг Өлгий сум |

УЛСЫН БАЙЦААГЧ № 013

СЭХ
2023.05.12
БҮРТГЭВ

2023-05-05
БҮРТГЭВ

| д/д | Нэгжийн төрөл | Ямар шийдвэрийг үндэслэн бүртгэсэн | Дугаар | Нэгжийн байршил, хаяг |
|---|---|---|---|---|
| 20. | Багануур салбар | Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 1 дүгээр сарын 3-ны өдрийн 5 дугаар тушаал. | | Багануур дүүрэг |
| 21. | Баянзүрх салбар | -"- | | Баянзүрх дүүргийн 7 дугаар хороо |
| 22. | Төв салбар | Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 1 дүгээр сарын 31-ний өдрийн 64 дүгээр тушаал | | Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг |
| 23. | Сүхбаатар салбар | -"- | | Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг |
| 24. | Зуун айл салбар | -"- | | Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг |
| 25. | Чойр салбар | Монголбанкны Ерөнхийлөгчийн | | Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум |
| 26. | Архангай салбар | 2011 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн | | Архангай аймаг Эрдэнэбулган сум |
| 27. | Дундговь салбар | 683 дугаар тушаал | | Дундговь аймаг Мандалговь сум |
| 28. | Говь-Алтай салбар | -"- | | Говь-Алтай аймаг Есөнбулаг сум |
| 29. | Баруун-Урт салбар | -"- | | Сүхбаатар аймаг Баруун-Урт сум |
| 30. | Зуунмод салбар | -"- | | Төв аймаг Зуунмод сум |
| 31. | Цогтцэций салбар | -"- | | Өмнөговь аймаг Цогтцэций сум |
| 32. | Налайх салбар | Монголбанкны Ерөнхийлөгчийн 2011 оны 11 дүгээр сарын | | Улаанбаатар хот Налайх дүүрэг |
| 33. | Ард салбар | 24-ний өдрийн 683 дугаар тушаал | | Улаанбаатар хот Чингэлтэй дүүрэг |
| 34. | Цайз салбар | МБ-ны 2012 оны 3-р сарын 16-ны өдрийн А-31 дугаар тушаал | | Улаанбаатар хот Баянзүрх дүүрэг |
| 35. | Түшиг салбар | Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 3 дугаар сарын 07-ний өдрийн А-131 дүгээр тушаал | | Улаанбаатар хот Сүхбаатар дүүрэг |

УЛСЫН БАЙЦААГЧ № 013 МОНГОЛБАНК

УЛСЫН БАЙЦААГЧ № 019 МОНГОЛБАНК

УЛСЫН БАЙЦААГЧ № 050 МОНГОЛБАНК

2011.11.25

2012.03.28

2015.10.01 С.Т...

ХАСБАНК

СЭХ 2023.05.12 БҮРТГЭВ

2023-05-05 [illegible]

| д/д | Нэгжийн төрөл | Ямар шийдвэрийг үндэслэн бүртгэсэн | Дугаар | Нэгжийн байршил, хаяг |
|---|---|---|---|---|
| 36. | Булган салбар | Монголбанкны Ерөнхийлөгчийн 2014 оны 8 дугаар сарын 07-ны өдрийн А-131 дугаар тушаал | | Булган аймаг Булган сум |
| 37. | Төв талбай салбар | Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 03 дугаар сарын 30-ны өдрийн А-81 дугаар тушаал | | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо |
| 38. | Сэнтрал тауэр салбар | ——"—— | | Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо |
| 39. | Оргил салбар | ——"—— | | Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг, 15-р хороо |
| 40. | И-Март төлбөрийн төв | Монголбанкны Ерөнхийлөгчийн 2016 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А-319 дугаар тушаал | | Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |
| | | | | |

2015.10.01 С.Тамбаяр (?)

(37-40) 2017.VIII/24

УЛСЫН БАЙЦААГЧ

УХН1937 2578097